4095 ...

4094 ... ...

4093 ...

4092 ...

"ولكن لا أعرف ما الذي يمكن أن أفعله حيال ذلك."

4131 وأضاف: "لقد أخبرت الشرطة بكل ما أعرفه، وأنا أعتقد أن الأمر يعود إلى
4132 أحد أمرين: إما أن الرجل الذي قتل ابنتي كان يعرف أنها ستكون في
4133 المكان المناسب في الوقت المناسب، أو أنه كان يراقبها لفترة طويلة
4134 قبل أن يقتلها."

4135 وقال: "لا أعرف أيهما أسوأ."

4136 وقالت والدة ليزا: "لقد كانت فتاة رائعة، وكانت تحب الحياة. كانت
4137 تحب الناس، وكانت تحب أن تكون حولهم. كانت تحب أن تضحك، وكانت
4138 تحب أن تجعل الآخرين يضحكون. كانت تحب أن تعيش، وكانت تحب أن
4139 تحب. كانت تحب أن تكون على قيد الحياة."

4140 وقالت والدة ليزا إنها تأمل أن يتم القبض على القاتل قريبًا، وأنها
4141 تأمل أن يتم تقديمه إلى العدالة. وقالت: "أريد أن أرى هذا الرجل
4142 خلف القضبان. أريد أن أعرف أنه لن يستطيع أن يؤذي أي شخص آخر."

4143 وقالت والدة ليزا إنها تأمل أن يتم القبض على القاتل قريبًا، وأنها
4144 تأمل أن يتم تقديمه إلى العدالة. وقالت: "أريد أن أرى هذا الرجل
4145 خلف القضبان. أريد أن أعرف أنه لن يستطيع أن يؤذي أي شخص آخر."

4146 وقالت والدة ليزا إنها تأمل أن يتم القبض على القاتل قريبًا، وأنها
4147 تأمل أن يتم تقديمه إلى العدالة. وقالت: "أريد أن أرى هذا الرجل
4148 خلف القضبان. أريد أن أعرف أنه لن يستطيع أن يؤذي أي شخص آخر."

ظلمتي

4151 تدمدم وهو يتقدم نحوي بخطوات بطيئة مثل الأسد:

4150 سأمزقك إربا إربا أيها الأحمق الصغير.

فجأة

4149 توقف عن التقدم نحوي. وقف ساكنا. وأخذ يحدق

4148 في عمق ظلمتي. وأنا أحدق في وجهه

الممتقع

4147 بدت عيناه وكأنهما تخرجان من محجريهما. ثم

4146 فجأة أخذ يتراجع بسرعة. وتعثر بالمقعد الذي

4145 كان يجلس عليه. وسقط أرضا. وأخذ يصرخ

277

4144 بأعلى صوته وهو يزحف على يديه ورجليه:

4143 "أرجوك لا تقتلني. سأعطيك كل ما تريد. سأعطيك

4142 كنوز الدنيا. سأعطيك ما تشاء. أرجوك لا

4141 تقتلني. أنا لا أريد الموت. أنا أحب الحياة".

4140 ثم أخذ يتوسل بصوت مرتجف. "سأعطيك كل

ما تريد

4139 فقط اتركني أعيش".

فقط

4138 اتركني أعيش".

4137 وهو يتراجع

4136 حتى اصطدم بالجدار خلفه. وأخذ يتلوى

4135 ويتمرغ على الأرض. "أرجوك لا تقتلني

4134 يا سيد الظلام". ثم أخذ يبكي بحرقة

4133 وهو يزحف على الأرض نحوي

4152 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4153 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4154 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4155 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4156 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4157 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4158 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4159 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4160 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4161 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4162 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4163 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4164 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4165 Начальник Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4166 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4167 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4168 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

278

4169 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4170 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4171 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4172 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4173 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4174 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4175 Руководитель Управления Федеральной службы по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций по Республике Татарстан (Волжскому межрегиональному округу связи) Ю.Ю. Ефимов

4202 ...ستمگر شدند. سپس خداوند به آنان گفت: «بمیرید و سپس زنده شوید.»

4201 سپس ما ابرها را بر شما سایه‌افکن کردیم و برای شما

4200 من و خوراک فرستادیم و گفتیم: «از چیزهای پاکیزه‌ای که

4199 به شما روزی داده‌ایم بخورید.» آنان به ما ستم نکردند،

4198 بلکه به خودشان ستم می‌کردند.

4197 و هنگامی که گفتیم: «وارد این شهر شوید و از هر جای

4196 آن که خواستید به فراوانی بخورید و از دروازه با

فروتنی

4195 وارد شوید و بگویید: «خدایا، گناهان ما را ببخش تا

4194 ما نیز گناهان شما را ببخشیم و به نیکوکاران پاداش

4193 بیشتری خواهیم داد.»

4192 ستمگران گفتار دیگری را به جای گفتار

4191 که به آنان گفته شده بود، بیان کردند، پس ما بر

(۵)

4190 ستمگران به سزای نافرمانی‌شان عذابی از آسمان

فرستادیم.

4189 و به یاد آورید هنگامی را که موسی برای قوم

4188 خود طلب آب کرد و ما به او گفتیم: «با عصایت

4187 بر صخره بزن.» پس از آن دوازده چشمه

4186 آب از آن جاری شد و هر گروهی از مردم

4185 آبشخور خود را شناختند. (گفتیم:) «از روزی

خدا

4184 بخورید و بیاشامید و در زمین فساد نکنید.»

4183 و به یاد آورید هنگامی را که گفتید: «ای موسی،

4182 ما هرگز بر یک نوع غذا صبر نمی‌کنیم.

4181 پس از پروردگارت بخواه که از آنچه زمین

می‌رویاند

4180 برای ما بیاورد، از سبزی و خیار و سیر و عدس و

پیاز.»

4179 موسی گفت: «آیا غذای بهتر را با غذای پست

4178 عوض می‌کنید؟ به شهری بروید، آنچه

4177 خواسته‌اید در آنجا خواهید یافت.»

و

4176 خواری و بینوایی بر آنان مقرر شد و

4231 ؟ ؟ ؟

4236 ٥٩٨٤ ٥ ٢٨ ٢٠٠٤ ٢٠٠٤ ٢٠٠٤

4258 ...

4259 ...

4260 ...

4261 ...

4262 ...

4263 ...

4264 ...

4265 ...

4266 ...

4267 ...

4268 ...

4269 ...

4270 ...

4271 ...

4272 ...

4273 ...

4274 ...

4275 ...

4276 ...

4277 ...

4278 ...

ونحن

نتمنى أن نكون قد أجبنا على سؤالك، أيها

4279 الصديق العزيز. إذا كان لديك أي سؤال آخر، فلا

تتردد في أن تسأل.

280

4320 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4319 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4318 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4317 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4316 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4315 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4314 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4313 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4312 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4311 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4310 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4309 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4308 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4307 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4306 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4305 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4304 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4303 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4302 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4301 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה' ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

281

...ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4300 ...ואת הבית אשר בנה שלמה המלך לה'...

4328 ...

4327 ...

4326 ... 1690 ...

282

4325 ...

...

4324 ...

...

4323 ... (ع) ...

...

4322 ... 0620 ...

...

4321 ...

ЗАРИМ ҮГИЙН ТАЙЛБАР ТОЛЬ

ОРШЛЫН ОРОНД

Дундад эртний Монголын түүх, утга зохиолын алдарт дурсгал бичиг «Монголын нууц товчоон» бол XIII зууны эхний хагаст монголчуудын түүхээ бүртгэж товчоолон бичих уламжлан хадгалах тэргүүтэн эртний бүх хэв заншил уламжлаар бичсэн монгол овог аймгуудын нэгдсэн улсыг байгуулсан Чингис хаан, түүний ширээг залгамжилсан Өгэдэй хааны албан ёсны («нууц») түүхийн бичиг мөн билээ.

Энэ хосгүй дурсгалт бичгийг анх худам (язгуур эртний) монгол бичгээр туурвин бичсэн нь илэрхий боловч харин тэр бичгийн эх нь бидэнд бүрэн бүтнээрээ уламжилж ирсэнгүй. Харин тэр худам монгол бичгийн эхээс Юан улсын Буянт хааны (1312—1320 оны) үе болон Хятадын Мин улсын Ён-ло хааны өмнөхөн үед дам хийсэн гэж үздэг монгол хэлийг нь хятад үсгийн тэмдгээр сийрүүлсэн сийрүүлэг, үг бүрийн хажуугийн (хадмал) хятад үгийн орчуулга хийгээд зүйл (хэсэг) бүрийн эцэст хавсаргасан товч (ерөнхий) хятад орчуулга ийм гурван өөр агуулгатай хятад үсгийн эхээр бидэнд хадгалагдан үлджээ. Эл эх нь «Ён-ло-гийн их дүрэмлэх бичиг» гэдэгт бүртгэгдэн орж Хятадын хаадын ордны номын санд хэдэн зуун жил хадгалагдаж байжээ.

Тэр эхийг Бээжинд Оросын шашны төлөөлөгчийн газар сууж байсан эрдэмт лам Палладий (П. И. Кафаров) олж хуулан аваад түүний төвч хятад орчуулгыг 1866 онд нийтлүүлснээс хойш ургахуйгаас шинэхүй нарны доорх дахины эрдэмтэн сонирхон шинжлэх болж «Монгол нууц товчоон»-ы олон улсын судлал үүсч хөгжөөр зуун гучаад жил болж байна.

Энэ хугацаанд дэлхийн алдарт монголч хятадач эрдэмтэн Монголын Цэнд гүн, Германы Э. Хэниш, Орос зөвлөлтийн С. Козин, Францын П. Пеллио, Японы Кобаяси Такиширо, Ширатори Куракичи, Белгийн А. Мостарт, Мажарын Л. Лигети, Австралийн И. де Рахевильз, Хятад-өөр монголын Баяр тэргүүтэн олон эрдэмтэн «Монголын нууц товчоо»-г хятад үсгийн галигаас нь уйгаржин (гэгдэх) хуучин монгол бичгээр уг эхийг сэргээн босгох эрдэм шинжилгээний нарийн түвэгтэй нэн бэрх ажлыг хийж уг дурсгалт бичгийн орос, латин, уйгаржин монгол үсгийн олон галиг эхийг сэргээн босгожээ.

Үүний зэрэгцээгээр эдгээр олон сэргээмэл эхээс олон улсын эрдэмтэд япон, герман, орос, шинэ монгол, франц, чех, түрк, англи, мажар (унгар), польш, казах зэрэг олон хэлээр орчуулж нийтлэн Дорно Өрнийн соёлт улс түмний уншигчдын хүртээл болгожээ. «Монголын нууц товчоон»-ы судлалын улс түмний авъяас билэгт эрдэмт цэцдийн нөр их хөдөлмөр, тэдний үнэнийг магадлан шинжлэх гэсэн чин шударга гавьяа зүтгэлийн ачаар манай Монголын эртний дурсгалт бичиг алдарт туурвил хүн төрөлхтний утга соёлын эрдэнэсийн санд хувь нэмэр болж орлоо.

Ийм учраас 1990 онд соёлт улс түмний хэмжээгээр тэмдэглэх гэж байгаа «Монголын нууц товчооны» 750 жилийн ой бол түүнийг судлагч олон улсын монголч эрдэмтэн мэргэдийн эрдэм судлалын ажлын ололт ялалтын баяр мөн.

Энэ ойд зориулан уншигч олондоо өргөн толилуулах гэж байгаа энэ ном бол Монголын нууц товчооны худам монгол бичгийн эхийг сэргээн босгохыг оролдсон анхны туршиц болно. Энэ ажлыг зориглон оролдсон учир бол Монголын нууц товчооны урьд эрдэмтэдийн сэргээсэн олон эх болон орчуулгыг нарийвчлан судалсны дүнд бидэнд уламжлан ирсэн Монголын нууц товчооны хятад үсгийн галигийг уг дурсгалт бичгийг зохиогдсоноос хойш зуугаас зуун тавиад жилийн дараа түүний анх бичигдсэн худам монгол бичгийн эхээс нь шууд буулгасан биш, харин түүнийг XIV зууны II хагасын монгол хэлний дуудлагаар буулгаж тэмдэглэсэн байна гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Чухам энэ учраас «...нууц товчооны» хятад үсгийн галигийг яаж ч нарийвчлан судлаад түүний анхны худам монгол бичгийн эхийг бүрэн зөв сэргээх боломжгүй шиг санагдана. Энэ зохиолын анх бичигдсэн худам монгол бичгийн эхийг энэ хир сэргээн босгож ча-

даагүй учраас эл дурсгалт бичгийг утга зохиолын үүднээс нарийвчлан судлах боломж бүрдээгүй байна гэж бид үзэж байна.

Нууц товчооны анх бичигдсэн худам монгол бичгийн эхийг бид юуны өмнө монгол бичгийн уламжлал, утга судлалын үүднээс хятад үсгийн галиг ба утгын хятад орчуулгын алдаа эндэгдлийг шүүмжлэн залруулах Ц. Дамдинсүрэнгийн орчуулгадаа баримталсан зарчмын чиглэлээр ажиллаж сэргээв.

Тэгэхдээ худам монгол бичиг ба хуучин (уйгаржин гэгддэг сонгодог) монгол бичгийн ялгаа, түүнчлэн хятад галиг үсгийн эхэд худам монгол бичгийн бичлэг ба XIV зууны үеийн монгол хэлний аялгын үүднээс гарсан ялгаа зэргийг харьцуулан бодож энэ эхийг сэргээв. Үүнд худам монгол бичгийн бичлэг нь хуучин (сонгодог) монгол бичгээс дараах хэдэн зүйлээр ялгаатай гэж үзэв.

Нэгд Худам монгол бичгийг монгол хэлэнд урт эгшиг үүсээгүй байсан эрт үед авч хэрэглэсэн учир хожмын хуучин монгол бичигт урт эгшгийг хоёр эгшиг үсэг хоёрлон бичих арга журам худам монгол бичигт байгаагүй гэдгийг үндэс болгов.

Хоёрт. Худам монгол бичгийг монгол хэлний үгэнд орсон эгшиг авиа уруулын талаар зохицдог ёс гарахаас өмнө авч хэрэглэсэн учир энэ талаар хуучин (сонгодог) монгол бичигт байдгаас өөрөөр зарим үгийг бичиж байсан гэдгийг үндэс болгов.

Гуравт. Худам монгол бичигт үйл үгийг эр эм хүйс ялган бичдэг ёс арилаагүй байсан гэдэг журмыг үндэс болгов.

Дөрөвт. Худам монгол бичигт нэр үг (заримдаа үйл үг ч) хүртээл нэртэйгээ ганц ба олон тоогоор зохицдог ёс арилаагүй байсан зэрэг хэд хэдэн ялгааг гарган бичиж байсан гэдэг зарчмыг баримтлан энэ эхийг сэргээхийг чармайсан болно.

Нөгөө талаар «МНТ»-ы хятад үсгийн галигт урт эгшиг үүссэн, үүсэх явцын хос эгшиг, мөн тоо, хүйсийн ялгаа арилсан эсвэл аман аялгууг тусгасан галиг учраас худам монгол бичигт байгаагүй h, үгийн дунд орсон «б» авиаг суларсан «в, у, ү» эгшгээр тэмдэглэсэн, жич авиа, үеийн солигдол зэргийг хасаж худам монгол бичигт бичигдэж байсан уламжлалаар нь өөрчлөн бичиж сэргээсэн болно.

Жич худам буюу хуучин монгол бичигт бичдэгээс өөрөөр аман аялгуугаар тэмдэглэсэн хятад үсгийн галиглал нь заримдаа өөр үгийн бичлэгтэй адил болж, үүний улмаас хожим хийсэн бололтой хадмал болон товч орчуулгад өөр үгээр эндүү ташаа утга оноосон үг хэллэг цөөнгүй байх тул тэдгээрийг утга судлалын үүднээс учир зүйг олж залруулахыг оролдож өөрөөр сэргээсэн зэргийг учирлан өгсөү.

Энэ бухний улмаас бид уг эхийн дотор хятад үсгийн галиг ба хятад хадмал болон товч (ерөнхий) орчуулгаас өөрөөр сэргээсэн өөрөөр ойлгож тайлбарласан 700 орчим үг хэллэгийн доор дараалалт тоон зүүлт хийж хойно нь хавсаргасныг нягтлан болгоож ийнхүү өөрчлөн сэргээсний зөв бурууг тунгаан шүүнэ үү.

Эцэст нь Монголын нууц товчооны худам монгол бичгийн эхийг чухам юунд тулгуурлан сэргээн босгов? гэсэн асуудал бидэнд тулгарч байгаа бөгөөд энэ бол бидний хувьд «—Шувуу юунаас гардаг вэ? — Өндөгнөөс гардаг. — Өндөг юунаас гардаг вэ? — Шувуунаас гардаг.» гэсэн ээдрээтэй ярилцаатай адил нарийн түвэгтэй учирлал шаардсан хүнд асуулт юм. Бидний сэргээсэн Нууц товчооны худам монгол бичгийн сийрүүлэг эх бол манай «Монголын нууц товчоон» гэдэг түүхэн сурвалж бичгийг хятад үсгийн галигийн бат хальсан дотроо хэдэн зуун жил хадгалсан тэр анхны өндөг мөн бөгөөд түүнээс дэлхий дахины хятадач, монголч алдарт эрдэмтэний эрчим халуун элэгээрээ дарж дэлбэрүүлсэн элдэв галиг үсгийн эхийн ихэр олон шувуудыг жигүүрлүүлэн нисгээгүй бол, бас тэр анхныхтай ижил өөр нэг өндгийг Монголын түүхч Лувсанданзан олж түүхийн «Алтан товч» гэдэг хуурцгийн дотор нандигнан хадгалж ирээгүй бол бидний Монголчууд «Монголын нууц товчоо»-г төрүүлэх өндгийн алтан хальсыг хагалж Монголын алдарт хан бүргэдийг жигүүрлүүлэн, хүн төрөлхтний утга соёлын уудам тэнгэрт элин халин нисгэж чадахгүй байлаа. Бидний сэргээсэн энэ дурсгалт бичгийн худам монгол бичгийн эх бол хятад үсгийн галигаас нь уг эхийг хуучин монгол бичгээр сэргээсэн, орчуулсан, судалсан болон ер нь Монголын хэл бичиг, утга зохиол, түүх, аман зохиолыг судалсан улс түмний бүх эрдэмтэдийн жигүүрлэн нисгэсэн Монголын судлалын аварга жигүүртнээс гаргасан өндөг гэж үлгэрлэн ойлгож, тэр бүх эрдэмтэн мэргэд цэцдийн нөр их хөдөлмөр хувь нэмэр ач гавьяаг энд бишрэн тэмдэглэхийг шиншлэх ухааны үнэн шударга ёсны өмнө хүлээсэн үүргээ гэж үзэж байгаагаа өчье.

Иймд Нууц товчооны судлалын хятад монгол хоёр ихэр өндөгнөөс улс түмний гэгээн билэг оюунт бүх судлагчдын хамтын эрчим хүчээр жигүүрлүүлэн бойжуулсан шувууд болох олон эх бичиг, орчуулга тайлбар сэлтээс бид Монголын нууц товчооны худам монгол бичгийн эх гэсэн шинэ өндгийг гаргаж аваад түүгээрээ ерөөсөө шувуу юунаас гарсныг тайлбарлах гэсэн хир чадлаас хэтэрсэн их сэдэл сэдэж энэ эхийг санал бол-

гон сэргээн сийрүүлж судлагч улс түмний эрдэмтэн мэргэд өргөн олон уншигчдадаа толилуулж хүлээн авах эсэхийн соёрхлыг хичээнгүйлэн хүсэхийн хамт «Монголын нууц товчооны» эхийг дураар аашилж хэтэрхий гуйвуулсан хүнд осол зэхийг гаргасан бол түүнийг өршөөн хэлтрүүлж жич засаж залруулж сургаж суяхыг хүссэн энэ өчүүхэн учирлалаа хамтад өргөн толилуулав.

Жич бид энэхүү сэргээн босгосон эхийн дотор Лувсанданзаны «Алтан товчийг» «Нууц товчооны худам монгол бичгийн нэг эхийг өөртөө багтаасан бичиг гэж үзэж нууц товчооны хятад галиг эхэд байхгүй зарим зүйлсийг болон, бидний бодлоор нөхөж оруулбал зохино гэсэн зарим үгийг дөрвөлжин хаалтад хийж оруулснаас гадна бас сэргээн босгож буй үгсийн дотор галигаас хасмаар буюу эсвэл нэммээр зарим үсгийг дүгүй хаалтад бичсэнээ энд тайлбарлахыг хамт энэ ажлыг хийхэд эрдэмтэн И. де Рахевильзын гаргасан нууц товчооны үгийн жагсаалт ном түүнчлэн Монголын эрдэмтэн Т. Дашцэдэнгийн «Монголын нууц товчоо» сийрүүлэг номын мөрийн дугаарыг тавьсан тоон заалт маш их тус хүргэснийг баярлан тэмдэглэхийн сацуу Т. Дашцэдэнгийн номын дугаарыг өөрийн номын мөр бүрийн дээр хуулан бичиж судлах эрдэмтэд тус болгохыг хүссэн учраа энд тэмдэглэе.

Нууц товчооны худам монгол бичгийн эхийг сэргээн сийрүүлэх эрдэм шинжилгээний ажлыг минь халуунаар дэмжин бүхий л бололцоо олгосон тус улсын ШУА-ийн ерөнхийлөгч Н. Содном, ХЗХ-ийн хамт олон, түүний захирал Д. Ёндон, Нууц товчооны ойг тэмдэглэх комиссын нарийн бичгийн дарга Ч. Догсүрэн, мөн түүнчлэн энэ номыг хэвлэн нийтлэхэд бүх талын туслалцааг үзүүлсэн Улсын хэвлэлийн газар, түүний уран сайхны ерөнхий зураач П. Төмөрпүрэв, Цэргийн хэвлэлийн өрөгч Ш. Эрдэнэбаатар нарт гүн талархлаа илэрхийлье.

1990. III. 23. Нийтлүүлэгч Ш. Гаадамба

1. **Манггул-ун** (Монголын) гэсэн нь энэхүү номын жинхэнэ нэр гарчгийн (1. 130—132 дугаар тал) эхний үг мөн. «Монгол» гэдэг үгийн гарлыг эрдэмтэн судлаач нар элдвээр (2,3—19, 3,3—15) тайлбарласан боловч бидний бодвол энэ үг эртний монгол хэлний «ба» (бид) гэсэн үгнээс дараах маягаар улиран хувьсч үүссэн. Үүнд: Ба<бан+уд<бан (г)+уд<ман(г)+уд манггул <монгол гэх мэтээр монгол хэлний авианы хувьсал хөгжлийн жамаар үүсч гарсан үг болно. Ингэж үзэхийн гол үндэс нотлох баримт гэвэл нийт монгол угсаатан овог аймаг, улс үндэстнээ «бидний улс» гэсэн утгатай «бада улс» «бида улс» гэх зэргээр нэрлэн түүх судартаа бичдэг байсан явдал мөн.
2. **Нигуча** (нууц) гэсэн нь бидний бодоход уул дурсгалт бичиг «нууцлан» хадгалж байсан түүхэн ойллого мөн болохыг гэрчилж байна. Учир нь монголын түүхийн зарим мэдээ хийгээд аман ярианы уламжлал, бас бус баримтаас үзэхэд монголчууд эрт балар цагаас овог аймаг, улсынхаа түүхийг ганцхан хувь бичээд түүнийгээ машид нууцлан хадгалдаг заншилтай байжээ. Ингэдгийн учир нь хожим овог, аймаг, улсын толгойлогч хан, хаанаа сонгож өргөмжлөх зэрэг чухал хэрэгт гарч болох элдэв зөрөлдөөн маргааныг «нууц түүхээ» гаргаж дуудан уншаад тэнд бичигдсэн зүйлээр гэрч үндэс болгож шүүмжлэн хэлэлцэж таслан шийдвэрлэдэг байжээ. Харин тэр «нууц» түүхийг уншсан хүн овог аймгийн толгойлогч зэрэг холбогдох хүмүүст өвгөд дээдсийн нь түүхийг ярьж өгөхөд түүнийг сонссон хүмүүс хэн бүхэн үр хүүхдээ бага балчраас нь насанд хүртэл нь олж сонссон ойлгож мэдсэнээ дамжуулан ярьж, удмын судраа хойч үеийнхэндээ амаар уламжилдаг заншилтай байсан бололтой. Учир нь удам угсаа өвгөд дээдсээ долоон үе хүртэл мэдэхгүй хүн «ойд төөрсөн сармагчинтай (ө. х. адгуустай-Ш. Г.) адил болж, «төрлөө мэдэхгүй нохой мэт» самуурч, ясан төрлийн хүмүүс өөр зуураа гэрлэн, цус ойртон яс чанар нь муудах тул удам угсаа гарал төрлөө дээш долоон үед нь хүртэл андахгүй мэддэг болох өөр зорилгын үүднээс «бичиж нууцалсан» түүхээ амаар уламжлан дамжуулдаг байжээ.
«Монголчуудын заншил нь гэвэл өвгөд дээдсийнхээ удмын судрыг хадгалах, түүнийгээ ертөнцөд мэндэлсэн хүүхэд бүрдээ үүх түүхий нь (мэдүүлэрээ) уламжлан ярьж сургаж сургамжилж байдагт оршино. Тэд (Монголчууд—Ш. Г.) тийнхүү үүсэл гарлын тухай үгийг ард нийтийн хүртээл болгох учир тэдний дунд аймгаа болон түүний гарал үүслийг эс мэдэх нэгхэн ч хүн байдаггүй юм» (4, том 1, кн. 2., с. 13) гэж Рашид-ад-Дин хэлжээ.
3. **Тобчийан** (товчоон)—энэ үг угтаа «товч хураангуй, нэгтгэн цэгцэлсэн» гэсэн утгатай эртний монгол үг мөн боловч хожим «түүх» гэсэн утгатай болжээ.
Учир нь «нууц» түүхээ амаар уламжлан дамжуулсаар хэдэн арав, зуу, мянган жил өнгөрөхөд «нууц» түүх нь үргэдэж мартагдахад хүрдэг байжээ. Тийм үед монголчуудын дотроос хамгийн ухаан бодлоготой, эрдэм мэдлэгтэй хэн нэг буюу хэд нь мартагдсан түүхээ дахин сэргээж бичдэг байжээ. Тэгэхдээ амаар уламжлан ирснийг сонссон хүн бүрийн амнаас түүж цуглуулан сонсоод тэдгээрийн зөрөө ээдрээг гаргаж товчоолон нэгтгэж хураангуйлан бичээд дахин «нууцлан» хадгалж амаар уламжлах түүхээ сэргээдэг байжээ.
Энэ учраас «түүх» гэдэг үг анх «түүж цуглуулсан юм» гэсэн утгатай, «тэгүкэ» (5, 147 дугаар т.) гэж бичигдэг үг байгаад хожим энэхүү үгийн II үеийн шүргэх «г» авиа нь сугарч урт эгшиг үүсэхийн өмнөх байдлаар «тэ'үкэ» (6,1) гэж сонгодог монгол бичгийн хэлэнд тэмдэглэгдэн үлджээ. Монгол хэлэнд үгийн дотор эгшиг авиа зөвхөн хэлний талаар биш, уруулын байдлаар зохицох ёс гарсан үед энэ үгийг «төгүхэ» (7, 13 дугаар талд үз) гэж бичдэг удаа ч байжээ. Гэвч хүн

бүрийн амнаас түүж тэмдэглэсэн зүйлс нь өөр хоорондоо авцалдахгүй, зөрчил ээдрээ ихтэй, эрээвэр хураавар зүйл болох учир түүх сэргээгчид эрхбиш түүнийг цэгцлэн нэгтгэж товчоолон бичиж түүх болгодог байсан учир «товчоон» гэсэн үгэнд ийнхүү «түүх» гэсэн утга орсон бололтой.

Энэ бүхнээс үзэхэд «Манггул-ун нигуча тобчийан» (Монголын нууц товчоон) гэдэг нь уул дурсалт бичгийн анхны жинхэнэ монгол нэр гарчиг нь гарцаагүй мөн. Харин уг номыг худам (язгуурын) монгол бичиг мэдэхгүй хүн хуулж бичсэн учраас тэр хоёр эгнээний 8 үсгийг уг нэр гарчгийн хятад орчуулга нь болох Юань Чао Ми-Ши гэсэн үсгээс жижиг үсгээр бичиж үлдээсэн байх гэсэн бодол эрхбиш төрүүлж байна.

4. **Чингис**—гэдэг нэгдсэн монгол улсын хаан Тэмүжиний цолын нэр **мөн. Чинггис гэдэг үгийг зарим түүхчин Чинг+с** буюу чин бат гэдэг үгийн олон тооны хэлбэрээс (4, т. 1. кн. 1, с. 167) үүссэн гэдэг. Зарим нь «Чингис төмөр эцэгт, чин шулуун эхт» («Алтан орду-йин голумтан-у йэкэ өчик») гэх зэрэг үгнээс үндэсэлж гал гаргах хэт, гал тахих ёстой холбоотой үг (8, 2) гэх зэргээр элдвээр тайлбарладаг боловч бид Чингис гэдэг үгийг «Тэнгис хаан, далай хаан гэсэн үг бололтой» гэсэн Ц. Дамдинсүрэн (7, 79 дүгээр т.) гуайн саналыг ул үндэстэй хамгийн зөв тайлбар гэж үзэж байна. Юу гэвэл энэ үгийн Т авиа нь Ч болж сэлгэхийн хамтаар Э эгшиг нь И эгшиг болон хувьссан байж болно. Нөгөө талаар монголын эзэнт улсын их хаадыг «Далай хаан» гэж нэрлэж байсан баримт бол «Чингис» гэдэг үг «тэнгис» гэсэн утгаа алдсаны учир тийнхүү улам ч их усыг нэрлэх «далай» гэдэг үгээр түүнийг сольж «Далай хаан» гэж өргөмжлөх болсон бололтой.

5. **Ижагур** (язгуур) — энэ үг хятад галиг эхэд hужа'ур (9, 3) гэж тэмдэглэгдсэн боловч худам (эртний) монгол бичигт хэрэглэж ирсэн уламжлалт бичлэгээрээ ийм байсан гэмээн төсөөлөн сэргээв. Жич. «Чинггис ха'ан-у hужа'ур» гэсэн гурван үгийг уг хятад галиг эхэд нэг мөр эзлүүлэн бичсэн нь олонхи судлаачдын сүүлийн үед боддог шиг уг номын гарчиг учраас тэгж бичсэн хэрэг хэрхэвч бус, харин онцлон хүндэтгэсэн үгээ мөр тэтгэн дээрээс бичдэг монгол бичгийн уламжлалыг баримталж тийнхүү бичсэн гэж бодож байна. Хүндэтгэлт нэрийг ийнхүү мөр тэтгэж бичсэн тэр үеийн баримт гэвэл «Чингисийн чулууны бичигт»: Чинггис хан-и сартагул иргэн дагулижу багужу... гэх зэргээр мөр тэтгэн бичсэн байх бөгөөд мөн Өлзийт хааны бичигт:

Ман-у сайин
Элинчик сайин
Эбүгэ сайин... гэх зэргээр мөн мөр тэтгэн бичсэн явдал болно. Үүнд энэ бүхэн нь уг бичгийн гарчиг бус, харин онцлон хүндэтгэсэн үгийг цохон тэмдэглэсэн арга хэрэглүүр болох нь илэрхий байна.

6. **Дэгэр-э тэнгри-эчэ жайагату** (Дээр тэнгэрээс заяат)—гэсэн энэ үг нь бидний бодлоор Чингис хааны удмын тэнгэрлэг гаралтайг хүслэнчилэн магтах гэсэн зүйл бус ер нь бөө мөргөлт нүүдэлчин монголчуудын ертөнцийг үзэх үзлийг илтгэсэн зүйл гэж үзнэ. «Дээр тэнгэрээс заяатай» гэдэг нь дээр тэнгэр нарын тив, дундах хүний болон адгуусны тив доор луус (луус) савдгийн доод тив байдаг гэх үзэл, түүнчлэн хүн бол дээр ахуу тэнгэр нараас тодорхойлсон заяагаар, мал адгуус бол газар тэнгэрийн заяагаар төрдөг гэсэн үзэл тусгагдсан шиг санагдана. (10, 27—35 дугаар т. үз).

7. **Төрэксэн** (төрсөн)—гэдэг үгийг хятад галигаас нь олонхи судлаачид түүний дотор Өвөр Монголын судлагч Баяр гуай ч (11, I, 1) «төрэксэн» гэж сэргээн бичээд ард нь хуучин монгол бичгээр «төрүксэн» гэж бичжээ. Нууц товчоог анх бичсэн эртний худам монгол бичиг үгийн эгшиг уруулаар зохицох ёс монгол хэлэнд үүсээгүй байх үед автсан учир эртний монгол бичгээр бичигдсэн уг эхэд «төрэксэн» гэж байсан гэж үзэж ийнхүү бичсэн болно. Энэ мэтээр үгэнд орсон эгшиг үсэг (авиа) тэр үед дан ганц эр эм эгшиг буюу хэлний байдлаар зохицож бичигдэг байсан гэж үзэж олон үгийг үүний адилаар буулгасан болно.

8. **Бөртэ-Чинб-а** (Бөртэ Чоно) бөрттэй (буюу бор толбот) хөх чоныг хэлсэн үг бөгөөд эл «бөртэ» гэдэг үгийг монгол хэлэнд эгшиг хэлний байдлаар төдий бус, бас уруулаар зохицох ёс гарснаас хойш «Бөртү» (12, 294 б т.) гэж бичигдэх болжээ. Энэ бол бидний бодлоор уггаа жинхэнэ түүхэн хүн бус, харин монголчуудын гарал үүслийн домог-үлгэрийн онгон амьтны нэр байж магадгүй. Гэвч нөгөө талаар тэр гарал үүслийн онгон шүтээний нэрээр нэршсэн түүхт хүн байсан байж болохыг бас эрс үгүйсгэх аргагүй.

9. **Хубай-Марал**—гэдэг нь Ухаа Марал (эм буга) гэсэн монгол үг бөгөөд Марал гобай (Марал-гуа) гэсэн үг биш юм. Хожим үеийн монгол хэ-

лэнд марлыг согоо гэж хэлдэг болсон боловч Марал гэдэг нь бүр эрт монголын домог-үлгэрийн цагт согоог нэрлэж байсан үг байх. Гурван марал одны үүсэл гарлын домог-үлгэрт энэ нэрийг хэрэглэсэн нь (13, 34—37) үүний баталгаа болно. Ухаа-Марал гэдэг энэ нэр ч мөн Бөртэ Чоныи онгон шүтээн амьтны нэр болохыг давхар батлах мэт.

10. **Ажихай** (ажээ)—гэдэг бол эртний монгол бичигт үйл үгийн хүйс ялган хувилдаг хувилал байсны гэрч болсон зүйл бөгөөд энд а-(байх гэсэн утгатай) үндэст үйл үгийн өнгөрсөн цагийн эм хүйс заасан хэлбэр нь болно. Бөрт Чоно «ажуху» гэдэг нь эр хүйс заасан өөр хэлбэр нь мөн байна. Худам буюу язгуур монгол бичигт үйл үг хүйс ялган заах хэлбэртэй байснаараа сонгодог (хуучин) монгол бичгээс нэг гол ялгаатай байжээ. Бид эхийг сэргээхдээ энэ онцлогийг харгалзан тусгахыг хичээсэн билээ.

11. **Тэнгис** (Тэнгис) —гэдэг нь гадаад далайтай гол мөрнөөс өөр усаар холбоотой их усны (буюу дотоод далайн) нэр юм. Нууц товчооны энэ үгийг эрдэмтэд судлаачид олонхидоо «тэнгис» (внутреннее море) (14, 79), тэнгис буюу нуур (15, 1, 9, 121) гэх мэтээр орчуулсан байна. Зарим нь их далай буюу их тэнгис, Каспийн далай. Мөн (8, 4—5 дугаар нүүрийн тайлбарыг үз). Тэнгис гэдэг нь үнэхээр нэг голын нэр байх гэсэн Х. Пэрлээ, Элдэндэй Ардажав нарын саналыг зөв гэж үзэж байна. Учир нь Хорилардай мэргэн ангийн шинэ газрыг нээж Бурхан халдунд ирсэн мэт зүйл нь анчны аж төрөлтэй эрт балар цагийн нөхцөлд үнэхээр нэг өөр тивийг нээсэнтэй адил чухал нээлт байсан тул Бөртэ Чоныи Хөвсгөлийн Тэнгис голыг гэтэлж Бурхан халдунд ирсэн нь мөн ч түүнэнд тэмдэглэх их нүүдэл мөн байсан байж ч болно.

12. **кэтүлжү** (хэтэлж)—гэдэг нь орчин цагийн монгол хэлэнд «гэтэлж» гэсэн үгийн эртний бичлэг мөн. Энэ үгийг чухамхүү гол мөрний цаана хэтрэн гарсанд холбогдуулан хэлдэг тул Бөртэ Чоно, Ухаа марал хоёрын гэтэлсэн ус нь далай буюу тэнгис бус, харин гол байсныг энэ үгийн бичлэг давхар баталж байна. Учир нь «Тэнгис» гэдэг үг голын нэр бус, тэнгис буюу далай байсан бол энэ үгийн оронд «гадалжу» (гаталж) гэсэн үг байх учиртай шиг санагдана. Юу гэвэл «гадалж» гэдэг үг бол их ус (далай тэнгис) дотроос гадна талд нь гарсан гэсэн утгатай юм.

13. **Онан** (Онон)—голын нэрийг монгол хэлэнд эгшиг уруулаар зохицох ёс хараахан гараагүй байсан үед авсан эртний монгол бичигт энэ голын нэрийг ийнхүү Онан гэж бичиж байжээ. Хожим монгол хэлэнд уруулаар зохицох ёс гарснаас хойш Онун гэж бичдэг болж улмаар **Онон гэж дуудах болсон болов уу гэж энэ үгийг эртний монгол бичгийн хэлбэрээр нь Онан гэж бичив.**

14. **Бурхан халдун-а**—гэсэн үгийн «Бурхан» гэсэн нь үнэхээр бурхан (тэнгэр бурхан) гэсэн утгаар хэрэглэгдсэн байж болно. Учир нь энэ үг энд «бурхан босхагсан» гэсэн хүний нэр [Э. Хэниш (15, 2) П. Пеллио 9, 122) Л. Лигети, (16, 10) П. Поуха (17, 12)] биш, харин хүний үйл (18 с, 1, 82; Ц. Дамдинсүрэн, Элдэндэй Ардажав) заасан үгтэй холбогдож байгаагаас энэ нь ил байна. (10 94—111 дүгээр талд үз). Нөгөө талаар Монголын зарим түүхчин (19, 77—82 дугаар т.) бурхны шашин Монголд бүр эрт цаг Монголын Хүн улсын үеэс дэлгэрч байсны баримтыг олж тогтоосон байх тул энэ үг эл утгаар хэрэглэгдсэн байхад гайхах явдалгүй.
«Халдун» гэдэг үгийг зарим судлаач «Бурхан хад уул» (8, 5—6 дугаар нүүр) гэх буюу эсвэл «Бурхан (шүтээн) уд бургас» гэж зарим эрдэмтэн (20, 188—191) тайлбарласан. Олонхи нь газар орны тусгай нэр гэж үзэж ирсэн боловч бидний бодоход халдун гэгч тахилга оршуулгатай газрын ерөнхий нэр бололтой. Учир нь «МНТ»-ы (§164) зүйлд «Би бэр өтүлбэ, Нама-йи өтүлжү өндүд-э (өндөр газарт) гарбасу, хагучидба би. Хагучитчу халдуд-та гарбасу» гэсэн үг гарч буйн доторх «халдуд-та» гэдэг үг бол «оршуулгын газар» гарвал гэсэн утгатай байна. Тийм газар нь өндөр газар байжээ.

15. **Нунтаглажу**—гэсэн нь орчин цагийн монгол хэлний «нутаглаж» гэдэг үгийн эртний монгол бичлэгийн хэлбэр мөн гэж болно. Бидний бодлоор бол эртний монголчууд нутаглан суусан газраа анх «нунтаг» (шороо) гэж нэрлэж байжээ. Хожим түүнээ «нүүг» гэж нэрлэх болжээ. Иймээс монгол хэлэнд эгшиг уруулаар зохицох ёс гарахаас өмнө авсан худам (язгуур) монгол бичигт «нунтуг» биш «нунтаг» гэж бичиж байснаар төсөөлж ийнхүү сэргээв. Харин хятад галиг эхэд үүнийг XIV зууны аман аялгууны байдлаар «нунтуглажу» гэж тэмдэглэсэн нь тэр үед Монгол хэлэнд нэг үгийн доторх эгшгүүд уруулын байдлаар зохицох ёс нэгэнт гарсан байсны улмаас болсон гэж бодогдохоор байна.

16. **Бадачи-хан**—гэдэг «Ба+да+гийн (бидний буюу манай) хан» гэсэн утгатай эртний монгол үг мөн. Балар эртний монголчууд нийгэм, байгаль, хүн, адгуус тэргүүтнийг ялгаж ухамсарладаггүй байсан үедээ зөвхөн өөрсдийгөө «күмүн (хүн)» гэж ялган нэрлэж бусад овогтон

аймгийг **байгалийн** нэг хэсэг адгуус мэтээр боддог байв. Хожим бусад аймаг овогтон ястан үндэстэн ч мөн л бидний адил хүн мөн юм байна гэдгийг ухамсарласан үедээ өөрсдийгөө тэднээс ялгахдаа «Ба» (бид) улс гэж нэрлэх болсон бололтой (Үүнд холбогдуулан энэхүү тайлбарын 1 дүгээр зүйлийг үз).

Иймд бид энэ үгийг «Батучаган» «Батачихан» гэж сэргээхийг оновчтой биш гэж үзэж «Бадачи-хан» гэж бичив. Энэ үгийн утгыг бидний бодлоор ийнхүү тайлбарлах үндэстэй (21, 17б; 22, 35—37; 23, 72) бөгөөд «МНТ»-нд энэ мэтээр овог, яс, аймаг, үндэснийхээ ерөнхий нэрийг түүхэн нэг хүний нэр болгон домгийг түүхчилэх хандлага цөөнгүй илэрсэн байдаг билээ.

17. **Тамача**—гэсэн үг энд хүний зөвхөн нэр мэт харагдавч угтаа «Тамгачи» гэсэн тушаалын нэр байж бас магадгүй юм.

18. **Хоричар мэргэн**—гэсний «Хоричар» гэсэн хэсэг нь Хори овгийн жижиг салаа салбарын нэр байх гэж бодож байна.Нөгөө «мэргэн» гэдэг нь нум сумаар сайн онож харвадаг гэсэн утгатай үг бөгөөд анчны аж төрөлтэй овгийн нөхцөлд овгийн толгойлогчийн цол байсан бололтой. Иймд энэ нь «Хори овгийн бяцхан толгойлогч» гэсэн утгатай нэр байж болох юм.

19. **Агужин Борухула**—гэснийг зарим судлаачид «Агужим Бугурал (Уужим Буурал)» [Ц. Дамдинсүрэн (7, 25), Х. Дугаржав (24, 1)] гэж, зарим нь А'ужам боро'ул [Пеллио, (9, 5); Рахевильз (25, 13),: Т. Дашцэдэн 26, 10)], зарим нь Агужам Борохул [Баяр (11, I, 2), Мансан (27, 8); Элдэндэй Ардажав (8, 6); Иринчин (28, 4] гэх мэтээр янз бүрээр бүүлгажээ. Гэвч бид Агужин Бугурал (Уужим буурал) гэсэн үг бус, харин Монголжин-гуа, Чагужин Ортагай гэх мэтийн адил Агу+жин бүтэцтэй үг бөгөөд Борухула гэдэг нь «Буурал» гэсэн үг бус үлгэр-домгийн Хара-хула (хүн гөрөөс) гэх мэтийн зэрлэг араатны зүсээр нь нэрлэсэн нэр гэж үзэж ингэж галиглав. Эхнийх нь уул хүний буюу овгийн нэр, сүүлчийнх нь адилтгасан хоч нэр байж ч болно. Агужин гэдгийн дараа «Б» авиагаар эхэлсэн үг орсны нөлөөгөөр «н» нь «м» болж, хэлж галиглуулагчийн тэр (XIV зууны) үеийн аман аялгууны нөлөөгөөр -жим биш -жам гэж тэмдэглэгдсэн гэж төсөөлж «Агужин» гэж бичив.

20. **Боржигидай**—гэдэг Боржигин овгийн хүн гэсэн утгатай монгол үг юм. «Нууц товчоон», хятад, персийн түүхэнд Боржигин овгийг Бодончараас үүсч гарсан гэж бичдэгийг Боржигидай Мэргэн гэдэг нэр нялцааж байгаа буюу, адаглаад, эргэлзээтэй болгож байна. Учир нь гэвэл энэ овгийг үүсгэсэн гэх Бодончараас хоёр үеийн өмнө Боржигидай мэргэн буюу «боржигин овгийн хүн» гэсэн нэр дурдагдаж байгаа нь Бодончараас өмнө Боржигин овог байсны баримт мөн. Жич энд Боржигидай мэргэн гэж дурдагдаж байгаа нь Баргужин төхмийн эзэн Баргудай мэргэн, Хори түмдийн ноён Хорилардай-мэргэн гэдэг шиг Боржигин овгийн тэргүүлэгч учраас ч анчны аж төрөлтэй овгийн тэргүүлэгчийн «мэргэн» (оноож харвадаг) цолтой байжээ гэж бодмоор.

21. **Монголжин**—монгол овог аймгийн эмэгтэй гэсэн утгатай монгол үг юм. Монгол (1 дүгээр тайлбарыг үз) гэдэг үгийн үндсэнд эм хүйс, энхрийн аяс илтгэх-жин дагавар залгаж бүтээжээ. Монголжин гуагийн үед монгол гэдэг нь овгийн нэр төдий байжээ.

22. **гобай**—гэдэг нь орчин цагийн монгол хэлний «гуалиг сайхан» гэдэг үгийн эртний бичлэг мөн. Энэ үгийг монгол хэлэнд урт эгшиг үүсч гараагүй үед автсан худам (язгуур) монгол бичигт зөвхөн хүйс ялган эр хүнд «гоба» («МНТ»-ы 172 дугаар зүйлд, Толуй өөрийгөө «Нигур гоба» гэжээ) эмэгтэй хүнд «гобай» гэж ялган бичиж байснаас зайлахгүй.

23. **Дуба-сокур**—гэдэг нь түүхт хүн бус, үлгэр домгийн гаралтай уран дүр бололтой. Учир нь энэ хүний нэр хятад персийн зохиогчдын Монголын түүхэнд ер дурдагддаггүй юм. «Дуба» гэдэг үг бидний бодлоор «Аваргасун» гэсэн утгатай монгол түрэгийн гаралтай эртний хуучирсан үг бололтой. Учир нь Киргиз-орос толь бичигт «Дөө» гэсэн дуудлагатай «аваргасун» (великан) гэсэн утгатай үг тохиолдож (29, 214) байна.

Нөгөө «сокур» (сохор) гэдэг үг эртний монгол түрэг хэлэнд юм үздэггүй хараагүй гэсэн утгагүй, харин «ганц нүдэт» гэсэн утгатай үг байжээ. Энэ үг ийм утгатай байсныг зарим монголч эрдэмтэн Амбагай хааны хүү Хадаган тайжийн түүхийн зарим бичигт «Хадаган сохор» гэж бичсэн байдгаар баримт болгон тайлбарласан. Үүнд: • Хадаган тайж Мэргэд аймгийн Тудур-билгэ-тигинд найрамдан хамт явж энх амар аж төрье гэж элч илгээсэнд Тудур-билгэ элчийн үгэнд хариу хэлэхийн оронд хутга билүүдсээр дуугүй суужээ. Элч гайхаж учрыг асуувал «Хадаган андын үлдсэн ганц нүдийг ухаж өгье гэж хутга билүүднэ би» гэсэнд Хадаган тайж гомдож цэрэглэн ирж түүнийг амьдаар бариад «Урьждар чи амаараа (ганц) нүдний минь ухсан. Өнөө-

дөр бн чинийхийг (нүдийг) гараар ухъя» гэж нүдийг ухаж түүнийг алсан тухай түүхч Рашид-ад-Дин (4, т. 1, кн. 2, с. 37—38) бичжээ. Хадаган тайж тулалдааны үед өрөөсөн нүдээ суманд автаж ганц нүдтэй болсон тул «Хадаган Сохор» гэгдэж байсан нь бариmттай билээ. Жич, Якутын «Эр сохотогийн туулийн гол баатар Эр Сохотог Баруун Монголоос Якутад очиж нэг баяныд зарцлагдаж байгаад юманд нь эзэн сууснаар гарах бөгөөд нэр нь «Эр ганц» (30, 299). Ганц ч үлдэлгүй дутахыг монгол хүн «сох дутав» гэдэг нь үүнтэй холбоотой байх.

Иймд Дуба-Сохор гэгч түүхт хүн бус, Өрнө (Полифейн домог-үлгэр) Дорно (Лаларын үлгэр) дахинд түгээмэл дэлгэрсэн домог-үлгэрийн дүр мөн боловч «МНТ»-нд түүнийг түүх чилж түүхэн хүн шиг болгохын ялдамд Добу-мэргэнд Алун-гуаг гуйж гэргий олох зохиомол аян шалтаг уран хэрэглүүр болгон оруулж өгүүлэгдэхүүнийг зангидан үйл явдлыг хурцатгажээ.

24. **Добу-мэргэн**—энэ үгсийг хятад галиг үсгээс олонхи эрдэмтэн судлаачид (Ц. Дамдинсүрэн, Мансан хоёроос бусад нь) цөм «Добун» гэж сэргээсэн боловч бид дараах «мэргэн» гэсэн үгийн эхний авианы нөлөөгөөр Добу гэдэг үгийн эцэст «н» байгаа мэт хятад үсгийн галиглагчид болон эрдэмтдэд сонстсон учраас тэд ташаа тэмдэглэсэн гэж үзэж Добу гэж сэргээн буулгасан билээ. Жич Монголын түүхчид: Лувсанданзан (31, 7) Н. П. Шастинагийн нийтэлсэн Шара туджи-(32, 22); Шамба (6, 9) цөм Добу мэргэн гэж бичдэг уламжлалтай юм. Энэ бас Тобу буюу Тоба мэргэн гэсэн үг ч байж магадгүй юм.
25. **Нэгүрид** (нүүдлүүд)—Энэ үгийг нүүдэл гэсэн утгатай нэгүри гэсэн хуучирсан Монгол үгийн олон тооны хэлбэр гэж үзэж ийнхүү сэргээв. «Нэгү+ри» гэсэн бүтэцтэй энэ үг угтаа сагу-ри буюу «суурь» гэсэн үгтэй ижлээр бүтжээ. Нэр үг ба түүний хуртээл нэрийн хоороnд олон ба ганц тооны зохицол эртний монгол аман ба бичгийн хэлэнд шинж төрс байсны нэг нотолгоо нь энэ болно. Нэгүри+д гэж олон тооны нөхцөл залгасан нь түүний өмнөх «гурван» гэсэн тооны хуртээл нэртэй зохицуулсны баримт юм. (8, 11—12).
26. **Дэгү** (дүү)—гэсэн энэ үгийг монгол хэлэнд урт эгшиг үүсээгүй байсан эртний худам (язгуур) монгол бичигт ингэж бичиж байсан гэж төсөөлөн сэргээн буулгав. Энэ үгийг судлаачдын олонхи «дэ'ү» гэж [Пеллио, (9, 5), Л. Лигети (33, 16), Рахевильз (25, 13)] эсвэл «дэгүү (дүү) гэж [Дугаржав, (24, 2) Мансан (27, 8) г. м.] зарим нь хожмын хуучин бичгийн бичлэгээр буулгасан юм. Бид Лувсанданзаны Алтан товч (31, I, 8) Баяр (11, I, 6) зэрэг эрдэмтдийн буулгасныг эртний монгол бичгийн зөв бичлэг гэж бодож байна. Үүнийг бас «дүү» гэдэг үгийг XIII—XIV зууны худам монгол бичгийн дурсгал гэгдэх Алтан ордоны үйсэн дээр бичсэн бичигт (34, 111) «Ах-а дэгү эчирэ күрбэ» гэсэн мөр шүлэгт «дэгү» гэж задгай үеэр төгсгөн бичсэн баримт давхар баталж байна. Иймд энэ нь монгол хэлэнд урт эгшиг хоёр эгшгийн хоорондох «г» гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг нь ижилсэн нийлэх загвараар үүсч гарсны нэг баримт болно. Учир нь монгол хэлэнд «урт эгшиг бүрэлдэх нөхцөл тогтсон...» (35, 20—30) байдал энэ үгийг бичигт байснаар нь биш, дүүдэн үншигч болон галиглагчийн сонссоноор буюу XIV зууны эцсийн монгол хэл аялгуунд тэмдэглэгдсэнээр нь «дэ'ү» буюу дэү (26, 11 дүгээр) гэж галигласан явдал нууц товчооны зохиогдсоноос хойш 150 орчим жилийн дараах монгол хэл аялгуунд үгийн гийгүүлэгч сугараад хоёр талын эгшгүүд нь хараахан ижилсэн урт болж амжаагүй байсныг тодорхой харуулж байна.
27. **Түнгкэлик**—гэгч нэг горхины тусгай нэр юм. Сүүжний ясны хонхор мэт тойрны уулсын доторх хонд хонхор дотор үрсах усыг «түнгкү» (12 635 дугаар т. үз)-тэй зүйрлэн ингэж нэрлэсэн байж болох юм. Эртний монгол бичигт эгшиг уруулаар зохицох ёс гараагүй үед «Түнгкэлик» гэж бичиж байгаад хожим уруулаар эгшиг зохицох ёс гарсан үед «Түнгкүлик» гэж бичдэг болсон байх гэж санамаар.
28. **Нэгүжү айисухун** (нүүж айсхун)—гэдэг үг энд олон хүний хүран цугласныг заасан утгатай буюу эсвэл «иргэ (ганц тоот нэр) +н (олон тооны нөхцөл)» гэсэн бүтэцтэй учир түүний хийж буй үйлийг заасан айсах гэдэг үйл үг (түүний үйлт нэрийн одоо цагийн хэлбэр) нь мөн олон тооны хэлбэртэй бичигдсэн байна. Үүнд үйлдэгч ба үйлийн хооронд тоогоор зохицдог зохицоо эртний монгол хэл ба бичигт байсны тод жишээ энэ болно. «Айисухуй»-гэдэг энэ үйлт нэрийн олон тооны хэлбэр нь «айисухун» гэдэг үг болно. Сур+т+хуй «Их суртахуй бичиг» гэдэг номын нэрэнд ганц тооны хэлбэрээр бичигдэж үлдсэн бол «ёс суртахуун» гэсэн үгэнд олон тооны хэлбэрээр үлдсэнийг баримт бөгөөд энэ үгийг үйлт нэрээс үүсэгүй харин сур+тахуун гэсэн бүтэцтэй гэж буруу таниад «сурт» гэж хэлэгдэх үйл үгийн үндэс байхгүй тул «-тахуун» буюу «-хуун» гэсэн дагавар гэж үздэг хэл шинжлэлтэн нар энэ үгийг хэлбэрийг анхаарах нь чухал биз.

29. **Харагутай—гэсэн энэ үгийн хятад хадмал орчуулгыг Э. Хэниш (36, 60) «хар тэрэг» гэж тайлжээ. Иймээс Ургахуйгаас Шингэхуй дахины** эрдэмтэд их төлөв «хар тэрэг» гэж ташаа орчуулсан бөгөөд Лувсандансан шикур буюу шүхэр гэж, Ц. Дамдинсүрэн «тэргэн-ү мухулаг» буюу мухлагтай тэрэг гэх зэргээр тайлбарласан буюу ухаарч орчуулсныг зөв гэж үзэж «харагутай» гэж буулгав. Тэгэхдээ энэ үг хара (үйл үг)+гу (дагавар)+тай (тэмдэг нэр бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй монгол үг байж болмоор боловч зала+гу (залуу), тара+гу тарагу (тараруу) гэдэг загвараар бүтсэн үг гэхэд утга нь төдий л тааралцүй мэт. Хара (өнгө)+гу (жааз)+тай гэсэн бүтэцтэй монгол үг мөн бөгөөд хар исгий (эсгий) бүрээстэй модон жааз (гуу)-тай (ө.х., мухлагтай) гэсэн утгатай үг гэж санаж байна. Энэ үгийн «гу (гуу)» гэсэн II үгийн үндсийг түрэг хэлний у(у) буюу «Дээрээ исгий бүрээстэй хийсэн монгол гэрийн жийаса» гэсэн үгтэй холбож тайлбарлах (8, 13) явдал төдий л үндэстэй биш юм. Учир нь хара-гэсэн өнгө заасан монгол үг дээр у гэсэн түрэг үг нэмж нийлмэл нэр зохиосон биш, харин гу (жааз) гэсэн монгол үг нэмж «хар бүхээгтэй» гэсэн үг бүтээсэн гэвэл илүү үнэмшилтэй юм.

Хар тэрэгний талаар Марко Поло бичихдээ «Тэдний (монголчуудын —Ш. Г). хар эсгийгээр бүрхэгдсэн бөгөөд өдөржин бороо орсон ч тэргэн доторх юм нормохооргүй сайн бүрэгдсэн байдаг» (37, 88) гэх буюу эсвэл «Түүнээс гадна тэд (монголчууд -Ш. Г.) цуулсан жижиг цууд-саар (саваагаар) авдарын хэмжээтэй дөрвөлжин чингэлэг хийж урд урд талд нь бага шиг хаалга гаргаж, өөхөн тос, хонины сүү нэвт шингээж бороо нэвтрэхгүй болгосон хар эсгийгээр өнөөх чингэлгийг бүрж, эрээн нэхмэлээр буюу үслэг эдээр мөн адил чимэглэн, тэр чингэлэгтээ бүх эдлэл, агуурс баялгаа хийж, өндөр тэргэн дээр бэхлэн тэмээ хөллөн эдгээр чингэлгийг зөөж явах бөгөөд гол гаталсан ч болно» гэж (38, 191—192) бичжээ. Гэвч эд баялгаа хадгалах хар тэрэгнээс гадна Харагутай тэргэнд тэмээ хөллөөд эмс охидоо суулгаж явдаг байжээ. (39, 15) Иймд «харагутай» тэрэг гэдэг нь ерөнхийдөө хар «бүхэгэгтэй» (12, 295б) буюу «Мухлаг бүрээстэй тэрэг» (8, 13) байжээ.

30. **Өлжигэ-д-э**—гэдэг нь тэргэний өмнөх тал (36, 123) суудал (39, 15 дугаар т.) гэсэн үг юм. Тэргэний мухлагийн өмнөд хэсэгт охидыг суулгах өндөрлөг «суудал бүхүй» гэсэн утгатай үг бололтой. Өлжигэ гэдэг үг э эгшгээр төгссөн тул тийм үгэнд өгөх оршихын тийн ялгалын -э нөхцөл дагуулахдаа хоёр эгшгийн хоорондх -д-гийгүүлэгч жийрэглэн хэлдэг ёс XIV зууны монгол хэлний зарим аялгуунд байжээ. Монгол бичгийн ёсоор бол уг эхдээ «өлжигэн-э» гэж бичсэн байсныг галиг хийхэд нь уншиж өгсөн хүн өөрийн аялгаар өлжигэ-д-э гэж хэлж өгсөн болов уу гэж бодож болмоор санагдана.

31. **Өктэксэн** (өгөгдсөн)—гэдэг бол өк+т+ксэн гэсэн бүтэцтэй монгол үг юм. Үүний «-т-» нь өк (өг) гэсэн үгийн үйлдэгдэх хэвийн нөхцөл мөн бөгөөд «ксэн» гэсэн залгавар нь орчин цагийн монгол хэлэнд сан сэн сон сөн гэсэн дөрвөн хувилбарт үйлт нэрийн өнгөрсөн цагийг заах залгавар болно: Үйлт нэрийн үйлдэгдэх хэвийн «-т-» ховордох хандлагатайн дээр -гсан -ксэн гэсэн хэлбэр нь олон тоогоор хувилахдаа «өктэксэд» гэх мэтээр хаягдсан г (к) нь сэргэж бичигддэг билээ.

Хуучин монгол бичгийн хэл найруулгад үйлдэгдэх хэвийн нөхцөлийг бараг хэрэглэдэггүй байсан гэж зарим эрдэмтэд батлан өгүүлдэг боловч «МНТ»-ы үг найруулгад энэхүү үйлдэгдэх хэвийн нөхцөлтэй үг их олон тохиолддог нь саях саналын эсрэг хандсан баримтууд болно. Жишээ нь 1305 онд Чойжи-Одсэрийн орчуулсан номд «сайин нөкүр багши-йи абурида амин-даган күртэбэсү бэр үлү тэбчикдэкүй» (40, 55) гэж бичсэний дотор «күртэбэсү, тэбчикдэкүй» гэсэн хоёр үг үйлдэгдэх хэвийн «-т» «-кд» нөхцөлтэй байна. Нууц товчоонд хар-а тэригүн-дүр ийэн күртэкү болба» гэх буюу «халх-а кэн-э болдаху» (126, §111, 850—852 дугаар мөр) гэх зэргээр олонтаа тохиолддог билээ.

32. **илэбэ** (илгээв)—илгээв гэсэн утгатай энэ үг худам монгол бичигт **ийнхүү богино э эгшиг үсэгтэй бичигдэж байсны гэрч мөн. Энэ мэтээр** хуучин монгол бичигт богино эгшигтэй бичигддэг үгс хожим урт эгшигтэй хэлэгдэх бичигдэх болсныг зарим эрдэмтэн (Жишээ нь Широ Хаттори) тэр үгийн аль нэг үеийн «анхнаасаа (угаасаа) урт» дуудлагатай байснаар тайлбарласан юм. Харин бид энэ тохиолдлыг Монгол хэлэнд задгай үеэр төгссөх үг уртаар дуудагддаг жам ёсноос уртатгалтай болсон гэж санаж байна. Үүнд илэ гэсэн энэ үгийн төгсгөлийн -лэ- гэсэн задгай үе нь уртаар дуудагддаг байснаас үүнийг сонгодог монгол бичигт илэгэбэ гэж уртатгал үүсгэсэн хоёр эгшгийн хоорондоос гийгүүлэгч сугарахын үлгэрээр уртыг нь тэмдэглэх болжээ гэж ойлгож байна. Хойшид тохиолдох ийм урт эгшигт үгийг энэ тайлбарт хамааруулан заая.

33. **Хүрбэсү** (хүрвээс-хүрвэл)—гэдэг үгийг хуучин монгол бичигт ингэж тэмдэглэдэг нь эртний монгол бичгийн уламжлал мөн гэж үзэж ийнхүү сэргээн босгов. Хятад галиг эхэд «хүрү'эсү» (9, 1)

буюу эсвэл «хүрүэсү» (26, 11) гэх зэргээр тэмдэглэсэн нь худам монгол бичгийн эхийг уншиж өгсөн хүн болон түүний аман аялгууг сонсож хятад үсгээр галиглагч хоёрын нөлөөгөөр ташаа бичигдсэн зүйл гэж үзэв. Учир нь энэ XIV зууны монгол хэлэнд үгийн дунд тохиолдсон «б» гийгүүлэгч авиа у буюу ү эгшиг авиатай ойролцоо буюу «в» авиа болж ирсэн учир эртний худам (удам буюу язгуур) монгол бичигт үгийн дунд б үсгээр тэмдэглэгдэж байсан авиа у, ү авиа буюу «в» авиа шиг сонсдох болсон тул хятад үсгийн галигаар болбасу гэсэн үгийг болу'асу гэж тэмдэглэсэн бололтой. Эртний монгол бичгээр байсан «МНТ»-ы нэг өөр эх гэгдэх Лувсанданзаны «Алтан товчид» энэ үгийг «хүрбэсү» (31, I, 8) гэж бичсэнийг эртний монгол бичгийн зөв бичлэг гэж ийнхүү сэргээв.

34. **Йэкэ-тэй** (ихтэй)—гэсэн энэ үг бол йэкэ+тэй гэсэн бүтэцтэй бөгөөд үгийн үндсээр илэрсэн чанар шинжийг эзэмшсэн утгатай харьцангуй нэр бүтсэн байна. Нууц товчоонд ийм харьцангуй нэрийг эм хүйсэнд -тай тэй, эр хүйсэнд -ту -тү залгавар залгаж хэрэглэдэг байсны баримт нь энэ болно. Алдар нэр «ихтэй» гэсэн харьцангуй нэр Алун-гуа гэсэн эм хүйсэнд хамаарагдах учраас -тэй дагавартай бичигджээ.
Гэтэл эр хүйс-Торголжин баянд холбогдсон Борогчин гуа «гэргэй-ту», Боролдой, Суйулби «жалагу-ту» Дайир Бору хойар күлүк-уд «агтас-ту» (3§) гэх мэтээр ямагт «-ту» «-тү» хувилбарт дагавар хэрэглэсэн байна. Иймд харьцангуй нэрийг ингэж хүйс ялган хэрэглэдгээрээ эртний худам монгол бичиг хуучин (сонгодог) монгол бичгээс ялгаатай байжээ.

35. **Алун-гобай**—гэсэн хүний нэрийг хятад галигт «Алан» (9, 1; 11, 1, 9) гэж бидний бодлоор ташаа буулгаснаас зарим эрдэмтэд (Х. Пэрлээ «Нууц товчоонд гардаг «Алан» гэдэг үгийн учир» (41, 25) «алан» гэгч «бүрэн бүтэн», гоо сайхан гэсэн утгаар эндүү тайлбарлажээ. Монгол эмэгтэй хүний нэрд залгаж овгийн хамаарлыг заадаг-лун -лүн залгавар байдгийн дээр нууц товчооны эртний монгол бичгийн эхтэй байсан гэгддэг түүхч Лувсанданзан (31, 8), Ц. Дамдинсүрэн, (7, 26) Дугаржав (24, 3), Мансан (27, 4) нарын буулгасан эхийг баримтлан Алун гэж сэргээн буулгасан бөгөөд зөв гэж бодож байна. Гобай-энэ үгийн талаар 9 дүгээр тайлбарыг үзмүү.

36. **иргэн-бэр**—гэсний «-бэр» гэсэн нь юмыг онцлон цохож хэлсэн утга оруулдаг сул үг юм уу гэж үзэж «бэр» гэж бичив. Үүнийг Элдэндэй Ардажав (8, 16) «өгүүлэгдэхүүний илтгэгч үг» гэж тайлбарлажээ. Гэвч энэ «бэр» гэдэг онцлох сул үг тэр бүр өгүүлэгдэхүүний илтгэгчийн үүргээр хэрэглэгдэггүйг өмнөх 7 дугаар зүйлд байгаа «күмүн-э бэр өгтэгэ эдүй» гэсэн үг харуулж байна. Хүнд ч бас өгөгдөөгүй гэсэн утгатай нь энд ил байна. Энэ үг биеэ даасан үг учраас ямагт «бэр» гэсэн эм үгийн байдлаар бичигдэнэ.

37. **көл** (хөл)—гэсэн нь гол мөрний адаг гэсэн утгатай монгол үг юм. Гол урсгалынхаа адагт гулдрилаа байн байн өөрчилж нуур үүсгэх учир түрэг хэлэнд «көл» буюу «күл» гэсэн үг «нуур» гэсэн утгаар хэрэглэгддэг бололтой.

38. **Хорилардай**—«Хори нарын (овгийн) хүн» гэсэн утгатай үг бөгөөд «-лар» гэдэг нь түрэг хэлний олон тооны нөхцөл, монгол хэлний «нар» гэсэн олон тооны нөхцөлтэй адил утгатай юм.

39. **Ариг**—Энэ нь «аригун» гэдэг монгол үгийн үндэс мөн бололтой бөгөөд түрэг хэлний зохих утгатай тохирч байж болох юм.

40. **Гоба-д-ача**—гэсэн нь үнэн чанартаа гобай (гуа)-ача (гуагаас) гэсэн утгатай үг бөгөөд эртний монгол бичигт эгшгээр төгссөн үгэнд эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад -д, -т, г, н, гэх мэт ямар нэгэн гийгүүлэгчээр жийрэглэн бичдэг дүрэм байсныг харуулж байна.

41. **Хорилалдужу**—гэсэн энэ үгийн бүтцийг хори+(үгийн үйл үндэс) +ла (олон удаа үйлдэх байдлын нөхцөл) +лд (харилцан эсрэг үйлдэх хэвийн нөхцөл) +жу (нөхцөл үйлийн зэрэгцэх үйлийн хэлбэр) гэж үзэж хятад галигт [П. Пеллио (9, 9) Т. Дашцэдэн (26, 11) болон бусад] («хорилалдужу» гэж, зарим нь) [Элдэндэй Ардажав (8, 18), Мансан (27, 4)] «хориглалдужу» гэж сэргээн босгожээ. Баяр гуай эртний монголоор «хорилалдужу» хуучин монгол бичгээр «хориглалдужу» (11, 1, 12) гэж буулгажээ. Ц. Дамдинсүрэн «хориглан булийалдажу» (7, 26) гэж орчуулжээ.

Хориглалдаж гэдэг нь үнэн зөв бол энэ үг хори+г+ла+лд+ж гэсэн бүтэцтэй үг байж бас болох юм. Энэ тохиолдолд хориг гэсэн нэрээс -ла залгавраар үйл үг бүтээсэн гэж болох юм.

42. **Гөргүүли** (гөргүүл)—агнуур гэсэн утгатай энэ үгийг уг хятад галиг эхэд бодвол «гөрү'үли» (9, 6) гэж тэмдэглэсэн бололтой. Энэ үгийг Пеллио «зэрлэг» (9, 122), Кливз (42,2) «ан», Хэниш (15, 2) «Ангийн газар» Лувсанданзан (31, 9) «гөрөөс», Дамдинсүрэн (7, 26) Дугаржав (24, 3) «ан гөрөөс» гэж, Мансан (27, 4) «ан гөрөө», Рахевильз, Иринчин орхин тус тус орчуулсан бөгөөд хадмал хятад орчуулгад «агнуурын боломж» (36, 51) гэсэн шиг байна.

Бид **энэ үгийг төрү-**(алах агнах гэсэн утгатай үйл үгийн язгуур I үндэс) +гүли (**үйл үгнээс нэр үг бүтээх дагавар**) гэсэн бүтэцтэй үг бөгөөд «сур+га+гули» «тор+го+гули» гэх мэт үг бүтэх загвараар бүтсэн гэж бодож байна. **төрү-**(агнах), **төрү+гэ** (агнах ажил), **төрүгэ+сүн** (агнуурын юм) гэсэн үгс үүснэ.

43. **Эжэд** (эзэд)—энэ бол эжэ (н)+д гэсэн бүтэцтэй эзэн гэдэг үгийн олон тооны хэлбэрт үг юм. Үүнийг Э. Хэниш (15, 2), П. Пеллио (9, 122) тэргүүтэн Бурхан халдун уулыг эзэмшигч хоёр хүн гэж арай ташаа орчуулсан нь хятад галиг эхэд «Бурхан босхагсан» гэсэн хоёр үгийн дор «хүний нэр» гэж эндүү хадмал хийснээс болсон хэрэг. Элдэндэй, Ардажав (8, 19—20) Бурхан халдун дээр шүтээн босгож тахиж тайснаас тэндэхийн эзэн гэгдсэн «Шинчи-байан» урианхай хүн гэж тайлбарласан нь эргэлзээтэй. Учир нь Бурхан халдуны эзэн нь Шинчи баян урианхай ганцаар байсан бол Бурхан халдуны «эзэд» гэж олон тооны нөхцөлтэй бичигдэмгүй сэн. Ц. Дамдинсүрэн (7,26) Дугаржав (24, 3) нар Бурхан халдуны эзэн (эзэмшигч) нь Шинчи баян ганц хүн тул эзэн гэдэг үг «эзэд» гэж ташаа буулгасан гэж үзжээ. «Эзэд» гэсэн үгийг бид Шинчи баян урианхайд бус, харин Бурхан-халдуны уул усны далдын эзэд бурхад буюу овоо тахилгыг нь босгосон Шинчибаян гэсэн үг гэж ойлгож байна. Үүнд Монголын эртний бөө мөргөлийн үүднээс уул ус бүр тус тус далдын сахиус эзэдтэй гэж үздэг учир газар усны «эзэд» гэж олон тооны хэлбэрээр бичдэг байжээ. «МНТ»-ы өөр зүйл (272 дугаар §)-д Хятадыг байлдаж яваад өвчин хүртсэн Өгэдэй хааны өвчний шалтгааныг бөө нар «Хитад иргэн-ү гажар усун-у эжэд гажар усун-ийэн эбдэкдэрүн, иргэн орга-бан да'улигдарун түргэн-э адаламуй» (26, 204) гэж тайлбарласны дотор газар усны онгодыг «эзэд» гэж олон тооны нөхцөлтэй бичсэнийг бодолцууштай.

44. **Бурхан-босгосон**—гэсэн энэ үгийн хажууд «хүний нэр» гэсэн хятад орчуулга байсан учир энэ үгийг Э. Хэниш (15, 2), П. Пеллио (9, 122) гэх мэт олон эрдэмтэд Бурхан халдуны эзэд болох Бурхан-Босхагсан, Шинчи Баян гэсэн хоёр хүнд Хорилардай-мэргэн нүүж асуй гэж үзтэл эндүү орчуулжээ. Монгол хүнд өнгөрсөн цагт үйлт нэрээр нэр өгөх заншил байгаагүй тул Бурхан босгасан гэдгийн хажууд «хүний нэр» гэсэн хадмал орчуулгыг монголын судлаачид алдаатай буюу «ташаарсан болов уу» Элдэндэй Ардажав (8, 19) гэж үздэг юм. Ц. Дамдинсүрэн (7, 26), Мансан (27, 4), Иринчин (28, 8), Т. Дашцэдэн (26, 12) **нар цөм ингэж ойлгосон байна.** Гэхдээ «бурхан» гэсэн үг бурхан багшийг биш бөгөөд онгон шүтээн тахилга гэсэн утгатай гэж бодмоор билээ.

45. **Шинчи (Шинэчи)-баян**—гэдэг үгийг бид «харгай буюу шинэсүний охин тэнгэр» гэгчээс гарсан үг байж магадгүй гэж таамагласан (10, 94—111)

46. **Төрэгүлби**—эртний худам монгол бичигт эр эм хүйсийг үйл үгийн хувилалд ялган заадаг жам байжээ. Энэ үгийн төгсгөлд буй «-би» залгавар бол эм хүйсийн цаг заах төлөвийн өнгөрсөн цагийн хэлбэр болно. Эр хүйстэй үгэнд «-ба -бэ» нөхцөл залгадаг байжээ. Сонгодог монгол бичигт хүйс ялгахгүй. Эр үгэнд «-ба» эм үгэнд «-бэ» нөхцөл залгадаг нь эр эм хүйс зааж буй бус, харин тухайн үгийн эр, эм (чанга хөндий) эгшигтэйг ялган заана.

47. **Бэкинүгүдэй**—энэ үгийг хятад галигийг баримтлан олонхи судлаачид «Бөхүнүдэй» гэж сэргээдэг боловч бид Лувсанданзан (31, I, 9) «Бэкинүгүдэй» гэж буулгасныг түүнд байсан бололтой гэгддэг «МНТ»-ы худам монгол бичгийн эхэд ийм бичлэгтэй байсан болов уу гэж ийнхүү галиглав.

Энэ нь бидний санавал, Бэки+нүгүд+ай гэсэн бүтэцтэй бөө нарын овгийн хүн гэсэн утгатай монгол үг мөн. Учир нь «МНТ»-ы 216 дугаар зүйлд «Монггол-ун төрү (ёс) ноён мөр бэки болохуй йосун» байсан тухай дурджээ. (9, 85). Монголын «бэки» буюу «Бэх» гэдэг үг түрэг хэлний «бек» буюу «бег» гэдэг үгтэй утга үүсгэлийн холбогдолтойг Владимирцовын өгүүлэл (43, 287—288), П. Пеллиогийн шүүмж (44, 229—230)-ээс мэдэж болно.

48. **Бэлгэнүгүдэй**— энэ нь хүний нэр мөн бөгөөд Бэлгэ+нүгүд+ай гэсэн бүтэцтэй, бэлгэнүүдтэй буюу шинж тэмдэгнүүдтэй гэсэн утгатай монгол үг болно. Бэлгэ (тэмдэг) гэсэн үгэнд -нүгүд гэсэн олон тооны нөхцөл залгаад дээр нь -ай гэсэн овгийн хамаарал заасан үг нэмж Бэлгэнүгүдэй гэсэн үг бүтсэн мэт санагдана. Ийм нэртэй овог байсныг заасан үгээр ийм нэртэй хүн байсан болгон бичиж монгол хэлтэн эсгий туургатан цөм нэг гаралтайг нотлон үзүүлэхийг Нууц товчооны зохиогч зорьжээ.

49. **Көбэгү-тү** (хөвгүүнт)—гэдэг нь Дуба-сохор гэсэн эр хүйст хүнд хамаарагдах тул -тү дагавартай бичигджээ. Харин «Дуба сокур дөрбэн көбэгү-тү» гэсэн мэдээ бол зохиогчийн уран сэтгэмжийн зүйл биз. Учир

нь, нэгд, Дуба (Аварга) сокур (ганц нүдэт) бол үлгэр домгоос түүхэнд орж ирсэн хүн тул дөрвөн хүүхэдтэй байж боломгүй юм. Хоёрт. Рашид-ад-Дин (4, 1952. I. 2. 9—10) Тамачагийн таван хүүхдээс ахмад нь Хоричар-мэргэн эцгийн ор сууж бусад дөрөв нь түүнээс салж нүүгээд дөрбэд (одоогийн дүрвэд) овогтон болсон гэжээ. Монголын түүхч Саган-цэцэн «Доу-а сохор-ун көбэгүн ану Доной, Догшин, Эмлик, «Эркэ»- бэр ойрад: өөлд, баатуд, хойд хэрээнүүд дөрвөн овогтон болов. (23, 73) гэх зэргээр бичжээ. Бодвол дурдсан дөрвөн овогтныг ямар нэг хүний дөрвөн хүүхдээс үүссэн гэсэн аман уламжлал домог үг байжээ. Харин эл дөрвөн хүүхдийн нэрнээс дурдсан дөрвөн овогтон үүсэн гэж үзэх үндэсгүй биз ээ.

50. гэжү (гээж)—энэ үгийг «МНТ»-д ямагт богино эгшигтэй бичдэг нь сонирхолтойн дээр задгай үеийг монголчууд уртаар дуудаад богино эгшигтэй бичдэг байсны нэг гэрч болно. Яагаад худам монгол бичигт «гэжү» гэж богино эгшигтэй байсан үг хожим хуучин (сонгодог) монгол бичигт «гэгэжү», ярианд «гээж» болж хувирсан бэ? Энэ нь японы зарим эрдэмтэдийн баталдаг шиг анх монгол хэлэнд урт эгшиг байгаад бичигт тэмдэглэгддэггүйн учраас урт болсон (46, 50) биш, бидний санавал монгол хэлний үгийн төгсгөлийн задгай үе ямагт уртаар дуудагддаг өөр шалтгаанаар урт эгшиг үүсчээ. Жишээ нь эл үгийн үндсийг гэ-гэж бичих тул уртаар дуудагддаг байжээ. Гэтэл битүү үед (гэжү) богиноор дуулддаг байжээ. Энэ нь орчин цагийн Монгол хэлэнд та (таа)-гэж задгай үед уртаар дуудавч «танд» гэхэд «таанд» гэж уртатгаж болохгүйтэй адил юм.

51. Дөрбэн (дөрвөн)—энэ үгийн ганц тооны хэлбэр нь «дөрбэ» олон тооны хэлбэр нь «дөрбэн» болно. Овгийн нэрийг ямагт олон тооны нь хэлбэрээр илэрхийлдэг уламжлал манай монголд байжээ. «Дөрбэн овогтон» гэж бичсэн нь хүртээл нэр тодотгуулагч хоёрын хооронд ганц ба олон тооны зохицол байсныг гэрчилнэ. Учир нь «овог-ту» (овог бүхий эр) «овогтай» (овог бүхий эмэгтэй), «овогтон» (овог бүхий олон хүн) гэсэн ялгааг эдгээр хувилал ялган заадаг байжээ. Дөрбэн гэсний -н (олон тооны нөхцөл) нь мартагдаад ирэх үед нь «дөрбэд» гэж олон тоо заах -д нөхцөл залгах болжээ.

52. Чөкэ (цөх)—гунан бугыг нэрлэх энэ үгийг хятад галиг эхэд «жө'э» (9, 6) гэж байвч түүний хадмал хятад орчуулгад «гунан буга» гэсэн хийгээд Лувсанданзаны эхэд энэ үгийн өмнө «чөкү» (гунан бугыг цөх гэнэ) гэсэн үг хадаж тайлбарласан зэргийг харгалзан ингэж бичиж сэргээв. «Чөгэ» гэсэн үгийг хожим монгол үгэнд эгшгүүд уруулаар зохицох ёс гарснаас хойш уруулаар зохицуулан «чөкү» (цөх) гэж бичдэг болсон бололтой. Лувсанданзан энэ хятад галигийн «ча'о» гэсэн үгэнд «чөкү» гэсэн тайлбар хийснээс үзвэл түүнд хятад монгол эхийн аль алин нь байжээ гэж бодмоор (10, 5 дугаар тал, 2 дугаар зүүлт).

53. Абид—гэсэн энэ үгийг бид «(галын) тахилгын богино хавирга) гэж тайлбарласан билээ. (10, 23—25)

54. Нөкүр сиролга-д-а (нөхөр шорлогодоо) гэсэн энэ холбоо үгийг бид «нөхрийн чанар шорлогодоо (ямар мах шорлон авч өгөхдөө) мэдэгдэх» гэсэн утгатай зүйр үг гэж тайлбарласан билээ. (10, 5—26)

55. Жүлдэ буюу жилдү (зүлд)—гэгч агнасан ан, алсан амьтны сүр сүлд буян хишиг нь агуулагдсан бөгөөд анчин буюу нядлагч өөртөө үлдээх толгой, мөгөөрсөн хоолой уушиг зүрхтэй нь хамт зүлдэж авсан тахилёслолын холбогдолтой тусгай хувь махыг зүлд гэдэг байжээ. Энэ үгийг олонхи эрдэмтэд Пеллио (9, 6), Лигети (33, 17); Игорь де Рахевильз (25, 15) тэргүүтэн цөм «жилду» буюу эсвэл «жилдү» гэж, Х. Дугаржав (24, 4) Мансан (27, 5) тэргүүтэн «жилдү» гэж буулгасан байна. Гэвч бид «жүлдэ» (12, 543б) гэдэг нь эртний монгол бичгийн бичлэгт ойр болсон гэж үзэж түүнийг даган сэргээв. Учир нь эртний монгол хэлний аялгуунд дангаар байсан ж авиа ихэнхдээ и-гийн өмнөх байранд тохиолдсон нь «ж» (дж) хэвээр үлдэж бусад эгшгийн өмнөх нь халх аялгуунд з (дз) авиа болсон байдаг. Иймээс халхын аялгуугуунд «зүлд» гэж орсон энэ үгийн ж үсгийн ард и биш өөр «ү» авиа байсан гэх үндэстэйн дээр энэ үг монгол хэлэнд үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс үүсээгүй байхад эртний (худам) монгол бичигт «жүлду» биш «жүлдэ» гэж бичигддэг байсан гэж төсөөлнөм. (10, 5—7 дугаар тал, зүүлт № 1-ийг үз)

56. Майалиг—энэ үгийг хятад галигаас судлаачид санал нэгтэйгээр «Ма'алиг байагудай» гэж заншсан боловч бид түүхч Рашид-ад-Дин (4, т. 1, кн. 2. с. 10) энэ ядуу хүний нэрийг «Баялик» гэж заасан тул энэ мэдээнд үндэслэн үгийн эхний «б» авиа нь «м» авиатай сэлгэж «Майалиг» болж улмаар хоёр «а» авианы дундах «й» гийгүүлэгч нь сугарч «Ма'алиг» гэсэн үг болсон гэж төсөөлөн бодож Майалиг гэж сэргээн босгож бичив. Харин сонирхолтой нь Баялаг (Майалик) гэж нэртэй хүн ядуу явж хүүгээ гөрөөсний өрөөл гуяар худалдсан мэдээ байгаагийн дээр түүнээс байагуд (баячуудын) овог үүссэн гэдэг нь зөрчилтэй бөгөөд сонирхолтой зүйл юм. Байагуд овог хэн нэг баян хү-

нний удмаас үүсч баячуудын овог болсон байгууштай санагдана.

57. **Үгэй -күй** (үгүй-хүү)—гэсэн энэ үгийг «үгүй» гэсэн үгэнд «бас хүү» гэдэг шиг хүч нэмэгдүүлэх сул үгтэй үүсгэсэн үг гэж ийнхүү сэргээв. Жич энэ «хү» гэдэг дагавар сул үг нь кү (эр хүйс), күй (эм хүйс), хун-хүн (олон тооны) хэлбэр тус тус залгаж хэрэглэгддэг онцлогтой байсан хийгээд эл хоёр үг нийлж үгээгүү (ядуу) гэсэн үг үүссэн зэргийг хойно тайлбарлах үгсийн тайлбараас мэдэгдэх байх гэж бодож байна.

58. **Бодончар Мунхаг** (Боданчар Мунхаг)—гэгч нь ардын үгийн гарлын зүйгээр тайлбарласан жишээ нь энэ болно. Угтаа бол Бодан гэгч овгийн толгойлогч баатар бүсгүйг нэрлэдэг нэр байжээ. Хожим энэ нэрийг эцгийн эрхт ёс тогтоноос хойш эр хүнд хамааруулдаг болжээ. Бодан+чар гэсэн бүтэцтэй энэ үг бол овгийн бяцхан толгойлогч гэсэн утгатай юм. Бодан гэдэг үг бода (том)+н=Бодан (том биет гэсэн тэмдэг нэр) гэдэг үүсмэл нэр болжээ. Энэ нь мод (юмын нэр) мод+н=модон (үг юмаар бүтсэн эдийн шинж) гэсэн үг үүсдэгтэй адил болно. «МНТ»-ы 155 дугаар зүйлд Есүй хатан Чингис хаанд хэлэхдээ: «намайи күмүн-э бода-д-а болгажу» гэсэн «хүний ихэд тоож» гэсэн утгатай хэлсэн байдаг (25, 72) мөн Бода (том) мал, бог (жижиг) мал гэж ялган хэлэлцэнэ. «Мунхаг» гэсэн нь угтаа Боданчар Ман хан буюу «бидний хан» гэсэн утгатай цол байсан атал үүнийг Нууц товчооны зохиогч уран сайхны зорилгоор «мунхаг» гэсэн үг болгон Боржигид овгийн толгойлогчийн бэрхшээл давж гарч ирснийг харуулах гэж зориуд үгийн гаралыг таамаглан тогтоох ардын гарал зүйн тайлбар хийсэн байна.

59. **Ури-д-а**—гэдэг нь хугацааны хувьд өнгөрсөн үед холбогдох утгаар хэрэглэсэн байна. Ури-гэдэг үгэнд өгөх оршихын «а» нөхцөлийг залгахад төгсгөлийн «и» нь «а» нөхцөлтэй давхардах тул «-д-» гийгүүлэгч жийрэглэн «ури-д+а» гэсэн бүтэцтэй болгон үг хувилгажээ.

60. **Тэгүн-үай**—гэдэг нь түүний ай (хамаатай зүйл) гэсэн утгатай бөТэгүн-үай гэсэн дагавар үг нь аймаг гэдэг үгийн үндэс нь болно. Тэгүн-үай гэсэн дагавар үг дагавар болж нийлэхэд ү, а гэсэн хоёр эгшгийн хооронд х, г гийгүүлэгч жийрэглэж, бас эгшгүүд нь эр эмээр зохицон хожим тэгүн-ү-хэй (түүнийх) (47, 288—290 [4—6] болжээ.

61. **Экэ ану**—гэдэг үгийн «ан+у» гэдэг а буюу гуравдугаар биеийн төлөөний үгийн олон тооны хэлбэр+у гийгүүлэгчээр н-ээр төгссөн үг энд дагуулсан харьяалахын тийн ялгалын нөхцөл мөн. «Монголын нууц товчоон»-д I биеийн (ганц тоот хэлбэр) «Би» олон тооны хэлбэр нь ба, II биеийн ганц тоот нь ти (одоогийн чи) олон тоот нь та, III биеийн ганц тоот төлөөний үг нь и, олон тоот нь а гэсэн төлөөний үгийн тогтолцоо байжээ. III биеийн төлөөний үг и, а хоёул мартагдаж тэдгээрийн харьяалахын нөхцөлтэй «ину» гэснийг эм үгэнд, «ану» гэснийг эр үгэнд дагуулна гэж үсгийн дүрмийн зүйл болгожээ. Нууц товчооны эртний худам монгол бичигт энэ бүх биеийн төлөөний үг, түүний дотор и, а хоёр ч бараг бүх хувиллаар хувилж хэрэглэгдсэн байна. Иймд «экэ ану» гэдэг нь «тэдний эх» гэсэн утгаар оржээ. Энэ бол ану гэдэг эр үгэнд дагуулах нөхцөл биш. харин III биеийн олон тоот харьяалахын тийн ялгалын нөхцөл болох нь ил.

62. **Онширмал**—энэ үгийг һөнгшилмэл [Пеллио 9, 7; Рахевильз, Легити, Баяр болон бусад] сэргээн зарим нь «хатсан» Ц. Дамдинсүрэн (7, 27), көнгшилмэл-хөгшилмэл (Баяр (11, 25), Иринчин) гэж, «хуршсан буюу хуршиж хагширсан» (Мансан (27, 6), Дугаржав) «көнгширмэл (хуршиж хатсан)» Элдэндэй Ардажав 8, 33 гэж тус тус бүүлгаснаас гадна «хатсан» (Пеллио 9, 123) гэх зэргээр элдвээр орчүүлсны дотор он дамжсан буюу «өнгөрсөн оны хонины мах чанаж» (15,3) гэж орчүүлсан Э. Хэнишийн орчүүлгыг бид зөв гэж үзэж «онширмал» гэж сэргээн босгов. Үүнд Лувсанданзан нүгүчэ (үгүчэ) хөкшимэл хонины мах чанаж гэж бичээд хөкшимэл гэсний өмнө «хөгшин» гэсэн тайлбар хийснийг бас бодолцов. Монголчууд хуучин жилийн эцсээр 11 сард жилийн идшээ (олон малыг тарган байхад нь алж) нөөц буюу үүцэндээ хийж хойтон хаврыг дуустал их л хумжааргатай идэг тул хаврын цагт онширмал (үүцний) махаа харамлаж (хэмнэж) идүүлдэг байснаас үүц ханзлах хүртэл хүүхдүүд нь махсаж:

Мах магнаг болов
Манай эх шулам (харамч) болов гэж хэрилцдаг

байжээ. Урьд онд идшинд алж, дараа жилийн хавар болтол (онширмал) хадгалж урь идүүлсэн мах чанаж өгсөн нь ил байна. Хятад галиг дахь үгийн эхний h үсэг болон ө -э эгшигтэй бичигдсэнийг XIV зууны монгол хэлний аялгууны өөрчлөлт галиглагчийн алдааны зүйл гэж хасаад «онширмал» гэж утгачлан сэргээв. (48, 38—41)

63. **Сагулжу** (суулгаж)—гэсэн энэ үг сагу+л+жу гэсэн бүтэцтэй эртний монгол үг юм. Сагу (суу) гэсэн үйл үндэс, -л гэдэг нь үйлдүүлэх хэвийн нөхцөл (одоогийн -уул, -үүл, га, гэ зэрэг нөхцөлтэй адил утгатай) бөгөөд-гул, -гүл нөхцөл хураагдаж дуудагдсанаас үлдсэн («гү) л» байж

магадгүй. «-жу» гэдэг нь нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөлюм. Иймд эртний монгол хэл болон бичигт «суулгаж» гэж бидний өнөөдөр хэлдэг бичдэг үгийг «сагу(гу)лж» гэж хэлж бичиж байсан байж болно.

64. Мө[л]сүд (мөсөд) — гэдэг нь сумны мод болгохоор холтос долонг хуулж зулж мөлийлгөсөн (саваа мэт) моднууд» гэсэн утгатай эртний монгол үг юм. Хятад галигт уг үгийг «мүсүд» (Пеллио, Баяр) гэж байгаа боловч язгуур монгол бичигт «мөлсүд» гэж бичиж байсан гэж төсөөлөн «мөлсүд» гэж сэргээв. Энэ сум хорын мөлийлгэж зассан мод хэчнээн шулуун сайн бол сум хор нь сайн болдог тул хүний чанар зарчим сайтай хүнийг «хүний мөс сайтай» гэдэг үг сумны мөлстэй зүйрлэн хэлсэн үг юм.

65. Хугулутхун (хугулагтун)—гэсэн нь хугу (үйлийн 1 үндэс)+л [үйл үг бүтээх дагавар]+т-үйлийн олон тооны нөхцөл,+хүн (ирээдүй цагт үйлт нэрийн олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн бөгөөд хожим үеийн хуучин монгол бичигт т+хүн залгаврын «т» «х» авиа нь **байраа** сэлгэсэн хувилбараар «хугулагтун» гэсэн хэлбэрээр тэмдэглэгджээ. Энэ нь худам буюу язгуур монгол бичиг хожимын сонгодог (хуучин) монгол бичгээс ялгаатай байсны бас нэг баримт болно.

66. Гүйүлэлдүн (гүйлгэлдэн)—гэсэн энэ үгийг олонхи судлаач (Пеллио, Лигети, Баяр, Рахевильз, Дашцэдэн тэргүүтэн) «гүйүлэлдүн гүүлэлдүн» гэж буулгаснаас гадна Ц. Дамдинсүрэн Мансан нар «дараалан оролдож» «ээлжлэн оролдож» гэж, Элдэндэй Ардажав Иринчин нар хүмүүлэлдүжү» гэж буулгаад «хүн бүр дараалан» гэж, Х. Дугаржав «Хүн бүр тойруулан» гэж тус тус ойлгосон байна. Бид «гүйү» (гүй-) [гэсэн үйл үгийн язгуур, I үндэс дээр]+л-[үйлдүүлэх хэвийн залгавар]+лд [үйлдэгдэх хэвийн залгавар]+н [нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл] тус тус залгаж бүтээсэн «гүйлгэлдэн» гэсэн утгатай үг гэж үзэж ийнхүү сэргээв.

67. Бидугулжу (бядуулж) — гэсэн энэ үгийг судлагчид их төлөв хятад галигт бичигдсэнээр нь «битү'үлжү» (Пеллио, Лигети, Рахевильз Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин, Дашцэдэн) тус тус буулгаж ойролцоогоор зөв ухаарч орчуулсан байв. Гэвч олонхи нь дуудан уншигч болон галиглагчийн алдаатай бичлэгийг тэр чигээр нь баримталжээ. Бид энэ үгийг «биду- (үйл язгуур 1 үндэс) +гул (үйлдүүлэх хэвийн нөхцөл) + жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй, «хэсүүлэн, дамжуулан барьж» гэсэн утгатай эр үг гэж үзэж буулгав.

68. Чэгэгэн. (цэгээн)—гэсэн монгол үг бөгөөд «цайвар царьдгар цагаан» гэсэн утгатай гэж бодно. «Чэгэ» (айраг)+гэн (тэмдэг нэр бүтээх дагавар) өөрөөр хэлбэл цэгээний өнгөтэй адил өнгөтэй гэсэн утга гаргасан байж болно. Иймд цэгээн шар гэдэг нь «цайвар шар» гэсэн үг болжээ.

69. Гэгэ-бэр — энэ үгийг зонхилох судлаачид гэгэ-бэр гэж хятад галигийг буулгадаг билээ. Энэ үгийг Пеллио (9, 123—124) «өрх үүдний зай завсараар» гэж, Хэниш (15,3) «гэрийн дээврийн нүхээр» гэж, Рахевильз (49, № 4. 1971, 121) «өрхний нүх, хаалганы дээгүүр орсон гэрлээр» гэж, Ц. Дамдинсүрэн (7, 28) «өрх тотгоор гийгүүлэн орж» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 35), Иринчин (28, 14), Дугаржав (24,6) «өрх тотгын гэгээгээр» гэж, Мансан (27,7) «гэрийн өрх тотгыг гийгүүлэн» гэж тус тус орчуулсан байна. Энэ үг «гэгэ» (бүдэг гэрэл)+бэр гэсэн бүтэцтэй «Гэгээгээр» гэсэн утгатай үг юм. Үүнийг кэкэ-бэр гэж галиглавал« кэкэ» гэгч эртний монгол хэлэнд «эх» гэсэн үг байж болох боловч өрх тотгын эх (ээж) биш, харин «кэки-бэр» гэж галиглахыг ташааран галигласан байх гэмээр санагдана.

70. Билижу (илбэж буюу илж) — гэсэн үг бол илэх гэсэн утгатай үйл үг «били- (үйл үгийн үндэс) + жу» (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй юм. Хожим үеийн сонгодог (хуучин) монгол бичигт эхний хоёр үе нь тонгорч сэлгэн «илбижу» гэж бичигдэх үг болжээ.

1 2

— + — +жү=ил (II үе тонгорчээ) би (I үе нь ухарчээ) жу (нөхцөл би ли

нь тонгорч болохгүй тул байрандаа үлджээ).

71. Дэлэмэ (дэлим)—гэдэг нь угтаа дэмэйи-лэ (12, 665б) гэдэг үгийн тонгорсон хэлбэр бололтой. Шагж гуай энэ үгийг «учиргүй, хоосон» гэсэн утгатай гэж тайлжээ. **Хэрэв дэлэм (уртын хэмжүүрийн нэгж-хагас алд гэсэн үг гэвэл дэмэлэ гэх бус дэлим** (12, 668б) гэж бичигдэх учиртай байв.

72. Йа-кин (яахин)—гэдэг нь асуух үг бүтээх үндэс болох йа (яа)+ки (хий-гэсэн үйл үгийн үндэс) +н (нөхцөл үйл үгийн хам хэлбэрийн нөхцөл) гурав нийлж үйл үгэнд тавих асуултын йа кин? гэсэн үг бүтэхээс өмнөх үеийн монгол бичгийн үгэнд нийм байсан болов уу

гэж ингэж салангид бичиж сэргээв. йа+гу (юу?) йа+кин (яакин?) гэдэг асуух төлөөний үгс бүтээдэг байсны дотроос кин гэж богино эгшигтэй байсан үг бидний бодлоор дээр 32 дугаар тайлбарт заасны адилаар ки (хий) гэсэн үндэс нь задгай үед уртаар дуудагддаг жамаар урт дуудагдсаар урт эгшигтэй үг болсон боловч энд битүү үед буюу -н нөхцөлийн өмнө йа кин гэж богино эгшигтэй байсан бололтой.

73. Үгүлэд та — гэсэн үгийг олонхи эрдэмтэд үгүлэд та гэж буулгадаг **бөгөөд** энэ үг өгүүлэгч нь та (**өөрөөр** хэлбэл «Бэлгэнүгүдэй Бэхинүгүдэй» хоёр хүн учраас олон тоотой эзэн бие тул өгүлэд гэдэг үйл үг нь түүнд зохицож бас олон тооны хувиллын -д нөхцөлтэй бичигджээ. Эртний монгол хэл аялгуу болон бичгийн үг ярианд эр эм хүйс болон эзэн бие, үйл үгийн зохиоцол байсан нь хожим монгол хэл аялгуу болон хуучин бичигт алга болжээ. Энэ баримт нь дурсгалт бичгийн эх эртний худам монгол бичгээр бичигдсэнийг дам гэрчилж буй. **Учир нь урт эгшиг бүрэлдэх буюу хэлний хүйс, тоо хүртээл нэр ба жинхэнэ бодит нэрийн хоорондох зохицол байснаа арилах зэрэг өөрчлөлт нь ганц нэг зуу буюу зуун тавин жилд тийм хурдан болж өнгөрөх үйл явц бус билээ.**

74. Суйугар (соёгар ~ суягар)—үг гэдгийг хятад галиг эхэд галиглагчдын аман аялгууны ташаарлаар «**сүйүгэр үгэ**» гэж буулгадаг **боловч** «сургаал үг» гэж олонхи судлагч нар зөв ойлгож орчуулсан байдаг. Энэ үг 14 дүгээр зууны хэл аялгуунд ийм дуудлагатай байсан боловч эртний монгол бичигт «сойугар үгэ» гэж бичдэг байсан гэж бодож байна. Учир нь тэр эртний монгол бичигт үгийн эгшиг уруулаар зохицох ёс гараагүй үед үгийн эхний үед нь их төлөв о, ө эгшиг орж дараах үед у, ү эгшиг ордог нэг ёс байсан боловч эхний о-гоор амилсан зарим үгийг у-гаас ялгахын тулд о- эгшгийг хоёрлон бичиж байсан тул хэрэв энэ үсгийг «доор, гоол» гэдгийн адилаар сообугар гэж хоёрлон бичих ёстой байжээ. **Нөгөө** талаар ихэд хувиссан халхын аялгуунд үүнтэй нэг язгуураас бүтсэн соёл гэдэг о эгшигтэй болсон байхад харьцангуй бага шиг хувиссан буриад зэрэг аялгуунд соёл гэхийг «суйул» гэж хэлдгээс үзвэл анх у эгшигтэй байсан шиг санагдана. Бас одоогийн нийт монгол хэлэнд «сургаж суях» гэсэн үг байдаг нь у дуудлагатай байсныг нь давхар гэрчилнэ.

75. Аду[гу]сун идэгэ-бэн—гэсэн энэ холбоо үг, бидний санавал, «мал хөрөнгө, эд агуурс» гэсэн утгатай эртний монголын хэвшмэл хэллэг **мөн. Аду** (маллах **агуулах** гэсэн үйл үгийн үндэс) +гу (үйл үгнээс нэр үг үүсгэх дагавар)+су (нэр үгээс «юм» гэсэн утгатай нэр үг бүтээх дагавар) +н (уг юмны нэрийн олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй гэж үзэв. Учир нь гөрү (үйл) +гэ (нэр үг) +сүн (агнуурын юм) +н (түүний олон тооны нөхцөл) гэсэн загвараар бүтсэн байж болох юм. Нөгөө талаар аду- гэсэн үйл язгуур, I үндэс дээр -су (үйлийн утгын холбогдолтой юм гэсэн утга оруулах дагавар) -н (түүний олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй үг байж ч болох юм. Үүний загварын амны «хахасун» (77§) НТ-нд дайралдаж байна. Гэвч бид энд аду +[гу]+сун гэсэн загварын үг бичигт байсан, түүний зарим үе галигт хаягдсан гэж ингэж буулгав. НТ-ны өөр зүйлд (39§-д): «адүгун идэгэн-э аран тутхар-а, ахуй сагухуй-а күрбэ» гэж бичсэн баримт байна. Иймд «адугусун» гэж байсан гэдэг нь илүү үнэмшилтэй юм.

76. Үлү тоган (үл тоон) — гэсний «тога» (үгийн язгуур үйл үгийн I үндэс) +н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд угтаа тоох гэдэг нь «тоонд оруулах» гэсэн утгатай тул «тог-а» гэдэг нэр үндэс, тоо(х)-гэсэн үйл үндэс хоёр ижлээр «тога» гэж бичигддэг байжээ. Энэ тога-гэдэг үйл үгийг анх энэ тог-а гэдэг нэр үндэстэй нь адилаар бичиж байсны баримт Шантидэвын Бодхичарья-Авида-гийн 1305 онд Чойжи-Одсэрийн хийсэн хуучин орчуулгад (40, 34) «Сумун» жида мэсэн-э онугдаху зобланг-и йагун-а ба-үлү тогар-ун» гэж бичсэн явдал болно. Хожим энэ үгийг хуучин бичигт «тогон» буюу «тогун»—(12, 600а дугаар талд үз) гэж бичих болжээ.

77. Гоол (гол) — эртний худам монгол бичигт урт эгшиг гараагүй үеийн монгол хэлний аялгууг тусгаж эгшиг хоёрлон бичиж урт эгшгийг тэмдэглэдэггүй байв. Харин үгийн эхэнд О голдуу оровч бас У хаяа орох тул түүнээс ялгахын тулд үгийн эхний үеийн О эгшгийг хоёрлон бичдэг байжээ. «Гол» гэж бичвэл энэ нь «гул» гэж уншигдах, харин «гоол» гэж бичсэн бол түүнийг «гол» гэж богиноор дуудан уншина. Иймээс тэрхүү ялгах эгшгийн улмаас бичгээр «доор» гэж бичсэнийг уртаар соносч «ширээн доор» гэх мэтээр урт эгшигтэй хэлэх бичих болжээ.

78. Оруг-шингхула (орогшин-хула?) — гэсэн энэ үгийг судлаачид гол төлөв ингэж галигладаг (Лувсанданзан, Пеллио, Баяр, Хэниш (36, 147), Дугаржав, Иринчин, Лигети, Рахевильз, Элдэндэй Ардажав нар Дашцэдэн) боловч харин Ц. Дамдинсүрэн «Оруг Шинхор» гэж,

Мансан «Хүрэн зээрд» гэж, Э. Хэниш хятад хадмал орчуулгыг барьж «цагаан морь» гэж, Ф. В. Кливз (42,5) «цагаан бор» гэж, Рахевильз «хар бүхүй цагаан морь» (49, № 4,1971 121—122 дугаар т.) гэж тус тус орчуулсан байна.

Бидний бодлоор энэ үг «төв+шин», «хав+шин» (аман зохиолын «хавшин хар буур» гэх мэт) үгийн загвараар үүссэн «орогшин» хула буюу оруг (цагаан саарал хул морь) гэсэн үг байсныг XIV зууны галиглагчид уул хоёр үгийг буруу асалж ташаа нийлүүлснээс ийм үл танигдах үг болсон байж магадгүй гэж бодож байна.

79. **Үкүбэсү (үхвэл) мин-у** — гэсэн энэ үгийг судлаачид Пеллио (9,7) тэргүүтэн, их төлөв «үхү'эсү», «үхүбэсү ину» (Ц. Дамдинсүрэн тэргүүтэн) гэж буулган сэргээсэн буюу орчуулсан нь нэгдүгээр үгийн хувьд цөм зөв боловч «ину» гэсэн III биед хамаатуулах нөхцөл дагуулсан нь хятад галигч нарын алдааг дагалдсан хэрэг. Харин «үхүсүгэй» гэсэн I биеийн (даалган захирах) төлөвийн үйл үгтэй нь холбож бодвол түүнд зохицож «үхүбэсү мину» гэж байвал зохихыг үзтэл галигч нар ташаарсан бололтой.

80. **Абасу мину**—гэсний абасу (байвал) гэдэг нь өмнөх үгийн адил а- (амьдар, бай- гэсэн үйл үгийн язгуур I үндэс) -басу (нөхцөл үйлийн болзох хэлбэрийн нөхцөл) мину (I биеийн хамаатуулах нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн. Абасу (авааc, авал) гэдгийг «амьдарваас» гэж олонхи судлаачид зөв буулгаж сэргээсэн байна. Мин-у гэсэн нь эртний монгол бичигт 1 дүгээр биеийн төлөөний үгийн харьяалахын тийн ялгалын хэлбэр мөн. Энд 1 биед хамаатуулах нөхцөлийн үүрэгтэй оржээ. Иймд «абасу ину» бус «абасу мину» биз.

81. **Балжи-йин арал**—гэснийг уг хятад галиг эхэд «Балжун-арал» (9, 7 дугаар т.; 11, 36 дугаар н., болон бусад) гэж бичигдсэн боловч бид энд Лувсанданзан (31, I, 13 дугаар т.,) Ононы «Балчир арал-а» гэж алдаатай буулгасан баримт, Ц. Дамдинсүрэн (7, 28 дугаар т.,) «Балжи-йин арал» гэж бидний бодлоор зөв буулгасан баримт, Жич одоо нутгийн ардууд «Балжийн гол» гэж нэрлэдэг баримт басхүү эртний монгол хэлэнд байсан ж авиа орчин цагийн монгол халхын аялгуунд их төлөв «з» авиа болж харин и эгшгийн өмнө бичигдэг нь «ж» дуудлагаа хадгалж үлдсэн баримт зэрэгт үндэслэн «Балжийн арал» гэж «МНТ»-ы худам монгол бичгийн эхэд бичээстэй байснаар төсөөлөн буулгав. XIV зууны үеийн монгол хэл аялгуунд үгийн дундад ба адагт зарим эгшиг балархайшин констохгүй болж байсны баримт Нууц товчоонд олон тохиолдогийн нэг нь энэ үгийн эцсийн и авиа мөн тул галиглагч «Балж (и)-ун» гэж ташаарсан гэж үзэв.

82. **Эбэсүн эмбүлэ** (өвсөн өмбөл) — энэ бол үзүүрээр нь боосон хэдэн шургааг модыг өвсөөр бүрж хошлон -(дээс)-гоор ороож барьсан оромжийг хэлдэг бөгөөд хятад галигт үүнийг «эбүсүн нэмбүлэ» (Пеллио, Баяр, Рахевильз, Дашцэдэн, Лигети, Элдэндэй Ардажав нар Дугаржав (эбэсү-бэр нэмбүлэ) гэх мэтчилэн) гэж буулгадаг боловч үүнийг бид «элэсүн-эмбүлэ» гэсэн үг үг ярианы урсгалд «эбэсүн-нэмбүлэ» гэж эхний үгийн төгсгөлийн «н» авиа дараах үгийн эхний «э» авиатай нийлж сонстосны улмаас галигчийн алдсан эндүү гэж үзэж нэмбүлэ биш «эмбүлэ» гэж буулгав. Үүнд Нууц товчооны худам монгол бичгийн эхтэй агсан гэж төсөөлөгддөг Лувсанданзан (31, I, 13) Ц. Дамдинсүрэн (7, 28) Иринчин (28, 16) тэргүүтэн цөм «эбэсүн эмбүлэ» гэж зөв сэргээсэн юм. Жич Мансан зөв ойлгоод «эбэсүн обохай» (27, 8) гэж бичжээ.

83. **Аба сагуба** (ав суув) — гэсний «эхний үгийг судлаач нар цөм ижлээр бичиж сэргээгээд зарим нь «аба» гэсэн үгийг Лувсанданзан «суув» (31, I, 13 дугаар т.) Ц. Дамдинсүрэн (7,28) Пеллио (9, 124) Хэниш (15,4), Рахевильз (49, 1971, № 4, 122) цөм суув амьдрав гэсэнээр орчуулсан. Монгол үлгэрт «ан суун жаргав» гэх амьдран суун жаргав гэх мэт үг байдгаас үзвэл «аба сагуба» гэгч үнэхээр амьдран суув гэсэн утгатай байж болмоор. Гэвч «аба сагуба» хоёр үйл үг хоёулаа үйлийн өнгөрөн төгссөн цагийн хэлбэрт байгаа нь хачирхалтай. Иймд бид «аба» гэдэг үг «байх» гэсэн утгатай биш ан хийх (ан аба) гэсэн утгаар хэрэглэгдсэн болов уу гэж эргэлзээж байна. Тэгвэл «ан хийж суув» гэсэн утгатай үг биш байгаа?

84. **Урахалажу** (урхилаж) — гэсэн энэ нь «ураха+ла+жу» гэсэн бүтэцтэй урхилах гэсэн утгатай монгол үг. Үүнийг Нууц товчооны хятад галиг эхэд «hурахалажу» (Пеллио, Баяр, Рахевильз, Лигети, Хэниш) гэх мэтээр сэргээн босгоод, Хэниш (36, 79) Пеллио (9, 124), Элдэндэй Ардажав нар (8, 42—43,), Ц. Дамдинсүрэн (7, 28), Дүгэржав (24, 7), Мансан (27,8) цөм «урхи тавих» хийх гэх зэргээр зөв орчуулжээ. Тэгэхдээ Элдэндэй, Ардажав, Иринчин (24, 16) тэргүүтэн зарим нь «ураха» (урхи), ург-а (ургалах) хоёрыг нэг үгэнд бодож ойлгожээ. Үүнд урхи гэхийг урах-а гэж, нөгөө уурга гэснийг «ург-а» гэж хоёр янз бичих бөгөөд сүүлчийн үг нь анх «огург-а» (орхих хэрэглүүр) гэсэн байдлаар эртний монгол хэлэнд байгаад хожим уурга гэж

«г» сугарах хэлбэрээр урт эгшигтэй болсон байх гэж бид төсөөлнө. Иймд ураха, огурга (уурга) хоёр нэг үг гэж харагдахааргүй байна.

85. **Гунд хоргасан** (гуунд хоргоосон) — гэсэн энэ үгийг Пеллио (9,8) Лигети (16, 20) Рахевильз (25, 17), Баяр (11, I, 38) Лувсанданзан (31, I, 13) гэх мэт цөм «хун-тур хоргасан» гэж хятад галигийг дагаж буулгаад хун гэдэг үгийг олонхи нь: Ц. Дамдинсүрэн (7, 28), Дашцэдэн (26, 15), Баяр, (11, 1, 38), Элдэндэй Ардажав нар (8, 43—44), Мансан (27, 8), Иринчин (24, 16), цөм гуу (жалга) гэж зөв ойлгож **бичжээ. Үүнээс үзвэл гуу гэдэг үг эртний монгол бичигт гу гэж бо**гино у-тай бичигдэж байсан боловч задгай үеэр төгссөн учир урт дуудагддаг байжээ. Иймээс хожим энэ үгийг го+у (гуу) гэж уртатган бичдэг болж. Харин н гийгүүлэгчийн өмнө (битүү үед) орохдоо «гун» гэж богино дуудлагатай болж байжээ. Эртний монгол хэлэнд х, -г авиа салаагүй үед хун гун хоёр ижил утгатай ба дуудлагатай байсан нь магадтай.

Хоргасан гэдэг нь хор-[үйл үгийн өөрөө үйлдэх хэвийн үндэс]+га [бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөл]+гсан (үйлт нэрийн өнгөрсөн цаг заах нөхцөл) гэсэн бүтэцтэй үг юм. Энд «Чонын гуу» гэсэн үг биш, харин «чонын хоргоосон» гэсэн үг болно.

86. **Марийажу** (мяраж) — гэсэн үүнийг судлаачид цөм ингэж буулгаад «гэтэж» ойртох гэсэн утгаар ойлгожээ. Бидний нэмж хэлэх нь марийа- гэдэг үг аливаа хэлний эрт цагийн адил мах «марийа», «марийаху» гэсэн нэр үндэс үйл үндэс нэгтэй байсны гэрч энэ болно. «Марийажу» гэсэн үг нь марийа-гаараа биеэрээ гулсан хөдлөх гэсэн утгатай үг бололтой. Мираах гэдэг нь хожим сонгодог (хуучин) монгол бичигт и авианы байр сэлгэлтээр ийнхүү бичигдэх болжээ. Энэ үг «марийажу» гэсэн хэлбэрээр (ө.х. эртний бичлэгээрээ Бодичарья-авадарагийн 1305 оны Чойжи-Одсэрийн хуучин орчуулгад (40, 50); (Н) охар (нохой-Ш. Г.) мис (мий) хигэд хулагайичи күмүн сэм ийэр м а р и й а н йабужу... гэж бичсэн байв. Иймээс энэ нь үлэмж эртний бичлэг нь мөн.

87. **Тэмкүлдүжү** (түүж, булаалдаж) гэсэн энэ үгийг судлагчид ижил төстэй сэргээн босгодог боловч олонхи нь (**Пеллио, Рахевильз, Хэниш** Кливз, Дашцэдэн, Иринчин) цөм хятад хадмал орчуулгын утгыг Хэниш (36, 148) түүж цуглуулах гэсэн үг гэж ойлгожээ. Энэ нь ерөнхийдөө зөв ч байх. Гэвч энэ үгэнд «тэмцэлдэж булалдаж» гэсэн утга бас байсан байж магадгүй гэж бид бодов. Энэ тохиолдолд галигч нар тэмчэлдэжү» гэсэн үгийг «тэмкүлдүжү» гэж ташаарсан байж магадгүй. Эсвэл «тэмгүлд» ч байж болно.

88. **Хогулай-ийан** (хоолойгоо) энэ үгийг судлагчид Пеллио (9, 8), Баяр (11, I, 39), Дашцэдэн (26, 15), Лигети (33, 20), Рахевильз (25, 17) тэргүүтэн цөм «хо'олай да'ан» гэж сэргээн босгодог нь хятад галиг эхийг дагасан хэрэг байх. Бид үүнийг хятад галигчийн гаргасан алдаа гэж үзээд «хогулай- ийан» гэж буулгав. Учир нь «тэжээлдүн» гэсэн үйл үг монгол хэлэнд өгөх оршихийн тийн ялгалт үгтэй бус, заахын тийн ялгалт үгтэй холбогддог билээ. Иймээс «хоолойдоо тэжээлдэн» гэдэг үг байх ёсгүй харин «хоолойгоо тэжээлдэн» гэж байх ёстой.

89. **Тэжийэлдүн (тэжээлдэн)** — энэ үгийг бараг бүх судлагчид хятад галиг эхийг дагаж «тэжи'элдүн» (Пеллио, Рахевильз, Лигети, Баяр, Дашцэдэн, Хэниш, гэж сонгодог хуучин монгол бичгээр Ц. Дамдинсүрэн «тэжигэгсэгэр» (7, 28), Баяр (11, I, 39), Иринчин (28, 16), Элдэндэй Ардажав нар (8, 43) цөм «тэжигэлдүн» гэж; Дугаржав «тэжигэкү-бэр» гэх зэргээр сэргээн босгосон боловч бүр эртний (худам) язгуур монгол бичигт «тэжийэлдүн» гэж байсан гэж төсөөлөн буулгаж сэргээв. Үүнд Лувсанданзанд байсан бололтой гэгдэх Монголын нууц товчооны эхэд «тэжийэлдүн» гэж байсан учраас Лувсанданзан (31, I, 13) «тэчийэгэд» гэж бичсэн байж болох юм гэдгийг бас харгалзсан билээ. Иринчин судлаач энэ үгийг «тэжийэлдүн» гэж байж болно гэсэн санал хэлээд Сулхарнайд ийм бичлэг тааралддагийг заажээ. (28, 17) Жич энэ «йэ» авиа хуучин монгол бичигт жи ши чи гийгүүлэгч болон и эгшиг авианы дараа олонхидоо тохиолдог тул ингэж буулгах нь зөв гэж бодож байна. Жишээ нь тушийал (тушаал) хэчийэл (хичээл) хэмжий-э (хэмжээ) гэх мэт.

90. **Тэйилэгүлжү** (сойж, өлсгөж) — гэснийг хятад галиг эхийг дагаж судлаачид Пеллио (9, 8), Рахевильз (25, 17), Баяр (11, I, 39) Лигети (33, 20), Дашцэдэн (26, 15), болон бусад «тэйилэ'үлжү» зарим нь сонгодог (хуучин) монгол бичгийн дагуу «тэйилэгүлжү» (Баяр, Элдэндэй Ардажав нар, Иринчин) гэж буулгаад зарим нь уул үгийн утгыг Дугаржав (24, 7), Мансан (27, 9), Ц. Дамдинсүрэн (7, 29) тэргүүтэн олонхи нь «сойижу» (сойж) гэж ойлгож тайлсан юм. Лувсанданзан (31, I, 13) энэ үгийг «татаж» гэсэн нь бас уяж сойж

гэдгийг «татуулах» гэсэн утгатай гэж бодно. Иймээс уг үг тойилжу тойи (сойи)+(гу-) л+жу гэсэн үг байгаад хожим сойх гэсэн үг болсон болов уу гэж санана.

91. Хожигулас (хожуулс) — энэ үгийг хятад галиг эхээс судлаачид (Пеллио, Лигети, Қозин, Рахевильз Баяр) «хожи'улас» гэж, зарим нь (Баяр, Элдэндэй Ардажав нар, Иринчин, нар болон бусад) «хожигулас» гэж, Дашцэдэн Қозин нар «хожиулас» гэж, Дугаржав Мансан, Ц. Дамдинсүрэн цөм хуучин монгол бичигт бичдэгийн адилаар (12, 380б) «хожуул-а» гэж буулгажээ. Баяр нарын буулгасан «хожигулас» гэдэг нь эртний худам монгол бичгээр зөв буулгасан гэж бид үзнэ. Энэ үг хожий-(үгийн язгуур 1 үндэс) +гул (үйл үгийн үндэснээс нэр үг бүтээх дагавар) +с (олон тооны үндэс бүтээх нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг гэж бодно.

92. (Х)оншигуд (оншигууд)—гэсэн нь хятад галигийг дагаж Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Хэниш тэргүүтэн судлагчид «хонгши'ут» «хунгши'ут» гэж, Элдэндэй Ардажав нар Иринчин, Баяр тэргүүтэн зарим нь хуучин (сонгодог) монгол бичгийн маягаар «хонгшигуд» гэж, Қозин Дашцэдэн нар «хоанш ут» буюу хонгшиуд» гэх зарим нь Дугаржав, Ц. Дамдинсүрэн нар орхиж орчуулсан буюу буулгасан байна. Хамгийн гол нь энэ үгийг Пеллио, Иринчин, Хэниш, Қливз, Рахевильз цөм «өмхий үнэр» гэж, Элдэндэй Ардажав нар, Дугаржав нар хиншүү хуншуу (үнэр) гэж тус тус ойлгосон нь цөм хонгши'ут» (36, 79) гэсэн үгийн хятад хадмал орчуулгыг дагасны хэрэг юм. «Хоншигуд» гэдэг үгийг бид он (он жил гэсэн утгатай нэр үгийн үндэс)+ши (нэр үгнээс он өнгөрсөн шинж орох гэсэн утгатай үйл үг бүтээх дагавар) +гу (үйл үгийн үндэснээс нэр үг бүтээх дагавар) +д (нэр үгийн олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Оншуулсан (борцолсон) шувууны мах гэсэн утгатай мэт санагдана. Эл учраас энэ үгийг «Хожуул-а бүри-эчэ хойар гурбан шибагу өлгөсөн» гэж орчуулсан Ц. Дамдинсүрэн гуайн орчуулга утгыг яг зөв гаргажээ.

93. Унжигулас (унжуулс) — гэсэн энэ үгийг судлаачид XIV зууны галиглагч нарын хэл аялгууны онцлогийг тусган тэмдэглэсэн хятад галигийг мөрдөж «һөнгжи'үлэс (Пеллио) «һүнгжи'үлэс» (Баяр, Лигети, Рахевильз, Дашцэдэн зэрэг) эсвэл «һунгжиулас» (Элдэндэй Ардажав нар) гэх мэтээр өөр өөрөөр буулгаж, үүний утгыг «модны гол» (Пеллио) «хатсан модны гол» (Хэниш, Рахевильз), «хатсан мод» (Қливз), «модны гишүү» (Қозин), «хиншүү» (Элдэндэй Ардажав нар, Дугаржав), «мөчир» (Дамдинсүрэн, Мансан) гэх мэтээр ойлгож орчуулжээ. Эхний «һ» авиаг тэмдэглэх үсэг эртний монгол бичигт байгаагүй тул үүнийг XIV зууны галиглагчдын аялгын алдаа гэж хасаад бид энэ үгийг унжи-(үйл үгийн язгуур, I үндэс) +гул (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +с (нэрийн олон тооны үндэс үүсгэх нөхцөл) гэсэн бүтэцтэй «унжуулс» гэсэн утгатай үг гэж бодно. Иймд бидний бодлоор бол Қозин, Дамдинсүрэн Мансан нар ерөнхийдөө зөв ойлгож орчуулсан гэж хэлмээр байна. Лувсанданзан (31, 13) энэ үгийг «ө(н)-гчигүлэ» гэж уг хятад эхэд байгааг ойлголгүй алдаатай бичсэн нь «унжигулас» гэсэн үг байсныг гэрчилнэ. Юу ч болсон уг монгол бичгийн эхэд үгийн эхэнд «һ» байгаагүйг харуулав.

94. Үнэшигүд (үнэр орсон махнууд)— гэсэн энэ үгийг хятад галигт «муухай үнэр, өмхий самхай» (36, 79) гэж Хэниш утгачилсныг «хиншүү» (Пеллио), «өмхий үнэр» [Рахевильз (49, № 4, 1971, 122] Қливз (42, 6); «Хиншүү хуншуу» (Элдэндэй Ардажав, Мансан). Харин Қозин «үнэр орсон мөч чач», Ц. Дамдинсүрэн «мөч гуя» гэж тус тус ойлгосон байх бөгөөд энэ сүүлчийн хоёр эрдэмтнийх илүү ойртсон орчуулга юм. Учир нь» «Үнэ(р)-(нэр үгийн язгуур) +ши (нэр үгнээс үйл үг бүтээх дагавар) +гу (үйл үгнээс нэр үг бүтээх дагавар) +д (нэрийн олон тооны үндэс үүсгэх нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд энэ нь чухамдаа «үнэсдэхүүн» үнэртэх юм (мах, мөч чац) гэх мэт биет зүйлийг хэлжээ. Зөвхөн «үнэр» гэсэн хийсвэр нэр байж таарамгүй.

95. Тойиран (Ойт)—гэсэн энэ үгийг хадмал хятад орчуулгад уулын нэр гэж заасан бөгөөд олонхи судлаач Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн, Элдэндэй Ардажав нар цөм «Дүйирэн» гэж, Баяр «Түйирэн» гэж, Қозин «Түйрэн» гэж тус тус буулгаад олонхи нь түүний дотор Мансан (27, 9) цөм Дүйирэн буюу Тойиран уул гэж уулын тусгай нэр болгон орчуулжээ.

Харин бид Иринчиний адилаар (28, 18) Лувсанданзаны «Алтан товчид» (31, I, 15) «Тойиран» (ой-йин) гэж бичсэнийг Нууц товчооны худам бичгийн эхэд байсан бичлэг мөн байх гэж таамаглан мөрдөж «Тойиран» гэж сэргээв. Ц. Дамдинсүрэн гуай үүнийг «битүү модот уулын» (7, 29) гэж орчуулсан нь чухамдаа бас Лувсанданзаны эхийн тайлбарыг мөрдсөнөөс зайлахгүй. Бидний бодлоор бол энэ үгийн «той» гэсэн язгуур hой болж, улмаар «ой» болж улиран хувьссан байж магадгүй.

96. Кир-а-дача (хяраас) — гэсэн энэ үгийг судлагч Пеллио, Рахевильз, Хэниш, Қозин, Лигети, Дашцэдэн, Элдэндэй Ардажав нар, Лувсанданзан (31, I, 14) цом «гэрү» гэж сэргээн буулгасан нь харин хятад галигийг дагасан хэрэг бөгөөд энэ үгийг XIV зууны аман аялгууны гуйвсан хэлбэрээр буулгасны улмаас утыг нь зарим нь Элдэндэй Ардажав нарын тайлбарласнаар (8, 48, № 2) ухаарсан бололтой. Энэ үгийн утыг Пеллио (9, 122) Қливз (42, 6), Хэниш (15, 4), Мансан (27, 9) нар цом «уулын ар тал, умар талаас» гэж ойлгосон байна. Үүнийг гагцхүү Ц. Дамдинсүрэн «кир-а» (уулын эгц ирмэг, хэц) гэж буулгаж орчуулсан нь хожим сонгодог (хуучин) монгол бичгийн бичлэгээр (12, 369а) сэргээн босгож зөв оноожээ. Эртний монгол бичигт «кир-а-д-ача» гэж бичиж байсан учраас одоо «хяр» гэсэн дуудлагатай болсон байх. Учир нь энэ үгнээс гаралтай үүрийн «киpar-a», «киралаху» (хяраар явах) эмээлийн «кир-а» (эмээлийн бүүрэгийн ирмэгээр хадах чимэг) гэх мэт ямагт -а төгсгөлт үндэс болох нь ил. Харин хирү- гэсэн үгийн үндэснээс кирүкү (жижигленэ хярах хэрчих) кирү+гэ (хөрөө) гэх зэрэг хигэх хирчих гэсэн өөр утгатай үгс бүтэж байна.

97. Ирэксэд (ирэгсэд) — энэ үг ирэ+ксэн+д гэсэн бүтэцтэй үйл үгийн үйлт нэрийн ирээдүй цагийн олон тооны хэлбэрт үг гэдэг нь тодорхой Харин энэ үйлт нэр «иргэн» гэсэн олон хүнийг хамтатган нэрлэсэн хам нэрд холбогдсон хүртээл нэр учраас түүнтэй тооны ялгалаар зохицож олон тоонд «ирэксэ (н) д» гэж бичигдсэнийг тэмдэглэе.

98. Маг-а ха—гэсэн энэ үгийг бодвол хятад галигт «хо'а» Хэниш (36, 54) гэж тэмдэглэсэн тул эрдэмтэн Пеллио (9, 8), Лигети (32, 21), Рахевильз (25, 18), Баяр (11, 1, 44) тэргүүтэн цом «ха'а» гэж, Дашцэдэн (25, 16), Қозин нар «хаа» гэж, Лувсанданзан (31, I, 13) Баяр (11, I, 44) Иринчин (28, 19) «мах-а хамиг-а» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 50) «маг-а хага» гэж, харин Ц. Дамдинсүрэн (7, 29), Дугаржав нар (24, 8), Мансан (27, 10) цом ганц «хамиг-а» гэж зөв ойлгож хоёр үгийг нэгтгэн сэргээсэн байна. Қозин Хэниш (36, 54), эсвэл Хэниш (15, 5) Пеллио (9, 125) Рахевильз (49, № 4, 1971. 123), Қливз (42, 7) цом «хаана» гэж зөв орчуулсан байна. Бидний бодоход эртний монгол бичигт ха- гэж богино эгшигтэй бичсэн зүйлийг XIV зууны дуудан уншигч задгай үеийн ёсоор «хаа» гэж уртаар дуудан хэлж өгснийг галиглагч ха'а гэж хятад галигт тэмдэглэсэн учраас ташаа болжээ гэхээс гадна хаана гэсэн утгатай үг эртний монгол бичигт ха+мага «хамаг-а» гэж үг нийлэх аргаар бүтсэн нь хожим сунжирч «хамиг-а» болжээ. Иймээс Дамдинсүрэн, Дугаржав, Мансан нар зөв сэргээжээ.

99. Эдүд (еднүүд) — гэсэн энэ үгийг бүх судлаачид «өдүн» (Пеллио, Хэниш, Лигети, Баяр, Элдэндэй Ардажав нар, Қозин, Иринчин, Дашцэдэн тэргүүтэн) гэж, зарим нь (Дамдинсүрэн, Мансан, Дугаржав тэргүүтэн) «едү» гэж цом зөв буулгасан бөгөөд энд эхнийх нь хятад галигийг дагаж сүүлчийнх нь монгол бичгийн ганц тоот хэлбэрээр сэргээжээ. Харин бид Лувсанданзны Алтан товчид (31, I, 14) бичсэнийг дагаж «өдүд» гэж олон тоот хэлбэрээр нь сэргээв. Гэвч энэ нь эртний монгол бичигт «өдү+н үсү+н» гэж бичээстэй байсны сүүлчийн «н» нь олон тооны нөхцөл байсан байж болох тул «өдүд» гэж олон тоонд бичигдэгтэй утга адил учраас Лувсанданзан хоёр үгийг товчилж уг монгол эхэд байсныг дагаж «өдүд» гэж бичсэн байж магадгүй.

100. Үгэй-күн (үгэгүүс) — гэсэн энэ үгийг бүх судлаачид цом «үгэй'үн» гэж буулгадаг ба энэ нь чухам юу болохыг тодий л тайлбарласангүй, гагцхүү Элдэндэй Ардажав нар «үгэкүн нь «үгэй»-ийн олон тоо (8, 54) гэжээ. Чухамдаа энэ нь бидний санавал үгэй+хү (й)+н бүтэцтэй үг бөгөөд үгэй (үгүй) гэдэг үг хү, хүй, хүн гэж хүйс тоо ялган заадаг хүч нэмэгдүүлэх сул үгтэй нийлж бүтсэн үүсмэл үг юм. «Үгэгүү» гэдэг үг ч «үгэй кү» гэсэн хоёр үг нийлж бүтсэн бололтой бөгөөд эцсийн «н» нь олон тооны нөхцөл мөн бололтой юм. Иймд үгэйхүн гэгч нь «огт үгүй» гэсэн утгатай үг юм шиг байна.

101. Хагулуй-а (довтолъёо) — гэсэн энэ үгийг олонхи нь «ха'улай-а» «хаулай-а» гэж буулгаад Хэниш (15. 5) «цэрэглэж дээрэмдье» гэж, Пеллио «дайръя» (9, 126), Рахевильз «довтольё» (49, № 4, 1972, 123), Қливз «дээрэмдье» (42, 7), Ц. Дамдинсүрэн (7, 30) Дугаржав (24, 9) Мансан (27, 10) нар «эзлэн авъя» гэж, Иринчин (28, 21—22), Элдэндэй Ардажав нар (8, 54—55 дугаар т.) агуулъя гэж бүруу галиглан «хагулуй-а» гэсэн үгийг уулгалах гэсэн үг гэж ташааран тайлбарласан атал 37 дугаар §-д байгаа «хагулгай-а» гэсэн үгийг (8, 55) довтолох гэсэн утгаар бидний бодоход зөв тайлбарлажээ. Иймд «Хагулуй-а» гэсэн энэ үг нь хагу (үгийн язгуур хуу гэсэн дайвар үгийн I үндэс) +л (дайвар үгээс үйл үг бүтээх дагавар) +й-а (үйл үгийн шийдэн хүсэх төлөвийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд

мориор газрын хөрс хуулуулан дайръя довтолье гэсэн утгатай үг мөн бөгөөд харин уухайлан уулгалан (хашгиран) довтлох (12, 153а) гэдэгтэй төрөл үг биш болов уу. Харин «МНТ»-ы 56 дугаар §-д «ха' улг-а» (хөрс хуулан давхисан зам нь) «ину үлү олху» гэх мэт үгнээс «мориор давхин довтлох» гэдэг үг болох нь мэдэгдэж байна.

102. Хэлэлэлдүжү (хэлэлцэж) —энэ үгийг галиглах ба ойлгох талаар зөрөөтэй зүйлгүй боловч бид үүнийг хэлэ (нэр үгийн язгуур I үндэс) +лэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +лд (үйл үгийн үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жү (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд эртний монгол хэлэнд «хэл» гэсэн үг нэр ба үйл язгуур нэг дор байгаагүй. Харин хэлний хөгжлийн явцад хэлэ+лэ гэсэн хоёр ижил авиа хураагдаж хэл (нэр үндэс), хэл (хэллэ гэсэн үйл үндэс) хоёр ижил болжээ гэдгийг тэмдэглэе.

103. Алгинчи — гэсэн энэ үгийг хятад галигаас бүх судлагчид ингэж сэргээн босгодгийн дээр үүний утгыг зарим нь «тагнуулч» (Пеллио, Кливз, Хэниш, Элдэндэй Ардажав, Иринчин, Рахевильз, Дугаржав нар) гэх. Харин Ц. Дамдинсүрэн «тэргүүлэн хянагч» (7, 30), Дугаржав «алгинч-тэргүүлэн явж» (24, 9), Мансан «Хушууч болгож тэргүүнд явуулав» гэж (27, 11) гэж тус тус орчуулжээ. Алгинчи гэдгийг чухамдаа мэдээ занги авагч (8, 55) гэсэн манж үгтэй холбож тайлбарладаг. Гэвч бид үүнийг хушуучлан довтлогч газарч гэсэн утгатай болов уу гэж бодно. Учир нь НТ-ы бусад мэдээнээс үзвэл манлан (манлай) нар дайсантай хэлэлцэж мэдээ авалцснаар гардаг юм.

104. Думда кэгэли тай эмэ — гэснийг галиглах талаар судлагчид онц зөрөөгүй. Харин утгыг ойлгох талаар гэвэл Кливз хүүхэдтэй эмтэй дайралдаж Боданчар чи хар хүнтэй юу гэсэн утгаар асуусан мэтээр (42, 8) гэснээс бусад нь жирэмсэн байх хугацааны дунд орсон (Хэниш, Пеллио, Рахевильз, Элдэндэй Ардажав, Иринчин) гэж зөв ойлгож зарим нь «жирэмсэн» (Ц. Дамдинсүрэн, Дугаржав нар), Мансан, Лувсанданзан (31, I, 16) «томун кэгэлиту эмэ) гэж бичээд «томун» гэсний өмнө «бүдүгүн» гэсэн тайлбар хийснийг Иринчин (28, 23 дугаар т.) Лувсанданзаны эхэд «тумта» гэж бичээстэй байсны гэрч гэжээ.

Гэвч энд Лувсанданзан «думун» гэж «дум+н» гэсэн тэмдэг нэр үүсгэн бичсэн байж магадгүй. Учир нь думда гэдэг бол үгийн язгуур 1 үндэс дум+да (дагавар буюу дайвар үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг байж болно. (Ури+да = урида гэдгийн адил) Жирмүсүн гэдэг нь жир (хоёр) мүсүн (бүтүн) гэсэн хоёр үг нийлж хоёр бүтүн гэсэн үг тул (бүдүгүн» гэсэн тайлбар нь ч «бүтүхүн» гэсэн эртний үг байж болно.

Харин энд «жирбүтүн» гэхийн оронд «кэгэли тай» гэсэн нь мал адгуус хүн хоёрыг зааглаагүй байх маш эрт цагийн бүдүүлэг хүний үг найруулга хадгалагдсаны гэрч мөн байж болохыг тэмдэглэе.

105. Дагулижу (дагуулж) — гэсэн энэ үгийг Пеллио, Лигети, Рахевильз, Баяр нар «давулижу» гэж, Элдэндэй Ардажав нар «да'у лижу» гэж, Козин Дашцэдэн нар «даулижу» гэх зэргээр сэргээн босгож байв. Элдэндэй Ардажав нар (8, 58 дугаар т.) үүний утгыг олон толь бичиг аман аялгууны хэрэглэгдэхүүнээр үгийн язгуур дагули, дагулижу гэдэг нь «булааж тонож дээрэмдэх» гэсэн утгатай гэж тайлбарласан нь чухамдаа хятад хадмал орчуулгын (36, 32) дагуу тайлбар юм. Пеллио «хэрэгцээгээ хангасан (?)» гэж, Кливз, Хэниш «дээрэмдэж» гэж, Дамдинсүрэн Мансан «довтолж...зарц болгов» гэж, Дугаржав Рахевильз нар «эзлэн авч» гэж тус тус орчуулснаас сүүлчийнх нь оновчтой. Учир нь Чингисийн чулууны бичигт энэ үгийг тэр үеийн аялгаар «даулижу» гэж бичээд сартуул иргэнийг байлдан «дагуулж» гэсэн утгаар хэрэглэгдсэн байдаг юм. Иймд энэ нь дага+гули+(ла)+жу гэсэн бүтэцтэй үг хураагдаж үүссэн байх.

106. Адугун-идээн (адуун идээн) — гэсэн энэ хоршоо үгийг галиглах талаар судлагч нар санал нэгтэй. Энэ үг бидний бодлоор зөвхөн адуу бус «мал сүрэг идэж уух юм» гэсэн өргөн утгатай хэвшмэл хэллэг юм. Үүнийг судлагч Пеллио, Хэниш, Кливз, Дугаржав нар, Мансан, Элдэндэй Ардажав нар үндсэндээ зөв ойлгож орчуулжээ. Ц. Дамдинсүрэн, Мансан «адуу мал» гэж товчилж, Рахевильз адуу идээ» гэж үгчилж тус тус ухаарчээ.

107. аран тутхар-а (ард амьтан) — энэ үгийг судлагч Пеллио (9, 9). Рахевильз (25, 19), Лигети (33, 23), Баяр (11, I, 53—54) Элдэндэй Ардажав (8, 58—59), Дашцэдэн (26, 17) төм «һаран тутхар-а» гэж зөв галиглаад зарим нь Пеллио «хүний бүрэлдэхүүн» (9, 126), Хэниш «үйлчлэгч хүмүүс» (15. 5), Рахевильз «хөлснийхөн ба зарц нар» (49, № 4, 1972, 124) Кливз «ардууд ба зарц шивэгчин» (42, 8), Элдэндэй Ардажав (8, 59), Иринчин (24, 23—24) «ард зарц» гэж, Дамдинсүрэн (7, 30), Дугаржав (24, 10) «хүн ард» гэж тус тус ерөнхийдөө зөв ойлгож орчуулжээ. Энэ үгийн талаар Элдэндэй Ардажав на-

рын (8, 59) тайлбар хамгийн үндэстэй зөв болохыг тэмдэглэхийн хамт аран (түүний олон тоо)-арад гэсэн үг уттаа Харан, Харад гэсэн үгнээс үүсч гарсныг галигаас мэдэж болох мэт.

108. Ахуй сагухуй-а (ахуй сухуяа) — гэсэн энэ үгийг судлагчид цөм адилавтар галигласан боловч харин утгыг Хэниш «аж төрөх эд юм, сууц» (15, 5) гэж, Кливз аж төрөгч болон сууц» (42, 8), Рахевильз (49, № 4, 1972, 124) «сууц» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 59) «аж амьдархуйд хүрэв» гэж тус тус ойртуулж орчуулсан буюу тайлбарлажээ. Пеллио (9, 126) Дамдинсүрэн (7, 30) Дугаржав (24, 10), Мансан (27, 11), Иринчин (28, 24) зэрэг зарим нь орчуулж тайлбарлалгүй орхисныг үзвэл утгыг сайтар ойлгоогүйн учир болов уу.

Бидний бодлоор энэ нь «ахуй» гэдэг нь «байгаа бүх юм» «сагухуй» гэдэг нь даруй «аж төрж байгаа хүмүүс» энэ бүхнийг нь ээлэлээ гэсэн утгатай бололтой.

109. Жадаран (задаран) — гэсэн энэ үгийг галиглах ба утгыг ойлгох талаар судлаачдын дунд зөрөөтэй санал үгүй бөгөөд «овгийн нэр» гэдэг нь маргаангүй. Харин Нууц товчоонд Задаран овгийг харь овог гэж батлан үзүүлэх гэсэн энэ оролдлого нь их эргэлзээтэй бөгөөд Жамухыг Чингис хааны оронд хаан суух эрхгүй харь овгийн хүн болгох гэсэн зохиогчийн бодлогын илрэл болно. Учир нь энэ талаар Рашид-ад-Дины Судрын чуулган»-д (4, I, 1, 190) энэ овгийн нэрийг Жадаран биш Журъят буюу Жажирад гэж бичсэн юм. «Тэр үед энэ овгийн нэрт толгойлогчдоос Жамуха цэцэн гэж байв» гэжээ. Ер нь ч Нууц товчоонд (§ 40) «Жад иргэн-ү көбэгүн бүлэгэ кэмэн Жажирадай нэрэйидбэ. Жадаран-у эбүгэ тэр болба» гэсэн өгүүлбэр байгаагийн доторх Жажирадай гэдэг нь Жадаран овгийн хүн гэсэн утгатай тул «Жадаран» (харь) гэсэн овгийн нэр энэ хүний нэрээс гарсан гэдэг хуурамч болохыг гэрчилнэ. Түүнээс гадна Тэмүжин Боданчараас хойш 11 дэх үеийн хүн байхад Жамуха Бодончараас хойших тавдах үеийн хүн байж тэр хоёул нэг үед амьдарч байж таарамгүй. Иймд энэ бол Нууц товчоог зохиогчийн улс төрийн бодлогын үүднээс урнаар зохиосон зүйл болно. Жад гэдэг үгийн талаар хамгийн сонирхолтой тайлбарыг Элдэндэй Ардажав нар (8, 60) хийжээ. Гэвч энэ үгийг түрэг хэлний «жат (йат)» гэсэн үгнээс гарсан гэдэг эргэлзээтэй бөгөөд харин монгол хэлний гад (харь-гадаад) гэсэн үгнээс авианы хувьслын дүнд үүссэн биш байгаа гэж эрхгүй санагдуулж байна. Ер нь түрэг монгол ойролцоо дуудлага ба утгатай олон үгсийг хэн нь хэнээс авсныг албадан тогтоох аргагүй бөгөөд эдгээр хэлний төрөл гарал нь бидний огт мэдэхгүй маш эрт балар цагт хамаарах учраас ийнхүү тогтоох аргагүй юм.

110. Тэгүнүгүдэй — гэсэн энэ овгийн нэрийг Нууц товчооны хятад галигт «Түгү'үдэй» (9, 9) гэж байгаа нь овгийн нэрнээс гаргаж өгсөн нэр болох нь ил. Гэтэл энэ хүний нэрийг Лувсанданзаны эхэд «Төгүдэй» (31, I, 16) гэж бичсэн байна. Энэ бол монгол хэлэнд эгшиг уруулаар зохицдог ёс гараагүй эртний худам (язгуур) монгол бичгээр бичигдсэн эхэд Тэгүс «Тэгү+д+ай» гэсэн бүтэцтэй үг байсныг Лувсанданзан уруулаар зохицох ёсоор болгож «Төгүдэй» гэж бичсэн байж болох юм гэж бодож байна. XIV зууны галиглагчид энэ «Тэгүс» гэсэн нэрээс үүссэн гэдгийг ойлголгүй тэгү- гэж эгшгээр төгссөн үгэнд олон тооны нүгүд нөхцөл залгаж тухайн үеийн уруулаар зохицох дуудлагаар Төгү+нүгүд+ай гэж төгүнү'үдэй гэж тэмдэглүүлсэн гэж бодож ийнхүү галиглав. Ер нь овгийн нэрийн эцэст залгадаг дай нөхцөл бол олон тооны д дээр «ай» (аймаг гэдгийн язгуур) гэдэг өөр үг хавсаргаж бүтээсэн зүйл тул зүй нь Тэгү+д+ай гэж (өөрөөр хэлбэл тэгү (с)+д+ийн ай (аймаг) гэсэн биеэ даасан үг хавсаргаж) хэлж байсан боловч ай гэдэг утга нь алдагдаад уг үгийн дагавар болж нийлсэн учир дай дэй заримдаа тай тэй гэж өмнөх өргөлтөд үеийн эгшиг зохицох ёсоор бичигдсэн юм.

Бас хэн+у+ай, йагун+у+ай гэх мэтээр эгшгээр төгссөн элдэв нөхцөлтэй нийлж хэлэгдэх болохоор хоёр эгшгийн хооронд -х -г гийгүүлэгчээр жийрэглэж хэнүхэй, иагунухай (хэнийх юуных) гэсэн үг болжээ. Энэ талаар Мостарт гуайн тайлбарыг үз (47, 289—290, [5—6]).

111. Багарин-у (Баарины) — гэсэн энэ үгийг бас галиглах ба ойлгох талаар судлагч эрдэмтэдийн дунд санал зөрөх зүйлгүй юм. Харин «МНТ»-д энэ Баарины овгийг «барьж авсан эм бүлгээ» гэж Баридай гэж нэрийдэв. «Багарин-у эбүгэ тэрэ болба» гэсэн нь төдий л үнэмшилтэй биш. Учир нь Баридай гэдэг хүний нэрнээс энэ овог «Багарин» овог үүсч таарахгүй, харин «барид» овог үүсч болох юм. Иймд Багарин гэдэг нь өөр нэрнээс үүссэн нь ил байна. Харин «Бари+д+ай» гэсэн энэ хүний нэр нь бари нарын овог гэсэн өөр овгийн хүн гэдгийг харуулж байна. Ер нь энэ мэт баримтаас үзвэл Монголын

нууц товчоонд «Олон монгол аймгийг нэг эцэг эхээс гаралтай нэгдмэл байгаад бутарсан гэж бичсэн нь түүнийг нэгттэх хэрэгтэй гэдэг ухуулга мөн. Чухамдаа олон монголчууд Бодончараас үүссэн гэдэг баримттай хэрэг биш» (50, 60) гэж бичсэнийг үнэн болохыг батлахаас гадна. Монголчууд түүхээ олон хувь бичээд овог бүрийд хадгалдаг байсан бол түүнд овог бүр өөрийн үзэл бодлого ашиг сонирхлын үүднээс энэ мэтээр засвар оруулж болох ашуултай учраас тэд түүхээ ганц хувь бичээд нууцлан хадгалдаг заншилтай байсан гэсэн бидний саналын (үүнийг энэ тайлбарын 3 дугаарт бичсэнийг үз) үндэстэй болохыг харуулж байна.

112. Житгүл-бөхэ — гэсэн энэ хүний нэрийг Нууц товчооны хятад галиг эхэд үзтэл «Чидухул-бөхө» (Пеллио 9) гэж тэмдэглэсэн боловч бид Ц. Дамдинсүрэн (7, 31) гуайн утгачлан сэргээснийг баримтлан Житгүл-бөхэ гэж буулгав. Энэ нь хичээнгүй нөр гэсэн утгатай монгол үг гэж бодож байна.

113. Эмс олату — энэ үгийг хятад галиг эхэд «олоту» [Пеллио (9, 9) Баяр (11, 1, 57)] гэж буулгасан нь чухамдаа XIV зууны галиглагчдын аялгууг тусгасан юм. Монгол хэлэнд үгийн доторх эгшиг уруулаар зохицох ёс гараагүй үеийн худам монгол бичигт «олату» гэж бичсэн байсан гэж бодож ийнхүү галиглав. Жич энэ үг «олан (тооны тэмдэг нэрийн язгуур, 1 үндэс) +ту (чанар эзэмшсэн гэсэн утгатай харьцангуй нэр үг бүтэх -ту дагавар)» залгаж бүтээсэн бөгөөд үгийн эцсийн зарим гийгүүлэгч хаягдаг ёсоор «н» нь хаягдаж «олату» гэсэн үг бүтжээ. Тэгэхдээ Житгүл бөхэ (Зүтгэл бөх) эр хүн учраас -ту залгаж хүйс ялган заасан гэж үзнэ.

114. Боржигин — гэсэн энэ үгийг овгийн нэр гэж олонхи эрдэмтэн судлагчид хэвээр «Боржигин» гэж сэргээн босгожээ. Энэ үгийг Элдэндэй Ардажав (8, 61—62) «бору цэнхэр нүдтэй» гэсэн утгатай гэх боловч Көлүн Буир аймгийн гурван гол (хэн, талбар, Хабул)-ын Талбур голд цутгах Боржигун гол гэдэг Боржигин овгийн үүсэлтэй холбоотой болно гэж газрын нэрээр тайлбарлажээ. Гэвч бид Рашид-ад-Дин (4, т. I кн. 1. с, 79) «хөх нүдэт» гэсэн үг гэдэг боловч энэ төдий л үнэмшилтэй биш. Үүнийг нь «Боржигин» гэдэг үг үнэхээр нүдний өнгөтэй холбоотой бол гагцхүү «Бору» гэсэн үндэстэй байж болно. Тэгвэл «Боружигин» гэж баймаар юм. Гэтэл боржигин гэдгийн сүүлчийн «н» нь олон тооны нөхцөл байж Хатагин гэдгийн үлгэрээр бүтсэн үг гэж бодож байна. Хэрэв ингэж үзвэл үгийн үндэс нь Боржиги гэсэн үг байх тул харин «Буржигир үст» гэсэн хоч нэрээс гарсан байж бас магадгүй юм. Гэвч энэ бол зөвхөн таамаг юм.

115. Абали(н) эм-э (авааль эм) — гэсэн энэ үгийг Пеллио, Хэниш, Баяр, Иринчин зэрэг олонхи нь хятад галиг эхийг мөрдөж «аблин» гэж, Лигети, Рахевильз, Дашцэдэн зэрэг зарим нь «а[б]лин» гэж ташаа сэргээж, Дамдинсүрэн, Дугаржав, Мансан зэрэг зарим нь хуучин бичгийн уламжлалыг барьж «абали эм-э» (эсвэл «гэргий») гэж зөв сэргээсэн буюу орчуулсан юм. Хятад хадмал орчуулгыг нь «өөрийн авсан эм» гэж Хэниш тайлсан (36, 2) тул өрнөдийн орчуулагчид ойролцоо утгаар орчуулжээ.

Бид энэхүү үгийг XIV зууны галиглагчид дуудан уншсан ба сонсож тэмдэглэсний дагуу хоёр и, э хоёр эгшгийн хоорондын гийгүүлэгч жийрэглэх, б гийгүүлэгчийн дараах балархайшсан (а) эгшгийг хасах зэргээр гуйвуулан «аблин эм-э» гэж бичсэн гэж бодно. Үүнийг бид хуучин монгол бичгийн уламжлалт бичлэгийн үүднээс «абали эм-э» гэж сэргээн сийрүүлсэн бөгөөд зөв гэж бодно. Үүнийг нь үүнтэй гарал нэгтэй абахай (язгууртны охины хүндэтгэл нэр) абагай (эм хүний хүндэтгэл нэр) (12, 4б) зэрэг үгийн бичлэг үүнийг гэрчилж байна.

116. инжин-э ирэксэн-и (инжинд ирснийг) гэсэн энэ үгийг хятад галиг эхэд «инжэ ирэксэн-и» гэж хятад хадмал орчуулгад «бэрийн дагуул бүсгүй» Хэниш, (36, 82) гэсэн тул судлагчид ихэвчлэн «инжэ ирэксэн-и» (Пеллио, Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин), Лигети, Рахевильз, Дашцэдэн зэрэг зарим нь «инжэ» ирэк (сэ)н» гэж ташаа сэргээжээ. «Инж-э» гэсэн үгийг Ц. Дамдинсүрэн, Мансан, Дугаржав нар «инжид» буюу «инжинд» гэж өгөх орших тийн ялгалын нөхцөлтэй үг гэж зөв ухаарч Элдэндэй Ардажав нар (8, 62—63) утгыг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Бид «инжэ» гэсний эцсийн -э авиаг өгөх оршихын тийн ялгалын нөхцөл гэж үзэж, түүнийг галигт ж гийлүүлэгчийн дараа бичсэнийг XIV үеийн галигч нарын аялгуунд ж-гийн дараах и балархайшиж гээгдсний гажуудал гэж бодож эртний хуучин бичигт энэ үгийг «инжи» гэж бичдэг уламжлалаар «инжин-э (инжид) ирэксэн-и (ирсэн бүсгүйг)» гэж сэргээн сийрүүлэв.

117. Жүкэли-дур — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс Хэниш, Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Элдэндэй Ардажав нар «жү'эли» гэж, Лувсандансан, Иринчин, Мансан, Баяр зэрэг зарим нь «жүкэли» гэж, Ц. Дамдинсүрэн «жүкүли» гэж Дугаржав «тахилга-дайллага» гэж буулгасан байна. Хятад хадмал орчуулгад Хэниш, (36, 94) «Тэн-

гэр газарт зориулсан тавиг өргөж» гэсэн байх тул цөм энэ утгаар ойлгож Пеллио «тавиг тайлгад оролцох эрх» (9, 127) Кафаров (комм. № 40) «өвгөдийн онгонд тавиглах ес» гэж, Хэниш «Шургаагт тайлга», Рахевильз «махтай тайлга», Кливз «жүгэлид хувьтай» (42, 9) гэхчлэн орчуулжээ. Ялангуяа Элдэндэй Ардажав нар энэ үгийг ихэд дэлгэрэнгүй (8, 163) тайлбарлажээ.

Гэвч бид «жүкэли» гэсэн үгийг ихсийн газар гарч хийх тавигийн нэр биш, харин тэр тавиг дээр онгодын ивээл хүртэхээр үглэж гуйх үгийн нэр бөгөөд «жүкэкү» (Шагж, 12, 531а) гэсэн үгнээс гаралтай гэж үзэж Лувсанданзаны «А. то.»-д (31, 17) бичсэнээр сийрүүлэв.

118. Гэр даруг-а (гэр дарга) — энэ үгийг судлагчид ийнхүү буулгаад цөм гэрт Аданхан Урианхай хүн ямагт байлаа гэсэн утгатай гэж орчуулснаас гадна даруг-а гэсэн үгийг Баяр гуай «талуга» гэж өөр үгээр галиглаж Элдэндэй Ардажав нар (8, 64) «гэрт үргэлж (байнга) гэсэн утгатай» гэж тайлбарлажээ. Энэ нь бодвол хятад хадмал орчуулгын эндүүгээс гарсан зүйл гэж бодож байна. Бидний санавал «гэр даруг-а» гэдэг «гэрт байнга» байсан гэсэн утгагүй. Харин гэр тэргэний хэргийг мэдэгч даруг-а (гэрт хөдлөх зарц нарын ахлагч) гэсэн утгатай гэж бодож байна. Тэмүжинийг хан болоход Гүчүгүр гэгч «би гэр тэрэг эрхэлье» гэж ам өгснөөр (§124) гардаг юм. Хожим энэ үүргийг Чингис хаан хэвтүүлд хамааруулж «Бидан-у умдан идэгэн-и хэвтэгүл даругалатугай» Пеллио, (9, 91) [§232] гэснээс «гэр даруг-а» гэгч зарц нарын дарга ахлагч гэсэн утгатай байсан нь баримттай байна.

119. Аданха Урианхадай — гэсэн нь галигчид ба судлаачдад овгийн нэр гэдэг нь илэрхий. Гэвч «Аданхан» (§ 38) гэдэг нь «урианхажин» гэдэг үгийн хүртээл нэр мөн бол Аданха гэдэг нь уг овогтны биеэ даасан нэр учир Аданха-Урианхадай гэдэг нь уг овог аймгийн нийлмэл нэр болно.

120. Мэнэн-дотахун — гэсэн энэ хүний нэрийг хятад үсгийн галигт Мэнэн Түдүн (9, 9) Рашид-ад-Дин (4, I, 2, 17) Дутум Мэнэн гэж тус тус бичсэн юм. Гэвч бид энэ хүний нэрийг Мэнэн гэж «дотахун» гэдгийг нь 7 дугаар үеийн өвөг гэсэн үг байгаад тэр нь 13—14 дүгээр зууны үед Дотун буюу Тодун гэж өөр гуйвсан дуудлагаар тэмдэглэгдсэн байж болно гэж «Мэнэн дотахун» гэж галигласан болно. Мэнэн бол Чингис хааны долдугаар үеийн өвөг мөн гэж Рашид-ад Дин (4, I, 2, 18) бичив. Рашид-ад-Дины түүхийн ёсоор бол Чингис хааны VII өвөг нь Мэнэн-дотахун, VI өвөг (Бу'ути) нь Хайду-хан V өвөг (Бүдэ-үкү'ү) нь Байшонхор-догшин VI өвөг (Будуту) нь Түмбинай-цэцэн, III өвөг (Элинчиг-элин эцэг) нь Хабул хаан, II өвөг (эбүгэ-өвөг) нь Бартан баатар, I өвөг нь (эчигэ-эцэг) нь Есүхэй баатар болно. Иймээс «МНТ»-д Боданчарын авааль эмээс Барим ширату Хабич-баатар төрсөн гэдэг нь үнэмшилгүй. Учир нь Боданчар ойд авааль гэргийгүй ганцаар байсан. Иймээс Хабичийн эхийн инжид ирснийг татаж явсан, түүний хүү Жагурдайн тухай өгүүллүүд бол Жамухын овгийг хаан суух ёсгүйг батлах гэсэн улс төрийн бодлогоор оруулсан зохиогчийн товчооллын зүйл юм. Нууц товчооны ёсоор Мэнэн-дотахуны хүү Хачи хүлэг, түүний гэргий Номолун (Монолун), Харин Рашид-ад-Дины ёсоор Монолун тарган бол Мэнэн дотахуны гэргий юм. Персийн түүхч Барим ширату Хабич баатрыг Түмбинай хааны хоёрдугаар хүү, Барим шир Бука-буджу (4, I, 2, 29), Хачи күлүкийг мөн Түмбинай хааны тавдугаар хүү Баткүлки (Бату-Күлүк) (4, 1, 2, с. 30) гэж тайлбарласан байдаг. Энэ нь үндэстэй байх.

Энэ бүхнээс үзэхэд Боданчар ман-хан, түүний хүү Хабичи баатар, түүний хүү Хачи хүлүг нарын тухай «МНТ»-ы өгүүллүүд бол төрийн бодлогын үүднээс оруулсан үлгэр домгийн шинжтэй зүйл бололтой.

121. Монолун экэ — энэ хүний нэрийг Нууц товчоонд «Номолун» [(Пеллио (9, 10), Хэниш (36, 180)] гэж тэмдэглэсэн боловч бид өөр түүхэн сурвалж бичгийг үндэс болгон [Рашид ад-Дин (4, I, 2, 18) «Мунулун» «Дайзу Чинггис хаган-у тугужи»-д (51, 4. А) «Моналун» гэж, «Юван улус-ун судур»-т (52, 3 А.) «Манан Дутан-у эм-э Моналун» гэснийг] дагаж Маналун (буюу монгол гэж нэрлэгдэж агсан өөр) аймгийн эмэгтэй байжээ гэж бодоод «Монолун» гэж буулгасан бөгөөд «Номолун» гэдэг нь «монолун» гэдэг үгийн эхний үеийг сэлгэж дуудсан XIV зууны галигч нарын ташаа бичлэг гэж үзэв.

122. Нойахан (ноёхан) — гэсэн энэ үгийг галиглах ба ойлгох талаар судлаачдын дунд зөрөөтэй зүйл байхгүй. Бид энэ үгийг нойа (үгийн язгуур, I үндэс) +ан (овгийн хамаарлыг заах үг, хожим дагавар болж ай, эй гэж уг үгийн эгшигтэй зохицох болсноос гадна үгийн үндэсийн а, ай дагаврын эхний а хоёрыг «х» гийгүүлэгч жийрэглэн салгаж нойа-х-ай гэсэн үг болж улмаар олон тооны нөхцөл н залгахад «й» нь хураагдаж «нойаха(й)н» гэсэн үг бүтсэн гэж үзэв.

123. Барулас (Барлас овог) — энэ үгийг Нууц товчоонд эл овгийн гарлыг ардын үгийн үүсэл зүйн ухаарлаар идээн барах ховдог гэсэн үгнээс үүссэн гэж **тайлбарласан** боловч энэ нь төдий л үнэмшилтэй биш. Учир нь тийм бол энэ үгийг «МНТ»-ы хятад галиг эхэд «Барулас» Хэниш (36, 73), Пеллио (9, 10) гэж бичих ёсгүй харин «Баралас» гэж бичих ёстой байв. «Идэ'эн-э барух» гэсэн хятад галигийг баримталж Пеллио (9, 10), Баяр (11, I, 64), Иринчин (27, 27), Ардажав Элдэндэй нар (8, 67), Рахевильз (25, 20) тэргүүтэн цөм «идэ'эн-э барух» гэж, Лигети, Дашцэдэн нар «бару (г)» гэж миний бодоход алдаатай сэргээжээ. Энэ нь хятад галигч нар «идэ'эн бараху» гэсэн үгийг ташаа галигласнаас болжээ. Хятад хадмал орчуулгыг Хэниш «долгин омголон, ховдог» (36, 13) гэж орчуулснаас «бараху» (ховдог) гэж ухаарсан нь мэдэгдэнэ. Харин «баруг» гэгч «ихэвчлэн» (Шагж, 12, 247а) гэсэн утгатай тул «ховдог» гэсэн утгатай нийцэхгүй Иймээс энэ үгийг Ц. Дамдинсүрэн (7, 31), Дугаржав (24, 11) «идэгэн бараху ховдог» гэж, Мансан (27, 13) «идэгэн хогосуратулдаг» тул гэж орчуулсан нь зөв юм. Жич Лувсанданзан (31, I, 18 дугаар талд) «Идэгэн-и барахун тул барлаг омуртан болба» гэж бичсэн нь түүнд байсан «МНТ»-ы худам монгол эхэд ингэж бичээстэй байсныг дам гэрчлэх мэт байна. Учир нь «барахун» гэдэг нь овог буюу олон хүний үйлийг заасан учир «барахун» гэж үйлт нэрийн олон тооны хэлбэрээр зохицолтой бичигдсэн байна. Бас «барлаг» гэдэг нь «баралас» гэж бичээстэй байсны л үсгийн эврийг а-гийн ацгаас татсан алдаа ба үгийн эцсийн «с» авиаг богино сүүл шиг бичдэг хуучин бичгийн уламжлалаар л-ийн дараах а-тай нийлж -(а)г (агшлага) шиг болжээ.

Гэвч Лувсанданзаны эхэд «Хачила-йин көбэгүн идэгэн-э барухун-а йэкэ бэйэ тү-ийн тула йэкэ Барула кэмэн нэрийтбэ. Баруласку омог тан болба. Эрдэм тү барла тодэкэн тэригүтэн Барулас-ун эбүгэс тэр бүлүгэ» (31, I, 12) гэх зэргээр бичсэнээс үзвэл энэ овгийн нэр «Барулас» гэж байсныг «идээ барах» гэсэн ардын үгийн гарал зүйн тайлбарт зориуд хамруулах гэж оролдсоныг харуулж байна. «Баруг» гэдэг үгийг Элдэндэй Ардажав нарын (8, 67) тайлбарласныг үүнд холбогдуулан үзэхэд сонирхолтой болно.

124. [+мэтү] хутхул(д)уху — гэсэн энэ үгийг Пеллио, Баяр, Дашцэдэн тэргүүнтэн зонхилох судлагчид хятад галигаас «хутхулаху» гэж сэргээн, хятад хадмал орчуулгад «хутхах» «хөдөлгөх» (Хэниш, 36, 73) гэж ойлгодог билээ. Пеллио «гараар цагаан будаа авахдаа ахлагч үгүй» (9, 127) гэж, Хэниш мөн «цагаан будаа хутгахдаа (аягалахдаа?) дэс дэвгүй тул» (15, 6) гэж Рахевильз «будаа чанахдаа ахлах ёс баримталдаггүй тул» (49, 125), Кливз «Шар будаа хөдөлгөхдөө толгойлогч үгүй тул» (42, 10) гэж, Элдэндэй Ардажав нар «будаган» гэмэн нэрэлэгдэксэн инү гагчахү шингэн будаган луга зүйирлэксэн йабудал болумуй» (8, 68) гэж, Дугаржав нар «будаг-а мэтү эхи адаг үгэй тула» (24, 11), Мансан «будаг-а хутхухү мэтү эки адаг үгэй тула» (27, 13) гэж тус тус орчуулжээ. Бид Лувсанданзаны «А. то»-д «буда (г-а) мэтү» (31, I, 18) гэсэн эхийг баримталж Ц. Дамдинсүрэнгийн «будаг-а мэтү эхи түрүгүү үгэй хутхулдуху тул» (7, 31) гэж орчуулсныг чухам зөв нь гэж баримтлан ингэж сэргээв. Хятад галиг эхэд «мэт» гэдэг үг нь орхигдсон гэж бодож байна.

125. Адархин — энэ үгийг галиглах ба орчуулах талаар онц зөрөөтэй зүйлс байхгүй. Харин энэ үгийн утгыг хятад товч орчуулгад (Хэнишийн орчуулгаар) «доромжлох, хордуулагч (хорсолдон тэмцэлдэгч?)» (36, 2), Хэнишийг дагаж Пеллио «харилцан маргагч» (9, 127), Хэниш «хоорондоо [хов] хөөцөлдөгч» (15, 6). Рахевильз «гүтгэлэг муу үг тараагч» (49, 125), Кливз «эсрэгцэлдэгч» (42, 10), Дугаржав нар «адарулдугчи» (24, 11), Мансан «атагархажу өшийэркэкч» (27, 13), Элдэндэй Ардажав «тааралдахгүй (таарамжгүй) хэдэр зантай» (8, 69) гэх зэргээр ойлгож орчуулсан байна. Лувсанданзан «эндэ тэндэ кэлжү йэнгкүкчи» (олхийан өгүлэкчи) (31, I, 18) гэж Ц. Дамдинсүрэн «адарматай (йакир кэрэгүлчи)» (7, 19) гэж ойлгосон байна.

Энэ овгийн нэрийг Рашид-ад-Дин «Кадаркин» (4, I, 1, 190) гэснээс бид адараатай гэдэг үг эртний монгол хэлэнд «хадаргатай» гэдэг үгнээс гарсан болов уу гэж «адархин» гэж буулгав. «МНТ»-ы 164 дүгээр зүйлд «Арагату могай-а адарда'асу» гэсэн нь могойн шүдэнд «хадрагдаваас» (гахайд хадрагдвал гэдгийн адил) гэсэн үг байх гэж таамаглав.

126. Уруғуд (овгийн нэр) гэсэн энэ үгийг хятад галиг эхээс Пеллио (9, 10) Баяр (11, 65) гэх мэтээр судлаачид «уру'уд» гэж сэргээсэн юм. Харин Рашид-ад-Дин «урут» (4, I, 1, 184) гэж бичсэнээс үзвэл тэр (XIV зууны) үеийн Иранд байсан монгол хүний хэл аялгуунд уруг-уд гэсэн үгийг г гийгүүлэгч нь сугарч уру'уд болсноор барахгүй

эгшгүүд нийлж «урууд» гэж хэлэгдэх болсныг персийн түүхч «Урут» гэж тэмдэглэсэн байж болох юм.

Бидний бодлоор бол уруг (үгийн язгуур, нэр үгийн 1 үндэс) +уд (гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулдаг нэр үгийн олон тооны үндэс үүсгэх нөхцөл) гэсэн бүтэцтэй үг юм. Бас Лувсанданзан энэ үгийг «ургуд» (31, I, 18 дугаар талд) гэж бичсэнээс үзвэл энэ үгийг түүхчийн хуучин эхэд үгийн эгшиг уруулаар зохицдог ёс гарахаас өмнөх үеийн эртний бичлэгээр ураг+уд гэж бичдэг байгаад а нь балархайшсан учир хаягдсан байж ч болно. Эсвэл энэ үг «Оруг+уд» (саарлууд) гэсэн үг байсан байж ч бас магадгүй.

127. Манггуд (овгийн нэр) — энэ үгийг судлагчид хятад галигаас голдуу (Пеллио, Хэниш, Баяр, Дашцэдэн тэргүүтэн) «мангхуд» гэж сэргээн босгосон байна. Энэ үгийн утгыг бид монгол гэдэг үгийн хуучин хэлбэрийг хадгалсан нэртэй овог байжээ гэсэн утгаар ойлгож байна. (Энэ тайлбарын 1 дүгээр зүйлийн тайлбарыг үз)

128. Шижигудай (Шижин овгийн хүн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас судлагчид [Пеллио, Хэниш (36, 182), Дашцэдэн, Баяр, Элдэндэй Ардажав нар, Лигети, Рахевильз, Мансан] бараг цөмөөрөө «шижи'удай» буюу «шижигудай» гэж, Дугаржав «Шижүгудэй» гэж сэргээсэн байна. Харин Ц. Дамдинсүрэн «Шижигдай» (7, 32 дугаар т.) гэж сэргээн босгосныг бид зөв гэж мөрдөн бичив. Учир нь Лувсанданзаны «Шижихудай» (31, I, 18 дугаар т.) гэж Рашид-ад-дин «Сиджиут» (4, I, 2, 183) гэж тус тус бичсэн нь энэ үгийн уг бичлэгт ойр болсон байна. Бид энэ үгийн утгыг Ши (шигэхү-гэсэн үгийн язгуур) +жи (бусад үгээс үйл үг бүтээх дагавар) +(н)г (үйл үгээс их зэргийн нэр бүтээх дагавар байгаад (н) нь сугарч хаягдсан тул г нь үлдсэн) +уд (нэр үгийн олон тооны нөхцөлийн гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулах хувилбар) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Иймээс овгийн нэрийг «Шижингүүд» (шижинг) (53, 845 А)-уудын овог гэсэн овгийн хоч нэр бололтой. Энэ нь Энх+жи+нг=Энхэжинг гэдэгтэй адил загвараар үүссэн үг бололтой.

129. Догуладай (Доголад овгийн хүн, — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио, Хэниш, Баяр, Дашцэдэн тэргүүтэн ихэвчлэн «Доголадай» гэж сэргээн босгожээ. Харин үүний утгыг бид Пеллио авгайн тайлбарласнаар «доголон» (54, 69—70) гэсэн утгатай гэж бодно. Энэ үг ийм утгатайг Лувсанданзан мэдээд энэ хүний нэрийг «Догулху дай» (31, I, 18) гэж, мөн Ц. Дамдинсүрэн (7, 32) Баяр (11, 66) нар мэдээд хуучин монгол бичгээр «Догулдай» гэж бичсэн байв. Гэвч бид энэ үгийг Догу (дайвар үгийн язгуур, 1дүгээр үндэс) +л (дайвар үгээс үйл үг бүтээх дагавар) +анг (үйл үгээс нэр үг бүтээх дагавар)-д (олон тооны нөхцөл. Үүнийг залгахад «нг» гийгүүлэгч хасагдаж догулад болно) +ай (доголадын ай (аймаг) бүюу доголад овгийн гэсэн үг болсон) гэж бид таамаглаж ийнхүү сийрүүлсэн болно.

130. Бар-сингхур догшин (хүний нэр) — энэ үгийг хятад галигаас судлагчдын зарим (Дамдинсүрэн, Дугаржав, Мансан, Баяр) нь «Байшинхор» гэж, зарим нь (Пеллио, Иринчин, Баяр, Дашцэдэн, Лигети, Хэниш, Элдэндэй Ардажав нар) «Бай-шингхор» гэж гагцхүү Лувсанданзан эртний худам монгол бичгийн эхээ баримталж «Бар-шинг-хур» (37, 19) гэснийг эртний бичлэгийн зөв хэлбэр нь гэж бид ингэж сэргээж бичив.

Учир нь эртний худам монгол бичигт Хангай-хан гэхийг «Хангар-хан» хоголай гэхийг «хогулар» гэх зэргээр үгийн эцсийн «й» гийгүүлэгчийг түүнтэй сэлгэдэг «р» авиагаар тэмдэглэдэг байсны баримт цөөнгүй байна. Нөгөө талаар энэ нэрийг Рашид-ад-Дин «Бай Сонкур» (4, I 2, 25) гэж бичсэнээс үзвэл XIV зууны Иран дахь монголчуудын хэл аялганд си (ши) нь со (шо) болж, харин II үеийн «у» хожимийн үеийх шиг О-гоор бус, У-гаар дуудагддаг, бас эл хоёр үгийг салангид бичиж байсныг гэрчлэх мэт. Иймд бид энэ үгийг Бай (бая (н) сингхур (Шонхор) гэсэн утгатай хүний нэр гэж бодож байна.

131. Чарахай Лингхуба (хүний нэр цол) — гэсэн үгийг хятад үсгийн галигаас судлагч Пеллио, Лигети, Хэниш, Рахевильз, Дашцэдэн, Баяр, Элдэндэй Ардажав нар, Мансан тэргүүтэн олонх нь «Лингху» гэж, Лувсанданзан (31, 1, 19) Ц. Дамдинсүрэн (7, 32), Мансан (27, 13) тэргүүтэн зарим нь «Лингху-а» гэж сэргээж бичсэн юм. Энд сүүлчийнх нь арай ойртуулжээ. Рашид-ад-Дин энэ хүний нэрийг «Чаракэ лингүм» гэж бичээд «лингүм» «ахмад эмир (ноён)» гэсэн хятад үг (4, I, 2, 21) гэснээс үзвэл тэр үеийн (XIV з.) монгол хүний хэл аялгуунд эртний үгийн «б» авиа бүтэх орон ойртой «м» авиатай сэлгэдэг байжээ. Иймд энэ үг лингүм биш «Лингхуба» гэж бичигдэж болох юм. Лувсанданзан энэ үгийн утгыг сайн мэдэлгүй хожимын монгол бичигт гардаг нэг зүйл цэцгийн нэр гэж ухаарсан бололтой.

132. Чагужин ортагай (хүний нэр хоч) — энэ үгийг хятад галиг үсгээс Лувсанданзан «Чаучин Өртэгэй» (31, I, 19) гэж, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Элдэндэй Ардажав нар, Иринчин, Мансан тэргүүтэн

олонх нь «Чаужин өртэкэй» гэж, Дамдинсүрэн Дугаржав хоёр «Чагужин ортагай» гэж сэргээн бичжээ. Рашид-ад-Дин энэ хүний нэрийг «Чаоджин-Хүкүр» (4, I, 2, 20) гэж тэмдэглэсэн юм.

Бид үүний «Чагужин» гэдгийг Тэмүжин, Мэгүжин гэх мэтийн адилаар бүтсэн хүний нэр гэж, нөгөө ортагай гэдгийг «орсугай» (гадагшаа цухуйсан шүдтэй) гэсэн хочийн эртний худам монгол бичгээр бичигдэж байсан хэлбэр нь гэж таамаглаж байна. Учир нь Рашид-ад-Дины «Чаоджин хүкүр» гэсний күкүр гэдэг нь ч айргийн сав, «хөхүүр» гэдэг хоч нэр байж магадгүй юм эсвэл тамхины «хөөрөг» гэсэн хоч ч байж болмоор санагдана. Юу гэвэл хоёр нэрийн 2 дугаарт байгаа нь их төлөв хоч нэр байх бөгөөд тэр хочноос нь овогийн нэр үүсдэг байжээ.

133. Сэнггүм Бэлгэ (хүний цол нэр) — гэсэн энэ нэрийг хятад галигаас судлаачид цөм «Сэнггүм Билгэ» гэж сэргээн босгодог. Харин бид гагцхүү Лувсанданзан (31, I, 19) энэ хүний нэрийг «Билгэ» бус, харин «Бэлгэ» гэж сэргээснийг зөв гэж баримтлав. Учир нь «Бэлгэ» гэдэг ялгах «тэмдэг» гэсэн утгатай монгол үг бөгөөд үүнийг хуучин (сонгодог) монгол бичигт ийнхүү бичдэг уламжлалтай. Энэ эртний худам монгол бичгийн эхэд нь «Бэлгэ» гэж байсан учраас Лувсанданзан хятад галигаас нь зөрүүлэн бичсэн байж болно. Хэрэв энэ хүний нэрийн утга «ухаан авъяас» гэсэн утгатай байсан бол монгол бичгийн уламжлал ёсоор «Билиг» гэж бичигдэх ёстой байсан биз.

134. [бүлүгэ Сэнггүм Бэлгэ-йин көбэгүн]... [хаган тэригүү—] [бөлгөө. Сэнгүм Бэлгийн хөвгүүн]... [хаан тэргүү—] гэсэн үгсийг бид Лувсанданзаны «Алтан товч» (31, I, 19)-оос хуулан авч нэмж оруулав. Үүнд бид энэ хэдэн үгийг Монголын нууц товчооны хятад галиг эхэд оролгүй орхигдсон бөгөөд Лувсанданзаны үзсэн «МНТ» өөр бүрэн эхэд нь байсан үгс гэж үзсэн Пеллио (55, 1—17)-гийн саналыг зөв гэж үзэж Нууц товчооны хятад галигт орхигдсон энэ хэдэн үгийг Лувсанданзаны эхээс Пеллиогийнхоор нэмж оруулав.

135. Бэсүд (Йисүд) овогтон — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс судлагчид «Бэсүт» буюу «Бэсүд» гэж сэргээн босгодог юм. Харин энэ үг юу гэсэн утгатайг хэн ч бараг тайлсангүй. Бид энэ үгийг «Йисүд» гэсэн үг гэж бодно. Нууц товчоог хятад галиг үсгээр тэмдэглүүлсэн хүн «йисүд» гэсэн үгийн й (j) үсгийг XIV зууны үеэс хэрэглэгдэх болсон «в» үсэгтэй хутгаж буруу дуудан уншиж өгсөн бололтой гэж санагдана. Учир нь: Рашид-ад-Дины «Йисүд» аймаг (4, I, 1, 193) гэж бичээд энэ овгийн алдарт хүнд Зэв ноёныг оруулснаас (тэнд 194 дүгээр талд) Бэсүд Йисүд овог адил болох нь мэдэгдэнэ. П. Пеллио Амби нар үгийн Үншин (үүшин) гэдэгтэй хослуулж хэрэглэж байжээ. (54, 73) гэсэн боловч бид «Йэсүд» гэсэн үгийг XIV зууны галиглагчид «Висүд» гэж буруу дуудаж өгөхдөө үгийн эхэнд В үсэг байхгүй тул «бэсүд» гэж хэлж өгснөөс ташаарсан гэж бодоод «Йисүд» гэж буулгав. Харин «Үгүшин» буюу Рашид-ад-Диний «хушин» (4, I, 1, 171) гэж бичсэн өөр овог бол Зүрхэний нутгаас олдсон гэж «МНТ»-нд тэмдэглэгдсэн Борохул ноёны овог мөн. Харин Бэсүдийн нутгаас олдсон Көкүчү (§ 138), Зэв ноён хоёр бол даруй энэхүү Йисүд овгийн хүмүүс болно.

136. Хонгхутан (овгийн нэр) гэсэн энэ үгийг хятад галигаас судлаачид «хонгхотан» гэж сэргээн бичдэг бөгөөд энэ үгийн утгыг Рашид-ад-Дин «том хамарт» (4, I, 1, 167) гэж тайлбарласнаас үзвэл хонхор нүдтэй том хамартай онхор царайтай хүний удмыхан ажээ. «Хонхор Гомбодорж» гэж нэг бөхийг хочлон нэрлэдэг байна. Иймд Хонхо(—р)+та(—й)+н гэх зэргээр дагаврын аргаар бүтсэн үг бөгөөд хонхор нүдтэй, монхор хамартны овог гэсэн утгатай үг бололтой юм.

137. Өкин Бархаг (хүний алдар нэр) — гэсэн энэ үгийг галиглах ба орчуулах талаар эрдэмтэд судлаачид онц зөрөөгүй боловч Рашид-ад-Дины тэмдэглэснээр бол «өкин» гэдэг үг «охин хүүхэн» гэсэн утгатай бөгөөд залуу сайхан бүсгүй шиг үзсэн хүнийг гайхан бишрүүлэм үзэсгэлэнтэй учир Охин Бархаг гэж алдаршуулж нэрлэдэг» (4, I, 2, 32—33) байжээ. Иймд «Өкин» гэдэг нь энэ хүний алдар Бархаг гэдэг нь нэр, нийлээд «Сайхан Бархаг» гэсэн үг болно.

138. Хутугту Мөнгхүр—энэ үгийг олонхи судлагчид: Пеллио, Дугаржав, Хэниш, Баяр, Иринчин, Элдэндэй Ардажав цөм «Хутугту Мөнгкүр» буюу «Мөнгхүр» гэж, Лигети, Рахевильз, Дашцэдэн нар «Хуту(г)ту мөнггүр» гэж тус тус сэргээн сийрүүлжээ. Бодвол хятад галиг эх ба Лувсанданзаны эхийг баримталсан хэрэг. Гагцхүү Ц. Дамдинсүрэн «Хутагту монгхор» гэж сэргээн сийрүүлсэн нь бас ч байж болох санал юм. Учир нь Дөрбэй догшин, Хачиун элчи гэх мэтийн адилаар өмнөх үг нь нэр, дагалдсан үг нь овогийн нэр, хоч, алдар, хэргэм байж боло-

хыг үгүйсгэх аргагүй. Нөгөө талаар «Монхор» гэх мэт үйл үгийн захирах хүсэх төлөвийн үгээр хүнд нэр өгөх удаа бараг үгүйн дээр мөнгүр (Мөнгө+р) буюу «мөнгө бол» гэсэн утгатай нэр ч байж таарамгүй юм. Бас Рашид-ад-Дин Хутукту Мунгур буюу Мункур (4, I, 2, 33—34) гэснээс үзвэл Дамдинсүрэн гуайн сэргээлт илүү зөв гэж түүнийг баримтлан бичив.

139. Хотала хаган (хүний алдар цол) — гэсэн энэ үгийг хятад галигт «Хутула хаһан» (Пеллио, Рахевильз, Баяр, Дашцэдэн тэргүүтэн олонхи нь) гэж тэмдэглэснээр сэргээн сийрүүлж хүний нэр гэж ухаарч иржээ. Гэвч Лувсанданзаны Алтан товчид (31, I, 19 дүгээрт), «Хотала» гэж бодвол хуучин эртний монгол бичгийн эхийг дагаж сийрүүлэн бичсэн байх тул түүний энэ сэргээлтийг Ц. Дамдинсүрэн (7, 32), Мансан (27, 14), Баяр (11, I, 70), Дугаржав (24, 12) нар зөвшөөрөн дагасныг бид зөв гэж баримтлан сийрүүлэв. Хэдийгээр «Хотула» (хоёр настай тарбага—(12, 383а) «Ходул» (хандгайн зулзага—12, 383б) гэх мэт утгатай үг байж болох авч тийм гэсэн утгатай үгээр Монголын язгууртнууд залгамжлагч нартаа нэр өгсөн гэхэд үнэмшилгүй. Иймд бид «Хотала хаан» гэсэн үгийг уг хүний онооссон нэр бус харин нийт олны хаан гэсэн утгатай бөгөөд Даян хан, Ун-хан, Чингис хан гэдгийн адил «Хотала (нийтийн бүгдийн) хаан» гэсэн алдарын нэр гэж үзэж «Хотула» гэсэн нь Монгол хэлэнд үгийн дотор эгшиг уруулын байршлаар зохицох ёс гарснаас хойш үеийн (XIV зууны) аялгаар тэмдэглэсэн гаж буруу сэргээлт гэж бодож байна.

140. Зүркин (овгийн нэр) — энэ үгийг галиглах ойлгох талаар зөрөлдөөн судлагчдын дунд үгүй. Гэвч энэ овгийн үүсэл гарлыг «МНТ»-д тайлбарласны адил ардын үгийн гарал зүйн гэнэн тайлбараас үзвэл «Жиргүкэ» (зүрх) гэсэн үгийн дуудлага XIII зууны үед (ө.х.: «МНТ»-г зохиох үед) Жүрки гэдэг Охин Бархагийн хүүгийн нэртэй ойролцоо дуудлагатай болсон явдал энэ мэт тайлбар хийх үндэс болсон болов уу гэж бид таамаглаж байна. Учир нь нэгд: хэдийгээр «Соркуту» гэдэг үгийг Рашид-ад-Дин (4, I, 2, 87) «биендээ мэнгэтү» гэсэн утгатай гэж тайлбарласан боловч энэ үгийг Лувсанданзан «Журх-а ту жүркэ» (31, I, 19) гэж, эсвэл «Жоригту Йурб(к?)и» (31, I, 86) гэж бичиж энэ үгийг ямагт зориг зүрхтэй холбосон нь учиртай бөгөөд зөв байж болно. Хоёрт Жүрхи болон «Жүркин» гэдэг овгийн үүслийг «МНТ»-д бас тэдгээр хүмүүсийг «уурtан цөстөн» омогтон «жөркимэс» (9, 38 дугаар т.) (139 дүгээр зүйл) тул жүркин гэгдсэн ёс тийм гэж тайлбарлажээ. Энэ «Жүркэмэс» гэсэн үгийг Лувсанданзан «зоргимаг» (31, I 87) гэж, Дамдинсүрэн «чанга зүрхтэй» (7, 93), Дугаржав «жирүхэмэг» (зүрхмэг) (24, 80) гэж, Мансан «жирүкэтэн» (27, 120), Баяр «Жүркимс» (11, II, 450), Иринчин «Жоркимаг» (28, 105) гэх зэргээр сийрүүлсэн буюу орчуулсан байгаа нь ерөнхийдөө цөм зүрх (зориг)-тэй холбож зөв ойлгож ухаарсныг гэрчилжээ. Иймд Жүркин биш «Жирүкэн» гэсэн нэр байсан ч байж магадгүй юм.

141. Мэнггэтү Кийун (хүний хоч, овог) — гэсэн энэ үгийг хятад галиг эхийг дагаж Пеллио, Хэниш, Баяр, Дашцэдэн тэргүүтэн цөм «Мэнггэтү Кийан» гэж уг үгийг сэргээн сийрүүлсэн байв. Гагцхүү Ц. Дамдинсүрэн, Х. Дугаржав нартан «Мэнггитү» гэж арай өөрөөр сийрүүлжээ. Лувсанданзан «Мэнггэтү хий-а» гэсэн нь «кийун» гэсэн овгийг өөрийн үеийн «хиа» гэсэн үгтэй хутгасан бололтой. Бид энэ үгийг Мэнггэтү гэдэг нь уул хүний хоч нэр (мэнгэтэй учир), нөгөө «кийун» гэдэг нь авиа солигдон хожим «чоно» болж улиран хувирсан үгийн маш эртний бичлэг→кийун→чину-а→Чоно гэх зэргээр дуудлагын өөрчлөлт хувьслаа дагаж элдвээр тэмдэглэж ирсэн уг мөн бололтой. Өөрөөр хэлбэл, «Чонос овгийн Мэнгэт (хүн)» гэсэн утгатай гэж ингэж сийрүүлсэн болно.

142. Нэгүн тайжи (хүний хоч нэр ба угсаа) — гэсэн энэ үгийг хятад галигаас голцуу (Пеллио, Баяр, Дашцэдэн, Рахевильз тэргүүтэн) «Нэкүн тайжи» гэж сэргээн сийрүүлж, хүний нэр гэдэг. «Нэкүн» гэдэг уг «МНТ»-ы 200 дугаар зүйлд «Богол нэкүн» гэж гарсны хятад хадмал орчуулгад «гэрийн хүн» «тахар-зарлага» (36, 114) гэж хятад хадмал орчуулгын утгыг Хэниш тайлсан байна. Тайж хүнд ийм утгатай үгээр нэр өгсөн гэхэд эргэлзээтэй. Ийм учраас бид «Нэгүн тайж» гэдэг нь илүү зөв дуудлага болов уу гэж санана. Учир нь энэ үг Чонос овгийн өөр нэг нэр «Нэгүс» гэдэг үгтэй холбоотой байж болно. Тэгвэл Чоно гэдэг үгээр нэр өгсөн байж магадгүй юм. Мөн «МНТ»-ы 188 дугаар зүйлд «Дидик сахал-ун нэкүн (нэгүн?) усун-а» гэсэн газрын нэр гарна. Үүнд Дидик сахлын «нэкүн» (боол зарц) ус гэж баймгүй, харин «нэгүн» (чонон) ус гэж байж болмоор санагдам биз ээ.

143. Бэлгэтэй (хүний онооссон нэр) — энэ хүний нэрийг уг эхийн хятад галиг үсгээс судлагчид цөм «Бэлгүтэй» гэж сэргээн сийрүүлдэг боловч бид үүнийг XIV зууны галиглагчдын дуудлагын гажуудал гэж үзэж

эртний монгол бичгийн уламжлалын үүднээс «Бэлгэтэй» гэж буулгав. Учир нь монголын хуучин бичгийн уламжлалд «Бэлгэ» (бэлгэ тэмдэг) «Билиг» (оюун билиг) «Бэлэг» (бусдад бэлэглэж өгсөн зүйл) гэсэн гурван зүйл бичлэг олон дайралдах бөгөөд хэрэв энэ хүний нэр оюунтай ухаант гэсэн утгатай бол «Билигүтэй» гэж бичмээр. Хэрэв бэлэг сэлт гэсэн утгатай бол «Бэлэгүтэй» гэж бичмээр тул бид үүнийг Бэлгэ (тэмдэг)+тэй (бүхүй) гэсэн бүтэцтэй бөгөөд «Тэмдэг бүхий» гэсэн утгатай нэр гэж үзсэний дээр Нууц товчооны эртний монгол бичгийн эхтэй байсан бололтой гэгддэг Лувсанданзаны эхэд (31, I, 28) «Есүхэй баатрын нөгөө гэргий Сөчгэл эхээс төрсөн «Бэктэр Бэлгэтэй» хоёр бөлгөө гэснийг зөв сэргээлт гэж үзэж ийнхүү «Бэлгэтэй» гэж сэргээн сийрүүлж бичив. Энэ хэсэг «МНТ»-ы хятад галигт байхгүй орхигдсон гэж Пеллиогийн үзсэн энэ хэсэгт энэ үгийг ингэж бичсэн нь Лувсанданзанд байсан эртний монгол бичгийн эхэд ийм бичлэгтэй байсныг давхар баталж байна гэж үзэв.

144. Дархад-ун нойан — гэсэн энэ үгийн бичлэг ба утгын талаар эрдэмтдийн тайлбар саналыг бүрнээ дэмжиж байна. П. Пеллио (9, 128), Хэниш (15, 1948, 7) Поуха (17, 18), Лигети (16, 4) тэргүүтэн цөм уг үгийг орчуулалгүй «дархад-ун» гэж хуулан бичжээ. Дамдинсүрэн, Баяр, Дугаржав, Дашцэдэн цөм л «Дархад-ун ноён» гэж зөв утгаар нь хэвээр нь бичсэн нь ч ойлгомжтой. Энэ үгийн утга ба хэрэглэгдэж ирсэн түүхийг Элдэндэй Ардажав нар (8, 78—80) дэлгэрэнгүй тайлбарлажээ. Бидний бодлоор бол Бадай, Хишилиг мэтийн дархад бол хожмын дархад юм. Харин «МНТ»-ы 120 дугаар зүйлд гарч буй «Дархад-ун Хадаган Далдурхан ах нар дэгү нар табун дархуд» гэж гардаг нь бүр эртний дархад мөн байх. Бидний санавал энэ нь Монголчуудыг Эргүнэ хоноос анх гарахад хадан уулыг хайлуулж тэрэг хөсөгт нь зам нээсэн дархнуудын удмын таван овогийн хүмүүс мөн байх. Дархадын нэр таван овгийн нэрийг тэдний домгийн ёсоор нэрлүүлсний дотор «хар дархад, ухаа дархад, шарнууд, барнууд, (борнууд?), өөлд» (56, 82) гэж тоолжээ. Сүүлчийнхээс бусад нь эртний таван дархдын овгийн нэр мөн байх гэж бодогдоно.

Жувэйнийн «Ертөнцийг дагуулагчийн түүх» (57, I, 20) Монголчуудын чухамхүү төмөр эзэмшиж чадаагүй ядуу буурай байсныг «Тэдний дотроос хамгийн их ноён нь гагцхүү төмөр дөрөөтэй байжээ» гэж тэмдэглэснээс үзвэл төмөр эзэмшээгүй учир бусад харь овгийнхонд ялагдаж Эргүнэ Хонд хоргоджээ. Тэндээс хэдэн зуун жилийн дараа гарахдаа тэд харин хадан уулыг хайлуулж гэтэлж гарсан гэсэн домгоос үзвэл төмөр тунгааж чаддаг болсон бөгөөд төмөр хайлуулж төмөр зэвсэг хийдэг дархан хүмүүс нь монголчуудад ихэд хүндтэй болсон учир бусдаасаа илүү эрхтэй байжээ. Тэгээд ч «Дархан хүн бурхан ухаантай» гэх мэт цэцэн үг гарсан ба Эргүнэ хоноос гарсныхаа ойг тэмдэглэж «Дархны баяр» хийдэг болжээ. Чухам үүний улмаас хожим Чингис хааны амийг аварсан Бадай Хишилиг мэтийг урьдын (Дархнуудын үлгэрээр) тусгайдаа газар нутаг эзэмших өнцгой эрх дарх олгожээ. Иймээс «дархад» гэдэг үг нь «дарха (н)+д» гэж бүтсэн тул ингэж бичих нь зөв. Харин XIV зууны галиглагчид үүнийг «дарх+уд» гэсэн үгээр тэмдэглэсэн нь овгийн нэр бус, олон тоот ажлын нэр болох тул ташаа сэргээлт гэж орхив.

145. Агаригуд буйиругуд татар—гэсэн энэ үгийг бүх судлагчид XIV үеийн галиглагчдын арай ташаа тэмдэглэсэн бололтой хятад эхийг бариманлж «айира'ут буйиругут татар» гэж сэргээн сийрүүлсэн боловч бид үүнийг агариг буюу Шагж авгайн «сархиаг үлэмж (12, 86) газар» болон Буйр нуурын хавиар нутагладаг татаар гэсэн утгатай үг гэж ийнхүү өөрөөр сийрүүлэв. Учир нь энэ бол татаарын овог аймгийн нэр биш юм. Татаарын үндсэн зургаан овог аймгийн нэрийг Рашид-ад-Дин «тутукули, алчи, цагаан күйн, тэрат, баркуй татаар» (4, I, 1, 103) гэж тодорхойлсон байдаг. Агаригуд Буйругуд татаар гэгч иймээс Сэлэнгийн мэркид, Ононы тайчиуд гэсэнтэй адил нутгаар нь ялган заасан үг гэж бодож байна. Дорноговь аймагт хар сархиагтай газрыг хар агариг (аариг) гэж нэрлэж байсан нь одоо авианы талаар сунжирч Хар айраг сум гэж нэрлэх болсон нь үүнийг давхар баталж байна. Айиригуд буйиругуд гэдэг үгийг Элдэндэй Ардажав нарын тайлбарласнаас (8, 85—86) бид арай өөрөөр ингэж ухаарч тайлбарлав.

146. Жү-йин иргэн — гэсэн энэ үгийг хятад галигаас эрдэмтэн судлагчид «Жүйин» гэж сэргээн сийрүүлдэг нь миний бодоход Жү-йин гэсэн харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй нь нийлүүлсэн ташаарал мөн шиг байна. Энэ үгийн чухам утгыг Э. Хэниш (15, 150), Элдэндэй Ардажав нар (8, 86), П. Поуха (58, 65), Мансан (27, 35 дугаар т. I ботийн тайлбар № 24) тус тус зөв зүйтэй тайлбарласнаар хятад хадмалд хэлсний адил аймгийн нэр бус, харин Зөрчидийн Алтан улсын хилийн

харуулын «цагдах цэрэг»-ийн бүлэг иргэд хятан, зөрчид, татаар нарын нутаг дэвсгэрт газар бүхэнд байсан бололтой.

147. Хятадын алтан хаан — энэ үгийн утгыг Хэниш (15, 150, 53 дугаар зүйлийн тайлбар) Элдэндэй Ардажав (8, 87), Дугаржав (24, 13., зүүлт №1), Мансан (27, 35., тайлбар №25) зэрэгт зөв зүйтэй тайлбарласнаар Зөрчидийн (манжийн) Алтан улсыг хэлж байна гэж ойлгох нь зүйтэй. Зөрчидийн Алтан улсыг байгуулагдахын өмнө умард хятад оронд Да Ляо улс буюу монгол угсааны Хятан улс тогтнож байсан тул Хятан гэдэг нэр дээр олон тооны «—д» нөхцөл залгаж «хятад» гэж манжийн улс, түүний газар нутгийг нэрлэх болж улмаар хожим хятан ба манж нарыг ч биш ерөөс Өмнөдийхөн буюу Нангиад гэж нэрлэгдэж байсан жинхэнэ хятад хүмүүсийг болон дундад улсыг «хятад» (хятан нар) гэсэн өөр үгээр ташаа нэрлэх болжээ.

148. Балгачи элчин-ийэр — гэсэн энэ хүний алдарыг буюу эсвэл нэрийг эрдэмтэн судлаач нар бараг төлөв «Балахачи» гэж сэргээн сийрүүлээд олонхи нь жирийн хүний нэр гэж ухаарсан юм. Гэтэл Рашид-ад-Дин энэ элчийн нэрийг «Булагачи» (4, I, 2, 42) гэж, Лувсанданзан «Балгагчи гэгч нэрт элч» (31, I, 21) гэж ташаа сэргээж, Элдэндэй Ардажав нар «Балагачи» гэж сийрүүлж (8, 83), Хэниш (36, 1939, 12) «балагачин» гэсэн үгийн хадмал хятад үсгийг «хотыг захирагч» гэж орчуулжээ. Поуха (58, 88) Балахачи гэдэг элчийн нэрийг монголоор «хотыг захирагч» гэсэн утгатай гэж бас тайлбарласан. Харин Мажар улсын эрдэмтэн Л. Беше (59, 359) түрэг хэлний Бала (хүүхэд) гэсэн үгийн үндсэнд —«хач» гэсэн энхрийлэх утгат дагавар залгаж ерийн нэр үүсгэсэн гэж тайлбарлажээ. Энэ тайлбар XIV зууны галигч нар Балгачи гэхийг «Балахачи» гэж буруу тэмдэглэснээс болж төөрөлдсөн ташаа тайлбар мэт. Иймд энэ үгийг бид Ц. Дамдинсүрэн (7, 33), Дугаржав (24, 13) нарын «Балхачи» гэж балга(с)чи буюу хот эрхлэгч гэсэн утгатай үгэнд ойртуулсан бичлэгийг зөв гэж ийнхүү сийрүүлэв. Жич энд тэмдэглэхэд элчин гэдэг үгийг Элдэндэй Ардажав (8, 89—90) нарын түрэг үгийн утгаар «ноёны цол бололтой» гэснийг алдаатай буруу тайлбар гэж үзээд энэ бол эл (найрсах гэсэн утгатай монгол үгэнд +чин) (гэсэн үйл эрхлэгчийг заах утгатай дагавар) залгаж найрамдуулагч гэсэн утгатай «элчин» гэдэг монгол үг бүтээсэн гэж бодож байна. Учир нь монгол хүн түүхээ ямагт түрэг хэлний үгээр зохиосон гэдэг төдий л үнэмшилтэй биш бөгөөд шинжлэх ухааны үзэл тайлбар хараахан биш биз ээ.

149. Кимул (хумс) — гэсэн энэ үгийн бичигдсэн хэлбэр нь сонирхолтой. Энэ үгийг бүх судлаачид кимусу (хумс) гэсэн үг гэж зөв ойлгосон байдаг. Энэ үгийг Лувсанданзаны «Алтан товчид» «килум» «кимум» гэж хоёр янзаар алдаатай бичсэн байдаг боловч энэ бичлэг нь монгол хэлний авиа сэлгэх жамын үүднээс их сонирхолтой бичлэг мөн юм. Энэ үгийг А. Мостарт авгай хятад хадмалыг «хумс» гэж орчуулаад монгол бичгийн «кимусун» гэдэгтэй адил гэдгийг тэмдэглээд кимул гэдгийн төгсгөлийн Л нь монгол гэдэгт байгаагийн адил эртний монгол хэлний олон тооны нөхцөл байж магадгүй гэсэн юм. (47, [8] эсвэл сэтгүүлд хэвлэгдсэний 292 дугаар т.), Элдэндэй Ардажав нар (8, 89 дүгээр т., тайлбар №15) энэ —Л нь язгуурын эцсийн гийгүүлэгч орхигдсон журмаар орхигдож «кимусу гэмээх нь кимул-ын үүсмэл үг» гэж тайлбарлажээ. Иймд бид энэ үгийг киму (үгийн язгуур) +су (юм гэсэн утгатай үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй монгол үг гэж үзэж сийрүүлэв.

150. тамтал — гэсэн энэ үгийг судлаачид хятад галиг эхийг баримтлан «тамутал-а» гэж сэргээгээд Элдэндэй Ардажав (8, 89—90) нарын тайлбарласан шиг эвдэх элээх гэсэн утгаар ойлгож орчуулдаг билээ. Энэ үгийг бид там («эвдэх» үйлийг өөрөө үйлдэх хэвийн үндэс) +тал-а (үйл үгийн нөхцөл үйлийн үгтах хэлбэр бүтээх нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Тамту гэсэн өөр нэг үндэс энэ үгэнд байдаг нь уул үгийн үйлдэгдэх хэвийн үндэс байж магадгүй. Энэ нь үйл үндэс мөн учраас тамту+г гэж «тамтуг» (тамтаг) гэсэн шинэ үг үүсдэг байна. Бас «тамту» гэдэг нь дайвар үг байж ч болно. Тамту (үгийн I язгуур, дайвар үгийн үйлдэгдэх хэвийн I үндэс) +л (үйл үг бүтээх дагавар) залгаж «тамтулху» гэсэн үйл үг үүсдэг нь «эмт» гэдэг дайвар үгнээс «эмтлэх» гэдэг үйл үг үүсдэгтэй адил юм. «Тамтулху гэдэг нь тамтаг болоход хүргэх» гэсэн утгатай үйл үг болно.

151. абтатал-а (авттал) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс судлаачид их төлөв «hауттала» (Пеллио, Рахевильз, Лигети, Баяр, Дашцэдэн, Мостарт (47, 200 [8] гэж, Баяр (11, I, 79), Иринчин (28, 32) нар «агудтала», Элдэндэй Ардажав нар (8, 89—90) «хагудтала» (хуулагдтал), Лувсанданзан (31, 21) «хадудтала» (хадагдтал?) гэх мэтээр сийрүүлснээс гадна Дамдинсүрэн (7, 33), Мансан (27, 15) нар «барагдтал» Дугаржав нар «дуустал» (24, 13) Козин «алга болтол» (14, 80), Хэ-

ниш «элэгдтэл» (15, 7—8) Пеллио «үрэгдтэл» (9, 128—129) гэх зэргээр ойлгож орчуулсан байна. Бид энэ үгийг XIV зууны галиглагчдын тэр цагийн аман аялга дуудлагын нөлөөгөөр эхэнд нь h авиа нэмэгдэж үгийн дунд орсон б үсэг нь суларсан в буюу «у» үсгээр тэмдэглэгдэх зэргээр гуйвуулагдан ташаа галиглагдсан гэж үзэж «абттал-а» гэж худам монгол бичгийн эхэд бичээстэй байсан гэж бодож ийнхүү сийрүүлэв. Иймд энэ нь бидний бодлоор бол аб— (үгийн идэвхтэй язгуур «авах» гэсэн үйл үгийн I үндэс)+т (үйл үгийн үйлдэгдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +тал (**нөхцөл үйл** үгийн үгтах хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд арван хуруундаа «автталь» гэсэн утгатай үг гэж бодож байна.

хотан» гэж сэргээн бичдэг бөгөөд энэ үгийн утгыг Рашид-ад-Дин «том

152. Хачи (хач—өшөө) гэсэн энэ үгийг хятад галиг эхээс Пеллио, Рахевильз, Баяр, Лигети, Дашцэдэн тэргүүтэн олон судлаачид «hачи» гэж, бас Баяр, Иринчин, Элдэндэй, Ардажав Лувсанданзан тэргүүтэн зарим нь «ачи» гэж, Дамдинсүрэн, Мансан, Элдэндэй Ардажав (8, 90) Пеллио, Хэниш, Рахевильз тэргүүтэн цөм **«өшөө»** гэсэн үгээр зөв орчуулсан юм. Харин энэ «өшөө хонзон» гэсэн утгатай «ачи» гэдэг үг бас «ач» хариулах гэсэн өөр үгтэй ижилээр «МНТ»-д яагаад бичигдсэн бэ? Бидний санахад энэ үгийн эхний Х гийгүүлэгч XIV зууны галиглагчдын хэл аялгуунд h болж сонстож улмаар алга болох хандлагатай тэмдэглэгдсэн учир «хачи» (өшөө), ачи (хариулах ёстой тус) гэсэн хоёр шал өөр үг ижил бичлэгтэй болсон бололтой. Иймд энэ «өшөө» гэсэн утгатай энэ «hачи» гэсэн үг «МНТ»-ы худам монгол эхэд «хачи» гэж бичигдсэн байснаар төсөөлөн бодож, бид «хачи» гэж сэргээн сийрүүлснээ зөв гэж бодно. Учир нь өшил өшин, кисал хисах гэдэг үг монгол хэл, нууц товчооны хэлэнд байхын дээр «хачиху» гэсэн үйл үгийг Шагж (12, 324б) хихаху (хяхах) гэсэн үгээр тайлбарлажээ. Хясал хясах хачи авах, өшөө авах, хариу авах гэсэн ойролцоо утгатай хэллэг цөм «авах» гэсэн үгтэй холбогддог байхад ач ачлах, ач хариулах, ач санах гэх мэтээр ач гэдэг үг ямагт өөр үгтэй нийлж чадах нийлэмжтэй байгаа нь хачи ба ачи гэсэн үгс хоёр өөр утгатай хоёр үг байсныг гэрчилнэ.

153. Олхунугуд (овгийн нэр) — энэ үгийг утгыг Элдэндэй Ардажав нар (8 91) эртний Нэгүс, Кийун хосоос гаралтай гэх буюу Хабул голд цутгах Олхуну голын нэртэй холбож тайлбарлажээ. Бид энэ аймгийн нэр Олхун буюу толгод гэсэн үгнээс гарсан байж магадгүй гэсэн тааглал дэвшүүлэхдээ энэ үгийг **«Чингис хааны цадиг»** (5, 43)-т «Тэмүр **олху»** гэх мэтээр бичсэн нь урьд Олху+ну+гуд гэж олон тооны нөхцөл **залгаж** дов толгодынхон гэсэн овгийн нэр үүсгэсэн байж болох мэт **сэтгэгдэнэм.**

154. Эгүсгэжү (үүсгэж) — гэсэн энэ үгийн утгыг мөн Элдэндэй Ардажав нар (8, 92)-ын тайлбарласнаар үнэхээр «мордуулж иржээ» гэсэн тайлбар үндэстэй байх. Бид «эгүсгэкү» гэсэн энэ үг өөрөө монголчуудын гэрлэх маш эрт цагийн заншлаас буюу гэрлэгсдэд шинэ үүд нээж (өөрөөр хэлбэл, өрх гэр тусгаарлан) өгдөг заншлаас үүссэн болов уу гэж таамагланам. Учир нь «эгүсгэл» гэдэг үгийг хуучин монгол бичигт заримдаа «эгүтгэл» гэж бичдгээс үзвэл Эгүд [э] гэ (үүдтэй болго) гэсэн эртний үгнээс **«эгүсгэ»** гэсэн үг хожим д∼т∼с болон хувисах журмаар үүссэн байж болох юм. Н. Поппе «Эртний монголчуудын нэн эрт дээр цагийн нэг заншил» (60, 159—164) өгүүлэлдээ Нууц товчооны 64 дүгээр зүйлд Дай цэцний охиноо Есүхэй баатрын хүү Тэмүжинд өгөх талаар хэлсэн үгийг хожим (1880 онд) Позднеевийн нийтлүүлсэн «Буртагтайн өндөр даваанд» гэдэг бэрийн гунигт дуутай харьцуулан энд монголын маш эртний гэрлэх ёс заншил тусгагдсаныг тэмдэглэжээ.

Дэй цэцний үгнээс «е'үсгэжү отчу» (үүсгэж одож) гэсэн үгийг Поппе «Гэрлэх аянд үдэж мордуулах» (60, 161) гэж орчуулсан нь сонирхолтой. Цэрэг үүсгэх гэдэг нь үүд нээх (эхлэх) буюу цэрэг эмхлэн үүсгэж мордуулах гэсэн шилжсэн утгатай байж магадгүй.

155. Бишитэй (гайхалтай) — гэсэн энэ үгийг хятад галигаас Лувсанданзан, Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн, Баяр, Иринчин тэргүүтэн цөм «буситай» гэж сийрүүлээд утгыг гагц Баяр авгай хуучин монгол бичгээр «бишитэй» (11, 80) гэж сэргээсэн нь бидний бодоход хамгийн зөв сэргээлт юм. Үүний утгыг Хэниш, Пеллио, Поуха, Рахевильз, Элдэндэй Ардажав нар, Мансан тэргүүтэн цөм «онцгой» гэж ерөнхийдөө зөв тааж орчуулсан байна. Гэвч бид энэ үгийг XIV зууны үеийн галиглагч нарын аман аялгуу дуудлагын нөлөөгөөр «буситай» гэж эндүү ташаа тэмдэглэгдсэн гэж үзэж эртний монгол бичгийн эхэд лав **«бишитэй»** гэж Баяр авгайн хуучин бичгээр сэргээсэнтэй адилаар бичигдсэн **байсан байх гэж төсөөлөн бодож** сэргээв. Учир нь энэ үг бидний бодлоор бишрэх (нүдээр үзэж үнэмших, гайхах бахдах гэсэн

утгатай) гэдэг үгтэй язгуур гарал нэгтэй үг мөн. Одоогийн монгол үг ярианд олон дайралдаж болох ерийн юмыг «бишгүй» байна гэж хэлдэг. Энэ «бишгүй» гэдэг нь энэхүү «бишитэй» гэдэг үгийн эсрэг утгатай харьцангуй нэр мөн. Биши гэсэн үндэс дээр —р залгавал «бишир» гэсэн үйл үг бүтнэ. Иймд энэ үгийг бид Биши (гайхан бишрэм онцгой гойд гэсэн утгатай үгийн язгуур, I нэр үндэс) +та (тийм зүйл бүхий гэсэн утгатай эм хүйст үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй монгол үг мөн гэж үзэв. Бодичарьяавадарагийн орчуулгад «Маш бишихуяа сэтгэлээ сахигдахуй» (40, 37) гэсэн нь «сайнаар» гэсэн утгатай бололтой.

156. Ама алус (ам алс) — гэсэн энэ үгийг XIV зууны галиглагч хүмүүс уг үгийн бичлэгийг тэр үеийнхээ аман аялгаас эндүү сонсч ташаа тэмдэглэсэн шиг санагдах бөгөөд олон судлаачид хятад галиг үсгийг мөрдөж «Намбалис» (Пеллио, Хэниш, Рахевильз, Лигети, Дашцэдэн зэрэг) гэж сэргээж сийрүүлж Хэниш (36, 113) «цаад тал уруу давж» гэж тайлсан тул энэ үгийн утгыг Дамдинсүрэн «уулын бэлээр» (7, 33), Дугаржав «уул давж» (24, 14) Элдэндэй Ардажав нар «Хөх нуурын монголчуудын аялгуунд «харайн гарах, нүх буюу гуу сувгийг үсрэн гарахыг заав» (8, 94) гэж, Мансан «чанадхи гу (р?) вийг даван» (27, 13) гэж, Пеллио, Рахевильз тэргүүтэн «толгод давж» гэж, Хэниш «толгойн тойруугаар» (15, 8) гэж тус тус орчуулсан нь ерөнхийдөө зөв байна. Гэвч бид «гувури ам алус» (толгойн сугаар хол давж) гэсэн үг гэж бодно. Учир нь Лувсанданзаны эхэд (31, I, 22) «Губури (гурав [и?] н) алун бургутулуг-а» гэж бичсэний «Алун» гэдгийн эцсийн «н» нь «хуучин монгол бичигт «с» авиаг тэмдэглэх тохиолдол олон тул «алус» гэж унших учиртай. Бас энэ үгийг Иринчин «амбалис» (28, 33) гэж тэмдэглэснээс үзвэл «намбалис» бус харин «ам [а] алус» гэсэн бичлэг байсан нь ил. Иймд эцсийн а эгшиг балархайшиж м+а нь «ба» болж ташаа сонсогдсон бололтой.

157. Хучилис (тойрч) — гэсэн энэ үгийг галиглах талаар зөрөлдөөнгүй. Цөм «хучилис» гэж сэргээн бас цөм уулын хошууг тойрч эргэж ирсэн гэж зөв ухаарч сэргээн босгосон буюу орчуулсан байдаг. Гагцхүү Лувсанданзан түүхч «хучилис» гэсэн үгийг хошугу «хучижу» гэсэн үгээр сольсон байв. Үүнээс бид «хучих» гэдэг үгэнд юмыг «бүрхэх бүтээх» гэдгээс гадна тойрох гэсэн утга байдгийг олж мэдэв. Энэ үгэнд ийм утга байдаг нь орчин цагийн халхын хуучцуулын үг ярианд аливаа юмыг гамнаж хэмнэж аргацаан хүргэв гэсэн утгатай

Хуруу
Хучиж
Эрхий

Эмжиж арай чарай хүргэв гэдэг үг байдгаас мэдэж болно. Иймд бид энэ үгийг хучи — (үгийн идэвхтэй язгуур, «бүрх, ороо» гэсэн утгатай үйл үгийн I үндэс) +л (уг үгийн олон дахих байдлын нөхцөл) +с (үйл үгийн үндэснээс дайвар үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг бөгөөд энд энэ үг «харьж» гэдэг үйл үгийн байдал дүрийн байцийн үүрэгтэй хэрэглэгдсэн байна гэж санаж байна.

158. Өгэлүн үжин — гэсэн энэ үгийн утгыг Рашид-ад-Дин (4, I, 2, 57) хятад хэлээр «гэргий» гэсэн үг гэсэн боловч энэ үжин гэдэг үгийг бид хятад фу-жень гэдэг үгийн ормол гэж үзэхгүй, харин монгол манжийн маш эртний балар цагийн овгийн толгойлогч том бичет баатарлаг толгойлогч анчин бүсгүйн «Пүдин» «бодан» гэх мэт нэрийг хятадын энэ үгээр бичигт тэмдэглэсэн зүйл байж магадгүй гэж бодож байгаа бөгөөд манж, монгол хэлтний (монголын бодан→бодун→будан→бүдүн. манж хэлний «Пүдин» гэх мэт үгний дотроос (пүдин гэдэг хэлбэр нь пүдин→фүдин→фуджин→үжин гэх зэргээр хувирч утгаараа фү-жень гэсэн хятад үгтэй дүйсэн байж магадгүй гэж бодно. (10, 106—107)

159. Өки хату — гэсэн энэ үг «өкин», «хатун» гэсэн үгийн уг идэвхгүй язгуур мөн бөгөөд одоо бидний үед идэвхгүй буюу утга хадгалж байгаа нь мэдэгдэхээ больсон иймэрхүү үгийн олон идэвхгүй язгуур дээр үедээ утга хадгалсан идэвхтэй язгуур, үгийн I үндэс мөн байсныг энэ хоёр үгийн баримт харуулж байгааг тэмдэглэе.

160. Өгэлүн дахи (Өэлүн дахи) — гэсэн энэ үгийг хятад хадмал орчуулгад нь «Бас, мөн, түүнчлэн» (36, 147) гэж тайлсан юм. Энэ учраас Пеллио, Хэниш, Рахевильз, Поуха цөм «бас, түүнчлэн» гэж орчуулж Дамдинсүрэн, Мансан, Элдэндэй Ардажав нар цөм «дахин» гэж ухаарч орчуулж тайлбарласан нь үндсэндээ илүү зөв юм. Иймд бид хятад галигт «тэки» гэж тэмдэглэснийг XIV зууны галиглагч нарын дуудлага ба сонсголын алдаа гэж үзэж «дахи» гэж сийрүүлэн энэ бол дахи гэдэг дахих гэсэн үйл үндэс үүсгэх дайвар үг тул «дахин» гэсэн нөхцөл

үйлийн хам төлөвийн нөхцөлтэй үйл үгийн адил утгатай үг гэж тайлбарлав.

161. Наруйитчу (налаж) — гэсэн энэ үгийг хятад галигаас Пеллио, Баяр, Дашцэдэн тэргүүтэн судлагчид их төлөв «наруйитчу» эсвэл «наруйидчу» гэж галигласан бөгөөд хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «гар сунгаж» (36, 114) гэж тайлжээ. Пеллио «мориныхоо өндөрт тохируулан шүүрч аваад» (9, 129) гэж, Хэниш «гар сунгаж» (15, 8), Дамдинсүрэн (7, 34), Дугаржав (24, 14) нар «тонгойж» гэж, Мансан (27, 16) «бие бөхийж» гэх зэргээр цөм утгыг дөхүүлж орчуулсан ажээ. Бид энэ үгийг «налаху» гэдэг үйл үгийн эс тусах хэлбэр буюу налуутжу (хажуу тийшээ бөхийж) гэсэн утгатай үг гэж бодох боловч одоо цагийн монгол хэлэнд энэ үйл үгийн эс тусах хэлбэр нь хэрэглэгдэхгүй болсон гэж таамаглав.

162. Чихус (чухас) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийг мөрдөж Пеллио, Баяр, Дашцэдэн, Элдэндэй Ардажав тэргүүтэн олон судлагч «Жухус» гэж сэргээж иржээ. Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгад «машид яаруу» (36, 94) гэж Хэниш авгай тайлсан болоолтой тул Элдэндэй Ардажав (8, 98) «түргэн давхин» гэж, Дамдинсүрэн (7, 34) Пеллио (9, 129) Кливз (42, 12) нар «яаран» гэж, Рахевильз «түргэн давхиж» (49, 128) гэх зэргээр тус тус орчуулжээ. Бид монгол бичгийн уламжлалт бичгийн үүднээс «чихус» гэж сэргээн сийрүүлэв. Монгол бичгийн хэлэнд «чихул» (давч), «чихулдаху» (давчдах) гэсэн үгс байгаа нь Шагж гуайн толь бичигт (12, 763) байх тул эдгээр үгийн «чиху—» гэсэн язгуураас «чиху+с» (чухус) гэсэн «дайвар» үг үүссэн байна гэж үзэж байна.

163. Дэргэчэжү (зэрэгцэж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс сэргээн сийрүүлэх ба түүний утгыг тайлах талаар судлаачдын саналаас зөрөөтэй зүйл үгүй юм. Харин сонирхолтой нь орчин цагийн монгол хэлний «зэрэгцэх» гэсэн үг энэ «дэргэцэх» гэсэн үгнээс авианы сэлгэлтийн үр дүнд үүсч гарсныг харуулж байгаад оршино. Бас үүний зэрэгцээгээр Нууц товчооны өөр (жишээлбэл, 108 дугаар) зүйлд: «Жэ-д-эчэ хожигдагсан-и Жэргэ-д-эчэ гаргай-а кэмэлдэлүгэ» гэх мэтээр дэргэ гэдэг үгнээс сүүлд үүссэн «Жэргэ» гэдэг үг нь өөр утгатай болсон баримт ч байна.

164. Хэйисүгсэгэр, өлүсүгсэгэр (хийсэмсэр, өлсөмсөр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс «кэйисүмсэр, өлүсүмсэр» гэж Пеллио (9, 12), Баяр (11, 86), Дашцэдэн (26, 22), Лигети (33, 28) тэргүүтэн олон судлагч буулгаад бас хятад хадмал орчуулгыг баримталж Пеллио, Хэниш, Баяр, Мансан, Элдэндэй, Ардажав, тэргүүтэн цөм «хийсгэж байгаагүй, өлсөж байгаагүй» гэсэн үг гэж ойлгож орчуулсан байдаг билээ. Японы эрдэмтэн М. Хашимото үгүйсгэх—сар, —сэр дагаварыг дундад үеийн монгол хэлэнд ховор тохиолдох бөгөөд тэр хэлбэр аажмаар ховордоход хожим «гүй» гэдэг нэрийн үгүйсгэх хэлбэр дэлгэрсэн байна гэдэг дүгнэлт хийжээ. (Олон улсын монголч эрдэмтний IV их хуралд түүний тавьсан илтгэл)

Бидний бодоход энэ үгийг XIV-ийн үеийн галигч нар үг үгийг буруу дуудаж, ташаа дуулаад «хэйисүмсэр, өлүсүмсэр» гэж тэмдэглэсэн байх. Ингэж бодох үндэс нь нэгд, энэ үгийг Лувсанданзан «кэйисүгсэгэр, өлүсүгсэгэр» (36, I, 23) гэж тэмдэглэсэн явдал болно. Хоёрт, эдгээртэй адил бүтэцтэй «үдэ жилда ухамсар бэркэ ой-дур» (§ 240) гэсэн үг хэллэгт байгаа ухамсар гэдэг үг үгүйсгэх утгагүй учраас «үд ба үдшийг ялгаж ухамсарлахад бэрх» гэсэн утгаар хэрэглэгдсэн явдал болно.

Иймд бид энэ үгийг «хэй (үгийн язгуур, нэр үгийн I үндэс) +с (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +гсэгэр (одоогийн нөхцөл үйлийн үргэлжлэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж ойлгож Лувсанданзаны сийрүүлснийг зөв гэж баримтлан сийрүүлэв. Жич —гсэ [н]+[ий] эр гэсэн үйлт нэрийн өнгөрсөн цагийн нөхцөл ба үйлдэхийн тийн ялгалын «ийэр» нөхцөл хоёр хураагдан нийлж үйл үгийн энэ төлөвийн хэл зүйн айг үүсгэсэн болов уу.

165. болба [й]у? (болов у?) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийг мөрдөж Пеллио тэргүүтэн судлаачид **«бөлийн»**, Баяр тэргүүтэн зарим нь **«бөлиги** (болай)» гэж сэргээн сийрүүлэн бичдэг боловч бид энэ үгийг XIV зууны үеийн галигч нарын аман аялга дуудлагаар эр эгшгийг эм эгшгээр дуудах хандлага их байдгийн дээр үгийн дунд б авиа суларч у, ү, и зэрэг эгшиг авиа шиг сонстох болсон шалтгаанаар бүрүү тэмдэглэгдсэн «болба [й]у» гэсэн үг байжээ гэж таамаглан ингэж бичив.

166. Сибэргэл «гээгэг үс) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаар нь Хэниш «шибилгэр (=шибүлгэр)» гэж сэргээн сийрүүлээд «хажуугийн тав үс» (36, 139) гэж хятад хадмал орчуулгын утгыг тайлжээ. Бусад нь (Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Иринчин тэргүүтэн) цөм «шибүргэл» гэж сэргээсэн юм. Үүний утгыг Дамдинсүрэн (7, 34)

Дугаржав (24, 15) «сэвэлгэ үсү-бэн» гэж, Хэниш (15, 8) Калужинский (61, 40), Рахевильз (49, 128), Мостарт (62, 151—156) Элдэндэй Ардажав (8, 102) цөм «хоёр (салаа) гэзэг» гэж орчуулсан байна. Харин Пеллио (9, 129) «уяа боолт» гэж ухаарчээ.

Энэ үгийг Мостарт гуай дээр дурдсан «Монголын эзэнт улсын эзэн хаадын хэдэн хөргийн тухай» гэсэн өгүүлэлдээ гөхөл ба шибэргэл гэсэн хоёр үгийн утгыг зааглан тайлбарлахын хамт ширбэгэл гэдгийн хоёр хувилбар «шилбигэр» (шибилгэр) үүнээс үүссэн гэж тайлбарлаад Ширбэгэл гэдэг нь Ордос авгай нар эрд очихдоо үсээ хийж энгэрийнхээ хоёр талаар унжуулж чимдэг дугтуй (гэр) буюу шивэг гэдгийн нэр юм. Шибэгтэй холбож «шивэгчин» гэсэн үгийг зүүлтэд иш татжээ. Энэ үгийг Баяр «сэбэлгэр» (11, 87), гэж бичсэн нь сэв (үс самсны сугарсан үсийг хэлнэ) гэсэн үгтэй холбох гэсэн санаа болов уу. Бидний бодоход энэ үг анх шилбигэр—шибилгэр—шибэлгэр—ширбэгэл—шибэргил—шибэргэл гэх зэргээр авиа сэлгэлтийн жамаар хувирч үүссэн бөгөөд шил+бэр+гэ+л гэсэн бүтэцтэй монгол үг гэж бодно. Энэ үгнээс бас шибэ [р] г+чин буюу хатадын шибэргэлийг нь самнаж богтог малгайд нь хийж өгдөг зарц бүсгүйн нэр ч үүссэн нь үнэн биз. Гэжигэ гэдэг үг хүний толгойн арын гэд [и] гэ—буюу гэдгэр хэсгийн нэрийн д нь ж авиатай сэлгэж, мөнхүү гэдгэрээс ургуулсан үсний нэр болсны нэг адил ургуулж шил уруугаа унжуулдаг үсний нэр мөн «шили» гэсэн үгнээс үүссэн бололтойг Мостарт гуайн олсон «шилбүгэр» гэсэн жишээ гэрчилж байна. Харин одоогийн баруун Монголын «боодогтой сэвгэр» гэх мэт үг охид хүүхний энэ үсний нэрээс үүссэн байж магадгүй. Бас үсний сэв (самнахад үгтээгдсэн үс), хүүхдийн сэвэлгэ (сэвлэг) үс, цагаан төмс шар төмсний сэвэлгэнэ зэрэг үүнтэй холбогдолтой болов уу гэх бодол толь бичгээс (12, 517) төрөгдөнө.

167. Огурчу (оорч орхих) — гэсэн үгийг галиглах утгыг ойлгох талаар судлаачид зөрөөгүй. Харин «Эдүгэ хэр элэ хойар шибэлгэр-йэн нэгэнтэ ару дэгэр-э-бэн огорчу нигэнтэ эбүр (эн) дэгэр-э огорчу» гэсэн энэ хэллэгийг Пеллио, Рахевильз тэргүүтэн зарим судлаач «Эдүгээ чи минь хоёр шибүлгэрээ нэгэнтээ ар дээрээ оорч нэгэнтээ өвөр дээрээ оорч» гэх зэргээр авааль эрийнхээ үс гэзэгний тухай Өгэлүн үжин Чилэдүд хандаж хэлсэн үг гэж бидний санахад буруу ойлгосон байдаг Чухамдаа энэ үгийг Өгэлүн үжин өөрийнхөө гэзэг үсэнд холбогдуулан хэлсэн үг юм. Тэр нь эр нөхрөөсөө хагацан аргагүйн эрхээр (хүчинд автан) явж байгаагаа эрд гарсны бэлэгдэл болгож хоёр салаа сүлжсэн хоёр шивэлгэрээрээ зүйрлэж дохиолон хэлсэн үг бололтой. Учир нь тэр үеийн Монголын охид үсээ Элдэндэй Ардажав нарын тайлбарласан шиг «...арваад нарийн гэзэг гөрж, ар өвөр тийш хоёр мөр уруугаа тавиад явдаг» (8, 102) байсангүй. Харин тэд үсээ ганц бүдүүн гэзэг болгон сүлжиж нуруу уруугаа унжуулж явдаг байжээ. Тэгээд эрд очиход нь охидын бүдүүн гэзгийг хагалж самнан хоёр салаа шибэлгэр болгон сүлждэг ёстой байжээ. Энэ нь үс гэзгэний нэг нь өөрт нь, нөгөө нь эрд нь хамаатай болсныг буюу эрд очсоны тэмдэг болгодог заншил байсны гэрч мөн гэж болно. Иймд Өгэлүн үжин өөрийн нэг шибэлгэрээ ардаа (ө. х. зүгтаж одсон эр Чилэдүд зориулж) нөгөөг (өөртөө зориулж) өвөр дээрээ оорч (орхин) унжуулж яаж явах билээ? гэж авааль эрээсээ хүчээр хагацуулагдаж байгаадаа энэлэн шаналан уйлсан бололтой юм.

168. ой жубур (ой жувар) — гэсэн энэ үгийг судлаачид хятад галигаас бултаар «ой жубур» гэж сэргээн сийрүүлдэг боловч харин утгыг нь Хэниш «Эргийн ой» (15, 8) гэж, Пеллио «голын дагуу» (9, 129), Рахевильз (49, 28), Мансан (27, 16) нар «ойт буюу ой хөндий» гэж, Лувсанданзан «ой [—жу] бури» (31, I, 23). Дамдинсүрэн (7, 34), Дугаржав (24, 15) нар «ой шугуй» гэж, Элдэндэй Ардажав нар «түрэг хэлэнд чубур ~ чупур гэмээх нь хонин ноос, нягт шигүү ой» (8, 103) гэж тус тус ойлгож орчуулсан буюу тайлбарлажээ.

Бидний санавал «жубур» гэдэг үг энд өндөр уулын үерийн (уруйн) усаар ухагдаж үүссэн гүн гуу жалга, хавчлын нэрийг тэмдэглэсэн үг бололтой. Учир нь эндүүрээгүй бол Монголын алдарт Лувсан хуурч улаан армид бичсэн захидлын шүлэгтээ улаан цэрэг фашистын цэргийг «Алтайн жувур шиг дайрч» устгана гэж бичсэн юм. Иймд энэ үг ойба уулнаас буудаг үерийн (буюу уруйн) усанд эвдэрч үүссэн гуу жалга, халил хавчлыг заах утгатай монгол үг мөн шиг байна. Юу гэвэл монгол бичгийн үгэнд «Жуба зам—хажуу газрын бэрх зам» «жубаг—ус урасгах нүх» «жубуху—өвсөн доогуур шургалан буруулах» гэх мэт энэ «жубуг» гэдэгтэй төрөл ойролцоо утгатай үгс Шагжийн толь бичигт бүртгэгдсэн (12, 522) байна.

169. Халайижу (халиаж) — энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио (9, 12), Рахевильз (25, 23), Лигети (33, 28) нар «хараужу» гэж, Дашцэдэн «харйижу» (26, 22) гэж Хэниш (36, 57), Баяр (11, I, 88), Иринчин

(28, 35) нар «халайижу» гэж тус тус галигласны дотроос сүүлчийнх нь зөв гэж баримтлан сэргээв. Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаас нь «эргүүлж тойруулж харах» гэж Хэниш герман хэлэнд тайлсан учир судлаачид Пеллио (9, 130), Рахевильз (49, № 4, 1971, 128) «эргэж харавч чамайг үзэхийг хүсэхгүй» гэж, Кливз (42, 13), Хэниш «эргэж чамайг үзэхгүй» (15, 9), Лувсанданзан «үл үжэгдэм» (31, 23), Дамдинсүрэн (7, 34), Дугаржав (24, 16) Мансан (27, 17) нар «харж чамайг үзэхгүй» гэж, Элдэндэй Ардажав (8, 99, 103), Иринчин (38, 35) «халайж (эргэж харж) үзэхгүй» гэж, Баяр «хялайж» гэж тус тус ойлгож сэргээсэн буюу орчуулж тайлбарласан байна.

Гэвч энэ үгийг баруун монголын нутгийн аялгуунд одоо ч хүртэл хэрэглэгдсээр байгаа «халиаж» гэсэн үгийн эртний бичлэгийн хэлбэр нь гэж үзэж байгаа бөгөөд Баяр гуайн ойлгосон шиг «хялайж» (өрөөсөн нүдээрээ ч харж) үзэхгүй гэсэн утгатай үг болов уу гэж бодож байна. Эртний монгол бичгийн хэлэнд «марайажу» гэж байсан нь халхын аялгуунд «мярааж» болсоны адил «халайижу» байсан «халиаж», «хялайж» болж үе тонгорох журмаар хувирсан гэж төсөөлж байна.

170. хагулга (хуулга—зам) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид Пеллио (9, 12), Рахевильз (25, 23), Хэниш (36, 64), Баяр (11, I, 88), тэргүүтэн цөм «ха'улуга ха'ул[у]га» гэж, Лигети «ха'улга» (33, 28) гэж, Дашцэдэн «хаулга» (26, 22) гэж, Иринчин «хагулга» (28, 35) гэж, Дамдинсүрэн (7, 34) «хагалга жам», Баяр «хагалга» гэж тус тус буулгасан. Эдгээрээс Иринчиний «хагулга» гэснийг хамгийн оновчтойд үзэж бид мөн ингэж сэргээн сийрүүлэв. Энэ үгийг Лувсанданзан (31, 23) «үл үзэгдэм» гэж үл ойлгогдох үгийг орхиж, Мансан утгачлан «зам мөр» гэж, Дамдинсүрэн «хаалга (одоогийн хальмагт замыг хэлдэг дуудлагаар нь) зам гэж, Баяр «хаалга (үүд)» гэсэн утгаар тус тус ухаарсан шиг бодогдоно. «Хагулга» гэдэг үгийг бид довтолж одсон морины туурайн газрын хөрсийг хуулж халцалсан зам гэсэн утгатай үг гэж бодож байна. Халхын аялгуунд энэ хагулга гэсэн үгийн г гийгүүлэгч сугарч эхний а нь II үеийн у эгшигтээ ижилсэн «хуулга» (жишээлбэл дээлийн «хуулга» гэдэг үг үүсгэсэн, халимагт энэ үгийн г нь сугарч II үеийн у нь эхний үеийн а эгшигтэй ижилсэн «хаалга» гэсэн үг болж «зам» гэсэн утгаа хадгалан үлдсэн гэж төсөөлөн бодож тайлбарлав.

171. Эбдүк-т-э элүхэг (өвдөг газар)-т үлхэг (элэгдэж ухагдсан хонхор) —гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс судлаачид Пеллио (9, 12), Хэниш (36, 40, 123), Лигети (33, 28), Рахевильз (25, 24), Баяр (11, I, 91), Элдэндэй Ардажав нар (8, 104), Иринчин (28, 36) тэргүүтэн цөм (эбүдүктэ өлкэк» гэж сэргээн сийрүүлж, утгыг нь хятад хадмал орчуулгад «үнэс, тоос» гэж байгаагаар Хэниш (36, 123) тайлжээ. Энэ үчраас Хэниш (15, 9), Пеллио (9, 130), Рахевильз (49, 129), Кливз (42, 14), Поуха (17. 21) «өвдөгцөө тоос чандар» гэж, Калужинский (61, 40) Лувсанданзан (31, I, 24) «эбүдүк-эчэ үлэкү болтала» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 106) өвдөгцөө (өвдөг тулам) «үнэс тоос», «хог тоос» гэж, Мансан «өвдөг дүүрэн тоос болтол» (24, 16) гэж, Дамдинсүрэн «Өвдөг газрыг үлтэртэл» гэж тус тус орчуулснаас сүүлчийнхийг хамгийн зөв орчуулга болсон гэж үзнэ

Үчир нь бид энэ үгийг «Эбүдүк-т-э элүхэг» болтол гэсэн үг гэж сэргээн сийрүүлэх нь зөв гэж бодсон юм. Үчир нь нэгд, энэ хэсгийг

Хабирга-д-а
Хагулга
Эбүдүк-т-э

Элүхэг гэсэн шүлэг байх тул өлкэк гэдэг нь XIV зууны галиглагч нарын аялгууны буруу дуудлага гэж үзсэн юм. **Хоёрт,** хуучин монгол бичгийн үгэнд «элү»—ухагдсан газар «тарбага мэтийн томхон амьтны нүх» (12, 85) гэсэн үг бүртгэгдсэн байна. Орчин цагийн монгол хэлэнд «үлий» (53, 620) гэдэг үг байгааг «үлий» гэж хуучин бичгээр бичсэн нь ташаа зүйл бөгөөд сүүлийн үеийн бичлэг юм. Чухам зөв нь «элү» гэж бичих ёстой байв.

Иймд бид энэ үгийг элү (элж ухагдсан газар гэсэн утгатай үгийн язгуур, үйл үгийн үндэс) +гэ (үйл үгийн үйлдүүлэх хэвийн дагавар) +г (үйл үгээс нэр үг үүсгэх дагавар) гэсэн бүтэцтэй гэж сэр—сэргэ—сэргэг гэдэг үг бүтдэгтэй ижил загвараар бүтсэн үг мөн бололтой.

172. Дэлигүн болдаг-а (Дэлүүн болдогт) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс «Дэлигүн болдог-а» гэж сэргээн сийрүүлдэг бөгөөд энд тэмдэглэвэл зохих нь үгийн агшлага «г»-гийн дараа өгөх оршихын тийн ялгалын —а, э нөхцөл тусгай бичигдэж дуудлага нь салангид байсан явдал болно. Өөрөөр хэлбэл агшлага г нь нөхцөл а-тай нийлж хөөмийн шүргэх «г» авиа бололгүй «болдокъа» гэсэн дуудлагатай байжээ.

173. нөдин (нөж) — гэсэн үгийг хятад галиг үсгээс Пеллио (9, 12) Хэниш (36, 118), Баяр (11, I, 94), Рахевильз (25, 24), Лигети (33, 29) Дашцэдэн (26, 23) тэргүүтэн судлагч авгай нар цөмөөр «нөдүн» гэж сэр-

гээн босгож сийрүүлдэг боловч бид үүнийг XIV зууны галигч нарын ташаа дуудлага ба сонсголын гажуудал гэж үзэж «нөдин» гэж сэргээн сийрүүлэв. Учир нь хуучин монгол бичигт энэ үгийг Баяр авгайн (11, 94), Лувсанданзан (31, 26), Дамдинсүрэн (7, 35), Дугаржав (24, 17), Мансан (27,18) нарын тэмдэглэсэн шиг «нөжин» буюу «нөжи» гэж бичдэг уламжлалтай нь д гийгүүлэгчийн дараа ү биш, и байсныг харуулж байна. Хэрэв эртний худам монгол бичигт д авианы дараа и биш ү авиа байсан бол д авиа нь ж авиа болж хувирахгүй байжээ. Хожим үеийн монгол бичигт энэ үгийг нөжин ~нөжи гэж бичигддэг нь баримттай тул бид ийнхүү уг эхэд «нөдин» гэж бичээстэй байсан гэж төсөөлөн ингэж сийрүүлсэнээ зөвд бодном.

174. Тэмүжин (хүний нэр) — энэ үгийг хятад галиг үсгээс «Тэмүжин» гэж сэргээн сийрүүлдэг бөгөөд татаарын Тэмүжин Үкэ гэдэг хүнийг олзлон авчирах үед тохиолдож төрсөн гэж «Тэмүжин» гэдэг нэр өгсөн гэж энд дурдсанаас үзвэл, **нэгд**, Татаар, Боржигид хоёр нэг ижил монгол хэлээр хэлэлцэж байсныг гэрчилнэ. **Хоёрт**, Тэмүжин гэдэг нэрийг «—жин» гэсэн эм хүйсийн дагавартай «Төмөр» гэдэг монгол үг» (58, 86—87) гэж Поуха тайлбарлав. Д'Оссон түүхч энэ үгийг «Тэмүчин» буюу монголоор «шилдэг төмөр» гэсэн утгатай үг (63, 48—49) гэж тайлбарлажээ. Зарим эрдэмтэд нялх хүүхдийг энхрийлэх утгаар «Тэмү(р)+жин» гэсэн нэр өгсөн байх гэдэг боловч Татаарын Тэмүжин Үкэ, Мэгүжи-йин сэгүл» гэх зэрэг хүний нэрд мөн «—жин» гэсэн дагавар залгасан баримт энэ таамгийг няцаах мэт байна.

Иймд энэ үгийг бид «Тэмүчин» гэдэг үгийн татаар хэл аялгууны янзаар гажуу тэмдэглэгдсэн бөгөөд тэмү[р]+чин (төмрийн дархан) гэсэн үг байж магадгүй. Энэ үгийг Элдэндэй Ардажав (8, 108—111) дэлгэрэнгүй тайлбарласан байна.

175. Жөчи Хасар (хүний нэр—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс бараг бүх судлаачид «Жочи-Хасар» гэж, Лувсанданзан «Чочи-Хасар» (31, 28), Баяр «Жөчи Хасар» (11, I, 95) гэж, Рашид-ад-Дин заримдаа «Жочи Бара» (4, I, 2, 119) гэж сэргээн босгож сийрүүлдэг билээ.

Рашид-ад-Дин Жочи гэдгийг нь хүний нэр гэж, хасар гэдэг алдаршил нэр бөгөөд «зэрлэг араатны нэр» (4, I, 2, 51). Харин Чингис хааны их хүү Зочийн нэрд холбогдуулан Рашид-ад-Дин «Тэр хүү сананандгүй байтал орчлонд мэндэлсэн тул «Жочи» гэмээн нэрлэсэн (4, I, 2, 68—69) гэжээ. Поуха Архай Хасарт холбогдуулж «Хасар гэдэг үгийг «нохойн зүйл» (58, 84) гэж тайлбарласан байна. Энэ нь хятад хадмал орчуулгыг герман хэлэнд орчуулсан Хэнишийг (36, 62) саналыг дэмжсэн зүйл болно. Бидний бодлоор бол «хасар» гэдэг үг эртний монголын домоглолын нохой хэлбэрийн арсланг нэрлэж байсан үг мөн бололтой бөгөөд энэ тухай бид өөр өгүүлэлд (48, 39б) саналаа хэлж тайлбарласан билээ.

176. Хачигун элчи (хүний нэр ба алдар) — энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн тэргүүтэн «хачи'ун элчи» гэж, Баяр Иринчин тэргүүтэн зарим нь «хачихун элчи» гэж, Лувсанданзан «хачухун элчи» гэж, Дамдинсүрэн, Дугаржав нар «хачигун алчи» гэж, Мансан, Элдэндэй Ардажав нар «хачигун элчи» гэх зэргээр сэргээн сийрүүлсний сүүлчийнхийг зөв гэж баримтлав. Тэмүжиний энэ дүү ой сайтай хүн учир дуу бариулах үгийг сайн тогтоож элчээр байн байн томилогдож, бие хүн ба улсад элчээр явдаг хүн байсан болохой.

177. гунан насуту — гэсэн нь галиглах ба утгын талаар эрдэмтэд санал зөрөөгүй боловч найруулга зүйн үүднээс гунан гэдэг энэ үгийг малын биш хүний насыг тодорхойлоход хэрэглэсэн талаасаа маш эртний хүний хэл ярианы найруулгыг тусгасан гэмээр. Учир нь энэ үгийн утгыг тайлбарласан Элдэндэй Ардажав (8, 113) нарын тайлбарласан шиг хүний насыг мал адгуусны настай адилаар гунан дөнөн настай гэж хэлэх, найруулах явдал гагцхүү маш эртний аман зохиолын зүйлд тохиолдоно. Жишээ нь Жангарын туулийн нэг хувилбарт:

Гунатай гурван байр эвдсэн
Гурван ноёны тугийг өмнөө хатгасан
Дөнөтэй дөрвөн багана эвдээд
Дөрвөн ноёны тугийг өмнөө хатгасан (64, 110) гэх мэт. Гурван нас нь эр хүйст хүнд (Тэмүгэ отчигинд) хамаарах учир «насуту» гэж эр хүйст үг хэрэглэжээ. Жич энд «Тэмүлүн өлгэтэй бүлүгэ» гэсэн үгийн дараа П. Пеллиогийн саналаар (55, 17) нууц товчооны хятад галиг эхэд орхигдсон хэсэг гэж үзсэн [Есүгэй багатур-ун нөгүгэ гэргэй Сочигил (үүнийг Пеллио Сучигэл гэсэн нь эр эм эгшиг хутгалдан орсон буруу бичлэг гэж үзэж засав) экэ-д-эчэ төрэксэн Бэктэр Бэлгэтэй хойар бүлүгэ] гэсэн өгүүлбэрийг дөрвөлжин хаалтад нөхөж оруулснаа тайлбарлая.

178. насуту бүхүй-дур (настай байхад) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио, Лувсанданзан, Рахевильз, Лигети тэргүүтэн зарим нь «бүхүй-түр» гэж буулган сийрүүлсэн нь буруу бөгөөд үүнийг жинхэнэ

монгол хэлтэн судлагчид — Баяр, Мансан, Иринчин, Дашцэдэн тэргүүтэн «бүхүй-дүр» гэж сэргээн босгосон нь зөөлөн дэвсгэрийн дараах нөхцөл учраас —дур нөхцөл бичдэг нь зөв болохыг дурдалтай. Учир нь гагцхүү хатуу дэвсгэр гийгүүлэгч Багарсадын дараа бичигддэг—түр нөхцөлийг энд «й» (е) гийгүүлэгчийн дараа бичсэн нь «й» гийгүүлэгчийн дараа—дүр гэсэн нөхцөл бичих дүрэмтэй харшилж байгаа тул ийнхүү «бүхүй-дур» гэж сэргээн босгох нь зөв гэж бодож байна.

179. Төркүд (төркүмүүд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио, Лигети, Дашцэдэн, Рахевильз тэргүүтэн «төргүд» гэсэн нь XIV-ийн галиглагчдын буруу дуудлагаар алдаатай тэмдэглэсэн зүйл гэж үзэж нөгөө «төркүд» буюу «төркүм» гэсэн үг нь илүү зөв мэт бодогдоно. Учир нь төркүд гэдэг бол төркүм гэдэг үгийн олон тооны хэлбэр мөн бөгөөд төркү [—м]+д гэсэн бүтэцтэй үг мөн болно. Үүнийг монгол хэлтэн судлагч Ц. Дамдинсүрэн, Баяр, Элдэндэй Ардажав, Дугаржав, Мансан цөм «төркүд» буюу «төркүм» гэж галигласныг зөв гэж үзэж тэр ёсоор сэргээн сийрүүлсэн болно. «Төрхүм» гэдэг үгийг Шагж (12, 623б) «бэр [ийн] өөрийн төрөл» гэж тайлбарлажээ.

180. нагачу нар-ача (нагац нараас) — гэсэн үгийн утга эхийн нь төрөл садангуудаас гэсэн утгатай нь ив илхэн бөгөөд харь овгоос бэр (охин) гуйж авдаг экзогамийн гэр бүлийн ёс дэглэм байсныг харуулав.

181. хон-хэрийэд-ай (хон хэрээд-ай) гэсэн энэ үгийг XIV зууны галигч нарын буруу дуудаж алдаатай тэмдэглэсний үршгаар хятад галигийг дагаж, Пеллио (9, 12), Рахевильз (25, 25), Лигети (33, 29), Хэниш (36, 184), Баяр (11, I, 97), Элдэндэй Ардажав, нар (8, 115), Иринчин (28, 37) тэргүүтэн «Унггирад» гэж, Дамдинсүрэн (7, 36), Лувсандан-зан (31, 28), Дугаржав (24, 17), Мансан (27, 18) тэргүүтэн цөм «Хонггирад-ай» гэж тус тус эхийн энэ үгийг сэргээн босгож сийрүүлжээ.

Гэвч энэ үгийн утга чухам юу болохыг нарийвчилсангүй. Ордост «хэрийэд» (хэрээд) овог байдаг тухай анх А. Мостарт (65; 23, 30, 43) мэдээлсэн бөгөөд хожим П. Пеллио «Кэрэит» гэдэг үгийг Рашид-ад-Дин Хээр гэсэн өнгө зүсмийн нэр гэж тайлбарласан гэдэгт эргэлзээд, монголын хэрий-э буюу хэрээд овог гэж нэрлэгдэж байсан болов уу гэж «Чингис хааны байлдааны түүх» (54, 209) номондоо энэхүү саналыг дэвшүүлжээ. Энэ нь бидний «хэрээд» ба «Хон хэрээд» овгийн талаарх үзэл бодлын зөвийг баталсан баримт мөн тул энэ үгийг энд бид ийнхүү Хон-хэрийэд-ай буюу Хон-хэрийэд ийн айн хүн гэсэн үг гэж бодож ийнхүү сийрүүлэв.

182. Худа (худ) — гэсэн энэ бүх монгол хэлтэнд ургийн холбоог холбосон хүмүүсийн бие бнеэ нэрлэх үг тул монгол хэлтэн судлагчид энэ үгийг ямар ч тайлбаргүйгээр «худа» гэж сэргээн сийрүүлсэн боловч гадаадын эрдэмтэд утгыг нь баахан гуйвуулж ойлгосон удаа байна. Жишээ нь Пеллио энэ үгийг «төрөл садан» гэсэн үгээр орчуулсан байхад Хэниш, Поуха хоёр энэ үгийн утгыг илтгэдэг герман, чех үгээр орчуулсан байна. Рахевильз, Калужинский, Кливз нар энэ үгийг үл орчуулагдах үгийн ёсоор «худа» гэж хэвээр үлдээсэн байна.

Дай-цэцэн ураг худ бололцохын өмнө тааралдсан Есүхэйг «худа!» гэж нэрлэн хандсаны учрыг Элдэндэй Ардажавын (8, 116) тайлбарласнаар үнэхээр кийуд, хонхэрийэд хөрөг аймаг хоорондоо ураг худ бололцох гэрээт байснаас шалтгаалсан байж болно гэж хүлээж байна.

Гэвч Нууц товчоонд болсон явдлыг өнгөрсөн хойно тэмдэглэн бичсэн учир зарим хүний хожим олсон алдар цол нэршлийг өмнөх үеийн хэрэг явдлыг ярих тухайд холбогдуулан хэрэглэсэн баримт цөөнгүй байх тул ойллогоч энд бас Есүгэй баатрыг худ Дай цэцнийг ийнхүү «Йэсүгэй худа!» гэж хандаж ярьснаар бичсэн байж магадгүй юм.

183. Нидун-дур-ийан галту, нигур-тур-ийан гэрэтү (нүдэндээ галт, нүүртээ гэрэ (л) т) гэсэн энэ үгийн «галту» «гэрэтү» гэсэн нь эр хүйст үгс болно. Бөртэ охинд холбогдуулж энэ үгийг «МНТ»-ы 66 дугаар зүйлд «нигур-тур-ийан гэрэтэй, нидун дур-ийан галтай» гэж байрыг сольж хэлсэн нь нэгд эм хүйс заасан «—тай» «—тэй» дагавартайгаар эм хүйс ялган заажээ. Нөгөө талаар энэ нь бас давхар сайхны зүйн өөр учир холбогдолтойг бид урьд өөр өгүүлэлдээ (10, 131—142) тэмдэглэсэн юм.

184. Би...жэгүдүлбэ би (би...зүүдлэв би) — гэсэн энэ үгийн хэл зүйн хэлбэр сонирхолтой бөгөөд төлөөний үгийг ийнхүү давтан хэрэглэх заншил эртний монгол бичгийн хэлний үг найруулгад байсан нь хожим Буриадын зэрэг зарим аялгуунд үйл үгийн бие заан хувилах хувиллын нөхцөлийн шинжтэй болсныг тэмдэглэе. Үүнд буриад хэл аялгуу, аман яриандг: би суухаб, чи суугыч, та суугыт гэх мэт хэлбэр дайралддаг нь үүний гэрч болно.

185. тагуба (суув) — гэсэн энэ үгийн бичлэг нь бидэнд их сонирхолтой

юм. Учир нь энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио, Лигети, Рахевильз, Хэниш тэргүүтэн судлагчид «ту'уба» гэж Баяр, Мансан, Иринчин нар «ту'уба» буюу «тугуба» гэж, Дашцэдэн «тууба» гэж тус тус галиглаад бараг цөмөөр «суув» гэсэн үг гэж ухаарчээ.

Бид энэ үгийг хятад галиг үсэгт «ту'уба» буюу «тугуба» гэх мэтээр тэмдэглэснийг XIV зууны үеийн галиглагч нарын дуудлага ба сонсголын гажуудуулал гэж үзэж хожим хуучин монгол бичигт энэ үгийг «сагуба» гэж бичдэг уламжлалыг харгалзан, монгол хэлэнд үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс үүсч гарахаас өмнөх үеийн худам монгол бичигт «тагуба» гэж бичигддэг үг байснаар төсөөлөн бодож ийнхүү «тагуба» гэж сэргээн босгож сийрүүлэв. Сонирхолтой нь энэ үгийн эхний «т» авиа «с» авиагаар солигдож «сагуба» гэсэн хэлбэрээр, жишээлбэл, 24 дүгээр зүйлд болон бусад зүйлд ч тааралдаж байгаа нь болно.

186. цаган багуба (цагаан буув) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио «чахан бавуба» (9, 13), Хэниш «чаган бао'уху» (36, 25, 12) Рахевильз (25, 25) Лигети (33, 30) «чахан бавуба» гэж, Дашцэдэн «чаган бауба» (26, 24) гэж, Баяр «чахан бав'уба» (11, I, 100), Иринчин «чахан бахуба» (28, 38), Элдэндэй Ардажав нар «цаган багуба» (8, 117) гэж сийрүүлээд энэ үгийн тайлбарт (8, 118—119) Загчид сэцний эл хоёр үгийн дундаас Шингхур гэдэг үг сугарсан гэсэн саналыг дурдахын хамт энэ үгс «сайн бэлэг тэмдэг буув ирэв гэсэн утга буюу» гэж тайлбарлажээ. Дамдинсүрэн «буух нь гайхалтай» (7, 36) гэж, Дугаржав нар «ямар л сайн бэлэг тэмдгийг үзүүлэх буй гэж бодож байсан билээ» (24, 18) гэж элдвээр ухаарч тайлбарлажээ. Үүнийг Хэниш «цагаан буув» (15, 10) гэж үгчлэн орчуулж, Пеллио «энэ нь цагаан [төлөг?] тавив» (9, 131), Рахевильз «цагаан юм буув» (49, 130) гэж Кливз «энэ (цав) цагаан буув» (42, 15) гэж, Поуха «цагаан буув» (17, 22), Калужинский «Бас тэгээд цагаан Шонхор» (61, 41), гэж тус тус голцуу үгчлэн хуулж орчуулав. Лувсанданзан ч эл үгийн утгыг ойлгоогүй учир «гар тур мину гэгэн цахан болгаба» (31, 29) гэжээ.

Энэ «цагаан буув» гэсэн нь бидний бодлоор бол «мэргэ төлөг цайв» гэсэн утгатай үг бололтой. Монголын мэргэ төлгийн ёсонд хамаг муу ёр хамгийн сайн бэлэг мэтээр мэргэ төөрөлдөж төлөг буухыг «шоо нь цайх» гэж хэлэлцдэг юм. Иймд энэ хачин зүүдийг мэргэ төлөг цайсаны (цагаанаар буусны ёр байх гэж Дай цэцэн айж бусад хүнд «энэ ямар л сайныг үзүүлэв гэж» гэмээн эргэлзэж сэжиглэж хэлж байсан бололтой.

187. Хара бугур-а хүлигэжү (хар буур хүлж ө. х. хөллүүлж) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Лувсанданзан (31, 29), Хэниш (36, 103, Пеллио (9, 13), Рахевильз (25, 25), Дашцэдэн (26, 24), Баяр (11, 100), Иринчин тэргүүтэн цөм «хара бугур көлгэжү» гэж сэргээн сийрүүлээд Хэниш «көлгэжү» гэснийг «көллүүлж» (36, 103) гэсэн болович орчуулахдаа «хар бууртай хасаг тэргэнд» гэж (15, 10), Козин «хар буурал тэмээ хөллөгдсөн» (14, 87), Пеллио «хар тэмээ хөллөж» (9, 131), Дамдинсүрэн (7, 36), Мансан (27, 19), Дугаржав нар «Хар буур (бууруа) хөллөж (эсвэл хөллөөд)» гэж, Мостарт «хар буур хөллүүлж» (47., 294 [10]) гэж, Поуха «хар эр тэмээ түүнд көллөсөн» (17, 22,, Калужинский «хар тэмээ хөллөсөн» (61, 41) гэж тус тус оруулсан бололтой байна.

Бид энэ «көлгэкү» гэсэн үгийг XIV зууны галиглагч нарын гажуу аялгуу ба буруу сонссоны улмаас гуйвсан бичлэг гэж үзэж утга зүйн үүднээс «күл [и] гэжү» гэж бичих нь зөв гэж бодов. Учир нь энэ үг дундад үеийн монгол хэл аялгуунд Нууц товчоонд тэмдэглэсний адил ө дуудлагатай болж уламжилж ирсний улмаас хуучин (сонгодог) монгол бичгийн хэлэнд «көлкү» (хөллөх) «көлгэ» (наадмын хөсөг уналгын хүндэтгэл) «көлбүри» (тэрэг чарганы хөлөх газар) гэх мэт үг Шагж гуайн толь бичигт орсон (12, 426) байна. Гэвч энэ бүх үг көл (хөл) гэсэн нэр үгээс үүссэн байж таарахгүй. Күл (үйл үг) +гэ (үйлдүүлэх хэв) күл(и)+г=күлиг—хүлэг (хүлэх сур) күл (и) +бүри (хүлгийг торгох газар) гэх мэтээр нэг үг үүсч болох нь дар (үйл үг) +га=дарга (дарж захирах хүн) зур (а)+г=зураг (зурсан юм) үз (э) (үйл үг)+бүри=үзэбүр (үзвэр) гэх мэттэй загвар нэг ижил болно. Күл [и] гэсэн үйл үг көл дуудлагатай болсноос көл (хөл) гэсэн нэр үгтэй эндүүрэгдэж «күликү» гэсэн үгийг «көллөх» гэсэн үгээр орлуулан илэрхийлэх болсон гэж бид үзэж байна.

188. Өкид-ийэн (охидоо) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 122), Пеллио (9, 12), Рахевильз (25, 25), Мостарт (47, 292 [9] Дашцэдэн (26, 25) Баяр (11, 106) Элдэндэй Ардажав нар (8, 120) Иринчин (28, 39) Дамдинсүрэн (7, 37) Дугаржав нар (24, 19), Мансан (27, 20) цөм өкид ~ өкит-ийэн» гэж сийрүүлж цөм өхи буюу оки (охин) гэдэг үгийн олон тооны хэлбэр гэж ойлгож орчуулжээ. Бидний бодлоор энэ

үг угаасаа өки —ганц тооны хэлбэр «өкин» олон тооны хэлбэр гэж байгаад өкин гэдэг нь олон тоот нэрийн утгаа алдахад дахин —д (олон тооны нөхцөл) залгаж, ийнхүү залгахад н гийгүүлэгч нь хасагдаж «өкид» гэсэн хэлбэрээр бичигдсэн гэж бодном. Гэсэрийн туужид ялгуусан гурван өки гэж гардаг нь өки гэдэг үг гурав гэсэн олон тоо заасан үгтэйгээ зохицолтой бичигдэх ёс алга болсны хойно ганц тоот хэлбэрээрээ бичигдсэн баримт мөн болохыг харуулж буй.

189. Хатун халхатан (хатан халхтан) — гэсэн энэ үгийг галиглах талаар зөрөөгүй. Харин энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгад халх (бамбай) гэсэн утгатай гэснийг Хэниш (36, 58) германаар мэдээлж, Козин «эмс мань халхаараа алдартай» (14, 87), Хэниш «манай эмс та нар лугаа гэрлэх нийтлэгт хамаатай» (15, 10), Поуха «эмс мань халх мэт халдашгүй» (17, 23), Пеллио «дугуй халх өмсөнө» (9, 13) гэж, Мостарт «Дугуй халх болсон хатадтай» (47, 294 [10]) Лувсанданзан (31, 1, 29), Дамдинсүрэн (7, 37) Дугаржав нар (24, 19) «Хацар гуа хатадтай» гэж, Элдэндэй Ардажав нар «халхлан хамгаалах хэрэгсэл» (8, 123) Мансан «хатнаар халх хийж» (27, 20) гэж орчуулснаас сүүлчийнх нь бидний бодлоор илүү зөв юм. Хон хэрээд овогтон улс иргэн олж авахаар дайтахгүй, харин хаан болсонд нь «хатан» өгч түүгээр овгоо хамгаалдаг улс гэсэн утгатай үг бололтой. Жич энд «хатан» гэдэг нь өгүүлэгдэхүүн «халхтан» гэдэг нь өгүүлэхүүн мөн тул хоёр үг олон тооны зохицолтой байгаа нь ил байна. Иймд «хату» ганц тоот нэр үг «хатун» гэвэл —н нь олон тооны нөхцөл болно. Түүнчлэн «халхту» гэвэл эр хүйсийн ганц тоот үг, «халхтай» гэвэл эм хүйсийн ганц тоот нэр үг «халхатан» гэдэг үгийн эцсийн «н» гийгүүлэгч нь олон тооны нөхцөл мөн тул эр, эм хүйсийг ялгахгүй хэрэглэгджээ.

190. Өкид өчилтэн (охид өчилтөн) гэсэн энэ үгийн утгыг Хэнишийн герман хэлэнд тайлснаар бол «мэдээ, илтгэл танилцуулга гэрлэх санал тавих» (36, 121) гэсэн утгатай үгээр хятад хадмал орчуулгад тайлсан бололтой. Энэ үгийн утгыг Хэниш «манай охид бэр гуйлгах жагсаалтад бий» (15, 10), Козин «охид мань даруу энхрийгээрээ (14, 87) алдартай» гэж, Пеллио «гуйлгадаг охидын» (9, 131) гэж, Мостарт «гуйж гувшуулах юм мань болсон охид» (47, 294, [10] гэж тус тус орчуулсан шиг санагдана. Монгол хэлтэн хэн бүхэнд энэ «Өхид өчилтөн» гэдэг үг их ойлгомжтой зүйл боловч Лувсанданзан, Дамдинсүрэн нар энэ үгийг «Өнгө сайт охидтай» (31, I, 30; 7, 37) гэсэн нь оновчтой болсонгүй. Мансан «Өкид-ийэр элч болгож» (27, 20) гэсэн ба I бүлгийн 33 дугаар тайлбарт «өкид өчилтөн» гэдэг нь охидоороо-охидын өнгөрөө бусад аймагтай өчилцөж (ярилцаж) харьцдаг гэсэн санаа болой» (27, 39) гэсэн нь уг санааг зөв илэрхийлжээ. Элдэндэй Ардажав нар «өкид өчилтэн» гэснийг эл зүйлийн 13 дугаар тайлбарт «өчих айлтгах хэлэхийн хүндэтгэл» (12, 163а) гэж заагаад Дорнотивын 21 дүгээр тайлбарт «өчилтэн» гэмээх нь хаан хүнд үг айлтгах эрхэм зэрэгтэй гэсэн үг» (8, 123—124) гэсэн нь Мансангийн тайлбарт хүрсэнгүй.

Бид энэ үгийг Хон-хэрээд овогтон бусад иргэнийг эзлэх гэж тэмцдэггүй, харин охидоо хаан болсонд нь хатан болгон өгч түүгээрээ тэдэнтэй үгээ ололцдог гэсэн утгатай үг гэж бодож байна. Энэ нь охид мань бидний өчил залбирал мөн гэсэн үг юм. Үүнийг «МНТ»-ы 103 дугаар зүйлд байгаатай «Манагар бүри малайасугай, үдүр бүри өчисүгэй» гэсэн үгтэй жишиж үз. Өчил гэгч тэнгэртээ хүсч гуйх мөргөлийн үг гэсэн утгатай нь илэрхий биз ээ.

191. Нугун (нуган) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 119) «о'ун» гэж, Пеллио (9, 13,) Мостарт (47, 293 [9]), Баяр (11, I, 109) Лигети (33, 31), Рахевильз (25, 25) тэргүүтэн «ну'ун» гэж, Лувсанданзан (31, I, 30) Баяр, Иринчин (28, 40) нар «нухун» гэж, Дашцэдэн «ну [г]ун» (26, 25) гэж, Дамдинсүрэн (7, 37) Дугаржав нар (24, 19) Мансан (27, 21), Элдэндэй Ардажав нар (8, 124) тэргүүтэн «нугун» гэж сэргээсний сүүлчийнхийг чухам зөв нь гэж бид мөрдөн сийрүүлэв. Утгын талаар бараг цөм «эрэгтэй хүүхэд» гэсэн утгатай гэж үздэг нь эргэлзээгүй болой.

192. Нугун көбэгүд ману нунтаг харайу (нуган хөвгүүд мань нутаг харъюу) — гэсэн энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгад түшиглэн янз бүрээр ойлгож судлагчид буруу зөрүү орчуулж байсныг бид өөр өгүүлэлдээ (10, 119—126) задалж дурдсан тул энэ үгийн утга нь «нуган (эрэгтэй) үр мань нутаг харъюу (сахиж үлдэнэ)» гэсэн утгатайг тэмдэглэе.

193. Өкин көбэгүн ману өнгкэ үжэгдэйү — гэсэн үгийн утгын талаар бид мөн үүний өмнөх тайлбарт дурдсан өөр өгүүлэлдээ задлан шинжилж тайлбарласан бөгөөд үүний утга нь охин үр харь овгоос ирсэн залуу эрчүүлд өнгө шилэгдэн өөр овогт одох ёстой гэсэн санааг гаргасан болно.

194. Өкин көбэгүн (охин хүү) — гэсэн энэ үгнээс үзвэл көбэгүн гэсэн үгийн дундах б гийгүүлэгч авиа суларч бас «э» ба «ү» эгшгийн хоо-

ронд буй г гийгүүлэгч сугараад урт үү болох хандлага гарсан учир XIV зууны аман аялгуунд «кө'үн» гэсэн дуудлагатай болоод байснаараа Нууц товчооны хятад галигт тэмдэглэгдсэн байна. Энэ нь одоогийн буриад аялгуунд эрэгтэй үрийг нэрлэдэг үгтэй их л адилавтар дуудлагатай юм. Хожмын хуучин бичигт уламжлан ирсэн бичлэгээр бид «көбэгүн» гэж сэргээн сийрүүлж бичив. Гэвч энэ «көбэгүн» гэдэг анх «көбүгэн» гэж анхны худам монгол бичигт бичигдэж хэлэгдэж байгаад хожим эгшиг ба үе нь солигдож «көбэгүн» болж хувисчээ. Учир нь худам монгол бичигт урт эгшиг үүсээгүй байсан үеийн аялгууг тусгах учир «кэүкэн» (хүүхэн) гэсэн бичлэг байх ёсгүй юм. Энэ учраас кэбүкэн гэсэн үгийн «б» нь суларч сугараад «кэ [б] үкэн» болж улмаар хэ+ү авиа нь ижилсэн урт эгшиг болж хүүхэн (эрэгтэй эмэгтэйг ялгахгүй нялх балчир «хүүхэд» гэсэн утгатай үг үүсч) улмаар хожим «эмэгтэй үр, бүсгүй» гэсэн утгатай болж хувирсан юм. Энэ талаар Дамдинсүрэн авгайн «хүү ба хүүхэн гэдэг үгийн учир» өгүүллийг (66, 121—129) үзвэл ойлгомжтой. Иймд энэ үгийн хувисал нь көбэкүн көбүкэн кэүкэн хүүхэн гэх мэт байсан байж болох юм.

195. өчүкэн (өчүүхэн) — гэсэн энэ үгийг хятад галигт «үчү'үгэн» (36, 158) гэж бичсэн бөгөөд үүнийг баримталж Пеллио (9, 13) Рахевильз, Лигети, Баяр цөм «үчү'үгэн» гэж сэргээн бичдэг боловч энэ нь урт эгшиг үүссэн үед түүнийг хоёр эгшгийн хоорондоос «г» сугарч үүссэн мэтээр төсөөлж XIV зууны үед Нууц товчоог галиглагчдын буруу дуудлагаар тэмдэглэсэн зүйл гэж үзнэ. Учир нь энэ үг анх өчү— (гэсэн бага бяцхан гэсэн утгатай язгуур, нэр үгийн үндэс) +гэн (улам багасгах энхрийлэх аястай үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй бөгөөд өчү— гэсэн үндэс нь задгай үеийг уртаар дуудах монгол хэлний жамаар хожим уртаар дуудагдах болж улмаар өчү+гү+хэн гэж уртатгалтай бичих болжээ. Үүнийг Лувсанданзан (31, 30) Дамдинсүрэн (7, 37) Баяр (11, 109) Дугаржав нар (24, 19), Мансан (27, 21) цөм «өчүкэн» гэж зөв бичсэн нь хуучин бичигт уламжилж ирсэн бичлэг мөнийг гэрчилнэ. Үүнийг Дашцэдэн «өчүүхэн» (26, 25) гэсэн нь мөн «г» сугарч урт эгшиг болоогүйг хүлээсэн мэт бодогдож байна. Элдэндэй Ардажав нар «өчүгүкэн» (8, 124) гэж сийрүүлээд, энэ зүйлийн 4 дүгээр тайлбарт «өчүкэн» гэсэн үг гэж тайлбар хийхийн хамт 135 дугаар зүйлд «өчүган» гэмээн гарна» (8, 125) гэж заасан нь бас буруу галиглал гэдгийг баталсан баримт болно.

196. гуйугулжу (гуйлгаж) — гэсэн энэ үгийг хятад галигаас Пеллио (9, 13), Рахевильз (25, 26), Лигети (33, 31) Баяр (11, 111), Иринчин (28, 40), Мансан (27, 21) тэргүүтэн цөм «гуйу'улжу» бүюу «гуйугулжу» гэж, Дашцэдэн «гуйуулжу» (26, 25) гэж тус тус сэргээж галигладаг бөгөөд утгыг нь Лувсанданзан (31, 30) Дамдинсүрэн (7, 37), Дугаржав нар (24, 20) цөм «гуйулгажу» гэж хуучин монгол бичгийн бичлэгээр сэргээсэн нь зөв юм.

Энд сонирхолтой нь худам монгол бичгээр бичиж байх үед үйл үгийн үйлдүүлэх хэвийн —гул залгавар залгаж байсан үг хожим үеийн монгол хэлэнд —га залгавар залгаж үйлдүүлэх хэвийг илтгэх болж хувирсан баримт юм. Сонгодог (хуучин) монгол бичигт «сагулгажу» гэж бичдэгийг эртний худам монгол бичигт «сагулжу» гэх мэтээр өөрөөр бичиж байсны баримт Нууц товчоонд олон байх тул бид үүнийг санамсаргүй алдаа бус гэж үзэж «гуйугулжу» гэж сэргээн босгож бичив.

197. Өкин-ийэн бэ[р] өксү, хөбэгүн-ийэн бэ[р] (охиноо бэр өгсү, хөвгүүнээ бэр) гэсэн энэ үгийг хятад галигийг мөрдөж Хэниш (36, 14) Пеллио (9, 13) Рахевильз, Лигети, Баяр, (11, I, 111), Элдэндэй Ардажав (8, 125) Дашцэдэн (26, 25) нар цөм «өкин-ийэн бэ өксү, хөбэгүн-ийэн бэ» гэж сийрүүлэн сэргээсэн боловч Элдэндэй Ардажав нар «бэ гэмээх нь ба байвал зөв» (8, 127) гэж тайлбарласнаас үзвэл ба (бид) гэсэн үгтэй хутгаж буруу ойлгож байсан бололтой. Энэ «бэ» гэсэн үгийн утгыг хятад хадмал орчуулгад Хэниш авгайн орчуулснаар «бас» «түүнчлэн» гэх мэт утгатай гэж тайлсан боловч Хэниш (15, 11) Пеллио (9, 132) Рахевильз (49, 131) тэргүүтэн энэ үгийн утгыг орчуулгадаа туссагүй. Тэр ч байтугай Лувсанданзан (31, 30) Дамдинсүрэн (7, 37) Мансан (27, 21) нар ч уг үгийг орхисон байна.

Харин МУИС-ийн багш Чоймаа Нууц товчооны ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан нэг илтгэлдээ «ба» «бэр» гэх мэт хүч нэмэгдүүлэх утгатай сул үг байгааг илрүүлэн тайлбарласан билээ. Бид энэ «бэ» «ба» гэсэн хятад галиглалыг XIV зууны үед Нууц товчооны эхийг галиглагчдын алдаатай тэмдэглэсэн бичлэг гэж үзэж чухам нь «бэр» гэсэн хүч нэмэгдүүлэх сул үгийн эцсийн «р» авиаг дутуу буулгасан гэж үзэж бэ[р] гэж сийрүүлэв. Энэ бэ гэсэн үг бид гэсэн утгатай «ба» гэсэн I биеийн төлөөний үгийн олон тооны хэлбэр байсан гэвэл I хэсэгт утга тохирох боловч II хэсэгт («хөбэгүн ийэн

ба») утга нь тохирохгүй болох тул үүнийг «ба» гэж сэргээж тохирохгүй гэж үзэв.

198. Хүргэд-[т]-э талбижу (хүргэдэд тавьж) — гэсэн энэ холбоо үгийг хятад галиг үсгийг мөрдөж «гүрэгэт-тэ» (Пеллио, Рахевильз, Лигети «гүргэт-тэ» гэх буюу эсвэл «гүрэгэ [т]-тэ» гэж, Дашцэдэн «куригэдтэ» гэх буюу эсвэл «күрэгэд-тэ» гэж, Баяр, Ардажав Элдэндэй нар «күригэд» буюу «күрэгэд-тэ» гэж, Иринчин «күрэгэд тэ» гэж элдэв олон янзаар сэргээн сийрүүлжээ. Бид энэ холбоо үгийн утгын талаар Элдэндэй Ардажав нар (8, 127) зөв зүйтэй тайлбар хийсний дээр бид урьд бичсэн өгүүлэлдээ (67, 39) тодорхой тайлбарласан билээ.

Энд бид «Күргэд [т]-э талбижу» гэж сэргээн сийрүүлж бичихдээ —тэ гэсэн нөхцөлийг Баяр гуай зэрэг зарим нь өгөх оршихын —ту нөхцөлийн өөр хэлбэр гэж үзэж бичигт «күргэд-ту» гэж бичсэн шигээс арай өөрөөр үзэв. Энэ бол XIV үеийн галигчийн сонссон сонсголоор үгийн эцсийн д гийгүүлэгч авиа сунжран уртаар күргэт-т-э гэж буруу тэмдэглэгдсэн хэлбэр гэж бодоод уг бичигт «күргэд (олон тооны д нөхцөлт нэр үг) +э (өгөх орших тийн ялгалын эрт цагт их л олонтоо хэрэглэгддэг агсан нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож ийнхүү сийрүүлснээ тэмдэглэе.

199. сочимдахай (чочимтгай) — гэсэн энэ үгийг зарим судлагчид хятад галиг үсгээс Пеллио, Хэниш (36, 29), Рахевильз, Лигети, Баяр, Дашцэдэн, Элдэндэй Ардажав (8, 125) Иринчин нар цөм «чочимдаву» буюу «чочимдагу» гэж сэргээн босгодог нь энэ үг бусад олон үгийн адил тэр (XIV зууны) үеийн аман аялгууны дагуу тэмдэглэгдсэн үг мөн болохыг харуулж байна. Харин хуучин монгол бичгийн уламжлалыг бодвол энэ эртний худам монгол бичигт «чочимта-гу» гэж бичигдэхгүй, харин «сочимдагу» буюу сочимтахай» гэж бичигдсэн байж болох юм. Учир нь Нууц товчооны хуучин бичгийн эхтэй байсан гэгддэг Лувсанданзан энэ үгийг «чочимтахай» гэж бичсэн нь уг эхээ дагасных байж магадгүй. Иймээс ч Дамдинсүрэн (7, 38), Дугаржав нар (24, 20) энэ үгийг «сочимтгай» гэж сэргээсэн нь зөв гэж бид үзэв. Иринчин (28, 41) бас Лувсанданзаны «сочимтахай» гэж бичсэнийг зааж хэлсэн нь чухал санал юм.

Иймд бид энэ үгийг сочи—(үгийн идэвхтэй язгуур, үйл үгийн I үндэс) +м (чочмоор юм гэсэн утгатай, үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +да [та?] (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +хай (үйл үгээс нэр үг бүтэх дагавар) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна.

200. бэлэк-э өкчү (бэлэгт өгч) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио, Рахевильз, Лигети, Баяр, Элдэндэй Ардажав (8, 125) Дашцэдэн Иринчин цөм «Бэлгэ» гэж сэргээн сийрүүлсэн нь хоёр үгийг хутгасан алдаа болно. Учир нь хуучин монгол бичигт «бэлгэ» гэвэл «тэмдэг» гэсэн утгатай үг бөгөөд «тэмдэг» болгож хүнд юм өгөх заншил байхгүй юм. Хүнд баярласан талархсанаа илтгэж үнэ ба хариу нэхэхгүй өгөх зүйлийг «бэлэк» гэж бичнэ. Хөтөл морио яг энэ утгаар өгсөн тул зүй нь тэр үгийг худам монгол бичгийн эхийг баримталж буулгасан бол «бэлэг-э» гэж бидний сэргээснээр бичих учиртай байв. Гэтэл XIV зууны энэ зохиолыг галиглагчдын аман аялгуунд энэ «бэлэк» гэдэг үгийн II үеийн э эгшиг балархайшин суларч дуулдахаа больсон тул галиглагч түүнийг орхижээ. Харин араас дагуулсан —э (өгөх оршихын тийн ялгалын нөхцөл) сонстож байсныг галиглагч тодорхой сонсч тэмдэглэсэн тул бэл [—э] к—э=бэлгэ гэсэн өөр үгтэй адилаар тэмдэглэсэн байна. Харин Лувсанданзаны эхэд «бэлэк-э» гэж бичигдсэн нь XVIII зууны үед ингэж эгшлэгээр төгссөн үгэнд —э (өгөх оршихийн тийн ялгалын нөхцөл) дагуулахаа нэгэнт больсон тул Лувсанданзан «э» нөхцөлийг хасч «бэлэк өгчү» гэж бичсэн бололтой. «Морио бэлэк өгч» гэсэн үг найруулгаар зохисгүй учир Дамдинсүрэн үүнийг «морибар бэлэк өгчү» (7, 38) гэж, Дугаржав «бэлэк болган бариад» (24, 20) Мансан «көтүлүгэ мори бан бэлэк өкчү» (27, 21) гэхчилэн засч сэргээжээ. Иймээс бид эртний худам бичигт «бэлэк-э өкчү» гэж бичээстэй байсан гэж төсөөлөн ингэж сийрүүлэв.

201. Хихасу-бан (хяхаасаа) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио (9, 14) бодвол, Лувсанданзаны эхийг (31, 31) мөрдөж «кэгэсүлэн» гэж, Рахевильз (25, 26) Лигети (33, 32), Баяр (11, 114), Элдэндэй Ардажав (8, 128—129) тэргүүтэн олон судлагч Хэнишийг (36, 97) дагаж «кэгэсү-бэн» гэж тус тус сэргээн галигладаг билээ. Харин Дашцэдэн «кээсү-бэн» гэж «г» авиаг уртатгалын сугарах авиа гэж үзсэн юм. Үүний утгыг Хэниш хятад хадмал орчуулгыг дагаж «үзэн ядах, өшөө, дайсагнал» гэх мэтээр тайлсан байна. Дамдинсүрэн гуай «өшөөгөө» (7, 38), Дугаржав нар «өшигэ-бэн» (24, 20), Мансан «хорусул ийан» (27, 21), Элдэндэй Ардажав «өший-э хорусул» (8, 129) гэж тайлбарласан буюу орчуулсан байна.

Бид энэ үгийг «Хихасу-бан» гэсэн үг болов уу гэж таамаглаж байгаа юм. Ингэж бодох үндэс бол «МНТ»-ы 58 дугаар зүйлд бидний

бодлоор **энэ үгтэй гарал нэгтэй «өшил өшин, хисал хисан» (9, 58)** гэсэн **төрөл үг нь гарч байгаа явдал болно. Жич** энэ «өсүл өсүн» гэж энд бичсэнийг «өшил өшин» гэж бид (58 дугаар зүйлд) сэргээсэн явдал «өшөө гэсэн үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «өсий-э» (өший-э) гэж бичдэг явдал болно. Энэ үг анх өси гэж бичигдэж байгаад хожим зарим аялгуунд нь эцсийн и нь балархайшч орхигдоод өс—гэсэн үг болж, заримд нь өси—хэвээр үлдсэнээс өсүлэхү «өсийэлэкү» гэсэн хоёр янзын үндэстэй үг үүссэн гэж санана. Үүнчлэн кихасу кисаху (12, 370 б) кихаху (12, 365 а) гэсэн үгс үүссэн бололтой.

202. **өйислэ (л) дүн** (өшөөлөлдөн) — гэсэн энэ үгийг хятад хадмал орчуулгыг дагаж Хэниш (36, 130) «ойисулатун», Пеллио (9, 14), Рахевильз (25, 26), Лигети (33, 32) Дашцэдэн (26, 26), Баяр (11, I, 114), тэргүүтэн «оуисуладун» гэж сийрүүлэн буулгаж, хятад хадмал орчуулгыг дагаж Хэниш (36, 130) нууцаар (муу) санаалж «хорлохын тулд» «хорлож үхүүлэхийн тул» (15, 11) Пеллио (9, 132), Рахевильз (49, 132) Кливз (42, 18), Дамдинсүрэн «нууцаар хэлэлцэн» (7, 38), Дугаржав нар «далдуур хэлэлцэн» (24, 20) Мансан «нууцаар хорлохоор хуйвалдан» (27, 21), Элдэндэй Ардажав нар «сэмээр өшөөгөө бодолцон» (8, 120) гэж тус тус ойлгож орчуулсан буюу тайлбарласан байна.

Бид энэ үгийг «өсийэлэ (л) дүн» гэсэн үг гэж бодохын үндэс нь нэгд, Лувсанданзан үүнийг «өслүлдүн» (31, 1, 31) гэж бичсэнд бий. Хоёрт, «өйисүлэдүн» гэсэн үгийн йи сү хоёр үе солигдон орж ийм үл мэдэгдэх дуудлагатай үг болсон байж бас болно. Юу ч болсон «ойису» (үгийн идэвхгүй язгуур, нэр үгийн I үндэс) +лэ (нэр үгээс үйл үг бүтэх дагавар) +д (үйл үгийн олны нөхцөл) +н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) байж болно гэж бодов. Эсвэл өйисүлэ (гэсэн үүсмэл үйл) үгэнд +(л)д гэсэн эсрэг үйлдэлдэх хэвийн нөхцөл залгасны (л) нь галигт орхигдсон байж бас болно гэж бодном. Тийм эс болбол өйисүлэ — гэсэн үйл үгнээс —д дагавар залгаж дахин үйл үг бүтээсэн байж боломгүй бодогдоно.

203. **Хачирчу** (хачи авч)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «Хужирху» (36, 71), Пеллио (9, 14), Рахевильз (25, 26) Лигети (33, 32), Баяр (11, I, 114), Иринчин (28, 42) тэргүүтэн цөм хужиржу» хужирчу» гэж сэргээн сийрүүлж бичдэг боловч бид энэ үгийг «хачи» (өс хонзон) гэсэн утгатай нэр үг (+р) нэр үгээс эс тусах үйл үг бүтэх дагавар (+чу) нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож ийнхүү сэргээн сийрүүлэв. Учир нь «хужир» гэгч монгол хэлэнд гагцхүү «шүү, шүлт» гэсэн үг болох тул хятад хадмал орчуулгын утгыг Хэнишийн «хорлож алах» «хор өгөх» гэсэнтэй утга огт ойртохгүй. Харин «хачилаху» «хачи абху» гэвэл «өс авах, хорсох, үзэн ядах» гэсэн утгатай тул «хачирчу» гэсэн эс тусах үйл үг «өсөрхөх хорсох» гэсэн утгатай нь илэрхий. Иймээс «хужирчу» гэсэн энэ бичлэгийг XIV з. үеийн галиглалын алдаа болов уу гэж төсөөлөн ингэж сийрүүлсэн болно. «Хачирчу» гэдэг «өшрөн хорсч» гэсэн утгатай мэт.

204. **магу** (муу)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «Мао'уи» 36, 107) Пеллио (9, 14) тэргүүтэн Баяр (11, I, 114), Элдэндэй Ардажав (8, 128—129) Дашцэдэн (26, 26) тэргүүтэн цөм «ма'уй» «мавуй», «мауй» гэх мэтээр сэргээдэг боловч үүнийг бид XIV зууны галигч нарын аман аялгууны дуудлагын гажуудал туссан гэж үзэж «магу» гэсэн эртний уламжлалт бичлэгийг баримтлав. XIV зууны ярианы хэлэнд магу+одчу гэсэн хоёр үгийн адаг ба эхний у, о хоёр эгшгийг й гийгүүлэгч жийрэглэн хэлж салгасан учраас «магу» биш «магуй отчу» гэж тэмдэглэсэн байх гэж санагдаж байна.

205. **Мэнггэлик** (хүний алдар)—гэсэн үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш гуай (36, 180) Пеллио (9, 14) Баяр (11, I, 116) Дашцэдэн (26, 26) тэргүүтэн цөм «Мөнглик, Мүнглүк» гэж, Иринчин (28, 41—42) Дамдинсүрэн (7, 38) Мансан (27, 22) Дугаржав (24, 21) тэргүүтэн «Мэнглик Минглик» гэж сэргээн сийрүүлдэг юм.

Энэ хүний нэрийг бид Мэнггэлиг (буюу олон мэнгэт) гэсэн монгол үгээр илэрсэн хоч нэр гэж үзэж ингэж сийрүүлэв. Үүнд Иринчин (28, 43) Юань улсын судраас иш татаж «Баясгалант» гэсэн түрк үг» гэж тайлбарлажээ. Энэ бол энэ хүний хоч нэрийг Мэнглик гэж буруу галигласны улмаас ийм тайлбар гарахад хүрсэн бөгөөд зөв дуудлага нь «Мэнггэлик» гэсэн монгол үг бөгөөд энэ нь «Мэнгэ олонт» гэсэн утгатай гэж бодно. Бас энэ үгийг Элдэндэй Ардажав (8, 130) Мэнглик гэгч түрэг хэлний «мэнгэтэй хүн» гэсэн үг гэж тайлбарлаад монголын мэнгэттэй адил гэжээ. Гэвч Мэнггэлиг гэдэг нь олон мэнгэтэй гэсэн үг байх тул энэ хүнийг монголчууд монгол үгээрээ хочилсон гэж бодох үндэстэй. Нөгөө талаар Элдэндэй Ардажав нар Дэв Тэнгэр бөөгийн эцэг бөгөөд чанару тайлгын дарга болж оролцдог болохоор «эцэг» кэмэгдсэн бололтой» (8, 130) гэж таамагласан гэсэн нь төдий л үнэмшилтэй биш. Бидний бодвол Есүгэй баатар өөрийн авга ах Чираха

өвгөний хүү Мэнггэлик-т өнчин үлдсэн хүүхдүүд бэлбэсэн эм Өгэлүнийг гэрээслэсэн учир тэр цагийн

«Ах үхвэл бэргэн нь гэрээс
Агт үхвэл шир нь гэрээс» гэсэн заншил ёсоор

Тэмүжин болон дүү нарт нь хойд эцэг, Өгэлүн үжинд эрийн гэрээсээр асарч явах хоёрдох эр нь болсон тул түүнийг улсын албан ёсны түүхэнд «Мэнггэлик эцэг» гэж тэмдэглэгдэх жам ёсны эрхтэй юм. Иймээс Чингис хааны түүх «МНТ»-д «Мэнггэлик эцэг» гэж тэмдэглэгдсэн ажээ.

206. **«чиг-а мину»** (чагаа минь)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн эхээс Хэниш «чаха» (36, 25) гэж тэмдэглэсэн тул Пеллио (9, 14) Баяр (11, I, 116), Дашцэдэн (26, 26) тэргүүтэн судлагчид «чаха» гэж сэргээн сийрүүлдэг ба ахмад хүнээс дүү хүнд энхрийсгээр «чаха мину!» гэж хандахыг Хэниш «хүүхэ!» гэж дууддагтай адил балчир хүүхэд (эрэгтэй эмэгтэйг үл ялган нэрлэх) кнабе гэсэн үгээр тайлжээ. Ц. Дамдинсүрэн «күү минь!» (7, 38) гэж бичжээ. Чаха (Би эндүүрээгүй бол Ж. Цэвээн «Арван таван наст капитан» номыг орчуулахдаа «чиг-а (чагаа) мину» гэж бичсэн тул (энэ үгийг зарим аялгуунд бас «чаг-а» гэж дууддаг байсан болов уу) гэсэн үг орчин цагийн халхын аялгуунд мөн оросын «ребенок» гэсэн үгтэй адилаар хэлэгдэх «хэүкэ!» (хүүхээ!) гэдэг үгтэй адил утгатай хандлага үг байжээ. Элдэндэй Ардажав нар энэ үгийг «чага» гэсэн түрэг үг (8, 130—131) гэж тайлбарласан нь чухамдаа монгол түрэгийн дундын үг тул энэ үгийг эртний монгол худам бичигт «чиг-а» гэж бичиж байсан болов уу гэж «чиг-а» гэж буулгав.

207. **Өчүкэд хочуругсад** (өчүүхэн хоцрогсод) гэсэн энэ үгийг галиглах ба түүний утгыг ойлгох талаар бид судлагчдын саналтай зөрөөгүй боловч өчүкэ (ганц тоо) +н (олон тооны нөхцөл) гэж урьд ойлгогдож байгаад хожим «н» нь олны тоог заахаа больсон үед тэр «н» нөхцөлийг орхиж +д гэж өөр олон тооны нөхцөл залгаж хоцрогсод гэсэнтэй адил олон тоот нэр ба түүний хүртээл нэрийг адилхан олон тооны нөхцөлөөр ижилсгэсэн нь эртний худам монгол бичигт хүртээл нэр ба юмын нэрийн хооронд тооны зохицол байсны нэг гэрч болохыг энд тэмдэглэе.

208. **Асараху йи** (асрахыг)—гэсэн энэ үг бол маш эртний монгол овогтны дунд харь овгоос гэрлэх (экзогами) ёс байсны улмаас бэлбэсэн эмсийг төрхөмд нь буцаах ёсгүй тул эрийг нь үгүй болсны дараа түүний ах дүүгийн хэн нэгэн нь тэдгээр «өнчин хоцорсон дүү нар ахын бэлбэсэн эмийг талийгаачийн гэрээс ёсоор асрах (харж хандах ба эмийн ёсоор хэрэглэх) заншилтай байсныг энэ үг харуулж буй. Энэ үчраас авга ахын хүүхд-(өнчин дүү нар)эд Мэнгэлэг (хойд) эцэг нь болж бэлбэсэн Өгэлүн бол түүний жидүгэр (жөтгөр) II эм болсон гэсэн утгатайг энэ үг харуулжээ. Үүнээс бас монголчуудад олон эхнэр авах ёс гарч тэдгээрийг хүүхдүүд нь «эх нар» гэж нэрлэх болсноос «эхнэр» гэдэг үг үүсч гэргий гэсэн утгатай болжээ.

209. **мөрэлжү** (мөрөөдөж)—гэсэн энэ үг эртний худам монгол бичигт урт эгшиг үүсээгүй үед бичигдэг байсан хэлбэрээрээ энд тэмдэглэгдсэн гэж бид бодож байна. Нөгөө талаар мөн эртний худам бичигт монгол хэлний үгийн доторх эгшгүүд уруулаар зохицох ёс байгаагүй тул энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «мөрүгэдкү» гэж бичдэгээс өөрөөр «мөрэлжү» гэж бичигдсэн гэж санах тул энэ үгийг «мөрэлжү» гэж сийрүүлсэн. Пеллио (9, 15) Хэниш (36, 111) нарын сэргээлт зөв гэж баримтлав. Бусад нь «мөрөлжү» гэж хуучин (сонгодог) монгол бичгийн бичлэгт ойртуулсан нь буруу биз ээ.

Иймд энэ үгийг бид мөрэ-(үгийн идэвхгүй язгуур, нэр үгийн үндэс) +л (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +жү (нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодно. Жич худам монгол бичгийн эхтэй агсан Лувсанданзан уг эхэд байсан мөрэлжү гэсэн үгийн утгыг ойлгоогүй бололтой «мөгэтчү» (31, 1, 32) гэж алдсан байж болохоос гадна утгыг тааж II удаа «мөргэткү» гэж хуучин бичгийн «мөрүгэткү» гэж бичихээс өөрөөр бичсэн алдаа нь ч уг эхэд үбиш э байсны учраас болов уу. Мөрэ-гэсэн энэ үгийн үндэс задгай үеэр төгссөн тул дуудлага нь аажмаар урт болж бас э эгшиг нь өргөлтөт үеийн ө эгшигтэйгээ уруулаар зохицон ижилсэж хожим «мөрүгэлкү» (мөрөөлөх) гэж хуучин монгол бичигт бичигдэх болсноос зайлахгүй.

210. **Өрэ-бэн** (өрөө)—гэсэн энэ үгийг хятад галиг эхээс судлагчид ийнхүү зөв сэргээж утгыг өр (зүрх) гэж зөв ойлгон орчуулсан буюу тайлбарласан юм. Энэ үгийн бичлэг нь монгол хэлэнд үгийн эгшгүүд хоорондоо уруулаар зохицох ёс гараагүй зөвхөн хэлний байрлалаар зохицож байх үед Монголчууд худам (эртний) монгол бичгийг авч хэрэглэсний нэг гэрч энэ бөгөөд Нууц товчоо эртний худам монгол бичгээр бичээстэй байсны баримт мөн болохыг энд тэмдэглэе. Элдэндэй

Ардажав нар (8, 132) энэ үгийг тайлбарлахдаа «МНТ»-ы 84 дүгээр зүйлд «өрө гэж гарна» гэж тэмдэглэсэн нь XIV зууны галиглагч нарын хэл аялгуунд үгийн эгшиг уруулаар зохицох ёс гарчихсан байсны нөлөөгөөр буруу сийрүүлсэн баримт гэж бодно.

211. **Өрэ эбэдүмү** (өрөвдөнө) — гэсэн энэ холбоо үг «энэрэх хайрлах санаж мөрөөдөх» гэсэн утгаар хэрэглэгдсэн хийгээд тийм утгатай «өрөвдөх» гэдэг үйл үг монгол хэлэнд үүсгэснийг энд тэмдэглэе. «Эбэдүмү» гэсэн энэ үг бас эртний худам монгол бичигт үгийн эгшиг зөвхөн хэлний байрлалаар зохицож байсан үеийн бичлэгээрээ уламжлан ирснийг харуулж байна.

212. **Орбай Сухатай жирин** (Орбай Сухатай хоёр) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь И. дэ Рахевильз (25, 27) Лигети (33, 33) Мостарт (47, 298 [14] Иринчин (28, 44) Лувсанданзан (31, I, 32) тэргүүтэн «Өрбэй» гэж, Хэниш (36, 181) Пеллио (9, 15) Дамдинсүрэн (7, 42) Баяр (11, 1, 121) Дашцэдэн (26, 27) Элдэндэй Ардажав нар (8, 133) Дугаржав (24, 22), Мансан (27, 42) тэргүүтэн цөм «Орбай» гэж сийрүүлснийг бид зөв гэж баримтлав. Харин нөгөө хатны нэрийг Хэниш, Пеллио тэргүүтэн судлагчид цөмөөр «Сохатай» гэж сийрүүлсэн боловч бид энэ хатныг сохорын овгийн биш, харин Сухайд овгийн эмэгтэйг овгоор нь «Сухатай» гэж нэрлэж байсан байж магадгүй гэж «Сухатай» гэж сийрүүлэв. Жич «жирин» гэдэг энд хоёр эм хүний нэрд холбогдон хүйс зааж хэрэглэгдснийг тэмдэглэе. Энэ нь эртний Монголын хэлэнд эр эм хүйс ялган бичдэг үгс ба үйл үгийн хувилал байсныг худам монгол бичигт тэмдэглэдэг байсны гэрч болно. Хүйс ялган бичдэг байсан талаар судлагчид тэмдэглэж байжээ. Үүнд Дамдинсүрэн (50, 64—67) Элдэндэй Ардажав (8, 133—134) тэргүүтэн олон бий.

213. **Икэс-үн гажар-а инару гаруссан дур** (ихсийн газарт янар гарсанд)— гэсэн эдгээр үгсийг уг эхийн хятад галиг үсгээс Хэниш (36, 57), Пеллио (9, 15) Баяр (11, I, 121) Дашцэдэн (26, 27) Иринчин (28, 43—44), Лигети (33, 33) тэргүүтэн цөм «икэс-э гажару инэрү гаруссан-дур» гэж XIV зууны галиглагч нарын осол ташаа сийрүүлгийг мөрдөн буруу сэргээн босгож сийрүүлэн бичицгээсэн бөгөөд үүний утгын авцалдаагүйг Лувсанданзан мэдэж эргэлзэн залруулахыг оролдсон (31, 1, 32—33) боловч өөрөө учрыг мэдэхгүй тул улам ч их гуйвуулсан бололтой. Лувсанданзаны энэ гуйвуулсан буруу сэргээлт нь Мостарт авгайг 47, 300[16]—308[24] бас төөрөлдүүлснээс гадна хятад галиг үсгийн алдаа нь Элдэндэй Ардажав нарыг ч бас төөрөлдүүлж энэ хэсгийн зарим (Жишээлбэл «инару» гэсэн) үгийг буруу тайлбарлахад (8, 135—136) хөтөлбөрлөсөн юм. Хятад галиг эхийн эдгээр сэргээлтийн алдаатайг Ц. Дамдинсүрэн мэдэж «Икэс-үн гажар-а» (7, 42) гэж залруулсан байх бөгөөд үүнийг Дугаржав (24, 22) Мансан (27, 43) нар харгалзан баримталсан бололтой.

Бидний бодлоор бол эдгээр үгсийн утга нь Орбай Сухатай жирин хатан ихсийн газарт (өвгөдийн оршуулгын газарт) янар (буюу тогтсон хугацаанаас наана) Өгэлүн үжинд хэлэлгүй түрүүлж гарсан учир Өгэлүн үжин «хожид хүрч» тайлга тахилгын идээ умдаанаас «хожитуулдаж» өнчин өрөөсөн гэж, хүүхдийг минь өсч том болохгүй юм шиг санаж гадуурхан «үзээд (нүд үзсээр ялгаж) идэх, үл сэрүүлэн нүүх» болов та нар гэж Өгэлүн үжин хоёр хатанд хэлсэн болох нь илэрхий. Иймд хятад үсгийн эхэд байгаа «инэрү» гэдэг үг нь Элдэндэй Ардажав нарын тайлбарласны адил «чинэрү» гэсэн үгийн эхний «чи» үсгийг «и» үсгээр сольсон алдаа биш, харин «инару» (наана) гэсэн үгийн «а» «у» хоёр эр эгшиг авиаг «э» «ү» гэсэн эм эгшгээр сольсон алдаатай бичлэг юм. Хэрэв энэ үг үнэхээр «инэрү» биш «чинэрү» (оршуулгын тайлга) гэсэн үг байсан бол «гарсан» гэдэг үгэнд тэг хэлбэрт заахын тийн ялгалаар биш өгөх оршихын «-э» буюу «-дур» нөхцөлөөр захирагдан холбогдох байсан байх. Харин энэ «инару» гэдэг бол хугацааны дайвар үг учир «гаругсан» гэсэн үйл үгэнд үндсээрээ хамжин холбогдож болдог нь «сая гарсан», «хожим гарсан» «урьд гарсан» гэх мэттэй адил болно. Жич Лувсанданзанд байсан худам монгол бичгийн эх чухамхан худам монгол бичгээр байсны учраас Сухатай гэсэн үгийг «Хугадай» гэж «инару» гэхийг «ираху» гэж алдаж солисон бололтой. Лувсанданзан «Өгэлүн үжин хожид одбасу Өрбэй Хугадай ираху (янар) наругсан нь идэгэн-эчэ хожидагулбасу» гэж бичсэн нь чухамдаа уг эхэд Өгэлүн үжинийг хэн хэн ямар шалтгаанаар хожитуулсны бүрхэг хэлснийг тодруулах зорилгоор уг эхийн үгсийн байрыг сольж бичсэн гэж санамаар байна.

214. **хожидуулдажу** (хождуулдаж)—гэсэн үг нь бидний бодлоор хож- (үгийн язгуур, үйл үгийн I үндэс) +д-(үйл үгээс эс тусах үйл үг бүтээх залгавар) +уул-(үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс үүсгэх нөхцөл)+д (үйлдэгдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд энэ үг Өгэлүн

үжин Орбай Сухатай хоёрын ихсийн газар янар (хугацаанаас өмнө) гарсан гадуурхан ходдуулах үйлийн эрхэнд өртөж хохирсныг илчилсэн утгатай юм. Жич эртний монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн үйл үгийг хэрэглэх хандлага голлож байсны бас нэг баримт болно.

215. кэбэгүд-и мину йэкэ үлү болхуй-ача (хөвгүүдий минь их үл болхоос)-гэсэн эдгээр үсгийн утгыг Қозин (14, 88) «хөвүүдийг минь том болж өсч чадахгүй гэж бодоод» гэж, Хэниш «Харин хөвгүүдийг минь нэгэн цагт том болно гэж та нар айхгүйгээс» (15, 12) гэж, Пеллио «бас түүний (ө. х. Есүгэй баатрын) көвгүүдийг бага байна» гэж (9, 132), Мостарт «хөвгүүдийг минь өсч том болоогүй учраас» (47, 300 [16]) гэж тус тус орчуулснаас миний санахад Қозины орчуулга ойр болжээ. Элдэндэй Ардажав нар «болхуй-ача» гэсэн үгийг тийн ялгалыг эндүүрсэн гэж үзэж «болохуй-дур» (8, 136) гэж тайлбарлажээ. «Хөвгүүдийг минь их үл болхуй-гаас» гэсэн иймэрхүү хэлбэр Нууц товчооны өөр зүйлд дайралдаж байгаагаас үзвэл «хөвгүүдий минь их болохгүй юм шиг» гэсэн басах утгыг илэрхийлж байгаа бололтой бөгөөд өгүүлбэрийн ийм найруулга бол сонгодог бичгийн хэлэнд үзэгдэхээ больсон хэлбэр, «МНТ»-ы онцгой өвөрмөц хэллэг гэж болно.

216. йэкэс-үн кэсик-эчэ—гэсэн энэ үг, бидний бодлоор, кэси-хувилан түгээх өглөг гэсэн утгатай үгийн язгуур, үйл үгийн үндэс) +к (үйл үгээс нэр үг бүтэх дагавар) -эчэ (нэр үгийн гарахын тийн ялгалын нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж үзнэ. Энэ үгийн утгын талаар Элдэндэй Ардажав (8, 136—137) Мостарт (47, 306 [22]) нар зөв зүйтэй тайлбарлажээ. Гэвч кэсик буюу ээлж хувь гэсэн үгийг нөгөө кэсэк (хэсэг) гэсэн үгтэй хутгаж болохгүй бөгөөд Пеллиогийн тийнхүү хутгаж ташаа орчуулсныг Мостарт заасан байна.

217. билагур-ача (бялуу)р(наас)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 16), Пеллио (9, 15), Лигети (33, 33) Мостарт (47, 298 [14]), Лувсанданзан (31, I, 32), Баяр (11, I, 122) Дашцэдэн (26, 27) тэргүүтэн «билэ'үр, билэгүр, билэүр» гэх мэтээр буулгадаг нь XIV зууны галигч нарын аман аялгууны онцлогийн гажуудууллыг дагасан хэрэг юм. Бидний санавал энэ үг «билагур» буюу өнөөгийн монгол хэлний бялуу гэдэг үг мөн бөгөөд тэр цагийн тайх тавиглах ёсонд хонины ууц, хайлсан тос мэт идээгээр тавагласан идээ гэсэн утгатай үг болов уу. Хотала бялуу гэдэг бүтэн буюу ёслолын дугариг идээг нэрлэдэг билээ. Билдах (тос түрхэх) бялуурах (өөх тосонд шандах) гэх мэт үгтэй төрөл үг байж болох юм. Иймд бид «била-(элбэг дэлбэг гэсэн утгатай үгийн язгуур, үйл үг буюу эсвэл дайвар үгийн 1 үндэс) +гур (үйл үгээс нэр үг үүсгэх хуучирсан дагавар) -ача (нэрийн гарахын тийн ялгалын нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож сийрүүлсэн болно.

218. **Сархуд-ача** (сархад-аас)—гэсэн энэ үгийг хятад хадмал орчуулгад «тавигийн мах» гэж Хэниш (36, 132) тайлсанаас үзвэл илэрхий алдаатай бололтой. Үүнийг Қозин (14, 88), Хэниш (15, 1948, 12) «тавигийн (идээний) үлдэгдлээс», Пеллио «билүүдмэл чулуун (хэлбэрт амтат бялуу)-наас» (9, 132), Мостарт «тавигийн илүүдлээс» (47, 307, [23] гэж орчуулан, Элдэндэй Ардажав нар энэ үгийг түрэг хэлний «саркыт»-аас ирэл (гарал)тэй үг» (8, 137—138), «утга нь доордос буюу бүсгүйчүүдэд өгөх үлдвэр хоол умдыг өгүүлэх» үг гэх мэтээр хятад хадмал орчуулгын дагуу тайлбарлахыг оролдож «билэгүр» гэсэн монгол үг сархуд гэсэн түрэг үг-ийм хоёр адил утгатай үгийг хослуулж хэрэглэсэн гээд энэ сархуд гэдэг үг нь хожим анхны утгаа алдаж өөр юмны нэр болсон гэжээ.

Бидний санавал «сархуд» гэдэг үг «архи» гэдэг үг гаднаас орж ирээгүй байхад монголчуудын тараг цагаагаар нэрж гаргадаг агсан шимийн архийг нэрлэдэг «сархуд» гэдэг монгол үг байсан гэлтэй. Архи гэдэг үг орж ирснээс хойш заншил ёслолд хуучин монгол нэрээ «архины хүндэтгэл» (12, 811б) гэж Шагж гуайн тайлсан чилэн хүндэтгэлийн нэр болсон бололтой. «Сархуд» гэсэн нь монгол хэлэнд үгийн эгшиг уруулаар зохицох ёс гараагүй үед бичигт орсон нь түүний бичлэгээс илэрхий бөгөөд хожим «сархад» гэж дан хэлээр зохицон эгшиг нь ижилсэжээ.

Жич энд кэсик-эчэ, билагур-ача, сархуд-ача гэх мэтээр тийн ялгалын нөхцөлийг давтан хэрэглэсэн нь сонирхолтой бөгөөд хожмын монгол хэлэнд өгүүлбэрийн зэрэгцсэн олон гишүүний эцсийн үгэнд нөхцөлийг залгадаг ёс гараагүй эрт үеийн монгол хэлний нэг онцлогийг харуулж байгаа мэт. Жич «Билагур» «сархуд» гэсэн хоёр үг Элдэндэй Ардажав нарын тайлбарласан шиг монгол түрэг үг хоршоо үгийн журмаар («цэрэг цуух» гэдэг шиг) хэрэглээгүйг харуулж байна. Дашрамд хэлэхэд XIV з. үед Нууц товчооны хятад хадмал орчуулгыг хийсэн хүн нь түрэг хэлтэн хүн байсан болов уу гэж санагдуулмаар. Монгол хэлний үг, монгол түрэг хэлний дундын өдий төдий үгийг түрэг хэлний

үгийн үүднээс утгыг тайлсан нь баримттай юм. Иймд Өвөр Монголын эрдэмтэн багш Баяр гуайн «Баруун орны балга хотын хүн» (11, I, 42) «Цагааныг Нууц товчооны утгын орчуулагч болохоор барахгүй бас авианы орчуулагч ч мөн» (1, 11, 44—45) гэж үзсэн нь үндэстэй бөгөөд зөв санал болов уу гэж санагдаж байна.

219. Үжэгэд идэхүй (үзээд идэх)—гэсэн энэ үгийг Хэниш «Та нар намайг үзсээр байж хоол идэх болон нүүж зайлахдаа» (15, 12), Қозин «харуулж нүдэн дээр идэх» (14, 88), Пеллио «идэр-э одохдоо сэрүүлэхгүй нүүх» (9, 133), Мостарт «нүдэн дор (дээр) та идэх» (47, 307 [23]) гэж тус тус орчуулсан мэт байх тул Қозин, Мостарт хоёроос бусад нь энэ үгийн утгыг сайн гаргаж чадаагүй бололтой. Харин Дамдинсүрэн «нүд үзсээр үл өгөх» (7, 42) гэж, Дугаржав нар «Нүд үзсээр байгаад олж идэхгүй болов» (24, 22), Мансан «Танус нүд үзтэл үл өгөх» (27, 43), Элдэндэй Ардажав нар «үзэж байтал идэх, үзүүлж байгаад идэх» (8, 138) гэх зэргээр хөрвүүлсэн нь ерөнхийдөө зөв болжээ. Лувсанданзан «үзээд одох» гэж сэргээсэн нь уг худам монгол бичгийн эхэд «итчү» гэсэн үг байгаад андуурагдсан хэрэг болов уу гэмээр. Бид энэ үгийг «үзүүлж байгаад өгөлгүй идэх» гэсэн утгатай мэргэн үгийн эхний мөр гэж үзсэн болно.

220. Үлү сэрэгүлүн нэгүкүн (Үл сэрүүлэн нүүхүй)—гэсэн энэ үгийг Хэниш «Та нар намайг үзсээр байж хоолонд явах, хөдөлж зайлахдаа намайг сэрүүлэлгүй хийдэг болох нь уу?» гэж, Қозин «сэрүүлэлгүй нүүн одож чадах хүмүүс та нар», Пеллио «үзтэл, идэрээ одохдоо та нар намайг сэрүүлэхгүй нүүхийг хүссэн биз ээ» (9, 133), Мостарт «бууцнаас босохдоо сэрээхгүй» (47, 307 [23]) гэж тус тус орчуулсан бололтой. Элдэндэй Ардажав нар энэ үгийг «унтаж байхад дуудахгүйгээр нүүх, орхин нүүх» гэж тайлбарлажээ (8, 138). Дамдинсүрэн «Нүүхдээ үл хэлэх болов» (7, 42) гэжээ.

Бид үүнийг «Үзээд идэх
Үл сэрүүлэн нүүх»

гэсэн мэргэн буюу зүйр цэцэн үг гэж бодох тул түүний илтгэх далд санааг нүд үзүүрлэх, гадуурхан ялгах гэсэн утгатай үг гэж бодож байна. «Нэгүкүн» гэдэг нь «нэгүхүй» гэдэг үйлт нэрийн олон тоо заасан хэлбэр бөгөөд Орбай Сухатай хоёр хүнд холбогдох тул түүнтэй тоогоор зохицож, үйл үг нь олон тоотой бичигдсэн гэж үзнэ.

221. Арга-ача (аргаас) — гэсэн энэ үгийг Қозин «үгссэн ёсоор» (14, 33) гэж, Хэниш «удтал зөвлөлдсөн ёсоор» (15, 12), Пеллио «ажаамуу» (9, 133) гэж, Мостарт (дараах маягаар хөдлөх нь) «илүү сайн» (47, 307 [23]) гэж, Рахевильз «Та нарт илүү сайн төлөвлөгөө бол» (49, 133) Кливз Мостартын адилаар, Дамдинсүрэн «аргацаан» (7, 42) гэж тус тус орчуулжээ. Бид сүүлчийн орчуулгыг илүү зөв болсон гэж үзэж байна. Учир нь энэ үгийн гарахын тийн ялгалын оронд орчин цагийн монгол хэлэнд үйлдэхийн тийн ялгалын нөхцөл залгаж хэлэлцэх болсон тул энэ нь «аргаар» гэсэн утгатай үг байжээ. «МҤНТ»-ы 166 дугаар зүйлд «Тогорил өгүлэрүн: Арга-ача одчу Тэмүжин-у улс ину абуй-а» гэж хэлсний дотор энэ үг ямар нэг «аргаар» (аргацаан) улсыг нь эзэлж авъя гэсэн санал бололтой. Бас 208 дугаар зүйлд арга-ача ан (тэдэн)-д зорьж» гэж байгаагаас ямар нэг арга залиар гэсэн утгатай нь тодорхой байна.

222. Манагарши (маргааш)—гэсэн энэ үг нэгд «маргааш» гэсэн утгаар энд хэрэглэгдсэнийг тэмдэглэе. Хожимын монол хэлэнд на авиа нь сугарч, -р, -га авиа нь солигдон «ма [-на]ргаши» гэсэн өөр дуудлагатай болжээ.

223. Таргутай (хүний хоч буюу эсвэл овгийн нэр)—гэсэн энэ үгийг Хэниш (36, 182) «Таргубай» гэсэн нь алдаа болов уу. Учир нь Пеллио, Баяр (11, I, 126), Лигети (33, 34, Рахевильз (25, 27), Дашцэдэн (26 27), цөм «Тархудай Таргудай» гэж сэргээсэн тул бид Таргудай гэж сийрүүлэв. Нууц товчооны өөр (149§) зүйлд «Морилаж үлү чидаху Таргудай-йи барижу тэргэн-дур унугулжу» гэсэн үг байгаагаас бид «Таргудай» гэдэг нь хэтэрхий тарган учраас олсон хоч гэж мэддэг билээ.

224. Кэрэлдүг (хүний хоч нэр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 179а), Пеллио (9, 15), Мостарт (47, 298 [14]) тэргүүтэн цөм «Кирилтүк» гэж сэргээн бичдэг боловч бид үүнийг Кэрэ (харилцан эсрэг хэлэлцэхээр бэлтгэх гэсэн утгатай үгийн язгуур, үйл үгийн I үндэс) +лд (үйл үгийн эсрэг үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +г (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг гэж бодож ийнхүү буулгав. Хэрэв Нууц товчооны энэ үгийн утгыг Рашид-ад-Дины тайлбарласан шиг «харамч кирэг» «атаархаг» (4, 1, 1, 183) гэсэн утгатай үг байсан бол «кирилтүк» гэсэн галиг нь буруу юм. Учир нь кири+л+туг гэсэн бүтэцтэй үг байж таарахгүй. Харин «кириг» (харамч

гэсэн утгатай үгийн язгуур, нэрийн I үндэс) +лиг (нэр үгээс чанар шинж тэмдэглэх дагавар) гэсэн бүтэцтэй үг байж ганц боломжтой тул энэ нэрийн утгыг харамч «кирэг>кирик» гэсэн үгнээс үүсэгүй нь ил байна. Иймээс Кэрэлдуг хэрэлддэг хэрүүлч) гэсэн үг байсан гэж бодох үндэстэй.

225. гэжү нэгүгдэрүн (гээж нүүгдэрүн)—гэсэн эл хоёр үйл үг нөхцөл үйлийн нөхцөлөөр буюу найрах аргаар холбогдож бараг нийлмэл нэг үг шиг хэрэглэгдсэн атал Өгэлүн үжин, экэс, хөвгүүд гэсэн гурван үг «гээж» гэсэн тусах үйл үгэнд заахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдон шууд тусагдахууны журмаар захирагдсаны гадна «нүүгдрүүн» гэсэн эс тусах II үйл үгэнд утгаараа «Чарахай өвгөн» гэсэн үгийн хамт энэ өгүүлбэрийн ерөнхий эзэн бие буюу өгүүлэгдэхүүний хувиар бас холбогдсон нь сонирхолтой бөгөөд олонтаа тохиолдох тул эртний монгол бичгийн найруулгын нэг гойд ялгаатай арга хэрэглүүр мөн гэдгийг тэмдэглэе.

226. нидуралуга (тасарлаа)—гэсэн энэ үгийн хятад хадмал орчуулгын (36, 116) «хатсан» гэсэн утгыг дагуулж Хэниш (15, 14), Пеллио (9, 134) Рахевильз (49, 1979, 134), Кливз (42, 20), Поуха (17, 28), Калужинский (61, 45) цөм «хатлаа» гэж, Дамдинсүрэн (7, 49), Дугаржав нар (24, 23), Мансан (27, 44), Дорнотив (68, 25), Элдэндэй Ардажав (8, 140—141) нар «ширгэж» гэж тус тус ойлгож орчуулдаг буюу тайлбарладаг боловч бид энэ үгийг «тасарлаа» гэсэн утгатай гэж урьд (1976 онд) нэг өгүүлэлдээ тайлбарласан (10, 142—146) билээ.

227. Чабаралуг-а (хагарлаа))— гэсэн энэ үгийн хятад галиг үсгийг Хэниш (36, 25), Элдэндэй Ардажав (8, 140), Дашцэдэн (26, 27) нар тэргүүтэн зарим нь «ча'уралуга чугуралуга» (цуурлаа) гэж нөгөө Пеллио (9, 15), Баяр (11, I, 127), Иринчин (28, 45) Лигети (33, 34), Рахевильз (25, 28) тэргүүтэн зарим нь «чэ'үрэлүгэ» гэж тус тус галиглаад, Хэниш (15, 13), Пеллио (7, 134), Рахевильз (47, 1971, 134), Кливз (42, 20), Поуха (17, 28), Калужинский (61, 45), Дамдинсүрэн (7, 42), Дугаржав (24, 23) тэргүүтэн олон судлагчид үүнийг «бутарсан» «хагарсан» гэсэн утгатайгаар, харин Мансан «сүйрэв» (27, 44), Элдэндэй Ардажав «цоолж нүхэлсэн» (8, 142, тайлбар № 12) гэж элдвээр орчуулж тайлбарлажээ.

Урьд бид энэ үгийг «цуурлаа» гэсэн утгатай гэж ойлгож тайлбарласан (10, 142—146) юм. Гэвч энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «чугураху» (12, 785) тул төдий л сайн нийцэхгүй байв. Энэ удаа бид энэ үгийг «чабаралуга» гэсэн үгийг XIV зууны галиглагчид үгийн дунд суларсан «б» авиаг «у» авиагаар сонстоод «ча'уралуга» «чавуралуга» гэж гуйвуулан бууруу галигласнаас ийм ойлгодохгүй, бас «хагарах» гэсэн утгадаа ч нийцэхгүй үг болсон болов уу гэж таамаглаж «чабаралуг-а» гэж галиглав. Чаба (ан цав гэсэн утгатай нэр үгийн язгуур, I үндэс) +ра (нэр үгээс үйл үг бүтээх дагавар, «цавтай болох» гэсэн утгатай үйл үг бүтжээ) +луг-а (үйл үгийн өнгөрсөн цагийг илтгэх нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бололтой гэж таамаглав.

228. хурийагдагсан (хураагдсан) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио (9, 15), Рахевильз (25, 28), Лигети (33, 34), Баяр (11, I, 129) нар «гурийагдагсан», Баяр, Элдэндэй Ардажав нар (8, 142), Иринчин (28, 45) болон Дамдинсүрэн (7, 43), Мансан (27, 42), Дугаржав (24, 23) тэргүүтэн монгол судлагчид «хурийагдагсан» гэж сийрүүлэн сэргээдэг юм. Тэмдэглэлтэй нь сүүлчийн гурван судлагчид цөм «хурийагсан» гэж тусах үйл үгээр орчуулсан буюу буулгасан явдал юм. Эртний худам монгол бичгийн үг хэлэнд үйлдэгдэх хэвийн дагавартай үйл, үйлдэх хэвийн дагаварт үгээс дутуугүй өргөн хэрэглэгдэж байсны нэг баримтын хувьд сонирхолтой юм.

229. ничугаба (няцааб-буцаав) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 1962, 80), Пеллио (9, 16), Рахевильз, Лигети, Дашцэдэн (26, 28), Баяр (11, I, 130), Элдэндэй Ардажав (8, 142) Иринчин тэргүүтэн цөм «ичугаба» гэж сэргээн босгож сийрүүлдэг боловч энэ үг бол «ничугаба» гэсэн үгийн эхний «н» авиа «и», «э» авиатай сэлгэсэн хувилбар гэж үзэж ийнхүү сэргээн сийрүүлэв. Энэ үгийн утгыг Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз тэргүүтэн «эргүүлж дагуулж авчирсан» гэж, Дамдинсүрэн Дугаржав Мансан Элдэндэй Ардажав (8, 144) нар «буцааж, няцааж» гэх зэргээр цөм зөв орчуулжээ. Бид энд «ичугаба» гэсэн нь «ничугаба» гэсэн үгийн эхний и н авиа сэлгэдэг тохиолдлын нэг гэж үзэж худам монгол бичгээр ийм байсан болов уу гэж бичив.

230. гохойитол-а (гоохойтол)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Пеллио «горайитала» (9, 16) гэж, Лигети, Дашцэдэн, Рахевильз, Баяр (11, I, 132), Иринчин (28, 46), Элдэндэй Ардажав нар (8, 144), Мансан (27, 45) нар «ухитал-а» гэж, үүнийг Лувсанданзан «өрэйитэлэ» гэж бичээд ямар үг болохыг ойлгосонгүй орхижээ. Хэниш (15, 13), Пеллио (9, 134), Рахевильз (49, 1971, 134) нар «дарж бат суурилуулж. духдуулж», Поуха «уяж бичилж» гэх зэргээр орчуулж Дамдинсүрэн

«оёдолт дээлийг огшоон бүсэлж» гэж энэ үгийг алгасан орхиж орчуулжээ. Элдэндэй Ардажав нар үс гэзгээ эм хүний янзаар гөрж самнах» (8, 145), Мансан «гэзгээ дээш огитал-а ороож үс богтлох гэсэн үг бөгөөд бэр богтлох гэдэг нь энэ үсийг эвхэн богтлохоос гаралтай (27, 65., II бүлгийн тайлбар № 4) гэж, «Оготор болтол богтлон бүсэлж», (27, 24) гэх зэргээр хэлснээс үзвэл хамгийн ихээр үнэнд ойртуулж тайлбарласан нь Мансан бололтой. Гэвч огитала (дээшэ) гэж ухаарсан нь бас ч бүрэн бус. Бид энэ үгийг «гохойитал-а» (гоохойтол) гэсэн үг гэж ийнхүү сэргээн сийрүүлээд үсээ хоёр салаа сүлжиж богтого малгайдаа хийснээс хүзүү нь урт гоохгор болдгийг хэлсэн гэж таамаглав. Бидний бодоход энэ үг «горзгор» нарийн бөгөөд өндөрхөн юм» (53, 151) «гозгор» (53, 148а) гэх мэт үгтэй үндэс язгуур нэгтэй гэж бодно. Бас морины дэлийг «гуухайтал» засах гэдэг бол энэ үгийн өөр у дуудлагатай хувилбар мөн бөгөөд эмэгтэйн үсийг шуухын адил морины дэлийг хайчилж хүзүүг урт нарийн гоёмсог харагдуулах гэсэн утгатай үг мэт сэтгэгдэнэм.

231. богта(га) лажу (богтаг малгай өмсөх)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «Бохталаху» [бохтахлаху?] гэж сийрүүлээд «толгой самнах» гэж хадмал хятад үгийн орчуулгыг тайлжээ. Мостарт гуай нэг өгүүлэлдээ (69, 143—144) энэ «Богтого» гэдэг үгийн тухай тайлбарласан байдаг. Бид энд «богталах» охиныг бэр буулгах яриа биш, харин богтоглох тухай яриа гэж бодож үүнийг ийнхүү «богта(га)лаху» гэж сэргээгээд Мостарт авгай болон Мансангийн өмнөх тайлбарт хэлсний дагуу ухаарч байгаагаа тайлбарлав. Өөрөөр хэлбэл [хүзүүгээ] гоохойтол [үсээ шууж] богтоглож Богтага малгайдаа хийж гэсэн утгатай үг гэж бодном.

232. гожийитал-а (гожийтал бүсэлж)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 1962, 65), Пеллио (9, 16), Дашцэдэн (26, 28) нар «гожитала хожитал-а» гэж, Рахевильз (25, 28), Лигети (33, 34) hоожитал-а» гэж, Баяр (11, I, 132, Иринчин (28, 46) нар «ожитал-а» гэж тус тус сэргээн сийрүүлсэн байна. Үүний утгыг Хэниш «богинохон уяж бүсэлж?» гэж (15, 13), Пеллио «хүрмээ богино [хөөргөн] бүсэлж» (9, 134), Рахевильз «бүсээ жавхайтал уяж» (49, 1971, 134), Кливз «(Хормойгоо шуусан шигээ) бүсэлж» (42, 21) гэх зэргээр орчуулжээ. Дамдинсүрэн «оготор хормойг шуун бүсэлж» гэж (7, 43), Элдэндэй Ардажав нар хорчины аялгууны ожитол (охор бяцхан) гэсэн үгтэй холбож дээлээ ожитол (оодойлгож?) бүслэх гэжээ. Мансан «энгэрээ агсан бүсэлж» (27, 45) гэж ойлгон сийрүүлсэн байна.

Бидний бодвол энэ үг угтаа «гожийтал-а» гэдэг үг байсныг XIV зууны галиглагчид «хожитала» гэж буруу гуйвуулж галигласан учир тайлбарлахад бэрхтэй үг болжээ. Гожийтол бүслэв гэвэл оготойлгож (богино болгож) хөөргөн бүслэх гэсэн үг биш, харин гожитал нарийхан болгож бүслэх гэсэн утгатай. Ийм утгатай болох нь «нядуртал-а бүсэлэжү» гэсэн үгийн тайлбараас давхар батлагдах мэт санагдана.

233. өгэ-д-э уру -д-а (өөд уруудаа) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 82) «о'эдэ ирада» гэж, Пеллио (9, 16), Лигети (33, 34), Баяр (11, I, 132), Иринчин (28, 46) нар цөм «ө'эдэ ирада» буюу эсвэл хуучин (сонгомол) монгол бичгийн маягаар «өгэдэ ирада» гэж сэргээгээд утгыг нь Хэниш хятад хадмал орчуулгын дагуу «мөрний өөд уруу» гэж тайлж тэр ёсоор (15, 13), Пеллио (9, 134), Рахевильз (49, 1971, 134), Кливз (42, 21), Поуха (17, 28), Калужинский (61, 46) «Онон голын өөд уруу» гэж, Дамдинсүрэн (7, 43) Онон мөрнийг «өгсүжү уругудажу», Мансан (27, 45) Дугаржав (24, 24) цөм «өөд уруу гүйж» гэж орчуулсан юм. Гагцхүү Элдэндэй Ардажав нар «ирэдэ» гэдэг үгийг ир-ирмэг гэдэг үгээр тайлж «голын хөвөө буюу голын эргийг заав» (8, 148) гэж өөрөөр тайлбарлав.

Бид энэ үгийг өгэ- уру- гэсэн задгай үеэр төгссөн үндсэнд өгөх орших тийн ялгалын -э -а гэсэн эгшгээр бүтсэн нөхцөл залгахад хоёр эгшгийн хооронд -д гийгүүлэгч жийргэлэн оруулах журмаар өгэ-д-э уру-д-а гэсэн дайвар үгс үүссэн гэж үзэж ийнхүү сийрүүлэв. Өгэ гэдэг үндэс нь хожим эгшгийн хоорондоос г гийгүүлэгч сугарах журмаар, нөгөө уру-гэдэг үндэс нь задгай үе уртаар дуудагдах журмаар хожим урт эгшигтэй болжээ. Уру-гэдэг үг худам монгол бичигт богино эгшигтэй бичигдсэн нь галигчийн галиглуулагчийн аялгад балархай эгшгээр хэлэгдсэн учир уру-гэснийг галигч ира-гэж соносч буруу тэмдэглэсэн болов уу гэж таамаглаж байна. Учир нь эртний монгол хэлэнд урт эгшиггүй байснаас өргөлтгүй үеийн богино эгшиг төдий бус бас үгийн эхний эгшиг ч балархайшиж орхигдсон баримт умартаху мартаху гэх мэт олон байдаг.

234. олирсун (аньс) — гэсэн энэ үгийг галиг үсгээс нь Хэниш (36, 123), Баяр (11, I, 133), Дашцэдэн (26, 28) нар «Олирсун» гэж, Пеллио (9, 16), Рахевильз (25, 24), Лигети (33, 35), Иринчин (28, 46), Элдэндэй Ардажав (8, 144) нар «өлирсун» гэж тус тус сэргээн сийрүүлсэн юм.

Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаас нь Хэниш «зэрлэг лийрийн мод, лийр жимс» (36, 123) гэж тайлаад орчуулахдаа Хэниш «тэс» (15, 13), Пеллио (9, 134) Рахевильз (49, 1971, 135) «алим» гэж, Поуха «жимс» (17, 29), Калужинский «элдэв жимсгэнэ» (61, 46) гэж орчуулаад үүнийг Палладий «зэрлэг алим» гэж тайлбарласныг заав. (61, 191) Элдэндэй Ардажав (8, 148), Иринчин (28, 46), Мансан (27, 45), Дугаржав нар (24, 24) «өрил» (өрөл) гэж тус тус ойлгож орчуулсан байна. Харин Дамдинсүрэн гуай «олирсу» (7, 43) гэж энэ үгээр ямар жимсийг нэрлэж байгаа нь монгол хүн бүхэнд илэрхий гэж бодоод орчуулалгүй хэвээр бичжээ.

Бид энэ үгийг «өлирсүн» гэж XIV зууны галиглагчид тэр үеийнхээ нутгийн аялгууны дуудлагаар гуйвуулан галигласны учраас энэ үгийг өрөл зэрэгтэй хутгаж олон янзаар буруугаар орчуулсан гэж бодож «олирсун» гэсэн нь «алирс аньс» (70, 36а) гэж нэрлэгдэж байгаа жимсний нэрийн эртний худам монгол бичигт бичигдэж байсан хэлбэр мөн гэж үзэж «алирсун» гэж сэргээн бичихдээ бас манай улсын нэр томьёог ч харгалзав (71, 102).

235. тэ(м)гүжү (түүж, төнхөх)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 148), Лигети (33, 35), «тэнггүжү» гэж, Пеллио, Рахевильз, Баяр, Иринчин, Элдэндэй Ардажав тэргүүтэн зарим нь «тэмкүжү» гэж Дашцэдэн, Дамдинсүрэн, Мансан, Дугаржав цөм «тэгүжү» гэж сэргээсэн ба ингэж ойлгон орчуулснаас гадна «Нууц товчооны» худам монгол бичгийн эхтэй байсан гэж бидний боддог Лувсанданзан энэ үгийг «тэгүжү» гэж бичсэн, бас үгийн утга нь аньс мойлыг төнхөж авдаггүй, түүж авдаг тул «тэ (м) гүжү» гэж м үсгийг хасаж бичих нь зөв гэж бодож байна.

236. сүлдэр тэй (сүлдэртэй)— гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь судлагчид их төлөв (сөлсутэй) (зоригтой) гэсэн утгаар ойлгосон байх боловч ганцхан Лувсанданзан «сүлдэр тэй» (31, I 34) гэж, Дамдинсүрэн «чадалтай» (7, 43) гэж буулгаж сийрүүлсэн нь утгын хувьд илүү тохиромжтой тул бид энэ цөөнхийн саналыг сонгож ийнхүү бүүлгав. Учир нь «сөлсүтэй» гэдэг үг уур омогтой гэсэн үгээр хэрэглэгдсэн байх тул Өгэлүн үжинд төдий л нийцэмгүй тодотгол юм. «Сүлдэртэй» гэдэг нь биеийн тэнхээ чадал, цог жавхлантай гэсэн утгатай тул утгын үүднээс илүү тохирох мэт бөгөөд энэ үг ийм утгатай нь «Нууц товчооны» 249 дүгээр зүйлд гарч буй «сүлдэртү» гэдэг үгийн утга Хэнишийн тольд (36. 137) бүртгэгдсэн Хятад хадмал орчуулгын тайлбараас мэдэгдэж буй. Хэниш энэ үгийг «сүр жавхлан, алдар» гэж германаар орчуулсан байдаг.

237. чигарсун (чаргас) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс Пеллио, Баяр 11, I, 134), Лувсанданзан (31, I, 34) тэргүүтэн цөм чигүрсүн» гэж, ганц Хэниш «чигорсун» (36, 1962, 27) гэж сэргээгээд хятад хадмал орчуулгад «сүпрэссэ» гэдэг үг оноож тайлсан боловч энэ үгийг герман хэлэнд орчуулахдаа «арц модон цуудас» (15, 13) гэжээ. Пеллио, Рахевильз, Кливз тэргүүтэн булт Хэнишийг дагаж «арцны залтас» гэх мэтээр орчуулсан бол монгол судлагчид Элдэндэй Ардажав нарын тайлбар (8, 149—150) «чигурсун», «майилсу», «чагласун» гэсэн гурван өөр мод гэж өөр өөр нэр толь бичигт байдгийг дурдсан бөгөөд Дугаржав энэ үгэнд «Жагугасу-саранын үндэс (24, 25) гэсэн тайлбар хийжээ. Дамдинсүрэн (7, 42), Мансан (27, 45) «царс» гэж орчуулжээ.

Бид энэ үгийг XIV зууны галиглагчид «чигүрсүн» гэж тэр үеийн аялгуу дуудлагаараа буруу галигласан боловч Хэниш гуай «чигорсун» гэж худам монгол бичгийн бичлэгт нь ойртуулж сэргээсэн болов уу гэж санана. «Чигарсун» гэдэг үг авиа сэлгэж хувирч чиргасун<чаргас [у]<чаргай мод гэгдэх болсон болов уу гэж таамаглаж байна. Нууц товчоог XIV зууны үед галиглагчид олон эр үгийг эм үг болгон галигласан удаа олон байх тул чиргасун гэдгийг уруулаар зохицсон аялгадаа оруулан «чигүрсүн» гэж гуйвуулж галигласнаар барахгүй таван хэлний толь бичигт (72, III, 4022) «чиркүсү» гэж бүртгэгдсэн байгаа гэр өө, үү голлох аялгууны нөлөө хойшид сүүлийн үе хүртэл үргэлжилснийг гэрчилж байна. Чигарсун чигурсун чигүрсү чиркүсү гэх зарим үе нь тонгорч чигарсун нь чиркүсү болсон болов уу.

Нөгөө талаар чигарсун нь чигурсан чигусун чиргусун чиргасу чиргай гэх мэтээр хувиссан гэж бодох үндэстэй мэт.

Учир нь энэ үг «модны шудурга өндөр бөгөөд ягц (нягт) ургасныг» (53, 815а) чаргай гэдэг гэж тайлжээ. Нууц товчооны өөр (245§) зүйлд «чигуд нарад мэтү дүү нэр» гэж гардаг нь нарс чигарсун (эсвэл чаргай?) модны олон тооны хэлбэр тул Чингис хааны тэрсхэн өсч том болсон дүү нарыг ойд өндөр бөгөөд ягц (нягт) ургасан эдгээр модтой зүйрлэсэн санаа биз.

328. сөдү[гэ]н-[э] (сөд өвс) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш, Мансан нар «судун» гэж, Пеллио, Рахевильз, Лигети тэргүүтэн «сүдүн» гэж сийрүүлж Пеллио «Улаан тэс» (9, 134), «улаан үндэс» (Рахевильз) гэх зэргээр орчуулдаг. Хэниш хятад хадмал орчуулгыг «нэг зүйл өвс

ногооны үндэс» (15, 136) гэж тайлжээ. Дамдинсүрэн, Баяр, Иринчин, Дугаржав, Элдэндэй Ардажав тэргүүтэн монгол судлагч нар их төлөв «сөдүн» гэж бичээд онц их тайлбаргүй ойлгогдох үгийн ёсоор тайлбаргүй бичжээ. Харин Элдэндэй Ардажав нар Рашид-ад-Дин Д'Оссон нарыг зааж «сөдүсүн» гэдэг гэсэн ба буриад хэлний толиос «улаан үндэс, хүнчил гэнэ» гэсэн нь төдий л үнэмшилтэй биш юм. Учир нь Хүнчил гэдэг «эмд хэрэглэх маш гашуун хортой үр» (53, 747) гэж тайлбарласан байх тул хүний иддэг үндэсний нэр биш баймаар. Бид энэ үгийг одоогийн халхчуудын хүүхдийн биж өвчний ерөндөг гэж буцалгаж өгдөг хүрэн ягаан түрүүтэй нэг зүйл өвсөн, ургамлын нэр (53, 489а) мөн болов уу гэж бодож байна

239. Гичигина (гичгэнэ)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио (24, 16), Хэниш (36, 27), Баяр, Мансан цөм «чичигина» гэж сэргээсэн нь үзтэл XIV зууны галиглагч нарын дуудлагын гажуудал гэж үзэв. Бидний бодвол Дамдинсүрэн, Дугаржав нарын буулгаснаар «гичигина» гэдэг нь зөв шиг байна. Энэ үгийн хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «иддэг ногооны үндэс» гэж тайлаад орчуулалгүй бичсэн, зарим нь «хуваагдан үржих булцуу» (Пеллио), «улаан булцуут үндэс» (Рахевильз) гэхчлэн орчуулдаг бол Элдэндэй, Ардажав «чичигина» гэдэг нь «гичигина» (гичгэнэ)-гэж, Я. Цэвэлийн (53, 145а) дурдсан тайлбарыг заав. Монгол Алтайд гичгэнийн нуруу гэдэг нэртэй уул ч байдаг. Энэ учраас Ц. Дамдинсүрэн (7, 43), Дугаржав (24, 24) гичигэнэ, гичэгэнэ-гэж бичсэн нь зөв боловч гичигина гэж бичсэн Я. Цэвэлийн бичлэгийг илүү зөв гэж ийнхүү буулгав.

240. Хөбэгүд хад (хөвгүүд хад-хаад)— гэснийг «хад» гэдэг нь хан (үгийн язгуур, нар үндэс) +д (нэр үгийн олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн бөгөөд олны нөхцөлийг залгахад «н» нь орхигдсон гэдгийг тэмдэглэхийн хамт «көбэгүд» гэсэн нэр үгтэйгээ тооны талаар зохицолтой байгаа нь худам монгол бичигт байсан нэг онцлог бөгөөд хуучин монгол бичигт энэ онцлог алга болжээ.

241. Чибагас-ийар (чавгасаар)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс зарим судлагч «жа'ухасу-бар» (Пеллио, Рахевильз, Лигети, Баяр) (11, I, 136). Хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «Уулын (зэрлэг) идэшний ногооны улаан үндэс» (36, 87) гэснийг баримтлан зарим нь «сарана (төмс) сонгино» (Пеллио) гэх чилэн орчуулдаг байна. Элдэндэй Ардажав (8, 151) нар «жагугус жигасу» болсон гээд дагуур аялгууны «жоогос» «мукаддимат» толийн «чугасун-у» цэцэг гэсэн үг, Хөх нуурын урад аялгууны «саргасу» «Эрдэнийн товчийн» «жархасун» гэх мэт үгтэй уялдуулан Улаан хэлгий саранын сонгинолог эшит ургамал гэжээ. Мансан «жогуг-а» (27, 46) гэж сийрүүлээд «хайлс модны үр цэцэг» (27, 66) гэж тайлбарлав. Иринчин «чаугасу-бар» гэсэн үгээр сэргээн Лувсанданзан чадгасу гэсэн нь чаугасу гэдгийн ташаарал гэж тайлбарлажээ.

Бидний бодвол «Чибагас-ийар» гэсэн үгийг XIV зууны галиглагчид чигэснийг жа-гаар, б-авиаг у-гаар тус тус олон тооны с-ийн дараах б авиаг бас у-гаар сонсоод ийнхүү «жаугасу-бар» гэсэн үл мэдэгдэх үг болоо болов уу гэж таамаглан «Чибагас-ийар» гэж сэргээн бичихдээ Лувсанданзан монгол эхээ барьж ча-үсгээр эхэлсэн боловч хятад галиг барьж у-авиаг да авиагаар буулгасан гэж бодно. Галиглагч нарын аялгуунд (XIV зууны үед) үгийн дундах б авиа у болсноос ийм будлиан гарсан байж магадгүйн дээр «чибагас» гэсэн үг зэрлэг жимсийг нэрлэх ерөнхий нэр байсан бололтой.

242. Гогусун (гогод)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн эхээс «Хохосун» (Пеллио, Рахевильз, Лигети, Баяр) Иринчин (28, 137), Дашцэдэн (26, 28), Баяр (11, I, 137), Элдэндэй Ардажав (8, 152) тэргүүтэн «гогосун» гэж, Дамдинсүрэн (7, 44), Дугаржав (24, 25), Мансан (27, 26) нар «гогод» гэж Лувсанданзан «гонуд» гэж тус тус сийрүүлсэн байна. Пеллио (9, 134), Хэниш (15, 13), Рахевильз (49, 1971, 135) нар гогод гэдэг үгийг зөв орчуулсан байх бөгөөд монгол судлагч нар энэ үгийн утгыг цөм зөв ухаарсан нь эргэлзээгүй. Бид харин «гогуд» гэсэн нь эртний худам монгол бичигт үгийн эхний үед О орсон бол дараах үед нь ижлээр О орохоосоо. У, эхний үед Ө орсон бол хойшид Ү үсэг голцуу бичигддэг журамтай тул ингэж бичих нь зөв гэж үзэв.

243. Хагулга [тан] хөбэгүд (зам мөрт хөвгүүд) — энэ үгийг хятад галиг үсгээс ха'улуга (Баяр, Элдэндэй Ардажав, Дашцэдэн нар) хөбэгүд» гэж Пеллио, Хэниш нар «ха'улугаст)» гэж буулгажээ. Энэ үгийг Хэниш «магтсан тэмдэг үг» (36, 64) гэж таавarласан, хадмал орчуулга байхгүй гэснийг тэмдэглээд Пеллио (11, 134), Мансан (27, 46) нар «өлсгөлөн хүүхэд» гэж, Дугаржав «гоц мэргэн» (24, 25) тус тус орчуулсан юм.

Бид энэ үгийг «хагулга т[ан] буюу зам мөртөн эсвэл довтолготон (довтлогоотон) хөбэгүд» гэсэн утгатай үг болов уу гэж таамаглаж

байна. Галиглагчид «хагулгатан» гэхийг «хагулуга т» гэж дутуу буруу тэмдэглэсэн учир хожим хадмал орчуулга хийгчид утгыг гаргаж хадмал орчуулга хийсэнгүй. Учир нь энэ хагулуга буюу «хагулга» гэдэг үг довтлон давхиж одсон хүний «мөр зам» гэсэн утгатай нь бусад зүйлээс мэдэгддэг билээ.

244. Хойилагуд (хойлохууд)— гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (15, 69) «Хойирагут» гэж галиглаад **«Эрчүүлийн нэг шинжийг магтах утгаар хэлсэн» гэжээ. Галиглагчид цөм ингэж галиглаад утгыг Хэниш «аймшиггүй» (15, 13), Пеллио орчуулж чадахгүйгээ тайлбарласан юм. Дамдинсүрэн «хутугтан» (7, 44), Дугаржав нар «хурц» (24, 25), Элдэндэй Ардажав нар «хойрго» гэдэг үг буриад аялгуунд байгаагийн утга байх ёстой гэсэн ба ордосын аялгууны «гойрох» сойгдох гэсэнтэй ч холбож бодож тайлбарлажээ. Гагцхүү Рахевильз энэ үгийг «хүндэтэй» (49, 1971, 135) гэсэн нь хамгийн ойртуулсан орчуулга шиг байна.**

Учир нь бид энэ үгийг «хойилагуд» гэж галиглаад хойгуур буюу хоймроор суух «хүндэтэн» сайцуул болов гэсэн утгатай үг гэж бодов. Үүнд бас Ун ханы хүү Сэнгүмийн Чагур бэхийг гуйхад ихэрхэж хэлсэн үгнээс ийм утгатай нь мэдэгдэж байна гэж бодно. (§ 165).

245. эрэ-күн омуг-ун (эр хүү омгийн) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь судлагчид «эрэкүн омог-ун» (36, 45) гэж бараг бүгдээр сийрүүлэн бичээд «эрэкүн» гэсэн үгийн утгыг Хэниш «эрийн шинжтэй, эрэлхэг зоригтой» (мөн тэнд) гэж тайлаад «эрэкүн омгийн» гэснийг «эр хүний ёсоор нэгэнт байж чадна гэж найдаж болох» гэсэн хятад хадмал орчуулга бийг Хэниш тайлжээ. Рахевильз «Эрийн сайн чанараас эрэлхэг аймшиггүй болж өссөн» (49, I, 135), Кливз «эрэлхэг зоригтой» (42, 21), Элдэндэй Ардажав нар энэ үгийг «эрэг-үн» гэсэн бөгөөд эрэг гэдэг түрэг хэлний «хүчирхэг чадалтай» гэсэн утгатай гэж арай ташаа гэмээр тайлбарлажээ (8, 153), Дамдинсүрэн (7, 75). Мансан (27, 46) «эрх омог төгөлдөр болж» гэж, Дугаржав «эрэлхэг омогтон болцгоов» (24, 35), Иринчин «эрэкүн омугун» гэж галиглаад эрэхүү, омогу, эрэлхэг омогт гэсэн түрэг үг гэж тайлж (28, 47) Элдэндэй Ардажав нарын адил тайлбарлажээ. Бид эр гэсэн үгэнд «хүү» гэсэн хүч нэмэгдүүлэх сул үгийн олон тооны хэлбэр «күн» гэсэн хоёр үг нийлж бүтсэн үг бөгөөд «эрэлхэг омгийн» (овгийн) гэсэн утгатай гэж таамаглав.

246. эл болдаба (эл болгогдов)—гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио, Рахевильз, Лигети, Элдэндэй Ардажав нар «элэ»гэж, Хэниш «эл» гэж хоёр янзаар сэргээн сийрүүлж Хэниш энэ үгийн утгыг «найрамдуу» (36, 43), Пеллио «Үнэнхүү долгин бадрангуй нандин чанартан болсон» (9, 135) гэж, Баяр «элэ» гэж буулгаад ла (сул үг) гэсэн (11, I, 138) нь арай ч үгүй л болов уу гэж эргэлзмээр. Элдэндэй Ардажав (8, 151) Дугаржав нар (24, 25), Дамдинсүрэн (7, 44), Мансан (27, 46) нар энэ үгийг орхиж орчуулжээ. Гагцхүү Хэниш «эл» гэж сийрүүлж «найрамдуу» гэж оновчтой тайлсан болович орчуулсан гүй.

Бидний санавал энэ үг «эрэлхэг омог-ун (овгийн) найрамдалтан (холбоотон) болгогдов» гэсэн үг болов уу. Учир нь Гүюг хааны тамгын бичигт «эл (найрамдалт-Ш. Г.) булха (дайсагнагч) иргэнд (ард түмэн улсад) хүрвэл айтугай, биширтүгэй» гэсэн үг бий. Жич: эл+чин (найрамдуулагч), элсэкү (найрамдан дагах), элбэхү (найрамдан хамжих) зэрэг үгс цөм «эл-» гэсэн нэг язгуураас гарсан төрөл үгс бололлтой. «Эл» гэдэг үгийн утгыг шагж «нийлэмжтэй сайн» (12, 85б) гэж тайлсан байна.

247. гэгүги (гөхий буюу гох дэгээ) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «гэоги» (36, 43), Пеллио, Рахевильз, Лигети, Иринчин нар «гэүги» гэж, Баяр Элдэндэй, Ардажав, Мансан, Дугаржав нар цөм «гөги» гэж, Дамдинсүрэн «гох» гэх зэргээр сийрүүлж цөм загасны «дэгээ гөхий» гэж ерөнхийдөө зөв ойлгоцгоосон байна.

Бидний бодлоор эртний худам монгол бичигт үгийн эхний «о» эгшгийг «у»-гаас ялгахаас өөрөөр хоёр эгшиг үсэг дараалан бичих ёс байгаагүй тул энэ үг худам бичигт Пеллио тэргүүтний сийрүүлсэн шиг «гэүги» гэж бичигдэж байгаагүй, харин «гэгүги» гэж бичигдэж байгаа болов уу гэж бодно. Хожим «э» «ү» хоёр эгшгийн дундаас «г» нь сугарч урт эгшиг болж амжаагүй байдлаараа «гэүги» гэж бичигдэх болсноос гадна «э» «ү» хоёр эгшиг нь хэл уруулын байрлалаараа ижилсэн хувисч «ө» болоод «гөгий» гэж хэлэгдэх бичигдэх болсон байж болно гэж үзэв. Халхын аялгуунд сүүлчийн «ги» буюу «ки» гэсэн үе нь аажмаар «х» болж «гөхий, гох» гэсэн дуудлагатай болсон байх гэж төсөөлөн бодно. Иймд «Нууц товчооны» худам монгол бичгийн эхэд энэ үг анхны үүсгэл хэлбэрээрээ «гэгүги» гэж бичигдсэн болов уу гэж ийнхүү сийрүүлэв.

248. көлми [<чөлми] (загасны тор)—гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 51), Рахевильз (25, 29), Лигети (33, 35) Баяр

(11, I, 141), Элдэндэй Ардажав нар (8, 152), Дашцэдэн (26, 29), Иринчин (28, 47) нар цөм «чилүмэ» гэж сэргээн босгодог нь бидний санавал XIV зууны үед хятад үсгээр галиглагчдын дуудлага ба сонсголын талаар ташаарсныг дагаж давтсан алдаатай сэргээлт юм. Гагцхүү Пеллио, бодвол, «гөлми>көлми» (31, 1, 35) гэж сэргээсэн Лувсанданзаны эхийг дагаж «гөлмэ» (9, 16) гэж сэргээсэн нь энэ үгийн эртний бичлэгт ойртуулсан сэргээлт юм. Мансан орчин цагийн монгол хэлэнд «алага хаях, алага тавих, өгөөш тавих» гэсэн үгээр сольж (27, 66, тайлбар № 9) «алага то[о]р тавьж» (27, 47) гэж сэргээжээ.

Бид энэ үгийг эртний худам монгол бичигт «чилүмэ» биш, харин «көлми» буюу «чөлми» гэж бичигддэг хамах тор гэсэн утгатай үг гэж төсөөлөн бодож «көлми» гэж сэргээв. Ингэж бодох үндэс нь нэгд «нууц товчооны» худам эхтэй байсан гэгдэх Лувсанданзан «гөлми» гэж бичсэнд байна. Энэ нь худам монгол бичгийн эхэд «көлми» гэж бичигдсэн байсны гэрч биз. Хоёрт «МНТ»-ы 199 дүгээр зүйлд үүнийг **«гөлми» гэж илүү зөвөөр сийрүүлсний дээр хуучин** (сонгодог) монгол бичигт энэ үгийг «көлми» (гөлми?) (12, 480б) гэж бичдэг уламжлалтай зэрэг **гурван зүйлд тулгуурлан «көлми»** гэж сийрүүлэв. Энэ үгийн «к» авиа нь «ч» авиатай сэлгэж «чөлми» гэсэн үг гарсан байж боллох юм. Гэвч энэ үгийг **«Чилүм-э»** гэж галигласан нь ташаа юм. Учир нь энэ үгийн эхний үе **«чө»** биш **«чи-» байсан** бол энэ үгийн үндэс язгуур болох **«чөлбүкү» «чөлмүкү» (12, 790б) гэх зэрэг үгс халхын аялгуунд «цөл,** цөлбөх, цөлмөх» гэж «ц» авиа болж үлдэхгүй, харин «чөл, чөлбөх, чөлмөх» гэсэн дуудлагатай байх сан билээ. Иймд «чөлми» гэдэг үг **загасыг үлдээлгүй хаман авах, цөлмөн авах багаж** гэсэн утгатай «чөлми>көлми» гэдэг үг мөн болох нь илэрхий.

249. жирмад жигасу (жарам загас) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 90), Пеллио, Рахевильз, Дашцэдэн (26, 29) тэргүүтэн «жирамуд» гэж сэргээгээд, Дамдинсүрэн Дугаржав нар «жараахай» гэж, Элдэндэй Ардажав (8, 156) нар «жирам-уд», Баяр «жирамуд» «жарма» (11, I, 141 гэж сийрүүлэн. Мансан «агаг жарм-а», «бага загас, зулзган загас» (27, 66, II бүлгийн тайлбар № 10) гэж ухааран тайлбарласан байна.

Бидний санавал, хэрэв «жирамуд» гэсэн үг «бага загас, зулзган загас» гэсэн утгатай байсан бол «жирамуд» биш «жирагахай» (12, 510б) гэж бичигдэх байжээ. Гэтэл энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт Шагж «жарм-а» (12, 495а) загас гэж өөрөөр бичсэн байна. Иймээс эртний худам монгол бичгийн эхэд энэ үг «жирмад» гэж бичигдэх учиртай шиг санагдана. Учир нь «жирм-а» гэсэн загасны нэрд олон тооны «-уд» нөхцөл биш, харин «д» нөхцөл залгах ёстой. Иймд XIV зууны галигч нарын аман аялгуунд энэ үгийн төгсгөлийн «а» эгшиг нь балархайшин орхигдон «жир[а]м» гэж гийгүүлэгчээр төгссөн үг шиг сонстох болсон учраас олон тооны «-уд» нөхцөл ташааран залгасан бололтой. Иймээс бид «жирамуд» гэж биш, харин «жирмад» гэж сэргээв. Эхний «ж» үсгийн дараа хуучин (сонгодог) монгол бичигт «а» биш «и» байсан нь нэгд, жижиг (загас) гэсэн үгтэй нэг үндэстэй учир «жи» байсан гэж, нөгөө талаар «ж» үсгийн дараа «и» байгааг үгүй болгохын аялгуунд **«жарма»** биш «зарма» гэж дуудагдах байв. «Жирм-а» гэх нь үлэмж эртний худам монгол бичгийн анхны бичлэг мөн гэж төсөөлөн бодож сэргээв.

250. булижу абуба (булааж авав) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 22), Пеллио (9, 16), Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр (11, I, 143) цөм «булижу» гэж сэргээн босгож сийрүүлсэн байдаг. Булих «булиархаж» гэсэн энэ үйл үг мартагдсан учир оронд нь Лувсанданзан (31, I, 35), Дамдинсүрэн (7, 45), Мансан (27, 47) нар «булийажу» гэж тусах үйл үгийн шинэ хэлбэрээр бичсэн нь зөв юм. Бидний бодлоор бол «булаах» гэсэн утгатай энэ үг булих (булиагаар) хүчээр (авах гэсэн утгатай) тусах үйл үгийн I үндэс байжээ. Учир нь энэ үндсэнд «-гд» залгаж булигдаху (булаагдах) гэсэн эс тусах үйл үг бүтдэг байжээ. «Нигүлэскүй» сэтгэл үгэкү үкүл-үн эжэн-э булигдажу» (40, 49) гэсэн нь үүний баримт юм. Жич энэ үгийн үндсэнд були+йа дагавар залгаж булийа (булиа) гэсэн нэр үг үүсдэг байна. Энэ үгэнд цаашдаа бас булийаху (булаах) гэсэн үйл үгийн утга орсон учир булих гэдэг үндэс нь орхигджээ. Үүнчлэн түши+эй=түшийэ (гүн) гэдэг нэр үг гарсан нь үүнтэй нэг загвараар бүтсэн мэт санагдана.

251. йа кигүжэй (яах нь вэ) гэсэн энэ **хориглох утгатай үгийг хятад га**лиг эхээс Хэниш «йэгү'үжэ'ай» (36, 169), Пеллио, Рахевильз Лигети, Дашцэдэн, Элдэндэй Ардажав цөм Хэништэй адил сэргээдэг. **Үүний утгыг хятад хадмал орчуулгаар** Хэниш «үүнийг бүү хий!», Пеллио цэглэгтүн!» гэж, Рахевильз «Та нарыг яалтай билээ?,» (49, 1971 36), Кливз **«больцгоогтун!»** (42, 22), Элдэндэй Ардажав нар «юу хийх гэсэн юм бэ?» (8, 157, тайлбар № 4), Мансан «яах [нь] бэ!» (27, 67), Дугаржав «яасан юм бэ!», Баяр Иринчин нар «яахигүзай!» (яагуузай) гэх зэргээр янз бүрээр ойртуулж тайлбарлажээ.

Бидний бодвол йа кигүжэй гэж хоёр үгнээс бүтсэн тул худам монгол бичигт «йа кигүжэй» гэж бичих нь зөв бөгөөд «ямар нэг юм хийгүүзэй!» гэж хориглон захирсан үг гэж төсөөлж байна.

252. чичигэ (чичих юм, шилбүүр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио, Рахевильз, Лигети (33, 36), Дашцэдэн, Баяр (11, I, 144), Элдэндэй Ардажав (8, 157) Иринчин тэргүүтэн цөм л «чичу'а буюу чичуг-а» гэж сэргээн босгодог боловч энэ үгийн хадмал хятад орчуулга нь «ташуур, шилбүүр» гэсэн үг байгааг Хэниш (36, 27) зааж, Ц. Дамдинсүрэн (7, 76), Мансан, Дугаржав нар үүнийг дагаж үг үгийг «ташуур» гэсэн нь бидний бодоход зөв юм. Харин Элдэндэй Ардажав нар энэ зүйлийн 5 дугаар тайлбарт (8, 157—158) энэ үгийг түрэг хэлний чичиг, хонины сүүлийн өөх гэсэн утгаар тайлбарласан нь сонирхолтой боловч итгэх аргагүй юм.

Бид XIV зууны үед хятадаар галиглагчид «чичигэ» гэж бичээстэй байсныг «чичуг-а» гэж ташаа тэмдэглэснээс утгадаа тохирохгүй үг болжээ гэж үзэж **ийнхүү «чичигэ» гэж буулгав.** Тэгэхдээ Лувсанданзан энэ **үгийг «чүчигэ» гэж бичсэн нь эм** үг байсны баримт гэж үзэв. Хоёрт «сэгүл» гэдэг нь угаасаа **«дагуул»** нөхөрлөгч гэсэн өөр шилжсэн утгатай тул «чичигэ» гэдэг үг араатны өөдөөс чичих зэвсэг ташуур шилбүүр гэсэн утгатай байжээ. Чичи (**үйл үгийн** 1 үндэс) +гэ (**үйл** үгээс нэр үг бүтээх **дагавар) гэсэн бүтэцтэй тул дару** +га гэдэг **үгийн** загвараар бүтжээ гэж сананам.

253. гашигу [бэркэ ажу (хачи ану)] (Гашуу [бэрх байж (хачийг ану)]) — гэсэн энэ үгийг судлаачид **цөм зөв сэргээж** зөв ухаарсан боловч «гашуу» «абурахун» гэсэн хоёр үг хоорондоо утгын талаар нийлэмжгүй байгааг хэн ч анзаарсангүй. Утга зүйн үүднээс үзвэл гашуу гэдэг үг тэр цагт «өс хонзон» гэсэн утгагүй, харин «зовлон гаслан» гэсэн утгатай байсан нь 77 дугаар зүйлээс мэдэгддэг тул «гашууг авах» гэсэн холбоо үг байж боломгүй тул хоорондоос нь хэдэн үг орхигдсоноос зайлахгүй. Бодвол Лувсанданзан тэдгээр хэдэн үгийг өөрт нь байсан худам монгол бичгийн эхээс нөхөж бэрх ажу (31, I, 36) оруулсан бололтой байна. Утгын үүднээс бодвол Лувсанданзаны эхэд бас «хачи ану» гэсэн үг хаягдсан байснаас гадна «хэр» гэсэн үгийг «хэн» гэж зохиогч эндүүрсэн бололтой тул бид «хачи ану» гэсэн үг нэмж «хэн» гэдгийг орхиж сэргээв.

254. абурхун (авахуй) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс судлагчид бараг цөм «абурахун» гэж сэргээн утгыг хятад хадмал орчуулгын үгнээс Хэниш (36, 2) «Гашууны **төлөө өшөөл»** гэж орчуулсан ба «ичүүрийг **өшөөлөх»** (15, 14), Пеллио «доромжлолыг **өшөөлөх»** (9, 135), Рахевильз «гэмт хэрэг, доромжлолын **төлөө өшөөлөх»** (49, 1971 136), Поуха «муу хөнөөлийг **өшөөлөх»** (17, 30) гэж, Калужинский ч энэ үгийг «**өслөх»** (61, 46) гэж, Дамдинсүрэн (7, 45), Мансан (27, 47), Дугаржав нар «**өшөөгөө** авч чадна?» гэж **тус тус орчуулсан нь цөм зөв юм.**

Харин энэ үгийг Элдэндэй Ардажав нар (8, 158, тайлбар № 7) «абурахун» абураху -ийн олон тооны хэлбэр гэжээ. Авах аварах хоёрын алинаар ухаарч буй нь мэдэгдэхгүй.

Бидний санавал энэ үг авах (тусах үйл үг) абур- авах үйлийг үйлийн эзний биед хүлээлгэсэн эс тусах үйл үгийн үндэс бүхүй үг, -хун гэдэг нь үйлт нэрийн ирээдүй цагийн нөхцөл ба олон тоог заасан нөхцөл. Иймд энэ үгийг абура (аюулаас аврах гэсэн утгатай) гэсэн өөр үгтэй хутгаж болохгүй бөгөөд уг хятад үсэгт XIV зууны үеийн галигч нарын ташаарлаар илүү **«а»** үсэг **«р»** гийгүүлэгчийн дараа оруулснаас энэ үгтэй адил болж хутгалдсан болов уу гэж таамаглан **«абурхун» гэж сийрүүлсэн юм. Хага+р+хуй** гэдэг үгтэй адил бичих учиртай биз ээ.

255. бүтүгэй (бү хийтүгэй, **битгий хий**, болитугай) — гэсэн энэ үгийг хятад галигаас нь Хэниш **«бутугай»** (36, 24), Пеллио (9, 16) Рахевильз, Лигети, Баяр (11, 1, 145), Элдэндэй Ардажав (8, 157) Дашцэ**дэн, Иринчин цөм «бүтүгэй»** гэж сэргээн босгосон юм. Үүний утгыг Лувсанданзан «тийм бүү үйлд» (31, 1, 36) гэж зөв тайлбарласан тул бүх судлагчид цөм зөв ойлгож зөв тайлбарласан буюу орчуулсан **байна.**

Нэмж тэмдэглэхэд энэ «бү-» гэдэг хориглох үйл үг орчин цагийн монгол хэл болон хуучин монгол бичгийн хэлэнд «бүтүгэй» гэдэг үг «битэгий» буюу «битгий» гэсэн өөр дуудлагатай хориглох сул үг болж үлдсэнээс гадна «бү-» үндсээрээ бас «бүү» гэсэн хориглох сул үг болж хэрэглэгдсээр байна.

256. өчигэн (өчиг өдөр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «очиган, өчигэн» гэж сийрүүлэн босгоод хятад хадмал орчуулгын утгыг «саяхан», төдий л удаагүй» гэж тайлжээ (36, 21), Пеллио, Рахевильз, Дашцэдэн, Баяр, Иринчин (28, 48) тэргүүтэн цөм «өчигэн» гэж сэргээн, Дамдинсүрэн, Дугаржав, Мансан нар «өчүгэдүр» гэж хуучин (сонгодог) монгол бичгийн бичлэгээр (12, 163а) бичжээ.

Бид худам монгол бичигт «өчигэ(н) эдүр» гэж бичиж байсан байх

гэж таамаглаж ийнхүү сийрүүлэв. Учир нь өчигэ+эдүр гэсэн хоёр үг нийлэхдээ заагийн хоёр «э» авиа нийлж «өчигэдүр» гэж нэг үг бүтээд хожим монгол хэлэнд үгийн эгшиг уруулаар зохицох ёс гарсан үед «и» нь «ү» авиандаа ижилсэн «өчүгэдүр» гэж бичдэг болсон гэж бодно.

257. алдухун (хамт байлдах [байх]) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 5), Пеллио, Дашцэдэн, Баяр, (11, I, 146) нар тэргүүтэн цөм «алдухун» гэж зөв сийрүүлээд утгыг хятад хадмал орчуулгад хэлснийг Хэнишийн дурдсан талд «хамт амьдрах» гэж тайлсанаар ойлгож Пеллио, Рахевильз, Кливз, Дамдинсүрэн, Мансан, Дугаржав цөм яаж «хамт амьдрах» (суух, байх гэх зэргээр)гэж ойлгож зөв орчуулсан буюу тайлбарлажээ. Гагцхүү Лувсанданзан энэ үгийг алдах гэдэг үгтэй андуурсан бололтой «алдахун» (31, I, 36) гэж ташаарчээ. Бидний санавал энэ үг а (байх гэсэн утгатай үгийн тэр цагт идэвхтэй язгуур, үйл үгийн I үндэс) +лд (үйл үгийн харилцан эсрэг үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +ху (үйлт нэрийн ирээдүй цагийн нөхцөл) +н (үйлдэгчийн олонтой зохицсон олон тоот үндэс бүтээх нөхцөл) гэсэн бүтэцтэй үг болно. Энэ үйл үгийн хэв нь тэд хүүхдүүдийн эв эегүй, бие биенийн эсрэг хандсаныг тодотгож хэрэглэгдсэн нь илэрхий байна.

258. далдатчу (нуугдаж) — гэсэн энэ үгийг хятад үсгээс нь Хэниш (36, 31), Пеллио, Баяр (11, I, 147) тэргүүтэн цөм «далдатчу» гэж зөв Дашцэдэн «далдадчу» гэж үсгийн дүрмийн хувьд арай ташаа сэргээн бичжээ. Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаас Хэниш «нуугдаж» «далдтаж» гэж оновчтой орчуулсан тул Пеллио тэргүүтэн судлагчид цөм ингэж ойлгож орчуулснаас гадна Баяр, Мансан (27, 48) нар, Элдэндэй Ардажав нар (8, 163, тайлбар № 12) «далдлан» гэж, Дамдинсүрэн «нууцаар» гэж, Дугаржав «далдуур» гэж тус тус ойлгож орчуулсан буюу тайлбарлав.

Бид энэ үгийн «далдатчу» гэдэг нь эс тусах үйл үг, «далдалжу» гэдэг нь тусах үйл үг учир утгын ялгаатайг тэмдэглэе.

259. самбажу (зэхэж) — гэсэн энэ үйл үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 132) Дашцэдэн (26, 29), Баяр (11, I, 147), Иринчин (28, 48) Элдэндэй Ардажав (8, 159) нар цөм «самбажу» гэж, нөгөө Пеллио (9, 17), Рахевильз (25, 29), Лигети (33, 36) нар «салбажу» гэж сэргээн босгож сийрүүлсэн юм. Лувсанданзан энэ үгийн утгыг тулгуурлан мэдэлгүй «солбичижу» (31, I, 36) ташаарсан бололтой. Үүний хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «дэлиж татах» (36, 132) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 135), Рахевильз, Кливз, Поуха, Калужинский цөм энэ үгийг «татах дэлэх» гэж орчуулсан бололтой байна. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 45), Элдэндэй Ардажав нар (8, 163, тайлбар № 13), Мансан (27, 48) Дугаржав нар (24, 27) нумандаа «сум онилох» гэж ойлгож орчуулсан буюу тайлбарласан байна.

Бидний санавал энэ «самбах» гэдэг үйл үг хуучин (сонгодог) монгол бичгийн болон орчин цагийн монгол хэлэнд уламжлан ирэлгүй мартагдсан учир Лувсанданзан утгыг сайн мэдэхгүй «солбичижу» гэж Дамдинсүрэн тэргүүтэн сумаа (самбаж гэснийг) онилж гэж энэ тохиолдолд зөв таасан шиг санагдана. Энэ нь үг чухамдаа ямар нэг үйл хийхэд «завдан бэлтгэх» гэсэн утгатай мэт бөгөөд «сумаа самбаж» гэвэл «сумаа харвахад урьдаас завдан бэлтгэсэн» гэсэн утгатай тул энэ тохиолдолд сумаа нуманд тавьж онилох татах гэсэн утгатай байж болох юм. Үүнийг энэ үйл үгнээс дам үүссэн самбаа, самбаалах, самбаачилах гэх мэт үг батлах мэт. Үүний загвараар хасаа, дав+аа=даваа гэх мэт үг үүсчээ.

260. сөрүм-үсүн (сормуус) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 138), Баяр (11, I, 148), Иринчин, Элдэндэй Ардажав (8, 159) «суримусун» гэж, нөгөө Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн (26, 78) сурумусун» гэж хоёр янзаар сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «биеийн үс» гэж тайлсан нь ташаа юм. Энэ үгийг утгаар нь Лувсанданзан хуучин монгол үсгийн бичлэгт дөхүүлж «сормусун» (31, I, 37) гэсэн учир Пеллио (9, 135), Хэниш (15, 14) «нүдний сормуус», Рахевильз, Кливз «нүдний бог?», Поуха нүдэнд орсон хөмсөг» гэх зэргээр ташаа орчуулсан бололтой байна.

Дамдинсүрэн, Дугаржав нар «сормуусу» гэж зөв ухаарч, харин Элдэндэй Ардажав нар (8, 163—164, тайлбар № 16), Мансан (27, 48) «нүдний хог» (суримусу-гэдэг нь сормуусу биш) гэжээ.

Бидний бодвол энэ үгийг XIII зууны галиглагч нар тухайн үеийнхээ аялгуугаар «суримусун» гэж ташаа тэмдэглэсний дээр хятад хадмалд «биеийн үс» гэж ташаа орчуулсан мэт бөгөөд, Лувсанданзаны худам монгол эхэд зөвөөрөө «сөрүм-үсүн» гэж байсан учир зохиогч хуучин (сонгодог) бичигт бичдэгээс нь арай өөрөөр «сормусун» гэж бичсэн шиг байна. Ер нь «сормуусу» гэдэг үг нь «сөрүм-үсүн» гэсэн хоёр үгээс нийлж бүтсэн нь эндээс мэдэгдэж буй учир «сурим усун» гэж байж таарахгүй. Сөр-гэсэн үйл үгийн үндсэнд хувилгагч м үсэг (үг бүтээх дагавар) залгахад -рү- болж хувилан сөрүм гэдэг үг (ор+м=орум

гэдгийн загвараар) бүтжээ. Үүн дээр «үсүн» гэдэг үг бүтэх үед сөрүм гэсэн үгийн «ү» нь балархайшиж сөрмү- гэж дуулдах болсоноос сөрмүүсүн гэж хоёр эгшиг нэг урт эгшиг болжээ.

261. амны хахусун (амны хахсан юм) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 56), Пеллио, Баяр тэргүүтэн цөм «хахасун» гэж сийрүүлжээ. Дашцэдэн «хагасу» (26, 30) гэсэн учир тодорхойгүй. Лувсанданзан «хогусун» гэж буруу сийрүүлээд «халисун» (31, I, 37) гэсэн нь хальс гэсэн үг бус харин амнаас хальж гарсан зүйл гэсэн утгатай бололтой тул «бөөлжис» болгох гэсэн үг гэж ойлгожээ.

Элдэндэй Ардажав нар (8, 164—165, тайлбар № 16) хоолойд хахсан загасны яс гэж тайлбарласан нь төдий л үнэмшилтэй биш, учир нь «хаху-» гэсэн идэвхтэй эс тусах үйл үгэнд «-сун» залгаж үүссэн энэ үг **хахугул** (р) хахаах багажны нэр үүсэхгүй, харин хахсны үр дүнд үхсэний нэр үүсэх тул «хахусун» гэвэл үхсэн хүүр болгох гэсэн утгатай үг болов уу. Энэ хоёр үг нийлээд сэг сэвс болгох гэсэн утгатай эртний өвөрмөц хэллэг байх магадгүй. Жич хахасун гэдэг нь XIII зууны аялгын нөлөөгөөр гуйвсан бүруу дуудлагын бичлэг тул зөв нь «хахусун» гэж худам бичгийн эхэд байснаар төсөөлж бодсоноороо сийрүүлэв.

262. үдүрмэлжү (онь мултлах, харвах) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь —үтэрмэлэжү» гэж буулгадаг бөгөөд утгыг хятад хадмал орчуулгаар Хэниш «ойроос ойр бай харвах», «хамгийн ойрхноос харвах» (36, 14) гэж тайлснаас үндэслэн Пеллио «бай мэт харвах» Рахевильз «харваж эцэтгэн харвасан» (49, 1971, 137), Кливз «дуусган харвах» гэхчлэн элдвээр орчуулжээ. Элдэндэй Ардажав «үдүр» гэдэг «үтэр» (түрэг харваж алах гэсэн үгийн галиг бөгөөд монголчууд үтэрмэлж гэж «алах харвах» гэсэн үгийг цээрлэж «үтүрм-э» гэсэн (тариа цайруулах) гэсэн үг хэрэглэсэн гэх зэргээр тайлбарласан (8, 166, тайлбар № 21) нь төдий л үнэмшилтэй санагдахгүй байна.

Дамдинсүрэн, Дугаржав, Мансан нар жирийн «харван алж, унагаж одов» гэх зэргээр орчуулсан нь угтаа зөв мэт бодогдоно. Учир нь бидний бодоход энэ үг сумаа онь мултлаж тавихыг хэлдэг бөгөөд «үтүрм-э» (тариа цайруулах газар) гэсэн үг биш, харин «үдүркү» (шүргэх) (мултлах) (12, 179б) гэдэг үгнээс үүсэлтэй юм. Үдүр (шүргэх үйл) +мэ (сум мултлах нэг арга) +л (тэр аргаар сум мултлах гэсэн үйл үүсгэжээ) +жү (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэр) гэсэн бүтэцтэй үг болов уу гэж бодном.

263. көбүгэд-үн ийэн (хүүхэд юүгээн) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс «кө'үкэд-ү'эн» гэж Пеллио, Рахевильз (25, 30) тэргүүтэн сэргээдэг билээ. Ардажав Элдэндэй «кэүкэд-ийэн» (8, 116) гэж сэргээжээ. Бид үүнийг эртний худам монгол бичиг урт хос эгшиг монгол хэлэнд үүсч гараагүй байхад хэрэглэгдсэн үг гэж энэ үүднээс хуучин (сонгодог) монгол бичигт «кэүкэд» гэж бичдэг үгийг эрт цагт «көбүгэд» гэж бичдэг байгаад хожим үе солигдон «көбэгүд» гэж бичигдэх болсноор төсөөлөн таамаглаж энэ үгийг бид ийнхүү сэргээн сийрүүлэв.

264. халагун-ача мину (халуунаас минь) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш тэргүүтэн судлагчид «хала'ун» гэж сэргээн бичээд хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «эхийн (хүйс) эрхтэн» (36, 57) гэж тайлсан нь зөв бөгөөд Пеллио халуунаас гэж үгчлэн орчуулаад «эхийн хэвлий, умай» гэж тайлбарласан юм. Дамдинсүрэн (7, 46) Мансан (27, 48), Дугаржав (24, 27) нар «халуун хэвлий» гэж орчуулсан нь цөм зөв байна.

Бид энд Нууц товчооны хэлэнд юмыг шинжээр нь орлуулан нэрлэх үзэгдэл олонтаа хэрэглэгддэг нь уг ном маш товч хураангуй бичигдэхийн нэг хэрэглүүр болсон юм гэдгийг тэмдэглэе. Цогтын чулууны бичигт «халагут авга» гэдэг нь бас халуун хэвэл нэгт гэсэн утгатай болов уу.

265. хала-д-а гарарун (халд гарахдаа) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «халат» гэж сийрүүлээд хятад хадмал орчуулгын утгыг «халуун долгин, догшин хэнээтэй» гэх мэт үгээр тайлснаас үзвэл хятад хадмал орчуулга нь буруу байжээ. Хадмал орчуулгын утга тааралтүй учир Хэниш, Дамдинсүрэн нар уг үгийг орхиж орчуулж, харин Пеллио «туйлдсан хэвлээс минь хэрцгийгээр гарсан» гэж бүрүү орчуулжээ. Учир нь «барагсад» гэсэн үгэнд туйлдах дуусах гэсэн хадмал орчуулга байсныг «халуун» гэдэгтэй холбож буруу тайлбарлажээ. Дугаржав «халд» гэдэг үгийг хэвээр, Мансан «хагарч» гарах гэх мэтээр орчуулжээ.

Бидний бодоход «хала-д-а» гэсэн энэ үг гаднын зохисгүй орчин, бэрхшээлт орчин гэсэн утгатай үг тул зүй нь халуун хэвлээс «хатуу орчлонд» гэж орчуулмаар санагдгаг. «Хал үзэж хашир суух», «хал үзэж халуун чулуу долоох» гэх мэт үгнээс үзвэл «хал» гэдэг үг таньж мэдэхгүй орчин, бэрхшээлт орчин гэсэн утгатай болов уу. Энэ үгийг Элдэндэй Ардажав нар (8, 168, тайлбар № 2) санамсаргүй, гэнэт амархан хялбар хөнгөнийг заана гэж хорчины аялгуунд тулгуурлан тайлбарласан нь үнэмшил учирлал муутай санагдана.

266. Хасар нохай (Хасар нохой)-гэсэн энэ үгийг хятад галигаас «Хасар» **гэж Хэниш (36, 62) гэж сийрүүлээд хятад хадмалыг** «нэг зүйл нохой» гэж тайлжээ. Элдэндэй Ардажав нар (8, 69, тайлбар № 5) энэ үгийг догшин нохой гэсэн үг болох хийгээд Өвөр Монголын ардын домог үлгэрээс гаралтайг жишээгээр заажээ. Хасар гэдэг нь чухамдаа маш эрт цагт монголчуудад «арслан» гэж төсөөлөгдөж байсан үлгэр домгийн амьтан бөгөөд нохой хэлбэрт арслангийн эртний монгол нэр (48, 38—41) гэж бид урьд тайлбарласан юм.

267. Хаблан мэт (хавлан мэт)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш болон олонх судлагчид «хаблан» (36, 54) гэж сийрүүлээд хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «зэрлэг амьтан, махчин араатан амьтан» гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш «Хаблан-бар» (15, 14), Пеллио (9, 136), Рахевильз (49, 1971, 137), Кливз (42, 26) «ирвэс» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 169, тайлбар № 6) түрэг хэлний «каплан» барс ирвэс) гэсэн үг болгож тайлбарлажээ. Дамдинсүрэн «харцага шонхор мэт» гэж, Дугаржав «хавлан нэрт араатан» гэж, Мансан «хаблан ирбис мэт» гэж тус тус орчуулжээ.

Бидний санахад түрэг хэлний «каплан», монгол хэлний «хавлан» гэсэн хоёр үгийг аль нь алинаасаа авсныг тогтооход их ярвигтай бөгөөд ашиггүй юм. Хаблан гэдэг үг Хаб-(хав) гэсэн язгуур нэр үндэс дээр -лан гэдэг том амьтны нэр бүтээх монгол хэлний үг бүтэх ёсонд нийцэж бүтсэн үг юм. Жишээ нь хаб+лан=хаблан, арс+лан=арслан гэх мэт. Түүнээс гадна жинхэнэ арслангийн угсаанаас одоо ганц хав үлдсэн гэдэг монгол домог үлгэр байдаг тул энэ хаблан гэгч нохой хэлбэрийн том араатны нэр тул бар ирвэсийн (мийн) язгуурт огт холбогдолгүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

268. өмүгрэкү (өмөөрөх)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 124), Пеллио (9,16), Баяр тэргүүтэн цөм өмэргү буюу өмэрхү гэж сэргээн бичээд Хэниш хятад хадмал орчуулгын утгыг «хамсан бүлэглэх» гэж тайлжээ. Үүнийг Хэниш «эргэж довтлох» гэж, Пеллио «өмгөөлөн хамгаалах» гэх зэргээр элдвээр ойлгож орчуулсан байдаг. Судлагчдаас Элдэндэй Ардажав нар (8, 171) энэ үгийг туслах тэтгэх гэсэн утгатай өмэр гэдэг түрэг үгнээс гаралтай «өмөглөх, өмүгэрэкү, хамгаалаху» гэсэн утгатай үг гэжээ.

Бидний бодвол энэ үг өм (идэвхгүй язгуур, үйл үгийн 1 үндэс) +г (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +рэ (нэр үгээс эс тусах үйл үг бүтээх дагавар) +кү (үйлт нэрийн ирээдүй цагийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг тул түрэг хэлний «өмэр» гэдэг үгтэй гарлын холбогдолгүй биз гэж санана.

269. чөгэбүри (цөөвөр)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «жө'эбүри» (36, 92) гэж, Пеллио бас энэ мэт сэргээжээ. Харин Лигети, Рахевильз, Баяр, Элдэндэй Ардажав тэргүүтэн цөм «чөгэбүри» гэж сэргээжээ. Энэ үг нэг зүйл жижиг биет чононцорын нэр гэж монгол хүн мэдэх тул Дамдинсүрэн (7, 47), Мансан (27, 49), Дугаржав (24, 28) «чөгэбүри» гэж тайлбаргүйгээр хэрэглэжээ.

Элдэндэй Ардажав нар «-бүри» гэдэг нь түрэг чоно гэсэн үг гэжээ. (8, 171—172), тайлбар № 13). «Чөгэ» гэдэг нь хэрэв түрэг үг биш бол монгол хэлэнд тэр цагт байсан «чө'э» буюу «бага» жижиг гэсэн үг байж магадгүй. Иймээс чөгэбүри гэгч жижиг биет бүри (чоно) гэсэн үг ажээ. Үүнийг монголчууд Элдэндэй нарын тайлбарласнаар «шарнууд» гэж нэрлэхээс гадна бас чононцор гэж нэрлэж байсан биз ээ.

270. баруг (бараг) -гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 13) «барух» гэж сэргээгээд «долгин догшин» гэж хадмал орчуулгын утгыг тайлсан байв. Энэ «баруг» гэдэг үгийг Хэниш, Лигети хоёр «барус» гэж, бусад судлагчид «баруг» гэж сэргээгээд Хэниш нэг араатны нэр гэж, Элдэндэй Ардажав нар (8, 172) түрэг хэлний «барак» гэдэг нэг зүйл урт үст нохойн нэр гэв. Түрэг хэлний тольд «Баруг» гэж домог-үлгэрийн ёсоор бүргэдийн хоёр өндөгний нэгээс гарсан урт үст нохой гэснийг Японы эрдэмтэн Мураками Пеллиогийн Мухамет ал Қсиокамийн зохиосон «түрэг хэлний үгийн толийн» баримтаас иш татаж заасан гэжээ.

Элдэндэй Оюундалай хоёрын «нэг зүйлийн араатны нэр, гахай үстэй нохой» гэсэн тайлбарт тулгуурлан Мансан нохой гэжээ (27, 67, II бүлгийн тайлбар № 15). Баруг гэж нэрлэгдсэн энэ араатны нэр монгол түрэг үлгэрт гардаг нэг зүйл нохойн нэр бололтой.

271. килдүмү та (хийлдэмү та)-гэсэн үгийн галиг ба утгыг ойлгох талаар судлагчдын саналаас зөрөх зүйлгүй. Гагцхүү ки-гэдэг үйл үгийн үндэс орчин цагт урт эгшиг болсон шалтгааныг бид задгай үеийг уртаар дуудах монгол хэлний онцлогоос болж дуудлага нь «килдүмү» гэж хуучин (сонгодог) бичгийн хэлэнд богино үеийн ёсоор тэмдэглэгддэг гэдгийг хүлээх ёстой.

272. Хагучин үгэс хадалун (хуучин үгс хадлан)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «хадалху» (36, 55) гэж сэргээгээд хятад хадмал орчуулгын утгыг «мөрдөж шинжлэх» гэсэн үгээр тайлжээ. Хэниш энэ

үгийг хуучин үг «нотолгоо болгож» (15, 15) гэж, Пеллио «хуучин үгийг шинэтгэн авч» (9, 136, Рахевильз «сонгон авч» (49, 1971, 138), Кливз «иш татаж» (42, 24) гэж, Дамдинсүрэн (7, 47), Дугаржав (24, 29), Мансан «үндэс болгож» (27, 50) гэх мэтээр орчуулж Элдэндэй Ардажав нар энэ үгийг «кадал, казал» гэсэн түрэг үг «хадуулах, хатгагдах, чичигдэх» гэснээс үүсгэж тайлбарлаж, буриад аялгын «хайха хадарха» гэдгийн адил «эрж хайх» гэсэн утгатай гэжээ (8, 173). Бид энэ үгийг хада-(бат тогтоож хадах гэсэн утгатай үйл үгийн үндэс) +л (үйлийн дахин үйлдэх байдлын нөхцөл) +н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг бөгөөд хүүхдийн санаанд уг үгийг бат тогтоолгох гэж хадсан гэсэн шилжсэн утгатай гэж бодно. Монгол хүн мартахгүй дурдагдсаар байгаа зүйлийг «Миний цээжинд хадаатай байна» гэдэг. Үүнтэй адил үг болов уу гэж санана.

273. Өтэгүс-үн үгэс өркидүн (өтгөсийн үг өркидөн)- гэсэн энэ үгийг хятад галиг эхээс нь Хэниш «өркиткү» (36, 126) гэж сийрүүлээд хятад хадмал орчуулгын утгыг «нотолгоо болгох, иш татах» гэж тайлаад тэр ёсоороо ч орчуулжээ (15, 15). Пеллио, Рахевильз, Кливз, Дамдинсүрэн, Дугаржав, Поуха, Калужинский, Мансан тэргүүтэн цөм иймэрхүү үгээр орчуулжээ. Элдэндэй Ардажав нар «орхидун» гэж сийрүүлээд Мухаддиматын толь зааж тавих, байрлуулах, нэмэх, оруулах гэсэн утгатай (8, 173, тайлбар № 20) гэжээ.

Бид энэ үгийг иш татах, дурдах, сануулах гэсэн утгатай маш хуучирсан **үйл** үг байх **гэж ерөнхий утгаас нь тааварлах төдий** байна.

274. хурагад голугуд (хурагад гологууд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «хулугад» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «(тэд) муусайд» гэж **товч** орчуулгын бололтой хятад үгсийг «Бидний анх орхигсод, гологдогсод» (36, 65) гэж тайлжээ. Пеллио «өөдгүйс» (9, 136), Рахевильз «ангайхад» гэж, Кливз «өөдгүй муусайд» (42, 25), Дамдинсүрэн «хурагад» (7, 47), Элдэндэй Ардажав нар «хулухуд» (хулхи) (8, 174—176), Мансан «зулзага шувуу» (27, 67—68) гэж тус тус орчуулж тайлбарлав.

Бид үүнийг хэрэв хурагад гэсэн үг биш бол «гологуд» гэсэн үг болов уу гэж бодож сийрүүлэв. Үүнийг ингэж ойлгох нь дараах үгий нь яаж ухаарахаас хамаарна.

275. гогужижуху гобожижуху (гуужижээ, гоожижээ)- гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «го'ожихуу» (36, 66), гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «тэдгээр (ноолуур) одоо гуужих» гэж товч орчуулгын нь утгыг «тэдний өд сөд нь ургасан» гэж тайлжээ. Үүнийг Пеллио, Рахевильз, Кливз, Дамдинсүрэн, Баяр (11, I, 158) цөм гуужих үсээ хаях гэж орчуулжээ. Элдэндэй Ардажав (8, 167), «хогжрох ховхрох хуурах» гэжээ.

Бид энэ үгийг хэрэв «гуужжээ» гэсэн үг л биш бол «гоожжээ» (гоо сайхан болжээ) гэсэн үг байж магадгүй гэж таамаглав. Учир нь хэрэв урьдах үг нь «хурагад» мөн бол гуужжээ» (үс ноосоо хаяжээ) гэж хэрэв тэр нь «гологууд» (гологдогсод) гэсэн үг бол «гобажижуху (гоожжээ) буюу сайжирч, царай оржээ гэсэн үг байж болох юм.

276. силүгэд ~ силүхэд (төлгөд ~ шүлхэд)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «шилүгэт» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг (тэд багачуул) шүлсээ гоожуулахгүй байж үл чадагсад, шүлсээ гоожуулсаар бүхүй (36, 140) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио «нусгад» (нусгайнууд) гэж (9, 136), Рахевильз «хургад» гэж, Кливз «шүлхийнүүд» гэж, Поуха «шүлстэн» (32, 32) гэж, Калужинский «нусгайд» (61, 47) гэж, Баяр «шилүстэн» (шилүгэд) гэж, Элдэндэй Ардажав нар (8, 177) Мансан (27, 50) нар «шүлс» гэж, Дугаржав «нус нулимс» (24, 29), Дамдинсүрэн «төлөгний бие» (7, 47) гэж элдвээр орчуулжээ.

Бид энэ үгийг хэрэв шилүгэд гэдэг төлөг гэсэн үг л биш бол шилүхэд буюу «шүлхэд» (шүлхий нар) гэсэн үг байх гэж таамаглаж байна.

277. сибэр-[ил]эжүкү ~ сэбэрэжүкү (шивэр [л] эжээ ~ сэвэржээ) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «Шибэрикү» (36, 139) гэж сэргээн сийрүүлээд хадмал хятад үг-үсгийн утгыг «өсөх» «том болох» гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 15), Пеллио, Рахевильз Поуха, Калужинский цөм «өсч том болсон» гэсэн утгаар орчуулснаас гадна Мансан энэ **үгийг «сайирагулжу гүйичэксэн, байиг-а»** (27, 50) гэж орчуулаад II бүлгийн 16 тайлбарт «Шибэрэгүлкү» «сайирагулху» (савируулах?) гэсэн (27, 67) гэжээ.

Бидний санахад энэ үгийг XIV зууны галиглагчид тэр цагийнхаа нутгийн аялгын дагуу гуйвуулж галигласан ба хожим хадмал хятад орчуулгыг ч алдаа зөрчилтэй **хийсэн учир** өдий их будлиантай болсон болов уу гэхийн учир энэ үг «хурагад» гэдэг үгтэй холбогдвол «шибэрилэжүкү» гэж, хэрэв «шилүхэд (шүлхий нар)» гэдэг үгтэй холбогдвол «сэбэрэжүкү» (хатаж гоожихоо больсон) гэсэн үг худам монгол бичгийн эхэд нь байсан гэж таамаглаж болно. **Учир нь хонь**

хурга таргалж сүүл бөгсөнд нь тостой хөлс зунгаг гарч бараан өнгөтэй болохыг халхчууд хонь шээглэх «шивэрлэх» гэж ярьдаг юм. Нөгөө талаар нус нулимс алив ус болсон юм хатаж эхлэхийг монголчууд «сэвэрэх» гэж хэлдэг бөгөөд үүнийг хуучин (сонгодог) монгол бичигт «сэбэрэкү» (12, 817) гэж бичдэг байна. Иймд эдгээр дөрвөн үг хэрэв Дамдинсүрэн гуайн ухаарснаар «хурагад гуужижжээ, төлгөний бие төлжжээ (шивэрлэж таргалжээ) гэсэн үг биш бол «гологууд» (гологдогсод гэсэн хараалын үг) гобажижухуй (гуа сайхан болжээ), шүлхийд (шүлхий нар- шүлсээ гоожуулагсад) сэвэрэжүкүй (сэвэрчээ) гэж, өөрөөр **хэлбэл өсч тэнхэрчээ гэсэн үг болов уу гэж бид** төсөөлөн бодож сийрүүлэв.

278. хоргулажу (хорголж)- гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс хорхолаху» (36, 67) гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «мод унагаж хаалт барих» гэж тайлжээ. Энэ үгийг «хаалт» (Хэниш, Поуха, Калужинский) «хороо хашаа» Пеллио (9, 137), «баррикад» (Рахевильс), «шивээ» (Дамдинсүрэн, Дугаржав, Мансан) гэж элдвээр орчуулжээ. Элдэндэй Ардажав (8, 177, тайлбар № 5) корган «бэхлэлт» гэсэн түрэг үгээс гаралтай гэж тайлбарласан нь өрөөсгөл юм. Учир нь энэ үгийн бүтэц нь хор- (бөөгнөр цугла- гэсэн утгатай үгийн язгуур, үйл үгийн I үндэс) +гу (үйл үгээс нэр үг бүтээх дагавар, хорсон юмыг хадгалж хамгаалах бүрхүүл гэсэн утгатай нэр үг үүсчээ) +л (нэр үгээс үйл үг бүтээх дагавар: хорго барих гэсэн утгатай үйл үг үүсчээ) + жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) болно. Иймээс энэ үг түрэг хэлний корган гэдэг үгээс бус, хор- гэсэн монгол үйл үгээс үүссэн нь тодорхой. Таши + гу + ташигу (ташуу) гэх мэт үг энэ загвараар бүтдэг гэж болно.

279. унгшигдажу (уншигдаж)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «унгшиху» гэж сэргээн бичээд хадмал хятад орчуулгын утгыг «дуудах, нэрлэх» гэж тайлжээ. Судлагчид энэ үгийг их төлөв хашгаран хэлэх бархирах гэж орчуулсан нь зөв зүйтэй байна.

Энд бид энэ үг эртний монгол хэлэнд хашгиран бархиран холоос чанга дуугаар ярилцах гэсэн өөр утгатай байсан бөгөөд хожим ном уншихгэдэг утга оржээ. Ном унших гэдгийн унших нь урьд дуудан унших гэсэн утгатай байжээ. Иймээс ч захидал буюу албан **бичгийг уншуулах** гэсэн хөдөөний ард «энэ захидлыг дуудаад аль!» гэж гуйдаг нь «уншаад аль» гэсэн үг болно. Жич «унгшигдажу» гэсэн нь эс тусах үйл үгээр бичигдсэн нь үйл үгийн энэ идэвхгүй хэлбэр өргөн хэрэглэгддэг онцлог тэр үеийн бичгийн хэлэнд байсны гэрч болно.

280. дутагажу (зугтаж)- гэсэн энэ үгийг хятад галигаас Хэниш «дута'аху» гэж сэргээгээд хадмал хятад үг үсгийн утгыг «гүйх, зугтан одох, нуугдах» (36, 39) гэжээ. Энэ утгаар ч судлагчид орчуулдаг. Жич энэ үг дута- (хүрэхгүй, дутуу байх гэсэн утгатай тусах үйл үгийн I, үндэс, үгийн язгуур) +га (үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөл) + жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд дутах гэсэн үгнээс гаралтай, хойноос хөөж яваа хүнийг зугтагчаас «дутаах» «орхиж одох» гэсэн утгатайг энд тэмдэглэе. Ийм «дутаах» (дутуу болгох) гэсэн утгатайг түүнийг эсрэг утгат «гүйцэх» (дутуугүй болгох) гэсэн үг байгаа нь нотолж байна.

281. харижу (харьж)- гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «хариху» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгыг «арагшаа эргэх» (36, 62) гэв. Сонирхолтой нь энэ үг орчин цагийн монгол хэлэнд байгаа шигээ «гэртээ эргэх» гэсэн утгаар биш, харин явах чиглэлийн эсрэг «эргэх» гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ. Өөрөө хэлбэл «ар тийш (нүүрийн эсрэг) эргэх» гэсэн тодорхой утгатай байжээ. Орчин цагийн монгол хэлэнд «эргэж харах» гэхийн оронд «харьж үзвэл» г. м. ажээ.

282. хосилиг-ун тэдүй (хошлогийн төдий)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь «хошилиг-ун тэдүй» (Пеллио, Баяр (11, I, 163), Дашцэдэн (26, 32) тэргүүтэн цөм ингэж сэргээдэг бөгөөд энэ үгийг Хэниш (15, 16), Пеллио (9, 137), Рахевильз (49, 1971, 139), Кливз (42, 25) нар цөм «майхны төдий» гэж Дамдинсүрэн (7, 48), Мансан (27, 51), Дугаржав (24, 30) нар «гэрийн чинээ» гэж тус тус орчуулсан бөгөөд «хоси (хош)» гэдэг нь чухамдаа хэдэн шургааг мод үзүүрээр нь бооож шовойлгон боогоод эсгий, холтос зэргээр бүрээсэлж хошлонгоор ороож хийсэн түр (аяны) сууцын нэр болно. Өнөө үед аянд явах хүн «хоол хошоо бэлтгэнэ» гэж ярьдаг нь «хоол хүнс ба аяны (түр зуурын) сууцаа бэлтгэнэ» гэсэн утгатай хоршоо үг ажээ. Иймд «хошилиг» гэгч хоши маягийн сууц буюу хошийн нэг зүйлийн нэр бололтой. Жич «хоши-оланг» гэсэн хоёр үг нийлж «хошиланг» гэсэн үг үүссэн нь «хоши(гэр)-ийн олом» буюу гэрийн бүслүүр гэсэн утгатай үг болсныг энд тэмдэглэе.

283. гүрү (гүр хүр)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «гүрү» гэж сэргээн сийрүүлээд «чулуу» гэсэн үгээр хадмал хятад үгийн утгыг тайлжээ (36, 53). Энэ үгийг Лувсанданзан ч «чулуу» гэж тайл-

барласан (31, 1, 34) ба Хэниш (15, 16) «чулуун хаалт» гэж, Пеллио (9, 137), Рахевильз (49, 1971, 139), Кливз (42, 25) нар «хад» гэж, Поуха «үхэр чулуу (?)» (17, 32), Калужинский «хаалт хад (?)» (61, 48) гэж тус тус орчуулсан санагдана. Дамдинсүрэн (7, 48), Мансан (27, 51), Дугаржав (24, 30) нар чулуу гэж орчуулжээ.

Бидний санавал гүрү гэдэг ерийн чулуу буюу хад гэсэнтэй ив ижилхэн утгатай биш учраас ийм үг монгол хэлэнд бий гэж бодох бөгөөд энэ бол маш бат бэх бөгөөд **«төмрийн хүдэр» (53, 166) бүхий чулуу** гэсэн утгатай байх гэж төсөөлөн бодож байна. **Бат бөх чулуу** болох нь **«Нууц товчооны»** дотор **147** дугаар зүйлд **Зэв Чингис хаанд** «күр гэсэн газарт көх гүрү кэгүр, хал гэсэнд хар гүрү хам-хар добтолж өгсүү» гэж амласнаас ил байна.

284. орчин гарбасу (тойрон гарвал)- гэсэн энэ үгийг судлагчид ингэж сэргээж **босгодог ба ийм утгатай** гэж ойлгодог юм. Харин энд орчин гэсэн үг «тойрон» гэсэн үйл үгийн утгаараа хэрэглэгдсэн нь баримттай бөгөөд сонирхолтой юм. Хуучин (сонгодог) монгол бичигт «орчин тойрон» гэсэн нийлмэл үг хожим үүсч, үйл үг биш нэр үгийн ёсоор тийн ялгалаар ялгагдах болсон нь бүр ч сонирхолтой юм. Жишээ нь «орчин тойрны байдал» гэх зэргээр хэрэглэгдэх болсон явдал тэмдэглүүштэй зүйл юм.

285. Баху ~ багу-бар-ийан (бахуу ~ бугуйгаараа)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш **«буха'у»** гэж сэргээн хадмал хятад орчуулгын утгыг **«ичүүрийн зах»** (дээлийн) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 18), Рахевильз (25, 31), Лигети (33, 19), Баяр (11, I, 168) нар Хэнишийн адилаар, Дашцэдэн **«бугуу»** (26, 32), Элдэндэй Ардажав «бухагу» (8, 181), Иринчин «бухаху» (28, 52) гэж сэргээсэн байна. Энэ үгийг Хэниш «модон зах» (15, 16), Пеллио «тушаа (гав)», Рахевильз, Кливз (42, 26) «хүзүүний гав» гэж, Дамдинсүрэн «багу (дөнгө)» (7, 48), Баяр «багуу» гэж, Дугаржав «гаваараа» (24, 30), Мансан «дөнгөө» (27, 51) гэж орчуулж байжээ. Мансан (24, 68, тайлбар № 18) энэ үгийг «ялтны гар ба хүзүүнд хийдэг гав дөнгө» гэж тайлбарлажээ. Элдэндэй Ардажав нар **«бухагу»** гэдэг үгийг түрэг хэлний «быгау» буюу «гав гинж, дөнгө» гэсэн үгтэй холбож гав дөнгө бүхүй гэсэн үг гэх зэргээр тайлбарласан байна.

Бид Лувсанданзаны Алтан товчид **«гинж баху-бар-ийан»** 31, 1, 40) гэснийг худам монгол бичгийн эхээс хуулсан зөв бичлэг нь гэж үзэж «баху» буюу хүзүүнд углах «гав», эсвэл «багу» (гэж бугуйд хийх гав гэсэн утгатай үг байх гэж таамаглан ийнхүү сийрүүлэв. «Баху» гэдэг нь «модны хавдсан мэт газар» гэсэн утгатай, хуучин монголоор «бахуу» худам монголоор «бахугу» гэдэг нь «хоолойн өвчин» (12, 232) гэсэн утгатайгаар хуучин (сонгодог) монгол бичигт уламжлан иржээ. **Нөгөө** талаар багуу гэдэг нь «багубчи-багуу йин чимэг» (12, 234) гэсэн бичлэгээр хадгалагдан уламжилж ирсэн гэж бодож **байна.**

286. харигтур (харигт) -гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс «харки» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг «урсгал» «гүйдэл» (36, 62) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио, Рахевильз, Лигети, Лувсанданзан (31, I, 40), Дашцэдэн, Баяр, Дамдинсүрэн, Элдэндэй Ардажав (8, 182), Мансан цөм Хэнишийн адил сэргээсэн нь бидний бодоход алдаатай бөгөөд үүний утгыг хятад хадмал орчуулгад урсгал, түргэн урсгал» гэж ташаа тайлбарласнаас Мансан (27, 68, II бүлгийн тайлбар № 19), Элдэндэй Ардажав (8, 184, тайлбар № 6) «түргэн урсгал» гэх буюу ус тэргэл болсонгүй газрыг харги гэнэ» гэж, Дугаржав нар «усны гүехэн газарт» (24, 31) гэхчлэн ташаа тайлбарлажээ. Хэниш «усны урсгал дотор» (36, 16), Пеллио «усны тохойд» (9, 138), Рахевильз, Кливз, Поуха (17, 33) нар Хэнишийн адил «усны урсгалд» гэж, Калужинский «усны түргэн урсгал дотор» (61, 48) гэж орчуулсан шиг байна.

Бидний бодвол ойд нуугдвал харагдах байх гэж айсан хүн усны гүехэнд нуугдахгүй харин усны гүнд бүх биеэ далдалж нуугдах нь гарцаагүй тул Пеллио авгайн ойлгосон шиг «усны тохойд» нуугдсан нь лавтай. Иймд «харги» гэснийг «Урсгалын хажуудах тогтмол ус» (7, 48) өөрөөр хэлбэл усны «хариг» (12, 3306)-т гэж ойлгох нь зөв. Учир нь голын усны урсгал голын тохойд хүрээд зарим хэсэг нь хариж эргэлдэх тул тийм харигийн гүнзгий усанд Тэмүжин хэвтсэн гэж бодох үндэстэй. Иймд «харигт» гэсэн үгийг 14 дүгээр зүүны галиглагчид «харки» гэж буруу галигласнаас хожим хийсэн хадмал хятад орчуулгад «урсгал гүехэн газар» гэж ташаарсан бололтой.

287. сарагур-а (саруулд)- гэсэн энэ үгийг хятад хадмал галиг үсгээс нь Хэниш «сарагур-а» гэж зөв сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг нь «саран гиймэлд (сарны гэрэлтэйд)» (36, 132) гэж орчуулсан тул судлагчид цөм зөв сэргээж зөв орчуулсан юм.

Баяр авгай энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичгээр «сарагул-а» (11, I, 170) гэж, Элдэндэй Ардажав нар (8, 185) «сарагул-а» гэж сийрүүлсэн боловч энэ бичгийн үүдээс зөв боловч эртний худам мон-

гол үсгээр бичигдэж байсан бичлэг нь энэ «сарагур-а» гэдэг лавтай мөн гэж бодож ийнхүү сийрүүлэв. Үүнд «арчигур» гэдэг үг хожим үед хэлний хэмнэх зохицлын үүднээс «алчуур» гэх буюу эсвэл «арчигул» гэж хэлэгдэх бичигдэх удаа байвч худам монгол бичигт үүнийг «арчигур» гэж бичиж байсан нь илүү зөв болохыг тэмдэглэе.

288. Сүлдэс-үн (Сүлдсийн)-гэсэн овгийн нэрийг хятад үсгийн галигаас нь Хэниш «Сүлдус-» (36, 182) гэж сэргээжээ. Иймээс Пеллио (9, 18), Дашцэдэн (26, 32), Баяр (11, I, 170), Дамдинсүрэн (7, 48), Элдэндэй Ардажав (8, 185), Дугаржав (24, 31), Мансан (27, 52), Иринчин (28, 52) цөм Хэнишийн адил сэргээж гагцхүү Лигети (33, 39), Рахевильз (25, 32) нар Сулдус-ун» гэсэн нь үзтэл алдаатай сийрүүллэг мэт санагдана.

Учир нь энэ үг «сулдус» гэсэн утгагүй үг бус, харин сүлд тэмдэг гэдэг үгтэй холбоотой нь монгол судлагч нарт эргэлзээгүй зүйл юм. Харин энэ үгийг хуучин (сонгодог) бичгийн үгэнд «сүлдэ» (12, 87) гэж бичигддэг уламжлалтай тул энд «сүлду» гэж хятад үсгийн галигт бичигдсэн нь XIV зууны галигчдын эндүүрэл байхаас зайлахгүй. Учир нь энэ үгийн өөр хувилбарт (63 дугаар зүйлд) «сүлдэр» (9, 13) гэж бичигдсэн нь үүнийг батлан гэрчилж буй.

289. найитагдан (атаархагдан)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «найитахдаху» (36, 113) гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг нь «атаархагдах, хардагдах» гэсэн үгээр тайлсны 1 дахь нь зөв юм. Үүнийг Пеллио (9, 18), Лигети Рахевильз, Дашцэдэн, Баяр, (11, I, 171) нар «найитагдан» гэж сийрүүлж, утгыг нь Дамдинсүрэн (7, 49), Дугаржав, Калужинский нар «атаархан», Мансан «атаархагдан» гэж, Хэниш, Поуха нар мөрдөн мөшгиж» гэж тус тус орчуулсан байна.

Бидний бодоход «атаархагдан» гэх буюу «атаархан» гэдэг үг илүү оновчтой юм. «Найитагдан» гэж сэргээх нь худам монгол бичгийн үүднээс илүү зөв шиг санагдаж бид ийнхүү сийрүүлсэн болно. Най- (энэ үгийн идэвхгүй язгуур) +т (атаарх- гэсэн эс тусах үйл үг бүтээх дагавар) +гд (үйл үгийн үйлдэгдэх хэвийн үндэс үүсгэх нөхцөл) +н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг мөн гэж бодож байна.

290. нөгчибэ (нөгчив)- гэсэн энэ үгийг хятад галигаас Хэниш «нөкчигү» гэж сэргээж хадмал хятад орчуулгын утгыг «өнгөрөн одох» гэдэг үгээр тайлсан нь зөв юм. Үүнийг Пеллио «алга болж одов» гэж, Рахевильз «мөрөөрөө одов» гэж, Кливз (42, 27), Дамдинсүрэн (7, 49) «өнгөрөн одов» гэж, Дугаржав «өнгөрөн явав» гэж, Мансан «өнгөрөн гарав» гэж тус тус ойлгож ерөнхийдөө зөв орчуулсан байна. Энэ үгэнд бас «өнгөрөх (үхэх)» гэсэн шилжсэн утга байдгийг дурдаж болно.

291. Ан-и (тэднийг)- гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «ани» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг тэд, III биеийн төлөөний үгийн олон тооны үгээр тайлсан нь туйлын зөв юм. Рахевильз, Поуха, Калужинский тэргүүтэн цөм III биеийн олон тоот төлөөний үгээр, энэ үгийн утгыг Иринчин (28, 54) маш зөв тайлбарласан байв. Лувсанданзан (31, 41) үүнийг орхиж, Пеллио, Дамдинсүрэн, Мансан (27, 53), Дугаржав (24, 32) цөм заах төлөөний үгээр (тэд) гэсэн үгээр орчуулсан нь Пеллиогоос буцдын хувьд зөв байв. Учир нь энэ гуравдугаар биеийн төлөөний үг ганц тоот и-, олон тоот а-гэсэн хоёр үг монгол хэлэнд мартагдаж оронд нь «энэ-эд, тэр-тэд» гэсэн заах төлөөний үг хэрэглэх болсноос монгол хүмүүс энэ үгийг аргагүй «тэднийг» гэж орчуулжээ. Гэтэл Нууц товчооны эхэд «и» «а» гэсэн гуравдугаар биеийн төлөөний үгс бүх тийн ялгалд олон цөөн тоо зааж тохиолдох тул эртний (худам) монгол бичгийн хэл хуучин (сонгодог) монгол бичгийн хэлнээс ялгагдах нэг ялгаа нь энэ болно. Эртний монгол хэлний биеийн төлөөний үгийн тогтолцоо нь I биед «би» (ганц тоо),«ба» (олон тоо), II биед «ти» (МНТ-д энэ нь «чи» болсноор) (ганц тоо) «та» (олон тоо), III биед «и» (ганц тоо) «а» (олон тоо) гэж байжээ. Мартагдсан III биеийн төлөөний үгээс ардын ярианы хэлэнд «и (й)-гээс би дээр» (түүнээс би дээр) гэх буюу «ана (тэд дийлэх үү?) мана (бид дийлэх үү?) үзэлцэх (байлдах, тэмцэлдэх)» гэх зэрэг өвөрмөц үг хэллэгт үлдсэн төдий болно.

292. түсүрүгэд (түсэргээд-юүлэх, уудлах)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш «түсүркү» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «юүлэх, уудлах» (36, 156) гэж тайлсан нь маш зөв гаргажээ. Хэниш «сүү юүлэх» (15, 17) гэж орчуулсан байна. Гэвч айраг бүлэх гэснийг «цөцгий тос цохих» гэж орчуулсан мэт санагддаг нь арай л юу бол? Пеллио (9, 139) «сүү хутгаж юүлээд», Рахевильз (49, 1971, 141), Поуха (17, 34), Калужинский (61, 49), Кливз (42, 28) тэргүүтэн цөм л «сүү юүлж (самрах?) «цөцгий цохих» гэх мэтээр орчуулсан бололтой. «Сүү түсүргэх (самрах)» гэдэг үг орчуулахад маш төвөг-

тэй нь ил. Лувсанданзаны «түсүрүгэд» гэснийг «Түсэрэгсэн» гэж эндүү, Дамдинсүрэн (7, 49), Мансан (27, 53) нар «сүү самарч» гэж, Дугаржав (24, 32), Элдэндэй Ардажав «түсүрүгэд» (8, 190) гэж, «сүү цутгах юүлэх» (8, 190—191 тайлбар № 2) гэжээ. Энэ орчуулгын бурууг Мостарт (47, 310—311 [26—27]) заасан билээ.

Бидний бодоход «түсүрүгэд» хутгах, самрах, сөн барих гэх зэргийн олон салаа утгатай монгол үг байгаад одоо мартагдсан тул сүү самрах гэдэг нь хамгийн оновчтой орчуулга бололтой. Хуучин монгол бичигт энэ үг уламжлан ирснийг өгүүлбэл «түсүркү- савтай усыг бүрмөсөн асгах зэргийн», «түсүргэ-газар цардахуйн зэрэгт хэрэглэх сав», «түсүргэкү- түсүрхүй дур хүргэх» гэх зэрэг үг толь бичигтээ оруулж Шагж гуай (12, 634а) тайлжээ.

293. торумтай (торомтой)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 155), Дашцэдэн (26, 34), Баяр (11, I, 181), Элдэндэй Ардажав (8, 190), Иринчин (28, 55) нар «туримтай» гэж, нөгөө Пеллио (9, 19), Лигети (33, 41), Рахевильз (25, 33), Дугаржав (24, 32), Мостарт (47, 310, [26]), Лувсанданзан (31, I, 42) тэргүүтэн цөм «турумтай» гэж тус тус сэргээсэн байдаг.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «тор» гэж тайлсан нь уул хадмал орчуулгад буруу орчуулсныг харуулж байна. Үүнийг «туримтай» гэж сэргээн сийрүүлснийг Мостарт дээр дурдсан номдоо «Хэниш энэ үгийг «идэгдэх шувуу» гэсэн бас Пеллио «харцага шонхорын эр» (9, 139), гэж Ковалевскийн толийг (1888) дагаж бууруу орчуулсныг дурдаад хятад олон толь бичигт байгааг зааж, ялангуяа 21-тийн тайлбар толинд энэ шувууг тодорхойлон бичсэнийг энд гаргаж иш татсан байв. Гэхдээ «турамтай» (тавиг болдог жижиг шувууны нэр гэж (47, 313 [29]) бууруу орчуулсан шиг санагдах бөгөөд бидний бодлоор бол «торумтай» гэдэг нь энд шувуухайг хөөгч махчин шувууны нэр бөгөөд түүнд хөөгдсөн шувуухайг бутанд хоргоосонд тэр шувуухайг бут аварчээ гэсэн санааг гаргажээ. Энэ шувууны тухай Элдэндэй Ардажав нар илүү зөв тайлбарласан (8, 192) тул товчильё. Харин энэ үгийг «турумтай» биш торомтой буюу чухам зөв нь «торумтай» гэж сэргээх нь зөв болов уу гэж бодно. Учир нь Шагж энэ үгийг «у» үсэгт бус «о» үсэгт бүртгэсэн (12, 1938, 607), хоёрт, энэ үг эхэд «о» эгшгээр эхэлсэн үг байсны учраас хадмал хятад орчуулгад мөн «о»-гоор эхэлсэн «тор», «торомтог» (12, 607) гэсэн үгтэй эндүүрч «тор» гэж орчуулсан байх. Харин худам монгол бичигт «о»-гоор эхэлсэн үгэнд гол төлөв хойшид «-у» бичдэг заншилтай тул «торумтай» гэх нь илүү зөв байх. Түрэг хэлний дуудлагаар «турамтай» гэж зарим аялгуунд байсны баримт:

Турааны морь
Туруугүй
Турамтайн тал
Ногоогүй (ширээ) гэсэн монгол оньсого байдаг нь гэрчилнэ.

294. нунггасу-ту (унгаст) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс сэргээх ба утгыг ухаарах талаар тусгай тайлбар шаардахгүй. Харин «унгасуту» гэдгийг энд «нунггасу ту» гэж өөрөөр бичигдсэн учир шалтгааны тухайд гэвэл бид үүнийг худам монгол бичигт үгийн эхэнд орсон «н» авиа «а»-гийн төрлийн долоон эгшигтэй сэлгэдэг нэг сонин шинж байдгийг энэ үг гэрчилж байна. Нунггасу гэсэн үгийг Хэниш чухамхүү «нунггасу» (36, 120) гэж сэргээн «ноос» гэсэн үгээр хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Рахевильз (25, 33), Лигети (33, 41), Дашцэдэн (26, 34), Баяр (11, I, 182), Мансан (27, 53) нар «нунггасуту» гэж буулгасан нь илүү зөв гэж бодно. Гэтэл Пеллио «нонггасу-ту» гэж «о» аялгуугаар оруулсны дээр Элдэндэй Ардажав (8, 193) нар энэ үгийг «нонггасу-т-» гэж үзэж үүнийгээ хонины «ноос» гэсэн үгтэй нэг гаралтай гэжээ. «Унггарил» гэдэг улиасны үрийн ноос мэт хөвөнлөгт үрийг хэлдэг нь «унггасу» гэж бичихийн зөвийг батална. Нөгөө «ноос» гэдэг үг нь «нонггасутай» холбоогүй, харин ноорох гэсэн өөр үгнээс гаралтай болов уу? гэсэн санаа бидэнд төрүүлж байна.

295. нэнгжилдүй-э (нэгжилдъе)- гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «нэнгжилдүкү» гэж сэргээгээд хятад хадмал орчуулгын утгыг «өөр зураа нэвт шувт эрье» (36, 115) гэжээ. Үүнийг Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр, Мансан, Элдэндэй Ардажав (8, 194) нар цөм Пеллиог дагаж «нэнгжилэлдүй-э» гэж сэргээсэн байна.

Бидний бодвол энэ үг нэнгжи- (эрэх гэсэн утгатай үйл үгийн идэвхтэй язгуур, 1 үндэс) +лд (үйл үгийн үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл), -й-э (үйл үгийн үйлдэлдэх шийдэн хүсэх (1 биеийн) (төлөвийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг тул нэгжи-гэсэн үйл үгээс дахин -ла, -лэ дагавар залгаж үг бүтээх ёсгүйн дээр олон үйлдэх байдлын **+л** нөхцөл залгасан бол «нэнгжилүлдүй-э» гэж би-

чих ёстой тул уг эхийн буюу эсвэл галиглагчдын ташаарал байх гэж -лэ- гэсэн дагаврыг хасаж сэргээв.

296. нунггасун дотор-а [хэвтэксэн күмүн] хэр дагусаху ажуху. Сэткил-дүр-ийэн адил болтал эри (унгасан дотор хэвтсэн хүн хэр дуусах (тэсэх?). Сэтгэлдээ адил болтол эр.) -гэсэн энэ үгийн утга сайн авцалдахгүй тул бид Лувсанданзаны эхэд байсан зүйлс хятад галиг үсгийн эхэд орхигдсон бололтой гэж төсөөлөн нөхөж оруулсан үгсээ дөрвөлжин хаалтад хийж сийрүүлэв.

297. тэлэ хураган (тэлээ хурга) -гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш (36, 72, 146), Пеллио, Рахевильз (25, 34), Лигети, Дашцэдэн 26, 35), Баяр (11, 1, 186), Иринчин цөм «тэл хуриган» гэж сэргээн, Дамдинсүрэн (7, 50) («тэлэй» гэж алдаатай) Дугаржав (24, 33), Мансан (27, 54) тэргүүтэн цөм «тэлээ хурга» гэж зөв ойлгож орчуулсан байна. Хэниш, Пеллио, Рахевильз (49, 1971, 142) тэргүүтэн цөм хоёр эх хөхдөг хурга гэж тус тусын хэлэнд орчуулсан бололтой байна. Бид харин энд эртний (худам) монгол бичгийн үгэнд монгол хэлэнд урт эгшиг үүсээгүй үеийн бичлэгээр «тэлэ хураг-а» гэж бичигдсэн байсан гэж ийнхүү сэргээснээ зөв гэж бодно. Учир нь «тэлэ» гэсэн үг задгай үеэр төгссөн учир уртаар дуудагдсаар хожим «тэлэгэ» гэж бичигдэх болсны дээр «хуриган» гэсэн нь XIV зууны галигч нарын авиа дуудлагын гажилт гэж төсөөлөн бодов.

298. көкүгүр (хөхүүр) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 51.) Пеллио, Рахевильз Лигети нар «гө'үр» гэж, Дашцэдэн «кө[г]үр» гэж, Баяр «ко'ур ~ көкүр» гэж, Элдэндэй Ардажав (8, 196), Лувсанданзан (31, 1, 43) «көкүр» гэж, Дамдинсүрэн (7, 50) Мансан (27, 54), Дугаржав нар (24, 33) «көкүүр» гэж сэргээн бичсэнээс үзвэл сүүлчийнх нь хуучин (сонгодог) монгол бичигт энэ үгийг бичдэг зөв бичлэг нь болно.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш дээр дурдсан зохиолд «бага ширэн хөнөг (суулга)» гэж орчуулсан учир Пеллио (9, 139), Рахевильз Кливз (42, 28—29), Поуха (17, 35), Калужинский (61, 50) тус тус «жижиг арьсан хөнөг» гэж зөв орчуулсан бололтой байна.

Бид энэ үгийг худам (эртний) монгол бичигт урт эгшиг хоёр эгшиг үсэг давхарлан тэмдэглэх ёс байгаагүй учир хуучин (сонгодог) монгол бичигт «көкүүр» гэж бичдэг байсныг эртний монгол бичигт «көкүгүр» гэж бичдэг байснаар төсөөлөв. Учир нь энэ үг көкү-(малын дэлэн гэсэн утгатай үгийн идэвхтэй язгуур, мөн «көкүкү» гэсэн утгатай үйл үгийн II үндэс (12, 417)+гүр (көкүкү гэсэн утгатай үйл үгийн I үндэс (12,+гүр) хэрэглүүр гэсэн утгатай нэр үг үйл үгээс бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг мөн мэт тул ийнхүү сэргээх нь зөв гэхээс гадна хэрэв энэ үг «көкү+р» гэж үүссэн бол түүнийг хуучин монгол бичигт «көкүүр» гэж тэмдэглэх учиргүй, харин хоёр эгшгийн дундаас «г» сугарах журмаар урт эгшиг үүссэн гэж үзсэн юм.

299. нигсагалжатал-а (нягсгалзтал)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 117), Пеллио (9, 20), Рахевильз, Лигети, Баяр (11, 1, 192), Дашцэдэн (26, 36), Элдэндэй Ардажав (8, 201), Иринчин (28, 58), Дугаржав (24, 34) цөм «нихсахалзтала», «нигсахалзтал» (Дашцэдэн), «нигсагалзтала» (Баяр, Элдэндэй Ардажав, Дугаржав) гэх зэргээр сэргээжээ.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «сэгсчих, гуйвах, найгах» гэж тайлсан ба Элдэндэй Ардажав (8, 203) «нягт боловч эмхэмх замбараагүй болтол чичиргэнэх ачсан байдлыг заав» гэхийн хамт үгийн язгуур «ни-» -багшрах, сайхан овоорох, чихэлцэй бөөмнөрөх гэх зэргээр тайлбарлажээ.

Бидний санавал энэ үгийн язгуур нь «ни» биш «ниг-» (12, 211б) «чигжүгү» гэсэн утгатай (нэр үгийн үндэс)+са (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +галз (үйлийн байх болохыг үзүүлэх байдлын нөхцөл) гэсэн бүтэцтэй үг юм. Олон тарвага ийш тийш нягт шигүү «санжигинаж» гэсэн утгатай бололтой.

300. гүрүмэл-э (гүрмэл хүрмэл)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 53), «гүрүмэлэ» гэж сэргээснийг судлагчид цөм адилаар сэргээдэг билээ. Харин энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нэгэн сэргэлэн кэүкэн» (36, 53) гэж тайлжээ. Пеллио (9, 140), Дамдинсүрэн (7, 51) «гавшгай» гэж, Хэниш (15, 19), Рахевильз (49, 1971, 144) «цовоо сэргэлэн залуу» гэж, Элдэндэй Ардажав нар (8, 203—204) түрэг хэлний «көрүмлүк» «үзэсгэлэнт» гэдэг үгнээс үүсгэн бас мэдлэгтэй ухаантай гэсэн үг гэж тайлбарлав. Мансан «гоёмсог» хөвгүүн» гэжээ.

Бидний санавал энэ үг күрмэл (авхаалжтай цовоо) гэсэн утгатай үг болов уу гэж таамаглах боловч энэ үгийг хуучирч мартагдсан үг гэж бодож байна. Урианхайн захчин Чойсүрэн гуайн туульд «Ал-

тайн гурван гүрмэл хар уул нутагтайхан байдаг» гэсний дотор «гүрмэл» гэдэг «сайхан» гэсэн утгатай хэрэглэгджээ (45, 1).

301. энэ манагар (энэ өглөө) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «манагар» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг «дараах өдөр, дараах өглөө» гэж тайлсан тул уул үг «өглөө» гэсэн утгаар хэрэглэгдсэнийг энд тэмдэглэе. Энэ нь Герман хэлэнд «Morgen» гэж том үсгээр эхэлж бичсэн бол «өглөө» гэсэн эр үг нэр байдаг байтал «morgen» гэж багаар бичвэл «маргааш» гэсэн үг байдагтай адил болох нь сонирхолтой.

302. өбэрсү-бэн (өөрөө) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 121) «о'эсүн» гэж сэргээгээд «өөрөө» гэж хадмал хятад орчуулгын нь утгыг тайлсан нь эргэлзээгүй зөв орчуулга юм. Бусад судлагчид «ө'эсүн» «өбэсүн» гэж, Лувсанданзан (31, I, 44), Дамдинсүрэн (7, 51), Дугаржав (24, 34), Мансан (27, 55) нар «өбэр-ийэн» гэж тус тус орчуулсан буюу тайлбарласан байна. Энэ үгийн дэргэд хадсан хятад орчуулгын утгыг Хэниш «өөрөө» (36, 121) гэж тайлсныг Пеллио, Рахевильз, Кливз болон бусад цөм дагаж орчуулсан шиг санагдана.

Бид «өбэс-ийэн» гэдэг нь энэ төлөөний үгийн олон тооны хэлбэр учир энд ганц хүн Богурчийн тухайд өгүүлэгдэх учир өбэсүн өбэс-ийэн гэж байхгүй, энэ бол галилагч нарын ташаарал байх гэж бодож Лувсанданзаны эхийг зөв гэж баримтлан «өбэрсү-бэн» (өөрийн төлөөний үгийн заахын тийн ялгалын хэлбэрээр) сийрүүлэв.

303. намбуга сагулуга-бан (намбага суулагаа) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 113), Пеллио (9, 20), Лигети (33, 43), Баяр (11, I, 195), Дашцэдэн (26, 36), Элдэндэй Ардажав (8, 202), Иринчин нар «намбуха са'улуга (сагулуга)» гэж, нөгөө Лувсанданзан «амаг-а сагулаха-бан» гэж, Дамдинсүрэн (7, 51), Дугаржав (24, 34), Баяр нар хуучин (сонгодог) монгол бичгийн дүрмээр «намбуга сагулага» гэж тус тус сийрүүлж, Мансан ганцаар «намбуга сагулга» (27, 55) гэж бичсэн нь суулга гэдэг нь хуучин бичгийн ёсоор (12, 802) савын нэр биш өвчний нэр болж ташаарчээ.

Бид энэ үгийг худам монгол бичгийн эртний бичлэгээр «намбуг-а сагулуга» гэж сийрүүлэхийг зөв гэж сонгож ийнхүү сийрүүлсэн болно. Учир нь энэ үг сагу (суу гэсэн утгатай үгийн идэвхтэй язгуур, эс тусах үйл үгийн 1 үндэс) +л (үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +га (үйл үгээс нэр үг бүтээх дагавар)-бан (жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөл) учир хувилагч 22 үсгийн нэг болсон -га дагаврын өмнөх хувилагч -л үсэг хувирч лу-болох нь зөв юм. Сагул- гэсэн үг үйлдүүлэх хэвийн нөхцөлтэй үндэс нь хожим орхигдсон учир сагу (суу) үндэс дээр үг бүтээх -лага дагавар залгаж шинэ үг бүтээсэн гэж үзэж хуучин монгол бичгэт энэ үгийг ийнхүү бичдэг уламжлал гарчээ. Намбуга гэдэг үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «их ширэн хөнөг (тулам)» гэж орчуулсан нь зөв бөгөөд бүх орчуулагчид зөв орчуулсан юм. Нөгөө «күкүгүр» гэдгийг «бага ширэн тулам» гэдэг хөхөх хэрэглүүр буюу гүүг саах арьсан тулам «борви» гэсэн утгатай үг бололтой.

304. мунгтанижу (мунгинаж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «мунгтанижу» гэж сэргээгээд «бэрхшээл тохиолдох» гачигдал амсах» гэсэн үгээр тайлжээ. Олонхи судлагчид «бэрхшээл гачигдалд учирч» гэж орчуулсан нь ерөнхийдөө зөв болович «Эрийн мунг нэгэн биз ээ» гэсэн энэ үгийг Хэниш, Рахевильз нар «эр хүнд тохиолдох бэрхшээл ямагт (Хэниш) [булт (Рахевильз)] ийм байдаг» гэж, нөгөө Пеллио «эр хүний бэрхшээлийн нэг нь (өнөөдрийнх) энэ биз ээ» гэж орчуулснаас гадна Рахевильз «Чи бөрүн маш мунгтанижу айисун ажуху» гэснийг «Чи маш их бэрхшээлд учирсан учир надад ирсэн биз» гэж буруу орчуулсан байв. Үнэндээ «эрийн бэрхшээл [хэнд ч] нэгэн адил тохиолдож болно» гэсэн санааг ойлгосонгүй.

Энэ үгийг Элдэндэй Ардажав нар (8, 205—206, тайлбар № 13) түрэг хэлний зовох, зүдрэх, ядрах, тамирдах, алжаах гэсэн утгатай үгнээс үндэслэж тайлбарласан нь төдий л итгэмээргүй. Мунг гэдгийг Шагж гуай «мэдэхгүй чадахгүй будлих» (12, 726а) гэж тайлбарлажээ. Бас «мунгганин» луга адил» гэжээ.

Бидний бодвол «мунгганиху» гэдэг нь тусах үйл үг, «мунгтанихү» гэдэг нь эс тусах үг түл сүрхий ялгаатай. Энэ үг Мунг (бэрхшээл зовлон гэсэн утгатай үгийн идэвхтэй язгуур, нэр үгийн 1 үндэс) +та (мунд тохиолдох гэсэн утгатай бөгөөд нэр үгээс эс тусах үйл үг бүтээх дагавар) +ни (удаан үргэлжлэх утга илрүүлэх, үйл үгийн байдлын нөхцөл) +жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг болно. Энэ нь тогту-ни-ху, заг(а)-ту-ни-ху үгнүүдтэй ижил загвараар бүтжээ.

305. Наху байан (Наху баян) — гэсэн хүний нэрийг хятад үсгийн галигаас Хэниш «Нагу баййан» (36, 180), Пеллио «Наху байан» (9, 20) гэх зэргээр сэргээсний сүүлчийнх нь илүү ойр болов уу гэж бо-

дож байна. Наху байан гэсэн энэ хүний нэр зарим түүх бичигт **«Лаха байан»** (73, [28] 24) гэж гардаг бөгөөд бодвол авиа сэлгэлтийн хэлбэр байх. Гэвч энэ баян хүний (өвөлжөө, зуслан) нутаг байсан болов уу гэж бодмоор газар одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Лаху Баян гэж хоёр ч уулын нэр байдаг нь Хүлэг Богурчийн аавын нэрээр нэрлэгдсэн газар байх гэж бодогдоно. Учир нь Хангар ханы зүүн талын шувтарга болох Наху гүн (хан?) гэдэг уулын дээрээс Найманы Даян хан Жамухатай хамт зогсож байгаад Чингис хааны хушууч баатруудын довтлон ирж байгааг ажиглаж, ярилцаж байсан гэж Нууц товчооны 95 дугаар зүйлд гардаг нь мөн энэнхүү Лаху (хан) уулыг нэрлэсэн болов уу гэж санах бөгөөд энэ Лах (у) Баян уулсыг Наху гүн (буюу хан) уулын нэр мөн гэж Х. Пэрлээ (74, 5) олж тэмдэглэсэн юм.

306. Богурчи (хүний нэр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «Бо'орчу» (36, 173 б) гэж сэргээн бичсэн нь бидний бодоход XIV зууны галиглагч нарын ташаа дуудлага мөн гэж бодно. Үүнийг судлагчид их төлөв Хэнишийг дагаж энэ нэрийг ингэж сэргээдэг боловч угтаа энэ багурчи (тогооч) гэсэн үг байгаад гуйвуулагдаж **«Богурчи» гэж нэрлэгдэх** болсон байж магадгүй юм. Юу ч болсон эртний худам монгол бичигт үгийн нэгдүгээр үед «а, о» орсон бол түүний дараа их төлөв «у» эгшиг ордог ёс байсан тул **«Богорчу»** биш «Богурчи» эсвэл бүр «Багурчи» байх нь зөв гэж болно. Гэхдээ бид Богурчи ноёныг угаасаа Багурчи («тогооч») нэртэй хүн байсан байх гэж бодно. Учир нь тэр хүн ажил мэргэжлийн нэртэй байсан учраас «Чингисийн цадиг» (5, 139) зэрэг эртний түүх бичигт **«Богурчи»** гэж бичиж байсан байх гэж бодно. Тийм биш бол XIV зууны галигч нар шиг «Богурчу» гэж бичих байсан гэж бодно.

307. шарга агтатан тэд буй (шарга агттан тэд буй) гэсэн энэ оруулбар өгүүлбэрийн үгийг сэргээн сийрүүлэх болон утгыг ойлгох талаар судлагчдад **гойдын зөрөөтэй санал ба бэрхшээл байхгүй боловч хэл зүй,** найруулгын талаар дараах үеийн монгол хэл ба бичгийн найруулгаас ялгарах хэд хэдэн тэмдэглүүштэй онцлог буй. Үүнд нэгд, орчин цагийн монгол бичгийн найруулгад бараг байдаггүй жинхэнэ оруулбар өгүүлбэр Нууц товчоонд олон байдгийн нэг нь энэ болно. **«Би... үлдэж гаргасугай»** гэсэн өөр өгүүлбэрийн дотор энэ өгүүлбэрийг **оруулсан онцлогтой.** Хоёрт, «агта тан» гэдэг үг бол угтаа «агтнууд бүхүй» гэсэн хүртээл нэрийн олон тооны хэлбэр байгаа боловч агт бүхүй хүн биш морьд гэсэн утгатайгаар хэрэглэгдсэн нь сонин. Агт тан гэсэн энэ үгийг Элдэндэй Ардажав нар (8, 162) хааны агтыг онцлох, хүндэтгэлийн тан гэж «Хорин нэгт тайлбар» толь бичгийн тайлбарт заасан ба «-тан» гэснийг хамтрах нэр үгийн дагавар» гэжээ. Бидний санавал энд «-тан» нь хамтрахын тийн ялгалын залгавар бус үг юмыг эзэмшигчийн нэрийг заах харьцангуй нэр үг бүтээх дагавар мөн бөгөөд энд агт бүхүй буюу **засагдсан гэсэн шинжийг эзэмшсэн морьд гэсэн утгатай оржээ.**

Гуравт, «агта тан» (агттай гэдэг үгийн олон тооны хэлбэр) нь «морьд» гэдэг олон тоот үгтэйгээ тооны зохицолтой, морьд гэдэг нь «тэр» гэдэг үгийн олон тооны хэлбэр болох «тэд» гэдэг үгтэйгээ бас тооны зохицолтой бичигдсэн нь эртний монгол хэлэнд байсан бөгөөд хожмын монгол хэлэнд мартагдсан (алга болсон) хэл зүйн нэг үзэгдэл болно.

308. огург-а (уурга) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «угурга» гэж сэргээн түүний хадмал хятад орчуулгын утгыг **«бугуйлт мод»** «барих гогцоот мод» (36, 160) гэж тайлжээ. Энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «үрг-а» (12, 141) гэж бичдэг уламжлалтай. Энэ «огург-а» гэсэн үгийг зарим хүн «урах-а» (цалам) (12, 137) гэсэн үгнээс гаралтай байх гэж таамагладаг боловч бид энд Нууц товчоонд тэмдэглэгдсэнээс үзвэл огорг-а орхих юм гэсэн үгнээс үүссэн «огург-а» (буюу орхих юм) гэсэн үг байж магадгүй гэж таамаглаж, «о» ба **«у»** эгшгийн дундаас шүргэх «г» гийгүүлэгч сугарч, эхний о нь дараах **«у»** эгшигтэй ижилсэн «уурга» гэж дуудагдах болсон болов уу гэж сананам.

309. тэгүшин (түүшин ~ хүүш) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «дү'үшин» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг **«бүрэнхий болох» «харанхуй болох» гэж тайлжээ.** Ихэнх судлагчид бүрэнхий харанхуй болж гэж орчуулдаг байна. Элдэндэй Ардажав нар (8, 210, тайлбар № 7) төвд монгол толь «бору дүгүшин» гэж барүй бүрий гэсэн утгатай. Эрдэнийн товчид «дүгүши» (бүрэнхий) гэж байгааг дурджээ. Тэгэвч бидэнд энэ мэт эртний мартагдсан үгийг аль нэг нутгийн аялгуунд үлдэж хоцорсон адил дуудлагатай үгийг олж утга холбогдлыг нь олж тогтоохоос гадна тэр үг хэлний хөгжлийн явцад хувирч өөр хэлбэртэй болсныг нь олж тогтоохыг бас чухалчилбал зохих тул «нар авд тусахгүй газар» (12, 363а) байнга сүүдэртэй (бүрэнхий) байдаг гэсэн утгатай кэүши (хүүш) гэдэг үг энэ үгээс

гаралтай байж магадгүй гэсэн санал гаргаж, хэрэв тийм бол «дүгүшин» буюу «тэгүшин» гэж галиглавал зохихыг XIV зууны галиглагчид тэр үеийн гуйвагдсан аялгаар «дүгүшин» гэж галигласан биш байгаа гэж сэжиглэнэ. «Кэүши» гэж хуучин монгол бичгээр бичдэг үгийг урт эгшиг гараагүй агсан худам (эрт язгуурын) монгол бичигт «кэгүши» гэж бичиж байсан гэж бодох үндэстэй. Иймээс бид «түгүшин ~ тэгүшин» гэж сийрүүлэв. Түгүшин буюу дүгүшин гэж бичдэг нь монгол хэлэнд үгийн эгшиг уруулын байдлаар зохицох ёс гарснаас хойших үеийн бичлэг гэж бодогдоно.

310. баруган болтажу (бараа болгогдож) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «бару'ан болтаху» гэж сэргээн бичээд «гэнэт харанхуй болж» (36, 13) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Хэниш «бүрэнхий тулж ирж» (15, 19), Пеллио «сүүдэр болгож» (9, 141) гэж, Рахевильз «харанхуйд гүйцэгдэн» (49, 1971, 144) гэх зэргээр орчуулжээ. Элдэндэй Ардажав нар «бараан өнгө» (8, 210) гэжээ. Дамдинсүрэн (7, 52), Мансан (27, 56) «бүрэнхий болсон тул» гэж «баруган болтажу» гэдгийг орхисон байна. Дугаржав нар хойноос ирсэн тэдгээр хүмүүс «бараан болж» (24, 35) гэж орчуулжээ.

Бидний бодоход нэхэгч хүмүүс «бараа сүүдэр төдий харагдах» гэсэн утгатай үг бөгөөд бараг бөрөг сүүдэр дүрс гэсэн үг. бар-а (бараа) гэсэн үгнээс бус, харин «баруй бүрүй» гэдэг үгэнд -га дагавар залгаж үүсдэг байсан бололтой. Учир нь нэгэнт дүүшин (бүрэнхий) болж гэсэн үг байгаа тул баруган гэдэг дахин «харанхуй болгодож» гэсэн үг байж болохгүй, харин бүрэнхийд хоцорч холдохын хирээр «баруг» буюу баргар бүдэг дүрс болж харагдаж хоцорсон гэсэн үг **бололтой.**

311. жабхажу (алдаж — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «забгагу» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «алдах, олохгүй болх» гэж зөв тайлжээ. Пеллио (9, 21) энэ үгийг «жабхажу» гэж сийрүүлсэн нь **Хэнишийнхээс илүү зөв учир хойшид судлагчид** их төлөв ийнхүү сийрүүлжээ. Бид энд «забхажу» гэсэн үгийг орчин цагийн монгол хэлэнд мартагдсан «завхах» гэдэг тусах үйл үгийн үндсээр нь ийнхүү хэрэглэсэн онцлогийг зөвхөн тэмдэглэх гэсэн болно. Одоогийн монгол хэлэнд энэ үгийг завхар-гэсэн эс тусах үүсмэл үндсээр нь хэрэглэдэг бөгөөд завха гэсэн үгийн идэвхгүй үндэс дээр -ай дагавар залгаж завхай гэсэн тэмдэг нэр үүсгэж хэрэглэдэг удаа бий. Энэ үгнээс бас «б» авиа нь «м» авиагаар солигдож «замхарах» гэдэг үг үүссэн нь сарних, алга болох гэсэн утгатай тул «завхах» гэсэн утга нь халх аялгуунд бараг мартагдаж буйг тэмдэглэе. Энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав (8, 213) нар зөв зүйтэй тайлбарласан билээ.

312. намбуга дэгүргэ (хөхүүр) дүүрэг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «дэ'үргэ» гэж сэргээж, хадмал хятад орчуулгыг «моринд ачих ачаа» (36, 36) гэсэнтэй Пеллио (9, 142) Рахевильз (49, 1971, 144—145), Кливз (42, 31) цөм ойролцоо утгаар орчуулсан байна. Монгол хэлтэн судлагчдад хоёр үгийн утга илэрхий тул Дамдинсүрэн ганзагын тулам (7, 52), Мансан (27, 57), Дугаржав «хөхүүрт умд хийж дүүрэг засч» (24, 36) цөм «дэгүргэ» гэж хэвээр бичсэн ба энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав (8, 214, тайлбар № 10) зөв зүйтэй тайлбарлажээ.

Бидний бодоход энэ «намбуга дэгүргэ» гэсэн үгийн намбуга гэдэг нь дээр хадмал хятад орчуулгад хэлсний адил «том ширэн тулам» байгаагүй, харин унасан моринд ганзалан авч явж болох багашиг сав байсан учир одоогийн халхчуудын «борви» гэдэгтэй утга илүү дүйх болов уу гэж бодно. Харин «хөхүүр» нь одоогийн хөхүүрийг бодвол нэг хувин хоногийн хэмжээтэй бага сав байж адуун дээр гүү саахад хэрэглэх сав байсан бололтой.

313. бү тэбчилдүткүн (бүү тэвчилдэгтүн) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «тэбчилдүкү» гэж сэргээн бичээд «хоёр талаас (бие биеэ) харилцан орхилдох» гэж хадмал хятад орчуулгыг тайлжээ. Энэ нь зөв юм. Судлагчид ч ийм утгаар орчуулсан буюу ойлгож тайлбарсан байна.

Энд бид бүү гэдэг үгийг Пеллио тэргүүтэн судлагчид цөм «бү» гэж богиноор бичсэн нь эртний худам монгол бичигт уул үгийг ингэж бичиж байсныг гэрчилж буйн дээр тэр үед энэ бол хориглох сул үг биш, хориглох үйл үг байсан гэдгийг тэмдэглэе. Жич «тэбчилдүткүн» гэдэг үгэнд байгаа «т» ба «к» авиа байраа сольж «тэбчилдүктүн» гэж хожим хэрэглэгдэх болжээ гэж бодож байна. Тэгэхдээ «тэвчилдүт» гэдгийн «т» нь олон тооны цөхцөл «-күн» гэдэг нь үйлт нэрийн «-күй» гэдгийн олон тоот нь болно.

314. эрүжу (зовниж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «эрүсгү» (36, 46) гэж буулгаад «гашуудал болж байна» (15, 20) гэж орчуулсан байна. Пеллио «гуниж» (9, 142), Рахевильз «шаналж» (49, 1971, 145), Поуха «гайхаш тасран» (17, 37), Кливз «сэтгэл түгшиж» (42, 34) гэхчлэн орчуулжээ. Дамдинсүрэн «зовнил» (7, 52),

Дугаржав «санаа зовж» гэж, Мансан «зовж байснаа» (27, 57), Элдэндэй Ардажав «зовж, гуниглаж сэтгэл зовж» (8, 215, тайлбар № 14) гэж тайлбарлаад олон жишээ гаргажээ.

Бид энэ үгийг эрү + (шаналах, тарчлах гэсэн утгатай үгийн язгуур, эс тусах үйл үгийн 1 үндэс) +жү (нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үйл үг гэж үзэв. Эрү гэсэн үндэс дээр с залгаж бусдыг «зовоох дайлах» гэсэн тусах үйл үг үүсгэх ба бас түүн дээр «-т» залгаж «эрүсдэкү» үйлд өртсөнийг илтгэх эс тусах үг үүсдэг байна.

315. Оруг жол нугу-д-ача (Орог зол нугаас) — гэсэн энэ газрын нэрийг хятад галиг үсгээс Пеллио **«Ураг жөл ну-дача» (9, 21), Лигети** (33, 45), Рахевильз (25, 37) Дашцэдэн (26, 39) Мансан (27, 57) нар «ураг чөл ну-дача» гэж, Баяр «ураг чөл нугу-дача» (11, 212), Иринчин (28, 62), Дугаржав (24, 37) «Ураг чөл нугу-дача», Дамдинсүрэн «Ураг чөл» (7, 53) гэж янз янзаар сэргээжээ.

Бид Ураг биш «Оруг» (ухаа) жол (зол) нугу-д-ача» гэж сэргээхдээ: Нэгд, Лувсанданзан (31, I, 47), **«Жол» гэж бичсэн тул түүний худам** монгол бичгийн эхэд ингэж бичигдсэн учраас байж болно гэж бодов. **Нөгөө талаар «чөл» гэдэг өвс ургамал юу ч үгүй элсэн бөөрөг нутгийг** хэлэх ба өвс ногоо ургасан, их голын хаялга тохой газрыг «нугу» гэж хэлэх учир «цөл нуга» гэж боломгүй санагдах тул цөл биш зол байх гэж сийрүүлснээ тэмдэглэе.

316. [марийан халугун болжу] (бие халуурч) — гэсэн эдгээр үгс Нууц товчооны хятад галиг үсгийн эхэд байхгүй боловч Лувсанданзанд байсан худам монгол бичгийн эхэд эдгээр үгс байсан учраас «Алтан товчид» зохиогч нь уг хуучин эхээс хуулж оруулсан болов уу гэж бодож үүнийг нөхөж оруулан, дөрвөлжин хаалтад бичив. Энэ нь уг эхэд заавал байх ёстой зүйл. Учир нь Дай цэцэн охиноо хүргэний овогт өөрөө биеэр хүргэж өгөхгүй байгаа нь үнэхээр охиноо татарт **хүргэн өгч баригдсан Амбагай** хааны цээрлэл болгосон **цээрийг цээрлэж байгаа тул түүнд очихгүй буцах** нэг шалтгаан **эс гэхэд ядаж** нэг ноцтой шалтаг бодож олох хэрэгтэй байсан **тул «марийан халуун** болжу» буцах шалтаг олжээ гэж бодож байна. (48, 40Б)

317. бөгтүр (бөгтүр?) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн тэмдгээс Хэниш «Бөкөтүр (бөгөтүр)» гэж сэргээгээд хадмал хятад **орчуулгын утгыг «бөгтөр нуруутай» гэж тайлсан нь зөв юм. Иймд** Пеллио, Рахевильз, Кливз тэргүүтэн Өрнөдийн эрдэмтэн судлаачид үүнтэй ойролцоо утгаар орчуулсан нь илэрхий. Бас монгол судлагч Баяр, Элдэндэй Ардажав, Дашцэдэн, Иринчин цөм хятад галиг үсгийг дагаж «бөкөтүр» гэж буулгаад Баяр, Дамдинсүрэн нар хуучин «сонгодог) бичгийн хэлбэрээр бөгэтүр гэж, Мансан Дугаржав нар сүүлийн үеийн ярианы дуудлагаар «бөгтүр» гэж бичсэн юм.

Бид энэ үгийн хувьд худам ба хуучин монгол бичгийн бичлэг адил байх болов уу гэж «бөгэтүр» гэж сийрүүлэв. Гэвч энэ үгийн язгуур «бөгэ- (бөг бөг цогих гэх мэт дайвар үгийн 1 үндэс) +т- (бөгтийх гэсэн утгатай эс тусах үйл үг, нэр ба дайвар үг, сул үгнээс үйл үг бүтээх дагавар) +р (үйл үг, дайвар үгнээс тэмдэг нэр бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг бөгөөд үүний утга бөгтөргө сайтай морь (сайн морины шинж) тул доожоо муутай харагдавч хатуужил чадал сайтай холч морь гэсэн утгатай гэж бодно. Бөг- гэсэн үндэснээс «бөгсэ», **«бөгсэ»** (Бөжин туулайн бөгөө шиг, бөгтөр чонын цогио шиг (зэрэглээ) гэсэн оньсого бий) «бөгэ» (шагайн хонин талаар буюу бөгтөр нь дээш туссаны нэр) гэх «бөгтүргэ» (морины нуруу урагш бөхгөр үчир мундаа нь өндөр) гэх зэргээр олон үг үүснэ Харин «бөхү» гэдэг үгтэй хутгаж үл болно.

318. өрмүгэ (өрмөг) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш тэргүүтэн цөм «өрмүгэ» гэж сэргээдэг бөгөөд харин хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «Ноосон цамц» (36, 126) гэж тайлаад «эсгий нөмрөг» (15, 21) гэж, Пеллио «хөх ноосон цамцтай» (9, 142), Рахевильз «бүдүүн нэхмэл хүрэм» (49, 1971, 145), Кливз «Бор ноосон пальто (гадуур хувцас)» (42, 32) гэх мэт элдвээр орчуулж байжээ. Энэ үгийн утга монгол хүн бүрт бараг тайлбарлалтгүй тул Дамдинсүрэн «Бор өрмөг (хэвнэг)» (7, 53), Мансан Дугаржав Баяр тэргүүтэн цөм «бор өрмөг» гэж бичиж Элдэндэй Ардажав (8, 129) энэ **үгийн утгыг дэлгэрэнгүй тайлбарлажээ.**

Энд бид «өрмүгэ» гэдэг нь эртний (худам) монгол бичигт, «өрмүг» гэдэг нь хуучин (сонгодог) монгол бичигт хэрэглэгдэж байсан бичлэг нь байх гэж үзэв. Жич «Өрмөг» гэдэг нь «ноосон гар нэхмэл» эдийн нэр бөгөөд эдийн нэрээр нь «хэвнэг» (нөмрөг) гэснийг төлөөлүүлж хэлсэн нь «МНТ»-ы найруулгын нэг онцлог мөн болохыг давтан тэмдэглэх гэсэн билээ.

319. Бурги эрги (бурги эрэг) — гэсэн энэ газрын нэрийг хятад үсгийн галигаас нь зарим нь **«Бурги эрги»** (Хэниш 36, 174) зарим нь «Бүрги эрги» (Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дамдинсүрэн цөм)

гэж сэргээдэг байна. Элдэндэй Ардажав Х. Пэрлээн тайлбар зэргийг иш татаад эцэст нь «Бүрги эрги гэгч шаварт голын эргийг заав» (8, 222) гэжээ.

Бид үүнийг утгын зүйн үүднээс Хэнишийн сэргээснийг баримтлахдаа «бурги, борги» гэх мэт ус булгийн нэртэй холбоотой эрги (эрэг) гэсэн нэр байх гэж бодно.

320. Шитүгүл (шүтгэл) — гэсэн энэ үгийг судлагчид хятад галиг үсгээс нь Хэниш «шиткүл» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг нь «хадам эхэд айлчилсны бэлэг» гэж тайлжээ. Судлагчид бүгд энэ тайлбарын дагуу орчуулж ойлгож Элдэндэй Ардажав нар (8, 222—223) тайлбарласны дотор хорчны «сэбэд» гэдэг үгтэй холбож, бас Шинжаанаас олдсон модон барын хуанлийн 7 дугаар зурваст «мод шиткүбэсү» гэсэн үгтэй холбож нэг гаралтай гэж тайлбарлажээ. Үүнийг Пеллио «Чотан эхийн бэлэг» (9, 144) гэж орчуулсныг Мостарт (47, 314—316 [30—32]) буруу гэж, нөгөө Козины «Чотан [хадам] эхийн бэлэг гэж авчирсан» (14, 97) гэж орчуулсныг зөв гэж энэ утгаар өөрөө орчуулсан билээ.

Гэтэл бидний бодоход энд Пеллиогийн орчуулга зөв байх. Учир нь монголын олон үлгэрт (Жишээ нь: 75, 61) эрт балар цагт монголчуудаас харь овогт бэр болж очсон бүсгүй өөрийн овог эхийн сахиус (шүтгүл) болсон мод тарьмал, мал адгуус авч очсоноор гардаг бөгөөд түүнийг нь харь (нөхрийн) овгийн хар санаатан утсгах гэж оролдох боловч тэр нь эзнээ ид шидийн хүчээр аварч хамгаалсан үлгэрийн нэг зүйл сэдэл байдгаас үндэслэж бид үүнийг «шитүгүл» гэсэн үг, тэгэхдээ Чотан эхийн «шитүгүл» гэж авчирсан гэж уг эхэд байгаа нь хятад хадмалд дурдсанчилан хадамд золгохын бэлэг биш, охиндоо харь овогт амьдрахад нь эхийн нь «шитүгүл» -(сахиулсан) болгож өгсөн бэлэг байх гэж бодов. «Мод шиткүбэсү» гэсэн үг нь шитүгүл» гэж мод суулгах ёс бас байсны гэрч бөгөөд энд «шитгүбэсү» гэсэн үг нь «шигитүгбэсү» гэсэн өөр үгийн үе авиа солигдлын жишээ байж магадгүй гэж бид бодож байна.

321. булаган даху (булган дах) — гэсэн үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «булуган» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг «булга» гэж тайлжээ. Энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт ямагт «булаган» гэж бичдэг уламжлалтайн дээр эртний (худам) монгол бичигт үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс гаргаагүй байсан тул «булаган» гэж бичигдэж байсан болов уу гэхийн дээр «булуган» гэж бичсэн нь XIV зууны галиглагч нарын аялгууны гажилт мөн байх гэж бодож ингэж сийрүүлэв.

322. Унг хан (Ван хан) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «Онг (өнг)» гэж сэргээгээд «Ван, тэргүүлэгч, Хун тайж» гэсэн утгатай гэж хадмал хятад орчуулгыг тайлжээ. Энэ үгийг эртний худам монгол бичигт хөндий «в» үсэг хэрэглэж байгаагүй учир Ван гэсэн үгийг «Унг» буюу эсвэл «Үнг» гэж бичиж байсан биз гэж санаж ийнхүү сийрүүлэв. Учир нь үгийн дунд ихэд уруулшсан «у, ү» авиагаар «б» бичигдсэн үсгийг орлуулж бичсэн нь «МНТ»-д цөөнгүй, «Болбасу» гэхийг «болуасу» гэнэ. Иймд Ван гэсэн үгийг «Онг» (Өнг) гэж хятад галиг үсэгт тэмдэглэсэн нь тэр үеийн аман аялгууны нөлөө бөгөөд төдий л зөв гэх аргагүй мэт. Баяр энэ үгийг «йанг» (11, 216) гэж хятад галигаас сэргээсэн нь сонирхолтой зүйл бөгөөд энэ мэтийн авиа үсгийг худам монгол бичигт тэмдэглэх өөр аргыг үзүүлсэн баримт болно.

323. анда (анд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «анда» (36, 7) гэж сэргээн сийрүүлээд хадмал хятад үгийг утгыг «тангаргийн нөхөрлөлтөн, найз нар» гэж тайлжээ. Элдэндэй Ардажав нар мөн энэ утгаар хорин нэгт тайлбар толь зааж «нөхөр болгож үзэхийг анд гэнэ» гэж тайлбарлажээ.

Бидний бодвол энэ маш эрт цагийн хоёр овгийн хоорондын эдийн засгийн харилцааны ёсыг тусгасан үг бөгөөд Тэмүжин, Жамуха хоёр гурван удаа «анда» бололцохдоо тухай бүрд (шагай, сум, морь ба алтан бүс) солилцон бэлэглэснээр өгүүлэгдэж байгаа нь эрт цагийн хоёр овог ард түмний эдийн засгийн харилцаа солилцооны холбоноос гаралтай ёс байсны үлдэгдэл тэмдэг мөн. Маш эрт цагт нүүдэлчин аймаг өөрийн мал аж ахуйгаас гарсан мах сүү арьс ширийг хот суурин газрын иргэний ойролцоо голын эрэг дээр аваачаад овоолж орхиход тэр тосгон суурины хүмүүс гар урлалын бүтээл ёрог бүс, тогоо шанага зэрэг зүйлийг оронд нь аваачиж тавиад үг авчирсан юмыг авч хэрэглэдэг. Ингэж эдийн засгийн харилцаа аралжааны худалдаа үүссэн гэдэг бөгөөд чухам үүнээс «анда» гэдэг монгол үг үүсэлтэй болов уу гэж таамаглаж байна. Учир нь III биеийн төлөөний үгийн ан[а] гэсэн үндсэнд өгөх орших тийн ялгалын +«-а» нөхцөл залгахад хоёр «а» эгшгийг салгаж дуудахын эрхэнд «ана-д-а» (тэдэнд) гэж үг үүсч

хожим 2 дугаар «а» нь балархайшин хаягдаж «анда» (тэдэнд гэж эчнээ худалдааныхаа найз нарт зориулан юм орхихыг нэрлэдэг байснаас «анда» гэдэг эдийн холбооны нөхөр найз гэсэн утгатай үг үүссэн гэж төсөөлнө. Үүнийг «МНТ»-ы 117 дугаар зүйлд «Анда күмүн амин никэн» гэсэн эртний цэцэн үг давхар баталж буй. Учир нь энд «амин» гэдэг нь «аж төрөл амьжиргаа» гэсэн утгаар хэрэглэгдсэн юм. Энэ үгийн талаар бид урьд өөр өгүүлэл (76, 13) ба номд (77, 199) тайлбарласан тул энд хэмнэе.

324. гэргэй багулжу (гэргий буулгаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш «бао'улху» гэж сэргээн сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг нь «гэргий богтлох, авах» (36, 12) гэж зөв зүйтэй гаргаж тайлсан ба судлагчид цөм ингэж ойлгон орчуулжээ. Монгол хэлтэн судлагчид Дашцэдэн (26, 40), Баяр (11, I, 217) Элдэндэй Ардажав (8, 221) тэргүүтэн цөм «гэргэй багулжу» гэж сэргээн сийрүүлснийг зөв гэж баримтлав. Элдэндэй Ардажав нар (8, 224) энэ үгийг тайлбарлахдаа Кобаяси Такасиро-гийн «шинэ бэрийг мориноос буулгаж, хувцасаа тайлж авчраад өргөв» гэж буруу орчуулсныг шүүмжлээд энэ үг энд гэргий авах (багулгаху) гэсэн түсгай үг гэж тайлбарлажээ.
Бидний бодлоор бол гэргийг буур хөллөсөн харуутай тэргээр гэртээ аваачдаг эртний тусгай заншил (60, 159—164) байсан тул бодвол тэргэнээс нь буулгаж авах гэсэн санаагаар бэр буулгах гэдэг байсан болов уу гэж бодно.

325. Бокир-ун бөксэ-дүр, чэгэр-үн чэгэжи-дүр (Бохирын [муугийн] бөгсөнд, цэврийн [сайны] цээжинд атугай) — гэсэн энэ хэвшмэл хэллэгийг хятад галиг үсгээс нь Хэниш «Бохорай-йин бөксэ-түр, чэкэраййин чэ'эжи-дүр атугай» (36, 17) гэж сийрүүлж хадмал хятад орчуулгын нь утгыг «Би зүрхэндээ (сэтгэлдээ) ямагт бодож байх болно». гэж тайлжээ. Үүнийг Пеллио [Энэ бодол] бөөрний минь буланд, цээжний минь өрцөд орштугай» (9, 143) гэж, Рахевильз «Бөөрний газар бөксөнд, сайн итгэл цээжинд байх ёстой» (49, 1971, 146) гэж, Кливз «миний амлалт «Бөөрний минь ёроолд, цээжний минь өрцөнд байг!» (42, 33) гэж өрнөдийн судлагч нар орчуулсан бололтой байна. Дамдинсүрэн энэ үгийг бөөр нь бөксөнд цээр нь цээжинд байг (ах захтай байг) гэх буюу Элдэндэй Ардажав нар (8, 225, тайлбар № 10, 11, 12) түрэг хэлний гаралтай үгээр чэгэр-э гэснийг хадмалд «цээж» гэж орчуулсныг буруу гэж түрэг хэлний «чыкыр-хяхнах, хахинан, дуугарах» гэсэн үг гэж бокэр-э гэдгийг түрэг, хэлний «бөгтийх, бөгцгөр» гэсэн үг гэж хятад хадмал орчуулгад «бөгэр» (бөөр) гэсэн нь ташаа болно гээд «Бөгтөр болсон бү(к)сэ дотор минь, шуугиан гаргах цээж дотор минь бат сийлэгдтүгэй» (8, 225) гэж тайлбарлажээ.

Бидний бодлоор бол энэ өвөрмөц хэллэг бохир (муу) ину бөксэ-дүр (сүүлд), цэбэр (сайин) ин [у] чэгэжи-дүр (эхэнд) атугай (байтугай) гэсэн үг байсныг хятад галигч ба хадмал орчуулга үйлдэгч нар ойлголгүй «бокир» гэдгийг «бөгэрэ» гэж буруу уншиж, буруу галигласан ба ташаа орчуулжээ. Бид «чэгэр» гэдэг «чэбэр» гэдгийн авиа сэлгэлтийн өөр хэлбэр гэж бодож байна. Учир нь хуучин монгол бичигт «чэгэр» — явдал ариун мэтийн» (12, 752а) гэсэн утгаар хэрэглэгдэж иржээ. Энэ нь дэгэл～дэбэл (дээл) гэдгийн адил авиа сэлгэлтийн загвараар бичигдсэн бололтой тул бид «чэбэр» гэж ухаарч байна. Иймд энэ нь Ун хан Тэмүжиний талаар муу юм хийхийг азнаж сайн юм хийхийг урьдал болгоно гэсэн санаатай «бохир нь бөгсөнд, цэвэр нь цээжинд» гэсэн үг гэж ойлгож тайлбарлав.

326. көгэргэ-бэн (хөөргөө) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «кү'үргэ(=гүрэгэ)» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг «хийн гүүшин татуургэ» «хөөрөг (хийт тулам)» (34, 105) гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 21), Кливз (42, 33), Пеллио (9, 143, Рахевильз (49, 146) Поуха (17, 38) нар «дархны хөөргөө үүрч» гэж Калужинский «дархны хөөрөг мөрлөж» (61, 53) гэж орчуулсан шиг санагдана.

Монгол судлагч Баяр (11, I, 221), Иринчин (28, 64), Элдэндэй Ардажав (8, 226) хятад үсгийн галигийг дагуулж «көгүргэ» гэж арай ташаа сэргээсэн боловч цөм «хөгэргэ» буюу дархны хөөрөг гэж зөв ойлгосон юм. Дамдинсүрэн (7, 54), Дугаржав (24, 38), Мансан (27, 58) цөм «хөгэргэ» гэж бичсэн нь хятад галигаас илүү зөв сэргээн бичсэн шиг бидэнд санагдана.

Учир нь бидний бодлоор бол энэ «көгэргэ» гэдэг үг галыг дээш бадраах гэсэн утгатайн хувьд «көгэрэх хөгжихү» гэх мэт үгтэй гарал үүсэл язгуур нэгтэйн хувьд ингэж худам монгол бичигт бичигдэж байсан нь лавтай. Харин «күгүргэ» гэж бичвэл хэнгэрэг хүүргэ гэдэг өөр үг болох тул хятад галигт монгол үгийн эгшиг уруулаар зохицох ёс

гарснаас хойших XIV зууны үеийн монгол хэл аялгууны хожмын нөлөөгөөр буруу хазгай тэмдэглэгдсэн байж болохыг гэрчилнэ.

327. Нэл[көл]кэй нялхөлкэй [?] нялха-ай [?])-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «нэлкэ» (36, 114) гэж сийрүүлээд түүний хадмал хятад орчуулгын утгыг «нялх хүүхдийг өлгийдөх ороолт булган өлгий» гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш «булган өлгийвч» (15, 21) гэж орчуулсан мэт. Пеллио «нэлкэй» (9, 22) гэж сийрүүлээд өлгийвч (9, 143) гэж, Рахевильз (25, № 4, 1971, 146), Кливз (42, 33) Поуха (17, 38), Калужинский (61, 53) нар ерөнхийдөө хүүхэд өлгийдөх булган жихэвч өлгийн давуу» гэж орчуулсан бололтой. Өвөр монголын судлагч Баяр (11, I, 222), Элдэндэй Ардажав (8, 226), Мансан (27, 59 болон 71) **тэргүүтэн цөм «нэлкэй ~ нэлкэ»** гэх мэтээр сийрүүлж, «жихэвч хүүхдийн хучлага» гэх чилэн орчуулж Барга дагуурын хэл аялгуунд дайралдах төстэй үгийг заажээ. Гагцхүү Лувсанданзан «өлигэй» (31, I, 49) гэж Дамдинсүрэн «өлүгэй» гэж бидний бодлоор хамгийн зөвөөр ойлгож буулгасан буюу орчуулсан мэт.

Бидний санавал энэ үг худам монгол бичгийн үг эхэд «[н]элгэй» (элүгий) буюу эсвэл «[н]элгүгэй» (өлгий) гэж бичигдсэн үг байсныг галиглагчид XIV зууны аялгуугаараа хазгай дуудаж, ташаа тэмдэглэсэн байж болох юм. Үүнд нэгд өмнөх «булаган» гэсэн үгийн эцсийн «н» авиаг сунжруулан «булаган -[н] элкэй» гэж илүү «н» авиатай тэмдэглэсэн байх. Энэ нь эбэсүн -[н] эмбүлэ гэсэн үгийг тэмдэглэсэнтэй адилаар ташаарсан болно. Тийм гэж бодвол энэ үг арьсны үеийг хусах гэсэн утгатай «элүкү» (12, 85б) гэсэн үйл үгийн «элү-» гэсэн үндсэнд «гэ ~ гэй» дагавар залгаж булганы элдсэн зөөлрүүлсэн арьсилгэн жихэвч гэсэн нэр бүтээсэн байж болно.

Эсвэл худам монгол бичигт «элүгэй» гэж бичигдэж байгаад хожим хуучин (сонгодог) монгол бичигт «өлүгэй» (12, 168) гэж бичигдэх болсон өлгий гэдэг үгийн хожмын дуудлагаар тэмдэглэгдсэн байж бас болох юм. Учир нь «Өлгий» гэдэг үг анх унь хана зэргээс өлгөдөг нялх хүүхдийн модон хэвтэрийн нэр байсан учир «элгүкү» гэдэг үйл үгийн эл гэсэн үндсэнд «-гэ» буюу «-гэй» дагавар залгахад хувилгагч үсэг «г» үсгийн өмнөх хувилагч «л» үсэг хувирч «элүгэй» гэсэн үг үүсгэсэн байж болно. Монгол ардын «Эхийн ач» гэдэг дуунд:

Өрөл гэдэг модоор
Өлгийгий минь сийлсэн, аав минь
Өвлийн шөнийн хүйтэнд
Өндийж хөхүүлсэн, ээж минь

гэх зэрэг үг байгааг үзвэл «өлгий» буюу хүүхдийг хэвтүүлэх дүүжин хэвтэр буюу өлгийг аав нь модоор хийдэг заншил байсныг гэрчилнэ. Энэ тохиолдолд «МНТ»-ы өөр зүйлүүдэд (60, 133, 203 дугаар зүйл) «өлэгэй, өлэгэйтэй, өлэгэйтэй-эчэ» гэх зэргээр тэмдэглэгдсэн нь хожим (XIV з.) үеийн хэл аялгууны хазгай дуудлагын эндүүрэл байж болох бөгөөд зүй нь хуучин монгол бичгийн «өлүгэй» гэдэг нь илүү зөв бичлэг байх. Харин энэ үгийг эртний худам монгол бичигт «элүгэй» гэж бичээтэй байсан болов уу гэж санагдуулна. Жич энэ үг «нилх-а-ай» буюу «нялхын юм» гэсэн үг байж ч бас магадгүй юм.

328. нэкэгүл (нэхүүл) — гэсэн энэ үгийг хятад үсгээр галигчилснаас нь Хэниш «нэгү'үлгү» гэж сийрүүлээд [үүд] «нээлгэх» (36, 114) гэж сэргээгээд «хаалгаа нээлгэж бай» (15, 21) гэж орчуулсан бөгөөд үүнийг Пеллио, Рахевильз (49, 147), Поуха (17, 39), Калужинский (61. 53, Баяр (11, 222) Элдэндэй Ардажав (8, 227) тэргүүтэн цөм «нэкүгүл» гэж, Иринчин «нэгэгүл» (28, 64) гэж ташаа буулгаад «нээлгэ» гэсэн үг гэж хятад хадмал орчуулгыг дагаж ташаарчээ. Харин энэ нэкэгүл гэсэн үгийг ганц Лувсанданзан зөв ойлгож «сэкэгүл» (сөхүүл) (31, I, 49), гэж үгийг сольсон нь зөв бөгөөд Дамдинсүрэн (7, 54), Мансан (27, 59) нар «сэкэгүл», Дугаржав (24, 38) «эргүгүл» гэсэн үгээр ерөнхий утгыг бас зөв гаргаж орчуулсан байв.

Бидний бодвол энэ үг «нэгэгүл» (Элдэндэй Ардажав, Иринчин), «нэгэгэгүл» (Баяр) гэсэн ч үг бус харин «нэкэгүл» (эргигүл) гэсэн үг мөн бөгөөд монголчууд эсгийгээр хийсэн үүдээ дээш нь сөхөж эргүүлэн гэр дээрээ тавихыг үүдээ нэкэх (эргүүлэх) гэдэг байжээ. Энэ үгийг хуучин монгол бичигт «нэкэкү»-өр нэхэх, бараа нэхэх мэт-ийн» гэж Шагж (12, 202б) гэж товч тайлжээ. Бас «улаа нэхэх» гэдэг нь морио эргүүлж авчрах гэсэн утгатай. Хүндэт хүнийг гэрт оруулахдаа зарц боол нь үүдийг нь сөхөж өгөх буюу эргүүлж (нэхэж) гэр дээр тавьж өгдөг ёс байснаас Жэлмэ-г тийм зарц боол мэт шадар хүнээ болгож ав гэсэн утгатай үг тэр өвгөн хэлжээ гэж бодном.

329. дэрбэлүмүй (дэрвэлнэ) — гэсэн энэ үгийг галигласан хятад үсгээс нь Хэниш «дэрбэлгү» гэж сэргээн хятад хадмал орчуулгын утгыг «чичирэх, дэнслэх (донслох)» гэсэн үгээр тайлсан бөгөөд Пеллио,

Рахевильз (49, 147), Кливз (42, 34), Поуха, Калужинский (61, 54), Баяр (11 224) цөм Хэнишийн адил орчуулсан буюу ойлгосон шиг байна. Элдэндэй Ардажав (8, 227—228) «дэрбэгэнэх, тургих, донслох, дуу гарах» гэж олон морьдын хамрын дуу гэж ойлгосон бололтой. Лувсанданзан «дэлбэримүй» гэсэн нь тэрбэлүмүй гэдгийн авиа солигдол буюу эсвэл алдаатай бичлэг ч байж болох бөгөөд харин Ц. Дамдинсүрэн «газар дэлбэрэх мэт чимээ гарч» гэж уран ихсгэл болгож орчуулжээ. Мансан газар «долгисчу» (27, 59) Дугаржав «дэрбэлзэжү» (24, 38) гэж тус тус ойлгожээ.

Бид энэ үгийн дэр- (чичрэх донслохын чимээ, хөдөлгөөнийг тэмдэглэх үгийн язгуур дайвар үгийн I үндэс) +бэ (дайвар үгээс үйл үг бүтээх дагавар, гэ дагавартай сэлгэнэ) +л (үйлийн олон давтагдах байдлын нөхцөл) +муй (үйл үгийн одоо цагийг үзүүлэх төлөвийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд чичирэх донслох гэсэн утгатай үг юм. Одоо үед ч энэ утгаараа өргөн хэрэглэгдэж буй. «Дэнжийн ногоог дэргэтэл, дээлийн хаваасыг ханзартал давхих» гэх буюу «дэргэтэл хатирах» гэж ярилцдаг. Бас дэржигнүүртэй зам гэх нь (жижиг чичрэх) донсолгоотой зам гэх, туг дарцаг салхинд ийш тийш чичрэхийг туг дарцаг «дэрвэх» гэнэ.

330. Бөкэн харагутай (бөхөн харуутай) — гэсэн энэ үгийг галигчилсан хятад үсгээс нь Хэниш «бокан» (бөкэ) (36, 17) гэж сийрүүлээд «далантай, чиргүүл аралтай» гэсэн үг болов уу гэжээ. Энэ үгийг «никэн» гэж ташаа тэмдэглэсэн Пеллиогоос бусад судлагчид цөм «бөкэн» гэж сэргээдэг байна. Энэ үгийг Хэниш «чиргүүлт тэрэг» (15, 22) гэж, Рахевильз «навсгар (уранхай) хар тэргэнд» (49, 147) гэж Кливз (42, 34) «бөкэн» гэж хэвээр орчуулж, Поуха (17, 29), Калужинский (61, 54) цөм энэ үгийг орхиж орчуулжээ. Харин үүнийг монгол судлагчид Дамдинсүрэн «бүкүгэгтэй» (7, 55) тэрэг гэж, Элдэндэй Ардажав тэрэг хэлний «бүкэн-бөгэтүр, бөгцүгэр, мухар» гэдэг үгийг зааж бас эсгий мухлаг тэргэний эсгийг тулж байгаа бөгэтүр мод» (8, 230) гэж тайлбарлав. Мансан «бөх бүрхүүл тэрэг» (27, 59, ба 71, II бүлгийн тайлбар №27) гэжээ. Дугаржав «мухлаг тэрэг» (24, 39) гэж тус тус ойлгосны дотроос «бөхүгэгтэй» гэсэн Дамдинсүрэнгийн орчуулгыг илүү оновчтой гэж болно.

Учир нь «бөкэн» (бөгэн) гэдэг үг бол бөг<бөгөтүр, бөгүгэ (бөгөө), бөгтийх гэх мэт олон монгол үг бүтээх үндэс мөн тул түүний гарлыг төрөл язгуур нэгтэй түрэг хэлний үг гэж тайлбарлах аргагүй юм. Бөкэн буюу «бөгэн» гэдэг бол мухлагийн эсгийг тулдаг модыг дангаар хэлж байгаа бишээ, харин мухлагийн бүрхүүл эсгийн гадагшаа төвгөр бөгтөр (бөгэн) хэлбэрийг тэмдэглэсэн үг гэж бодож байна.

331. кэжий-э буй-у (хэдүй [хол] вэ?) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигчлалаас нь Хэниш «кэжи'э» гэж сэргээн бичээд хадмал хятад орчуулгын утгыг «хэр хол?» «хэр хол бэ?» (36, 97) гэсэн үгээр тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 22), Пеллио (9, 149), Поуха (17, 39), Рахевильз (49, 148) Калужинский (61, 54) тэргүүтэн цөм «хэр хол вэ?» гэж зөв орчуулжээ.

Дамдинсүрэн «хамига (хаана) буй» (7, 55) гэж, Элдэндэй Ардажав нар «кэжигэ» гэж сэргээгээд «кэжигэ нь бичгийн хэлний хэзээтэй адил. Нууц товчоонд энэ үг огторгуйн орон байр бөгөөтөл бичгийн хэл ба аман яриандхарин цаг хугацааг заадаг» (8, 233, тайлбар №12) гэжээ. Мансан (27, 60), Дугаржав (24, 39) нар «Хэдүй хол вэ?» гэж орчуулснаас бид сүүлчийнхийг илүү зөв орчуулга болсон гэж бодов.

Бид энэ үгийг үнэхээр зайн хэмжээ асуух «хэжий-э» гэсэн үг гэж бодож байна. Энэ нь нэгд «Тэрэ чу ойира буйу» гэсэн эмгэний хариултаас ил байна. Хоёрт, энэ үг худам (эртний) монгол бичигт хэрэглэгдэж байсан «йа, кэ, ха-кэ» гэсэн цөөн асуух үгээс сүүлчийн тоо хэмжээ асуух «кэ» гэдэг үгээс дараах журмаар үүссэн асуух үг гэж бодно. Үүнд кэ-(үгийн язгуур тоо хэмжээ асуух төлөөний үгийн I үндэс) +[э]дүй (эдүй — ойрыг зааx төлөөний үг ганц тооны хэлбэр) +э (өгөх оршихын тийн ялгалын нөхцөл) гэж үг нийлэх аргаар бүтсэн бөгөөд «хэдүйд [зайд] буй у?» гэсэн утгатай асуух үгс мөн гэж бодно. Хэдүй-э гэсэн үгийн авиа хувисаад «хэжий-э» (хэзээ) гэсэн үг болоод байсан боловч «тоо хэмжээ зааx» утгаа хадгалсаар байжээ. Учир нь цаг хугацааг асуух өөр (кэ+ли гэж бүтсэн) «кэли» (хэзээ) (8, 233) гэсэн үг мартагдаагүй цаг хугацаа асуухад хэрэглэгдсээр байжээ

332. хойана-ача [босугад ирэби би] (хойноос [босоод ирэв би]) гэсэн энэ үгийг судлагчид «хойина-ача» гэж сийрүүлээд «хойноос» гэж үгчлэн Хэниш, Пеллио, Рахевильз (49, 148), Кливз (42, 35), Поуха 17, 40), Калужинский (61, 54), Элдэндэй Ардажав (8, 230), Иринчин (28, 66) цөм хойноос» ~ «гэрийн хашааны араас» гэх мэт бүрүү ойл-

гож, харин Дамдинсүрэн (7, 55) **түүнийг дагаж Мансан (27, 60)** Дугаржав (24, 39) нар «хойд гэрээс» ~ «хойно гэрээс» гэж ойртуулж орчуулсан байна. Бид энэ үгийг хойноос буюу зарц нарын гэрээс гэсэн утгатай гэдгийг урьд бичсэн өгүүлэлдээ (10, 148—154) нэгэнт тайлбарласан тул энд **тайлбараа товчильё.**

333. даручан (дару[й]цан) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш «даруча» гэж сэргээн босгоод хадмал хятад орчуулгыг нь «нягт араас нь дагалдах, үүний дараагаар гэдэгтэй ижил» (36, 33) гэж хөрвүүлэн германаар илэрхийлжээ. Энэ учраас энэ үгийг судлаачид Хэнишийн адилаар ухаарсан нь гарцаагүй. Пеллио (9, 144) Рахевильз (49, 148), Кливз (42, 35), Дамдинсүрэн (7, 55), Мансан (27, 60) үүнийг «байтал», «яг тэр үед» гэх зэргээр орчуулсан ба Иринчин «дарай-ача» (28, 67) гэснээс гарсан гэж, Элдэндэй Ардажав (8, 234) «даруйхан, даруй» гэж тус тус ойлгосон нь ерөнхийдөө зөв боловч бидний бодлоор энэ үгийг зөв бүүлгаж зөв ухаарч чадсангүй мэт. Бид хамгийн зөв сэргээлт нь Лувсанданзаны эхэд байгаа «даручан» (31, 59) гэсэн үйл үгийн хэлбэр мөн гэж тийнхүү сийрүүлэв. Үүнд нэгд, Өөр зүйлд (110, 193, 247 §) **«даручажу»** гэсэн даруча-гэдэг үйл үндэс мөнийг баталж байна. Хоёрт, «даручаг-а-бар» гэх мэт бичлэгтэй үг хуучин монгол бичигт дайралдавч, тэр нь даруча+га (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) залгаж үүсгэсэн нь тодорхой тул даруча - гэдэг нь үйл үг болохыг давхар баталж байна. Иймд Нууц товчоонд «даруча» гэж нэр үгийн ёсоор бичсэн нь буруу юм.

334. Мөд чэрик-үд (мөн цэргүүд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс судлагчид цөм ингэж сэргээж, утгыг хадмал хятад орчуулгаар нь мөн ингэж ойлгодог нь зөв юм. Харин Хэниш энэ үгийг «мүн» (36, 111—112) гэж ганц тоот хэлбэрээр бас «үүн» эгшигтэйгээр сэргээсэн нь ташаа юм. Үүнийг Пеллио (9, 23), Рахевильз (25, 39), Лигети 33, 48), Баяр (11, 233), Дашцэдэн (26, 42) Элдэндэй Ардажав (8 233—234) нар цөм хятад галигийг мөрдөж «мүд» гэж XIV зууны аялгаар буруу буулгаж гагцхүү хуучин (сонгодог) бичгийн маягаар Лувсанданзан (31, 51) Дамдинсүрэн (7, 55), Мансан (27, 60) нар «мөн» гэж Иринчин «мөд ~ мүд» (28, 67) гэж, Дугаржав (24, 39) үг үгийг орхиж тус тус зөв ойлгож орчуулсан буюу сэргээсэн байна.

Бид энд «мөд» гэж сийрүүлж «цэргүүд» гэсэн үгтэй худам (эртний) монгол бичгийн ёсоор олон тооны зохицолтой бичигдсэнийг нь цохон тэмдэглэж тайлбарлав

335. Бэлгэтэй-ийн экэ-и (Бэлгэтэйн эхийг) — гэсэн энэ үгийг бид энэ тайлбарын 143, 177 дугаарт тайлбарласнаа баримталж «Бэлгэтэй-йин экэ» гэж сэргээн Сочигил эхийг хэлж байна гэж ойлгож байгаагаа тэмдэглэе.

336. сундалагулдажу (сундлуулдаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «сундула'улдуху» гэж сэргээн сийрүүлээд хадмал хятад үгийн утгыг «хэн нэг хүнийг мориндоо суулгаж түүнтэй хамт мориор явах» (36, 137) гэж орчуулсан юм. Пеллио (9, 23), Дашцэдэн (26, 42), Баяр (11, 1, 233), Элдэндэй Ардажав (8, 233; 235) Иринчин (24, 67) цөм Хэнишийнхтэй адилаар сэргээж, харин Лигети (33, 49), Лувсанданзаны (31, 51) адилаар «сундулагулжу» гэсэн нь «д-»гийн дараа «а» биш, «у» бичсэнээрээ Лувсанданзанаас ялгаатай ажээ. Рахевильз (25, 39) «сундула'ук<ду>жу» гэж, Дашцэдэн, «сундулаулдужу» (26, 42) гэж, Дамдинсүрэн (7, 55), Мансан (27, 60) Дугаржав (24, 39) хуучин бичгийг дагуулж утгаар нь «сундаллажу» гэж бичжээ.

Бид худам монгол бичигт «сундалагулдажу» гэж буулгахдаа бас хуучин монгол бичигт бичдэг уламжлалыг (12, 858а) харгалзав. «Сундулагулдужу» гэснийг сундлахын хамтран үйлдэхийн хэв гэж тайлбарласныг арай ташаа гэж үзэв. Учир нь Сундала (үйл үгийн 1 үндэс) +гул (бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөл) +да (бусдын үйлийн эрхэнд үйлдэгдэх хэвийн нөхцөл) +жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн тул «-лд» гэсэн үйлдэгдэх хэвийн нөхцөл энэ үгэнд байхгүй гэж бодож байна.

337. цэрбэ[л] [гэл]жэгүлжү (цэрвэгэлзүүлж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «цэрбэгэлжэгүлгү» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгыг нь «унжуулж» (36, 26) гэж тайлжээ. Пеллио (9, 144), Рахевильз (49, 148) нар «савлуулж, санжагануулж» гэж, Кливз (42, 35), Поуха (17, 40), Калужинский (61, 54) цөм «унжуулж» гэж, Мансан (27, 60), Элдэндэй Ардажав цөм «унжуулж» гэж, Дамдинсүрэн (7, 55,) «санжуулж» гэж, Дугаржав «санжилзуулан» (24, 40), гэж тус тус орчуулснаас хамгийн их ойртуулсан нь Дугаржавын орчуулга шиг санагдана.

Бид энэ үгийг цэрбэ- (үйл үгийн 1 үндэс) +гэлжэ (олон давтагдах

үйлийн байдлын нөхцөл) +гүл (үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жү (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг бөгөөд Шагжийн толинд «чэрбэлжэкү» «чэрбэгүү» барилдах (12, 756а) гэх мэт төрөл үгс нь бүртгэгдсэн байна. Иймд «хойар көл ину» гэж уг хятад галигт бичсэнийг «хойар көл-и [-г] ину» гэж байх ёстой болов уу гэж бодно. Нэгэнт «чэрвэ+гэлжэ-» гэсэн үйлийн байдлын нөхцөл залгасан учир «чэрвэ+» үндсэнд «л» гэдэг олон дахин үйлдэх байдлын нөхцөл залгах нь илүүц учир энэ «л»-ийг XIV зууны үеийн галиглагчдын ташаарал гэж үзэж хасаж сийрүүлэв. Энэ «-гэлжэ» гэдэг нь «бэлжэ» гэдэг нөхцөлийн хувилбар болно. Жишээ нь татвалз, татгалз гэх мэт.

338. хагатай (хаалгатай) — гэдэг энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «ха'алтай ха'атай» гэж сийрүүлээд хадмал хятад орчуулгагүй боловч «хаалгатай тэргэн» гэж маш зөв орчуулсан байна. Үүнийг Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр нар «ха'атай ~ хаатай» гэж, Иринчин, Элдэндэй Ардажав нар «хагатай» гэж, Мансан (27, 60), «бүрхүүлтэй» гэж, Дамдинсүрэн Дугаржав нар «хаалттай» гэж тус тус сэргээсэн буюу ойлгож орчуулснаас сүүлчийнх нь бидний бодоход үнэнд хамгийн ойртуулсан орчуулга бөгөөд Хэнишийн сэргээлтэй үтга нийлэлцэх болов уу.
Учир нь «хага» (үйл үгийн үндэс гэдэг нь илэрхий) +тай (юм бүхий буюу эзэмшсэн гэх утгатай харьцангуй нэр бүтээх дагавар түл түүний)-г үйл үгэнд залгаж таарахгүй. Иймд хага (хаа) гэсэн үйл үгэнд (жарга+л=жаргал гэдгийн адилаар) «-л» дагавар залгаж нэр үг болгоод «тай» дагавар залгасан баймаар тул энэ үгийг «хагалтай» гэж Хэнишийн сэргээсэн нь чухам зөв нь болов уу гэж бодно. Нэгэ+л+хий гэдэг үгийн адилаар бүтсэн үг бололтой.

339. има-йи (имайг-түүнийг) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 82) тэргүүтэн цом «имайи» ~ «има-йи» гэж сэргээж гуравдугаар бнеийн ганц тоот төлөөний үгийн заахын тийн ялгалын хэлбэр гэж зөв ойлгосон юм. Элдэндэй Ардажав (8, 236) энэ үг ийм утгатайг «Хуа-эй-эй Ий үй» толь доорд дэвтэр 11 дүгээр нүүрт тайлбарласныг иш татан тайлбарлажээ. Дамдинсүрэн түүнийг дагаж Мансан, Дугаржав цом «түүнийг» гэж орчуулж бичсэн байна.
Харин бидний сонирхлыг III биеийн ганц тоот төлөөний үг и-гийн има гэсэн өөр үндэс үүссэн баримт татаж буй бөгөөд бодвол И-гэсэн төлөөний нэрд тийн ялгалын эгшгээр эхэлсэн и (заахын тийн ялгал), а (өгөх оршихын тийн ялгалын) ача ~ эчэ (гарахын тийн ялгалын) зэрэг нөхцөлийг залгахад хоёр эгшгийн хоорондх «м» гийгүүлэгч жүйрэглэсэн ба им гэсэн үндсийг им тэмдэг гэсэн өөр үгээс ялгахын үүнд има-гэж бичсэн байж магадгүй гэж санана.

340. булжабасу (булзвал) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээр нь Хэниш «булжигу» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгыг «хажуу тийш харайх» (36, 22) гэж тайлжээ. Пеллио (9, 23), Лигети (33, 49) Рахевильз (25, 39), Мостарт (47, 316[32]), Дашцэдэн (26, 42) нар «булжи'асу» «булжиасу» гэж, Баяр (11, 1, 236), Иринчин (28, 67), Элдэндэй Ардажав (8, 236) «булжибасу» гэж тус тус сэргээжээ. Үүнийг Хэниш «ийш тийш зайлсхийж» (15, 22). Пеллио «ийм тийм маягаар» (9, 144) гэж, Рахевильз «ийш тийш эргэж тойрч» (49, 148) гэх зэргээр Өрнөдийн судлагчид орчуулсан ба Монголын Дамдинсүрэн «урагш хойш явж» (7, 55) гэж, Мансан «үүгээр түүгээр явж» (27, 60), Дугаржав «ийш тийш эргэн тойрон» (24, 40) гэсэн үгээр шинэ монгол хэлэнд орчуулсан байна. Мостарт гуайн дээр дурдсан номдоо бичсэнээр бол Козин гуай «ийшээ тийшээ чавхдан давхиж» (14, 97) гэж их л зөв орчуулсан байна. Мостарт «заримдаа ийшээ гэсэн сэтгэлээр, заримдаа тийшээ гэсэн сэтгэлээр займчин ухасхийж» (47, 318 [34]) гэж орчуулжээ.
Бидний санавал энэ үгийг «булжабасу» гэж сэргээх нь зөв юм. Учир нь нэгд Нууц товчооны хүдам монгол бичгийн эхтэй байсан гэгдэх Лувсанданзан энэ үгийг «булчабасу» (31, 1, 51) гэж бичсэн нь «ж»-гийн дараа «и» биш «а» байсныг гэрчилнэ. Хоёрт, энэ үгийн «ж» үсгийн дараа «и» биш «а» байсан учраас хуучин монгол бичигт уламжлан ирсэн «булзах, булзааруулах» гэх мэтийн үгэнд «ж» нь халхын аялгуунд «з» авиа болж хувирсан байна. Хэрэв «ж»-гийн дараа «и» байсан бол энэ нь «з» авиа болохгүй «ж» хэвээр үлдэх байжээ. Энэ үйл үгийн үйлдэгдэх хэвийн хувилбарыг нь хуучин монгол бичигт «булташу-зайлж буруулах» (12, 286б) гэж бичигдэж байгаа нь үүний үйлдэх хэвийн «булжабасу» гэдэгтэй ижил «а» эгшигтэй байгаа бөгөөд ба римт давхар батална. Иймд «булжибасу» нь XIV зууны галиглагчнарын аялгын ташаарсан дуудлагаар тэмдэглэсэн зүйл биз ээ.

341. эмбү сибар (өмбө шавар) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «умубу» гэж галиглаад хадмал хятад орчуулгын утгыг «шигдэх намаг» (36, 164) гэж тайлжээ. Үүнийг Пеллио (9, 23),

Рахевильз (25, 39), Лигети (33, 49), Иринчин (28, 68) нар цөм үмбү ~ өмбү гэж, Баяр (11, 1, 236), Элдэндэй Ардажав (8, 236) нар «үмбү» гэж сийрүүлэв. Пеллио Рахевильз тэргүүтэн өрнөдийн судлагчид их төлөв Хэнишийн орчуулгыг дагаж орчуулсан боловч Мостарт авгай тэдний орчуулгаас хамгийн сайн нь Козины орчуулга болсон гэж түүнийг дагаж орчуулснаас гадна Козины (14, 339) Алтан товчийн эхэд «эмбү» шавар гэж бичсэн учир энэ үгийг «үмбү» гэж сийрүүлсэн учраа хэлээд Ковалевскийн толийн 339 дүгээр талд буй «эмбүри» гэдэг үгийн үтгыг үз гэж Мостарт авгай заажээ. Бас энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав нар (8, 237—238) эмбү-эмбүрих гэсэн үгтэй холбож «өмбү шавар гэвэл гишгиж болохгүй шигдэн ордог шавар» гэж зөв тайлбарлажээ.

Энэ бүхнийг харгалзаад бид «МНТ»-ы хүдам монгол бичгийн эхэд энэ үгийг (XIV зууны галиглагчдын сийрүүлсэн шиг) «үмбү» буюу «өмбү» гэж бичээгүй, харин Лувсанданзаны эхэд байгаа шиг «эмбү» шавар гэж бичигдсэн байсан гэж төсөөлөн ийнхүү сийрүүлэв.

342. Одуйид (одойд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 183), Пеллио (9, 23), Лигети (33, 49) Рахевильз (25, 39), Баяр (11, 237), Дашцэдэн (26, 43), Дамдинсүрэн (7, 56) нар Магауйя (78, 42) зэрэг олонх нь «удуйит» буюу «Удуйид» гэж, Элдэндэй Ардажва «Одүйид» (8, 236), Лувсанданзан (31, 52), Мансан (27, 61), Иринчин (28, 68), Дугаржав (24, 40) нар цөм хуучин монгол бичгээр буулгасан тул «Удуйид ~ Одуйид» гэж буулгасан бөгөөд сүүлчийнхээр нь ойлгосон болбол хамгийн зөвөөр буулгасан гэж бодно.

Учир нь энэ мэргэдийн нэг овгийн хоч нэрээс үүсэлтэй. «Удуйд» гэдэг үгийг Березин (Рашид-ад-Диний Судрын чуулганы орос хэлээр орчуулсан) Уда буюу Удэ голын нэрээс гарсан гэж тайлбарласныг Пеллио няцаагаад үүнийг «Одой хүн» (54, 274—275) гэсэн үг гэж тайлсныг бид баримтлан «Одуйд» мэргид гэж сийрүүлэх нь зөв гэж бодно. О-гэсэн энэ үгийн язгуураас о+готор, оготно (оготор сүүлт) гэх мэт ямагт «богинохон» гэсэн утгатай үгс бүтсэн байх тул «Одуйид» (богинохон тагжгарууд) гэсэн үг гэж тайлбарлав. Удуйид гэдэг нь XIV зууны нутгийн аялгууны гажуу дуудлага биз ээ.

343. Хубас мэргид (Ухаас мэргид) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 184), Пеллио (9, 23), Лигети (33, 49), Рахевильз (25, 39), Поуха (17, 40), Калужинский (61, 55), Баяр (11, 1, 237), Элдэндэй Ардажав (8, 236), Магауйя (78, 42), Дамдинсүрэн (7, 56), Мансан (27, 61), Дашцэдэн (26, 43), Дугаржав (24, 40) нар цөм «Увас» гэж, Лувсанданзан «Унаг [ухас (?)]» (31, 1, 52), Иринчин (үйгаржин монгол үсгээр сийрүүлсэн тул) «уха (н) с» (28, 68) гэж тус тус сийрүүлж Элдэндэй Ардажав нар (8, 239) энэ зүйлийн 5 дугаар тайлбарт 1) түрэг хэлний «Увас»-йас-ос нь алага (гарын [?] -Ш. Г.) атга, битүүлэх; 2) атга (хэмжээ [?] -. Г.) чимх: 3) цөөн өүүхэн гэсэн утгатай үгнээс гарсан гэсэн нь машид эндүүрсэн зүйл гэж бид бодно. Бид энэ үгийг ухаа гэсэн өнгө зүсмийн утгатай монгол үг гэж бодох тул хуучин (сонгодог) монгол бичигт үүнийг «хувас» гэж бичдэг боловч эртний хүдам монгол бичигт «в» үсэг үгүй тул ухаа гэхийг «хуба» гэж, түүн дээр олон тооны нөхцөл залгаж «хубас» гэж бичсэнээр төсөөлөн сийрүүлэв.

344. Дайир үсүн (Дайр [бор] үсэн) — гэсэн хүний энэ хоч нэрийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 175а), Лигети (33, 49), Дашцэдэн (26, 43), Баяр (11, 1, 237), Элдэндэй Ардажав (8, 236), Иринчин (28, 68), Магауйя (78, 42), Мансан (27, 61), Дугаржав (24, 40), Лувсанданзан (31, 52), Дамдинсүрэн (7, 56,) Мостарт (47, 327 [43]) цөм «Дайир усун» гэж, ганц Пеллио (9, 23) «Дайир үсүн» гэж бидний бодлоор зөв сэргээсэн байна.

Бид үүнийг «Дайир-үсүн» буюу цайвар үст гэсэн хоч нэр гэж бодож сийрүүлэв. Учир нь энэ хүн толгойдоо онго цагаан үстэй учир түүгээр нь бор үст (Дайир үсүн) гэж алдаршсан болоштой. Гэтэл усыг монголчууд хэзээ ч «дайир» гэсэн тодотголтой холбож байсангүй, усыг «хар» өнгөтэй их төлөв холбож ойлгодог тул «Дайир Үсүн» гэхийг «Дайир Усун» гэж галиглагчид эндүүрсэн гэж бодож байна.

345. хад-ай Дармала (хаадай Дармала) — гэсэн овог нэрийг Хэниш (36, 176), Пеллио (9, 23), Рахевильз (25, 40), Мостарт (47, 327[43]), Поуха (17, 40), Лигети (33, 49), Калужинский (61, 55), Баяр (11, 237) тэргүүтэн цөм хятад галиг эхийг баримтлан «ха'а-тай Дармала буюу Тармала» гэж, Лувсанданзан (31, 52), Дамдинсүрэн (7, 56), Баяр, Элдэндэй Ардажав (8, 236), Иринчин (28, 68), Магауйя (78, 42), Мансан (27, 61), Дугаржав (24, 40) нар цөм хуучин (сонгодог) бичгийн бичлэгийг дагуулж «Хагатай ~ хэгадай ~ хахатай Тармала ~ Дармала» гэх мэтээр сэргээн босгож сийрүүлжээ.

Энэ үгийг Поуха (58, 89) хадай Уӊ (көниг) буюу хан овгийн мэргид гэсэн утгатай гэж тайлбарласан нь зөв юм. Бид хад-ай буюу хад (хан нар)-ыӊ овгийн хүн гэсэн утгатай гэж, Дармала гэдэг нь нэр нь гэж үзэж «Хад-ай Дармала» гэж сэргээв. Учир нь XIV зууны галигч нарын аялгуунд ха гэсний задгай үеийг уртаар дуудах болсон үеийн дуудлагаар ха'ад гэж буруу тэмдэглэсэн хэрэг бөгөөд урт эгшиг үүсээгүй авсан худам монгол бичигт хаган (хаан) гэсэн үг байгаагүй учир ха-д-ай гэж бичигдсэн байгаа болов уу гэж таамаглан бичив.

346. хачи бан абурба (хачаа авав) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээр тэмдэглэснийг нь дагаж Хэниш «абураху» гэж галиглаад хадмал хятад орчуулгын утгыг «туслах» «аврах» гэж орчуулснаас судлагчид «хачи (өс) аврав» гэж ойлгож байв. Гэтэл энэ үг аврах гэсэн утгагүй, харин «авав» гэсэн утгатайг Лувсанданзан мэдэж «хачи» гэдэг үгэнд (өшил) гэж тайлбар хадаад абурабай гэдгийг «абубай» (31, 52), гэж бичсэн явдал гэрчлэв. Иймээс судлаач Дамдинсүрэн (7, 56), Мансан (27, 61), Дугаржав (24, 40) «авав» гэж ойлгож орчуулсан. Хэниш «өсөө хангав» (15, 23), Рахевильз «өсөлөв» (49, 149), Пеллио «доромжлолыг өслөв» (9, 144) гэж тус тус орчуулсан болоолтой байна.

Иймд «абурба» гэдэг үгийг бид «абуба» гэдэг тусах үйл үгийг өмнөх өгүүлбэрт нь хэрэглэсэн тул найруулгын хувьд нуршин давтахаас зайлхийж эс тусах хэлбэрээр нь абурба гэж бичсэн нь чухамдаа хачийг гэсэн үгтэйгээ эс зохилдох буруу найруулга болжээ гэж үзэв. Өмнөх өгүүлбэрт нь байгаа абур-а (өс авахаар) ирэв гэсэн нөхцөл үйлийн зорих хэлбэрт XIV зууны үеийн аялгууны гажилт орж «н» нэмэгдсэн байх. Эсвэл «өгүлэрүн» гэдгийн адил «абурун» гэж бичихийг буруу галигласан байх гэж бид таамаглаж байна. (Үүнд холбогдуулан бидний 152 дугаар тайлбарыг үз.)

347. гэйид (гэрүүд) — гэсэн энэ үгийг галиг үсгээр нь Хэниш (36, 80), Пеллио (9 23) гэхчлэн бүх судлагчид «гэйид» гэж сэргээн босгож сийрүүлдэг бөгөөд цөм гэрийн олон тоо гэж хадмал хятад орчуулгын дагуу зөв ойлгодог билээ.

Энд бид энэ үгнээс монгол хэлэнд хүрээ хийд гэдэг үг үүсч гарсан гэдэг саналыг хэлэх гэсэн билээ. Хэниш авгай энэ үгийн хятад хадмал үг үсгийӊ утгыг тайлахдаа «Байшин буюу кэйд (?)-ийн олон тоо» гэж кэйид (хийд, гэдэгтэй холбоотой бус уу гэсэн санал хэлсэн байдаг. Гэтэл энэ үгийг Владимирцов хуучин монгол бичгийн «кэйид-тэг дөрвөлжин (квадрат), гэйид «байшин, барилга байр сууц» гэж үг байдгийг заагаад, скитийн кейид (сүм хийд түүнд шавилагсад) гэсэн үгнээс гарсан байх гэсэн таамаглал (79, 272—274) хэлжээ. Гэтэл монголын «хийд» гэдэг үг эртний монгол хэлний үгийн эцсийн р-гийгүүлэгч йэ-гийгүүлэгчтэй сэлгэх солигддог хуулиар «гэр» гэдэг үг олон тоонд орохдоо «гэ(-р)+йи+д= гэйид» болж хувирдаг байсан бөгөөд үүнийг XV—XVII зууны үед бичигтэн хүмүүс «гэйид» гэснийг «кэйид» гэдгээр дуудаж сүм хийд гэсэн утгаар хэрэглэх болжээ. Энэ тухай монголд байгуулсан нэг хийдийг үзэхээр хятад манжийн нэг жугуулчны газар зүйн өгүүлэл тэмдэглэлд очиж уг хийдийг үзвэл тал нутагт жараад гэр байсан тухай дурдсан зүйл байдаг бөгөөд Монголд байгуулагдсан Эрдэнэ зуу зэрэг хийд анх дуган сүм баригдаагүй, том гэрт хурлаа хурж олон гэр барьж шавилан сууж эхэлсэн тул ийм орон сууриныг олоӊ гэр буюу «гэйид» гэж нэрлэх болсноор улмаар дуудлага нь сунжран кэйид<хийд болсон бололтой. 1305 оны Чойжи-Одсэрийн орчуулгад (40, 100) «Нүкэн ба хогүсүн бүхар сүм Кэйид ба модны дэргэд сагурин-и засажу» гэж гарна. Бас «Хятад богд хааны зуслага Жэ Хэ гэгч газрын зохиол»-д баса шитүгэн-ү гэр кийгээд бухар кэйид нүгүд-түр» (80, 22) гэснээс үзвэл хожим үед «кэйид» гэдгийг гэрийн олон тооны хэлбэр гэдгийг мэдэхгүй болж гагцхүү сүм «кэйид» гэсэн ганц тоот үг гэж санаж «-уд» гэх мэт олон тооны нөхцөл залгах болсныг харуулж байна. Элдэндэй Ардажав мөн энэ утгаар тайлжээ. (8. 239, тайлбар № 7).

348. көнгэгүлжү (өнгөрүүлжү) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «күнгкэгү» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын үгийн утгыг холдуулж» (36, 105) гэж тайлжээ. Энэ үгийг Лигети (33, 49), Рахевильз (25, 40), Дашцэдэн (26, 43), Баяр (11, 1, 241) нар тэргүүтэн цөм Хэништэй адилаар, харин Пеллио (9, 23), Баяр, Иринчин (28, 68), Элдэндэй Ардажав (8, 240) нар «көнгкэ'үлжү» буюу «көнгкэгүлж» гэж сэргээсэн нь илүү зөв сэргээлт шиг санагдана. Энэ үгийн утгыг Пеллио (9, 145), Рахевильз (49, № 4, 1971, 149), Поуха (17, 15), Мансан (27, 61), Дугаржав (24, 40), Элдэндэй Ардажав (8, 242) нар цөм Хэнишийн адил хадмал хятад орчуулгын дагуу ойлгож сүүлчийн хоёр нь энэ үгийг дагуур хэлний хазайлган гаргах,

савыг хөнтрөн дотрохыг асгах гэдэг үгийн утгыг шилжүүлж хэлсэн гэсэн нь төдий л үнэмшилтэй бишийн дээр энэ үгийн утга тодорхойгүй тул Дамдинсүрэн орхиж, Лувсанданзан «көгэлгэчү» гэж ташаа орчуулжээ.

Бидний бодвол энэ үгийн эхний «к» авиа нь үгүй (к<х<h<о) болж «өнггэрэгүлжү» гэсэн үг болж «аюулыг өнгөрүүлэх, дайныг өнгөрүүлэх, шуурга өнгөрүүлэх» гэх зэргээр энэ утгаараа хэрэглэгдэж байгаа (12, 170б) ч судлагчдад танигдахгүй үг болжээ. 1305 онд хийсэн Чойжи-Одсэрийн орчуулгад «Маши догшин нигүл-ту үйилэс үйилэдбэсү-бэр, Багатуд-та шитужу йэкэ айул-ача көнггэкүй-дур адали» (40, 5) гэсэн нь «аюулаас өнгөрөх» (гэтлэх) гэсэн утгатай нь үзтэл ил байна.

349. мөкүлэтчү (мойлдох) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн тэмдэгтээс нь Хэниш «мөкэ'элэткү» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «цохих, дэлдэх» (36, 110) гэж тайлжээ. Хэнишээс бусад судлагчид энэ үгийг Пеллиогийн адилаар «мө'элэтчү» буюу эсвэл «мөгэлэтчү» гэж сэргээн галиглаад цөм «цохих дэлдэх» гэсэн утгаар тайлж ирсэн юм. Гагцхүү Лувсанданзан «мөкүлитчү» (31, 51) гэсэн нь, магадгүй, бүр эртний зөв бичлэг нь байж ч болно.

Бидний бодоход энэ үг одоогийн халхын аман аялгуунд хадсан будааг сахал түрүүнээс нь салгахаар модоор нүдэх үйлийг «мойлдох» гэдэг үг эрт цагт будааны «мөкүлитэкү» (мөкүлик буюу будааг ялгаж сахал үс түрүүнээс салгах гэсэн утгатай үг байсан бололтой. Үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс хараахан гараагүй үеийн худам монгол үсгээр «мөгэлэтчү» гэж бичиж байгаад хожим хуучин (сонгодог) монгол бичгээр «мөкүгэлэдкү» гэж бичдэг болсон болов уу. Үүнээс энэ үгийн утга «цохих балбах» гэсэн утгатай болоо болов уу? гэж бид таамаглаж байна.

350. Үнэнг (үен) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш, Пеллио, Лигети, Мостарт, Баяр, Элдэндэй Ардажав, Дугаржав, Иринчин цөм «үнэн» гэж, харин Лувсанданзан (31, 1, 53), Мансан (27, 61) нар «Үн-э» гэж, Дамдинсүрэн «Үйэнг» (7, 56) гэж босгоод Элдэндэй Ардажав (8, 242—243), Мансан (27, 79) нар үгийн утгыг ерөнхийдөө зөв тайлбарласан юм. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «Үен цагаан хэрмэнцэр» (36, 164) гэж тайлсан атал орчуулахдаа «үнэг» (15, 23) гэж, Козин «Солонго» (14, 98) Пеллио «сууcap» (9, 145) гэж тус тус орчуулсныг Мостарт яг тохироогүй гэж шүүмжлээд «Үнэнг» гэсэн хэлбэрээр энэ үг дайралддагийг заахын хамт үүнийг «үен» (47, 319—324[35—40]) гэжээ. Иймд бид энэ үгийг хэдийгээр 5 зүйлийн үсэг хавсарсан манж үгийн толинд (72, III, 42 72) «үн-э» гэж, энд «үнэн» гэж тохиолдовч Мостартын мэдээлсний дагуу «үнэнг» гэж бичих нь зөв гэж ийнхүү сийрүүлэв. Учир нь «Үнэнг» гэсэн энэ бичлэгийн өөр хувилбар нь «үйэнг» (53, 615а) бөгөөд энэ хоёр бол нэг үгийн авиа сэлгэлтийн хоёр хэлбэр мөн. Ийнхүү авиа сэлгэх бусад үгийн жишээнээс үзвэл ийм үгсийн «йэ» бүхүй хувилбар нь эртний, «н» хэлбэртэй нь сүүлийн үеийн хувилбар бололтой. Жишээ нь кийүн<кинуа<чинуа; хой <хони; үйэнг<үнэнг<үнэ гэх мэт.

351. бодан (бодон) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 20, Баяр (11, 1, 242), Элдэндэй Ардажав (8, 240) нар «будун» гэж бусад нь (Пеллио, Рахевильз, Лигети, Лувсанданзан, Мостарт, Дамдинсүрэн, Иринчин, Дугаржав, Дашцэдэн) цөм Лувсанданзаныг дагаж «бүдүн» буюу «бүтүн» гэж сэргээгээд утгыг нь Хэниш хадмал хятад орчуулгаас «өөрийн, бодгаль бие» гэж тайлаад, орчуулахдаа «амин биеэ» (15, 23) гэж, Козин «нүсэр (том) биеэ» (14, 98), Пеллио «бүтэн бие» (9, 145) гэж тус тус орчуулсныг Мостарт шүүж дурдаад өөрөө «дан (цэвэр) амин биеэ» (47, 323[39]) гэж ойлгож орчуулжээ. Элдэндэй Ардажав «будун бие» гэдгийг «бүхэл бие, бүх бие бас уг бие» (8, 243) гэж Пеллиогийн адилаар тайлбарлав.

Бид энэ үгийг будун, бүдүн (бүдүүн) бүтүн (бүтэн) гэсэн үг ч биш, харин «бодан» буюу «их бие» гэсэн үг гэж бодох тул энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт Баяр авгайн «Будан ~ бодан» (11,1, 243), Мансангийн «Бода» (27, 51) гэж сэргээснийг зөв гэж бодов. Учир нь энэ үгийн талаар бид урьд өгүүлэлдээ (10, 105—109) хэлсэн билээ. Энэ сийрүүлэл яг тохирохын дээр «бода мал»-д их буюу том биет, адуу, үхэр, тэмээ орно. Иймд «бодан бэйэ» гэгч «их бие» гэсэн үг байж болно. Жич «МНТ»-ы 155 дугаар зүйлд татаарын Йэкэ Чэрэнгийн охин Есүкэн Чингис хаанд «хаган сойурхабасу нама-йи күмүн-у бода-да болгажу асараму» гэсэн үг байгаагийн утга «хүний ихэд» тоож гэсэн утгатай нь ил байна. Иймд бодан гэдэг «бода» буюу «их, том» гэсэн үгийн хавсрал нэрийн хэлбэр мөн гэж бодно.

352. Букий-а мори-ту (бухиа морьт) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн тэмдгээс нь Хэниш (36, 20), Пеллио (9, 23), Рахевильз (25, 40),

Лигети (33, 49), Дашцэдэн (26, 43), Элдэндэй Ардажав (8, 243) нар цом «бугий-а» гэж, нөгөө Баяр (11, 1, 243), Иринчин (28, 68), Мансан (27, 61), Дугаржав (24, 41) нар «букий-а» гэж, Лувсанданзан «бөкий-э» (31, 1, 52) гэж арай ташаа буулгасан байв. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар Хэниш «Морины тушаа буюу ногт» (36, 20) гэж тайлаад Хэниш (15, 23), Козины (14, 98) адил «болхи (хашин) мориор» гэж, Пеллио, «Миний тушаат морь» (9, 145) гэж тус тус орчуулсныг шүүмжилж Мостарт «дунд зайд урд хоёр хөлөө зэрэг тавих боломжтой тушаат морь» (47, 321[37]) гэх зэргээр элдвээр орчуулж байсан ч ончийг олсонгүй. Рахевильз (49, 1, 149) «тушаат морин дээр» гэсэн нь Пеллиогийн адил орчуулжээ.

Бидний бодвол «букий-а» морьт гэгч ойрхон газар яаран унасан (өөр солих морьгүй) ганц морьт гэсэн утгатай гэж бодно. Учир нь хуучин (сонгодог) монгол бичигт буукий-а (53, 112) гэдэг үгийг «буухиа элч», «буухиа бичиг», «буухиа өртөө», «буухиа уралдаан» гэх зэрэг «маш яаралтай» өртөөлөн дамжуулах зүйлийн утгатай үгс буй. Буухиа элчийг морьдуулах морийг элчийг саатуулахгүйн тул хол явуулахгүй гэж чөдөр тушаатай байлгаж бэлэн байлгах тул буухиа морь бол хятад хадмалд хэлсний адил «чөдөр тушаат морь» боловч ойрхон зуур (дараас өртөө хүртэл) маш хурдан давхих огцом хурдан морь мөн. Гэвч буухиа морь амархан цуцаж хол удаан давхиж тэсэхгүй тул хөтөлгөө морьгүй бол буухиа (дан) мориор дайснаас хол зугтах аргагүй тул «бухий-а мори-ту» гэж унаагаа голж хэлсэн үг биз

Буки+й -а; буким+м+д+х = букимдах (бачимдах яарах) гэсэн үгс цом богино эгшигтэй атал хожим «буукий-а» гэж урт эгшигтэй болсон нь ойлгомжгүй юм. Гэвч хожим XIII зууны үеэс яаралтай элчийг дамжуулах өртөөнд «Багуху уйаг-а» гэсэн хоёр үг нийлж «буухий-а» гэдэг үүсээд эртний худам монгол бичгийн «бухий-а» гэдэг үгтэй эндүүрэгдэн солигдсон байж бас магадгүй юм.

353. харага[й]-ийн тэдүй амин (хараацайн төдий амь) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн тэмдэгтээс нь Хэниш (36, 61), Пеллио (9, 24), Лигети (33, 50), Рахевильз (25, 40), Мостарт (47, 319[35]), Дашцэдэн (26, 43), Баяр (11, 1, 247), Иринчин (28, 69) тэргүүтэн цом «харча» гэж сэргээдэг нь галигч нарт түрэг аялгууны нөлөө байсныг гэрчлэх галиглалт мөн.

Хадмал хятад орчуулгагүй боловч энэ үгийн утгыг Хэниш хортон шавьж, нэг жижигхэн амьтан, яльгүй шал дэмий гэх мэт үг бус байгаа? гэжээ. (36, 61) Хэниш «шал дэмий амь» (15, 23), Пеллио «хэрмний маягаар» (9, 145), Мостарт «царцаан төдий» (47, 323[39]), Рахевильз (49, 149) Мостартын адил «царцаа» гэж орчуулав.

Энэ үгийг Лувсанданзан «харийачи» (хараацай) (31, 1, 53) гэж буулгасан тул Дамдинсүрэн «харцгаас дутагасган болжмур мэтү» (7, 57) гэж, Элдэндэй Ардажав «харча гэдэг бага харча буюу бага хараацай» (8, 246) гэж, Иринчин Лувсанданзаны сэргээснээр «Харийачай» (28, 69) гэж, Мансан «харийацай» (27, 62) гэж бидний бодоход хамгийн зөвөөр нь сийрүүлсэн байна.

Энэ үгийг анх худам монгол бичигт «харача» гэж бичиж байгаад хожим хуучин монгол бичигт «харайачай» гэж бичдэг болсон нь авианы хувьслын үр дүн гэж төсөөлнөм.

354. халхалагдаба (халхлагдав) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн тэмдгээс нь Хэниш (36, 58), Дашцэдэн (24, 44), Баяр (11, 1, 248) нар цом «халхалагдав» гэж сэргээж утгыг «халхалагдав» (хамгаалагдав) гэж ойлгож орчуулсан нь зөв байх.

Гэвч энэ үг «халха+ла+гд+ба» гэсэн бүтэцтэй бөгөөд энэ үгийн үндэс «халха» (хаалт, халхлах юм) гэсэн утгаар хэрэглэгдсэн нь энэ зүйлийн дотор «халхасун гэр» Пеллио (9, 24) гэдэг үг гарч байгаагаас ч ил байна. «Халхасун гэр» гэдэг бол миний бодоход, Элдэндэй Ардажав (8, 245), Мансан (27, 72) нарын Ордосын аялгууны үгэнд тулгуурлан тайлабарласан шиг «хагалсан бургасан» гэр гэсэн үг биш, харин «халха(халхлах) +сун (юм бүхий) гэр» гэсэн үг шиг байна. Хал[а] (гаднын зохисгүй нөлөө) -ха (тэр гаднаас халж ирэх аюулаас «хаах юм») гэсэн үг шиг бидэнд бодогдох бөгөөд орчин цагийн монгол хэлэнд «бороony халх» «нарны халх» гэх мэт үгийн адил бороо нар зэргээс халхлах дээвэр бүхий гэр» гэсэн утгатай нь илэрхий биз ээ. Хал[а]дах, хал[а]+д+вар «халдвар» хал+мж = халамж гэх мэт үгс цом энэ хал[а]- (гаднаас ойртож ирэх гэсэн утгатай) нэг үндэс язгуураас гаралтай үгс байх гэж бодож байгаагаа тайлбарлая.

355. айугулдаба (айлгагдав) — гэсэн энэ үгийг судлаачид «аймшигт суугдах» (Хэниш, 36, 11) гэх зэргээр үндсэнд нь зөв сэргээн зөв ойлгодог юм.

Бид энд айу- (ай- гэсэн утгатай үгийн язгуур, үйл үгийн анхдагч үн-

дэс) +гул (айлгах гэсэн утгатай бусдаар үйлдүүлэх хэвийн үндэс үүсгэх залгавар) +да (айлгах үйлэнд өртөх гэсэн эс тусах үйл үг үүсгэх дагавар) +ба (өнгөрөн үргэлжлэх цаг заах төлөвийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үйл үг мөн гэдгийг тэмдэглэхийн хамт орчин цагийн монгол хэлэнд энэ үгийн «айу» үндсэнд -лга (бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөл) +гд (үйлдүүлэх хэвийн үйл үгээс үйлдэгдэх хэвийн үйл үг бүтээх нөхцөл) +ба (саяхан өнгөрсөн цаг заах төлөвийн нөхцөл) гэсэн өөр хэлбэрээр энэ үйл үг уламжлан үлдсэн гэж бодож байна.

356. мялийасугай (мялаасугай) — гэсэн энэ үгийг хятад галигаас нь сийрүүлэх ба утгыг ойлгох талаар эрдэмтэд судлагчдад онцын зөрөлдөөнтэй санал үгүй гэж хэлж болно. Хэниш (36, 106), Пеллио (9, 24), Рахевильз (25. 40), Лигети (33, 50), Дашцэдэн (26, 44), Баяр (11, 1, 249). Элдэндэй Ардажав (8, 241), Иринчин (28, 69) нар цом «малийасугай» гэж сэргээн сийрүүлж, Хэниш (36, 106 бас 15, 23), Пеллио (9, 145), Рахевильз (49, 1971, 149) тэргүүтэн цом «тавигласугай» гэж, Дамдинсүрэн (7, 58), Элдэндэй Ардажав (8, 246), Дугаржав (24, 42) нар цом «мялаах» буюу тос түрхэх, сүү цацах ёслол гэж зөв ойлгож орчуулсан байна.

Гэвч Элдэндэй Ардажав нар энэ үгийг түрэг хэлний мал-тос гэсэн үгнээс үүсэлтэй мэтээр тайлбарласан нь хэдий үндэстэй боловч бид энэ үгийн авиа сэлгэлтийн өөр хувилбар, хуучин бичигт тохиолдох «малийасугай» (12, 716) нь монгол худам бичгийн үүднээс илүү зөв сэргээлт гэж үзэж бид ингэж сийрүүлэв. Учир нь энэ үг эртний монгол хэл ба худам бичигт анх бил-өөх тос билхаху, цалгих гэсэн үгнээс үүсч б авиа нь м-ээр солигдон «милийаху» гэсэн хэлбэрээр бичигдэх болсон гэж бид төсөөлж байна. Үүнд бил-гэсэн үгийн үндэснээс «билдагу» (тос элбэг дэлбэг түрхэх), «билаху» (тос бялах зэргийн) (12, 264—265), «билагу, билагураху» (өөх тосонд шандах) гэх мэт үг үүссэн гэж бодном. «Милийаху»-мялаах, марийаху нь мяраах болж хувирсан нь түрэгжсэн аялгууны гажуудуулал байж магадгүй.

357. махалай (малгай) — энэ үгийг галиглах ба утгыг ухаарах талаар судлаачдын саналтай адил саналтай байна. Ялангуяа Элдэндэй Ардажав (8, 249—250) нарын тайлбарыг маш зөв гэж дэмжихийн хамт махалай-магалай нь хожим сүүлчийн II, III үе нь сэлгэн солигдож «малагай» гэж дуудагдах ба бичигдэх болсон гэж санана. Монголын баатарлагийн туульд энэхүү «махлай» гэсэн хэлбэрээр энэ үг хадгалагдан үлдсэнийг энд тэмдэглэе.

358. сэгэжигэлэжү — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш (36, 133), Пеллио (9, 24), Лигети, Рахевильз, Баяр (11, 1, 251) Иринчин «сэ'эжигэлжү» ~ «сэгэжигэлжү» гэж сэргээн утгыг Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз (42, 37), Поуха, Калужинский цом «өлгөх, зүүх тавих» гэсэн үгээр, Лувсанданзан (31, 1, 53), Дамдинсүрэн (7, 58) «сэгэлдүрчү», Мансан (27, 63), Дугаржав (24, 42) нар «эгэлдүргэлэжү» гэж, Элдэндэй Ардажав (8, 250) «сээзгий саг мэт тохой дээрээ тохойлох» гэж оновчтой зөв тайлбарлав.

Бид «сэгэжигэлэжү» гэснийг энэ сүүлчийн тайлбарын дагуу малгайг сэгэлдэргээр нь гартаа «сээзгийчлэн тохойлж» гэсэн үг гэж бодохын хамт энэ «сээзгий» гэдэг үгийг хуучин монгол бичгээр «шэжигэй» (12, 878б) гэж бичдэг уламжлалтай нь худам монгол бичигт энэ үгийг анх «сижигэй» гэж бичиж байсны баримт байж болох боловч энэ нь дараах жи гэсэн үеийн нөлөөгөөр «с» нь «ш» болж хувирч хуучин (сонгодог) монгол бичигт арай хазгай дуудлагаар тэмдэглэгдэх болов уу гэж бодно. Учир нь сэжи- (өлгөж авах) гэсэн үгнээс буюу сэгэлд (гогцоолд) гэх зэрэг үгээс энэ үг үүсэлтэй болов уу гэж санаж байна.

359. сачули өчигүли (цацал өчил) — гэсэн энэ үгийг судлагчид хятад галиг үсгээс нь цом «өчи'илү ~ өчигүли» гэж сэргээн босгоод утгыг хадмал хятад орчуулгыг Хэнишийн «тэнгэрт мөргөх, залбиран гуйх» гэж тайлснаар «тавиглал дусаалга», «хүсэл залбирал» (Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз, тэргүүтэн) Лувсанданзан «өчин, сачули сачуба» гэж эдүгээчлэн, Дамдинсүрэн «өчил-и өчин, сачули сачуба» (7, 58) гэсэн нь Лувсанданзаны эхэд «өчил» гэдэг үг орхигдсон гэж бодсон болоттой. Элдэндэй Ардажав «тавиглахад цацлан орхих будаа; сачули-газар дэлхийд дээж өргөх нүхтэй мод» гэж Цэвэлийн толийг заан тайлбарласан ба (8, 250), Мансан «соржим (сэржим?) өргөж, залбарин даатгав» гэж эдүгээчлэн орчуулжээ.

Бид энэ хоёр үгийг сачу- (үгийн язгуур, үйл үгийн 1 үндэс) +ли (үйлээс цацах юм (сүү, айраг) гэсэн утгатай нэр үг бүтээх дагавар) гэсэн, нөгөө өчи- (ө буюу бодол сэтгэлээ илтгэх гэсэн үгийн язгуураас үйл үг бүтээх «чи» дагавар залгаж бүтээсэн үйл үгийн I үндэс) +гүли (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн тус тус бүтэцтэй нэр үгс гэж ойлгож байна. 1 нь сага+ли=сагали (сааль), II нь сур+га+гули (сургууль) гэдгийн загвараар бүтжээ. Үүний зэрэгцээгээр өчи+л, сачу+ +л-өчил, сачул (өчил, цацал) гэсэн үг ч бас жирга +л -жиргал (жар-

гал) гэсэн загвараар бүтсэн нь нууц товчооны өөр зүйлд (25, 108, 197) ч **буйг** тэмдэглэе.

360. дагулижу абтаба (дагуулж автав) — гэсэн энэ үгийг судлаачид ерөнхийдөө зөв сэргээж зөв ойлгож орчуулж **тайлбарласан** юм.
Энд бид өөр эзний үйлдсэн «дагулижу» гэсэн үйл «абтаба» гэж үйлийг хүлээсэн эзний үйл **заасан үг нийлж ийм холбоо үг бүтээсэн энэ** онцлог орчин цагийн монгол хэлэнд ховордож алга болж байгааг хэлэх гэсэн юм. Гэтэл үүнтэй ижил үйлийн холбоо үг «МНТ»-д «гэжү нэгүкдэжү» (74§), «абчу нэгүкдэрүн» (72, 73§), «булижу абтаба» (76§) гэх мэт цөөнгүй **байдгийг** тэмдэглэе.

361. нөдин-он (ноднин) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 166), Пеллио (9, 25), Дашцэдэн (26, 44), Баяр (11, 1, 254), Элдэндэй Ардажав (8, 25), Иринчин (28, 30) тэргүүтэн цөм «нидони» гэж, Рахевильз «нидөни» (25, 41) гэж сэргээсэн байна.
Бидний бодвол, энэ үг худам (эртний) монгол бичигт «нөдинөн» гэж бичигддэг байсан болов уу гэж санагдана. Учир нь энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «өнгөрсөн он» (36, 16) гэж тайлсан тул «нөгчиксэн», «нөгөө» гэх мэт үгийн «нө-» язгуураас «нө-[д]-йин+он» гэсэн хоёр үг нийлж «нөдинөн» гэдэг үг үүссэн байх гэж бодогдохоор байна. Эм эр хоёр үг нийлж бүтсэн учир нөдйин он<нөдин он (энэ бичлэгээрээ «МНТ»-ы худам бичгийн эхэд бичигдсэн гэж бид бодно) (<нидоно[н]<нидүнон) энэ бичлэгээр хуучин монгол бичигт бичигдэх (12, 212а) болж, <индони[н], <индөни (энэ хэлбэрээр «МНТ»-ы хятад галигт бичигдсэн) гэх мэтээр улирч хувирсаар ирсэн шиг бидэнд төсөөлөгдөж байна. Иймд бид энэ үгийг «нөдин-он» гэж сэргээв.

362. өшил-ийэн өшикүн (өшлөө өшихүн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «өсөгү» (36, 128), Пеллио «өсүкүн» (9, 25) гэж, Лигети (33, 52), Рахевильз (25, 41), Дашцэдэн (26, 45) нар «өсөкүн» гэж, Баяр (11, 1, 263), Элдэндэй Ардажав (8, 254) нар «өсэкүн» гэж тус тус сэргээсэн нь XIV зууны галигч нарын аялгууны алдаатай сэргээлтийн гажуудлыг дагасан зүйл гэж бодож байна. Учир нь нэгд, Лувсанданзан (31, 1, 54) энэ үгийг «хэр өшикү **бида**» гэж **бичсэн нь** түүнд байсан худам монгол бичгийн эхэд ингэж бичээстэй байсны баримт биз. Харин сударчийн үед үйлт нэрийн «кү»-г олон тооны «н» нөхцөлтэй бичдэг нь нэгэнт больсон учир тэр «н»-ийг хасч хуулсан бололтой юм. Иймд бид Иринчиний (28, 71) зөв сэргээсний адил «өшикүн» гэж сэргээх зөв гэж бодож байна. Хоёрт, «МНТ»-ы хятад галиг эхэд «өштү» (149, 210§), «өштэн» (133, 199§) гэж с биш ш гийгүүлэгчтэй үндэс дайралдаж байгаа нь энэ үсгийн с-ийн дараа и эгшиг байсныг харуулж байна. Гуравт, өс гэдэг үндэс нь нэр үгийн үндэс учир өс-ийэн (267§) гэж тийн ялгалаар хувилснаар тохиолдож байгаа тул түүн дээр л дагавар залгаж өсүл гэж нэр үг үүсгэснээр тэмдэглэсэн нь бас ташаа юм. Учир нь үйл үгнээс нэр үг бүтээх л дагаврыг нэр үгнээс үйл үг бүтээх ла, лэ дагавартай хутгаж болохгүй. Иймд «өсүл» гэж тэмдэглэсэн нь XIV үеийн гажуу дуудлагын алдаа мөн бөгөөд үүнийг өсил (өшил) гэж бичээстэй байсан гэж «өсил» гэж сэргээх нь зөв юм.

363. көүргэ (хүүрэг) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 105) «кэ'үргэ» гэж сэргээгээд «бөмбөр» «хэнгэрэгнүүд» гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлсан бөгөөд бусад судлагчид цөм үүнийг дагаж зөв сэргээж зөв ойлгож орчуулсан юм.
Бид энэ үгийг көг- (хөгжих хөхих гэх мэт үгийн язгуур, нэр үгийн 1 үндэс) +р- (нэр үг, дайвар үгээс үйл үг бүтээх дагавар) +гэ (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг гэж ухаарч энэ нь хүний сэтгэл **урмыг хөгжөөх** юмын нэр бөгөөд көхикү (сэтгэл хөөрөх) гэсэн үгтэй язгуур гарал нэгтэй үг гэж төсөөлөн сэргээж тайлбарлав.

364. көкидэк (хөхидөг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш **«көкидэк»** гэж сэргээн сийрүүлээд хадмал хятад орчуулгын утгыг «сэтгэл догдлохдоо амархан», «аймхай хулчгар» (36, 103) гэж тайлсан байна. Энэ үгийг судлагчид цөм ингэж сэргээн ийм утгатай үгээр орчуулдаг. Энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав (8, 260) бичгийн хэлэнд «зоригжих, урамшуулах (көкигүлкү, шангнаху, урамшигулху) зоригжигулху» гэсэн утгатай гэсэн нь ерөнхийдөө зөв боловч энд «муу эр дайнд хөөрөх» гэдэг зүйр үгийн адил аймхай сандрамтгай гэсэн өөр ёж утгаар хэрэглэгдсэн тул тайлбарлагчид арай өрөөсгөл хэлжээ. Энд хадмал хятад орчуулга (Хэнишийхээр бол) илүү зөв болохыг тэмдэглэе. Жич энэ үгийг Мансан (27, 78) «балдан хэлмэгдэх», Дугаржав «көксдэг» (24, 47), Дамдинсүрэн «ташаарсан» (7, 64) гэх зэргээр орчуулсан нь нийт монгол хэлтэнд төдий л оновчтой бус бөгөөд «көкидэк» гэснээр нь «көкэдэг» (зөв нь «көкидэк») гэж Лувсанданзаны сэргээснээс утга учир дутмаг болжээ гэж бодном.

365. [дал]давчиту хор (далдавчит сум) — гэсэн үгийг хятад галиг үсгээр нь Хэниш «дабчи -ту» гэж зөв сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг «ороолттой» «бүрхүүлтэй саадаг» (36, 30) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио «бүрхүүлтэй саадаг салгалахад» (9, 147), Козин «урт хөвчтэй нум манай энд долгилоход» (14, 101) гэж, Мостарт «бүрээстэй саадаг савлан хөдөлөхөд» (47, 351 [47]) гэж тус тус орчуулсан нь миний бодоход Хэниш, Мостарт хоёрынх илүү ойртжээ. Ойлгоход бэрх энэ үгийг Лувсанданзан орхиж хор гэдгийг «хой» дарвалзахад гэсэн нь хор гэдэг үгийн мадагтай бичлэг мөн боловч Мансан үүнийг «хуй» гэж ойлгосон бололтой «хуй ту сагадаг-ун дэрбэлгэнд (27, 78) гэж орчуулж, Элдэндэй Ардажав нар (8, 260) хөвчилсөн нумны хөвч урт болж хэв мөчдийг мөн тавч гэнэ гэсэн Хорин нэгт толийг заажээ.

Бидний санавал энд давч гэсэн нь нум саадагтаа багтахгүй давчуу байгааг хэлсэн тул энэ үгэнд холбогдолгүй болов уу. Хадмал хятад орчуулгын утгаар бодвол уг галиг эхэд үгийн эхний «дал»-гэсэн үе хаягдаад утга учир нь олдохгүй болсон мэт санагдана. Үгтаа энэ «далдавчи-ту хор дарвалзахад» буюу нуусан сум цухалзахад гэсэн утгатай үг байсан байх гэж таамаглан ийнхүү «[дал]давчи-ту» гэж сэргээв.

366. дайижи[г]чи (дайжигч) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «дайижичи» гэж сэргээгээд «үймээнч» «самуун дэгдээгч» (36, 31) гэж хятад хадмал орчуулгын утгыг тодорхойлжээ. Энэ үгийг Пеллио (9, 26), Мостарт (47, 329 [45]) (энэ үгийн хятад галиг үсэгт «дайижичи» гэж байгаа нь мадагтай гэж заагаад өөрөөр сэргээв). Рахевильз (25, 42), Лигети (33, 53), Дашцэдэн (26, 46), Баяр (11, 1, 272). Иринчин (28, 72), Элдэндэй Ардажав (8, 256) «дайижигчи» гэж сэргээгээд үгийн утгыг Хэниш «туйлаар айгч» (15, 25), Пеллио «үймээнч, бослогоч» (9, 147), Рахевильз «тал найзаа хаягч» (49, № 5, 1972, 151) гэх зэргээр орчуулсан байна. Лувсанданзан «дайичигчи» гэж, Дамдинсүрэн «ташааран дутаагч» (7, 164) гэж зөв ойлгожээ. Элдэндэй Ардажав нар (8, 261, тайлбар № 17) дайждаг, дутаадаг, салан явах хүн» гэж тайлсан нь арай л дутмаг болжээ.

Бидний санавал энэ үг дай[н] — (дайсан гэсэн утгатай байсан нэр үгийн үндэс)+жи (дайсан болох гэсэн утгатай үйл үгийн үндэс бүтээх дагавар) +гч (нөхцөлт үйлийн одоо цагт үйл эрхлэгчийг илтгэх үйлт нэрийн залгавар) гэсэн бүтэцтэй дайсан болж зугтаагч гэсэн утгатай юм.

367. тэмэчэкчи (тэмцэгч) — гэсэн энэ үг эртний монгол хэлний «тэмүүлэх», «зорих» гэсэн утгатай хэрэглэгддэг «тэмэкү» гэсэн үйл үг байсан бөгөөд үүнээс «тэмэгүлкү» (тэмүүлэх), тэмэчэкү (тэмцэх) гэх мэт үйл үг бүтээж энэ утгаараа эртний худам монгол бичигт хэрэглэгдэж байсны нэг нь энэ тэмэчэгч (тэмүүлэгч) гэсэн үг мөн болно. «Тэмэчэкү» гэсэн энэ үг эртний монгол хэлэнд хэрэглэгддэг энэ тэмүүлэх, зорин одох» гэсэн утгаараа монголын баатарлагийн туулинд одоо ч хэрэглэгдэж байдгийг орчин цагийн Монголын туульч Сүхийн Чойсүрэнгийн «Эзэн Улаан Бодон» туульд «Адууны аг сахал хөгшин... Адуун сүргээ тэмцээд гарчээ» (81, 99) гэсэн мөр харуулж буй.
Харин хуучин (сонгодог) монгол бичигт энэхүү тэмүүлэх зорих гэсэн утгатай «тэмэкү» гэдэг үйл үг хэрэглэгдэхээ байж түүнээс бүтээсэн «тэмэчэкү» гэсэн үйл үгийг «кэрэлдэкү тэмэчэкү» зэргийн (12, 587б) өөр утгаар хэрэглэх болсон тул гадаадын судлагчид энэ үгийг буруу орчуулахад хөтөлбөрлөсөн бололтой.

Хэниш энэ үгийг хятад галиг үсгээс нь «тэмэчэкчи» гэж зөв сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «уралдан тэмүүлэх», «маргалдан тэмцэх» гэж хуучин шинэ хоёр утгаар нь зөв тайлсан атлаа энэ үгийг Хэниш (15, 25), Пеллио (9, 147), Рахевильз (49, № 5, 1972, 151) «хурдан гүйж (?) орох» гэх зэргээр гол төлөв буруу орчуулсан нь энэ үгийн хожим хэрэглэгдэх болсон утгатай эндүүрсэн хэрэг. Лувсанданзан (31, 1, 56), Ардажав Элдэндэй (8, 256), Дугаржав (24, 47) нар «тэмэчэкү» гэж зорин тэмүүлэх гэсэн утгатай нь тайлбарлалтгүйд тооцон бичсэн бололтой. Харин Дамдинсүрэн «чиглэн... дутагагчи» (7, 56). Мансан шугуйд «шургуху» (27, 78) гэх зэргээр орчуулсан нь оновчтой болоогүй мэт. Бид энэ үгийг тэмэкү (зорьж тэмүүлэх), тэмэгүлкү (тэмүүлэх), «тэмэчэл» (тэмцэл), «тэмэгүлдэжү» (үүнийг 26-дугаар зүйлд «тэмгүлдэжү» гэж буруу галигласан байж магадгүй) гэх зэрэг үгтэй гарал нэгтэй төрөл үг байх гэж бодож ийнхүү сийрүүлэв.

368. кинггас..., сахал байан эсэн атугай (хянгас, сахал (сагал?) өвс баян эсэн байтугай) гэсэн эдгээр үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «кинггус» (36, 102) «сагал байан» (36, 131) «эсэн атугай» (36, 46) гэх мэтээр сэргээн босгоод хадмал хятад орчуулгын нь утгыг «кинггус-хөндлөн гэтлэх» гэж, «сагал байан» гэдгийг «хялгасан (?) өвс» гэж,

нөгөө «эсэн» гэснийг «амгалан байх» гэх зэргээр тайлсан нь цөм зөв болно.

«Кинггус» гэсэн үгийг Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр (11, 1, 275), Иринчин (28, 72), Элдэндэй Ардажав тэргүүтэн цөм «кингкүс» гэж сэрэгээж утгыг **Дамдинсүрэн «өнгөрч хөндлөн гараад»** (7, 65), Элдэндэй Ардажав **«хөндлөнөөр гэтлэх»** (8, 262, тайлбар № 22), Мансан **«гэтэлье»** (27, 78), Дугаржав **«хөндлөн гаталж»** (24, 48), Пеллио **«барууншаа огтолж»** (9, 147), Рахевильз **«хөндлөн огтлох»**, Поуха **«гэтэлж»** (?) (17, 47), Калужинский **«огтолж»** (61, 47) гэж орчуулсан бололтой санагдана.

Уул үг **«хөндлөн огтлох»** гэсэн утгатай нь үнэн болбол түүнийг **«кинггас»** гэж сэргээвэл илүү **зөв байх.** Учир нь зүсэх огтлох **багажийг «кинггар» (заазуур) гэж бичдэг бөгөөд «кингга-** (үгийн язгуур **үйл** үгийн 1 үндэс) +с (огтлох гэсэн утгатай дайвар үг бүтээх дагавар) залгаж «кинггас» гэсэн дайвар үг бүтжээ.

Нөгөө «сахал байан» гэсэн үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хилгасан (хялгана?) өвс» (36, 131) гэж **тайлж** герман хэлэнд орчуулсан (15, 25) **байдаг.** Үүнээс үзвэл хятад хадмал орчуулга нь сахал (сагал?) өвсний нэрийг «байан» гэсэн холбогдолгүй үгтэй буруу нийлүүлж орчуулсан бололтой. Пеллио **«сахал байан (өвс)»** (9, 147), Козин «тэдний сахал буянтай сайн байг» (14, 101), Мостарт **«сахал байан»** (өвс) (47, 332 [48]) гэж, Рахевильз **«өлөн өвс»** (49, № 5, 1972, 152), Клив **«огтолж»** (42, 41), Дамдинсүрэн **«өнгөрч хөндлөн гараад»** (7, 65), Элдэндэй Ардажав «улалжи» (8, 262, тайлбар № 8) гэж, Дугаржав (24, 48) «көндлөн гаталж» гэж, Мансан «гэтэлье» (27, 78) гэх зэргээр орчуулжээ. «Улалжи» гэгчийг С. Шагж **«өвс»** (12, 150б) гэж тайлбарлажээ.

Бидний санавал, сахал (буюу сагал) гэж гөрж сүлжиж уяа **татлагад** хэрэглэхэд тасрахгүй бөх өвсөн ургамлын нэр байх. Энэ **«улалж»** гэдэг үг «улжихуу»-**«арайхан тасрахгүй аху (байх)»** гэсэн (12, 153а) үгтэй утга ба гарал нэгтэй үг байж магадгүй. Энэ сагал буюу сахал гэдэг нь дангаараа тасардаггүй бөх улалжийн нэр **бөгөөд «байан» гэдэг нь «элбэг ургасан байгаасай» гэсэн оруулбар өгүүлбэрийн өөр үг байсныг** хадмал хятад орчуулгад ташааран нэгтгэжээ гэж бодож **байна.**

369. Эрүкэ (өрх) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн галигаас нь Хэниш «эрүгэ» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг нь **«дээврийн дугуй цонх»** (36, 46) гэж тайлсан бөгөөд энэ үгийг Пеллио, Лигети, Рахевильз Дашцэдэн, Мостарт цөм «Эрүгэ» гэж, Лувсанданзан (31, 1, 56), Дамдинсүрэн (7, 65), Баяр (11, 1, 276), Иринчин (28, 72), Элдэндэй Ардажав (8, 257), Мансан (27, 78), Дугаржав (24, 48) **цөм** «эрүкэ» (өрх) гэж зөв сэргээн ойлгосон юм. Энэ үгээр орчин цагийн монгол хэлэнд гэрийн өрхийг бүтээх ам дөрвөлжин эсгийг нэрлэдэг бол тэр үед ухмал газар гэрийн дээд нүхийг, дараа нь монгол гэрийн дээд онгорхойг нэрлэж байсныг бид урьд бичсэн өөр нэг өгүүлэлдээ (10, 163—164; мөн 82, 33—34) нэгэнт тайлбарласан юм. **«Эрүкэ»** гэдэг үг монголчууд нүхэн гэрт сууж байсан үеийн дээд нүхийг нэрлэдэг үг **байсан** гэдгийг нэмж тэмдэглэе.

370. Эркин экэд-[и]-ину (эркин эхдий нь) — гэсэн энэ үгийг хадмал хятад галиг үсгээс нь Хэниш «эркин э'эдэ» гэж сэргээгээд хадмал орчуулгын нь утгыг **«эрким,** чухал гол тавцан **(майхны гол тулгуур» (36, 46) гэж ерөнхийдөө зөв тайлжээ.** Энэ үгийн утгыг Хэниш, Пеллио, Рахевильз Клив тэргүүтэн цөм «гэрийн барилгын чухал хэсгийг» гэж ойлгож орчуулсан юм. Энэ «экэ-и ину» гэсэн үгийг дурдсан судлагчид «э'эд» гэж Хэнишийг дагаж сэргээдэг нь эргэлзээтэй. Энэ үгийг Лувсанданзан «экэ-дэ ину» гэж ойлгомжтой тодорхой сэргээсэн боловч чухам юуг тэмдэглэсэн үг болохыг тайлбарлаагүй юм. Энд «эркин эхэд [-э]ину» «хутуг экэдэ ину» гэж энэ хоёр үг хоёр удаа дайралдаж байгаагийн утгыг Дамдинсүрэн «эгүдэ (үүд)», «шитүгэн (шүтээн»)» (7, 66) гэж, Элдэндэй Ардажав харчны болон баарины аялгуунд «сарааЛжин маягийн цонх» буюу «дээдэх нь сараалж маягийн үүдийг хэлнэ» (8, 262—263) гэж, Мансан «их үүд» «их хаалга» (27, 79) гэж, Дугаржав «гэр, үүд, цонх зэргийг нийдэмд нь хэлсэн үг» (24, 48, т. № 2) гэж ойлгож тайлбарлажээ. «Эхэдэ» гэсэн энэ үгийг Козин «хамгийн хүндэтгэх юм» «ариун хутагт юм» (14, 101) гэж, Пеллио «гэрийн яс мод» «гэрийн хутгийн яс модыг» (9, 147), Мостарт «барилгын чухал яс мод» «Зол заяагаа тэнгэрт даатгасан хаалганы жааз буюу яс мод (?)» (47, 332) гэх зэргээр элдвээр орчуулсан байдаг.

Бидний бодлоор энэ үг өрх гэрийн их шүтээнийг залдаг өрх үүдний **«эхэд» (буюу Натигай ~ Начигай экэ», «Этүгэн экэ», «күснүг (күсүмэг) экэ»** (83. 95—101) эх тэнгэр онгонуудын ээл (эгэли-өлзий оршсон) эрхэм хутагт хэсэг-өрх үүд гэсэн утгатай байх гэж таамаглан төсөөлж «экэд-[э]ину» гэж сийрүүлэв.

371. буркиран бүкүй (бурхиран бүхий) — гэсэн энэ үгийг Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр (11, 1, 282) тэргүүтэн цөм «бүркирэн бүкүй» гэж сэргээн утгыг Хэниш «хүнгэнэн дүнгэнэн» (36, 23) гэх мэт үгээр хадмал хятад орчуулгын утгыг тайлсан тул өрнөдийн судлагчид үүнийг тэр утгын дагуу нүргэлэн (Пеллио), цуурайтан (Рахевильз), нүжгэнэн (Кливз) гэж, харгих (Ц. Дамдинсүрэн), хүнгэнэм (Мансан -27, 79) гэх мэтээр Элдэндэй Ардажав Дугаржав цөм «буркиран» буюу «буркир-э» (Дугаржав) их дуут гэж хэвээр хэрэглэжээ.

Бидний бодоход энэ үгийг «буркиран» гэж сэргээх нь илүү зөв гэж үзэв. Учир нь баркираху, урхираху, баргиа баргил хоолой гэх мэт үгтэй ойр утгатай учир «бүркирэкү» бус «бурхираху» байх учиртай. Хангинах, дүнгэнэх гэх мэт нь хан, дүн дан гэх мэт төмөрлөгийн шингэн дуутай холбогдох зүйлийг «дүнгэнэх» гэдэг тул бөмбөр бар бар дугарах дууг «буркир-а» дуут гэж хэлдэг байх. Энэ бол тасалдангүй чичрэнги дуу авиаг хэлэх тул ингэж сэргээх нь зөв биз ээ.

372. хатанггу дэбэл (хатуу болгосон дээл) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «гатангу» гэж сийрүүлээд «ган хатуу» «бөх» (36, 63) гэж хадмал хятад үгийн утгыг тайлсныг өрнөдийн судлагчид дагаж баримталдаг юм. Энэ үгийг Лувсанданзан «хатагу» (31, 1, 56) (хатуу) дээлээ гэсэн нь сонирхолтой бөгөөд энэ нь Хэниш авгайн ойлгосон шиг ган хуягт дээл гэсэн үг биш, бидний бодлоор Элдэндэй Ардажав (8, 264—265) нарын тайлбарласан шиг жирийн «хатуу хуяг дээл» гэсэн утгатай гэж бодном. Энэ учраас энэ үгийг Дамдинсүрэн «халх-а хуйагту дэбэл ийэн» (7, 66) гэсэн нь хамгийн зөв оновчтой орчуулга гэж болно. Учир нь энэ дээлэнд үхрийн хатсан зузаан ширээр илтсэн хуяг халх үдэж хийдэг байсан бололтой гэж таамаглаж тайлбарлав.

373. монггул жэ андгар тан бусуд-у (монгол зэ андгайтан бус уу?) гэсэн энэ үгийг галиглах ба утгыг ойлгох талаар судлагчдынхаас зөрөөтэй санал бидэнд алга. Харин «бусуд-у?» гэсэн үгийг Хэниш «үгүйсгэл үг» гэж тайлаад Хэниш «амандаа «күрэх үү? Үгүй юу?» гэсэн үгээр орчуулсан байхад энэ «бусуд-у» гэснийг Лувсанданзан «бусуху» гэж сэргээгээд «биш үү?» гэсэн үгээр тайлбарлаж, Дамдинсүрэн «биш билүү?» гэж, Дугаржав «бишиү?» (24, 51) гэж зөв сэргээсэн буюу орчуулсан байна. Харин Элдэндэй Ардажав «бусу ту?» (8, 269) гэж эндүү сэргээсэн ба Мансан «андгай-ача буцах буюу?» (27, 81) гэж арай өөрөөр орчуулсан байна.

Бидний бодлоор бол «андгартан... бусуд-у?» гэсэн нь монгол «андгартан» гэсэн олон тоот өгүүлэгдэхүүнтэйгээ «бус уу?» гэдэг өгүүлэхүүний «бусу» гэдэг үг нь олон тооны зохицолтой байдаг эртний монгол хэл ба худам бичгийн уламжлал ёсоор «бусуд» гэж бичигдсэний дээр «у» гэдэг асуух сул үг нь урт эгшиг үүсээгүй цагт автсан худам монгол бичигт «у» ганц эгшгээр бичигдэж байсан тул «бусуд-у» гэж Хэниш тэргүүтний буулгасан нь зөв гэж ингэж сийрүүлснээ тайлбарлая.

374. годулахуй и (годлохыг) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс нь Хэниш «годулаху» гэж зөв сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг «холбогдуулах» (36, 64) гэж ерөнхийдөө зөв чиглэлтэй тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 27), Дамдинсүрэн (7, 67) «торгох» гэж, Рахевильз (49, № 5, 1972, 154), Кливз (42, 44) «залхаах» гэж, Мансан «зэмлэх» (27, 81), Дугаржав «бууруушаан» (24, 52), Элдэндэй Ардажав «өв хөрөнгийн нэг хэсгийг сугалан авч яллаж байгааг харуулах» (8, 271) гэх зэргээр ойролцоо үсгээр ойлгож тайлбарласан ба орчуулжээ.

Бидний санавал энэ үгийг «годулахуй-йи» гэж сэргээн босгоод «голох зэмлэх» гэсэн утгатай гэж ухаарвал зөв болов уу гэж санана. Учир нь буруу муу явдал хийсний улмаас ах дүү, олон түмэнд ад үзэгдэхийг «году» болох гэсэн утгатай «Амьтанд ад адсаганд году болох» гэсэн зүйр үг байдаг тул үүнээс урьд цагт буруу хэрэг хийсний төлөө хүнийг голж муушаахыг «годулаху» гэж хэлдэг байжээ гэж бид таамаглав.

375. чамарлахуй-йи (голж зэмлэх) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «чимарлагу» гэж сэргээгээд, хадмал хятад үгийн утгыг «хараан загнах» (36, 27) гэж зөв орчуулжээ. Үүнийг Хэниш (15, 27), Дамдинсүрэн (7, 67) нар «шийтгэх» гэж, Пеллио (9, 149) «бууруушаах» гэж, Рахевильз (49, № 5, 1972, 15, 81), Кливз (42, 44) Дугаржав (24, 52) нар «зэмлэх» гэж, Мансан «яллах» (27, 81) гэж тус тус ойлгож орчуулсан бололтой. Энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав нар «түрэг нутаг» аялгууны чымат гэсэн уйгур «уур хилин» гэсэн үгтэй холбож «бууруушаах, уурлах, зэмлэх, гомдох, занал хорсол гэсэн утгатай» (8, 271) гэж тайлбарласан нь чухамдаа чам- чамла- гэсэн монгол үгнээс гаралтай монгол үгийг уур хилэн гэсэн уйгур үгтэй хүчээр холбосон гажуудалтай тайлбар шиг санагдана.

Бидний бодоход энэ үгийн үндэс нь чам- (үгийн язгуур дайвар үгийн I үндэс) +р (дайвар үгээс нэр үг бүтээх дагавар) +ла (гомдлох гэсэн утгатай үйл үг нэр үгээс бүтээх дагавар) +хуй (үйлт нэрийн ганц тоот одоо ирээдүй цаг заах хэлбэрийн **нөхцөл**) гэсэн бүтэцтэй үг **бөгөөд** гомдлоо зэмлэх, голж (чамлаж) зэмлэх гэсэн утгатай үг гэдэг нь илэрхий.

376. эчэлтэл-э (эцэслэтэл) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «эчэлтэлэ» гэж галиглаад «үлдээлгүй» (36, 41) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Энэ үгийг судлагчид Хэнишийн адилаар сэргээж утгыг мөн үлдээлгүй буюу «эцэслэтэл» гэсэн санаагаар орчуулсан байна. Харин Баяр энэ үгийг хуучин монгол бичигт «эчүстэл-э» (11, 1, 298) гэж арай ташаа сэргээсэн бололтой санагдана.

Учир нь эчүс гэдэг нэр үг тул түүн дээр үйл үгийн нөхцөл үйлийн үгтуулах хэлбэр бүтээх -тэл-э **нөхцөл** залгаж арай болохгүй мэт боловч **эчүстэл-э гэсэн энэ буруу бичлэг Шагжийн** (12, 73б) тольд эчүттэл, эчүстэл-э гэсэн үгс орсноос **Баяр гуайг төөрөлдүүлсэн бололтой байна. Түүнээс** гадна эчүс +л гэж нэр үг бүтээхэд эцсийн «с» гийгүүлэгч нь орхигдож эгшгээр төгссөн эчү- гэсэн үндсэнд лэ дагавар залгахад эцсийн «э» нь мөн орхигдож «эчүлкү» «эчүлтэл-э» гэх мэтээр энэ үг хувилдаг нь худам монгол бичгийн үсгийн дүрэмд нийцдэг байжээ. Эчүткү гэсэн үйл үг байхгүй, харин «эчүтлэкү эчүслэкү» гэсэн үйл үг мөн Шагжийн толь бичигт (12, 73б) байгаа нь «эчүдтэл-э, эчүстэл-э» гэсэн бичлэг буруу болохыг гэрчилж байгааг тэмдэглэе.

377. жигачин (загасчин) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «Жигачин» гэж сийрүүлээд «**загасчин**» (36, 89) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлсан нь зөв тул үүний галиг ба утгын талаар бүх судлагчдад ямар ч эргэлзээгүй юм.

Энд бид жигасу +чин гэж үг бүтээхэд эцсийн «су» нь хасагдаж «жигачин» гэдэг үг үүссэн сонин баримтыг энд тэмдэглэх гэсэн билээ. Энэ загвараар тэмүр+чин=тэмүчин (төмөрчин) гэсэн үг эртний монгол бичигт мөн дайралдгийг дурдалтай. Жич энэ зүйлд «**гөрүгүлүчин талбигсад**» (36, 31) гэдэг үг байгааг судлагчид Хэнишийн адилаар сэргээн босгоод «Ан баригчид, анчид» гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлснаар нь бусад судлагчид мөрдөн орчуулдаг байна. Хэниш «**зөвлөгөө өгч тусалдаг агсан анчид**» (15, 27) гэж, Козин «**ангийн ажил эрхлэгчид**» (14, 102) гэж зөв, Пеллио «...**ангийн ажилтай анчид**» (9, 149) гэж, Рахевильз (49, № 5, 1972, 155), Кливз (42, 44), Мостарт «ан гөрөөсний **гөрөөчин**» гэж урьдах судлагчдын адил орчуулахын хамт «**талбигсад**» гэдгийг «**дайн**» гэдэгт **хамааруулж «давхигсад дайсан** айсуй» (47, 333 [49]) гэж ташаа орчуулсан шиг байна. Энэ үгийг Лувсанданзан «танбиксан (талбиксан[-д]) тэр [дайин] [а]йисүн йаман <эдүр> [кэмэн]» гэх мэтээр цомийг буруу сэргээснийг үзвэл түүний худам монгол эхийн энэ хэсэг балархай, бичгийн хэлбэр маш муу байсан мэт. «Гөрүгүлүчин талбигсад» гэсэн үгс утга авцалдахгүйг мэдэж Дамдинсүрэн (7, 68), Мансан (27, 82), Дугаржав (24, 52) нар «**талбигсад**» гэдэг үгийг орхиж орчуулсан байна.

Бид энэ үгийг **XIV-ийн үеийн** галиглагчид буруу тэмдэглэсэн гэж бодоод утга зүйн үүднээс «**гөрүгүли талбигсад**» гэж сийрүүлэв. Учир нь «**гөрүгэчид талбигсад**» гэвэл загасчин, булгачин, гөрөөчдийг тэнд тавигсад (өөр хүмүүс) хэл хүргэхээр явсан гэсэн утга гарна. Иймд загасчин, булгачдаас гадна гөрүгүли (ангийн ажил) тавигсад буюу гөрөөчид тэр мэдээг хүргэсэн гэсэн учир зүйтэй үг гэж ойлгон сийрүүлэв.

378. дайн айисун (дайснууд айсуй) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс сэргээж ойлгох талаар судлагчдад зөрөөтэй санал байхгүй. Харин бид «дайин» гэдэг үгийг тэр цагт «дайсун» гэсэн утгаар хэрэглэгдэж байсныг Элдэндэй Ардажав (8, 172, т. № 4) нарын тайлбарласнаар тэмдэглэхийн хамт дайи гэдэг нь ганц тоот үг, дайин гэдэг нь олон тоот үг гэдгийг тэмдэглэе. Үүнд холбогдуулж бас айсуй гэдэг үгийг хятад галиг үсгээс нь «айиши» гэж эм хүйст үгээр сэргээдгийг галиглагчдын эндүүрэл гэж үзэж олон тоот нэрийн ёсоор хэрэглэгдсэн «дайн» (дайснууд) гэдэг үгтэйгээ тоогоор зохицож «айисун» гэж байхаар бодож сэргээв. Ингэж бодох үндэстэй нь Лувсанданзаны алдаатай балархай эхэд энэ үгийг «[а]йисүн» (31, 59) гэж ташаа бичсэн нь түүхчид байсан худам монгол бичгийн эхэд «айисун» гэж олон тоот хэлбэрээрээ бичээстэй байсныг давхар баталсан баримтаар нотлогдов.

379. даручажу (даруйцаж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь судлагчид цөм ингэж сэргээдэг ба даруйд нь араас нь залгаж гэсэн үйл үгээр орчуулдаг билээ. Энэ үгийн утгыг Хэниш «шууд дараа нь» (36, 33) гэж орчуулсан ба Дамдинсүрэн (7, 68), Мансан (27, 82) «**нэхэн нэхэмжлэн**» гэж тус тус ойлгосон юм. Элдэндэй Ардажав нар энэ үгийг манж хэлний дарухай гэх нь байнга, үргэлж хэзээд, ердөө, хэ-

зээ ямагт, тасралтгүй гэсэн утгатай гэж даруучажу гэвэл залгалдаж үргэлжлэх гэнэ» (8, 274) гэж тайлбарласан нь төдий л үнэмшилтэй бус. Бид энэ үгийг дару гэдэг нь дарах гэсэн үйл үгийн язгуур, 1 үндэс) +й (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +ча (нэрээс үйл үг бүтээх дагавар) +жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг бөгөөд «дару[й]цаху» гэх нь араас нь мөр дарун хөөх гэсэн утгаар хэрэглэгдсэн гэж бодно. (Энэ тайлбарын № 333-ыг үз).

380. бөжүкүй (байжээ) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «бүжү'үй» гэж босгож сэргээгээд хятад хадмал орчуулгын утгыг «байсан» (36, 21) гэж тайлжээ. Бусад судлагчид цөм Хэнишийн адилаар сэргээж тэр утгаар ойлгожээ.

Бид энэ үгийн хятад галиг эхэд «бүжүкүй» гэж «ү»-гээр тэмдэглэснийг XIV зууны галиглагчдын алдаатай тэмдэглэл гэж үзээд «бөжүкүй» гэж сэргээх нь зөв гэж бодов. Учир нь бү- үндэс нь хориглох үйл үг байсан (энэ тухай энэ тайлбарын 255 дугаар зүйлд үз) тул энэ нь үг нь бө-үндэстэй бү-гийн эсрэг бай-гэсэн утгатай үг байсан гэж бодно. Нөгөө талаар «бө'этэл-э» (111 дүгээр зүйлд) «бө'эт» (бөгөөд) (159, 170 дугаар зүйлд) гэх мэтээр энэ үйл үгийн бусад зарим хувилалд нь бө- үндэс бичигдсэн байгаа нь «бүжүкүй», «бүрүн» гэх мэт бичлэгийн буруу болохыг гэрчилнэ гэдгийг тэмдэглэе.

381. чулбугур (цулбуур) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «чилбур» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «Хазаар ногтны сур» (36, 27) гэж тайлсан бөгөөд судлагчид энэ саналыг дагаж цөм ингэж сэргээн ингэж ойлгож орчуулж тайлбарладаг билээ. **Бид энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «чулбугур» (12, 786) гэж бичдэг уламжлалаас ургуулан уламжилж** бодвол энэ үгийг эртний худам монгол бичигт «чилбур» гэж бичиж байгаагүй, харин **«чулбугур» гэж бичиж байсан гэж төсөөлөн «чулбугур» гэж сийрүүлэв. Учир нь** энэ үгэнд хэрэв «ч» авианы дараа «и» байсан бол халх аялгуунд цулбуур биш «чулбуур» гэж дуудагдах байсан биз. (чилагу чулуу, чөмү цөм гэх мэт). Нөгөө талаар энэ үг чулбу (чирэх татах гэсэн утгатай үйл үгийн язгуур, үйл үгийн 1 үндэс) +гур (үйл үгээс багаж хэрэглүүрийн нэр бүтээх дагавар) гэсэн үг гэж үзэв. Энэ нь хада-хадагур (хадуур гэх мэт) Чухамхүү чулбу үндэснээс -гур дагавар залгаснаар хуучин монгол бичигт бичдэг уламжлал чулбу+р гэсэн аргаар бүтээгүй, харин -гур дагаврын аргаар бүтсэнийг гэрчилнэ.

382. тосулчаба (тосолцов) — гэсэн энэ үгийг хятад галиг эхийн үсгээс нь Хэниш «тусху ~ тусулчаху» гэж сийрүүлээд хадмал хятад үгийн утгыг «нэг нэгэн уруугаа ухасхийлцэх» (36, 156) гэж тайлсан бөгөөд нөгөө «тусху» гэсэн өөр үгийг нь «зодох» (245§), «урах татлах», «бат барилцах» (36, 56) гэж хадмал хятад орчуулгыг германчилжээ. Энэ үгийг Козин «туйалчаба» (14, 225), Пеллио (9, 27), Лигети (33, 56), Дашцэдэн (26, 49), Баяр (11, 1, 304), Иринчин (28, 77), Элдэндэй Ардажав (8, 273) нар цөмөөр «тусулчаба» гэж сэргээв. Энэ үгийг Хэниш «тэврэлцэхээр ухасхийв» (15, 27), Пеллио (9, 150), Рахевильз (49, № 5, 1972, 155), Кливз (42, 45) цөм «бие биеийн тэвэрсэн гарт унав» гэх мэтээр орчуулжээ.

Бид энэ үгийг «тусху» гэдэг «цохих» гэсэн утгатай үгнээс өөр хоёр хүн бие биерүүгээ хүсэмжлэн угталцах гэсэн утгатай үг гэж ухаарах «тосуху» гэж сийрүүлэв. Монголчууд уулзалгүй удсан хүмүүс золгохдоо алгаа өөд харуулан «тосож» бие биеийн өдөөс гүйж тохой зөрүүлэн золгодог учир ийнхүү хүсэмжлэн тэврэлдэж уулзахыг бас «тосулчаба» гэж бичсэн болов уу гэж таамаглаж байна.

383. тэригү урида (тэргүүн урьд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «тэри'үн урит» гэж сийрүүлж хадмал орчуулгын утгыг Хэниш «Толгой, гол» гэх мэтээр тайлжээ. Бусад судлагчид ерөнхийдөө зөв сэргээж зөв ойлгож орчуулсан байдаг. Хэниш «бүр урьд» (15, 28), Пеллио «язгуур цагт» (9, 150), Рахевильз «эрт» (49, № 5, 1972, 155) гэж, Кливз «эхэн эрт урьд цагт» (42, 45) гэхчлэн орчуулснаас сүүлчийн судлагч нь утгыг илүү тусгажээ.

Бид энэ «тэригүү урид-а» гэж энэ «толгой» гэсэн үгийг уул ус, цэргийн ангийн дараалал зэрэгт утга шилжүүлэн хэрэглэхээр үл барам бас цаг хугацаанд хэрэглэсэн нь бидэнд сонирхолтой юм. Ардын баатарлагийн туулинд тэригүн гэдэг үгийн оронд «эрт урьд, эхэн ангхан түрүүн чагт л» (45, 141) гэх зэргээр хэлсэн байдаг нь мөнөөхөн «тэригүүн (толгой)» гэсэн үгийн утгыг цаг хугацааны түрүүчид шилжүүлэн хэрэглэсний баримт бөгөөд энэ үгийг худам монгол бичигт толгой тэригүүн гэдэг үгнээс ялгаж хугацаанд «түрүүн» (12, 632) гэх болсон ба ургамлын зүйлд хэрэглэвэл «цагаан түрүү», «далан түрүү» гэх мэтээр ялгаж бичдэг болжээ.

384. хатар магу (хатар муу) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «хатар мао'ий» гэж сэргээгээд «хадмал хятад орчуулга байх-

гүй» гэж өөрөө энэ үгийг «ерийн» «нийтийн» «муу» (36, 63) гэж ойлгосон юм. Энэ үгийн утгыг Хэниш «ердийн муу» (15, 28), Пеллио «ховдог муу» (9, 150), Рахевильз «жигшим муухай» (49, № 5, 1972, 156) гэж, Кливз энэ үг хадмал орчуулагүй ба өөр газар бүртгэгдээгүй гэж заагаад орчуулалгүй «хатар муу» гэжээ. (42, 46) Козин «эгэл үст», «харц тариачин» (14, 104), Мостарт энэ үгийг «муу» гэдгийг орчуулаад нөгөө «хатар» гэдгийг орчуулсангүй. «Хатар» гэдэг үгийг Дамдинсүрэн «хариугүй муу» (7, 69), Элдэндэй Ардажав (8, 280) түрэг хэлний катэр гэдэг «аюул, гай зовлон» үг байгааг заахын хамт Захчид-сэчэн Лессингийн толийн «агуулах сав» гэж тайлбарласныг зааснаас өөр тайлбар өгсөнгүй. Мансан (27, 99) «чанар муу» гэсэн үг гэж, Дугаржав Дамдинсүрэнтэй адилаар орчуулав.

Бид энэ үгийн жинхэнэ утгыг тодорхой төсөөлөхгүй боловч «хатар» гэж морины ширүүн гүйдэл болон олны бүжгийн нэр байх тул «хөнгөмсөг завхай явдалт, өөдгүй явдалт» гэсэн үг биш байгаа гэсэн сэтгэгдэл төрж байна.

385. унтагу (уур унтуу) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь судлагчид Хэнишийн адил «Хунтао'у» буюу «хунтаву» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «хор хөнөөл» (36, 79) гэж орчуулсныг ерөнхийдөө баримталдаг байна. Лувсанданзан «буруу» (31, 61) гэж, Дамдинсүрэн «хачигдах аюулд» (7, 69) гэж, Мансан «көнөөл» (27, 83), Дугаржав (24, 54) Дамдинсүрэнгийн адилаар орчуулж, Элдэндэй Ардажав «унтагу» гэж зөв сийрүүлэхийн хамт «зовлон, хохирол, хорлол, хөнөөл» (8, 280, № 12) гэж тайлбарлав.

Бидний бодвол энэ үгийг Элдэндэй нарын адилаар «унтагу» гэж сэргээх нь зөв гэхээс гадна үгийн эгшгүүд уруулын байдлаар зохицох ёсыг тусгаж хуучин бичигт «унтугу чаху-баахан килинглэкү» (12, 127б) гэсэн үгийн худам монгол бичгийн хувилбар гэж үзэх тул «унтагу» гэдэг «килэн хорсол, зэвүүцэл» төрүүлэх гэсэн утгатай гэж ийнхүү сэргээв.

386. хун, тогурагун (хун [цэн?] тогоруу) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «тохора'ун» (36, 150) гэж, Пеллио, Рахевильз «тохура'ун», Лигети «токура'ун», Дашцэдэн «тогураун» гэх зэргээр XIV-ийн аялгууны дагуу, Дугаржав хуучин монгол бичгийн дагуу тогуруу гэж, Баяр «тогурагун» гэж, Элдэндэй Ардажав (8, 277), Иринчин (28, 78) нар «тогурагун» буюу «тохурахун» гэж сэргээснээс эртний худам монгол бичгийн үүднээс тохурахун буюу тогурагун гэсэн Иринчин, Элдэндэй Ардажавынх хамгийн зөв нь гэж бид баримтлав. Учир нь хуучин монгол бичигт энэ үгийг «тогуруу» (12, 601б) гэж бичдэг уламжлалтай боловч монгол үгийн эгшиг уруулаар зохицох ёс ба урт эгшиг үүсэхээс өмнө авсан худам монгол бичигт «тохурахун буюу тогурагун» гэж бичигдэх нь лавтай гэж хэлж болно.

Энэ хоёр үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгаас нь «Гогой [хар галуу] буюу хөх дэглий, тогоруу» (36, 150) гэж, Козин «галуу тогоруу» (14, 104), Дамдинсүрэн (7, 69), Мансан (27, 84) нар «хун галуу», Пеллио (9, 150), Мостарт (47, 337[53]), Рахевильз (49, № 5, 1972, 156), Кливз (42, 46), Дугаржав (24, 54), Элдэндэй Ардажав нар цөм «хун, тогоруу» гэж орчуулсан нь зөв юм. Жич Козин Дамдинсүрэн Дугаржав нар «хун тогоруу» гэснийг «хун ба тогоруу» гэсэн үг биш хун [цэн] тогоруу гэж нэг нэр гэж бодоод «гуси-лебеди», «хун галуу» гэж эндүүрсэн байж магадгүй юм.

387. хунар (хунх) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн бичлэгээс Хэниш (36, 72), Пеллио (9, 28), Лигети (33, 57), Рахевильз (25, 46), Дашцэдэн (26, 50), Баяр (11, 1, 314), Иринчин (28, 78), Мансан (27, 84), Элдэндэй Ардажав (8, 277) тэргүүтэн цөм «хунар» гэж сэргээсэн нь зөв тул бид ч ийнхүү сэргээв. Харин энэ үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулагагүйг заагаад Ковалевскийн ёсоор «Хувцас хунар» гэж орчуулсан юм. Үүнийг Козин «үхээнц» (14, 104), Хэниш «ноорхой утэл» (15, 28), Пеллио «ховдог(?)» (9, 150), (Мостарт орчуулалгүй орхижээ). Рахевильз «өгөр» (49, № 5, 1972, 156) Поуха (17, 52) «чигчийн чинээ (өчүүхэн)» гэж, Калужинский «өөдгүй муу» (61, 62) гэж, Дамдинсүрэн «хувхай муу» (7, 69), Дугаржав «хувь муутай» (24, 55), Мансан «хунийар (дотор)» (27, 100, III бүлгийн тайлбар № 8) гэж, Элдэндэй Ардажав «айл хунар» «хувцас хунар» (8, 282) гэж тус тус ойлгож орчуулсан буюу тайлбарласан байна.

Бид «хунар» гэсэн энэ үгийг «хунгх-атай—хүний үзэмж сайтай» (12, 412а), «хунгши-нөхрийн ханилгааны чанар чансаа» (53, 730) гэсэн үгстэй гарал үүсэл нэгтэй үг бөгөөд «үзэмж чанар» гэсэн утгатай «хун» гэсэн үгийн язгуур үндэснээс -р, -[г]х-а, -[г]сн гэх мэт дагавар залгаж бүтсэн төрөл үгс гэж бодно.

388. киргусун (хуурсны) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн эхээс нь Хэниш «Хорхосун» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг

«хонины хорголын зүйл» (36, 67) гэж тайлсны улмаас энэ үгийг Хэниш (15, 28), Пеллио (9, 151), Рахевильз (49, № 5, 1972, 156), Кливз (42, 46), Козин (14, 104), Поуха (17, 5), Калужинский (61, 63), Дамдинсүрэн (7, 70), Баяр (11, 1, 316), Иринчин (28, 78), Элдэндэй Ардажав (8, 283), Мансан (27, 84) (Дамдинсүрэнгийн адилаар), Дугаржав (24, 55) цөм «хоргосны буюу хорголын төдий» амь гэж буруу орчуулсан буюу тайлбарласан байдаг. Гэтэл энэ үгийг Лувсанданзан хогусуны төдий гэж хоёр ч удаа зөв сэргээгээд урьд нь «хогурсуны» (31, 61) гэж зөв оновчтой тайлбарласан нь хятад галиг үсгийн эхээс **өөр бичлэгтэй** худам монгол бичгийн эх сударчид байсныг харуулж байна. Энэ үгийн Америкийн монголч талийгаач эрдэмтэн Хангин Гомбожав Өвөрмонголын багшийн их сургуулийн «Монголын нууц товчоон»-ы олон улсын эрдэм шинжилгээний ярилцах хурал-(хэлний салбарын хуралдаан)-д тавьсан «Монголын нууц товчоон» дахь зарим зүйр үгсийн тухай» илтгэлдээ хятад галиг үсэг ба хятад хадмал орчуулгын алдаатайг зааж Лувсанданзаны сэргээлт ба тайлбарын зөвийг зааж «хигурасу» гэж бичдэг уламжлалыг харгалзан «энд амьгүй хорголыг хэлээгүй, бөөстэй салшгүй «хуурс»-ыг хэлж байна» (84, 23) гэж зөв тайлбарлажээ. Иймд бид энэ саналыг хамгийн зөв гэж үнэлж энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт бичдэгээс эртний монгол бичигт арай өөрөөр «Киргусун-у» гэж сэргээхдээ хятад галиг эхэд уг үгийг «хоргусун» гэж алдаатай бичсэн үсгийн дарааллыг баримтлав. Энэ үгийг хожим хуучин монгол бичигт үе солигдон «кигүрсун» гэж өөрөөр бичих болжээ гэж таамаглав.

389. хигусун (хигурсун ~ хуурс) — гэсэн үгийг энд саях үгийн эртний бичлэгийн өөр нэг хэлбэр нь хигусун гэж Лувсанданзанд байсан худам монгол бичгийн эхэд ингэж бичигдсэн байсан байж магадгүй гэж бодож ийнхүү бичив. Энэ нь «чагарсун ~ чагасун» гэдэгтэй адил хувирлын хоёр шатны чухам алинаар байсныг тогтоох аргагүй тул ийм хоёр хэлбэрийг санал болгон зэрэгцүүлэн сэргээв.

390. навтархай (навсархай) — гэсэн энэ үгийг сэргээн босгох ба утгыг ойлгох талаар судлагчдад бэрхшээл ба санал зөрөх зүйлгүй. Энд бид энэ үгийг навт (навс-гэсэн үгийн язгуур ба дайвар үгийн 1 үндэс) +р (дайвар үгээс үйл үг бүтээх дагавар) +хай (үйл үгээс тэмдэг нэр бүтээх дагавар) гэсэн бүтэцтэйг үг болохыг хүлээхийн хамт энэ үг эртний монгол хэлэнд т (хамжих) гийгүүлэгч хожмын монгол хэлэнд их **төлөв с (шүргих) гийгүүлэгч болж хувирдаг нэг жам байсны нэг жишээ мөн гэдгийг тэмдэглэе.**

391. барагун... жэгүн эгүдэ[н]-ийэр (баруун... зүүн үүдээр) — гэсэн үгийг хятад галиг үсгээс нь гол **төлөв** «бара'ун... жэвүн эгүдэн-бэр» (Пеллио, Дашцэдэн) гэж бичсэнийг Лигети (33, 57), Рахевильз (25, 46) «эгүтэ(н) бэр» гэж залруулсан галигийн үүднээс зөв боловч харин үүнийг Баяр гуай «барахун ...жэхүн эгүдэ-бэр» гэж сэргээгээд хуучин монгол бичгээр «барагун... жэгүн эгүдэн-ийэр» гэж залруулж бичсэн нь худам монгол бичгийн үүднээс маш зөв сийрүүлсэн гэж бид баримтлав. Харин Пеллио, Дашцэдэн, Элдэндэй Ардажав (8, 283) тэргүүтэн цөм «э'удэн-бэр» гэх буюу «эгүдэн-бэр» гэж сэргээсэн нь чухамдаа XIV зууны галиглагчдын ташаа дуудлагыг дагасан буруу сэргээлт болно. Баруун зүүн үүд гэдэг үгийн утгыг Хэниш «хаалганы баруун талаар зүүн гар талаар» (15, 28), Пеллио (9, 51), Поуха (42, 47), Калужинский (61, 151) нар «Баруун... зүүн хаалгаар» гэж, Рахевильз «хаалганы баруун, зүүн гар талаар» (49, № 5, 1972, 157) гэж орчуулсны дотроос хамгийн сүүлчийнх нь илүү зөв болсон гэж үзэж байна. Монгол хэлтэн судлагчдад энэ нь хэн ч эндүүрэшгүй тодорхой зүйл учир Лувсанданзан, Дамдинсүрэн, Мансан, Дугаржав, Элдэндэй Ардажав цөм уг үгийг хэвээр тайлбаргүй сэргээжээ.

Эгүтэ ~ эгүдэ гэдэг үгийн үндсэн утга нь анх гэрийн хаалганы доторх **хөндий зай**, онгорхойн нэр байгаад сүүлдээ түүнийг битүүлдэг **унжуулсан** эсгийн нэр болсон учир энэ сүүлчийн утгаар нь энд хэрэглэгдсэнийг мэдэхгүй гадаадын судлагчид «хаалга» гэсэн өөр үгтэй хутгаж алдаа гаргажээ. Жич баруун... зүүн үүд гэдэг орчлонгийн дөрвөн зүгийг биш, баруун зүүн гар талын гэсэн утгатайг мэдвэл сая зөв ойлгож болно. Баруун гар талын үүд гэдэг нь гаднаас орох хүний баруун гар талаар урагшаа харуулж барьсан гэрийн үүдний зүүн талын завсраар орох гэсэн утгатай. Зүүн гар талын буюу үүдний баруун завсраар гадагш гарсан гэсэн үг болно.

392. түбэжүкүй (төөрчүкүй) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш «түбэкү» гэж сэргээн утгыг «ураг холбон, нийлж, самуурах» (36, 153) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Хэниш «ерийн хүнтэй толгой холбож» (15, 29), Пеллио «би муу хүнтэй нийлж явжээ» (9, 151), Поуха «ерийн хүнтэй явж байжээ (?)» (17, 52), Калужинский «үг муут хүнтэй холбож явжээ» (?) (61, 63), Рахевильз «би доорд

хүнтэй нийлж явжээ» (49, № 5, 1972, 157) гэж тус тус орчуулсан бололтой санагдана. Дамдинсүрэн (7, 70), Мансан (27, 85) нар «харц муу хүнд харьяалагдаж явна» гэж, Дугаржав «харийн хүний харьяат болж» (24, 56), Элдэндэй Ардажав нар энэ үгийн олон утгыг заан тайлбарласны дотор «түвэлдүн учирсан хатун чину» гэсэн Эрдэнийн товчийн (23, 130) үгийг «тэнгэрээс хүртээсэн сайн ерөөлөөр учирсан хатан чинь гэсэн үг» (8, 284—285) гэж тайлбарласан нь нэлээд үндэстэй тайлбар юм. Учир нь Лувсанданзан энэ «түбэжү» гэсэн үгийн оронд «муу хүнд учирч аму» (31, 1, 62) гэж бичсэн явдал түбэкү гэдэг хувь заяагаар учирсан гэсэн утгатай байж магадгүй юм.

Гэвч энд муу хүнд «тубэжүкүй» гэсэн үгийн утга нь ерөөл учирлаар учирсан гэдэгтэй учир зүйн хувьд сайн нийцэхгүй тул «түбэх» гэдэг үг бас «самуурах түвэж будлиулах» гэсэн саар өнгө аясын утгатай байж болно гэж бодно. Учир нь «бүбэгэх» гэвэл «будлиулах самуураруулах сүйтгэх» гэсэн утгатай тул түүний эс тусах хэлбэрийн «самуурах», «төөрөлдөх» гэсэн утгатай байж магадгүй юм.

393. Эбүриткүн мэтүс-и (Өвөртлөх мэтийг) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «Эбүритқү» гэж сэргээгээд хадмал хятад орчүүлгын утгыг «Өвөртлөх, эм болгох» гэж зөв тайлж бүх судлагчид түүнийг нь дагадаг юм.

Гэвч үүнийг Хэниш «эмэс ба хүүхдийг эмлэхийг» (15, 29) Пеллио «үлдсэн эмс ба тэдний охидыг өвөртөлмөөр цэвэрхэнийг өвөртлөх» (9, 151), Рахевильз «татвар эмсэд тэнцэх мэтийг татвар эмс болгох» (49, 157), Кливз «өвөртлөн төврэх болохыг өвөртлөн төврэв» (61, 47), Поуха «эхнэрт тэнцэхийг нь эхнэр болгов» (17, 53), Калужинский «өвөртөө авал зохихыг өвөртөө авав» (61, 63) гэх мэтээр орчуулсны дотор ялангуяа «эмэ көбөгүд» өөрөөр хэлбэл «охид» гэсэн үгийг Хэниш, Пеллио нар «эмс ба хүүхэд» (Хэниш) «эмс ба охид» (Пеллио) гэх мэтээр буруу ойлгож ташаа орчуулдгийг тэмдэглэе. Дамдинсүрэн «үүрд дотнолж авав» (7, 71), Мансан «өнгө сайтайг нь өвөртөө оруулав» (27, 85), Дугаржав «өвөрлөж болохыг өвөрлөв» (24, 56) гэж орчуулж, Элдэндэй Ардажав «асран тэжээх, аварах, хэлтрүүлэх, үүчлах» гэсэн утгатай гэдэг нь «бэлбэсэн гэргий буюу татвар эмсийг авах» гэсэн утгаар хаяа хэрэглэгддэгээс бусад нь оновчтой бус тайлбар болжээ.

Бид энэ үгийг «эм хүүхэд» буюу охидоос таалагдах заримыг (татвар) эм болгон авч» гэсэн утгатай үг бөгөөд эбүри (буюу өвөр үгийн яз-гуур, нэр үгийн 1 үндэс) +дэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +кү (үйл үгийн үйл нэрийн ирээдүй цагийн нөхцөл) +н (үйлт нэрийн олон тооны нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож ийнхүү сэргээн босгов.

394. эрэ хачиту (эр хачит) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш, Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр тэргүүтэн цөм «эрэ хачиту» гэж Баяр (11, 1, 325), Мансан (27, 86), Элдэндэй Ардажав (8, 236) нар «ачиту» гэж хуучин монгол бичгээр сэргээжээ. Энэ үгийн утгыг Хэниш (15, 29), Мансан (27, 100) нар «эрийн өшөөт» гэж, Дамдинсүрэн (7, 71), Дугаржав (24, 57) «эртний өшөөт мэргэд» гэж, гэтэл Рахевильз «эрэлхэг бөгөөд залхавал зохих» гэж, Кливз «эрийн өшөө авагч мэргэд» (42, 47) гэж янз бүрээр орчуулсан юм.

Бид энэ эрэ хачиту Мэргид гэдгийг эрэлхэг бөгөөд өшөөрхөгч мэргид гэж Мэргидэд хамаарах тодотгол гэж санана. Учир нь нууц товчоонд зүрхэн ба Ун хааны Жүрхэн овгийг ялсан тухайдаа бас ялагдсан овгийн баатар эрэлхэгийг ямагт хэлж эцэст нь «тэйим[-үн], омугтан иргэн-и Чинггис хаган дорайитагулжу» (9, 38, 139) гэх зэргээр бичдэг уламжлалт бичлэгээрээ энд өөрснийгөө бус харин ялагдсан дайсныхаа эр зориг, эрэмгий чадлыг магтаж тийм айхавтар дайсныг дарсан гэж Чингис хааныг магтдаг байна.

395. арбилаба (арвитган олзлов) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь бүх судлагчид цөм «арбилаба ~ арбилабай» гэж сэргээгээд утгыг нь Хэниш «дээрэмдэж» (36, 8; 15, 29) Пеллио «булаан авч» (9, 151) Рахевильз «олзлон барьсан» (49, 159), Кливз «дээрэмдэн хүчирхэж» (61, 47) гэх мэтээр гадаадын судлагчид орчуулдаг бол Дамдинсүрэн (7, 71), Дугаржав (24, 57) нар «олзлон» гэж, Мансан «хураамжлав» (27, 86), Элдэндэй Ардажав Иринчин нар тайлбарлалгүй «арбилаба» гэжээ.

Бидний санавал энэ арби(н)- (юмын их нөөцтэйг тэмдэглэсэн утгатай тэмдэг нэрийн үндэс) +ла (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +ба (үйл **үгийн цаг заах төлөвийн саяхан өнгөрсөн төгссөн** цагийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна.

396. бусанигаж (бүснүлж) — гэсэн энэ үгийг хятад галигаас нь Хэниш (36, 23), Пеллио (9, 29), Рахевильз (25, 47), Дашцэдэн (26, 52), Баяр (11, 1, 327), Иринчин (28, 80), Козин (14, 28 ба 226) нар «бусанг-

хажу ~ бусан(г)хажу» гэж, Элдэндэй Ардажав «бусахажу ичүй-э» (8, 287) гэх зэргээр сэргээсэн байдаг. Дамдинсүрэн «дайлаж буцав» (7. 71) гэж, Дугаржав «бусанигулжу» (24, 57) гэж орчуулсан юм. Гэвч бид энэ үгийг «бусанигажу» гэж бодож ингэж босгон сийрүүлэв. Учир нь хуучин монгол бичигт (12, 284б) «бусаниху» (сүйдэх зэргийн) гэсэн үг байгаа нь бус болох буюу үгүй болох гэсэн утгатай тул «бусу» гэдэг үгийг анх монгол хэлэнд үгийн эгшиг уруулаар зохицох ёс гарахаас өмнө «бусу» биш «буса» гэж бичдэг байсны гэрч гэж бодно. «Бусу» гэж байгаагүй «буса» гэж бичигдэж хэлэгдэж байсны өөр нэг баримт нь саях толинд «бусаки-үг явдал зольгүйг нь» «бусакилаху-золь үгүй-бэр аашлах» (12, 284б) гэсэн үгс буртгэгдсэн явдал болно. Эртний монгол хэлэнд буса<бусу гэсэн үгийн үндэс нь үйл үг байгаагүй гэдгийг «бусарлаа» гэдэг үг наалдсан хоёр юм «салаад» гэсэн утгатайгаар байсныг «өнчин Буш (Бүш) хүү» (85, 151—153) гэдэг үлгэрийн үг харуулж байна. Иймд Буса (бус) гэсэн утгатай үгийн язгуур нэр үгийн 1 дүгээр үндэс)+ни (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +га (үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жү (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Бусан(г)хажу гэдэг нь хэрэв зөв гэж үзвэл буса-гэдэг үндэс нь үйл үгийн үндэс, үүн дээр -нгхай гэсэн дагавраар үйл үгнээс тэмдэг нэр үүсэх тул туранха-гэдэг нь үйл үгийн үндэс болж хувирсан гэж итгэхэд хэцүү юм. Хэрэв энэ үг бусангха-гэдэг үйл үг биш гэвэл түүнд -жу гэсэн нөхцөл үйлийн нөхцөл залгаж болохгүй байхсан. Энэ үүраас бид энэ үгийг «бусанихажу» гэж худам монгол бичгээр тэмдэглэгдсэн үг галиглахад алдаатай бичигдсэн гэж таамаглаж байна.

397. Годун-годус- ту (Годан- гуталт) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «ходу(н)» гэж сийрүүлж, хадмал хятад орчуулгын утгыг «турайн (хөлийн) арьс» (36, 64) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 29), Лигети (33, 56), Рахевильз (25, 47), Дашцэдэн (26, 52), Баяр (11, I, 328), Иринчин (28, 80), Элдэндэй Ардажав (8, 289) нар цөм «ходун худусту» гэж сэргээдэг бөгөөд утгыг Хэниш (15, 29), Пеллио (9, 152), Кливз (42, 48), Рахевильз (49, № 5, 1972, 158), Поуха (17, 53) Калужинский (61, 63) цөм «марлын годон гутал өмссөн» гэж зөв орчуулжээ. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 71) «бугын арьсан гуталтай» гэж, Мансан «бугын шийрэн гуталт» (27, 86) гэж, Дугаржав «бугын годыг зүйж хийсэн гуталт» (24, 57) гэхчлэн орчуулсны дээр Элдэндэй Ардажав нар (8, 290) нар ерөнхийдээ зөв тайлбар өгчээ. (тайлбар № 1)

Бид годусу- ту гэдэг өөрөө годус буюу шилбэний арьс гэсэн үгнээс гаралтай тул «хутусу-ту» биш «годусуту» гэж сэргээн «гутал» гэж ухаарах нь зөв болохыг тэмдэглэе.

398. Илкин жархаг-а (илгэн [ишигний?] жархаг) гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Лигети Рахевильз «илкин жархаг» гэж, Пеллио дээрхийн адил сэргээвч бас «ичигин?» биш биз эргэлзсэн, Дашцэдэн Баяр, Иринчин нар «ичихин» гэж тус тус сэргээжээ. Үүнийг Хэниш «Усны булга залгаж хийсэн хүрэм» (15, 29), Пеллио «халиуны арьс элдэж **хамт оёсон хувцастай» (9, 152) Кливз (61, 48) Рахевильз** (49, 158) «үсийг булзалсан усны булгыг залгаж оёсон дээлтэй» гэж, Поуха «минжийн арьсан дээлтэй» (17, 53) гэж, Калужинский «илгэн арьс ба усны булгын ус» (61, 63) гэж, Дамдинсүрэн «булган көөмий дээлтэй» (7, 71), Мансан (27, 86) «янзган арьс усан булган залгамал дээлтэй» гээд үүнийгээ «усны булга нь халиу болой... янзгын арьс нь халиу булганы арьстай ойролцоо тул янзага халиу булганы арьсыг зүйж байгаад дээл хийсэн ажээ» (27, 100, III бүлгийн тайлбар № 13) гэж тайлбарлажээ. Дугаржав «булган арьсыг илгэн зархаг болтол элдэж хийсэн дээлтэй» гээд илгэн зархаг гэдгийг Элдэндэй Ардажав (8, 290—291-т тайлбар № 3 ба 4) нарын адилаар «илги» нь монгол үг, «жархаг» нь түрэг үг» ижил утгатай хоёр үгийг холбож хэрэглэсэн гэжээ.

Бид юуны өмнө «усны булга» гэдгийг халиу, булга, минжийн аль нь ч биш, харин «усны булга» (норка) гэсэн өөр үслэг ангийн нэр гэхийн дээр Лувсанданзаны уг эхэд «илкэн жархас» (31, 63) гэснийг худам монгол бичгийн эхэд «ишигэн жархаг» гэж байсныг буруу гаргаж ушсаны алдаа болов уу гэж таамаглан ишгэний жархагт (илгэнд) усны булга залгасан дээлтэй гэсэн үг байх гэж таамаглан «ишигэн жархаг» гэж сийрүүлэв. Учир нь нялх балчир хүүхдийн баривч дээлийг хурга ишиг мэтийн төл малын зөөлөн үстэй арьсаар хийдгийн дээр «илгэн» гэсэн үгийг Пеллио Дашцэдэн нарын адилаар «ичикин» гэж галигласан нь Элдэндэй Ардажав нарын тайлбарласан (8, 290) шиг «Ички» (илги) гэсэн түрэг үг бус харин «исигэн» гэсэн монгол үг байсан байх гэж бодно. Учир нь монголчууд түүхээ бичихдээ «ичкин жархаг» гэж ижил утгатай өөр хэлний хоёр үгийг нэг дор залгаагаар авч хэрэглээгүй биз гэж бодох нь илүү үндэстэй мэт санагдана.

399. Сабага (савга) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Пеллио (9, 29), Лигети (33, 58), Рахевильз (25, 47), Дашцэдэн (26, 52), Баяр (11, 1, 239), Иринчин (28, 81) тэргүүтэн цөм хятад галиг дагаж сауха ~ саух-а гэж сэргээх бөгөөд **хятад хадмал орчуулгын утгыг Иринчин, Мостарт нар «бэлэг» (86, 11) гэж тайлбарлажээ. Энэ үгийг Хэниш (15, 29) «бэлэг»** гэж, Пеллио энэ үгийг хэвээр бичиж орчуулалгүй орхиод хадмал хятад орчуулгад «бэлэг» гэснийг тэмдэглэсэн өгүүлэлдээ (87, 230—237) заажээ. Энэ үгийг **Рахевильз (49, № 5 1972 158) Қливз уг эхийн үгийг хэвээр тавьж 37 дугаар зүүлтэд (42, 48), Поуха (17, 53) Қалужинский** (61, 63) нар цөм «Бэлэг» гэж орчуулсан болоттой мэт. Дамдинсүрэн (7, 71) Дугаржав (24, 58) Мансан (27, 86) нар «бэлэг болгон» гэж, Элдэндэй Ардажав энэ үгийг «сога» түрэг хэлнийагнах зах зээл буюу жуулчлалаар авчирсан бэлэг гэсэн түрэг хэлний үг ба хятад хэлний «сахуа» (эрикү гэсэн утгатай» бэлэг сэлэг гэсэн үгтэй холбож тайлбарлав. Энэ үг евроазийн олон улс оронд өргөн дэлгэрсэн олон төсөөт үгтэйг нь Пеллио ч дээр дурдсан өгүүлэлдээ тэмдэглэсэн боловч энэ үгийг бид сауха биш «сабага» буюу эсвэл «шибага» (12, 831) «аз сонгох, «аз үзэх» мэргэлэх шоодох юмыг хэлдэг үгтэй холбоотой бөгөөд азын бэлэг болгож өгсөн гэсэн утгатай үг байж магадгүй гэж үзэж байгаагаа тэмдэглэе. «Сибага» гэж худам монгол бичигт бичдэг үгийг XIV зууны үед галигч тэр үед үгийн дундах б хөндийшин «у»-гаар түүний арын а балархайшч сауга- буюу «сиуга» гэж сонссон байж магадгүй. Энэ хүүхэд аз түшиж амьд үлдсэн тул азын бэлэг болгож Өгэлэн үжинд хүмүүжүүлэхээр өгсөн тул Лувсанданзан энэ сауха гэсэн үгийн утгыг «тэжий-э» (хүмүжүүл) (31, 63) гэж өгсөн байж ч болно.

400. чурхан гэр (чорхон гэр) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «чорхан (гэр)» (36, 29) гэж товч орчуулгад «татар (монгол) гэр» гэж тайлбарлажээ. Үүнийг Пеллио, Баяр, Дашцэдэн, Рахевильз, тэргүүтэн судлагчид цөм «чорхан гэр» гэж Хэнишийн адилаар сэргээсэн боловч хадмал хятад орчуулгагүй учир судлагчид элдвээр ойлгожээ. Үүнд Хэниш «Мэргидийн татар гэр» (15, 29) гэж, Пеллио хадмал хятад орчуулгагүй тул Ковалевскийн толь бичгээс «чорга, чоорга» (88, 2220), бас «ча'урга ча'урган» (88, 2089) гэсэн «түлхүүр, цоож» гэсэн утгатай үг олсон боловч утга нь тохирохгүй гэж чорхан манж хэлний «журган» гэдэг үгэнд Ковалевскийн (88, 2405) «зарга шүүх», «Дээд эзний орд» гэсэн утга онооснь баримталж «нэгдсэн албан гэр сууц» (9, 252) гэж, Рахевильз Мэргидийн «цуургатай тэргийг» (49, № 5, 1972, 158) гэж, Қливз (42, 48) үгийг орчуулалгүй орхиод зүүлт № 38-д «чуургатай (цооштой) урт гэр» гэж ухаарснаа тайлбарлажээ. Энэ үгийг Поуха «шовх оройтой гэр» (17, 54), Қалужинский энэ «чорхан» гэдэг үгийг орхиж «Мэргидийн гэрийг нурааж» гэж, Дамдинсүрэн «очгур гэр-и эбдэжү» (7, 72) гэж, Мансан Нагуйисайинкүү гэгч хүний тайлбарласнаар «эртний монголын тогтсон хугацаанд наймаа аралжаа хийх байшингийн нэр» (27, 100—101) Элдэндэй Ардажав нар түрэг хэлний «чорган», уурган» гэх нь бүтээлэг нөмрөг гэнэ. Чурхаль түрэг үг, гэр нь монгол үг гэхийн дээр энэ үгийн утгыг Мансаны адилаар худалдаа арилжаа маймаа хийх тогтмол гэрийг чурхан гэр гэнэ (8, 292—293) гэж тайлбарлав. Дээр дурдсан тайлбарт Мансангийн бичсэнээр бол энэ үгийг бас Нака Мичиёо «орон сууц», Козин «Шовх оройтой монгол гэр», Сийэ зай сан «бух майхан» «Кобаяси, Такасиро «цооктой хөсөг» гэх мэт элдвээр орчуулсан ажээ. Поуха энэ үгийг нүүц товчооны судлалын тусгай номдоо гэрийн нэг зүйлийн хувьд оруулсан (58, 169—170) боловч чухам ямар гэр болох тухай хийгээд «чорхан» гэдэг юу гэсэн үг болох талаар тайлбарласангүй байна.

Бидний бодлоор бол энэ нь чорхан гэр биш, чурхан гэр бөгөөд энэ гэр өрх ба үүдгүй цуурхай амтай гэр гэсэн үг юм. Учир нь ойн ард гэдэгт ойр байсан Мэргидийн аж төрөл анчны аж төрөлтэй байсан учир чурхан гэр бол талын нүүдэлчдийн өрх гэрээс буурай хэдэн шургааг боож юм нөмөргөсөн чурхай буюу ам нь цуурхай гэр байсан тул ялсан монголчууд нь тэдний овоохой гэрийг муу талаас нь ингэж чурхан (буюу цуурхай) гэр гэж нэрлэсэн байх гэж бодож байна. Чурхан гэдэг үг чуурхай гэдэг тэмдэг нэртэй холбоотой гэж бодох үндэс нь цурхай, загас гэдэг үг угтаа цуурхай амтай (ам нь их) загас гэсэн үг боловч худам монгол бичигт «чурхай» буюу урт биш анхны богино эгшигтэй байдлаараа хуучин монгол бичигт «чурхай» (53, 799а) гэж бичигддэг энэ загасны нэр цуурах гэдэг үйл үгийн язгуур анх «чурху» гэж бичигддэг богино эгшигтэй үг байсныг гэрчилнэ. Үүний үндэс болох «чу (цуу) татаху» гэдэг үг задгай үеэр төгсдөг байсан тул «чуу» гэж уртаар дуудагддаг байгаад хожим энэ урт дуудлагыг хуучин (сонгодог) монгол бичигт энэ цуурах гэсэн үгийг «чугураху, чугу (цуу) тат» «чу-

гучиху (олонтоо цуулах)» (12, 785а) гэх мэтээр урт эгшигтэй бичигдэх ба дуудагдах болсон байх гэж санамаар байна.

401. чохулигулжу (цохлуулж) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс зарим судлагчид «чохоли'улжу» (Хэниш, Пеллио, Рахевильз, Лигети, Баяр, Элдэндэй Ардажав), зарим нь «чохолиулжу» (Дашцэдэн), **зарим** нь (жишээлбэл: Иринчин) **«чохорихулжу», Мансан Баяр зэрэг зарим** нь «чоголигулжу» гэх зэргээр хуучин бичгээр сэргээдгээс нэгдэхийг хамгийн зөв гэж бид бодож байна.

Учир нь энэ үгийн утгыг Дамдинсүрэн, Дугаржав «эвдэж», Элдэндэй Ардажав, Калужинский «нурааб», Рахевильз «бут цохиж» гэж, Хэниш Пеллио, Кливз нар «хөмрүүлэх» гэх зэргээр орчуулснаас бид сүүлчийн гурвын орчуулгыг зөв гэж үзэх бөгөөд энэ нь Хэнишийн тайлснаар (36, 29) «хөрвүүлэх, хөмрүүлэх» гэсэн хадмал хятад **орчуулгын** утгатай яв цав нийлэлцэж байна. Учир нь бидний бодлоор бол энэ үг Баяр (11, I, 330), Дашцэдэн (26, 52) зэрэг нөхдийн сэргээж байгаа шиг «чоголигулжу»буюу, чоголиулжу» гэсэн үг биш, харин «чохулигулжу» (толгойг уруу харуулах) гэсэн утгатай үг байх гэж таамаглаж байна. Цоолох мэтийн бага хөнөөлтэй холбогдохгүй гэж бодож байна.

402. гачура-ту...улийа-ту сүбэчид (гачуурт... улиаст сүвчид) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 136), Пеллио (9, 29), Лигети (33, 59), Поуха (17, 54), Иринчин (28, 81), Калужинский (61, 64), Кливз (42, 48), Рахевильз (25, 47) тэргүүтэн цөм «хача'урату... hулийату субчит» гэж, Дамдинсүрэн (7, 72), Дашцэдэн, Баяр (11, I, 331). Магаулия Султанияулы (78, 48), Мансан (27, 87), Дугаржав (24, 58) зэрэг монгол хэлтэн судлагчид «гачагурату... улийату субчид», хачаурату... хулиату сүбчит» (Дашцэдэн) гэх зэргээр бараг зөв сэргээсэн байна.

Бидний бодлоор бол «Хачурату, Улийату сүбэчид» гэж худам монгол бичгээр сэргээвэл зохих үгс бөгөөд ерийн (гачуур, улиас гэх мэтийн ерийн нэрээр нэршсэн газрын тусгай нэр бөгөөд эдгээр хам бүтцэд оролцсон «сүбэчид» гэдэг нь Улиастайн ам гэдгийн ам гэдэг шиг ерийн нэр тул бага үсгээр бичих нэвтрэх сүв хавчил гэсэн утгатай тул хятад галиг үсэгт тэмдэглэсэн шиг сүбчид бус «сүбэчид»-ээр сэргээх нь зөв гэж ийнхүү сэргээн босгов.

403. чинггэлтүктү шиг-а (чингэлдэгт шагай) — гэсэн энэ үгийг хятад галигаас нь Хэниш, Лигети, Рахевильз Дашцэдэн, Баяр, Элдэндэй, Ардажав, Мансан нар «чинггүлтүк-тү шиг-а» гэж, Пеллио **«Чинггилтүктү»** (9, 29) гэж, Иринчин «Чэнггүлтүктү» (28, 82) гэж янз бүрээр сэргээсэн байна. Хадмал хятад орчуулгын нь утгыг «зэсээр цутгасан» (36, 28) гэж тайлаад тэр ёсоор «Хэниш (15, 30), Пеллио (9, 152), Рахевильз (49, № 5, 1971, 158), Калужинский (61, 64), Кливз (42, 49) тэргүүтэн «зэс буюу гуулиар (цутгасан) шагай» гэж орчуулсан байна. Энэ үгийг Дамдинсүрэн «цутгамал шагай» (7, 72), Дугаржав «гууль цутгасан шагай» (24, 59), Элдэндэй Ардажав нар гууль (хүрэл) цутгасан шагайг» (8, 300) гэж тайлбарлажээ. Мансан «чингкүлтүктү» гэж сэргээгээд «чүнгкүл гуу хоолой» гэсэн үгтэй холбож цүнхэлд нь тугалга цутгаж, үрж зассан шагайг чүнгкүлтүктү шагай гэнэ» (27, 103) гэж тайлбарлав.

Бид энэ үгийг — «чинггэлтүк-тү» гэж галиглах нь зөв гэж үзэж цутгамал (хиймэл) шагай гэсэн утгатай **гэж бодно.** Учир **нь энэ үгийг** бид чинг- (бат хатуу нягт гэсэн утгатай үгийн язгуур, 1 үндэс) +гэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +лт (үйл үгээс түүний явцыг нэрлэх нэр үг бүтээх дагавар) +л (үйл үгээс **үйлийн** явцын үр дүнд **бий** болсон юмын нэр үүсгэх дагавар) **гэсэн бүтэцтэй бөгөөд** юм чихэж хийх савын нэр «чинггэлиг», **«читхуху»** гэх мэт үгтэй гарал язгуур нэгтэй болов уу гэж бодож байна. **Чингэлтүг** нь уг цутгамал шагайг **цутгаж хийх хэвийн нэр байж болох** юм. Хэв бүхүй гэсэн утгатай харьцангуй нэр бүтээх -тү гэсэн дагавар эцэст залгасан бололтой юм. Харин энд хятад хадмал орчуулгад «зэс-(гууль?)ээр цутгасан» гэж тайлбарласнаас үзвэл хятад үсгийн галигт «зэс (эсвэл гагули)» гэсэн үг нь орхигдсон учир энэ үгийг **зөвхөн «читхумал»** шагай гэсэн Дамдинсүрэнгийн орчуулга хамгийн зөв болсон байж болно.

404. сигалчахуй (шагалцах) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн тэргүүтэн судлагч «ши'алжахуй» гэж Лувсанданзан, Дугаржав, Дамдинсүрэн, Мансан нар хуучин бичгийн ёсоор «шагалчахуй-дур», «шагалчажу», «шагалчаа», «шагай чокин» гэх мэтээр, нөгөө Баяр, Иринчин нар хятад галиг дагуу **«шигалжаху, шихалжахуй»** гэх мэтээр тус тус сэргээн босгодог. Утгыг цөм шагайгаар тоглох гэж хадмал хятад орчуулгын утгыг Хэнишийн орчуулсны (36, 139) дагуу зөв ойлгож орчуулсан буюу тайлбарладаг байв. Элдэндэй Ардажав нар Цэвэлийн толь бичгээр «шагай өлгэчэжү нагадху, шагачаху» гэж утгыг зөв тайлбарлан (8, 301) бичжээ.

Бид энэ үгийг худам монгол бичигт «сихалчахуй ~ сигалчахуй» гэж сэргээх нь зөв гэж үзсэн бөгөөд энэ үгийг шиха ~ шига (үгийн үндэс -шаха ~ шага (шаа) гэсэн үгийн язгуур, үйл үгийн 1 үндэс) ⌈+й (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) нэмж шагай гэдэг нэр үг үүсдэг боловч энд энэ нэр үгээс биш харин шага (шаа) үйл үндэс дээр⌉ +лч (хамжин үйлдэх байдлын нөхцөл) +хуй (үйл үгийн үйлт нэрийн одоо ирээдүй цагийн нөхцөл залгаж энэ үгийг бүтээсэн гэж бодож байна. Шига (шаа) гэдэг үйл үндэснээс үүссэн «шиганту<шаганту» гэдэг чөмөг ясны нэрээс шагантаг (шаантаг) болж шаант шилбэ хоёрын завсраар шааж орсон ясны нэр болжээ. Шаант чөмгийн нарийн талаар маш эртний бүдүүлэг монголчууд далан нас хүрсэн хүнд уе сүүл хонгоны мах өмхүүлж шааж гударч ёс үзүүлж алдаг заншил байсан тул энэ чөмөг ясыг шиганту буюу шааж гударч алах үйл үгнээс үүсгэн нэрлэсэн гэж бодно. Шигантаг гэдэг үг ч бас хоёр юмны хоорондуур шааж орсон зүйлийг нэрлэдэг нэр тул шагай гэдэг үг үүнтэй адилаар шига (шаа) +й (дагавар) залгаж үүсэн бүтсэн гэлтэй. Шага гэдэг үг одоо монгол хэлний зарим аялгуунд «шаа» гэж дуудагдах болсон гэдэг. Иймээс «Алаг» гэдэг үг түрэг аялгаар «Ала» болж түүн дээр шагай гэдэг үг нь «шаа» дуудлагаараа орж Алашаа гэдэг газрын нэр болсон гэдэг яриа байдаг нь ч үнэн болов уу гэж бодох үндэстэй гэдгийг тэмдэглэе.

405. Алангир (алангир) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс нь Хэниш (аланггир» гэж зөв буулгаад «модоор хийсэн» гэсэн үгээр хадмал хятад орчуулгыг тайлсан байна. Дараагийн бүх судлагчид Хэнишийн адилаар энэ үгийг галиглаж утгыг мөн адилаар ойлгож тайлбарласан буюу орчуулсан байна. Элдэндэй Ардажав нар «Аланггир нуму» гэдэг үгийг «Хорин нэгтийн тайлбар» толь, Я. Цэвэлийн толь зэргийн хожмын толь бичгийн тайлбарт тулгуурлаж «тосон харгай модоор элэггүй хийсэн нум, хавчаахай (хүүхдийн сулхан) нум» (8, 301) гэж тайлбарлажээ. Энэ үгийг гагцхүү Дамдинсүрэн гуай «Алунггир» (7, 72) гэж буулгаснаар үзвэл үүний утгыг арай өөрөөр үзэж байсныг нь илтгэж байна.

Энэ үгийг бид ал (алхуху, алчайиху гэх мэт үгийн язгуур салаа, салтаа гэх мэт утгатай үйл үгийн 1 үндэс) +нгги (үйл үгээс чанар шинжийн нэр бүтээх дагавар) +р (дайвар ба тэмдэг нэрээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг бөгөөд их дэлиж (алцайлган татаж) болох нум гэсэн үг гэж таамаглан ойлгов. Энэ нь сал+нги+д=салангид, хат+нги+р=хатанггир гэх мэт үгийн загвараар бүтсэн үг гэж бодож байна. Алцайх гэдэг үгийн ал+нги+р дагавар залгаж үүссэн бол хувилах хувилгагч үсгийн дүрмээр «алунггир» гэж бичигдэж болох талтай. Гэвч энэ үгийн ала-гэсэн өөр үндэс ч мөн эртний монгол бичигт дайралддаг юм. «Арг-а билик-и эсэ мэдэбэсү Алан доора ки имаган-у үнүгүн (ишиг)-и Алжу идэкүй-э бэркэ болай» (31, II, 31) гэж бичсэний доторх «Алан доорх» гэсэн үг бол «салтаан доорх» гэсэн үг болно. Бас «алабкин мордох» гэдэг нь «алаб кин» (алцас хийн) мордох гэсэн үг болно. Иймд «алангир нуму» гэснийг хадмал хятад орчуулга ба хорин нэгт тайлбар, түүнээс хуулсан Цэвэлийн толийн тосон харгай модоор элгэгүй хийсэн нум гэх буюу модоор хийсэн гэдэг тайлбар хожмын үеийн өөр талаас нь буюу бүтсэн эдээр нь хийсэн өөр тайлбар бөгөөд «алангир» гэдэг үгэнд сайтар онолдоогүй тайлбар гэмээр. Алангир нум гэгч амархан татагдах зөөлөн боловч их эвшээн ангайлгадаг алцгар нум гэсэн үг болов уу гэж таамаглан тайлбар хийв.

406. харбучалдун (харваалидун) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «харбийалдуху» гэж сэргээн бичээд хадмал хятад орчуулгын утгыг нь «харвах» гэж тайлахын хамт харбулалдун-зэвт сум тавилцах (уу?)» (36, 61) гэж эргэлзэн тэмдэглэсэн бололтой. Пеллио (9, 29,) Рахевильз (25, 47), Лигети (33, 59), Дашцэдэн (26, 53) Баяр (11, I, 334), Элдэндэй Ардажав (8, 298) Иринчин (28, 82) нар цөм Хэнишийн адилаар «харбийалдун» гэж сэргээв. Энэ үгийг Хэниш (15, 30), Пеллио (9, 152), Кливз (42, 49), Элдэндэй Ардажав (8, 302), Дамдинсүрэн «харваж бүхийд» (7, 72), Дугаржав «харвалдан байхад» (24, 59), Мансан «харвалдан наадах» (27, 87) гэх зэргээр орчуулсан буюу ойлгож тайлбарласан байдаг.

Бид энэ үгийг «харбучалдун» гэсэн үг байсныг XIV зууны галиглагчид ба Лувсанданзан худам монгол бичгээс нь ча- үсгийг үгийн дунд түүнтэй адил дүрстэй йа үсэгтэй сольж эндүүрэн хэлж өгсөн ба сэргээж бичсэнээс харбучажу гэсэн үг «харбуйалдун» буюу эсвэл «харбийалдун» гэсэн бүрүү бичлэгээр тэмдэглэгдсэн гэж санана. Учир нь энэхүү эс тусах үйл үгээс тусах үйл үгийн үйлдүүлэх хэвийн -йа-нөхцөл эртний худам бичигт гол төлөв и- эгшгийн дараа тохиолдог тул энд Лувсанданзаны эхэд «харбийалдун» гэж бичигдэмгүйн дээр «харбу» үндэс харби гэсэн хувилбаргүй юм. Харин үйлийг олонтаа хийх байдлын -ча -чэ нөхцөл харбу- гэсэн үндсэнд залгагдаж болох юм.

Иймд бид энэ үгийг харбу- (нум сумаар «харва» гэсэн утгатай үгийн язгуур, **үйл үгийн I үндэс**) +ча (үйлийг олонтаа хийх байдлыг илтгэх **үйл үгийн байдлын нөхцөл**) +лд (**харилцан үйлдэлцэх** хэвийн үндэс үүсгэх нөхцөл)+н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж төсөөлөн тайлбарлав.

407. Эсгэл (эсгэл) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь **Хэниш «эсгэл»** гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «олон жил **сувайрсан гүү» (36, 46) гэж тайлсан байна.** Пеллио, Лигети (33, 60) Рахевильз (25, 48) Дашцэдэн (26, 53) Баяр (11, I, 336), Элдэндэй Ардажав (8, 303), Дамдинсүрэн (7, 73), Иринчин (28, 83), Дугаржав (24, 59) Мансан (27, 88) Мостарт (47, 337 [53]) цөм «эсгэл» гэж Хэнишийн **адил босгож сийрүүлэв. Энэ үгийн утгыг Хэниш «олон жил боосроогүй гүү» (15, 30) гэж,** Пеллио «олон он хүртэл хусарсан хээгч гүү» (9, 15), Қозин «эсгэл халиу (выдры) хочтой гүү» (14, 105), Мостарт Пеллиогийн адилаар «олон он хүртэл боосроогүй» (47, 341 [57]) бөгөөд цагаан шаравтар бөгөөд хар дэлтэй гүү (47, 341 [57]) гэж, Дамдинсүрэн «эсгэл эрэмэг буюу агсум» (7, 53) гэж, Мансан «эсгэл гэгч дөрвөн настай засаагүй морь» гэж тайлбарлаад Нагуйсайинкүүгийн «дөрвөн настай эр хүйсийн адууг эсгэл буюу үрээ гэдэг» гэсэн тайлбарыг (27, 104) хийжээ.

Элдэндэй Ардажав нар мөн Мансантай адилаар эсгэл гэдэг хэдэн жилээр унагалаагүй гүүг хэлэхээс гадна тийм гүүний унага хэдэн жилээр эхээ хөхөх тул түүнийг эсгэл морь гэх, бас адуун сүрэгт жилээр хэрэглэхгүй тавьсан адууг эсгэл морь гэх» зэргээр тайлбарлаад хадмал хятад орчуулгыг дагаж үүнийг «гүү» гэж орчуулсан эрдэмтдийн ташаарсныг дурдсан юм.

Бид эсгэл халиун гэдэг үгийг Элдэндэй Ардажав Мансан нарын тайлбарыг ерөнхийдөө зөв зүйтэй гэж үзэж байгаа боловч эсгэл гэдэг үгийг «эсгэх засах» гэсэн үгээс үүсгэн тайлбарласнаас арай өөрөөр «исгэлэн омголон» гэсэн утгатай биш байгаа гэсэн өөр санал бас тавьж байна. Хэрэв тийм гэж үзвэл эсгэл биш «исгэл» гэж галиглавал ямар вэ? гэж бодож байгаагаа хэлэх гэсэн юм. Учир нь «эсгэх» гэсэн үгийг хуучин монгол бичигт «эсгэхү-айираг исгэхү зэргийн» (12, 101) гэж бичдэг уламжлалтай атал Монголын нууц товчооны хятад галигт «эсүкчилжү» (9, 8) (айраг ууж) гэж одоогийн халхын аялгатай ойрхон галигласан сонин баримт, бас нөгөө өөр зүйлд (132 дугаар §) «итгэс-үн **(айргийн) бүлэгүүд сугучижу» (9, 15)** гэсэн галиг бас исуг (айраг гэсэн үг бүр эртний дуудлага бичлэгээр «э» биш «и» байсныг харуулав. Иймд энэ үг эсгэх (хагалах) гэсэн утгаар хэрэглэгддэг байсан биш «исгэх» гэдэг үгнээс «исгэл» (агсам хурц) гэсэн утгаар хэрэглэгддэг байсан биш байгаа гэсэн бодолд хөтөлбөрлөж байна.

408. эбэр-тү үнүгүн чаган (эвэрт ишгэн чагаан) — гэсэн энэ үгийг Хэниш «эбэр-тү» (36, 40) «уногун чага'ан» (36, 165) гэж сэргээж, хадмал хятад орчуулгын утгыг «эвэрт хурга мэт харагддаг цагаан морь» гэж тайлсан байдаг. Үүнийг Қозин «эбэрт унгун цагаан» (эвэрт бага азарган)» (14, 105) гэж, Хэниш дээр тайлснараа (15, 30) Пеллио «эвэрт ишгэн (д-адил) цагаан морь» (9, 152) гэж, Мостарт «ишгэн цагаан зүсмийн эвэрт морь» (47, 341 [57]) гэж, Рахевильз «нэгэн эвэрт ишгин цагаан морь» (49, № 5, 1972, 159) гэж, Қливз «эвэр бүхий ишгэн (өнгөт) цагаан морь» (42, 50) гэж, Дамдинсүрэн С. А. Қозиныг дагаж «унаган цагаан морь» (7, 72) гэж, Поуха бээр Хэнишийг дагаж «эвэрт хурга мэт цагаан морь» (17, 54 ба 58, 145) гэж, Қалужинский «ямааны эвэрт мэт цагаан морь» (61, 64) гэж, Мансан «Хорин нэгт тайлбар» тольд тулгуурлан «үнүгүн» гэдгийг ишгэн гэж, эвэрт гэдгийг «морины мундаа буюу магнай дахь ямар нэг тэмдэг-бөөн үс буюу гөхлийн зүйл» (27, 105) гэж ерөнхийдөө зөв тайлбарлав.

Элдэндэй Ардажав (8, 305) «үнүгүн чаган» гэдгийг Мансаны адил тайлбарлаад «эвэрт» гэдгийг тайлбарлалгүй орхисноор, Дамдинсүрэн (7, 73) Дугаржав нар (24, 59) нар энэ үгийг орхиж орчуулжээ. Үүнийг гагцхүү Мостарт Ордост байхдаа олж мэдсэн болон бусад түүхийн мэдээнээс энэ нь жинхэнэ эврийн тухай биш, харин толгойн дээд хэсэгт байх ур холонгирын тухай үг гэж тайлбарлав (47, 340 [56]).
Энэ талаар Монголын эрдэмтэн Х. Лувсанвандан Өвөр Монголын багшийн их сургуулийн «Монголын нууц товчооны олон улсын эрдэм шинжилгээний ярилцах хуралд тавьсан илтгэлдээ морины шинжийг судар ба Чойсүрэнгийн тууль болон Данжуур зэрэгт байгаа баримтаас үүсгэн сахалтай морийг сайн морины чадар буюу шинжийг «эвэрт» гэдэг нэр томьёогоор хэлдэг бололтой (84, 17—20) гэдэг санал тавив.
Бид энэ үгийг халхын малчдын ярианд сайн морь үсний хоёр эргүүлэгтэй байдаг гэх үг байдагтай холбож магнайн хоёр талд хоёр эргүүлэг нь өөдөө тугалмай эвэр мэт сөрвийсөн үстэй морийг «эвэрт» морь

гэдэг байх гэж бодож байна. Учир нь хүүхдийн зулайд тав тавьсныг гөхөл гэдэг атал толгойн хоёр талд гэзэг ургуулахаар тавьсан хоёр тав үсийг эвэр гэж монголчууд ярилцдаг юм. Ерийн морины үсний эргүүлэг магнай дээрээ гол төлөв байх учир түүнийг эвэр гэхгүй, харин сайн морь үсний хоёр эргүүлэгтэй байх тул магнайн хоёр талд эргүүлэг үс нь хурга ишигний ургаж буй тугалмай эвэр шиг сөрвийсөн байдаг. Ийм хоёр сөрөвгөр үстэй морийг л сая эвэрт гэж нэрлэн сайн морины шинжид оруулдаг байсан болов уу гэж санаж байна.

409. Хулдагар хун (Гулдагар хан) — гэдэг энэ үгийг хятад галиг үсгээс галиглах ба уулны тусгай нэр гэж ойлгох талаар судлагчдад зөрөөтэй зүйл байхгүй гэж бодож байна.

Харин «хун» гэдэг үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хавчил, хяр, налуу газар» гэсэн үгээр тайлжээ. Энэ үгийг Хэниш «Хулдагарын хаһан хад» (15, 30), Рахевильз «хавчил хад» (49, № 5,. 1972, 159) Кливз «эгц налуу» (42, 50), Козин «Хулдагар хуны өмнө этгээдийн налуу» (14, 105), Мостарт «Хулдагарын үүдэн талын эгц налуу» (47, 341 [57]), Поуха «Ханан хадны өвөрт» (17, 55), Калужинский (61, 64) Пеллиогийн адил (9, 153) орчуулалгүй орхиод эгц хад гэж тайлбар зүүх зэргээр ойлгож орчуулсан байна. Мансан «хулдагар гуу» (27, 88), Дугаржав «Хулдагар гүн» (24, 60) Лувсанданзан (31, I, 65), Дамдинсүрэн (7, 73) нар «хун» гэж Элдэндэй Ардажав (8, 303), Баяр (11, I, 338) нар «гүн» гэж тайлбаргүй хэрэглэжээ.

Бидний санавал энэ «хун» гэдэг үг Рашид-ад-Диний тайлбарласнаар (4, I, 1, 153) хун-уулын налуу чавчим эргүнэ эгц товчилбол «эгц нуруу» гэсэн байдаг. Үүнийг эргин тойрон уултай хонхор газар гэж «гон, гүн, хон, хун» гэх мэтээр сэргээдэг нь буруу байж болох юм. Харин алив цавчим өндөр уулыг «хан» гэж нэрлэдэг тул «Гулдагар хан» гэж худам монгол бичгийн эхийг XIV зууны үеийн монгол хэлний дуудлагаар «хун» гэж хятад үсгээр ташаа сэргээн босгосон байж магадгүй гэж бодно. Ингэж бодох үндэс нь орчин цагийн монгол нэр нь «Зоргол хан» гэдэг нэртэй уулыг «МНТ»-нд «Жоргал хун-у» (§177) гэж «Лхаху хан» гэж байгааг «Наху хун-у» (§195) гэх мэтээр бичдэг явдал «эгц чавчим уул» гэсэн Рашид-ад-Диний тайлбарт нийцэж байна. Гэтэл «Хангай хан» гэхийг «Хангархан» (§193) гэж тэмдэглэснээс үзвэл өмнөх үгийн эгшиг нь «а» мэт хэлний эгшиг бол «хан» гэж урьд үг нь «о, у» дуудлагатай бол уруулаар ижилсэн «Жотал хун» «Наху хун» гэх зэргээр уруулын зохицлоор -хан, -хун гэсэн хоёр өөр дуудлагатай болсноос зайлахгүй мэт бодогдоно.

410. гагча хонулдухун бүлүгэ (ганц хонолдох бөлгөө) — гэсэн энэ хэллэгийг хятад галиг үсгээс нь Хэниш «гахча» (36, 56) гэж сэргээгээд «ганц ~ гагча» гэж хадмал хятад орчуулгын утгыг зөв тайлжээ. Энэ үгийг судлагчид цөм «гагча» гэж буулгаад үүний утгыг Хэниш (15, 30), Пеллио (9, 253), Рахевильз (49, № 5, 1972, 159), Кливз (42, 51), Поуха (17, 55), Калужинский (61, 64), Дамдинсүрэн (7, 73), Элдэндэй Ардажав (8, 307), Дугаржав (24, 60) цөм шөнө нэг хөнжилд хамт хонох гэж зөв орчуулснаас гадна Элдэндэй Ардажав нар (8, 306) «хонолдаху нь хонолдохын олон тоо» гэж тайлбарлажээ.

Бид энд «хонулдохун» гэсэн -лд (үйлдэлдэх хэвийн нөхцөл) хожим монгол хэлэнд хэрэглэгддэг болсны адил харилцан эсрэг үйлдэлцэх утгаас гадна бас хамт үйлдэх утгаар хэрэглэгдэж бас «гагц» ганцаар гэсэн утгаар бус харин «хамт» гэсэн өөр утгаар хэрэглэгдэх онцлогтой байсныг тэмдэглэе.

411. тэргэд-үн ури-д-а (тэргэдийн урьд явж) —гэсэн энэ үгийн тухайд энэ дайвар үг ури- (урих гэдэг үгийн язгуур) +а (өгөх оршихын тийн ялгалын нөхцөл) залгахад «и» «а» хоёр эгшгийн хооронд «д» гийгүүлэгч жийрэглэн бичиж «ури-д-а» гэдэг дайвар үгийг бүтээсэн бүтцийн онцлогтой бөгөөд бас энэ үг хожим үед дан ганц цаг хугацааны дайвар үгийн утгаар бус бас орон зайн утгаар хэрэглэгдсэн найруулгын онцлог буйн дээр ури (урь) гэдэг үг тэр цагт урих гэсэн үйл үгийн утгатайн зэрэгцээ бас нэр үгийн утга хадгалдгийн учир -а гэсэн өгөх орших тийн ялгалын нөхцөл залгаж болдог онцлогтой байсныг тэмдэглэе.

412. [+г]алчуг-а (галцагтаа хүртүгэй) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «Алчух-а» гэж сэргээгээд «майхан» (36, 4) гэж хятад хадмал орчуулгын нь утгыг тайлсан бөгөөд энэ үгийг Пеллио (7, 30), Рахевильз (25, 48), Лигети (33, 60), Дашцэдэн (26, 54), Элдэндэй Ардажав (8, 307), Иринчин (28, 84), Баяр (11, I, 341) тэргүүтэн цөм «алачуг-а» гэж сэргээн босгосон бөгөөд энэ үгийн утгыг Хэниш (15, 30), Пеллио (9, 153), Кливз (42, 50) тэргүүтэн цөм «майхан» гэж, Элдэндэй Ардажав түрэгийн «алачук алачык» гэсэн үгтэй холбож холтсон гэр, зуны модны салаагаар хийсэн гол тогооны гэр, татарын нүүдлийн эсгийт мухлаг, хатгуур гэр» гэх мэт утгатай (8, 309)

гэж, Дамдинсүрэн (7, 74), Мансан (27, 88), Дугаржав (24, 60) нар «гэр» гэж, Рахевильз «халх оромж» (49, № 5, 1972, 160) гэж тус тус ойлгож орчуулжээ.

Бид энэ үгийг «галчуг-а» (галцаг) гэсэн үг гэж ойлгож сэргээн босгов. Учир нь энэ үгийг Лувсанданзан «гал чог-а» (31, 65) гэж ойлгож буулгасан байна. Үүнээс бид Лувсанданзанд байсан «Монголын нууц товчоон»-ы худам монгол бичгийн эхэд «гал чуг-а» гэж энэ үгийг хоёр салгаж бичсэн байжээ гэж төсөөлөн бодов. Тэгээд бид энэ үгийг гал (үгийн язгуур «гал» гэсэн утгатай нэр үгийн 1 үндэс) +чуг (нэр үгээс нэр үг бүтээх дагавар) -а (нэр үгийн өгөх орших тийн ялгалын нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд аян буюу оторт нэгэн гал (бүлэг хэсэг) болж яваа хүмүүсийн галцаг (оромж) гэсэн утгатай үг гэж бодож байна. Энэ монгол үг олонг+чуг=олонгчуг (эмээлийн), ору+н+чуг=орунчуг гэх мэтийн үг бүтэх загвараар бүтсэн нь маргаангүй. Энэ үг зарим тохиолдолд XIV зууны монгол хэл аялганд «алчуг» гэж дуудагдаж байсан тул тэр дуудлагаараа Нууц товчооны хятад галиг эхэд тэмдэглэгджээ. Үүний баримт нь «гал улаан» гэсэн үг «ал улаан» гэсэн дуудлагатай болсон явдал бөгөөд «МНТ»-ы дотор (§237) «Ал дэ'эл-үн үүрɪэсүн-эчэ» гэсэн үг гарч байгаа явдал болно. Энэ «гал» гэдэг үг «ал» болж хувираад хурц тод өнгө гэсэн утгатай болсныг харуулж байна.

413. хогулара-а (хоолой-а-хооолондоо хүртүгэй) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «хо'олай» (36, 66), Пеллио (9, 30), Рахевильз (25, 48), Лигети (33, 60), Дашцэдэн (26, 54), Баяр (11, I, 342), Элдэндэй Ардажав (8, 307), Иринчин 28, 84) цэм «хо'олай-а ～ хоголай-а» гэж сэргээсэн бөгөөд гагцхүү Лувсанданзан «хогулар-а» гэжээ.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «багалзуур хоолой» (36, 66) гэж тайлаад үгийг Хэниш (15, 80), Пеллио (9, 153), Кливз (42, 50) нар тэргүүтэн «хоолой» «хоолойн тул хүнс» гэхчлэн орчуулжээ. Харин Дамдинсүрэн (7, 74), Рахевильз (49, № 5, 1972, 160), Дугаржав (24, 61), Мансан (27, 89) нар «хоол буюу хүнс тэжээл» (Рахевильз) гэж хамгийн зөв орчуулжээ.

Энд бид Лувсанданзаны сийрүүлгийг хамгийн зөв бөгөөд эртний хувилбар нь мөн гэж үзнэ. Учир нь худам монгол бичигт үгийн төгсгөлийн й ～ р авиа сэлгэдэг учир хангар ～ хангай, талбар ～ талбай гэх мэт үгийн адилаар хогулар ～ хогулай гэж гийгүүлэгч сэлгэсэн жишээ болно.

414. уйидангха[й] (уйданхай) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь судлагчид цэм «уйидангх-а» (Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Иринчин («уйидангг-а» (Мансан), «амархан, хялбар уйддаг зантай» (Дамдинсүрэн, Мансан, Дугаржав) гэх зэргээр сэргээн босгож энэ утгыг цэм уйдах зантай гэж ухаарч орчуулсан буюу тайлбарлажээ. Лувсанданзан «уйидумухай» (31, I, 66) гэж бичсэн нь уггаа «уйидумахай» гэдэг үг байсныг галиглигчид «уйидангхай» гэсэн ойролцоо утгат үгээр галигласан байж болмоор бодогдоно. Иймээс бид үүнийг «уйи-(үгийн язгуур уй (гашуу) гэсэн нэр үгийн 1 үндэс) +д (нэр үгээс үйл үг үүсгэх дагавар) +нг (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +хай (нэр үгээс тэмдэг нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг гэж бодном. Буд+нг+гуй=будунггуй гэх мэтийн үгийн загвараар бүтсэн үг байх.

415. силугуй-а (шулуухан) — гэдэг үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 140), Пеллио (9, 30), Рахевильз (25, 49), Лигети (33, 61), Дашцэдэн (26, 55) нар «шили'уй-а» гэж, Баяр (11, I, 346), Иринчин (28, 84), Элдэндэй Ардажав (8, 308) нар «шилигуй-а» гэж сэргээв. Энэ үгийн утгыг Хэниш «зөв» (15, 31), Пеллио «цэвэрхэн» (9, 153), Рахевильз «бүрмөсөн» (49, № 5, 1972, 160), Кливз «сайн [за!]» (42, 51) гэх мэт өөр үгээр орчуулсан шиг харагдавч тэр хэл дээрээ «шулуунаар» гэсэн үгийн утгыг гаргасан бололтой. Энэ үгийг Баяр «шилугун» (11, I, 346) гэж Дамдинсүрэн (7, 75), Мансан (27, 89) Дугаржав (24, 61) нар «шулуухан» гэж, Элдэндэй Ардажав нар энэ үгийг татаар хэлний зохих утгатай холбож тайлбарлаад үүнээс бичгийн хэлний шилугун гэдэг үг болсон гэхийн хамт шилигуй-а хагачан» гэсний «сайнаар хагачах» гэсэн утгатай (8, 310—311) гэсэн нь утгадаа төдий л нийцэхгүй мэт.

Бидний бодоход «шууд шийдвэртэйгээр» гэсэн утгатай шилу (шили?)-гэсэн үйл үгийн үндсэнд «гуй» гэсэн дагавар залгаж нэр үг бүтээгээд түүндээ «-а» гэсэн өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаж «шулуунаар» дайвар үгийн байдлаар хэрэглэсэн мэт санагдах тул үүнийг «шулуухан» гэх бус, харин «шулуунаар, шуудаар» гэсэн үг гэж төсөөлж байна. Энэ нь «ял+нгуй+а» гэсэнтэй адил загвараар бүтжээ гэж сананам.

416. жоричин (зорчин) — гэсэн үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «зөричигү» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг «нэг нэгнийхээ дундуур өнгөрөх, хутгалдах» (36, 93) гэж тайлснаас гадна Лувсанданзаны эхэд «зөричижү» (31, I, 66) гэж бичсэн учир бүх судлагчид цөм «зөричижү» гэж сэргээн босгоод Элдэндэй Ардажав нар «зөрөлдөн, зөрөлцөх, эсэргэлдэн явах» (8, 313) гэж тайлбарласан юм. Гагцхүү Дамдинсүрэн «шөнө хөдөлж Жамухагийн зүг одов» (7, 75) гэж, Дугаржав «Тайнчигуд айж мөн шөнөдөө хөдөлж нүүгээд Жамуха-гийн зүг одов» (24, 61) гэж тус тус орчуулсан байдаг.

Үнэхээр «шөни бөгэд жөричэн Жамуха жүк көдөлбэ кү» гэсэн өгүүлбэрийг утгын үүднээс бодвол энэ үг «зөричэн» гэсэн үг биш, харин «зорчин» гэсэн үг биш байгаа гэсэн эргэлзээ төрмөөр юм. Үчир нь зөричих үйлийг өдөр шөнийн алинд хийж болно. Харин зорин нүүх үйлийг шөнө биш өдөр л хийдэг заншилтай тул шөнө байтал зорчин хөдөлсөн гэж эсрэгцүүлэн хэлсэн баймаар. Тийм бол зорчин гэдэг үгийг «зоричин» гэж бичиж бас болдог баймаар. Үүнээс улмаар зорчих гэдэг үг анх зоричих (өөрөөр хэлбэл зорин явах) гэсэн үг байгаад зоригдэг үндэсний нь «и» эгшиг нь балархайшиж орхигдоод хожим «зорчиху» гэж өөрөөр бичигдэх болсон биш биз гэсэн бодол төрж байна.

417. тогорагун (тогоруу) — гэдэг үгийг сэргээх ба түүний утгыг тайлбарлах талаар судлагчдын дунд зөрөөтэй санал үгүй юм.
Харин энэ үг «Хачихун тогурагун», «харахай тогурагун, харалдай тогурагун, эдэ гурбан тогурагун» гэх зэргээр ганц ба олон тооны ялгалгүй бичигдсэн мэт байгаа нь сонин, Бидний бодоход энэ үг энд цөм олон тоот нэрийн хэлбэрээр бичигдсэн бололтой. Иймээс ч ах дүү гурван хүний тус бүрийн нэрийн ард ч «тогурагун» гэж олон тооны хэлбэрээр бас «гурван тохурагун» гэхэд ч адилхан «олон тоот нэрийн хэлбэрээр бичигдсэн бололтой. Нөгөө талаар энэ үг худам монгол бичигт «тогурагу» гэж бичигддэг байгаад сүүлчийн хоёр «а» «у» эгшгийн хоорондоос «г» гийгүүлэгч нь сугарааД улмаар хоёр эгшиг нь ижилсэн урт эгшиг болсон учир хуучин (сонгодог) монгол бичигт «тогуруу» (53, 533б) гэж бичигдэх болсон шиг санагдана.

418. Мужи Битэгүн (Мужи Битүүн) — гэсэн энэ хүний алдар нэрийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «Мочи Бэдү'үн» гэж сэргээгээд «хүний нэр» (36, 109) гэж, Жич «Мочи» гэдэг 223 дугаар зүйлд «модочи (мужаан)» гэсэн үг гэж (36, 106) тайлжээ. Энэ үгийг Пеллио, (9, 31), Рахевильз (25, 50), Лигети (16, 62), Дашцэдэн (26, 56), Калужинский (61, 65), Баяр (11, I, 354) нар «Мөчи бэдү'үн» гэж, Дамдинсүрэн (7, 75), Баяр (11, I, 354), Мансан (27, 90), Дугаржав (24, 62) нар «Мөчи бүдүгүн» гэж, Лувсанданзан (31, I, 67) «Мөчи Битүгүн» (31, 1, 67), Элдэндэй Ардажав «Мочи Бэдүгүн» (8, 314) гэж янз янзаар ойлгож сэргээв.

Хэниш (15, 32), Поуха (17, 56) нар «Модочи (уран) Бэдү'үн» гэж, Пеллио (9, 154), Рахевильз (49, № 5, 1972, 161), Кливз (42, 52) нар орчуулалгүй хүний нэрийн ёсоор, Лувсанданзан «Мөчи, Битүгүн» гэх хоёр хүний нэр гэж, Дамдинсүрэн, Баяр, Мансан, Дугаржав цөм «мөч бүдүүн» (гэсэн хоч нэр) гэж, Элдэндэй Ардажав «Мочи Бэдүгүн» гэсэн хүний тусгай нэр гэж тус тус ухаарч ойлгосон бололтой.
Бидний бодоход Лувсанданзаны худам монгол бичгийн эхэд энэ үгийг Мужи Битэгүн гэж хоч нэрээрээр нь бичсэн байсныг Лувсанданзан утгыг ойлголгүй Мөчи, Битүгүн гэсэн хоёр хүн гэж бодсон бололтой бөгөөд XIV зууны галиглагчид эл хоч нэрийг «Мочи Бэтүгүн» гэж алдаатай галигласан байх гэж бодно. Ийнхүү бодох үндэс нь «МНТ»-ы 209 дүгээр зүйлд Чингис хаан энэ хүний тухай «бас Бэдү'үн-ү можирхак-ун тула би магуйлжу йабужу минган эсэ өкбэ» гэж хэлсэн үг тэмдэглэгдсэн баримт болно. Энэ хүний нэр XIV зууны галиглуулагчийн ташаа дуулагаар «Бэдү'үн» гэж ташаа галигдсан байна. Үчир нь Лувсанданзаны худам монгол үсгийн эхэд «Битэгүн» (дуугүй зөрүүд гэсэн утгатай үг) бичээстэй байсныг энэ сэргээлт гэрчлэх мэт. XIV зууны галигч нар ба Лувсанданзаны үед «битэгүн» гэдэг үгийн «э» нь «у»-тэй уруулаар ижилсэн бэдүгүн ~ битүгүн гэж тэмдэглэгдсэн байх. Үг эхэд Мужи гэсэн үг бичээстэй байсныг Лувсанданзан «Мөчи» гэж, Нууц товчооны галиглагч «мочи ~ можирхак» гэж ташаа буулгасан нь ил байна. Иймд энэ хүн «Мужи» (зөрүүд) «Битэгүн» (дуугүй битүү) гэсэн хоч нэрээр алдаршсан, тиймээс ч Чингис хаан түүнийг «мүүлж (взмлэж)», «мянган эс өгөв» гэдэг нь баримттай байх тул «Мужи Битэгүн» гэж сийрүүлснээ тэмдэглэе.

419. Кэкэ гагчатан (эх ганцхан) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «Кэкэ хакчатан» гэж сэргээгээд кэкэ гэдэг үгийн хадмал хятад орчуулгын утгыг «умай, эхийн ус буюу эхэс)» (36, 97) гэж тайлжээ. Энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «Кэкэ» гэж сэргээдэг боловч энэ үг чухам ямар үг болохыг нарийн тог-

тоож чадахгүй байв. Энэ учраас сүүлийн үед судалсан Элдэндэй Ардажав нар энэ үгийг хятад хадмал орчуулгын дагуу «хойдохын ус» (8, 320) гэж, Мансан «Орчин цагийн монгол хэлэнд «гэгэ» гэдэг гээх орхихын утгатай нэр үг, хүүхэд агуулсан «икэс» мэтийн зүйл болой» (27, 106, III бүлгийн тайлбар № 25) гэжээ. Иринчин «кэкэ; икэс-үн усу» (28, 87) гэж тайлбарлажээ. Дугаржав (хэвтэш гагцтан» гэсэн нь ерөнхий утгаараа нийлэвч нарийн тохирохгүй юм.

Энэ үгийг бид урьд бичсэн нэг өгүүлэлдээ (10, 156—161) «кэкэ» гэдэг нь «экэ ганцтан» гэсэн утгатай гэж тайлбарласан тул тэр ёсоор «кэкэ (экэ)» гэж сэргээсэн болно. Нууц товчооны үед хэдийгээр энэ үг «экэ» гэсэн дуудлагатай болсон боловч «кэкэ» (эх) гэсэн энэ цэцэн үгийн II мөрийн «кэгэли» гэдэг үгтэй авиа ижилсэн шүлэг болсон тул түүнийг эвдэхгүйн гэж «кэкэ» (экэ гэлгүй) чигээр үлдээжээ. Нөгөө талаар эхийн ус «кэкэ-йин усу» гэж байгаад улмаар кэкэ усу кэкэ экэс эгш гэх мэтээр хувирсан нь ил байна. Эхийн ус буюу «икэс» гэдэг үгийг Булган аймгийн зарим буриад ястны аялгуунд одоо ч «хэхэ» гэж хэлдгийг Цэрмаа багш өгүүлэлдээ заасан байна. (89, 81—82). Цэрмаа багш эхийн усыг одоо ч «кэкэ» гэж хэлдэг заншил байгаагаас «кэкэ» гэдэг «экэ» гэсэн үг биш гэж няцааж байгаа боловч үнэндээ харин хуучин монгол бичигт «икэс» (эхийн ус) гэдэг үг «кэкэ» буюу «экэ» гэдэг үгнээс үүссэнийг давхар баталж байна. Үүнээс үзвэл Нууц товчооны галигт «кэкэ» биш «кэкэ ус» гэсэн хоёр үг байгаад тэр «ус» гэдэг үг нь хаягдсаны учир хятад галигт «кэкэ» гэдгийг «экэс» буюу эхийн ус» гэсэн хадмал хятад орчуулга хийгдсэн байх гэж санагдахаар байна.

420. Жигарин (загарин) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «Жа'арин» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг «тэнгэрийн зөн, ёр бэлгэс» (36, 84) гэж тайлжээ. Пеллио, Лигети, Рахевильз, Лувсанданзан (31, I, 68) «загаран» гэж алдаатай бичжээ. Дамдинсүрэн, Дашцэдэн нар «жаарин» гэж эдүгээчилж сэргээв (26, 57), Баяр (11, I, 357), Иринчин цом «жа'арин ~ жагарин» гэж сэргээсэн бөгөөд Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз, Поуха, Калужинский цом Хэнишийн адил «тэнгэрийн тэмдэг бэлгэс» гэж орчуулсан байна.

Харин энэ үгийг Элдэндэй Ардажав нар (8, 320—321) түрэг хэлний ягарын (хонины дал) ягаринчи далны ясаар төлөг үзэх хүн гэсэн үгтэй жишиж тайлбарлав. Гэвч энэ үг бөөгийн нэр Дагуурын аялгуунд дэд бөө гэдэг шүтээн ба хүний хооронд үг дамжуулж өгдөг гэлээ (8, 320—321) гэж тайлбарлав. Гэвч энэ үгийн хожмын утгыг хөөцөлдөж энд хэрэглэгдсэн утгыг анзаарсангүй. Харин үүнийг анхаарч Дамдинсүрэн «заарин тэнгэр ирж» (7, 76) гэж, Мансан мөн үүнчлэн орчуулаад III бүлгийн тайлбарт «хувь заяаг айлтгах тэнгэр болой» (27, 107) гэжээ. Дугаржав мөн Дамдинсүрэнгийн адилаар «заарин тэнгэр» гэж сэргээгээд «сахиус» гэж тайлбарлав (24, 63).

Энэ үгийг Мостарт «-рин» гэсэн дагаварт холбогдуулан монгол хэлний «жига»-заах гэсэн утгатай (47, 353 [69]) гэж 209 дүгээр зүүлтэд тайлбарлажээ.

Иймээс бид энэ хуучин (сонгодог) монгол бичигт «загарин» гэж бичдэг үг «жа'арин» буюу «жагарин» гэж тэмдэглэгдээд тэнгэрийн заалт (зөн бэлгэс) гэсэн утгаар хэрэглэгдсэнийг энэ үгийн маш эртний утга гэж үзэж хожим тэнгэрийн заалтыг таньж хүмүүст уламжлах хүнийг «заарин» гэх болжээ гэдгийг тэмдэглэхийн хамт энэ үгийг эртний худам монгол бичигт «жигарин» гэж бичиж байсан үгийн XIV зууны галиглагч нар түрэг «йагарин» гэдэг үгэнд ойртуулан «жагарин» гэж ташаа тэмдэглэсэнээс хожим худам монгол бичигт «жигарин» гэж бичихгүй «жагарин» гэж бичих болж улмаар тэнгэрийн тааллыг заагч гэсэн үгтатай «жигарин» гэсэн үг бөгөөд халх буриад аялгуунд «жагарин» буюу «жайран» бус харин «заарин, зайранг» гэж хэлэгдэх болсныг бид тэмдэглэе.

Жич энд «нидүн дүр-ийэн» гэж сийрүүлсэн нь үзтэл алдаатай тул Дамдинсүрэн «нидүн-ду мини» (7, 76) гэх зэргээр залруулан зөв орчуулсан байдаг. Үүнийг бид «эйин» гэсэн заах төлөөний үгийг галиглагчид эндүүрч «ийэн» гэсэн ерөнхийлөн хамаатуулах нөхцөл болгож ташаа сийрүүлсэн гэж үзэж «нидүн дүр эйин» гэж сэргээв.

421. гэр лүгэ тэгэри эргүжү күлжүкү (гэр лүгэ тээри өргөж күлжүкү) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «гэрлүгэ» гэж сэргээгээд үүний хадмал хятад орчуулгын утгыг: «гэрийн багана хөндөл» (36, 79) гэж нөгөө күлжү гэсэн үгийг «көлгү» гэж сэргээгээд «хөллөн тэргэнд оруулах» (36, 103) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Энэ үгийн тус бүрийн утгыг ийнхүү ерөнхийдөө зөв тайлсан боловч өгүүлбэр бүхлээрээ ойлгоход бэрхшээлтэй болсон тул Хэниш энэ өгүүлбэрийг «Ухаа үхэр нуруунд нь хөллөсөн их гэрийг чирч» (15, 32) гэж, Пеллио «хөллөсөн их гэрийн доод талын багана (арал?) өргөж, чирч» (9, 153) гэж, Рахевильз «Гэрийн доод модноос өргөж»

(49, № 5, 1972, 162) гэж, Кливз «гэрийн доорхи их багана өргөж» (42, 53) гэх зэргээр ерөнхийдөө Хэнишийн хятад хадмал орчуулгыг дагаж орчуулсан байна. Энэ үгийг Элдэндэй Ардажав нар «гэр» (монгол үг) «луг» (түрэг үг) хоёроос бүтсэн үг гэх чиглэлээр ухаарч «гэрлүгэ гэдэг нь бараг монгол гэрийн шалны хавтсыг тулж байгаа модон тулгуур (бул тэнхлэг)-ын зүйл болно» (8, 323) гэж, тайлбарласан хэдий ч төдий л үнэмшилтэй болсонгүй.

Харин энэ үгийг Дугаржав «Их гэрийг сууриар нь өргөж тэргэнд хөллөөд» (24, 63) гэж, Дамдинсүрэн (7, 76) түүнийг дагаж Мансан (27, 91) «их гэрт тэргэнд көллөжээ» гэх буюу «...хөллөснөө» гэх зэргээр орчуулжээ. Сүүлчийн хоёр хүний орчуулга үнэнд илүү ойртсон орчуулга болсон гэлтэй.

Учир нь учирзүй ба монгол бичгийн уламжлалын үүднээс бодоход энэ үгийг Лувсанданзан «йэкэ гэр гэрлүгэ (бараа) тэгэр-э эргүжү (ачижу) хүлжү» (31, I, 68) гэж их алдаатай сэргээсэн эхэд харин илүү үнэн зөв ухаарал илэрсэн гэж бодож байна. Үүнээс үзвэл хуучин худам монгол бичгийн эхэд нь «их гэр лүгэ тээр-э эргүжү күлжү» гэсэн үг байсныг Лувсанданзан хятад галиг үсгийн эхтэй тулгахад нь «гэрлүгэ» гэж хамт бичигдсэн үг байхад «их гэр» гэсний дараа хятад эхийн хамт бичсэн «гэрлүгэ» гэсэн үгийг нэмж үүнийг (бараа) гэж «тээр-э» гэснийг (ачаа) гэж тус тус тайлбар зүүж «өргөж» гэж тайлбарласан бололтой санагдана.

«Тэгэри» гэсэн үгийг хятад галигч нар «и» эгшгээр бус «э»-гээр төгссөн «дэгэр-э» гэж буруу уншигдмаар тэмдэглэж өргөж «күлжүкү» гэсэн өгүүлбэр төгсгөсөн үгийг «күлжү» гэж ярианы маягаар хурааж богиноор тэмдэглэсэн зэргээс ийм ойлгомжгүй өгүүлбэр болсон гэж бодож байна. Учир нь гэр лүгэ тэгэри эргүж күлжү» гэсэн өгүүлбэрийн «лүгэ» гэдэг нь хамтрахын тийн ялгалын нөхцөл тул гэртэй тэгээр-ийг (ачааг) хамт өргөж гэсэн үг байж болохын дээр тэр үед үхрийг тэргэнд оруулах (хөллөх) гэдэг нь үхрийг тэрэг лүгээ «күлих» үйлээр хэрэгждэг байсан учраас «күл[и]жүкүй» гэж бичсэн байх гэж бодно. Иймд «их гэр лүгэ тэгэри эргүжү күлижүку» тэр үед хааны орд гэр тэргэн дээр бариастай байсан тул гэр ба тэргэний «тэгэри» буюу тээштэй н нь хамтаар өргөж үхэр хүлжээ гэсэн утга гаргасан ба харин дараах зүгтэжү (житкүжү) гэсэн нь үхрийн гэр ба тээртэй хүлсэн хүмүүсийн үйл биш харин үхрийн үйл тул өөр дараах өгүүлбэрт хамаарах үг болох нь илэрхий. Энэ учраас бид энэ үгийг күлижү кү гэж урьд өгүүлбэрийг дуусгаад «Жүгтэжү» гэдгээр хоёрдох өгүүлбэрийг эхлүүлж сэргээв.

422. **отулажу** (отолж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «одора» (36, 121, Пеллио (9, 32), Рахевильз (25, 51), Лигети (33, 64), Баяр (11, I, 370), Элдэндэй Ардажав (8, 327) «утуражу» гэж тус тус сэргээдэг боловч орчин цагийн монгол хэлэнд отуху отлох гэх зэрэг үг байгаагийн дээр худам монгол бичгийн уламжлалаар үгийн эхэнд «о» орвол дараа нь их төлөв «у» орох тул «отулаху» гэж бид сийрүүлэв.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «аб хамарганд 1 гоцрох, авын (азын найдлагатай) хушууч» (36, 167) гэж тайлаад үүнийг «ангийн олзны анхныхыг өргөж байя» (15, 33) гэж герман хэлэнд орчуулжээ. Пеллио «авын хүрээнээс тэргүүнд нь гарч (9, 156), Рахевильз «анг хөөж өгч» (49, № 5, 1972, 162) гэж, Кливз «авын бүлгийн түрүүнд явж» (42, 54) Поуха «шахаж өгье» (17, 58), Дамдинсүрэн «отож ойртуулж» (7, 78) гэж, Дугаржав «ойртуулан өгч» (24, 65), Мансан «отын хүн болъё» (27, 93) гэж орчуулаад III бүлгийн 28 дугаар тайлбарт «хүрээ ав хийхэд хоёр үзүүрт буюу тэргүүнд нь явах хүн болж» (27, 107) гэж, Элдэндэй Ардажав нар «Хорин нэгт тайлбар» толь зааж Мансантай адил тайлбар өгчээ.

Гэвч бид энэ үгийг «утуражу» гэж байж таарамгүй гэж санана. Учир нь нэгд, орчин цагийн монгол хэлэнд отох, отын хүн гэсэн үг хэвээр уламжлан ирсний дээр худам монгол бичигт үгийн эхэнд «о» орсон бол дараа нь их төлөв «у» орох зохицол байсан тул «утураху» гэдэг үгийн үндэс нь «уту-» бус «оту-» гэсэн дуудлагатай байсан нь лавтай. Жич оту гэсэн үгэнд «ра» дагавар залгавал «оту болох» гэсэн эс тусах үйл үг үүсэх учир «оту хийж өгөх» гэсэн утгатай нийцэхгүй. Бас одоогийн ангийн нэр томьёогоор отох (отуху) гэдэг үгийн утга нь анг хөөж авчрагч биш, харин отож (хүлээж) байгаад харвах хүн тул отураху бус (отулаху» (отын хүнд ойртуулж) гэсэн үг байснаас зайлахгүй. Галигч «л» авиаг «р» авиагаар сольж ташааран буулгасан болов уу гэж төсөөлөн, утгад нийцүүлэн «отулаху» гэж сэргээв. Энэ нь «хагарав ~ хагалав» гэдгийн адил.

423. **хала[+м] чину** (хала[+м] чинь) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас судлагчид цөм «хала» гэж сэргээдэг боловч түүний утгыг

хадмал хятад орчуулгаар нь судлагч эрдэмтэд цөм «зарлиг, тушаал, журам, зөвлөгөө» гэх мэт утгатай үгээр орчуулж буюу тайлбарлаж ирсэн юм. Ганц Элдэндэй Ардажав нар «Монголын баруун аман аялгуунд хал- гэдэг нь Монголын ван гүнгийн зарлигийг» хэлнэ. «Халатай хатуу зарлигийг заав» (8, 330, тайлбар № 13) гэсэн тодорхой гэрч баримтгүй тайлбараас өөр хадмал хятад орчуулгын энэ үгэнд оноосон утгын зөв оновчтойг батлах баримтгүй. Иймд энэ орчуулга ташаа байж болох нь илэрхий.

Бидний бодвол энэ үг «хайр халамж» гэсэн утгатай өөр үг байсан болов уу. Ингэж бодох үндсийг Лувсанданзаны энэ үгийг «халх-а» буюу «халан-а» гэж хоёр янзаар уншиж болмоор бичсэн явдал болно. Үүгээр үзвэл Лувсанданзаны худам монгол бичгийн хуучин эхэд энэ үгийг «халам-а» гэж бичээстэй байсны «м» үсгийн эвэр (зурлага) нь орхигдсон байжээ гэж бодмоор байна. Иймд бидний бодлоор энэ үг хала-(үйл үгийн язгуур 1 үндэс) +ма (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй бөгөөд анхаарал халамж, ивээл гэсэн өөр утгатай үг бөгөөд хала+гун=халуун, хала+м+жи=халамж, хала+хай=халагай гэх мэт үгтэй гарал нэгтэй төрөл үг байсан болов уу гэж бодно.

424. Хари-Ширид-эчэ (хари ширээс) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид «хари шири-д-эчэ» гэж сэргээн хадмал хятад орчуулгын үгийн утгыг Хэниш, Пеллио, Козин тэргүүтэн судлагчид янз янзаар орчуулж байсны дотор сүүлийн үед Рахевильз «төрөл садангаас» (49, № 5, 1972, 163), Кливз «сайн сайхнаас» (42, 55) гэх буюу Элдэндэй Ардажав «ариг шилик» (8, 327) гэж сийрүүлээд «аруухан гэр бүл буюу эсвэл дархан овогтон (гэр бүл)-ы гэмээнэ» (8. 330, тайлбар № 15) гэж, Мансан «харш ордыг хурааж» (27, 93) гэж, Дугаржав «хайрт гэр өрхөөс минь» (24, 65) гэх мэтээр янз янзаар ойлгож орчуулж тайлбарлажээ. Үүнийг бид урьд нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ эхнэр авч өгөлцөх гэрээт харь овгоос» гэсэн утгатай болохыг магадлан тайлбарласнаа (10, 119—126) зөв гэж санана.

425. эрэс харад-ача (эрс ардаас) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «эрэс [харад-ача]» гэж сэргээн сийрүүлээд «эрчүүд ба зарц нараас» (36, 45) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлжээ. Судлагсад «эрэс харад-дача ~ эрэс харад-ача» гэж сэргээн үгийн утгыг Хэниш «эрчүүдээс» (15, 33), Пеллио «хүмүүс ба гэрийн зарц нараас» (9, 156), Кливз «гэрийнхэн ба сайн сайхнаас» (42, 55) гэж, Лувсанданзан «хари ширээс» (31, I, 70) гэж Дамдинсүрэн «эзэлсэн ардыг авч» (7, 79), Элдэндэй Ардажав Шиеэ-зай-шан «манай эмийг хөсөр газар цөлж болно» гэж орчуулсныг зааж (8, 332), Мансан (27, 93) Дамдинсүрэнгийн адил Дугаржав «эр цэргээс минь» (24, 66) гэж тус тус ойлгож орчуулж эсвэл тайлбарласан байна.

Бид энэ үгийг «эрэс (эрчүүд) ба арад (харцас)-аас» гэсэн үг гэж ойлгож байгаа учир дээр дурдсан орчуулгаас Дамдинсүрэн Дугаржав нарын орчуулга ерөнхий утгыг зөв гаргасан гэж үзэж байна. Учир нь эрс гэдэг нь «эр цэрэг» гэсэн утгатай ба «харад» гэдэг нь ард гэдэг үг мөн боловч Нууц товчоог зохиогч «харад» гэсэн дуудлагаар нь хэрэглэжээ гэж бодов.

426. ирчигүлжү (салгаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «хиричэгү» (36, 76) гэж сэргээн хадмал орчуулгын утгыг «салгагдах» гэж тайлжээ. Энэ үгийг зарим судлагч «hиричэ'үлжү» (Пеллио, Рахевильз, Лигети, Баяр), «hиричэүлжү» (Дашцэдэн) гэж, хуучин монгол бичигт «иричэгүлжү» (Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин) гэж тус тус сэргээдэг билээ. Үгийн утгыг Хэниш «салгаж» (15, 33), Пеллио «салгаж холдуулах» (9, 156), Лувсанданзан «эрүгүлжү (?)» (31, I, 71) гэж, Рахевильз «салган тусгаарлаж» (49, № 5, 1972, 164) гэж, Кливз «салгаж хагацуулах» (42, 55), Элдэндэй Ардажав «иричэгүлжү» гэдэг үгийн үндэс нь иричэгэдэг нь 203 дугаар зүйлд байгаа «ирчитэй утга адил» гээд хорчин аман аялгуунд «эссэн зөөхийг хүчтэй зуурч ус тосыг салгах хөдөлгөөнийг» (8, 203) хэлдэгийг заав. Мансан (27, 93), Дугаржав (24, 66) нар «салгаж» гэж зөв орчуулжээ.

Бид энэ үгийг «хирчих жижиглэн салгах» гэсэн утгатай ирчи- гэсэн үндэснээс буюу эсвэл и-(жижиг хэсэг) гэсэн язгуураас үүссэн үг гэж бодож байна. Учир нь махыг маш жижиглэн хэрчихийг «кируху» гэх, иржгэр (олон жижиг биржгэртэй юм) ижаганах (язганах) — олон жижиг юмны хөдлөх, иржайиху (ярзайх) олон жижиг юм зэрэг харагдах гэх мэтээр жижиглэх, хэсэглэхтэй холбоотой үг байгаа нь үүнийг батална. Иймд кирчихү ~ ирчикү гэх мэтээр улирч хувирсан гэж бодно.

427. мэкүдэгүлсүгэй (мөхөстүүлсүгэй) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш «мэгүсдэгү» (36, 108) гэж, Пеллио (9, 32) Рахевильз (25, 52), Лигети (33, 65), Баяр (11, I, 378) тэргүүтэн «мэгүдэ'үлсүгэй» гэж, Дашцэдэн «мэкэдэүлсүгэй» (26, 60), Баяр, Элдэндэй Ардажав (8,

332) нар «мэкүдэгүлсүгэй ~ мэкүстэгүлсүгэй» гэж ерөнхийдөө адилавтар сэргээжээ.
Энэ үгийн утгыг Хэниш «дутаах, багадуулах» (36, 108) гэж хадмал хятад орчуулгын дагуу тайлж «багасгахгүй» (15, 33) гэж, Пеллио «хүлээлгэхгүй» (9, 156) гэж, Рахевильз «дутмаг үлдээхгүй» (49, №5, 1972, 164), Қлливз «дутааж зовоохгүй» (42, 55), Поуха «умартуулахгүй» (17, 59, Қалужинский «чамлуулахгүй» (61) , Дамдинсүрэн «осолдохгүй» (7, 79), Мансан тасалдуулахгүй» (27, 94), Баяр (11, I, 378), Дугаржав (24, 67) «мэкүсдэгүлсүгэй мэкүсдэгүлкү үгэй» гэж тус тус ойлгож орчуулжээ.

Бид энэ үгийг худам монгол бичигт «мэкүдэгүлсүгэй» гэж сэргээх нь зөв гэж үзэх бөгөөд «Мэкү[с]+дэ+гүл+сүгэй» гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Мэкүс-гэсэн нэр үгэнд «-дэ» гэсэн үйл үг бүтээх дагавар залгахад «-с» нь орхигддох ёс эртний худам монгол бичигт байжээ.

428. [силүн?] шүлэн (шөл) — гэсэн үгийг хятад үсгийн галиглалаас Хэниш «Шүлэн» гэж сийрүүлсэн бөгөөд «шөл» (36, 143) гэж хадмал орчуулгын утгыг тайлжээ. Энэ үгийг Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн, Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин тэргүүтэн судлаач цөм «шүлэн» гэж буулгаад үүний утгыг цөм «шөл хоол» гэж ижлээр ухаарсан юм.

Бид энэ үгийг XIV зууны галиглагдын аман аялга ба хуучин монгол бичигт бичигдэх болсон хожмын хэлбэрээрээ буюу гуйвсан дуудлагаар уламжлан ирсэн гэж бодно. Харин монгол хэлэнд «ш» авиа байгаагүй үед авсан худам (язгуур) монгол бичигт энэ үгийг «сөлүн» бус, харин «силүн» гэж бичдэг байсан гэж бодно. Үчир нь нэгд гэвэл, анхнаасаа «сөлүн» гэж бичигддэг байсан бол орчин цагийн монгол хэлэнд «шөл» буюу «ш» авиагаар эхлэх авианы бүтэц гарамгүй. Үчир нь «ш» авиа хожим гагцхүү «с+и» гэсэн үетэй үгнээс үүдсэн байдаг тул «силүн» гэсэн үгнээс «шөл» гэсэн үг бүтсэнээр төсөөлж байна. Жич «силикү» гэсэн үгтэй «шилүн» гэсэн бичлэгээр толгой холбосон байж таармаар. «с+и» нь хожим «ш» авиа нэгэнт болж хувирснаас хойш аман аялгууны нөлөөгөөр үе тонгорч «шүлэн» гэж хэлэгдэх бичигдэх болсон байх гэж төсөөлөн бодно.

429. алам (алма) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 4), Қозин (14, 23) «алан» гэж, Пеллио, Лигети, Баяр, Дашцэдэн тэргүүтэн бусад нь «алам» гэж сэргээгээд үгийн утгыг хадмал хятад орчуулгыг Хэниш «тэргэний ёроол, тэвш» гэж тайлсан учир Пеллио, Рахевильз, Қалужинский, Поуха цөм түүнийг дагаж энэ үгийг орчуулсан бололтой байна. Элдэндэй Оюундалай нар «Алан-тэргэн-ү хашилаг гэбэ» хадмал хятад орчуулгыг тайлаад энэ бол «хүрээ хороо, хот» гэсэн утгатай «хой аран» (хонины хота) гэдэг түрэг үгнээс үндэслэн тайлбарлаад (90, 38—39), Элдэндэй Ардажав энэ үгийг «арам» (хонины хашаа) дүүргэсүгэй (8, 335) гэж тайлбарласныг Мансан «аралт тэргээ бүрхүүлж» (27, 95) гэж дагасан юм. Харин Дамдинсүрэн (7, 80), Дугаржав (24, 67) нар «арыг дүүртэл» гэж тус тус оруулсан нь бидний бодлоор хамгийн зөв оновчтой орчуулга мөн.
Үчир нь «алам» гэдэг үг бидний бодоход тэрэгний хашлага биш харин уулын «завсар жалга хөндий» гэсэн утгатай «алм-а-агазргн их нүх» (12, 47а) «алмалах-газрыг их л ухах» (12, 47б) гэсэн үг бололтой. Туульч С. Чойсүрэн баатарлагийн туулинд «Хотыг дүүргээд өсөгсөн Хотгор цагаан хойтой (хоньтой), Хөдөөг бүрхэж өссөн хөвөн цагаан хойтой» (81, 93) гэх зэргээр хашаа буюу тэргэтэй гэсэн үг бус, харин хотгор газар, хөдөө талтай холбож хэлдэг уламжлалтай байжээ. Иймд «алам» гэдэг нь уулын ам, жалга, хөндий-хотун-хотон гэсэн үг хадмал хятад болон Хэнишийн орчуулсан шиг «хашаа дүүргэсү» гэсэн үг бус, харин уулын завсар ам, хотгор дүүргэе гэсэн үг байж болох байна.

430. чагургатай (цувраатай) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш «чо'орхатай» гэж сэргээгээд хадмал хятад орчуулга үгийн утгыг «цооштой, алдах, дутуу харах» (36, 29) гэж тайлжээ.

Энэ үгийг Пеллио (9, 33) Лигети (33, 65), Рахевильз (25, 53) нар «чо'орхатай» гэж, Баяр «Шохурхатай» (11, I, 382) гэж Дашцэдэн «чоургатай» (26, 60) гэж Иринчин «чохурхатай» (28, 91) гэж, Лувсандансан «чэгүргэтэй» (31, I, 72) гэж, Элдэндэй Ардажав «чогоргатай» (8, 332 ба 336) гэж, харин Дамдинсүрэн (7, 80), Баяр (11, I, 382), Дугаржав (24, 68), Мансан (27, 95) нар «чагург-а ~ чагургатай» гэж тус тус хуучин (сонгодог) монгол бичгээр сэргээсэн нь бидний бодлоор хамгийн зөв сэргээлт болно.

Энэ үгийн утгыг Хэниш «тэнхлэгийн боолт (эрэг шураг)» (15, 34), Пеллио (9, 157), Қлливз (42, 56), Рахевильз (49, № 5, 1972, 165), Қалужинский (61, 67) нар «цооштой» гэж, Поуха «түгжээтэй» (17, 60) гэж орчуулсан бололтой. Элдэндэй Ардажав «оньс цоожтой» гэж ойлгоод

Жагчид сэчэний цоожтой гэснийг (8, 336, т. № 15) заасан байна. Бид энэ үгийг «чагургатай» буюу холын аяны цуваанд орсон «цувраастай тэрэг» гэсэн үг гэж өөрөөр төсөөлж байна. Учир нь, тэр цагт «Мөн тэнд (Монголд-Ш. Г.) үнэт зүйл дээрэмдэх, хулгай хийх гэж байхгүй тул эд агуурсаа хураасан гэр орон, тэрэг бараагаа түгжиж цоожлохыг үл мэднэ» (91, 22) гэсэн гэрч баримттай тул «цоожтой тэрэг» байгаагүй биз. Харин Нууц товчооны бусад зүйлст «чагур» «чагурун» (§254), «чагургулба» (§199) гэх зэрэг үг ямагт аян зам нүүдлийн цуваанд орсон «цувраастай» тэрэг гэсэн утгатай үг болох нь ив илэрхий. Иймд энэ үгийг «чогург-а тай, чогорг-а тай, чогурхатай» гэх мэтээр тэмдэглэсэн нь галиглалын алдаа байж улмаар «чогургатай» (цоож цуургатай) гэсэн үгтэй эндүүрч хожим хийсэн хадмал хятад орчуулгад утгыг алдаатай тайлсан бололтой санагдана. Гуравт, гэвэл энэ үгийн дараах өгүүлбэрт «тэнхэсгитэй» тэргийг тэргүүр замд тээглүүлэхгүй гэж аян нүүдэлд тэргийг эвдрэл сааталгүй болгох тухай ярьсан нь «чагургатай» гэдэг үгийг цоожтой биш, харин «чагург-а тай» өөрөөр хэлбэл аян замтай холбож ойлгохын зөвийг харуулж байна.

431. чигу (цүү)-гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш «чи'у[н]» гэж, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр тэргүүтэн цом «чи'у» гэж, Дашцэдэн «чиу» гэж, Дамдинсүрэн «чөү» (7, 80), Баяр (11, I, 382), Иринчин (28, 91), Элдэндэй Ардажав (8, 336) нар «чикү» гэж сэргээн чү (цүү) гэж ухаарсан буюу тайлбарласан юм. Энэ үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгын дагуу «тэргэний дугуйн тэнхлэгийн болт» (36, 28), Пеллио орчуулалгүй орхиод хадмал хятад орчуулгын утгыг нарийвчлан тайлбарлаад «тэнхлэгийн гадаргад нь гаргасан дугуй тогтоох төвгөр» (9, 157) гэж ухаарсан юм. Энэ үгийг Рахевильз «гулгах чагт чих (цөн)» (49, № 5, 1972, 65) гэж, Кливз «тэргэний чагт (чих)» (42, 56), Поуха «тэнхлэгийн холбоос» (17, 60), Калужинский «энэ үгийг орхиж «тэрэг ачааны түгжээ» (61, 67) мултрахгүй болгох гэж орчуулсан мэт. «Чиэхү» гэсэн энэ үгийг Лувсанданзан «чину» гэж ташаа ойлгож Баяр (11, I, 382), Элдэндэй Ардажав (8, 336), Мансан (27, 96), Дугаржав (24, 68) нар цом «чү (цүү) гэж үүд цонхыг торгох хөшүүр гэхчлэн ухаарсан юм.

Бидний санавал «Чикү» буюу чүү гэдэг нь тэргэний голыг мултрахгүй болгож дугуйны голын үзүүрт нүхлэж тогтоосон чагтыг хэлдэг болов уу. Ингэж бодох үндэс нь Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үед маиж-хятад түрэмгийлэгчдийн эсрэг ард түмний зохиосон нэг дуунд:

Чиглэгэд ирэксэн чичийан тэргэ ни
Чики нь сугарагад о(йи)чиба ай-кө! (92, 114) гэж

бичсэнээс үзэхэд энэ чики буюу эртний монгол худам монгол бичигт «Чикү» гэдэг үг нь хуучин монгол бичгийн цүү цуурганы «чү» гэдэг үг биш харин тэргэний дугуйг гол тэнхлэгээс мултрахаас хамгаалж гол модны үзүүрт гаргасан нүхэнд шаантаглан оруулсан модны нэр байсан бололтой бөгөөд орчин цагийн монгол хэлэнд «чики» (сонсголын эрхтэн) гэдэг үгтэй дуудлага нь хутгалдсан боловч утгаа хадгалж үлдсэн гэж бодном. Чикү-гэдэг үгийн язгуур нь «чик+ү=чикү» буюу «чихсэн юм» гол буюу булын үзүүрийн чигт торгомжийн нэг зүйлийн нэр ажээ.

432. чикүдэгүлсү (чихдүүлсүү) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь зарим судлагчид «чи'үдэ'үлсү» (Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз), Нөгөө нь «чиудэүлсү» (Дашцэдэн) гуравдахь нь ба хуучин монгол бичгийн үүднээс «чикүдэгүлсү» (Мансан, Элдэндэй Ардажав нар, Иринчин) бас зарим нь «чикүдэгүлсү» (Баяр), эцэст нь Лувсанданзан «чөхүдэгүлсү» (31, I, 72) гэх мэт янз янзаар сэргээж уг үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгын утгыг «тэнхлэгийн чагт нь нэг нэгнээсээ салаад унагачихгүй» (36, 29) гэж тайлаад «тэнхлэгийн чагтыг нь салаад унагачихгүй» (15, 34), Пеллио «онхолдуулчихгүй» (9, 157), Рахевильз «чих нь сугараад ойчуулчихгүй» (49, № 5, 1972, 165), Поуха «тэнхлэгийн холбоосы нь салгаад унагачихгүй» (17, 61) гэх мэтээр орчуулсан бололтой санагдахаас гадна Лувсанданзан «цөхөхгүй» гэж, Дамдинсүрэн «цуцран эвдэхгүй болгох» (7, 80), Элдэндэй Ардажав «цүүгээр тээглүүлэн торгуулахгүй» (8, 336, тайлбар № 17), Мансан «бүү унагая» (27, 95), Дугаржав «цуцлахгүйгээр» (24, 68), Иринчин «тэргэн цүү гэмтэх» (28, 92, тайлбар № 5) гэж тус тус орчуулснаас сүүлчийн тайлбар үнэн магадад их ойртсон шиг байна. Учир нь бидний бодоход энэ үг чи- (чигж чих гэх мэт үйл үгийн идэвхгүй язгуур) +гү- (үйлээс нэр үг бүтээх дагавар) +дэ (зохисгүйдэх утгатай үйл үг бүтээх дагавар) +гүл (үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +сү (үйл үгийн 1 биеийн захирах хүсэх төлөвийн шийдэн хүсэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн тул аяны тэргэний чигү буюу чих[ү]-ээр таныг зохисгүйдүүлэхгүй буюу тэргэний «чих бүү чих-

дүүлье» («тэргэний эвдэрсэн чихээр бүү ноцолдуулъя») гэсэн утгатай гэж бодно.

433. тэгүтэгүлсү (тээг [саад] болгоё) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз тэргүүтэн «тэ'үрэ'үлсү» гэж, Дашцэдэн «тэүрэүлсү» гэж, Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин нар хуучин (сонгодог) монгол бичгээр «тэгүрэгүлсү» гэж тус тус буулгаад үүний утгыг Элдэндэй Ардажав (8, 336, тайлбар № 19). Иринчин (28, 92, тайлбар № 6), Мансан (27, 95), Хэниш (36, 149; мөн 15, 34), Рахевильз (49, 1972, № 5, 165), Поуха (17, 60), Калужинский (61, 67), Кливз (42, 56) нар цөм хадмал хятад орчуулгыг утгыг дагуулжу «эвдрэх хэмхрэх» гэсэн үгээр орчуулсан бололтой байна. Гагцхүү Лувсанданзан энэ үгийг «тэгэтэгүлсү» гэж сэргээснийг Дамдинсүрэн «тээглэн саатахгүй болгож» (7, 80), Дугаржав «тээглүүлэхгүй болгох» гэж илүү зөв ухаарч зөв чиглэлтэй орчуулсан гэж бодож байна.

Учир нь гэвэл энэ үгийг бид «тэгүтэгүлсү» гэсэн нь илүү зөв сэргээлт гэж болно. Юу гэвэл нэгд, «тэгүрэгүлсү» гэсэн үг Элдэндэй Ардажав нарын бодсон болон хятад хадмалд дурдсаны адил «түгүрэкү» «тэгүркэй-(зөв нь түгүркэй баймаар (?)-Ш. Г.) хялбархан, эвдрэх, бяцрах, эмтрэх» (53, 570) гэсэн үгтэй гарлын холбоотой төрөл үг бишь, харин «тэгүтэгэ үгэй-огт түвэгдэл үгэй», «тэгүтэгэрэл үгэй-торж түлбэрэкү үгэй» (12, 582), «тэгүртэкү» (түүртэх саатах) гэдэг үгстэй гарал үүслийн холбоотой төрөл үг байх гэж үзнэ. Учир нь их зам дээр тэрэг эвдрэх талаас нь биш эвдэрч саатуулах талаас нь илүү анхаарч хэлсэн баймаар юм. Нөгөө талаар тэг [г]-(саатах гэсэн үйл үгийн идэвхгүй язгуур) +р (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +тэ (нэр үгээс эс тусах үйл үг бүтээх дагавар) +гүл (үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +сү (үйл үгийн захирах хүсэх төлөвийн шийдэн хүсэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд тэгүр +тэ залгаж үйл үг бүтээхэд «р» нь хаягдаж «тэгүтэгүлсү» гэсэн үг үүсч болох бөгөөд тээг саад гэсэн утгатай тэ- гэсэн язгуураас нь Лувсанданзан тэгэ(ри)+тэ+гүл+сү=тэгэритэгүлсү гэсэн бүтэцтэй үг бүтээсэн байж болно.

434. дуйасу (-д асу [байя]) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 38), Пеллио (9, 157), Рахевильз (25, 52), Лигети (33, 65), Дашцэдэн (26, 60), Баяр (11, I, 383), Элдэндэй Ардажав (8, 332), Иринчин (28, 91) цөм «дойасу» гэж буулгаад цөм «засах цэгцлэх» гэх зэргээр орчуулдаг юм. Хэниш хадмал хятад орчуулгын утгыг «цэгцлэх журамлах» (36, 38) гэж орчуулаад Хэниш, Пеллио, Кливз, Дамдинсүрэн, Мансан, Дугаржав цөм гэр тэрэг засан захирч явъя, гэр тэргийн аж ахуйг эрхэлж (Рахевильз), үйлдэх цэгцлэх (Иринчин) гэх мэтээр ойлгож орчуулсан буюу тайлбарласны дотор Элдэндэй Ардажав нар харчны аялгуунд «дойаху» гэж тэрэг хийхийг хэлнэ (8, 336) гэжээ. Гэвч бид энэ үгийг Лувсанданзаны Алтан товчид «тэргэчү (тэргэчи) болба» гэж тайлсныг хамгийн зөв нь гэж үзэж «гэр тэргэн дуй[дур] асу» (гэр тэргэнд байя) гэсэн үг худам монгол бичгийн эхэд байжээ гэж төсөөлөн бодно. Энэ дүй=гэсэн нь үгийн эцэст «й, р» гийгүүлэгч хоорондоо сэлгэдгийн дээр асу (байя) гэсэн үгтэй нь XIV галигч нийлүүлж «дуйасу» гэж ташаа галигласан учраас ийм үл ойлгогдох үг бүтсэн мэт санагдана.

435. бажагаласугай (базаалсугай) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь судлагчид «баса'алсугай» (Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз) зарим нь хуучин (сонгодог монгол бичгээр «баса'аласугай» (Баяр, Элдэндэй Ардажав) эртний худам монгол бичгээр «басахаласухай» (Баяр, Иринчин) гэх мэтээр сэргээдэг бөгөөд утгыг нь хадмал хятад орчуулгын дагуу Хэниш «нөёрхох», «харгалзан хянах» (36, 13) гэж тайлсан тул Хэниш, Пеллио, Кливз «харгалзан хянаж байя» гэх, Дамдинсүрэн «захируулав», Элдэндэй Ардажав, Мансан «багцалсугай» (захирах засах), Дугаржав «хамааруулах болгосон» гэх зэргээр орчуулсны дотор Рахевильз «Би санаа тавьж, халамжилж байя» (49, № 5, 1972, 165) гэсэн нь бидний бодлоор маш их дөхүүлсэн орчуулга байв. Бид энэ үгийг «бажагаласугай» (бэлтгэн нийлүүлж хангаж байсугай) гэсэн үг мөн болов уу гэж төсөөлөв. Учир нь «МНТ»-ы өөр зүйлд (§232) «Орду-йин чэрбин өкид-и, гэр-үн кө[бэг]үд тэмэгэчин-и үкэ(р)чин-и кэбтэгүл бажа(г)алажу орду-йин гэр тэргэн-и асаратугай» (26, 170) гэж бичсэний утга нь гэрийн охид хөвгүүд тэмээчин, үхэрчнийг хэвтүүл бэлтгэж хамаг юмаар ханган гэр тэрэгний талаар санаа тавьж бай гэсэн утгатай нь ил байна.

Энэ үгийг бид бажага- (бэлтгэ гэсэн утгатай үйл үгийн үндэс) +ла (ахин дахин хийх байдлын үндэс үүсгэх нөхцөл) +сугай (үйл үгийн захирах хүсэх төлөвийн 1 биеийн шийдэн амлах хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд энд XIV зууны галиглагсад «жа» авиаг «са» авиагаар ташаа тэмдэглэсэн гэж бодном. Бажагаху-бэлэтгэхү (12, 237) гэ-

сэн үг хуучин (сонгодог) монгол бичигт байдаг нь энэ үгтэй ижил утгатай гэж үзэж байна.

436. онглажитхун (оглогтун) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаар нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн, Баяр, Иринчин тэргүүтэн цом «онглажитхун» гэж сэргээгээд утгыг хадмал хятад орчуулгын дагуу Хэнишийн «хага цавч, цом цохь» гэж тайлсны дагуу цээжийг хага цавч цом цохь гэх зэргээр орчуулдаг байв.
Элдэндэй Ардажав энэ үгийг түрэг хэлний үнгрэ (үглэ) буюу «хоосон болго» гэдэг үгтэй холбож «цээжийг хоосортол малт гэсэн утга» (8, 338) гэж тайлбарласан нь албадан тааруулсан шинжтэй болжээ. Мансан, бодвол, энэ тайлбарыг дагаж «өвчүүгий нь үудал» (27, 95) гэж орчуулсан ба Дугаржав «унжуулагтун» (24, 69) гэж, Дамдинсүрэн «омрууг огтолж яв» (7, 81) гэсэн нь хамгийн ойр төсөр орчуулга болсон шиг бидэнд санагдана.

Үчир нь «омруу» гэдэг үг хадмал хятад орчуулгад хэлсний адил өвчүү цээж гэсэн үг биш бөгөөд үхрийн хоолойн доор унжиж байх арьс «хоолойн доорх газар» (12, 116)-ыг хэлдэг тул малын омруугаар зүйрлэн хэлсэн энэ тохиолдолд «огтлох» гэсэн утга нь илүү тохирох мэт санагдана. Өөрөөр хэлбэл омог ихтний омруу (хүний хувьд: хоолой)-г огтол (огло хирч) гэсэн утгатай гэж бодно. Онгла гэдэг үгийн «н» авиа нь сугарч «огла» гэдэг үг болсон байж болно. Онглакид гэсэн үгийн «кид» нь «жид» болон хувирсан болов уу гэж бодох үндэстэй. «Киду-шиду, кираху китугай» гэх мэт үгсийн язгуур нь цом огтлох хирчих гэсэн утгатай тул үүнийг огло хирчигтүн гэсэн утгатай үгнээс үүсэлтэй бөгөөд үйлт нэрийн олон тооны хүн хэлбэрээр төгссөн үг гэж бодож тайлбарлав.

437. хола-йин хочоцаг, ойир-а-йин отол (холын хоорцог, ойрын отол) — гэсэн өвөрмөц хэллэгийг хятад галиг үсгийн тэмдэгтээр нь судлагчид «хола-йин хо'очаг, ойир-а йин одор-а» (Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр) гэж, эсвэл «хола-йин хогочаг, ойира-йин одор-а» (Баяр, Дугаржав, Элдэндэй Ардажав) бас зарим нь «хола-йин хоочаг, ойир-а-йин одор-а» (Дашцэдэн) гэх зэргээр сэргээдэг билээ.
Энэ хэллэгийн утгыг Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз, Поуха, Калужинский, Элдэндэй Ардажав тэргүүтэн хадмал хятад орчуулгыг дагаж хол, ойрын зайд харвах сумын нэр гэж ойлгож орчуулсан буюу тайлбарласан юм. Энэ үгийн утгыг Лувсанданзан ч ойлгосонгүй холын хоночаг (хоног) ойрын одор-а (удиртгал газарч) болтугай гэж буруу тайлбарласан юм.
Гагцхүү Дамдинсүрэн «холын холбогч, ойрын оторч» (хол ойрыг сурвалжлах газарч) (7, 81), Мансан «холын холбооч, ойрын мэдээч болтугай» (27, 95—96) гэж бидний бодоход хамгийн зөв оновчтой орчуулснаар барахгүй Мансан Нууц товчооны гуравдугаар ботийн тайлбартаа хооцог, одор-а гэсэн үгсийн хажуугийн (хадмал) орчуулгад «сум» гэснийг няцааж «хооцаг одор-а» нь хараахан элч холбоочийг зүйрлэж буй» гэж үзээд дурдсан хүмүүс «хол ойрыг холбогч элчийн ажлаар удаа дараа томилогдож байсан Нууц товчооны мэдээ, толь бичгийн тайлбар сэлтээр баталсан байна.
Харин «Хооцог» гэдэг үгийг «цаг, хугацаа болзоо»-г зааж буй» (27, 109) гэсэн нь энэ үгийн бүтцийг гүйцэд ухааражгүй нь харуулсан мэт санагдана.
Бидний бодлоор бол энэ хогоцаг гэдэг үг нь холын хооронд бүхүй холбоо гэсэн утгатай бөгөөд энэ үг хогор-гэсэн нэр үгийн үндсэнд «-цаг» гэсэн нэр үгээс дам нэр үг бүтээх дагавар залгаж бүтээхэд «р» гийгүүлэгч нь орхигдож «хогочаг» гэдэг үүссэн бололтой. Үүнийг галиглагчид хоочаг гэж хоорондох «г» нь сугарч хэлэгддэг аман аялгын дагуу хятад үсгээр галигласныг хадмал орчуулагчид үгийн эхний хор (сум) гэдэг үгийн эхний «о» эгшгийг «у» эгшгээс ялгахын тулд бичсэн «хоор» гэж ойлгоод «сум» гэж буруу орчуулснаас зайлахгүй. Үнэндээ «хоор» гэж «у»-гаас ялгаж «о» үсэг давхарлан бичдэг бичлэг нь сумыг хэлдэг биш амь хөнөөх «хор» гэдэг үг байдгийг хадмал орчуулга хийгчид бас ухаарсангүй. Нөгөө талаар оту-(гэсэн отох гэсэн утгатай үйл үгийн үндсэнд «р» биш «л» дагавар залгаж отол буюу [жарга+л=жаргал гэдэг нэр үг үүсгэдэг загвараар] «отогч хүн» гэсэн нэр үүсгэснийг галигч нар эндүүрч «отор-а» гэж үл ойлгогдох буруу үг болжээ. Оту+ла залгавал үйл үг болох тул энэ сүүлчийн дагавар нь «ла» биш «л» байх учиртай гэж бид үзэж «отул» гэж сэргээв.

438. харамла[л]дсу (харамлалдсу) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн, Баяр, Иринчин, Дугаржав, Элдэндэй Ардажав (8, 333) цом «харамалдусу» гэж галиглагчийн алдаатай тэмдэглэснээр сэргээснээр барахгүй Элдэндэй Ардажав нар энэ үгийн язгуурыг харма- (тос) халмаху (өвс) малтах, хамах хармах гэсэн бидний бодлоор өөр үгтэй эндүүрч хорин нэгт тайлбар толь заан үзвэл буруу тайлбарласныг (8, 340, тайлбар № 35)

бас Мансан дагаж «харман авчиръя» (27, 96) гэж орчуулжээ. Энэ үгийн хадмал хятад орчуулгад Хэнишийн тайлснаар (36, 62) «шүүрэн авалцая» гэсэн боловч Хэниш «Гадаа юу байна. Түүнийг чамтай хамт барилцаж тогтоож байя» гэж, Пеллио, Рахевильз, Кливз «цуглуулъя» гэж, Калужинский ганцаар «хадгалъя» (61, 67) гэж орчуулсан боловч бөгөөд хэрэв би зөв ойлгосон бол сүүлчийн орчуулга нь илүү үнэн зөв болсон шиг санагдана. Дамдинсүрэн «харамлаж» (7, 81) гэсэн нь бидний бодоход хамгийн зөв утгыг гаргасан гэж санана.

Учир нь хар хэрээ гадуур байгаа хамаг юмыг цахлай мэт цөлбөн иддэггүй, харин олсон олзоо бусдаас хармалж өтөг шороонд булж нүүх араншинтай тул энэ үг «хамах хармах» гэдэг үгийн авиа сэлгэсэн хэлбэр болох «харма» гэсэн үйл үг бус, харин «харамла» гэсэн өөр үйл үг мөн байх. Харин энэ үгийг галиглагчид ярианы аялгаар нь буруу тэмдэглэсэн тул «кармалдусу» гэж үгтэй эндүүрэгдсэн бололтой. Иймд бид энэ үгийг «харамла[л]дусу» гэж сэргээснээ зөв гэж бодно. Учир нь энэ үг хар- (харамсах харуусах гэсэн үйл үгийн язгуур) +м (үйл үгээс нэр үг үүсэх дагавар) +ла (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +[л]д- (харилцан өрсөлдөх гэсэн утгатай үйл үгийн үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +су (үйл үгийн захирах хүсэх төлөвийн 1 биеийн шийдэн хүсэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж төсөөлж сэргээв. Харамлалдусу гэсэн үгийн хоёр л авиа аман ярианд нийлж сунжран нэг «л» болж сонстсон учир хоёрдох «л» авиа нь орхигдсон бололтой.

439. нэмбэгэ (нэмнээ) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Рахевильз тэргүүтэн зарим судлагч «нэмбэ'э» гэж, Баяр, Иринчин, Элдэндэй Ардажав, Дугаржав тэргүүтэн зарим нь «нэмбэгэ» гэж, Дашцэдэн «нэмбээ» гэх зэргээр сэргээж түүний утгыг дээвэр, (Хэниш), бүтээлэг (Кливз, Рахевильз), нөмрөг (Мансан), нөмрөх (Дамдинсүрэн), эсгий (морины) эсгий хөнжил (нэмнээ) (Пеллио) гэх зэргээр элдвээр орчуулж байсан боловч «нэмбэгэ» гэдэг үг чухамдаа «нэмнээ» гэсэн үг мөн болохыг Элдэндэй Ардажав нар (8, 340) бүрнээ нотолж зөв тайлбарласан тул бид «нэмбэгэ» гэж сийрүүлэн нэмнэгэ нэмнээ гэсэн үгийг хатуу бэрх үед «халх нөмөр болъё» гэсэн утга шилжүүлэн хэрэглэсэн өвөрмөц хэллэг мөн гэж бодно.

440. гэрисгэ (гэр эсгий) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «гэрисгэ» гэж сэргээгээд Баяр, Хэниш, Пеллио, Рахевильз, Кливз, Поуха, Калужинский цөм салхи хаах эсгий гэж орчуулдаг бол монгол хэлтэн судлагчид Дамдинсүрэн «нөмрөх исэгэй нөхөөс бамбай болж» (7, 81), Элдэндэй Ардажав «гэрисгэ нь -кэрэсгэ, хэрсэг, шатны хашлага, индэр асарын саравчны хашлага, гүүрийн хашлага, цэцэрлэгийн намхан хашаа (хайс) зэргийг өгүүлнэ» (8, 341) гэж тайлбарлаад «дугаргалах эсгий» гэжээ. Мансан «хэрэсгэ исгэй» (24, 97), Дугаржав «туургын иский» (24, 69) гэж тайлбарласан боловч энэ үг чухам юу гэсэн үг болохыг XVII зууны үеэс огт мэдэгдэхгүй хуучирсан үг болсон тул «гэрисгэ исгий» гэж нууц товчооны галигт тэмдэглэсэн ба Лувсанданзан энэ үгийг (гэрисгэ (шэчэгэй)» гэж бичээд «хэрээ шаазгай» (31, 73) гэж буруу тайлбарлажээ.

Бидний бодлоор бол «гэр» гэдэг үг аливаа юмын халх нөмөр бүрээсний нэр байжээ. Үүнд сахиусны гэр, хэтний гэр, хутганы гэр (хуй) гэх мэт. Хожим хүний сууцны нэр болжээ. Иймд «гэр исгэй» гэсэн хоёр үг нийлж «гэрисгэ» буюу «бүрээс» «халх нөмөр» гэсэн нэг үг болсон ийм хоёр үгээс бүтсэн үг болохыг хэн ч мэдэхгүй болсон XIII зууны үед «гэрисгэ исгий» гэж «бүрээс исгий халх нөмрийн исгий» гэж хэрэглэх болжээ. Хожим «исгэй» гэдэг үгийг «эсгэй» гэж «э» авиагаар дуудагдах болсон үед «гэрэсгэ» гэж бичигдэх болж янз болгон барьсан намхан хашаа хайс мэтийн юмын нэр болсон мэт санагдана.

441. гэрисгэлэлдүн (гэрэсгэлдэх) — гэсэн энэ үгийг хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нэг нь нөгөөд халх болох» (36, 49), Энэ учраас Пеллио «салхинаас хамгаалалцах чармайлт больё» (9, 157), Хэниш «гэрийг чинь салхинаас хамгаалах хаалт болъё» (15, 34), Рахевильз «гэрийг салхинаас хамгаалахыг оролдъё» гэх мэтээр Поуха Калужинский тэргүүтэн орчуулсан бололтой байна.

Лувсанданзан «гэрлэн» (халхлан) гэсэн боловч «сорису» гэсэн үгийг «хурийасу» гэж «х» үсгийг «с»-тэй андуурсан нь бас түүнд худам монгол бичгийн эх байсныг давхар гэрчилжээ. Элдэндэй Ардажав «гэрэсгэ болгоё» (8, 341) гэж, Дугаржав «дулаалан сууя» (24, 69), Мансан «гэрийн бүрээс болъё» (27, 96), Дамдинсүрэн «гэр орныг хамгаалах гэрисгэ бүрээс болъё» (7, 81) гэж орчуулсанаас сүүлчийн хоёр нь утгыг илүү зөв гаргаж чадсан шиг санагдана.

Гэр зүг «гэрисгэлэлдүн» гэсэн нь чухам гэрийн зүг ирэх аюулаас гэрийн бүрээс эсгий хаалт бололцохыг оролдъё гэсэн утгатай байх. Учир нь

гэр (нийлмэл үгийн I үндэс) +исгэ[й] (нийлмэл үгийн II бүрэлдүүлбэр үгийн үндэс) +лэ (нэр үгээс үйл үг үүсгэх дагавар) +лд (үйл үгийн үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +н (нөхцөл үйлийн хам үйлдэх хэлбэр) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна.

442. тусиба (томилов) — гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «тушиху» (36, 156), Қозин «тушиба» (14, 332), гэж, Пеллио (9, 33), Баяр (11, 1, 392), Дашцэдэн (26, 61) тэргүүтэн цөм «түшибэ» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг Хэниш «итгэж даалгах» гэж тайлжээ. Харин Дамдинсүрэн (7, 82), Мансан (27, 97) нар «тушаалд томилов» гэж, Дугаржав «ажлыг хуваааж тушаав» (24, 71) гэж, Хэниш «итгэн даалгах» (15, 34—35), Пеллио «үүрэгт ажилд тавив», Қливз, (42, 58), Рахевильз (49, № 5, 1972, 166) нар «томилов» гэсэн үгээр орчуулсны нь цөм ерөнхийдөө хятад хадмал орчуулгын утгатай нийцэж буй боловч харин «түшив» гэсэн үгийн утгатай тохирохгүй байна. Бид энэ үгийг «түшив» гэж сэргээснийг XIV-йин үеийн хэл аялгууны дуудлагаар ташаа тэмдэглэсэн бүруу сэргээлт гэж үзэж, нөгөө Хэниш, Қозин нарын «тушиба» гэж сэргээснийг зөв гэж «тушиба» гэж сэргээв. Учир нь монгол бичгийн найруулгын уламжлал нь аливаа ажилд хүнийг томилохыг тушаал гаргах, тушаалд тавих» гэдэг үгтэй холбоотой байдаг тул «туших» гэдэг нь уул ажилд тогтоох, тусгайлан даалгах гэсэн утгаар хэрэглэгдэж байсан нь тодорхой учир Дамдинсүрэн Мансан нарын орчуулга хамгийн зөв гэж бодож байна.

443. бү талаһхун (бүү талаар болгогтун) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «талху» (36, 156) гэж, бусад нь (Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Иринчин, Қозин, Элдэндэй Ардажав нар) цөм «талутхун» гэж сэргээн сийрүүлээд Хэниш, Пеллио, Қливз, Элдэндэй Ардажав нар «бүү тайлагтун» гэж орчуулсан буюу тайлбарласан нь даруй хадмал орчуулгын онооссон утгыг дагуулсан орчуулга бололтой. Бас Дамдинсүрэн (7, 83), Дугаржав (24, 71) нар «таслахгүй» гэж, Мансан «суладхахгүй» (27, 97), Рахевильз «хүчингүй болгохгүй» (49, 1972. № 5, 166) гэх зэргээр орчуулснаас миний бодоход Рахевильз уг үгийн утгад илүү ойртуулж орчуулсан мэт санагдана. Бид энэ үгийг «талагаар» (12, 574б) дэмий буюу хүчингүй болгох гэсэн үгтэй гарал нэгтэй «таладхун» гэсэн утгатай үйл үг гэж үзэж «ийнхүү сэргээв. Энэ дэмий хоосон гэсэн утгатай «тала» гэдэг үг нэр үгийн үндэс мөн тул түүнд тала-бар (гар) гэсэн үйлдэхийн тийн ялгалын нөхцөл залгаж «талаар» гэсэн дайвар үг бүтээсэн бололтой. Иймд бид энэ үгийг тала-(нэр үгийн идэвхгүй язгуур) +д (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +хун (үйлт нэрийн ирээдүй цагийн олон тооны үндэс үүсгэх нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд энэ сүүлчийн нөхцөлөөс авианы сэлгэлтээр «гтун» гэсэн захирах хүсэх төлөвийн хүндэтгэн захирах хэлбэрийн нөхцөл үүсч гарсан мэт бидэнд санагдана.

444. тамтуладхун (тамтаглах урах) — гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагч нар цөм «тамтулутхун» гэж сийрүүлээд Хэниш, Пеллио, Рахевильз, Қливз захаа «урж тасдахгүй», Элдэндэй Ардажав «ударугтун эвдэгтүн» (8, 346) гэж хадмал хятад орчуулгыг үгчлэн дагаж орчуулсан бол Дамдинсүрэн (7, 83), Мансан (27, 97) Дугаржав (24, 91) «Ах захаа алдахгүй» гэж орчуулсан нь тухайн үг хэллэгийн гүн нарийн (шилжсэн) утгыг оновчтой илтгэж чадсан юм. Бид энэ үгийг «там- (элэх гэсэн утгатай үгийн идэвхтэй язгуур) +т (эс тусах үйл үгийн үндэс бүтээх дагавар) +[г] (үйл үгээс элсэн юмын үлдэгдэл гэсэн утгатай нэр бүтээх дагавар) +ла (нэр үгээс тусах үйл үг бүтээх дагавар) +т (үйл үгийн олон тооны илтгэц) +хун (үйлт нэрийн ирээдүй цагийн олон тоот нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож «тамтуладхун» гэж сэргээх нь зөв гэж үзэв. «Тамтулутхун» гэдэг нь монгол хэлэнд уруулаар зохицох ёс гарсан үеийн XIV зууны галигчлагчийн аман аялгууны дагуу «тамтулутхун» гэж ташаа сийрүүлсэн гэж бодож байна.

445. хэрэгэс-эчэ (жүчээний хэрэгэ (уяа)) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 102) «килү'эсэ», Пеллио (9, 35) Лигети (33, 69), Рахевильз (25, 55) цөм «килү'эсэ-эчэ» гэж, Дашцэдэн «кирүэсэ-эчэ» гэж, Баяр «кирүгэсү-эгэ» (11, II, 410) гэж, Иринчин (28, 97), Элдэндэй Ардажав (8, 356) нар «кирүгэс-эчэ» гэж түс түс сэргээснээс бид сүүлчийн хоёр хүнийхийг илүү зөв гэж бодно.

Харин энэ үгийн утгыг Хэниш, Пеллио, Рахевильз, Поуха, Калужинский цөм хадмал хятад орчуулгыг дагаж цөм «морины талбай, морины буудал» гэх зэргээр ойлгосон байхад Дамдинсүрэн (7, 88), Мансан (27, 115) нар «морины уяанаас» гэж түс түс ойлгож орчуулснаас сүүлчийн хоёр хүнийхийг бид илүү зөвд тооцож байна. Харин **энэ үгийн утгыг Элдэндэй Ардажав олон түүхэн бичгийн баримт мэдээлэлд үндэслэн морины уяа гэсэн утгатай үг болохыг тодорхой**

тайлбарласан (8, 357, тайлбар № 3) боловч энэ үг чухам ямар үг болохыг хэлсэнгүй.

Бидний бодвол энэ үгийг «кирүгэс» «хэрэгэс-эчэ» гэж сэргээх нь зөв гэж бодно. Учир нь нэгд, кирүгэ = гэж бичвэл уяа биш мод таслан хөрөөдөх хөрөөний нэр болно. Хоёрт, Шагж багшийн толинд «кэрэгэжүчүгэн-ү кэрэгэ» (12, 354) гэж бичсэн бидний санахад хэлэлцэж буй үгийн эртний уламжлалт бичлэгийн хэлбэр нь мөнөөс зайлахгүй. Морь хэрэх гэгч морьдыг хөлөөр нь аргамжаар холбож уяхын нэр бөгөөд бас хоёр шонгийн хооронд татсан сур дээс зэргээр холбож уясныг монгол бичгээр «хэчэ» гэж нэрлэдгээс үзвэл «хэц, хэрэ+хэрэгэ» цөм гарал нэгтэй төрөл үг болов уу гэж санах учир «хэрэгэс-эчэ» гэж сийрүүлэв.

446. хуйимусчу (хуйвалдүн өмөөрч) — гэсэн энэ үгийг Хэниш, Пеллио, Рахевильз, Лигети, Дашцэдэн нар «hойимасчу» гэж, Баяр Иринчин, Элдэндэй Ардажав нар цөм «ойимасчу» гэж сэргээгээд энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш (36, 78) «хэн нэгний нь эсрэг хэн нэг хүнийг хамгаалах» гэж тайлаад Хэниш, Пеллио, Кливз, Рахевильз цөм «хамгаалах өмгөөлөх» гэж орчуулжээ.

Энэ үгийг Элдэндэй Ардажав нар «айимусба» гэсэн үг гэж үзэн, хилэгнэх зэмлэх гэсэн утгатай (8, 358) гэж тайлбарлаад өөр үг болох «айимусху» гэдэг үгийн холбогдолтой баримт заасан тул төдий л үнэмшилтэй бусын дээр хятад хадмал орчуулгын утгаас зөржээ. Энэ үгийг сударч Лувсанданзан «өмөгүрэн» (31, 77), Дамдинсүрэн (7, 88), Мансан (27, 115), Дугаржав (24, 74) нар цөм «өмүгэрчү» гэж орчин цагийн монгол хэлэнд орчуулсан нь утгын хувьд зөв бөгөөд хадмал орчуулагтай нийцэж байна.

Харин бид «хуймусчу» гэдэг далдуур санаа нийлэх, талсах гэсэн утгатай «хо[о]билдуху» гэдэг үгийн «б» «м» авиа сэлгэн «хо(о)мисчу, улмаар «и» нь урагшлан «хуйимусчу» (талсаж өмөөрөх) гэсэн үг үүссэн байж магадгүй. Учир нь хо[о] авиаг үгийн эхэнд «у»-гаас ялгахаар үсэг давхарлан бичдэг ёс байсан нь хожим олон үгийн дуудлага урт хос эгшигтэй болоход нөлөөлсөн юм. До[о]р гэж «дур»-аас ялгах зорилготой нэмэлт «о» үсэг бичдэг учраас хожим энэ үгийн дуудлага «доор» гэж урт болсон юм. Үүнтэй адил хувирал гарсан биш байгаа?

447. мөрү эдү[й]хү (мөр өдий хү) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиграас нь Хэниш, Пеллио, Козин, Рахевильз, Лигети, Дашцэдэн цөм «мэр удү'үй» гэж, Дашцэдэн «мэр удүүй» (26, 65), Иринчин «мэр удүхүй» (28, 97) гэж, Элдэндэй Ардажав «мэр удүхүй» гэж тус тус сэргээжээ. Үүний утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «шархадсан ч хүнд бус» гэж тайлаад «Харин ч хөнгөн шархадлаа» (15, 38) гэснийг Пеллио, Поуха, Калужинский, Кливз, Рахевильз, Мансан, Дугаржав цөм «жаахан (хөнгөн) шарх гайгүй, дажгүй» гэх зэргээр орчуулсан байна. Элдэндэй Оюундалай «мэр» гэдгийг бэртэхийн авиа сэлгэлт гэсэн утгаар тайлбарлав (27, 130, IV бүлгийн тайлбар № 4) гэжээ.

Бид үүнийг «Мөрү эдүй хү» (энэ зэрэг) бөлгөө» гэсэн хоёр үгийн авиаг бууруу салгаж ташаа галиглаа болов уу гэж таамаглав. Үүнд Лувсанданзан энэ үгийн утгыг «манагар эдүрэй чабчиксан бөлүгээ» (31, 78) гэж бууруу тайлсны дотор эдүрэй гэж «э»-гээр эхэлсэн бичлэг байгаагаас «мөрү эдүй-кү» гэсэн бичлэг байгаа юу гэж санамаар байна. Үүнийг XIV зууны галиглагчид тухай цагийн уруулаар ижилсгэх хандлагаараа «мэр-ү[э]дү[х]үй» гэж ташаа тэмдэглэсэн байх магадгүй.

448. ганалга (ганалга) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 59), Пеллио (9, 36), Рахевильз, Лигети, Баяр (11, II, 117), Иринчин цөм «ханалха» гэж, Дашцэдэн, «ханалга» (26, 66) гэх зэргээр сэргээн судлагчид эл үгийн утгыг хадмал хятад орчуулгыг Хэнишийн «аятай тохиол, шалтаг» (36, 59) гэж орчуулсантай дөхүү утгаар «энэ учрал тохиолд» гэж ихэвчлэн ойлгожээ. Лувсанданзан «касалха тур кабсау-а бида» гэсэн нь сонирхолтой. Дамдинсүрэн «энэ алалдаанд» (7, 89), Элдэндэй Ардажав «энэ шалтгаан, ташрам тохиол, завшаан» (8, 364, тайлбар № 1) гэж, Мансан «дашрамд (27, 116), Дугаржав «энэ шалтгаар» (24, 75) гэж тус тус орчуулсны дотроос Элдэндэй Ардажав нар манж хэлний «ханаган» (баримж, домог, үгийн домог, шалтаглах, шалтах), буриад «ханалга» (ханах, хангах, ханамж) гэсэн үгстэй холбож тайлбарласан боловч утгад нь сайтар нийцсэнгүй.

Бидний бодоход энэ үг «ганалга» гэдэг үг мөн бөгөөд анаж урьдаас отож бэлтгэж цагийг хүлээх гэсэн утгатай үгнээс гарсан бололтой. Ганаатай чадах, гагжаатай (хясаантай, занаатай) гэх мэт үг халхын аялгуунд байдаг боловч толь бичигт өргөн дэлгэр орсонгүй. Гэвч энэ

үгнээс хожим анах (хичээн отох), анагаах гэх мэт үг үүссэн болов уу гэж санана. Ганаатай гэдэг нь занаатай гэдэг үгийн ойролцоо утгатай ховор хэрэглэгдэх үг болно.

449. игтунажу (жигдрэн нэгдэж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио, (9, 36), Лигети (33, 71), Рахевильз (25, 56), Баяр (11, II, 420), Иринчин (28, 99), Элдэндэй Ардажав (8, 363) нар «иктүнэжү» гэж, Дашцэдэн «игтүнэжү» (26, 65) гэж Хэнишийн адил (36, 81) сэргээжээ. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «хүрч ирэх» (36, 81) гэж тайлсан бөгөөд Пеллио, Рахевильз, Поуха, Калужинский цөм «яаран [Чингис хаанд] хүрч ирсэн» гэж, Кливз товч орчуулгаар нь «биеэр хүрч ирсэн» гэж, Дамдинсүрэн «үгтан хүрч ирэв» (7, 90), Мансан «шалавдан мордож ирэв» (27, 116), Дугаржав «хурдлан мордоод» (24, 75), Элдэндэй Ардажав «Көлөн Буир аймгийн шинэ баргын нутгийн аялгуу: буруушаагдан зэмлэгдсэнээс тэвдэн мэгдэх байдлыг өгүүлэв. «Нууц товчоонд» он дэвших, зэрэг дэвших ахих, урагшлах, давших гэсэн утгатай болно» (8, 364, тайлбар № 5) гэжээ.

Тэгэвч энэ үг чухам юу гэсэн үг болохыг тодорхой хэлсэн нь үгүй. Бид энэ үгийг олон юмын нягтарч нийлэх байдлыг өгүүлэх «иг» язгууртай үг гэж таамаглав. «Үтэрлэн игтунажу» гэгч «яаран саная нэгдэн нягтарч» гэсэн утгатай гэж бодох үндэс гэвэл үүнтэй холбоотой «игчи-ургамлын няг(ту) сахлагийн байдал» (12, 91б), «игчү- иртэл дүүрсний байдал» (12, 92) гэсэн үгс байгаа явдал болно. Нөгөө талаар Нууц товчоог галиглагчидад үгийн нэгдүгээр үеийн саармаг эгшигтэй үгийг эм эгшигтэй үгээр галиглах хандлага их байсан тул «чабуралуг-а» гэхийг «чэвүрэлүг-э» (§72) «бидугулжу» гэхийг «битүгүлжү» (§19) гэх, «онширмал» гэхийг «нөншилмэл» (§72) гэх зэргээр тэмдэглэдэг тул энэ удаа ч «игтунажу» гэхийг «иктүнэжү» гэж ташаа тэмдэглэсэн гэх үндэстэй биз.

Иймд бид энэ үгийг иг —(үгийн язгуур) +т (үгийн идэвхгүй язгуураас игт (ягт) гэсэн утгатай үйл үг бүтээх дагавар) +на (үйл үгээс үйл үгийн давтагдах байдал бүтээх залгавар) +жу (үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна.

450. жагуд хури (жагуд хури) — гэсэн нэр цолын үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Рахевильз, Лигети, Мансан, Баяр, Иринчин, Поуха (58, 56) зэрэг зарим нь «жа'ут-хури, жахуд-хури, жагуд-хури» гэж, Пеллио, Калужинский, Дамдинсүрэн, Дугаржав зэрэг зарим нь «ча'утхури, ча'удухури» гэх зэргээр сэргээн босгоод олон хүн тайлбарлалгүй хүний цол нэр гэж ойлгосон бол Рахевильз Поуха нар «жагуд хури» буюу зуутын дарга гэсэн үг биш байгаа гэж эргэлзэн буюу тийм үг гэж баталсан бол Иринчин жөрчид (манж) жахуд (зах хилийн), хури (ноён) (28, 100—101) гэж, Мансан, Пеллио, Элдэндэй Оюундалай хоёрын «их эрх сүртэй аймгийнхны ахлагч» гэсэн тайлбарыг зөвшөөрсөн, Поуха «жагуд» гэдгийг жагу (зуу)-д (олон тооны дагавар) «хури-цэргийн дарга» гэсэн хитан (монгол -Ш. Г.) үг гэж тайлбарлажээ.

Бид энэ сүүлчийн тайлбарыг зөв гэж баримталсан бөгөөд учир нь Алхуши тнгид-хури гэсэн хүний нэрд мөн хури (дарга) гэсэн үг байгааг баримталсны дээр хитан нар монгол аймаг байсан тул «жагуд» гэдэг нь үнэхээр зуут гэсэн үг байсан байж болно гэж үзсэнд бий. Харин Лувсанданзан «чаг-ун төрү» гэдэг нь арай эргэлзээтэй гэж бодов.

451. Жабу-табу — гэсэн үгийг хятад галиг үсгээс нь судлагчид «Жаутау» (Пеллио, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Лувсанданзан, Дамдинсүрэн, Поуха, Кливз), «жао-тао» (Хэниш, Калужинский), «Жеутау» (Рахевильз, Лигети), «Жоу тоу» (Баяр, Мансан) гэх зэргээр элдэв олон янзаар сэргээдгээс бид Пеллио нарынхыг илүү зөв болов уу гэж баримтлав.

Энэ үгийн утгыг Хэниш хятадын чао тао гэгч «илбин тохинуулагч комиссар» гэж тайлжээ. Элдэндэй Ардажав нар «Жэү тау» гэгч хятан (жөрчидийн?) Алтан, Юван улсын ноёдын нэр түшмэл болно гэж тайлбарласныг бид баримтлан хэвээр сийрүүлэв.

452. дөрэбчи-ту (дөрөвчит) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «дөрэбчи» гэж сэргээгээд уул үгийн утгыг хятад хадмал орчуулгаас нь «бөгж цагираг» (36, 37) гэж тайлав. Судлагчид цөм Хэнишийн адилаар сэргээдэг байна. Харин энэ үгийн утгыг Хэниш (15, 39), Рахевильз (49, № 10, 1974, 60), Поуха (17, 68), Кливз (42 63), Элдэндэй Ардажав (8, 470—471), Мансан (27, 131—132) цөм «хамрын ээмэг» гэж орчуулсан буюу тайлбарласан байдаг.

Элдэндэй Оюундалай нар хэдий дөрөвч багадаа зүүж байсан гэх үзэмчин хүний үгийг баримт болгосон боловч Монголд ялангуяа хүүхдийн хамрыг дөрлөн цоолж ээмэг зүүж байсан баримт үгүйн дээр дөр+вчи

бүтэцтэй үг ямагт элгэвч, түрийвч, хуруувч гэх мэт ямагт **юмын гадуур бүрхэх хамгаалах утгатай үг байдаг тул энэ алтан ээмэг ба дөрөвч нь хүүхдийн биед биш харин хувцас хунарт нь байгаа дэгээ ба** гогцоонд холбогдох үг биш байгаадаа? гэж эргэлзмээр санагдана. Алтан бүсийн «горхидоос» (§ 238) гэсэн Идүгүдийн үгнээс үзвэл бүсэнд бас «гархи» горхи» буюу дөрөвч зүүдэг заншил монголчуудад бас байжээ. Алтан чимэгт бүс бол хан хүний ялгах тэмдэг байсан учраас ч үүгээр нь Өгэлүн эх энэ хүүг«язгуур сайт хүний ураг буюу зэ» гэж хэлсэн байх магадгүй.

453. агуруг (ар гэр) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш «А'урах» (36, 10) гэж, Пеллио (9, 37), Лигети (33, 72), Рахевильз (25, 58) нар «а'уруг» гэж, Лувсанданзан «ахураг» (31, 83) гэж, Дамдинсүрэн (7, 91), Элдэндэй Ардажав (8, 372), Мансан (27, 117), Баяр (11, II, 430), Дугаржав (24, 77) нар цөм «агуруг» гэж, Дашцэдэн «ауруг» (26, 68) гэж, Иринчин «ахурух» (28, 102) гэж элдвээр сэргээдэг билээ.

Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаар нь «хуучин лагерь», «ахлах лагерь, гол лагерь» (36, 10) гэж тайлаад Хэниш герман хэлэнд «гол лагерь» (15, 39), Пеллио орчуулалгүй хэвээр бичжээ (9, 136), Рахевильз «суурин лагерь» (49, № 10, 1974, 60), Калужинский «гол ачаа хөсөг» (61, 74), Дамдинсүрэн «ар гэр» (7, 91), Элдэндэй Ардажав нар «гэр, хөдөө аж ахуй» гэх буюу «агуруг» гэгч «эргүн-э» (өргө) гол гэдгээс гаралтай гэх зэргээр тайлбарласан нь үг зүйн үндэслэгээ муутай. Мансан (27, 117—118) саях тайлбарыг зөвшөөрчээ.

Бидний санахад «агуруг» гэдэг байх орших гэсэн утгатай а-язгуурт үйл үгийн үндсэнд гуд гэсэн бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөл залгавал агуул гэсэн юмыг байлга гэсэн үг үүснэ. Энэ агуул гэдэг үгэнд «р» дагавар залгавал нөхцөлийн төгсгөлийн «л» нь хасагдаж «агур» гэсэн эс тусах үйл үг үүсэх юм. Энэ үйл үг нь «агуулагдах» гэсэн утгатай болно. Агур- гэсэн үйл үгийн үндсэнд «г» залгахад «агуруг» буюу агуулагдан бүхий юм гэсэн үг бүтсэн гэж бодно. «Агурхай» «агуулага» гэх мэт үгтэй гарал төрөл нэгтэй «агуруг» гэдэг үг ар гэрт агуулагдсан бүх зүйл гэсэн утгатай үг болов уу гэж санаж байна.

454. өс тан кис тан (өстөн кистан) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «өстөн кистан» (36, 128 ба 102) гэж, Пеллио (9, 37) **«ошитэн киктэн»** [зөв нь: **өштөн киштэн**] (9, 37), Лигети (33, 75), Рахевильз (25, 58) нар «өштөн киштэн» гэж, Дашцэдэн (24, 69), Элдэндэй Ардажав (8, 373) нар «өшитэн кишитэн» гэж, Лувсанданзан (31, 83), Баяр (11, II, 433), Иринчин (28, 102) нар «өстэн кистан» гэж тус тус сэргээснээс бид Хэнишийн болон сүүлчийн гурван зохиогчийн сэргээлтийг чухам зөв нь гэж бодож байна.

Учир нь «өс» «кис» гэдэг нь жинхэнэ нэр үгийн үндэс мөн учир гагцхүү тэдгээрийн үндсэнд эр хүйсэнд «-ту, -тү» эм хүйсэнд «-тай, -тэй» олон тоонд эр эм хүйс ялгахгүй «-тан, -тэн» дагавар залгаж тухайн үгийн утгаар илэрхийлсэн зүйлийг эзэмшсэн буюу агуулах утгатай харьцангуй нэр үг бүтээж болох юм. Энд олон тоот хам нэр Татаарт өс кис бүхүй гэсэн утгатай «өстэн кистан» гэсэн үг хэл зүйн ёсоор бүтээсэн тул зөв юм.

Харин өши-гэдэг нь үйл үгийн үндэс мөн тул түүнд дүрдсан дагавар залгаж үг бүтээх учиргүй тул «өштөн киштэн» гэх буюу «өшитэн кишитэн» гэж сэргээх нь буруу юм. «Өси-киси» гэдэг нь үйл үг болохыг «өси+й-э» гэж үйл үгээс нэр үг бүтээх дагавар залгаж болдог баримт харуулж байна. Жич энэ үгийн утгыг Хэниш, Рахевильз, Калужинский, Поуха нар «дайсан» гэж, Пеллио «хор хөнөөл» гэж орчуулсан нь төдий л оновчтой бус, харин Кливз «үзэн ядах, өстөн» гэсэн нь дөхүүлсэн орчуулга болсноос гадна Дамдинсүрэн, Мансан, Дугаржав нар «өшөөтөн» гэсэн нь хамгийн зөв оновчтой орчуулга болсон шиг санагдана.

455. тэлэгэ ту амсар (тэлээт амсар) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 182), Пеллио (9, 37), Лигети (33, 37), Дашцэдэн (26, 69), Баяр (11, II, 434), Элдэндэй Ардажав (8, 373), Дугаржав (24, 78), Иринчин (28, 103) нар «тэлэту амасар-а» гэж, гэвч Хэниш «тэлэгэту амасар-а[уу?]» гэж, Мансан (27, 118) «тэлэгэту амасар-а?» гэж, Рахевильз (25, 58) Кливз (42, 64) нар «тэлэту» гэж, Дамдинсүрэн «тэлэту ама» (7, 91) гэж, Лувсанданзан «дэлту амасар-а» (31, 84) гэж тус тус сэргээжээ. Үүнийг газрын нэр гэсэн учир утгыг судлагчид анхаарсангүй. Гэвч «амасар-а» гэснийг Хэниш «эрэг хавчил» (15, 40), Поуха «нураа (ганга?)», Калужинский «гарах нүх», Рахевильз «хавчил гарц» гэж, Дамдинсүрэн «ам» гэж орчуулжээ.

Бид «Тэлэгэтү амасар-а» гэж сэргээсэн Мансангийн сэргээлтийг зөв гэж баримтлав. Учир нь «тэлэгэ тэлэ» гэдэг нь өргөн бол гэсэн утгатай үйл үг байж болох тул харьцангуй нэр бүтээх -тү дагаврыг түүнд залгамгүй бөгөөд харин тэлэ- гэсэн үгэнд «гэ» гэсэн дагавар залгаж нэр үг бүтээсний дараа сая -тү дагавар залгаж болно. Тэлэгэ (Тэлээ) гэдэг үгийн сүүлчийн «лэ'э» гэсэн хоёр үеийн дундаас «г» нь Рахевильз Кливз нарын тэмдэглэсэн шиг «тэлээтү» гэж урт эгшиг болж сонстон тэмдэглэсэн байж болно. Хэрэв энэ «тэлэгэтү» гэсэн үг биш бол Лувсанданзаны сэргээсэн шиг «дэл(хид) +тү» буюу дэлтү (дэл хадаг) ам гэсэн үг байж магадгүй.

456. тушижү (тушааж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 156), Пеллио (9, 37), Лигети (33, 73), Дашцэдэн (22, 69) нар «түшижү өкбэ» гэж аман аялгууны дуудлагаар, нөгөө Рахевильз (25, 59), Баяр (11, II, 435), Элдэндэй Ардажав (8, 373), Иринчин (28, 103), Лувсанданзан (31, 84) нар бичгийн үгээр «тусижу өкбэ» гэж тус тус сэргээсэн байна. Харин энэ үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгын дагуу «тэд хүзүүгээ бөхийлгеж өгөв» (15, 40), Пеллио (9, 163), Мансан (27, 118) нар «хүзүүгээ сунгаж» гэж, Рахевильз «хүзүүгээ илдэн доор тавьж өгөв» (49, № 10, 1974, 61), Дугаржав «толгойгоо тонгойж өгөв» (24, 78) гэж, Кливз «тэд түүний (ө.х. Чингис хааны) өмнө хүзүүгээ доош сунгаж өгөв» (42, 65) гэж тус тус орчуулсан шиг санагдана.

Бидний санавал энэ нь «түшиж өгөв» гэсэн үг бус, харин «тушиж өгөв» гэсэн үг бөгөөд биеэ «тушааж өгөв» гэсэн утгатай мэт санагдана. Учир нь туших гэдэг морь малыг хөдөлгөхгүй зүгтаалгачихгүйн тулд урд хоёр хөлийг нь тушиж зогсоодог. Иймээс хүнийг ямар нэг албан тушаалд тусгайлан тавихад уг тушаалд уяж бэхэлж өгөхийг бас «туших» гэдэг байжээ. Энэ үгнээс албан «тушаал» гэдэг үг гарсан байна. Иймд тэд буруугаа мэдэж эсэргүүцэлгүй биеэ «тушиж (тушааж) өгөв» гэсэн үгийг тэр цагийн үгэнд «тушижу» гэж хэлдэг байжээ. Учир нь «туший-а» гэвэл тэр үед «тушаа» гэсэн бусдаар үйлдүүлэх хэвийн үйл үг бус, харин «туших сурын» нэр болдог байжээ. Туших гэдэг үг тэр цагтаа бусдаар үйлдүүлэх утгатай байсан болов уу.

457. бүтэгэжү (бүтээж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 24), Пеллио (9, 37), Лигети (33, 73), Рахевильз (25, 59) нар «бүтэ'эжү» гэж, Дашцэдэн (26, 69) «бүтээжү» гэж, Баяр (11, II, 435), Элдэндэй Ардажав (8, 373) нар «бүтэгэжү» гэж, Лувсанданзан (31, 84), Иринчин (28, 103) нар «бүтүгэжү» гэж сэргээжэ.

Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «дуусгах (алах)» гэсэн үг гэж тайлсан бөгөөд герман хэлэнд «алж» (15, 40) гэж, Пеллио «зүйл дуусгаж» (9, 163), Рахевильз «үгийн нь ёсоор болгосон» (49, № 10, 1974, 61), Кливз Пеллиогийн адилаар «түүнийг (зүй ёсоор) дуусгасан» (42, 65) гэж, Дамдинсүрэн (7, 91), Дугаржав (24, 78) нар «алав» «алж гээв» гэж, Лувсанданзан Иринчин нар «алах ажлыг гүйцэтгэн дуусгасан» гэх зэргээр орчуулсны дотроос Баяр (11, II, 435), Мансан (27, 118), Элдэндэй Ардажав (8, 373) нар бүтээж (амьсгалыг таглаж) алсан гэж бидний бодлоор хамгийн зөв ойлгож оновчтой орчуулснаар барахгүй сүүлчийн хоёр зохиогч энэ үгийн утгыг олон баримтаар үнэмшилтэй тайлбарласан (8, 377) байна. Бид энэ саналыг дэмжиж «бүтэгэжү» (амьсгааг таглан) алсан гэхдээ «бүтэгэхү» гэдэг аливаа юмыг шинээр бүтэн болгож дуусгах гэсэн утгатай үгээс ялгаатай өөр үг гэж ойлгов. Харин гэрийн өрхийг бүтээв гэдэг нь мөн агаар орох онгорхойг бүтээх битүүлэх гэсэн энэ «бүтэгэкү» гэдэг үг мөн гэж бодож байна.

458. Тэргэтү байан (Тэрэгт баян) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид «Тэлэгэтү байан» гэж сэргээн босгож ирсэн бөгөөд хүний нэр гэж бат итгэж иржээ. Гэвч гагцхүү Лувсанданзан (31, 84), Дугаржав (24, 78) «Тэлгэтү байан» гэж сэргээсэн нь «Тэлэгэтү байан» гэснээс уг үгийн дуудлагад илүү ойр болжээ.

Бидний бодлоор энэ нь XIV зууны үед хийсэн галиглагч нарын ташаа тэмдэглэснээс «тэлэгэтү байан» гэсэн үг бус харин «Тэргэтү байан» гэсэн үг мөн бололтой. Учир нь гэвэл Лувсанданзаны эхэд «Тэлэгэд» бус харин «Тэлгэтү» гэж бичсэн нь уг эхэд «тэргэтү» байан» гэсэн үг байсны гэрч болно. «Тэлэгэтү» амсар гэдэг үгийн тайлбарт бидний хэлсэнээр-тү дагаврыг үйл үгэнд биш нэр үгэнд залгадаг тул тэлгэ бус тэргэ гэсэн үгэнд залгасан гэх нь илүү байх боломжтой зүйл юм. Энэ үгийг би эндүүрээгүй бол Пеллио Амби нар Чингис хааны аян дайны түүх (54, 365) номдоо Тэргэт баян гэсэн үг байх гэж санал хэлсний дээр Поуха (58, 50) Тэлэгэтү байан гэсэн үгийг «тэрэг эзэмшигч» баян болов уу гэсэн нь зөв гэж бодож байна. Харин «тэргэтү» гэснийг галиглагчид «тэлэгэтү» гэж ташаа тэмдэглэснээс зайлахгүй.

459. эткэжү (эсгэжү) — гэсэн энэ үгийг судлагчид **«эткэжү» гэж сийрүүлдэг бөгөөд үүнийг өнөөгийн бидний хэл** ярианд эсгэж оглох гэсэн үг мөн болохыг Баяр (11, II, 440) Элдэндэй Ардажав (8, 380, **тайлбар № 7**), Дугаржав (24, 79) зэрэгт зөвөөр нь сэргээсэн буюу **тайлбарласан тул үүнийг дагаж сэргээв.** Эртний монгол хэл бичигт **«д, т»** авиагаар хэлэгдэж бичигдэж байсан зарим үг хожим сонгодог монгол бичигт **«с»** болсон нь олон тохиолдохын нэг жишээ нь энэ мөн болохоос гадна бас хуучин монгол бичигт **«эбэдкү»** (өвдөх) **«хабудху»** (хавдах) гэх мэт **«д. т»** авиа нь хэвээр үлдсэн зарим үгийг буриадын болон Монголын Дорноговь аймгийн ардын аман аялгуунд өвсөх, хавсах гэх зэргээр **«с»** бүхий аялгаар хэлдгийг энд дашрамд тэмдэглэе.

460. Туг-а (Тугаа) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (26, 183), Лигети (33, 74), Рахевильз (25, 59), Дашцэдэн (26, 70), Иринчин (28, 104), Поуха (17, 70), Калужинский (61, 75), Кливз (42, 65), Элдэндэй Ардажав (8, 380) нар цөм **«Төнггэ»** буюу **«Түнггэ»** гэж сэргээдэг боловч харин Лувсанданзан (31, 85) Мансан (27, 119) нар **«Түгэ»** гэж сэргээсэн нь илүү ойртуулсан сэргээлт байв.

Учир нь Лувсанданзан худам монгол бичгийн эхэд юутай ч **«түнггэ» гэх** мэт инхлэгтэй **«н»** энэ үгэнд бичигдээгүй учраас ийнхүү хятад үсгийн галигаас өөрөөр сэргээсэн болов уу гэж бодогдоно.

Энэ хүний нэр Төнггэ буюу Түнггэ бус, харин «Туг-а» болохыг бид урьд бичиж нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ нотлон тайлбарласан (93, 23—38) тул ийнхүү ондоогоор сэргээн босгож сийрүүлэв.

461. миталжу (шанталж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Лувсанданзан «[н]итулжу» (31, 85), Хэниш (36, 109), Пеллио (9, 38), Лигети (33, 74), Рахевильз (25, 59), Баяр (11, II, 434) Дашцэдэн (26, 70), Элдэндэй Ардажав (8, 378), Иринчин (24, 104) нар цөм **«мидэрижү»** гэж XIV зууны аялгууны алдаатай галигийг ягштал баримтлан сэргээсэн билээ.

Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгад Хэнишийн орчуулснаар **«хөлөөр өшиглөх»** гэснийг элдвээр ойлгож орчуулсан үүнд: Хэниш (15, 40), Поуха (17, 70) нар «зүрхийг сугал» гэж, Калужинский (61, 75) «зүрхий нь дэлд» гэж, Рехевильз «ходоодны хонхор (буюу аюулхай) уруу нь» (49, № 10, 1974, 62), Мансан «өрц зүрхий нь тус тус **өшиглө»** гэж, Кливз «зүрхий нь дэвс» (42, 66), Элдэндэй Ардажав **«өрий нь өшиглө»** (8, 380) гэж, Дамдинсүрэн «өрий нь эмтэлж ала» гэж тус тус орчуулсан буюу тайлбарласнаас утгын хувьд Дамдинсүрэнгийн орчуулга хамгийн оновчтой болсон гэж бодно.

Учир нь бид энэ үгийг өрийг «миталжу» шанталж (өөрөөр хэлбэл: өрцийг нь цоолж) ал гэсэн утгатай үг гэж бодно. Юм мятрашгүй зоригтой гэдэг нь хугарч шантарч (бинет юманд шамрах) (хэлбэрээ алдах) гэсэн утгатай юм. Энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт **«митараху-санаа шинтараху зэргэ-йин»** (12, 715б) гэж бичсэн байдаг. Митараху гэдэг нь эс тусах үйл үг тул **«өрий нь»** гэсэн шууд тусагдахуунтай холбогдохгүй тул Лувсанданзаны «нитулжу» гэж бичсэний адил «миталаху» гэсэн тусах үйл үг байх учиртай гэж сэргээв. Хятад үсгийн галиг ба хадмал орчуулга нь алдаатай гэж бодно.

462. илүгэй (хязгуур-хөмхий) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (31, 87), Козин (14, 237), Пеллио (9, 39) Лигети (33, 75), Рахевильз (25, 60), Баяр (11, II, 454), Дашцэдэн (26, 72), Элдэндэй Ардажав (8, 384) нар цөм **«илүгэй»** гэж сэргээснээс гадна Лувсанданзан **«илүкэй»** (бэбэгэй) (31, 87) гэж бичсэн юм. Харин энэ үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгаас нь «уруулын доорхио зуух» (36, 82) гэж тайлсан байх бөгөөд энэ учраас Хэниш (15, 41), Пеллио (9, 39), Рахевильз (25, 60), Кливз (61, 67) цөм доорд уруулаа буюу уруулын доод хэсгийг зуух» гэж, Дамдинсүрэн (7, 94), Дугаржав (24, 81), Мансан (27, 121) нар цөм орчин цагийн монгол хэлэнд хэлэцдгээр «көмүкэй-бэн» зуух гэж орчуулсан нь утгын хувьд хамгийн зөв юм. Учир нь энэ **«илүгэй»** гэдэг үг Элдэндэй Ардажав нарын тайлбарласнаар (8, 384, тайлбар № 6) бичгийн хэлний **«доод уруул»** гэсэн үг ажээ. Үүнд тэд Зост аймгийн түмэд баруун хошууны аман ярианд доорд уруулыг **«Илиг»** гэдэг хийгээд буриад хэлэнд «улхы» нь эрүү гэсэн үг байгаа зэргийг заажээ.

Бид энэ тайлбарыг зөвшөөрөн баримтлахын хамт эртний монгол хэлний энэ үг мартагдаж оронд нь **«көмүкэй»** (хүн хонхор) гэсэн үг хэрэглэгдэх болсон учрыг тайлбарлах гэсэн юм. **«Көмүкэй»** гэдэг нь анх дээд уруулын дээр бүхий орчин цагийн аман ярианд **«күмүн хонхор»** гэдэг хонхорыг нэрлэж байсан ба харин доод уруулын хонхорыг **«илүгэй»** гэж нэрлэдэг байгаад түүнийг нэрлэх нэр мартагдахын хамт **«көмүкэй зуух»** гэдэг болсон гэж бодож байгаагаа тэмдэглэе.

463. арийаху (аялах) — гэсэн энэ үгийг хятад галигаас нь Хэниш (36, 91), Пеллио (9, 39), Лигети (33, 75), Рахевильз (25, 60), Баяр (11, II, 455), Дашцэдэн (26, 72), Иринчин (28, 106) тус тус «арийаху» гэж сэргээдэг бөгөөд энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «урьдаас шийдэж, итгэлгүй» (36, 140) гэсэн үг болохыг тайлаад Хэниш (15, 41), Дамдинсүрэн (7, 94), Рахевильз (49, № 10, 1974, 63), Дугаржав (24, 81) нар «зориуд» гэж, нөгөө Пеллио (9, 165), Мансан (27, 121), Кливз (42, 68) нар эргэлзэж байсаар «шийдвэргүйдсээр» гэж орчуулсан юм. Энэ үгийг Элдэндэй Ардажав (8, 387, тайлбар № 12) бичгийн хэлэнд «арийал» хэмээх нь эргэлзээл, татгалзах, зайлуулах, «Арийал үгэй» хэмээх нь эргэлзэлгүй («Манжийн үнэн магад хууль»), тус үг «арийал гэмээн § 169-д гарна» гэж тайлбарласан нь ерөнхийдөө зөв тайлбар байв.

Гэвч бид энэ үг «айалах» гэдэг үгийн уе солигдсон хэлбэр болов уу гэж арай өөрөөр бодож байна. Ингэж бодох үндэс нь эртний монгол хэлэнд «р» ба «й» (i) гийгүүлэгч сэлгэдэг ёс байсанд оршино. Жишээ нь хангайхан гэхийг «Хангар-хан» гэх мэт й-гийн оронд «-р» гийгүүлэгч ордог удаа байсан тул «айалаху» гэдэг үг «арийаху» болж энд тэмдэглэгдсэн нь чухамдаа «айираху» «айилаху» гэдэг үгийн уе солигдол байж болох юм.

464. кэд буй? (хэн хэн байна?) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид Хэниш (36, 100), Пеллио (9, 40), Лигети (33, 77), Рахевильз (25, 62), Баяр (11, II, 468) тэргүүтэн «кэт» буюу «кэ[т]» гэж сэргээдэг бөгөөд Дашцэдэн «кэд» (26, 74), Элдэндэй Ардажав нар (8, 395, тайлбар № 9 397-д) нар «хэд» гэж хадмал хятад орчуулгад үсэг эндүүрч «хамгаалах совилах» гэсэн алдаатайг заагаад «кэд» гэдэг нь «хэн» гэдэг үгийн олон тооны хэлбэр гэдгийг зөв тайлбарласан юм.

«Хэд» гэдэг нь орчин цагийн монгол хэлний «Хэн? Хэн?» гэж олон хүний нэрийг асуухтай адил утгаар хэрэглэгддэг үг бөгөөд «кэн» гэдгийн олон тооны хэлбэр мөн болно.

465. үлэгүд (үлэмж том биет -шилдэг) —гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «hүлэ'үт» (36, 80) гэж сэргээгээд «илүү томчууд, давуулигууд, хүч илүүтэн» (36, 80) гэж хадмал хятад орчуулгын утгыг тайлсан юм.

Энэ үгийг Пеллио (9, 40), Козин (14, 238), Лигети (33, 78), Рахевильз (25, 63), Дашцэдэн (26, 76) нар «hэлэ'үт, hүлэүт, hүлэүд» гэх зэргээр, нөгөө Баяр (11, II, 475), Элдэндэй Ардажав нар (8, 402) «үлэгүд» гэж, Иринчин «өлэнггүд (?)» гэж өөрөөр галиглах санал тавьсан байна. Бидний санавал «үлэгүд» гэж сэргээх нь зөв бөгөөд харин энэ үгийн утгыг Хэнишийн тайлснаар хадмал хятад орчуулгад илүү том, давуулаг, хүч илүү гэсэн нь ерөнхийдөө зөв байсан боловч энэ үгийг «үлэг-үд (томчууд, үлэмж биетэн) гэсэн үгийг орчуулагчид үлэкү буюу үлдсэн гэсэн үгийн олон тоо гэж буруу ойлгоод Хэниш (15, 44), Пеллио (9, 96), Дамдинсүрэн (7, 96), Кливз (42, 70), Дугаржав (24, 84), Мансан (27, 123) нар цөм «үлдсэн цэрэг» гэж буруу ойлгож орчуулсан шиг санагдана. Элдэндэй Ардажав нар үлэгүү-гийн олон тоо гэж тайлаад «илүү, нэмүү» гэсэн үгийн хувилбар гэж эрхэм сайн онц гэсэн утгатай (8, тайлбар № 9, 403—404) гэсэн нь утгыг дөхүүлсэн боловч оновчтой тайлбар хараахан болоогүй мэт. Бас Иринчин энэ үгийн галиглал алдаатай гэдгийг Рашид-ад-Дин (4, I, 2, 116)-ы зохиол болон Пеллиогийн энэ үгийн галигийн алдаатайг тэмдэглэсэн өгүүллийг (94, 200—202) зааж хэлсэн нь зөв боловч «өлэнггүд» гэсэн газрын нэрийг буруу галигласан гэсэн нь төдий л үнэмшилтэй санагдахгүй байна.

Бидний бодоход энэ үг бол үлэ- (үлэмж гэдэг үгийн үндэс үйл үгэнд үйл үгээс нэр үг бүтээх «г» дагавар залгаж үлэг (үлэмж биет) гэсэн үг бүтээгээд) +үд (олон тооны дагавар залгаж том биет (шилдэг баатар) цэргүүд гэсэн үг бүтээж хэрэглэсэн шиг санагдана. Ингэж бодоход хадмал хятад орчуулгын утга «илүү том, хүчирхэг» гэсэнтэй утга дүйж байгаа нь үндэс болно. Нөгөө талаар «Үлэг гүрвэл» гэдэг бол мөн үлэмж биет гүрвэл гэсэн үг бөгөөд үүнийг зарим хэл шинжлэлтэн өлий+г = өлүг гэсэн үг гэж боддог нь арай ташаа гэж бид бодож байна. Энэ Үлэг гэдэг нь үлдэгдэл гүрвэл гэсэн ч үг биш байх гэж бодож байна. Энэ үгийг Лувсанданзан «улхуд» гэж алдаатай бичсэн нь уг эхэд «ө»-гийн шилбэ дутуу алдаатай байсных болов уу гэж санагдана. «Өлэг-үд» гэж бичигдсэн үг «Олхуд» болж хувирах үсгийн боломж байгаа юм.

466. турхастан (торгон цэрэг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 40), Козин (14, 238), Лигети (33, 78), Рахевильз (25, 63), Баяр (11, II, 475), Элдэндэй Ардажав (8, 402), Дашцэдэн (26, 76) нар цөм «турастан» гэж сийрүүлдэг боловч Иринчин «турас

та» гэж өөрөөр сэргээх санал тавьсан юм. Энэ үгийн утгыг Хэниш «бамбайгаар зэвсэглэсэн» (15, 44) гэж, Пеллио «тооцож хайрцагласан» (?) (9, 167) Кливз «тэг дөрвөлжин хамгаалалт» (42, 70) гэж, Дамдинсүрэн «шилдэг» цэрэг (7, 96), Дугаржав «бамбайтай цэрэг» (24, 84), Мансан «үлэмж бамбай зэвсгийг» (27, 123) гэх зэргээр орчуулсан байх бөгөөд Элдэндэй Ардажав нар «турасун-бамбай, халх, хуяг» гэсэн утгатай гээд Мухаддиматын толийг заасан байхын дээр бас буриад хэлний тура- байшин барилга байр гэсэн үгтэй, бас түрэг хэлний тура бамбай халх, боомт хамгаалах шороо, хашилга гэсэн утгатай үгтэй холбож тайлбарласан боловч бидний бодоход турасун гэдэг нь модны холтос долонгийн зүйл, нөгөө тура- гэдэг нь хот балгадын суурь гэдгийн «тагури, тугури, туурь» гэх мэт монгол үгтэй холбоотой тэдгээр гадаад хэлний үгтэй холбогдохгүй болов уу гэж эргэлзмээр.

Харин энэ үгийг Лувсанданзан «тураг-тур» (31, 90) гэж бичсэн нь чухамдаа тураг биш «турха тур» гэж хуучин худам монголоор бичсэн үгийг буруу ухаарсан шиг санагдах бөгөөд «турхас тан» буюу «турхагуд» (хамгаалах туурга цэрэг) гэсэн үг байжээ гэж бид тааглав. Турхаг буюу торгон цэрэг шадар цэрэг гэсэн үг эртний монгол бичигт «тогурга» гэдэг үг уруулаар зохицох ёс ба урт эгшиг тэмдэглэгдэггүй байсан үеийн худам монгол бичигт турхаг гэж бичигдэж байсан болов уу гэж бодох үндэстэй юм. Энэ турхаг +с гэсэн олон тооны нөхцөл залгахад төгсгөлийн «г» гийгүүлэгч нь хасагдаж «турхас» гэсэн үг болсныг галигчид буруу сонсож турастан гэж ташаа тэмдэглэсэн гэж бодож байна.

467. сужийасу- бан (судаагаа) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 136), Пеллио (9, 40), Лигети (33, 79), Рахевильз (25, 63), Баяр (11, II, 477), Дашцэдэн (26, 76), Элдэндэй Ардажав (8, 405), Иринчин (28, 111) цом «сужийасу» гэж сэргээдэг нь зөв бөгөөд энэ үгийн утгыг Хэниш (15, 44), Пеллио (9, 167), Поуха (17, 74), Рахевильз (49, № 10, 1974, 66), Кливз (42, 71), Дамдинсүрэн (7, 96), Дугаржав, (24, 85) зэрэг цом «Хүзүүний судас» гэж хадмал хятад орчуулгыг дагаж орчуулсан боловч харин Элдэндэй Ардажав нар (8, тайлбар № 1, 407) ерөнхий орчуулгыг дагаж хүзүүний судас бус хүзүүний судаа (булчин) гэж орчуулсан нь бидний бодоход зөв бөгөөд хадмал хятад орчуулгад «хүзүүний судас» гэсэн нь үнэхээр ташаарал байхаас зайлахгүй. Учир нь морины хүзүүний хоёр талын гувгар булчинг монголчууд судаа» гэж ярих нь тохиолддог боловч судас биш судаа буюу зургар булчин байдаг юм. Гэхдээ судаа буюу сужийасу, суваг, судаг, судас цом нарийн зурвас хонхор буюу товгор, эсвэл сүв гэсэн утга гарал нэгтэй төрөл үг болохыг бас үгүйсгэх аргагүй.

468. шилүртэжү (хатгагдаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь «силүртэжү» гэж судлагчид цом адилаар сэргээгээд үгийн утгыг «шархдажу» гэж ойлгодог нь хадмал хятад орчуулгыг дагасан хэрэг бөгөөд уг үгийг чухам ямар үг болохыг үл мэднэ.

Бид энэ үгийг шилү- (цус, ямар нэг шүүс нэвчин гарахын утгатай үйл үгийн үндэс) +р (үйл үгээс нэр үг үүсгэх дагавар) +тэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +жү (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй гэж ойлгож тайлбарлав. Шилбурхай, шилбураху, шүлүсү (шүүрч гарах зүйл), шилүгүсү (цусыг ханаж шимдэг араатан) гэх мэт үгтэй энэ үг гарал ба утгын хувьд холбогдолтой төрөл үг бөгөөд «цус дуслах шарх» гэсэн утгатай үг гэж таамаглаж байна.

469. түридгэбэсү (тогтоовол) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цом «төритгэ'эсү» «төридгэбэсү» гэх зэргээр сийрүүлж уншаад утгыг хадмал хятад орчуулгыг Хэнишийн тайлсны (36, 91) дагуу «(цус) тогтоох» гэсэн утгаар ойлгож орчуулдаг боловч энэ үг чухам ямар утгатай ямар хэлний үг болохыг хэн ч тодорхой ойлгож тайлбарлаагүй юм.

Бид энэ үгийг бүх судлагчид цом ижлээр «төритгэбэсү» гэж сэргээдгийг хятад үсгийн галигч нарын арай ташаа сэргээлтийг дагасан алдаатай сэргээлт гэж бодож зөв нь «түридгэбэсү» гэж сэргээж бичив. Учир нь энэ үг монгол хэлний толь бичигт чухамхүү «түридгэкү» гэсэн дуудлагаар бүртгэгдсэн (12, 631б) бөгөөд харин утгыг С. Шагжгуай «түридгэкү-түридкүй-дур күрүгүлкү» гээд «түридкү-эбдэрэн өнгэрэкү» гэж тайлсныг нь төдий л оновчтой болоогүй гэж бодно. Учир нь энэ үг ийм утгатай байсан сан бол «цус тогтоох» гэсэн утгаар Нууц товчоонд хэрэглэгдэх ёсгүй юм. Чойжи-Одсэрийн XIV зууны үеийн монгол орчуулгын номд:

«Хамуг бурхан бодисаду-а нар
Түритгэл үгэй насу үжэгчи буюу» (40, 43) гэсэн үг

гарч буй нь үнэхээр «эвдрэн өнгөрөхгүй» нас насалдаг гэсэн үг байж болмоор боловч бидний бодсоноор «сааталгүй зогсолтгүй их нас насална гэсэн утгатай гэдэг нь илүү тохирох мэт санагдана. Энэ бүхний үндэс дээр бид энэ үгийг түр- (түр зуур гэсэн утгатай) (дайвар үгийн 1 үндэс) +[и]т (түр болох гэсэн утгатай үйл үг бүтээх дагавар) +гэ (түр болгох гэсэн утга оруулах, үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +бэсү (үйл үгийн нөхцөл үйл үгийн болзох хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд цус гарах үйлийг «түр зуур болгох (өөрөөр хэлбэл үргэлжлэн гарахгүй болгох) гэсэн утгаар энд хэрэглэгджээ) гэж төсөөлж байна.

470. амтуригдарун (өвчин орж эвэршээх) — гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 8) «андуригдарун» Пеллио (9, 40), Лигети (33, 79), Рахевильз (25, 63). Дашцэдэн (26. 76). Иринчин (28, 111) нар «амдуригдарун» гэж, Баяр (11, II, 477), Элдэндэй Ардажав (8, 405) нар «амтуригдарун» гэж, Лувсанданзан «атуригдарун ~ энтүригдүр-үн» (31, I, 91) гэж, Козин ганцаар «йандуригдарун» (14, 239) гэж тус тус сэргээсэн байдаг. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «[сэтгэл] догдлох дэнслэх, үймрэх» гэж тайлаад Хэниш «өвчнөөс энэлэх» (15, 44), Дамдинсүрэн (7, 96), Дугаржав (24, 85) нар «ядран зовж» «маш зовж» гэж, Поуха «өвдөн зовж» (17, 74) гэж, Элдэндэй Ардажав нар «тэвдэх, яарах мэгдэх, бачимдах, сандрах» (8, 108) гэж үүндээ Алтангэрэл судрын орчуулгын ижил үгийг иш татсан байна.

Энэ тайлбарын ерөнхий утгыг бид зөвшөөрөх боловч уул үг чухам ямар үгнээс яаж үүссэн ямар үг болохыг бас тодорхой болгосонгүй гэж санана. Энэ үгийг Козин «йантуригдарун» гэж сэргээсэн нь янтах «шарх өвчин орох» гэсэн үг гэж ойлгож болохоор боловч үгийн бүтцийн талаас сайн тохирохгүй тал байна. Учир нь «йан» (шархны гөн хор гэсэн нэр үгийн үндэс) +та (нэр үгээс эс тусах үйл үг бүтээх дагавар) +р (бас эс тусах үг бүтээх дагавар) +гд (тусах үйл үгээс эс тусах үндэс бүтээх хэвийн нөхцөл) +рун (захирах хүсэх төлөвийн нөхцөл) гэх мэтээр тайлбарлагдах боловч эс тусах «янтах» гэдэг үгнээс янтар гэж дахин эс тусах үйл үгийн үндэс үүсч болохгүйн дээр -гд эс тусах үйл болох хэвийн нөхцөл дагуулах ямар ч үндэсгүй болно.

Иймд бид энэ үгийг «ами+түрэгдэрүн» гэсэн нийлмэл үгийн үе авиа солигдсон хэлбэр болов уу гэж таамаглаж байна. Энэ II үг нь угтаа «тэгүрэгдэрүн» гэсэн үгийн гуйвсан хэлбэр болов уу гэж таамаглана. Учир нь монгол ярианы хэлэнд арай чарай амьд байх гэсэн утгатай «амь түүс» («тэгүс») гэсэн үг байдгийн дээр «аливаа юманд дийлдэн ядрах зовох гэсэн утгатай «түүртэх» («тэгүртэкү») гэдэг үг ч байна. Ажилдаа түүртэх гэвэл ажлаа хийж чадахгүй залхах цөхөх гэсэн утгатай. Энэ үгийн дуудлага XIV зууны үед бүрэн урт эгшиг-тэй болж чадаагүй учраас «тэүрэгдэрүн ~ түрэгдэрүн» гэж тэмдэглэгдсэн ба нийлж үгийн эм эгшгүүд нь 1 «ами» гэсэн үгийн эр эгшигтэй ижилсэн «и» эгшиг нь хойш ухарч «амтуригдарун» гэж хувирсан болов уу гэж бид таамаглаж байна.

471. намурган (намаг болох) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид намурхан буюу намурган гэж сэргээдэг бөгөөд хадмал хятад орчуулгын утгыг Хэниш (36, 113) «шалбааг» гэж тайлсны дагуу Хэниш (15, 44), Поуха (17, 74) Калужинский (61, 79), Рахевильз (49, № 10, 1974, 67), Кливз (42, 71) нар «шалбааг» «цөөрөм шавар» гэж, Дамдинсүрэн (7, 97), Пеллио (9, 168), Дугаржав (24, 86), Мансан (26, 77), Дашцэдэн (26, 77), Элдэндэй Ардажав нар (8, тайлбар № 18, 410) нар «намаг» гэж оновчтой зөв ойлгож орчуулсан байна.

Гэвч Элдэндэй Ардажав нарын тайлбарт дурдсанаар буриад хэлэнд үлдсэн «намарга» гэсэн үг намаг гэсэн утгатай байгаагаас энэ үг «намарган» гэдэг бүтэцтэй болсны учрыг хэн ч сонирхон тайлбарлаагүй билээ. Бидний санавал энэ үг намуг (усархаг хөрс гэсэн утгатай нэр үг) +р (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +ган (үйл үгээс нэр үг бүтээх бүтээмж багатай дагавар) гэсэн бүтэцтэй үг бөгөөд намуг+р гэж үйл үг бүтээхэд үгийн үндэсэнд байсан зарим гийгүүлэгч (энд «-г») орхигдож «наму -г+р+ган» гэсэн бүтэцтэй үг болсон гэж бодно. Энэ нь «яв+ган = явган» гэдэг үг бүтсэний загвараар бүтсэн гэж бодно.

472. эмүдүн (өмд) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «эмүдүн» гэж сэргээн «өмд» гэж зөв орчуулсан байдаг. Харин бид хуучин (сонгодог) монгол бичигт «өмүдү» (12, 162) гэх бичлэг нь монгол хэлэнд үгийн эгшиг уруулаар зохицох ёс гарснаас хойш тогтсон бичлэг гэж үзэж «эмүдүн» гэж сэргээж нь зөв гэж

батлан өгүүлэхийн хамт «эмүдү» гэж худам (эртний) монгол бичгийн эртний бичлэг мөн бөгөөд «эмү-өм татах гэсэн утгатай монгол хэлний дайвар үг болно. «Эмүдү» гэгч өм татсан «олон нүхэт» гэсэн үгнээс үүссэн байх гэж үзэж байна.

473. өрэссүгэй (амь өрссүгэй)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид бараг цөмөөр «эрүссүгэй» гэж сэргээдэг бөгөөд хадмал хятад орчуулгын утгыг дагаж Хэниш «хааны шаналсан сэтгэл нийцүүлэх» (15, 45), Пеллио (9, 169), Рахевильз (49, № 10, 1974, 68), Кливз (42, 72), Дугаржав (24, 86), Мансан (27, 125) нар «хааны умдаассан сэтгэл цангасан зовлонг тайлсугай хангасугай» гэсэн үг гэж ойлгож орчуулсан байна. Дамдинсүрэн «хааны зовсон биеийг амруулъя» (7, 97), Элдэндэй Ардажав нар энэ үгийг «эрэсдэх-гэдэг нь үрэгдэх чирэгдэх нэрвэгдэх» (8, 411) гэж галиглагдсан үгийн уг утгыг дагаж тайлбарласан нь зөв юм.

Гэвч бид энэ үгийг өөр үгтэй эндүүрч буруу галигласнаас ийм утга авцалдахгүй үг хэллэг болжээ гэж тааварлан «өрөссүгэй» гэсэн үг гэж сэргээн сийрүүлэв. Учир нь: нэгд, энэ үгийг Нууц товчооны худам монгол бичгийн эхтэй байсан гэгддэг Лувсанданзан «өрүсүгэй» гэж бидний бодлоор нэг «с» үсгийг хаяж алдаатай бичээд утгыг «амугулсүгай» (31, 93) гэж тайлсан явдал бидэнд ингэж өөрөөр ойлгох үндэс өгч байна. Уг эхэд худам монгол бичгээр «өрэ» (зүрх сэтгэл) гэсэн үгийг түүхч сонгодог монгол бичгийн «өрү-» гэсэн бичлэгт оруулж бичсэн бололтой. Хоёрт, хааны ангасан сэтгэлийг эрүсэх буюу зовоох, олзлох гэсэн үг байж таарахгүй харин тэр сэтгэлийн шаналгааг өрөвдөх гэсэн нь утгын талаар илүү тохиромжтой юм. Иймд бид энэ үгийг өрэ- (өр зүрх, сэтгэл гэсэн утгатай нэр үгийн идэвхтэй язгуур I үндэс)+с (нэр үгээс өрөвдөх хайрлах гэсэн утгатай тусах үйл үг бүтээх дагавар) + сүгэй (үйл үгийн захирах хүсэх төлөвийн I биеийн шийдэн хүсэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна.

474. нидун харан эйин (нүр ирмэх зуур ийн)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид гол төлөв «индүк кара эйин» гэж сийрүүлдэг бөгөөд энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаар нь Хэниш «нүдний од» буюу цэцгий (36, 61) гэж тайлсан бөгөөд герман хэлэнд орчуулахдаа «нүдний цэцгий шиг» (15, 45) гэж, Пеллио «хар нүд шигээ» бодож» (9, 169), Поуха «нүдний цэцгий мэт сэтгэж (17, 75) гэж, харин Лувсанданзан (31, 93), Дамдинсүрэн (7, 98), Дугаржав (24, 86), Элдэндэй Ардажав (8, 411) нар цөм «нүд харсаар байтал) гэж, Калужинский (61, 79), Рахевильз (49, № 10, 1974, 68), Кливз (42, 72), Мансан (27, 125) нар «нүд цавчилгүй, нүд ирмэх зуур» гэх зэргээр орчуулсан мэт байх буюу тайлбарласан нь цөм зөв мэт бодогдоно.

Гэхдээ бид энэ үгийг Лувсанданзан анх удаа «[н] идүн кара үжэлтэ (зөв нь: үжэтэл-э) ... одулуг-а» гэж, хоёрдох удаад нь «[н] идүн харан оружу» (31, I, 93) гэж тус тус бичсэн баримтаас үзвэл уг худам монгол эхэд «нидүн каран [эйин сэткижү] одулуг-а», «нидүн харан оружу» гэсэн үгс байсныг галиглагчид алдаж буруу ташаа сэргээж, улмаар «нүдүн хара» гэж буруу буулгаснаас хадмал орчуулгад «нүдний цэцгий» гэж буруу орчуулсан гэж бодно. Ингэж бодох үндэс нь орчин цагийн монгол хэлэнд хар нүдний цэцгий мэт хайрлах гэж ярьдаг байтал «нүд хар» гэж хятад, төвд, франц хэлэнд байдаг шиг эл тодотгол үг нь хар нь тодотгуулагч үгийн ард ордог ёс үгүй тул «нидүн хара» биш, «нидүн харан» гэсэн үйл үг байгууштайд оршино.

475. сэнгтэлбэ (сэргээв)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид нийтээр «сэнгтэлба ~ сэнгтэлбэ» гэж зөв сэргээн босгосон боловч харин утгыг нь хадмал хятад орчуулгаас нь Хэнишийн «амин сүнс (амьсгаа?)-ий минь уужим болгон сэргээв» (36, 133) гэж тайлсны дагуу орчуулсаар тайлбарласаар ирсэн билээ. Үүнд Хэниш «миний амийг дахин шинээр сэргээв» (15, 45), Поуха (17, 75), Калужинский (61, 79), Рахевильз (49, № 10, 1974, 68) нар Хэнишийн адилаар «дахин сэргээв» гэж, Пеллио «аврав» (9, 169) гэж, Дамдинсүрэн «аминд минь оров» (7, 98) гэж, Кливз «дахин нээв» гэж, Дугаржав (24, 86), Мансан (27, 125), Элдэндэй Ардажав нар (8, тайлбар № 29, 411) тус тус «сэнхрүүлэв» гэсэн утгаар орчуулсан буюу тайлбарласан юм.

Бид энэ эртний монгол үгийг сэнс, сэхээх, сэвэх, сэндийлэх гэх мэт үгтэй ойролцоо утгатай хуучирч мартагдсан монгол тусах үйл үг гэж үзэж байна. Харин энэ үгтэй нийлсэн «амин» (амь) гэдэг үг нь бидний боддог шиг зүгээр амьдрал амь гэсэн утгаар бус «агаар амьсгал» гэсэн утгаар анх хэрэглэгдэж байсан учир «амин минү сэнгтэлбэ» гэдэг үг нь «амьсгал оруулах» гэсэн үг бололтой. Иймээс сэнг- (хий орох, салхи орох гэсэн утгатай сэнгинэ гэсэн үйл үгийн язгуур нэр үндэс) +тэ (үгийн язгуураас дайвар үг үүсгэх дагавар) +л (нэр ба дайвар үгээс үйл үг бүтээх дагавар) + бэ (үйл үгийн өнгө-

рөн төгссөн цагийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Энэ сэнг- гэсэн үгийн үндэснээс «сэнгэ», «сэнггинэкү» гэх мэт үг үүссэн гэж бодож байна.

476. жарбийал (залбирал)- гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид цөм «жарбийал» гэж сэргээдэг юм. Харин Лувсанданзан «жэргэ-йин мод» (31, I, 95) өөрөөр үзтэл буруу сэргээжээ. Гэвч энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «ичүүрийн зах (дөнгө)» (36, 86) болон «ичүүрийн зах мод» (15, 46) гэж, Козин (14, 119), Кливз (42, 73) нар «жарбийал буюу бугай мод» уг үгийг орчуулалгүй үлдээж, Пеллио (9, 170), Дугаржав (24, 88), Рахевильз (49, № 10, 1974, 69) нар «дөнгөний мод буюу дөнгө мод» гэж, Мостарт (47, 348 [64]), Калужинский (61, 80) нар «дөнгийг бүтээсэн мод» гэж, Мансан (27, 126), Элдэндэй Ардажав (6, 416) нар «дөнгө буюу ялтны хүзүүнд хийдэг хавтсан буюу хавтгай мод хавчуур» гэж, ганц Дамдинсүрэн «загадасу дөнггэ-йи» гэж тус тус ойлгож орчуулснаас бидний санахад Мостарт, Калужинский, ялангуяа Дамдинсүрэнгийн орчуулга утгыг бүрэн гаргахад илүү ойртсон орчуулга болов уу гэж санаж байна. Учир нь бусад орчуулагч нар хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «жигшүүрийн зах, модон зах» (36, 95) гэж, Мансан «заамд хийсэн хавтсан мод» гэж тайлсны дагуу утгыг тааж орчуулснаас биш «жарбийал» гэдэг чухам ямар үг байсныг огт тайлсангүй.

Энэ үгийг бид уг модон дөнгийг хийсэн арга хийцийг заасан утгатай «жалбарил» мод гэсэн үгийн үе авиа сэлгэсэн өөр хэлбэр байж магадгүй гэж таамаглав. Учир нь «жалбариху- өршөөл гуйхын хүндэтгэл» (12, 497) гэж шинэ үеийн толь бичигт өөр утгаараа бүртгэгдсэн энэ үг утгаа тийнхүү бишрэн хүндэтгэхийг илэрхийлж хоёр гарын алгыг нийлүүлж хавсаргахын нэр байгаад хожим өршөөл гуйхын хүндэтгэл нэр болжээ. Хоёр банз буюу модны захад хоёр тал дугуйн хэлбэртэй хонхор гаргаж чавчаад хоёр тал дугуйн нийлж үүсгэсэн нүхэнд ялтны хүзүү, бугуй, шилбийг углаад хоёр банзны үзүүрийг залбируулан (хавсаргаж) зүүтаах оргох аргагүй болгодог дөнгө хавтсан гав хийдэг байсан учир тийм дөнгийг «жалбарил моду» гэж хийсэн аргаар нь дүрсэлж бичсэн бололтой. Энэ «жалбарил» гэдэг үгийн «л-р» авиа, мөн энэ солигдлын улмаас ойр дараалсан хоёр «р» авианы нэг нь «йэ»-гээр сэлгэж жарбийал болсон байж болох юм. Эл учраас Дамдинсүрэн гуайн «жагадасу» гэсэн орчуулга энэ дөнгийг хийх аргыг утга гарал ойролцоо «жагадасу» гэсэн үгээр орчуулснаараа бидний бодоход илүү оновчтой болсон гэж бодох үндэстэй. Учир нь «жалбарил, жалгаху, жагаг (зааг), жагадасу (гавлын ясны залгагдсан газар)» гэх мэт үгс цөм залгах нийлэх гэсэн утгатай бөгөөд хооронд «жа-» гэсэн нэг язгуурын төрөл үгс байгаа явдал болно.

477. тэдэ нирүгун дэгэр[—э]—эчэ (тэнд нуруун дээрээс) гэсэн энэ үгийг судлагчид цөм «тэдэ» гэж сэргээдэг байна. Харин энэ үгийн ямар утгатай ямар үг байгааг Хэниш герман хэлэнд «тэнд нуруун дээрээс» (15, 46) гэж орчуулсан бололтой байгаагаас үзвэл хадмал хятад орчуулгын утгыг зөв гаргасан бололтой. Гэтэл Козин (14, 147), Дамдинсүрэн (7, 99), Пеллио (9, 170), Мостарт (47, 351 [67]), Рахевильз (49, № 10, 1974, 70) нар энэ «тэдэ» гэсэн үгийг цөм орхиж орчуулсан шиг байна. Харин Кливз (42, 74), Дугаржав (24, 88) нар тэд гэдгийг тэр гэдэг үгийн олон тоо гэж буруу ойлгоод «тэр» нуруу гэж жирийн заах төлөөний үгээр орчуулж, Элдэндэй Ардажав (8, 417), Иринчин (28, 116) нар тайлбаргүйгээр «тэдэ» гэж хэвээр сэргээжээ.

Бидний бодлоор бол тэ—д—э гэсэн энэ үг бол тэр гэдэг заах төлөөний үгийн олон тооны хэлбэр биш, харин тэрэ гэх заах төлөөний үгэнд «э» гэсэн өгөх оршихын тийн ялгал залгахад тэр гэдэг үгийн «р» нь орхигдож тэ+э залгах болоход хоёр эгшгийн хооронд —д— гийгүүлэгч жийрэглэн «тэ—д—э» гэсэн «тэр газар—а» гэсэн утгатай дайвар үг үүсч «тэндэ» гэсэн үгийн эртний хэллэг бичлэгийн хэлбэрийг бүтээсэн гэж сананам.

478. көгэжү (хөөж ялзрах)—гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 76), Козин (14, 240), Пеллио (9, 42), Лигети (33, 82), Рахевильз (25, 66), Дашцэдэн (26, 80) нар «hө' эжү» ~ «hөэжү» гэж, Лувсанданзан (31, I, 95), Иринчин нар (28, 116) нар «үкүжү», Баяр (11, II, 502), Элдэндэй Ардажав (8, 417, тайлбар № 5), «үгэжү» гэж тус тус сэргээн сийрүүлжээ. Харин энэ үгийн утгыг Хэнишийн тайлснаар хадмал хятад орчуулгад «хог, новш, үлээ» (36, 76) гэж бичжээ. Иймээс Хэниш (15, 46), Поуха (17, 77) нар «бохир бүртаг болох», Пеллио (9, 170), Дамдинсүрэн (7, 99), Рахевильз (49, № 10, 1974, 70), Дугаржав (24, 89), Мансан (27, 127), Элдэндэй Ардажав (8, 417, тайлбар № 5) нар цөм «ялзрах өмхийрөх» гэж ойлгож орчуулж тайлбарлаж байжээ.

Гэвч көгэжү гэсэн үг чухам ямар үг болохыг судлагчид үгийн

утга бүтцийн талаар сайтар оноон таньж чадаагүй байсан шиг бодогдох бөгөөд бидний бодлоор бол энэ нь көгэ- (хөөх—хүүр халуунд ялзран тэсгийж том болох гэсэн утгатай үйл үгийн идэвхтэй язгуур) + жү (үйл үгийн нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн энгийн бүтэцтэй, одоогийн монгол хэлний хэн бүхний мэдэх үг гэж бодож байна. Гэтэл энэ үгийн үндэс көгэ- гэж задгай үеэр төгссөн учир уртаар дуудагддаг байсаар сүүлдээ урт эгшиг болж хувирсан учир хуучин (сонгодог) монгол бичгийн хэлэнд «көгэгэкү-үлдэкү (хөөх) көгэнгирэкү мэтийн» (12, 418а) гэж бичигдэх болжээ. Нөгөө талаар XIV зууны Нууц товчоог галиглагч нарын аман ярианы аялгуугаар «hэ'экү» гэж бичигдсэн учир «хүүр халуунд өмхийрэн тэсгийж «хөөх» гэсэн үг гэж танигидахын аргагүй үг болсон шиг санагдана.

479. мөндэ—манда (мунда манд[а])-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 112), Пеллио (9, 43), Лигети (33, 83), Рахевильз (25, 66), Дашцэдэн (26, 81) нар эл хоёр үгийг цом «мунда» гэж харин Лувсанданзан (31, I, 96), Баяр (11, II, 505), Элдэндэй Ардажав (8, 417), Иринчин нар цом «мөн дэ» гэж өөрөөр сэргээн сийрүүлсэн байдаг. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «харин, гэвч шал өөр» (36, 112), гэж тайлсан ажээ. Судлагчид энэ тайлбарыг дагаж Хэниш (15, 47), Дамдинсүрэн (7, 100), Пеллио (9, 170), Поуха (17, 77), Калужинский (61, 80), Рахевильз (49, № 10, 1974, 70), Кливз (42, 75), Дугаржав (24, 89), Мансан (27, 128), Элдэндэй Ардажав нар (8, 420 тайлбар № 13) цом «харин, гэтэл» гэсэн үгээр нэгдүгээр үгийг орчуулж нөгөөг давхардсан гэж орхин орчуулсан буюу тайлбарласан байна.

Гэвч энэ үг чухам ямар утгатай ямар үг болохыг судлагчид тодорхой мэдэхгүй тул хятад хадмал орчуулгад байгааг ерөнхийдөө дагаж харин Лувсанданзан, Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин нар «мөн дэ» гэсэн монгол үг гэж таасан нь чухамдаа сайтар оновчтой болсон шиг санагдана. Учир нь 1305 онд Чойжи-Одсэрийн хийсэн Бодичарияа Авдарагийн орчуулгад хэдийгээр:

«Нисванис луг-а нөкүчэн йабубасу элэ л
Мунда дадуру коор (хор) жобаланг болгамуй» (40, 33)
гэх буюу эсвэл:
«халагун күйитэн кэй хур-а кигэд
Эбэдкүй үкүкүй аскихуй тэригүтэн- дур
Нада үлү жаргалгагдаху буюу
Жаралгабасу (эмгинэкүй) жобаланг-уд, мунда нэмэйү».

(40, 60) гэсэн мөр бадаг дайралдаж буйн дотор гарч буй «мунда» гэдэг үг утгаар нь бодвол «мөн дэ» «харин ч», «улам ч» гэсэн утгаар оржээ. Иймд мөн-д-э гэдэг үг «мөн-дэ» гэсэн, бишийн эсрэг утгат үг «дэ» батлах сул үгтэй байгаа нь хараахан биш бол «мөн-дэ» (угтаа) гэсэн үйлдэхийн тийн ялгалын «-э» бүхий бөгөөд мартагдсан үүсмэл дайвар үг байжээ гэж бодож байна.

Харин бид энэ өгүүлбэрийн дотор хоёрдугаар удаа гарч буй «мунда» гэсэн үгийг энэ үг бус харин «манда» гэсэн өөр үгийг буруу галигласнаас утгын хувьд авцалдахгүй газар «мунда» гэдэг үг бичигдсэн гэж таамаглаж байна. Ингэж бодох үндэс нь нэгд «мунда» гэдэг үгийг нэг өгүүлбэрт хоёр удаа ийм ойрхон дараалан хэрэглэхгүй гэсэнд бий. Хоёрт энэ «жагаху» гэсэн үг Нууц товчооны бусад зүйлсэд өмнөө ямагт өгөх оршихын тийн ялгалт үг захирч холбоо үг үүсгэсэн баримт цөөнгүй байгаад оршино. Жишээ нь «Чинггис хаган-а жагабасу» (§136), «экэ—д—э жагажуху» (§244), «Бидан—а үлү жаган» (§278). «Мухали-да тэнггэри-йин жагарин жагагсан» (§206), «Бидэн-э жагатугай (§278) гэх мэт.

Иймд энд бас «Ман—да (Бидэнд) жаган буюу» гэсэн үг байж магадгүй юм. Түүнээс гадна «тан» «мөн» «мун» зэрэг үг нутгийн аялгуунд сольж хэлэгдэх жишээ олон байдгийн нэгийг дурдвал Ардын засгийн үед Монголд ирж ажиллаж байсан халимаг хүмүүсийн нэг дуунд:

«Давхар давхар ууландаа
Дангийн будан татна даа
Далай их торгууд нутаг минь
Дандаа л мандаа санагдана» гэсэн үгтэй дуу Монгол ард улсад:

«Дандаа л мөндөө (байсан янзаараа) л санагдана» гэсэн өөр хувилбараар дэлгэрч байсан баримт бий.

Энэ бүхнээс бодоод бид энэ хоёрдугаар «мунда» гэж галиглагдсан үгийг «Ман—да» гэж сэргээсэн болно.

480. йа кикү [буй] жэ (яахив жэ)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 170), Пеллио (9, 44), Лигети (33, 85), Рахевильз (25, 67) нар цом «йэки'үжэй» гэж сэргээдэг нь галиглагч нарын алдаар давтсан ташаа сэргээлт юм. Учир нь нийлмэл хоёр үгийн эгшиг хэлээр зохицохдоо эхний үгийн эгшигт голцуу захирагддаг тул «йэки'

үжэй» бус «йакихужай» болох ёстой байв. Энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаар нь Хэниш «юу хийх гээ вэ?» гэж зөв тайлсан атал орчуулахдаа арай өөрөөр хэлжээ. Энэ үгийн утгыг зарим нь «юу хийх гээ вэ?» [Дамдинсүрэн (7, 120), Кливз (42, 47), Дугаржав (24, 91), Мансан (27, 139)] гэж зарим нь «юунд хэрэгтэй вэ?» [Пеллио (9, 171), Калужинский (61, 85)] гэж, Поуха «авч одох хүч чадлыг хаанаас олох вэ?» [?] (17, 82) гэж, зарим нь «яах нь вэ?» [Хэниш (36, 170) мөн (15, 48), Баяр (11, II, 515), Дашцэдэн (26, 82), Элдэндэй Ардажав (8, 422), Иринчин (24, 118)] гэж утга ойролцоо бөгөөд ерөнхийдөө зөв орчуулсан байна.

Бидний бодлоор бол энэ үг эртний худам монгол бичигт «йа кикү буй жэ» гэсэн үг байсныг галиглагчид «йэки'үжэй» гэж ташаа тэмдэглэсэн бололтой. Учир нь «йэкигүжэй ~ йакигужай» гэсэн үг гэж ойлговол энэ нь үйл үгийн захирах хүсэх төлөвийн сануулан захирах хэлбэрийн үйл үг болох тул асуух үгэнд ийм хувилал утгын хувьд таарамгүй юм. Иймд худам монгол бичигт йа кикү гэсэн хоёр үг нийлж үйл үгийн утга асуух «яах» гэдэг үг болж үүсээгүй байсан үеийн бичлэгээр «йа кикү буй жэ» гэж үг эхэд бичээстэй байсан гэж таамаглаж байна. Иймхүү хоёр үг нийлж нэг үг болоогүй байсны баримт нь энэ үгийн галигт «нанки'үжэй» гэж эр эм эгшиг нэг үгэнд хутгалдан орсон баримт гэрчилж байна. Үгийн дунд орсон «б» Нууц товчооны хятад үсгийн галигт «у, ү» эгшиг авиагаар тэмдэглэсэн баримтаас үзвэл -үзэй нөхцөл биш, харин «буй жэ» гэсэн хоёр үг байсан бололтой.

481. Алтан Асиг (хүний нэр) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 172), (15, 51), Пеллио (9, 46), Поуха (17, 85), Лигети (33, 89), Калужинский (61, 88), Рахевильз (25, 71), Кливз (42, 81), Дашцэдэн (26, 87), Элдэндэй Ардажав (8, 439), Иринчин (28, 124) нар цөм түрэг хэл аялгууны янзаар «Алтун Ашуг» гэж, Дамдинсүрэн (7, 124), Баяр (11, II, 541), Дугаржав (24, 95), Мансан (27, 143) гэж сэргээн босгоод хүний нэр гэж үндсэндээ зөв ухаарч орчуулжээ.

Гэвч бид энэ үгийг түрэг хэлний нөлөөт аялгаар галиглагдсан боловч монгол үг гэж бодож «Алтан Асиг» гэсэн үг гэж сэргээв. Учир нь Ашуг-гэдэг үг Элдэндэй Ардажав нарын тайлбарласан (8, 442, тайлбар № 13)-шиг Алтан тагалцаг, шагай гэсэн утгатай үг юм бол «Ашуг» гэж өөр хэлний үгээр бичихгүй «Алтан Шаг-а ~ Алтан Тагалцаг» гэж бичигдэх байсан болов уу гэж эргэлзмээр санагдана. Жич эртний монгол бичигт «ш» авиаг байгаагүй, харин ганц «и» эгшгийн өмнө байранд тохиолдож орсон «с» үсэг хожим «ш» дуудлагатай болсон тул энэ үг «Ашуг» биш «Асиг» буюу «Ашиг» гэж бичигдсэн байснаас галигч нарын аман аялгуунд Ашуг гэж «ш» авиагаар тэмдэглэгдсэн байх гэж бодох үндэстэй тул бид ингэж галигласнаа тэмдэглэе.

482. барийас (бариас)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 11), Пеллио (9, 46), Лигети (33, 89), Рахевильз (25, 71) Баяр (11, II, 542), Дашцэдэн (26, 87) тэргүүтэн цөм «барийас» гэж, Элдэндэй Ардажав «баригас» (8, 439) гэж, Лувсанданзан «бэр-ийэн сэлт (ийэр)» гэж ташаараи бичсэн юм. Бидний бодоход «барийас» гэдэг нь илүү зөв гэж бодно. Харин энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь «күлээс, гав дөнгө» (36, 13) гэж тайлаад Хэниш «хүлэж (гавлаж) гэрт оруулах» (15, 52), Пеллио «эрүүдэх багаж хэрэгсэл бүрдүүлэх» (?) (9, 174) гэж, Кливз «тэднийг гэртээ хүлээстэй оруулж» (42, 81) гэж, Дамдинсүрэн (7, 124), Дугаржав (24, 96), Мансан (27, 143), Элдэндэй Ардажав (8, тайлбар № 15, 442) нар цөм «баривчлан авсан хүн, баригдагсад барьцааны хүнийг» гэж зөв ойлгожээ.

Бидний бодвол энэ «барийас» гэдэг үг Баяр гуайн бодсон шиг «барийасу» (барианы юм) гэсэн үг биш, бас Лувсанданзаны бодсон шиг «бэр-ийэн» (зодох мод) гэсэн үг биш, бас Пеллио авгайн ойлгосон шиг «эрүүдэх хэрэгсэл» гэсэн ч үг биш, бас хятад хадмал орчуулгад дурдсаны адил «гав дөнгө хүлээс» гэсэн үг ч биш, харин Дамдинсүрэн, Дугаржав, Мансан нарын ойлгосон шиг «баригдсан» хүмүүс гэсэн утгатай бололтой.

Учир нь энэ бол «барийа (хүн)» (§82) гэдэг үйлийн тэмдэг нэрийн олон тооны хэлбэр «барийа + с» гэсэн үг бөгөөд «баригдсан хүмүүс» гэдгийг орлосон төлөөлмөл үг мөн. Ийм учраас «барийас» гэсний «баригас» гэж Элдэндэй Ардажав (8, 442, т. № 15) «барихас» гэж Иринчиний (28, 124) сэргээсэн нь арай ташаа мэт бодогдоно. Учир нь и-гээр төгссөн үгэнд + йа дагавар залгах нь илүү шинж төгс юм.

Жич «барийас сэлтэ» гэсний учир нь бидний бодоход өмнөх өгүүлбэрт «Эл хутур, Хулбари, Арин тайси-тан» дүү нараа, ноёдоо барьжээ» гэсэн үг байгаа тул «тэднийг» гэдэг нь дүү нарт нь, «барийас сэлт» гэдэг тэдний хуйвалдаанд оролцож баригдагсад» гэсэн утгатай

болов уу гэж бид ойлгож байна. Иймд «сэлтэ» гэсэн үгийг Мансаны «салта буюу салж бүхүй тусдаа байсан гэрт» «27, т. №14, 160) гэж тайлбарласан нь төдий л оновчтой биш шиг санагдана.

483. тэригүн-ү (түрүүний)- гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш (36, 155), Пеллио (9, 47), Баяр (11, II, 547), Элдэндэй Ардажав (8, 443), Иринчин (28, 125), Дашцэдэн (26, 88) нар «түрүн-ү» гэж, Лигети (33, 90), Рахевильз (25, 71) «түрүн-ү» гэж, Дугаржав (24, 97) «түрүгүн-ү» гэж [хуучин (сонгодог) монгол бичгийн маягаар], Лувсанданзан [худам монгол бичгийн маягаар] «тэригүн-ү» (31, I, 115) гэж тус тус сэргээснээс хамгийн зөв нь бидний бодоход Лувсанданзаных бөгөөд худам монгол бичгийн эхэд байсан хэлбэрээс нь хуулсан болов уу гэж бодож байна.

Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «эхэлж довтолсон газар» (36, 155) гэж тайлаад, энэ үгийг Хэниш (15, 52), Дамдинсүрэн (7, 124), Пеллио (9, 175), Баяр (11, II, 547), Кливз (42, 81), Мансан (27, 88), Дугаржав (24, 97) нар «анх» «түрүүн 1 дүгээрт» гэж зөв орчуулсан юм.

Гэвч бид хуучин монгол бичигт «тэригүн-ү» гэж бичигддэг үг бол анх **худам монгол бичигт «тэригүн-ү» гэж бичигддэг** үг байгаад хожим үеийн (XIV з.) монгол хэлэнд үгийн эгшгийн уруулаар зохицох ёс гарсан үед «түрүгүнд» гэж бичигдэх болсон бөгөөд цаг хугацааны тэригүнд (толгойд) буюу анх түрүүнд гэсэн өөр утгатай өөр үг болсныг харуулж байгааг тэмдэглэе. Иймд эртний худам монгол бичгээр «тэригүн-ү» гэж Лувсанданзаны эхэд (31, 96) байсны адилаар сэргээх нь зөв гэж бодож байна.

484. йагу кэ (юу хэ) гэсэн энэ үгийг ч хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 169), Пеллио (9, 47), Баяр (11, II, 549), Элдэндэй Ардажав (8, 443) нар «йа'укэ»～«йагукэ» гэж, Лигети (33, 90), Рахевильз (25, 71), Дашцэдэн (26, 88), Иринчин (24, 125) нар «йа' у кэ» гэх буюу эсвэл «йагу кэ»～«йаху кэ» гэж тус тус сэргээдгээс сүүлчийнх нь эртний монгол бичгийн бичлэгт илүү ойр болсон тул бид ийнхүү сэргээсэн болно. Энэ үгийг Лувсанданзан «йахуба» гэсэн нь «йагу кэ ба» гэсэн гурван үгийн утга ба бүтцийг ойлголгүй андуурсны баримт болно.

Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш (15, 52) Пеллио (9, 47), Калужинский (61, 88), Кливз (42, 82) адуу ба олж авсан бүхнийг, бүх юм, олсон бүх юмыг нь гэсэн ерөнхийдөө зөв ойлгосон орчуулга хийсэн юм. Дугаржав (24, 97), Мансан (27, 144), Элдэндэй Ардажав (8, 443, тайлбар №11), Иринчин (28, 125, тайлбар №3) нар орчин цагийн монгол хэлэнд дэлгэр хэрэглэгддэг «юум хум» гэдэг үгтэй холбож «хамаг юм», «адуу идээгээ, юм хум» (ө.х. бүх юмыг) гэсэн утгатай гэж тайлбарласан нь яг зөв ойлголт, төсөөлөл мөн. Бид энэ үгийг эртний монгол бичгийн йа (асуух төлөөний үгийн язгуур дээр **«гу» гэдэг нэр үг бүтээх дагавар залгаж үүсгэсэн эд юмыг** асуух үг, бас хэ гэдэг нь «хэн» гэдэг хүнийг төлөөлүүлж асуух үгийн язгуур хоёр нийлж «йагу кэ» гэсэн «юм ба хүн» буюу бүх юм гэсэн утга илтгэх нийлмэл өвөрмөц хэлц үг үүсгэсэн гэж үзэж байна. Одоо цагт энэ «кэ» гэдэг язгуур нь хүний холбогдолтой утга алдаж харин «йагу»-тайгаа нийлж «бүх юм» гэсэн утгатай үг болсон бөгөөд нөгөө юм хум гэдэг нь «йа+гу+м-а» «кэ+гү+м-э» гэсэн үгнээс үүсчээ. Энэ хоёр үг асуух төлөөний нэрээс үүссэн нэр үг учраас түүн дээр -хан хэн гэсэн дагавар залгаж багасгасан утгатай «йагухан кэхэн» **гэдэг үг үүсдэг нь бага сага юм гэсэн утгатай болно.**

485. абхагулба (авхуулав)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 1), Пеллио (9, 47), Лигети (33, 90), Рахевильз (25, 71), Дашцэдэн (26, 88), нар «абха'улба～абхаулба» гэж, Дамдинсүрэн (7, 125), Баяр (11, II, 549), Элдэндэй Ардажав (8, 443), нар абхагулба (хуучин сонгодог монгол бичгийн тогтсон журмаар) гэж тус тус сэргээдэг нь цөм зөв зүйтэй ба үгийн утгыг цөм тэдний дайны үеийн цааз зөрчиж олзонд шунаж тулалдаанаас зайлсхийж тулалдааны араар олз хайж олж авсан бүх олзны юмыг нь бусдаар хураан авах ажил хийлгэсэн үг гэж зөв ойлгож орчуулсан буюу тайлбарласан байна. Харин «абхагулба» гэсэн үгийг «абугулба» гэсэн үг гэж Элдэндэй Ардажав нарын тайлбарласныг (8, 445, тайлбар № 12) арай ташаа болсон шиг бидэнд санагдаж байна. Учир нь аб-гэдэг нь тус үйл үгийн эзний хийх тусах үйл үг, аб+гул-абугул гэвэл дайны олзыг олж авсан тэр хүмүүс үг зүйлийг өөрснөө биш, бусдын эрхэнд авахад хүрсэн гэсэн өөр утгатай үг болно. Абха гэвэл аб+ха гэвэл авах үйлийг бусдын эрхэнд (жишээлбэл **Чингис хааны тушаалаар авсан**) хийсэн гэсэн утгатай эс тусах үйл үг үүснэ. Иймд «абхагулба» гэдэг нь Чингис хаан тэдний дайны хууль зөрчиж олзонд шунаж олж авсан зүйлийг өөрөө бус, харин Зэв **Хубилай гэсэн өөр хүнээр хураан авах үйлийг үйлдүүлсэн гэсэн өөр** утгатай тул энэ нь авуулсан» гэдэг үгтэй утгын хувьд адилгүй гэдгийг тэмдэглүүштэй.

486. самсижуху (самшижээ)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 132), Қозин (14, 244), Пеллио (9 ,47), Лигети (33, 91), Рахевильз (25, 52), Дашцэдэн (26, 89) тэргүүтэн цөм «самшижу'у» ~ «самшижуу» гэж, харин Лувсанданзан (31, I, 117), Баяр (11, II, 554), Элдэндэй Ардажав (8, 446), Иринчин (28, 127) нар энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт тэмдэглэдэг янзаар «самсижуху буюу самсижугу» гэж сэргээсэн нь туйлын зөв сэргээлт шиг бодогдоно.
Тэгэвч энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «алдах, хохирох» гэж тайлаад (15, 53), Пеллио (9, 176), Дамдинсүрэн (7, 125), Қалужинский (61, 89), Дугаржав (24, 98), Мансан (27, 144) цөм «их хохирол хүлээв» гэсэн ерөнхий утгаар нь ерөнхийдөө зөв орчуулсан боловч бидний бодлоор энэ үг монгол хэлний ямар утгатай ямар үг болохыг зөв ойлгож тогтоож чадаагүй юм. Гагцхүү Элдэндэй Ардажав нар орчин цагийн монгол хэлэнд байгаа шамшигдуулах (хувьдаа ашиглах завших, гарз хохирол учруулах) гэсэн үгтэй холбож тайлбарласан (8, 448, тайлбар № 11) боловч энэ үг яагаад ийм «ашиглах завших» гэсэн утгатай болохыг тайлсангүй.

Бидний бодлоор энэ үгийн үндэс нь сам- (үс самнахад зориулсан олон шүд бүхий хэрэглүүрийг хэлдэг утгатай нэр үг (+си(ши) (нэр үгээс самшиг болох гэсэн утгатай үйл үг бүтээх дагавар) +жуху (үйл үгийн мэдэгдэлгүй өнгөрсөн цаг заах тэлэвийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн бололтой. Энэ үг яагаад «цэргийн хохирол» гэсэн утгатай болсон гэвэл сам- гэдэг олон юмын завсар зайтай зүйлийн нэр тул цэргийн эгнээ энд тэндээсээ самны шүд хугарсан мэт сийрэг цөөн болж хохирсон гэсэн утгаар хэрэглэгджээ гэж төсөөлөн бодно. Эртний монгол хэлний самсиху гэдэг үг цаашдаа «самшиху» (сам мэт эгнээ сийрэг болох гэгдэх болоод эхний «с» нь II үед үүссэн «ш» авиандаа ижилсэн, «шамших» болж улсын хөрөнгийг шамшигдуулах (өөрөөр хэлбэл улсын хөрөнгийг сам мэт сийрэг болгох) хохироох гэсэн утгатай үг болсон болов уу гэж таамаглаж байна.

487. о[о] гугсан (уусан)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 47), Қозин (14, 245), Баяр (11, II, 556), Дашцэдэн (26, 89) нар «угсан» гэж, Хэниш (36, 160), Лигети (33, 91), Рахевильз (25, 72) нар цөм «уугсан» гэж уртатгалтайгаар, Иринчин «о[о]гсан» (28, 127) гэж тус тус буулгасан нь энэ үгийн XIV зууны үеийн хэл аялгууны дагуу галигласныг харуулсан бөгөөд Хэниш, Лигети, Рахевильз нарын сэргээснээр бол тэр үг «уугсан» гэж орчин цагийн дуудлагатай нь их л ойр тэмдэглэгдсэнийг харуулав.
Харин энэ үгийг Лувсанданзан «умдан оохсон [уугсан?]» (31, I, 117), Дамдинсүрэн (7, 126), Баяр (11, II, 556), Дугаржав (24, 98), Мансан (27, 145) «у[у]гсан» гэж галигласан нь ерөнхийдөө «уух» гэдэг үгийг хуучин (сонгодог) монгол бичгийн бичлэгээр нь бичсэн хэрэг бөгөөд үгсийн болон утгын үүдэнээс зөв тэмдэглэжээ.
Гэвч өтөг (зөв нь: өтүк) угсан гэдэг үгийн утгыг Лувсанданзан, Хэниш, Поуха, Қалужинский нар «умд уусны хойно» гэж, Дамдинсүрэн, Пеллио, Қливз, Дугаржав, Мансан, Элдэндэй Ардажав, Иринчин нар цөм «сархуд, дарс, архи уух» гэсэн үг гэж ухаарсан нь хадмал хятад орчуулгаас нь илүү зөв ухаарал шиг бидэнд санагдах бөгөөд энэ нь «Нууц товчооны» бусад зүйл (§275)-ээс тодорхой байдаг.

Бидний санахад энд нэмж тайлбарлах нь: уух гэсэн үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «о[о]гуху» гэж бичдэг уламжлалтайгаас үзвэл эртний худам монгол бичигт энэ үг «о[о]гуху» гэж бичигддэг үг байгаад хожим эгшгүүд хоёрдугаар үеийн «у» эгшигтэйгээ ижилсэн угуху ~ уух гэсэн дуудлагатай болсон бололтой юм. Учир нь худам монгол бичигт «о[о]гуху» гэж бичдэгийн эхний дараалсан давхар о үсэг нь уртатгалыг бус харин О-г У эгшгээс ялгах зорилгоор бичдэг байсан тул «о[о] гуху» гэсэн үгийн бичлэгийг XIV з. үеийн дуудлагаар «угсан ~ уугсан» гэж ташаа тэмдэглэсэн байна гэж бодох үндэстэй юм.

488. бүгкүгсэн (бүгж нуугдсан)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 21), Пеллио (9, 48), Лигети (33, 91), Рахевильз (25, 73), Баяр (11, II, 559), Элдэндэй Ардажав (8, 450), Дашцэдэн (26, 90), Иринчин (28, 128) нар цөм «бүксэн» гэж сэргээгээд энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш (36, 21), Элдэндэй Ардажав (8, 452, тайлбар № 8) Иринчин (28, 129 тайлбар № 2) нар «байсан» гэсэн утгатай үг гэж тайлбарласан боловч энэ нь бодвол утгын үүдэнээс өгүүлбэрийн бусад үгтэй найралдахгүй эргэлзээтэй тул Лувсанданзан, Дамдинсүрэн, Хэниш (15, 53), Пеллио (9, 176), Поуха (17, 87), Қливз (42, 83), Дугаржав, Мансан нар цөм энэ үгийг орхиж алгасан орчуулсан бололтой байна.

Үүнээс бид энэ үгийг «бүгкүксэн» (зугтаж нуугдсан) гэсэн үгийг XIV зууны галиглагчид орчин цагийн монгол хэлэнд дуулддагтай нь адилаар «бүгсэн» гэж ташаа галиглаад байсан гэдэг бүязгуурт үйл үгийн

үйлт нэрийн нөхцөлт үгтэй адилхан бичлэгтэй болгосон тул хожим хадмал орчуулгыг хийгчид «байх» гэсэн үг гэж эндүүрсэн бололтой гэж таамаглав. Учир нь Есүгэн «миний эгч надаас дээр хаан хүнд зохих биз ээ» гэж хэлсэн байхад «эгч чинь чамаас сайн байсан бөгөөс эрүүлье» гэж хэлсэн баймгүй. Харин Есүгэн хатан «одоо энэ будлианд хаашаа зорчив» гэж хэлсэн учраас Чингис хаан чиний эгч чамаас сайн бөгөөд «бүгкүксэн» (зугтан нуугдсан) бөгөөс эрүүлье» гэж хэлсэн гэвэл сая утга авцалдмаар санагдана.

489. Бүлү-дэ айитхатхун (бүлэгт айтгагтун)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 17), Қозин (14, 245), Пеллио (9, 48), Лигети (33, 92), Рахевильз (25, 73), Баяр (11, II, 565), Элдэндэй Ардажав (8, 453), Дашцэдэн (26, 91) Иринчин (28, 129) **нар цөм «Бөлдэйиткэткүн»** гэж сэргээсэн **бөгөөд** энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «салангид байлгагтун» гэж тайлсан байв. Эл учраас судлагчид үүнийг дагаж «аль ч овогт хамаарахгүй хүмүүсийг» Хэниш «онцгой болго» (15, 54), Пеллио «тусгай бүлэг» (9, 177), Поуха «өөр тийш гарга» (17, 88), Қалужинский «тусгай болгоно» (61, 90), Қливз «тусад нь гарга» (42, 84), Дамдинсүрэн «өөрийн аймагт бүү үлдээ» (7, 127), Дугаржав «тусгаар болго» (24, 99,) Мансан «тус тусад нь болго» (27, 146), Элдэндэй Ардажав «булталгагтун буюу тус тус болгон гаргах» (8, 455, тайлбар № 5) гэж орчуулсан буюу тайлбарласан байна. Ганцхан Лувсанданзан энэ үгийн утгыг «өөр болгон төгсгэгдэхүн» гэж өөрөөр бичсэн боловч энэ үгийг мөн л ойлгоогүй шиг санагдана.

Бидний бодоход энэ үг нь **«булу (төрөл—12.302)»-д-э айитхатхун** (аймагла) гэсэн хоёр үг нийлж буруу галигдсан тул утга нь мэдэгдэхгүй үг болсон бололтой. Ингэж бодох үндсийг В, Я. Владимирцовын нийтлүүлсэн «Хийн хүйтэн хөх Төмөр Зэв» туулинд аян дайнаас эргэж ирсэн Догшин Чингэл, Хүйтэн Хөх Зэв хоёрт Сайхан Мингмийан хаан «хоёр хөвгүүн минь, анд мордсоныг мэргэ гэдэг, аянд мордсоныг бөлүд гэдэг, над бөлүд хайрла» гэхэд хоёр хоёр муж хүн, хоёр хоёр муж малаар бөлүд бариваа» (95, 148) гэсэн мэдээлэл гарч буй баримт өгч байна. Иймд энэ бөлүд гэдэг үгийг бөлү гэдэг үгийн олон тооны хэлбэр гэж бодож, өгөх оршихын тийн ялгалд «бөлү-д-э» айтга гэсэн үг байж болох юм.

Эр, эм эгшигтэй хоёр үг ийнхүү хоршин нийлж үг бүтээхдээ эхний үгийн өргөлтөт үеийн дуудлагад дараах үгийн бүх эгшиг эр эмээр зохицон ижилсэх учир «бүлүдэйитхэткүн» гэж хувирсан байж болох юм. Ингэж бодвол энэ үгийн хадмал хятад орчуулгын утгадаа ч яг тохирох юм.

490. киткүн (хийгтүн)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь. Хэниш (36, 48). Пеллио (9, 48), Баяр (11, II, 567), Дашцэдэн (26, 91), Элдэндэй Ардажав (8, 453), Иринчин (28, 130) нар цөм «гэткүн ~ кэткүн» гэж Лигети (33, 93), Рахевильз (25, 74) нар «гээткүн» тус тус сэргээгээд Хэниш, Поуха, Қалужинский, Баяр, Элдэндэй Ардажав (8, 457, тайлбар № 14) нар цөм «гээж орхи» гэж бидний бодлоор арай ташаа буруугаар ухаарсан нь хятад үсгийн галиг ба түүнд хожим хийсэн хадмал хятад орчуулгын алдааг давтсаны урших юм.

Харин Дамдинсүрэн (7, 127), Дугаржав (24, 99), Мансан (27, 146) нар энэ үгийг «нүднээс далд болго» ~ «түүнийг эчнээ болго» гэж орчуулсан нь уг эхийн утгад илүү ойр болсон шиг бидэнд санагдах бөгөөд учир нь бидний бодлоор энэ үг гээж орхи гэсэн утгатай «гэткүн» гэсэн үг байгаагүй, харин «киткүн» (хийгтүн) гэсэн үг байсан гэж бодох ноцтой үндэс байгаа юм. Үүнд «Нууц товчооны» худам монгол бичгийн эхтэй байсан нь олон зүйлээр батлагдаж байгаа Лувсанданзан энэ үгийг «кигтүн» (31, 48) гэж өөрөө бичсэн баримт болно. «Нүднээс эчнээ (далд) хий» гэвэл «үгүй болго-ал» гэсэн утга гаргах юм. Харин нүднээс эчнээ «гээгтүн» гэвэл нүдэнд үзэгдэхгүй хол газар цөл» гэсэн утга саная гаргах тулд «нүдэн-үэчин-э киткүн» гэж сэргээн «далд оруул (ал)» гэсэн утгатай гэж ойлгох нь зөв гэж бодож байна.

491. билдумур (болжмор)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 16), Пеллио (9, 49), Лигети (33, 94) нар «билду'ур» гэж, **Баяр** (11, II, 577), Дугаржав (24, 101), Мансан (27, 148), Элдэндэй Ардажав (8, 464), Иринчин (28. 131) цөм «билдугур» гэж, Дашцэдэн (26, 92) «билдуур» гэх зэргээр буулгасан нь бидний бодоход төдий л зөв биш шиг санагдана.

Харин энэ үгийн утгыг хятад хадмал орчуулгаар нь Хэниш «харуй бүрүйн болжмор» (36, 16) гэж тайлаад Хэниш (15, 55), Пеллио (9, 178), Қливз (42, 86) нар «жижиг шувуу болжмор» гэж, Дамдинсүрэн «харьж нисэх шувуу» (7, 128), Мансан «нэг зүйл (гоу-а) болжмор» (27, 161, т. 23), Дугаржав «тарахай билдугур», Элдэндэй Ардажав (8, 464—468) «билдугур дуут буюу боролдой болжмор ~ билдугур» гэх мэт болжморын нэг төрөл гэж, Поуха «хөөндий» гэж элдвээр ойлгож орчуулсан буюу тайлбарлажээ.

Бидний санавал энэ нь «ажирах (нисэн одох) билдумур (болжмор)

гэсэн үг бололтой. Учир нь хуучин (сонгодог) монгол хэлийн уламжлалд энэ үгийг «болжумур» гэж бичдэг нь чухамдаа «билдумур» гэдэг үгийн авиа солигдож «болдимур» гэж яригдах болж улмаар «ди-» авиа нь «жи» авиагаар солигдон «болжимур» эсвэл «билжимур» (§77) болж улмаар «болжумур» (12, 276) болсон гэж бодох үндэстэй. Учир юу гэвэл хэрэв «болдимур» гэсэн хэлбэр байсан дээрээс энэ үгийн «ди» нь «ж» авиа болсон байх учиртай, хэрэв «и»-гээс өөр эгшиг байсан бол «д» авиа нь «ж» биш «з» болох байжээ. Нөгөө талаар «билжухай» (бялзуухай) гэдэг үгтэй энэ үг төрөл гарал нэгтэй учраас «болжумур» гэж бичигдэх болжээ. Иймд «билдумур» гэдэг үгийг судлагчид харуй бүрийн «болжумур» гэгчийн нэг төрөл зүйлийн нэр гэж олон янзаар тайлбарласан нь үнэнтэй нийцэхгүй. Билдумур, билжухай (бялзуухай) билжи'ур (бялдууч зусар) гэдэг үгс бидний бодлоор гарал нэгтэй төрөл үгс болно. Бидний санавал энэ үгийг Лувсанданзан «Билдахур» (31, I, 120) гэж бичихдээ «билдагур» (бялдууч) гэсэн үг гэж ухаарснаас ийнхүү эндүүрсэн байх. Учир нь Наяга ноёныг «МНТ»-нд ч «Найа билжи'ур» (§220) гэж бичсэнийг Пеллио (54, 162) «жисур» гэсэн утгатай гэж тайлбарласан билээ. Иймээс «билдаучи» (зусарч) (12, 265б) гэсэн үг бол нэг бол «билдаху» (тос түрхэх) эсвэл билдугучи (болжмор жиргэх адил хуурмаг ярьж ая тал засах гэсэн үгнээс гаралтай байж магадгүй. Юутай ч «билда[г]учи», «билжумур, билжухай» гэх мэт үгэнд «бил» гэсэн ерөнхий язгуур байх шиг санагдана.

492. Өбчиг[и]дэй Күрэнг багатур (Өбчигидэй Хүрэн баатар)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Калужинский, Кливз нар «Убчигтай буюу Убчиг овгийн Гурин баатар» гэж, Поуха (17, 89) «Убигийн Гүрин баатар» гэж сэргээгээд «Гүрин гэдгийг гүрү (чулуу) эсвэл гүр буюу даяны, нийтийн» гэсэн үгнээс гарсан (58, 49, ба 94) гэв. Дамдинсүрэн (7, 128), Баяр (11, II, 578) нар Убчигдай Хүрэнг (өнгө) гэж, нөгөө Дугаржав (24, 101), Мансан (27, 148) нар «Убчигдай ийн Хүрэнг (өнгө) баатар» гэж орчуулсан юм. Харин Лигети (33, 94). Рахевильз (25, 75) нар «Убчигтай Гурин» гэж Элдэндэй Ардажав (8, 464), Иринчин (28, 131) нар «Убчигдай Күрин» гэж сэргээжээ. Бидний бодлоор энэ нь уул баатарын хоч нэр бололтой. Учир нь Өбчигидэй буюу Өбчиртэй гэгч Монгол нутагт ургадаг улаан хүрэн өнгийн нэг зүйл жимсгэнийн нэр байсан бөгөөд энэ баатрын царай тэр жимс шиг улаан (хүрэн) тул «Өбчигидэй Хүрэнг» баатар гэж алдаршсан гэж Рашид-ад-Дин (4, I, 2, 113) тайлбарласан юм. Энэ үгийг **түүхч Лувсанданзан «Өрүчигидай күрүс»** баатар гэж алдаатай буулгаснаас үзвэл үгийн эхний үе нь Ө эгшгийн шилбийг Р гэж үгийн дунд суларсан Б-г У-гаар сэргээж, хоёрдох үе «чи» үе нь «ги» үе байсан байж болох тул бид «Убчигтай» биш, харин «Убчигидай» гэсэн нэр уул эхэд нь байсан болов уу гэж таамаглаж байна. Юу ч гэсэн Өбчигидай гэдэг овгийн нэр биш мэт бөгөөд харин Өбчи (бүх нүүр нь) улаан хүрэн учраас «Өбчигидай» гэсэн хоч нэр олсон байж болох юм.

493. улкин йэнггүн (ховлон гүтгэн муулан)-гэсэн утгатай энэ үгийг хятад үгсийн галигаас нь Хэниш (36, 163) «улгин жэнгкүн» гэж Пеллио «улкин чингкүн» (9, 49) гэж, Лигети (33, 94) Рахевильз (25, 75), Баяр (11, II, 587), Элдэндэй Ардажав (8, 464), Иринчин (28, 132) нар цөм «улкин жингкүн» гэж, Дашцэдэн «үлкин жингкүн» (26, 93) гэж тус тус сэргээжээ.

Энэ үгийн утгыг Хэниш хадмал хятад орчуулгаар нь «гүтгэн өгүүлэх» гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 55), Пеллио (9, 178), Кливз (42, 86) тэргүүтэн цөм энэ үгийг «гүтгэн муулах», «гүтгэн гутаах» гэж орчуулсан бололтой байна. Түүнчлэн Дамдинсүрэн «ховлож хочилж» (7, 128), Мансан «ховлож гоочилж» (27, 148), Элдэндэй Ардажав нар «улкин йэнгкүн» (8, 464) гэж сэргээгээд «ховлох, гүжирдэх, гүтгэх» тэргүүтэн элдэв утгатайг эдгээр үгсийн 7, 8 дугаар тайлбарт (8, 465—466) зөв бариттай дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Энд бид «улкин» гэдэг одоогийн монгол хэлний «улиг, улжих, уламжлах» гэх мэт дамжуулах, гуйвуулах, урт нуршуу» гэсэн утгатай эдгээр үгстэй утга, гарлын хувьд төрөл үг болов уу гэж таамаглаж байна. Юу гэвэл «улиг-хүнд жигшигдэх ичүүртэй явдал» (12, 151) «улигтай-будлиан алзууртай» (12, 151) гэх мэт. Бас үүний эсрэг утгатай «олиг» гэдэг «олиг үгүй» гэж үгүйсгэх үгтэй нийлж сая «муу» гэсэн санаа гаргаж байгаа бөгөөд энэ үгтэй адил утгатай үйл үг нь «олкү» гэж бичигддэг баримт байгаа нь «улиг» гэсэн нэр «улки» гэсэн үйл үгтэй нэг язгуур үндэстэйг харуулав. «Олки» гэдэг үг үйл үг болохыг «олкийа» гэдэг үүсмэл нэр үг үйл үгэнд залгаж нэр үг бүтээх «й-а» дагаврааар үүссэн баримт харуулж байна. Энэ бол дохи- гэсэн үйл үгийн үндсэнд «й-а» дагавар залгаж «докий-а» гэсэн нэр үг бүтээдэгтэй адил загвараар бүтсэн болохын баримт болно.

Нөгөө «йэнггүн» гэдэг үгийг хуучин (сонгодог) монгол бичигт хэдийгээр «инггүхэн үг-энгийн хэлэлцэх балмад үг» (12, 106) гэж бичигддэг боловч энэ нь анх «йэкэ» гэж бичигддэг үг орчин цагийн монгол

хэлэнд «их» болсны адил «инггүхэн» гэж өөрөөр бичигдэх болсон болов уу гэж төсөөлөн энэ үгийг «чингкүн» (Пеллио) биш, бас «жингкүн» (Хэниш, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн) ч бус, харин **«йэнггүн» гэж сэргээх нь илүү зөв гэж бодож байна. Учир нь йэнг+гү+кү гэсэн** үгнээс үүссэн болов уу гэж бидний боддог «егөх» гэдэг үг «к» биш «г» дуудлагатай байгаа нь үүний зөв болохыг гэрчилнэ.

494. түбэк-үд-и (түвгүүдийг)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 153), Козин (14, 246), Лигети (33, 75), Рахевильз (25, 75) нар цөм «тубу'ут» гэж, нөгөө Пеллио (9, 49) Баяр (11, II, 580) Дашцэдэн (26, 93), Элдэндэй Ардажав (8, 467) Иринчин (28, 132) нар «түбү'үт», «түбү(г)үд», «түбүгүд» гэж тус тус сэргээсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «зорилгыг барагцаалан» (36, 153) гэж тайлсан нь бидний бодоход арай ташаа ойлгоц юм. Энэ үгийг Хэниш (15, 55), Поуха (17, 89) нар Найманы төлөвлөгөөг мэдэж гэж, Калужинский «далд санааг» (61, 91) гэж, Дамдинсүрэн «түвэг учруулсныг» (7, 129) гэж, Дугаржав (24, 102), Мансан (27, 148), Элдэндэй Ардажав (8, 467, тайлбар № 5, 468), Иринчин (28, 132) нар энэ «түбүг ~ төбүк» үндэс төлөв тойм гэсэн утгатай гэж ухаарсан нь чухамдаа хадмал хятад орчуулгын утгыг дагасан орчуулгууд юм.

Бид энэ үгийг «түбүгүд» буюу «төбүгүд» гэсэн үг биш харин «түбэгүд» гэсэн үгийг тэр (XIV зууны) үеийн аман аялгуугаар ташаа тэмдэглэсний учир хожим хадмал хятад орчуулга хийгчдийг өөрөөр ойлгож орчуулахад хүргэсэн гэж үзэх тул Дамдинсүрэнгийн учруулах «түбэгүд»-ийг мэдэж гэсэн үг гэж ойлгож «түбэгүд» гэж сийрүүлсэн болно. Бас үүний дараах «аран-а эсэ тогалуга» гэсэн үгийг «олзлох ардуудыг тоосонгүй» гэсэн утгатай шиг санагдана. Өөрөөр хэлбэл тэр хоёр наймантай байлдахад түвэгтэй, ашиг олз багатай гэж байлдалгүй буцсан гэсэн утгатай үг гэж санана. Энэ үг «түвэг» гэсэн үг бус, «төб» гэсэн үг байсан бол «төбүгүд» гэж олон тоог заахгүй, харин «төбүд» гэж бичигдэх учиртай. «Түбэг» гэдэг үг монгол хэлний үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс гарчихсан байсан учир «түбүгүд» гэсэн дуудлагаар тэмдэглэгджээ. Уруулаар зохицох ёс гарахаас өмнө авсан худам монгол бичигт энэ үгийг «түбэг» гэж бичигдэж байсан нь магадтай бөгөөд хуучин (сонгодог) монгол бичигт энэ уламжлалаараа «түбэг» (12, 626а) гэж бичигддэг байна.

495. Хогор-тур (хооронд)-гэсэн энэ үгийн хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 135), Козин (14, 246), Пеллио (9, 49), Лигети (33, 95), Рахевильз (25, 75), Баяр (11, II, 582), Элдэндэй Ардажав (8, 468), Дашцэдэн (26, 93), Иринчин (28, 132) цөм «со'ор буюу согур ~ согор» гэх зэргээр сэргээсэн болно.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «энэ хэргийн үед» (15, 56) гэж, Пеллио «тулалдааны үед» (9, 179) гэж, Кливз «тулалдаж байх үед» (42, 86) гэж тус тус орчуулсан шиг санагдахаас гадна Дамдинсүрэн (7, 129), Дугаржав (24, 102) нар «завшааныг тохиолдуулан буюу завшаанаар» гэж, Элдэндэй Ардажав (8, 469) «зай завсар, зав, чөлөө гэсэн утгатай үг бөгөөд энд завшаан далим, тохиол дашрам гэсэн утгаар хэрэглэгдсэн гэж тайлбарласан нь утгын хувьд зөв юм.

Гэвч бид энэ үгийг «согор» гэсэн үгийг худам монгол бичгийн эхэд «хогур ~ хогор» (хооронд гэсэн утгатай) гэсэн үг байсныг одоогийн буриад аялгууны маягаар «со'ор» гэж ташааран хэлж өгсөн буюу соносч алдаатай тэмдэглэсэн болов уу гэж таамаглав. Үүнд Лувсанданзан түүхч энэ үгийг «хогор» (завсар) гэж тайлбарлан бичсэн нь түүнд байсан худам монгол бичгийн эхэд байсан бичлэгийг дагасны баримт болов уу гэж санана. Буриадын зэрэг зарим аялгуунд Х—С хоёр авиа тогтмол солигдож сэлгэдэг нь монголчуудын «сайин» гэхийг буриад аялгуунд «хайин» гэх мэт байдаг тул үүний эсрэг ийм сэлгэлт байж болох нь ил. Хогор буюу хогур гэдэг эртний монгол хэлний дайвар үг хоёр гэдэг үгийн эхний хо-үндэснээс гарсан болов уу гэж санана. Учир нь Монголд «хоёрын хооронд гурвын дунд» гэдэг зүйр үг байхаас гадна бас бидний урьд тайлбарласан «хогучаг» гэсэн үг ч хоёрыг холбогч гэсэн утгатай байгаа нь давхар баталж байна.

496. Улаган хут[у]-д-а (Улаан хусуудад)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 178) Козин (14, 246), Лигети (33, 95), Рахевильз (25, 76) нар цөм «hула'ан Хут-да» гэж Дамдинсүрэн «Улаган хус гэмээх газар» (7, 129) гэж, Дугаржав (24, 102), Мансан (27, 149), Элдэндэй Ардажав (8, 470) «Улаган худ» буулгаад Х. Пэрлээгийн олж тогтоосноор Баян-Өлгий аймгийн «Улаан хус» гэдэг газар бийг зааснаас (8, 470—471, тайлбар № 3) үзвэл «худ» гэдэг «хус» гэсэн үг гэж ойлгож сэргээсэн буюу орчуулсан байна. Харин Иринчин «Улахан худ та» гэж сэргээгээд «Хун (эгц хад)» гэсэн үгийн олон тоо гэж тайлбарласан нь өвөрмөц өөр санал боловч төдий л үнэмшилтэй бус санагдана.

Бид Дамдинсүрэн болон Пэрлээ нарын саналыг зөвшөөрч энэ «Улаган хут» гэдэг маш эрт цагийн монгол хэлний Хуту-д-а гэсэн үг худам монгол бичгийн эхэд «Хуту-д-а» гэж бичээстэй байсныг XIV з. үеийн галиглагчид хут-та гэж тэр үед хэлэгдэж сонстож байснаар нь арай ташаа тэмдэглэсэн болов уу гэж төсөөлөв. Хуту гэсэн эртний монгол үг сүүлдээ «Хусу» гэж Т. С-ийн солигдол сэлгэлтээр хувирч «хусу» гэсэн үг болсон гэж бодох үндэстэй. Учир нь тагуба гэсэн үгнээс сагуба (суув) гэсэн үг, тагури гэсэн үгнээс сагури буюу тугури (балгасын суурь) гэх мэт үгс үүсч гарсан нь баримттай юм.

497. гуйа хагтажу (гуяа харвагдаж)-гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 56), Козин (14, 246), Пеллио (9, 56), Лигети (33, 95), Элдэндэй Ардажав (8, 470), Иринчин (28, 133) нар цөм «хагдажу» гэж, Баяр (11, II, 585), Дугаржав (24, 102), Дашцэдэн (26, 94) «харвагдажу» гэж сэргээсэн нь бодвол хадмал хятад орчуулгын дагуу галигаас өөрөөр сэргээсэн бололтой. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «хагдажу» гэдэг хаху буюу харвагдахын эс тусах хэлбэр гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 56), Пеллио (9, 179), Поуха (17, 90), Кливз (42, 87) болон Дугаржав, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Иринчин цөм «харвагдаж» гэсэн үг гэж ижлээр, ганц Дамдинсүрэн (7, 129), Мансан (27, 149) нар «шархтуулж» гэж тус тус ойлгосон байна.

Гэвч, бидний бодлоор энэ үг чухам ямар учраас «харвагдаж» гэсэн утга гаргаж байгаа ямар үг болохыг Хэнишээс бусад нь тодорхой сайн мэдсэнгүй. Учир нь энэ харвах гэдэгтэй адил утгатай «хаху» гэсэн маш эртний монгол хэлний үйл үг «харвах, хатгах, хага» гэх мэт үгтэй язгуур нэгтэй төрөл үг боловч хожим бүрмөсөн мартагдаж хуучирсан үг бололтой. Монголчууд «буга хаах» гэдэг нэг зүйл хөлөгт тоглоомоор нааддагийг бид багадаа «бугыг явах замгүй болж хаах» гэдэг үг байх гэж бодож байв. Гэтэл энэ нь «буга хаху» буюу «буга харвах» гэсэн утгатай үг байсан бололтой. Энэ бол «харбах» гэдэг үгийн «ха-гэсэн язгуур нь эрт цагт харбах гэсэн утгатай үйл үгийн үндэс байсныг харуулж байна. Г. Сүхбаатар «Даригангын хүүхдийн тоглоом» гэдэг номдоо «бугатай нь аль болох олон идэштэй болох нүүдлийг харж нүүдэг. Хүүтэй нь бугын идшийг аль болохоор хаан нүүж байдаг» (100, 13) гэж бичсэнээс үзвэл энэ нь «буга хаху» гэдгийн ул мөр мөн бололтой байна.

498. өндүд-[д]-э, халдуд-[д]-а гарбасу (өндөрүүдэд... халдудад гарвал) гэсэн энэ хоёр үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 164 ба 57), Козин (14, 246) нар «ундут-та [тэ]», «халдут-та» гэж, Пеллио (9, 50), Лигети (33, 96), Рахевильз (25, 96), Дашцэдэн (26, 94), нар «үндут ~ үндүд-тэ», «халдут халдуд-та» гэж, Баяр (11, II, 589), Элдэндэй Ардажав (8, 471), Иринчин (28, 134) нар «өндүд-тэ» «халдуд-та» гэж тус тус сийрүүлэн босгосноос бидний бодлоор сүүлчийнх нь илүү зөв болсон гэж бодно.

Эдгээр үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш (36, 164 ба 122) «өндөрлөг ба уулын энгэр ханан хад» (15, 56) гэж тайлжээ. Эдгээр үгийг Хэниш «Өндөр ба ханан хаданд гарвал» (15, 56) гэж, Дамдинсүрэн «өндөр уулыг түшиж, хадан гэрт очибаас» (7, 130) гэж. Пеллио «өндөр газар гарваас» ба «ууланд гарваас» (9, 179, 180) гэж, Поуха «Өндөрлөг ба ханан хаданд гарвал» (17, 90), гэж, Калужинский «өндөрлөгт гарвал» (61, 92) гэж (орчуулсан бололтой), Кливз «өндөрлөг ба элгэн хад» (42, 88) гэж, Дугаржав (24, 101), Мансан (27, 150), Элдэндэй Ардажав (8, 471) нар цөм «өндүд-уул, хаданд хадат уул эсвэл өндөрт, хадад эсвэл өндөр ба хад гэдгийн олон тоо гэж, эсвэл Иринчин (28, 134) «үхэх» гэсэн утгатай гэж тайлбарлажээ.

Бид эдгээрээс «өндүд-тэ» гэсэн үгийг өндөр гэдэг үгийн олон тооны хэлбэр дээр «-э» гэсэн өгөх оршихын тийн ялгалын хүртээл залгасан хэлбэр гэж үзэж худам монгол бичгийн эхэд «өндүд-э» гэж бичээстэй байсныг XIV зууны үед аман аялгуунаас «өндүт-т-э» гэж, эцсийн д гийгүүлэгчийг нь сунжруулан хэлсний дагуу ташаараан тэмдэглэсэн гэж төсөөлөн тааварлаж байгаагаас гадна тэмдэг нэрд олон тооны болон өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаснаас үзвэл тэмдэг нэрээс нэршүүлэх аргаар «өндөр газар» гэсэн нэр үг бүтээж хэрэглэсэн гэж бодном. Харин нөгөө «Халдун» гэдэг нь эртний монголчуудын хүүр оршуулах газрыг нэрлэдэг ерөнхий нэр байсан байх гэж санана. Учир нь «Бурхан Халдун» (энэ тайлбарын № 14-ийг үз) гэдэг нь нэг л газрын тусгай нэр байсан бол энэ «халдун» гэдэг үг энд бичигдсэн шиг «халдуд» гэж олон тооны нөхцөлтэй бичигдэх учиргүй баймаар юм. Энэ үгийг Лувсанданзан «хадуд-да» (31, 122) гэж «л»-ийг хасч бичсэн нь жирийн алдаа байх. Хэрэв Лувсанданзан «хада» гэсэн үг гэж үнэхээр өөрөөр ойлгосон бол «хадуд-та» гэж бичихгүй харин «хадад-та» гэж

бичих байсан болов уу. «Халдуд» гэдэг үг хуучирч мартагдсан учир хадмал хятад орчуулгыг хийгчид үүнийг «хада» гэж буруу орчуулсан нь тэр үед нийт монголчууд «халдуд» гэдэг үгийн «хада» гэсэн үг байх гэж боддог болсноос тийнхүү андуурсан гэж бодох үндэстэй юм. Учир нь орчин цагийн монгол хэлэнд «ханат гэр холдож, хадан гэр ойртов» насан зүг болох ба үхэхэд ойртохыг (96, 21) хэлдэг мэргэн үг байна. Гэтэл анхны «халдун» гэдэг үгэнд «хада» гэсэн утга байгаагүй болов уу гэж бодох үндэс бас бий. Юу гэвэл монголчууд хүүрээ газарт ухаж оршуулаад түүнээ нуух гэж дээгүүр нь олон адуу хөөж хавийн нь газрын хөрсийг талхалж булсан газраа мэдэгдэхгүй болгодог заншилтай байсан нь илэрхий. Хаданд оршуулдаг байсан бол тэгж ухах боломжгүй тул «Халдуд» гэдэг үг хада гэсэн утгатай үг байгаагүй гэж бодно.

499. [х] адалган-и ину (хазалган) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 2), Козин (14, 247), Пеллио (9, 50), Лигети (33, 97), Рахевильз (25, 77), Баяр (11, II, 595), Дашцэдэн (26, 95), Элдэндэй Ардажав (8, 472), Иринчин (28, 135) нар цөм «адархан, адарган-и ину» гэж сэргээсэн бөгөөд ганц Лувсанданзан «адурган-дур ину» гэж өөрөөр бичсэн байна.

Энэ үгэнд хадмал хятад орчуулга байхгүйг заагаад Хэниш утгыг нь бодвол, товч орчуулгаас «хазалт шарх» (36, 2; 15, 57) гэж бидний бодлоор туйлын зөв орчуулсан байв. Энэ үгийг Дамдинсүрэн «Араат могойн шүд» (7, 132) гэж, Пеллио «Араат могой биднийг салгах гэвэл» (9, 180) гэж, Клывз «Соёот могойд бид өдөөн хатгагдвал» (42, 89) гэж тус тус орчуулсан байна. Энэ үгийг Дугаржав (24, 105) «адарханд нь» гэж, Мансан «атаанд нь» (27, 151) гэж, Элдэндэй Ардажав нар адар гэсэн үндэстэй бөгөөд «дуурайх, зүйрлэх, омогдох, бардах жигших, дургүйцэх, атаархах, муу хэлэх, муушаах, завсардуулах гэсэн утгатай гээд түрэг хэлний толь зааснаас үзвэл адар гэдэг тийм утгатай түрэг үгнээс гаралтай гэж тайлбарлах гэсэн бололтой.

Бид энэ үгийг «хадалган» гэж сэргээвэл зохих бөгөөд «хажалган» гэсэн монгол үгийн худам монгол бичигт бичигдэг хэлбэр байсан болов уу гэж төсөөлөв. Учир нь хуучин монгол бичигт «хажагар» (хазаар) гэж бичдэг үг «МНТ»-д «хадагар» (хазаар) (§278) гэж тэмдэглэгдсэн баримт бий бөгөөд энэ бүхнээс үзэхэд өвс «хадаху», «хазах» гэх мэт үгс гарал үүсэл утгын талаар холбоотой төрөл үг байсан гэхэд үгүйсгэх аргагүй юм. Иймээс хада- (хажа<хаза) гэсэн тусах үйл үг дээр л дагавар залгаж нэр үг бүтээгээд +га дагавар залгаж нэр үгээс нэр үг үүсгэсэн байж болохоос гадна сана+лга дагавар залгаж «уран саналга» гэх мэт нэр үг бүтээсний адилаар хада+лга-нийлмэл дагавраар үйл үгээс нэр үг үүсгэсэн байж болох юм. Харин «хада+р+га» гэсэн загвараар хада-буюу хажа-гэсэн үйл үгийн үндэснээс нэр үг бүтээсэн гэх төстэй загвар ховор учир галиглагч нар л-р хоёр авиаг сольж андуурсан сэргээсэн болов уу гэж бодно. Ингэж үзвэл Хэнишийн «могойн хазалт» гэж орчуулсантай утгын хувьд илүү тохирох мэт санагдана.

500. Зочи-[д]-а (Зочид)-гэсэн энэ хүний нэрийг хятад үсгийн галиглалаас нь зарим нь «Жөчи» (Дамдинсүрэн, Пеллио, Баяр, Дашцэдэн, Дугаржав) гэж, Магауия «Жүчи» гэж, бусад нь «Жочи» (Лувсанданзан, Хэниш, Лигети, Калужинский, Поуха, Клывз, Мансан, Элдэндэй Ардажав, Иринчин) гэж сэргээдэг юм. Энэ бол Чингис хааны их хүүгийн нэр бөгөөд Орос кипчакийн талд түүний байгуулсан Алтан ордны улсыг Орост Жүчийн улс гэж алдаршсан нь энэ хүний нэрийг XIV зууны аялгаар «Жөчи» гэдэг байсныг гэрчилнэ. Гэвч энэ хүний нэрийг Нууц товчооны эхэд олонх судлагчид «Жочи» гэж, түүний дотор Нууц товчооны худам монгол бичгийн эхтэй гэгдэж агсан Лувсанданзан ч «Жочи» гэж бичсэн нь уг худам монгол бичгийн эхэд «Жочи» гэж бичигдсэнийг гэрчилнэ гэж бодож «Жочи» гэж сийрүүлсэн юм. Нөгөө талаар Чингис хааны энэ их хүүгийн нэрийг Рашид-ад-Дин «энэ хүү гарчихна гэж бодоогүй байтал гэнэт төрсөн учир «Жочи» гэж нэрлэсэн» (4, I, 1, 69) гэж тайлбарласнаас гадна Жочийг олж жирэмсэн байхад нь Бөртэ үжинийг Мэргитүүд олзлон аваачсан гэдгийг Персийн түүхч тэмдэглэсэн боловч тэр хүү гэртээ гараагүй, харин Мэргидээс түүний эхийг Ван хан чөлөөлсний дараа Бөртэ үжинийг Тэмүжинд хүргэж өгөх замд нь нэгэнт төрчихсөн учир эцгийн гэртээ төрсөн хойноо Зочины ёсоор ирсэн гэж Жочи гэж нэрлэсэн нь түүхэнд тэмдэглэгдсэн баримт мөн тул бид Жөчи бус «Жочи» гэж сэргээсэн болно.

501. алагун-а (доод ширгүү буюу хатавч хавийн зайд)-гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш (36, 4), Пеллио (9, 51), Лигети (33, 97), нар «ала'ун» гэж, Лувсанданзан «алун-а» (31, I, 123) гэж

Баяр (11, II, 598) нар «алагун-а» гэж, Козин (14, 247), Дашцэдэн (26, 95) нар «алаун-а» гэж тус тус сэргээсэн буюу бичсэн байдаг нь ерөнхийдөө цөм зөв сэргээлт боловч харин энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «хаалганы булан» (зарц нарын зогсох газар) (36, 4; 15, 57) гэж, Элдэндэй Ардажав нар «үүдний ар» (8, 477—478) гэж, тайлснаас гадна Дамдинсүрэн (7, 132), Дугаржав (24, 105) Мансан (27, 151) нар «хатавчинд» гэж орчуулсан нь ерөнхийдөө хамгийн **ойр дөт болсон шиг санагдана. Энэ үгийг Пеллио** (9, 180), Кливз (42, 89) нар «хаалганы...», Поуха (17, 91), Калужинский (61, 92) нар «босгоны дэргэд зогсож» гэж, Элдэндэй Ардажав «алау» (гал) гэсэн түрэг хэлний үгтэй холбож үүдэнд гал түлж зочдыг галаар ариутгадаг заншлыг хэлсэн гэж тайлбарласан нь төдий л үнэмшилтэй болсонгүй. Учир нь тэр ариулах галыг жугуулчны «хоёр галын хоорондуур гаргах бөгөөд ингэж ариутгахаас наана хэн ч гэрт орох буюу ямар нэгэн юманд гар хүрэн авч зүрхлэхгүй» (91, 18) гэж хэлснээс үзвэл гэрийн гадаа үүдэнд асаадаг тул Элдэндэй Ардажав нарын тайлбарласан шиг хаалганы ард голомтоос өөр газар асаадаггүй нь ил байна.

Бидний бодлоор бол «алагун» гэдэг нь хаалга үүднээс голомт хүртлэх «зай завсар» гэсэн утгатай үг бөгөөд гэрийн доторх тийм зайг нэрлэх утгаа алдсан боловч ал-буюу ала-гэсэн зай гэсэн язгуураас «ал + гагчөлөө газар», «алгасаху-сэтгэл самуурах», «алхум-нэгэнтээ алхам хэмжээ» (өөрөөр хэлбэл хөл зөөх хоорондын зай) (12, 44 б, а) гэх мэт олон үгтэй төрөл үг болох нь мэдэгдэнэ. 214 дүгээр зүйлд «өрүнэжи исэри-йин алагун-а үүжүгүр-э сагужу» (25, 123) гэж гарч байгаагаас үзэхэд ганц үүдний зай ч биш, харин орны хөндий буюу зай ширгүүр ч алагун-гэж хэлдэг байжээ. Энэ ал-гэсэн үгийн язгуурт «н» дагавар залгаж «алун» гэдэг үг үүсгэж болох тул Лувсанданзан энэ үгтэй адил утгатай «алун» гэсэн өөрийн мэдэх үгээ бичсэн болов уу гэж бид бас тааварлаж байна. Тэгэхдээ түүхч ал- гэдэг үндсэн -и дагавар залгахад хувилгагч үсгийн дүрмээр алун болж бичигдэнэ гэж үзсэн мэт. Харин худам монгол бичигт «ала-» гэсэн язгуур дээр «н» залгаж бичсэн жишээг Лувсанданзан Алтан товчийн хоёрдугаар ботид «Арг-а билиг-йи эсэ мэдэбэсү, Алан до[о]ра ки имаган-у үнүгүн-и (ишгийг) алажу идэкүй-э бэркэ болай» (31, II, 31) гэж бичсэн байдаг. Энэ «алан» гэдэг үг хоёр хөлийн хоорондын зай буюу салтааны доорх зайд байгаа гэсэн утгатай нь ч эргэлзээгүй. Иймд бид энэ үгийг ала- (гэсэн үйл үгийн идэвхгүй язгуур) +гу (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +н (нэр үгийн олон тооны дагавар) +а (нэр үгийн өгөх оршихын тийн ялгалын нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг гэж бодно. Алгуу гэдэг үгийг яагаад олон тооны и нөхцөлтэй хэрэглэсэн бэ гэвэл хадмал хятад орчуулгад хэлсний адил «хаалганы ар» гэж тайлбарласнаас үзвэл дотогшоо онгойх хоёр хавтастай хаалганы ар гэдэг нь даруй хоёр хатавч мөн болох тул алагун-а» гэдэг нь баруун зүүн хатавчийн зайг хэлсэн тул олон тоот үгээр илтгэгдсэн шиг байна. Энэ учраас «алагун-а» гэснийг «хатавчинд» гэж орчуулсан нь хамгийн оновчтой болсон гэж санаж байна.

502. дур-а гучурчуху (гутарчээ)- гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 64), Пеллио (9, 51), Лигети (33, 97), Рахевильз (25, 77), Баяр (11, II, 599), Элдэндэй Ардажав (8, 475), Иринчин (28, 135) нар «дура хогорчу'у» гэж, Козин (14, 248), Дашцэдэн (26, 96) нар «хочорчуу» гэж, Лувсанданзан (31, 1, 124) «хорурчихуй [хочурчихуй]» гэсэн үгийн хэвлэлийн алдаа бололтой.

Энэ холбоо үгийн утгыг хадмал хятад орчуулгаас нь Хэниш «дур таа нь багасах сулрах» (36, 64; 15, 57) гэж, Дамдинсүрэн (7, 132), Элдэндэй Ардажав (8, 479) нар «дургүй болжээ» гэж, Пеллио «дотроо сэтгэл хөндийрчээ» (9, 180), Калужинский «хүйтэрсэн» (61, 92—93), Кливз «дассан сэтгэлээ алдав» (42, 90), Мансан «таагүй болов» (2., 251) гэж гагцхүү Дугаржав «дур гутурчээ» (24, 105) гэж тус тус ойлгож орчуулснаас Дугаржавын орчуулга хамгийн оновчтой болсон шиг санагдана.

Бидний санавал энэ үгийг галиглагчид тухайн (XIV зууны) үеийнхээ ярианы хэл нутгийн аялгууны дуудлагаар «хочорчуху» гэж ташааран тэмдэглээд хожим хадмал хятад орчуулга хийгчид «хочорху» (үлдэх хоцрох) гэж буруу ойлгоход хүргэсэн бололтой санагдана. Гэтэл халхын ярианы хэлэнд «дур гуцах» гэсэн үг байдаг нь чухамдаа дур гутах гэсэн утгатай байдаг тул худам монгол бичгийн хуучин эхэд нь лав «дур-а гутурчуху» гэж байснаар бодох байх үндэстэй юм. Учир нь энэ үгийн өөр хэлбэрийг худам монгол бичгийн эхтэй байсан гэх сэтгэгдэл төрүүлдэг түүхч Лувсанданзан «тэйин до ор-а хучуругсан-и» гэж бичсэн баримт уг эхэд ийм бичлэгтэй уг байсныг гэрчилнэ. Нөгөө талаар хуучин монгол бичигт «гутураху-гутурху» (12, 472б) гэсэн үг бүртгэгдсэн нь үүнийг давхар батална. Нөгөө талаар эрт цагт «хув-

тасу» гэж бичигдэж байсан үг хожим хубчасу хубцасу хувцас гэх зэргээр улиран хувьссан жишээ цөөнгүй байгаа нь энэ үг «гутурачуху гэсэн үг байж болохыг харуулж байна.

503. Кэжий-э тулуг (тулг-а) има-бэр-и (хэзээд түшиг түүгээр [и] болжу)-гэсэн энэ үгийг Лувсанданзан (31, I, 125) эхдээ оруулалгүй орхисон бөгөөд Хэниш (36, 42; 36, 155; 36, 82), Пеллио (9, 51), Лигети (33, 88), Рахевильз (25, 78) нар «эжи'э туруг има-'ар-и» гэж, Козин (14, 248), Дашцэдэн (26, 97) нар «эжиэ турук (~туруг) имаар -и» гэж, Баяр (11, II, 606), Иринчин (28, 137) «эжийэ туруг им-а бар-и болжу» гэж, Элдэндэй Ардажав нар «эжигэ туруг имагари» гэж тус тус сэргээсэн юм.

Харин эдгээр холбоо үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эдүгэ хүртэл тулгуур дэм, итгэл түүгээр болгож» (36; 42, 46, 155), (36, 82) гэж тайлаад энэ холбоо үгийг Хэниш (15, 58) Дамдинсүрэн (7, 133), Поуха (17, 93), Калужинский (61, 93), Кливз (42, 91), Дугаржав (24, 107) нар цөм ерөнхийдөө «одоо болтол түүгээр тулгуур болгож» гэсэн утгаар, нөгөө Пеллио «Аль хэдийнээс одоо болтол түүнд тулгуурлаж байгаад» (9, 181) гэж орчуулснаас гадна «эжийэ» гэснийг Мансан «эдүгэ» (27, 152), Элдэндэй Ардажав «эжигэ» гэж өөрөөр сэргээн Хуа йи йи Июй толь зааж «эдүгэ хүртэл», Лигетийг зааж «худ ураг барилдсанаас эдүгээгээс эгүри уртадаа» гэсэн санаатай гэснээс гадна бас «турук» гэснийг тулгуур гэх зэргээр олон утгатай түрэг үг (8, 483, тайлбар № 1, 2, 3) гэж тайлбарласан байна.

Бидний бодлоор энэ «эжий-э» гэдэг «кэжий-э» (хэзээнээс) гэсэн үг, нөгөө «туруг» гэгч «тулуг» (тулг-а) гэдэг үгийн өөр авиа сэлгэсэн дуудлага болов уу гэж төсөөлөн бодож байна. Учир нь энэ үг бидний бодлоор монголын түүхэн ойллого бичгүүдэд «тулг-а» «тариг» гэх зэрэг элдэв олон хэлбэрээр дайралддаг гэж хэлж болно. Жишээ нь: Лувсанданзаны «Алтан товчийн» дотор Зочийг кипчакуудын нутаг даруулан салгахдаа Богурчи ноёноор суяулсаны дараа Чингис хаан зарлиг болсон нь:

Эчигэ көбэгүн
Эе йагун (эегүн-эвдэрчү)
Эчинэ хола
Илэгэкү мэтү бусу
Эжэлэксэн-ийэн
Эжэлэгүл-үн
Хатагужигсан-ийан
Хадагалагул-ун
Нөгүгэ гэр
Өрүгэл бэйэ йүгэн

Тулг-а болган салгаму» (97, 113) гэж бичжээ. «Чинггис хаган-у чэдик» сударт «эм-э күн... уруг тариг ах-а дэгүүдү жокистай сайин» (5, 179) гэх буюу Лувсанданзаны «Алтан товчид» (31, II, 62) **«уруг тариг-тур** хүрчү одбасу» **уруг тариг** тур хүрч одбаас» гэх **мэт үг гардаг нь энэ «туруг»** гэдэг үгтэй холбогдолтой мэт буюу. Бидний таамаглаж байгаагаар бол тулуг, туруг, тариг гэгч чухамдаа олон овгийн үүсч гарсан «их овог» буюу эсвэл уруг худ бологчдын буюу эхнэрийн «овог» зэрэг овгийн хэн нэг хүнтэй харьцуулахад түшиг тулгуур болох нийтлэгийн нэр бололтой. Монголд «хүн ядарвал ургаа, тураг ядарвал уулаа» үүний хувилбарыг хар: (98, 84-а-б) гэсэн цэцэн үг ч ямар нэг талаараа холбоотой шиг санагдана.

504. Жөб-ү, таб-у (зөв, тов уу?)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 92), Козин (14, 249), Пеллио (9, 51), Лигети (33, 98), Рахевильз (25, 78), Баяр (11, II, 606—607), Элдэндэй Ардажав (8, 482), Иринчин (28, 137) **нар цөм л «жөб үү, таб у'у?» гэж,** Дашцэдэн «жөбүү табуу» (26, 97) гэж, Лувсанданзан «жөб-үү, таб-уу [буругу]» (31, I, 125) гэж тус тус сэргээжээ.

Үүний утгыг Хэниш «энэ зөв үү, эсвэл ямар вэ?» (36, 92) гэж зөв тайлаад «Хэзээнээс тогтворгүй хүн бөгөөд «үнэн биш үү, үнэн биш үү?» гэж тэр дандаа хэлдэг» (15, 58) гэж орчуулжээ. Үүнийг Пеллио «Жамуха хэлэндээ уян налархай. Тэр (үргэлж) зөв биш гэж үү? гэдэг байв» (9, 181), Кливз «үнэн үү, худал уу» (42, 91) Дугаржав «зөв буруу хэлж байна» (24, 107) гэж, Мансан «тэр дэмий зөв буруу үгүй чалчижу дураараа хэлж байна» (27, 152) гэж. Элдэндэй Ардажав (8, 484, тайлбар № 7) нар зөв гэгч мөн, зүйтэй, ёстой, оновчтой, зөв тал, нүүр тал, мөн сайн гэх мэт утгатай гэж, таб гэдэг нь тохирох, зохицох, нийлэмж, таарах, мөн сайн гэх мэт утгатай» гэжээ.

Бидний бодлоор бол энэ үг «зөв у тоб у?» гэсэн эртний монгол бичгийн үг бөгөөд «зөв үү, баттай юу?» гэсэн эргэлзэх бүтээлч сэтгэлгээний илэрхийлэл гэж үзэж байна. Ингэж бодох үндэс нь нэгд, Нууц товчооны 275 дугаар зүйлд «Ба бүрүн бусу һэлигэтү булха иргэн-дүр

морилаулдажу жөби таби болху болба кээжү бүкүй-дур» (26, 206) гэсэн өгүүлбэр тааралдана. Бид бодоҳдоо «зөв» гэдэг үнэн зүйд нийцэх, «тоб-маш тодорхой» 12, 597 а) буюу тодорхой, эргэлзээгүй гэсэн утгатай үг бөгөөд зөв үү? тобтой ху? (тодорхой юу?) гэсэн үг гэж төсөөлж байна. Учир нь «тоб-шийдвэр мэтийн» (12, 597 а) гэдэг үг нь чухамдаа хугацааг тодорхой тогтоох гэсэн утгатай. Иймд зөв (үнэн) үү, тоб (тов тодорхой) уу?» зөв бөгөөд яг тодорхой юу» гэсэн утгатай гэж бид бодном. Иймд энэ үгсийг урт эгшиг хараахан гараагүй эртний монгол бичгийн үед «жөб-ү, тоб-у» гэж бичиж байсан гэж төсөөлөн бодох үндэстэй гэж ийнхүү сийрүүлэв.

505. бэйэнгэдүн (биенгэдэн-биеэр)-гэсэн энэ үгийг судлагчид хятад үсгийн галигаас нь Хэниш «бэйэ (н) кэдүн» (36, 15) гэж, Қозин (14, 279) Лигети (33, 98), Рахевильз (25, 78) «бэйэн гэдүн» гэж, Пеллио «бэйэнгэдүн» (9, 51) гэж, Дашцэдэн «бээнгэдүн» гэж, Баяр (11, II, 607), Элдэндэй Ардажав (8, 482), Иринчин (28, 137) нар «бийэнггэдүн» гэж яльгүй ялгаатайгаар сэргээцгээсэн байдаг.
Энэ үгийн утгыг Лувсанданзан (31, 125), Дамдинсүрэн (7, 134), Хэниш (15, 58), Пеллио (9, 181), Поуха (17, 93), Қалужинский (61, 93), Қливз (49, 91), Дугаржав (27, 107), Мансан (27, 153), Элдэндэй Ардажав (8, 485, тайлбар № 10) тэргүүтэн цөм «өөрийн биеэр» гэсэн утгатай гэж орчуулсан буюу тайлбарласан нь эргэлзээгүй зөв юм.
Бид гагцхүү энэ үгийн бичлэгийг Элдэндэй Ардажавын иш татаж тайлбарласан «Чинггис хаган-у йэкэ өчик» дотор:

«Балар эртэн-ү хо(о)ртан дайисун-и
Бэйэнггидүн йабужу даругсан» (99, 76 а) гэж бичсэний

дагуу «бэйэнггидүн» гэж бичих нь илүү зөв гэж ингэж бичив. Учир нь энэ үгийн бүтцийг бид бэйэ (нэр үгийн идэвхтэй язгуур, I үндэс)$_{+}$нг (нэр үгээс нэр үг бүтээх дагавар) $_{+}$ги (нэр үгээс дайвар үг бүтээх дагавар)$_{+}$д (нэр үгээс үйл үг бүтээх дагавар)$_{+}$н (үйл үгийн нөхцөл үйлийн хам болох хэлбэрийн нөхцөл) буюу «бэйэ$_{+}$нг$_{+}$ги$_{+}$д$_{+}$үн» гэсэн бүтэцтэй үг гэж бодно. За$_{+}$нг$_{+}$ги$_{+}$д$_{+}$үн «занггидун» гэдэг үйл үг үүссэний загвараар бүтсэн болов уу гэж бид таамаглаж байна.

506. Бэлэ (бэлэ-эхэн)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 14), Қозин (14, 249), Пеллио (9, 51), Мостарт (47, 358), Лигети (33, 99), Рахевильз (25, 78), Баяр (11, II, 607), Дашцэдэн (26, 97), Элдэндэй Ардажав (8, 482), Иринчин (28, 38) цөм «бэл» гэж сэргээсэн байх бөгөөд Лувсанданзан ч (31, I, 125) бас ингэж бичсэн юм. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «тэрч байтугай, бас тэгээд, бүр тэгээд» (36, 14) гэж тайлсан тул Хэниш (15, 58), Қозин (14, 128), Пеллио (9, 181), Мостарт (47, 361 [77]), Қливз (42, 91), Элдэндэй Ардажав (8, 485, тайлбар № 11) нар цөм энэ утгаар «альхэдийн, тэр ч байтугай, бас тэгээд нэн ч» гэх мэт «сул үг» (28, 138, тайлбар № 3) гэж орчуулсан буюу тайлбарлажээ.
Утгын талаар энэ үгийг орчуулан тайлбарлагчдаас санал зөрөх шүүмжлэх зүйлгүй боловч бид энэ үгийг «бэлэхэн-э» гэсэн «үзтэл, бэлхэн одоо байгаагаараа» гэсэн утгатай хэрэглэгдэх үгийн «бэлэ» гэсэн эртний бичлэг мөн гэж бодох тул зүйгээр л бэл биш «бэлэ-худалдаа хийх хөрөнгө мэтийн» (12, 258) гэж бүртгэгдсэн үгтэй ижлээр бичиж сэргээх нь зөв гэж бодно. Нөгөө «бэл» гэдэг үг уулын налуу гэх мэт өөр утгатай бөгөөд энэ «бэлэ» (бэлэн) гэсэн үгийн сүүлчийн эгшиг XIV зууны үеийн дуудлагад балархайшин дуудлахаа байсан тул галиглагч нар «бэл» гэж арай өөрөөр сэргээжээ гэж бодно. Иймд энэ үгийг Ц. Дамдинсүрэн (7, 134), Мансан (27, 153) нар «одоо, эдүгэ» гэх мэт үгээр орчуулсан нь энэхүү «бэлхэнээ» гэдэг үгийн утгатай яв цав тохирно гэж бодож байна.

507. Өбэд-ийэн (өөрсдөө-өөрсдийгөө)-гэсэн энэ үгийг хятад-үсгийн галиглалаас нь Хэниш (36, 121), Пеллио (9, 52), Лигети (33, 100), Рахевильз (25, 79), Дашцэдэн (26, 98) нар «ө'эт-ийэн» эсвэл «өэд-ийэн» гэж, харин Баяр (11, II, 614), Элдэндэй Ардажав нар (8, 487), Иринчин (28, 139) нар «өбэд-ийэн» гэж сэргээн босгож утгыг нь өөрсдийгөө өөр-гэдэг үгийн олон тоо гэж ойлгож орчуулсан буюу тайлбарласан юм.

Харин энд худам (эртний) монгол бичигт энэ үгийг хожмын хуучин (сонгодог) монгол бичигт бичдэг болсны адил «өбэр» гэж бичээд түүнд олон тооны «с» буюу «д» нөхцөл залгахдаа эцсийн «р» авиаг хасч өбэ [-р] $_{+}$д$\sim$өбэ [-р]$^{+}$сү» гэсэн хоёр өөр хэлбэрээр бичигдэг болсон нь «Нууц товчооны» эхээс тодорхой. Сонирхолтой нь одоогийн монгол хэлэнд энэ үгийн «б» авиа сугарч түүний хоёр талын «ө э» авиа нь урагшлан ижилсэж өө [урт эгшиг] болоод дүрэм ёсоор орхигдог агсан «р» нь сэргэж «өөр» гэсэн ганц тоот хэлбэр болсон тул «өөрс» гэсэн үг бий болжээ. Энэ үгийн олон тоот хэлбэрийг орчин цагт «өөрсөд» гэх болжээ. Энэ тохиолдолд бидний бодвол эхний «с» нь олон тооны нөх-

цөл биш харин I бие заасан «сү» нөхцөл, II «д» нь олон тооны нөхцөл болов уу гэж төсөөлж байна.

508. бүчижү (бүчиж)-гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн эхээс нь Хэниш **(36, 20)**, **Қозин (14, 249)**, Пеллио **(9, 52)**, **Лигети (33, 100)**, Рахевильз (25, 79) Баяр (11, II, 616) Дашцэдэн (26, 99) Элдэндэй Ардажав (8, 488), Иринчин (28, 139) нар цөм санал нэгтэйгээр «бүчижү» гэж сэргээдэг бөгөөд үүний хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хүрээлэх, тойрох» (36, 20) гэж тайлжээ.

Энэ үгийг Хэниш (15, 59) Пеллио (9, 52) Қливз (42, 92) нар «тойрч» гэж, Дамдинсүрэн «хамарч» (7, 135), Дугаржав (24, 108), Мансан (27, 154) нар «бүслээд, бүслэж» гэж ерөнхийдөө зөв орчуулсан байна. Мөн Элдэндэй Ардажав нар (8, 487, **тайлбар № 9) энэ үгийг тойрох** хүрээлэх, бүслэх гэсэн утгатай гэж Мухаддимат толь зааж тайлбарлажээ.

Бид энэ үгийг монгол хэлний толь бичигт «бүчэ-оосор бүчийн» (12, 299а) гэж бүртгэгдсэн үгтэй утга язгуур нэгтэй төрөл үг гэж бодож байна. Энэ үгийн бү-язгуур дээр «чэ» залгаж юмыг «бүсэлж уях, оосор» гэсэн нэр үг, -чи дагавар залгаж тойруулж «бүсэл» гэсэн үйл үг, -сэ дагавар залгавал биеийг тойруулж ороох юмын нэр үг тус тус үүсгэдэг байжээ. Харин орчин цагийн монгол хэлэнд бүчи-гэдэг үйл үгийн үндэс нь мартагдсан учир «бүчих» гэхийг «бүчэлэкү» (12, 299а) эсвэл «бүсэлэкү» (12, 301б) гэж үүсмэл нэр үгээс дам үйл үг үүсгэж түүгээр хэлдэг болжээ.

509. Кисилик-э (Хишилигт)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 52), Лигети (33, 100), Рахевильз (25, 80), Баяр (11, II, 619), Элдэндэй Ардажав (8, 489), Мансан (27, 154), Иринчин (28, 140) нар цөм «Қисилиг-а» гэж, харин Хэниш (36, 179), Дамдинсүрэн 7, 135), Дугаржав (24, 109), Дашцэдэн (26, 99) нар «Қисилик-э» гэж сэргээсэн нь чухамдаа илүү зөв мэт санагдана. Учир нь Нууц товчооны бусад зүйлд (§66) ийм эгшлэг (К)-гээр төгссөн үгэнд өгөх оршихын «э» нөхцөл дагуулсан баримт байх тул «Қисилик-э» гэж сэргээх нь зөв юм. Харин хуучин (сонгодог) монгол бичигт ийм к (эгшлэгийн)-гийн дараа өгөх оршихын «э» нөхцөл дагуулахгүй буюу дагуулах тохиолдолд «тур-түр» гэсэн өөр нөхцөл хэрэглэх болсон тул Лувсанданзан үг эхийн Қисилик-э гэсэн бичлэгийг тэр журмаар өөрчлөн «Қисилиг-а» гэж бичсэн болов уу гэж санагдана. Эл учраас энэ эхийг зөвд тооцон Пеллио тэргүүтэн цөм Қисилиг-а гэж сэргээсэн мэт байх тул бид Қисилик-э гэж өөрөөр сэргээх нь зөв гэж бодно.

510. Арийал үгэй буй (эргэлзээгүй,)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 9), Қозин (14, 250), Пеллио (9, 53), Лигети (33, 101), Рахевильз (25, 80), Баяр (11, II, 624), Дашцэдэн (26, 100), Иринчин (28, 141), Элдэндэй Ардажав (8, 489) нар бүгдээрээ «арийал үгэй» гэж сэргээн сийрүүлдэг бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эргэлзээгүй», «гуйвалзалгүй» (36, 9) гэж тайлсан байна.

Энэ үгийг бас Лувсанданзан ч «арийал» гэж тодорхой бичсэн тул «эргэлзээгүй» гэсэн утгатай ийм үг хуучин бичгийн үг байгаад бараг бүрмөсөн мартагдсан бололтой гэж таамаглав. Энэ үгийг Хэниш (15, 60), Дамдинсүрэн (7, 136), Пеллио (9, 183), Қливз (42, 94) нар цөм «эргэлзээгүй» гэж Дугаржав (24, 109), Мансан (26, 100), Элдэндэй Ардажав (8, 489, тайлбар № 17) нар «сэжиглэх учир үгүй», «сэжиглэл үгүй» гэх мэтээр ойлгож орчуулсан буюу тайлбарласан нь цөм зөв.

Гэвч бид энэ өгүүлбэрийн бүтцийг бүх судлагчид буруу ойлгож ташаа орчуулсан гэж бодож байна. Бидний бодлоор бол энэ нь «сойорхбасу арийал үгэй буй» гэсэн оруулбар өгүүлбэрийг Чингис хааныг... бүчиж бария гэмээн үг барилдав гэв гэсэн өгүүлбэрийн дотор оруулж бичсэн гэж бодож байгаа юм. Учир нь энэ «соёрхбаас» гэсэн үгийг Монголын нууц товчоонд 16 удаа хэрэглэсний дотор 7 удаа үйлийн эзэнг дурдалгүй «соёрхбаас» гэж, 5 удаа хаан, анд би гэх мэт нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржсэн өгүүлэгдэхүүнтэй холбож хэрэглэсэн бөгөөд зөвхөн хоёр удаа «Алтан хааныг соёрхбаас, Чингис хааныг соёрхбаас» гэж **заахын тийн ялгалд хэлбэржсэн гишүүн өгүүлбэрийн** өгүүлэхүүнтэй холбож хэрэглэсэн байх бөгөөд харин бидний өгүүлбэрт байгаа шигтгол өгүүлбэрийн заахын тийн ялгалт шууд тусагдахуунтай хутгалдахаргүй тохиолд хэрэглэсэн байхын дээр энэ өгүүлбэрийн дотор мөн тэр хоёр удаагийн адил утгаар хэрэглэсэн гэж бүх орчуулагчид орчуултал «бүчиж (бүсэлж) барья» гэмээн үг барилдав гэв» гэсэн энэ өгүүлбэр нь утга төгсөөгүй, хэнийг барих гэсэн хэн барих гэж үг барилдсан зэрэг нь цөм тодорхойгүй болсон тул Пеллио зэрэг судлагчид «Бид бүчиж барья» гэж хамтаар хэлэлцэн тогтоосон» гэх мэт үгийг нэмж орчуулсан байв. Иймд бид энэ үгийг «Соёрхбасу эргэлзээгүй буй» гэсэн өгүүлбэрийг нөгөө Чингис хааныг... бүчиж барья гэмээн үг ба-

рилдав гэв гэсэн өгүүлбэрийн дотор оруулж бичсэн гэж бодож байна. Хожмын монгол бичгийн дотор үзэгдэхгүй болсон ийм оруулбар өгүүлбэр Нууц товчоонд цөөнгүй тохиолддогийн нэг нь бас үүнтэй төстэй (§80) «Модуд-и сумучи китугай (хутга) бар-ийан огтулигад мори-ийан халтаригулугад гархуй-луга, Тайижигуд сахижу ажугу, барижу авчу одба» гэсэн өгүүлбэр байдаг билээ. Энд чухамдаа «Тайижигуд сахижу ажугу» гэсэн нь «...гархуй-луга барьж авч одов» гэсэн өгүүлбэрийн дотор оруулсан өгүүлбэр болно.

511. Дори чохийу (дорвитой цохиюу)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 152), Пеллио (9, 54), Лигети (33, 103), Рахевильз (25, 81), Дашцэдэн (26, 101) нар «тойи жокийу» гэж, харин Козин «тоб жокийу» (14, 249) гэж сэргээсэн нь бодвол Лувсанданзаны эхэд «төб ~ түб» (31, I, 130) гэж бичсэнийг дагасан бололтой юм. Баяр (11, II, 633), Дугаржав (24, 111), Элдэндэй Ардажав (8, 494), Иринчин (28, 142) нар «той» гэж, Мансан «тоор жагсаал жокийажу» (27, 169) гэж тус тус сэргээж энэ «тойи» гэсэн үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «тулалдааны эгнээ» гэж «жокийу» гэснийг нь «тулалдааны эгнээ жагсаалаа журамтай хэвээр үлдээдэг» гэж тайлсан бөгөөд Пеллио (9, 184), Кливз (42, 96) нар мөн иймэрхүү утгатай үгээр орчуулсан байх бөгөөд Дугаржав (24, 111), «тогтоолтой жагсаал зохиож», Мансан «тоор жагсаал зохиож» гэж, Элдэндэй Ардажав нар «тойндоо оруулах (ёсоо дагуулах эрхэндээ оруулах) гэсэн утгатай гэж бидний бодлоор арай л өөр үгтэй хутгасан тайлбар өгчээ (8, 497, тайлбар № 17), Бид энэ үгийг «дор[б]и чокийу» гэсэн өөр үг байсныг хятад үсгийн галиг «дойи», «тойи» гэж авиа сэлгэлтийн хожим үеийн аялгууны хэлбэрээр ташаа тэмдэглэж нөгөө «чокийу» гэсэн үгийг «жокийу» гэж ташаа тэмдэглэсэн учир хожим хийсэн хадмал хятад орчуулгыг бас буруу болгоход хүргэсэн болов уу гэж төсөөлөн бодож байна. Ингэж бодох үндэс нь тойроҳ тутам (энэ үг анх тухай бүрд гэсэн утгатай хэрэглэгдэж байгаад «тусам» гэж өөр дуудлагатай болохын хамт «тухай бүрд улам илүү болох» гэсэн хүч нэмэгдүүлэх буюу лавшруулах утгаар хэрэглэгдэх болсон тул) энд тойрох бүрдээ улам илүү хүчтэй цохидог гэсэн утгаар хэрэглэсэн шиг санагдана. Хүн тутамд гэвэл хүн бүрд гэсэн утга гаргах атал тэгэх тусам гэвэл тэгж үйлдэх тусам илүү хүчтэй бөлох лавшрах гэсэн утга гаргадаг байна. Иймд тойрох (бүслэх) тусам дор[б]и-буюу дорбитой (илүү хүчтэй) цохидог гэсэн утга гаргаж байгаа мэт санагдана.**

«Дорби» гэж бичээстэй байсан үгийг Лувсанданзан «р» үсгийг нь «ө, ү»-гийн урт шүд гэж андууран төб буюу түб гэж бичсэн бол галигч нар дори буюу суларсан «б» авиаг орхиж дойи буюу дори гэж галигласан байж болох юм.

Хожмын үед дайсныг «бут цохив» гэж бичдэгтэй ойролцоо утгатай «дор[б]и чокийу» гэсэн үг байсан гэж бид төсөөлөн ийнхүү өөрөөр сэргээн тайлбарлав. Үүнд Дамдинсүрэн тойрч ирээд довтлон буудаг» гэж утгачлан орчуулсан нь бидний бодлоор утгын үүднээс оновчтой болсон гэж бодном. «Дори», «дойи» хоёр бичлэгийн тухайд гэвэл худам монгол бичигт р үсгээр тэмдэглэгдэж байсан авиа хожим XIV зууны үед «й» авиа болж сэлгэсэн жишээ Нууц товчооны эхэд олон байна. Жишээ нь Ханггархан-Хангайхан Хогулар-хогулай, дори-дойи, Тэмүдэр-Тэмүдэй г. м.

512. дэрэлэгү кү (дэрэлгэх)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 36), Пеллио (9, 54), Баяр (11, II, 633), Дашцэдэн (26, 101), Иринчин (28, 172)« дэрэлгүкү» гэж, нөгөө Козин (14, 250), Лигети (33, 103), Рахевильз (25, 81), Элдэндэй Ардажав (8, 494) нар «дэрэлгүкү, дэрэлгү гү, дэрэлкү кү» гэх мэтээр сэргээн босгосон байна. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «бүрэн эргэлт», «эргэлт» (36, 36) гэж тайлаад «бүтэн эргэлтийн үедээ эмх журмаа эвддэггүй» (15, 61) гэж орчуулсан нь Пеллио (9, 184), Кливз (42, 96), Дугаржав (24, 111), Мансан (27, 169), Элдэндэй Ардажав (8, 497, тайлбар № 18) нарын орчуулга тайлбарын үндэс болж өгчээ. Энэ үгийг Лувсанданзан «дэгэлкү» (31, I, 130) гэж өөрөөр бичсэн байна. Дамдинсүрэн «Ташаалдаж ирээд даран ордог» (7, 139) гэж орчуулсан нь Хэниш ба хадмал хятад орчуулгаас өөрөөр ухаарч утгыг зөв оновчтой, учир зүйд нийцүүлэн орчуулсан гэж бодогдуулж байна. Гол нь энд орчуулагч жокийу гэснийг «чокийу» гэж «дэрэлэкү кү» гэдэг үгийг «эргэх буцах» гэсэн үг биш, харин хажуунаас нь халдан довтлох гэж өөр өөр ойлгосон учраас «ташаалдаж ирээд даран ордог» гэж хэлсэн хэрэг юм. Иймд бид энэ «дэрэлэкү кү» гэсэн үгийн утгыг Я. Цэвэлийн толь бичиг зааж Элдэндэй Ардажав нарын тайлбарласан (8, 497, тайлбар № 18) шиг «дэс дараагаар ирэх очихыг» хэлсэн биш, харин С. Шагжийн толь бичигт «дэрэлэкү-дэрэ дэрэлэкү» (12, 666) гэсэн утгатай үг гэж бодов. Энд энэ үг «дайсанд халдаж, түшилдэн зууралдан байлдах» гэсэн шилжсэн утгаар хэрэглэгдсэн болов уу гэж төсөөлж байна. Учир нь «Нууц товчооны» өөр зүйлд (§205, 206) «Богурчи барагун гар-ун

Алтай дэрэлэгүн-ү түмэн мэдэтүгэй кэмэн жарлиг болба (25, 117) **гэсэн өгүүлбэрт гарч буй «дэрэлэгүн» гэдэг үг «Алтайн нурууг дэрлэж түшиглэн ойр хавьд нь б байгаа бүх газрын түмнийг мэд гэсэн утгатай нь илэрхий.** «Дэрэлэкү кү» гэдэг үг нь дайсны цэргүүд бие биеэсээ дэрлэж салж холдохгүй түшилдэн зууралдан байлдах гэсэн утгатай байж болох юм. Иймээс бид энэ үгийг дэрэ-(толгой дор ивж түшиглэх хэрэглэгдхүүн гэсэн утгатай нэр үгийн 1 үндэс) +лэ (нэр үгээс үйл үг **бүтээх дагавар) +кү (үйл үгийн үйлт нэрийн ирээдүй цагийн заах нөхцөл)** гэсэн бүтэцтэй үг бөгөөд «кү» гэсэн хүч нэмэгдүүлэх дагавар үг дагуулж «дэрлэх л тутам» (зууралдан тулалдах тусам, гэсэн утга илэрхийлсэн холбоо үг гэж ойлгож ийнхүү сийрүүлэв.

513. дэм чокийу (дэм цокиюу) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Козин (14, 250), Пеллио (9, 54), Лигети (33, 103), Рахевильз (25, 81) Баяр (11, II, 633), Дашцэдэн (26, 101), Элдэндэй Ардажав (8, 498), Иринчин (28, 142) нар «дэм жокийу» гэж, ганц Хэниш «дэн» гэж сэргээсэн юм. Гэвч бид «дэм чокийу» гэж сэргээх нь зүйтэй гэж үзэв. Учир нь Лувсанданзан энэ үгийг «дэм» гэж бичсэн тул худам **монгол бичгийн эхэд «дэн» биш «дэм» гэж байсан байх гэж төсөөлж байна.**

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш дэн-гэдгийг байрлах журам жагсаал» гэж «жокийу» гэснийг «журмыг нийцүүлэх» (36, 61) гэж тайлаад эргэж тойроход эгнээ жагсаалаа алддагүй хэвээр хадгалдаг (15, 61) гэж орчуулжээ. Пеллио (9, 184) Кливз (42, 96), Дугаржав (24, 111), Мансан (27, 169), Элдэндэй Ардажав (8, 498) нар ерөнхийдөө хадмал хятад орчуулгын утгыг дагуулж Хэништэй ижлээр орчуулсан буюу тайлбарласан байна.

Бид энэ үгийг «дэм жокийу» гэсэн үг бус, харин «дэм чокийу» гэсэн **өөр үг гэж ойлгож өөрөөр** сэргээхдээ хятад үсгийн галиглал ба хадмал хятад үгийн орчуулгад гагцхүү монгол бичгийн уламжлал ба утга судлалын үүднээс шүүмжлэлтэй хандахыг хичээсэн юм. Үүнд нэгд **«жокиху» гэсэн үг монгол хэлний найруулгад «сайтар зохих», «сайн зохих», «чамд зохих», «хувцас зохих» гэх мэт ямар нэг тэмдэг нэр буюу** эсвэл «юу юунд зохих» гэсэн үгтэй нийлэмжтэй атал харин «бут зохих», «хага зохих», гэх мэт үйлийн яаж болох дүр байдлыг заасан дайвар үгтэй нийлэмжгүй юм. Гэтэл «дори», «дэм» гэсэн хоёр үг бидний **бодлоор тийм дайвар үг мөн тул «жокийу» гэсэн энэ үгтэй утга найруулгаараа** нийлэмжгүй юм. Харин «хага цохих», «няц цохиэ», «бут цохих» гэх мэт үгтэй нийцтэй нь илэрхий учир үүнийг «дэм жокийу» гэсэн үг бус «дэм чокийу» гэсэн үг байх гэж бодлоо.

«Дэм-ая дэм-ийн», «дэмтэй-арга аятай» (12, 665 Б) гэх мэт энэ үгтэй «дэм» гэсэн дайвар үг утга нийцэхгүй бөгөөд харин «дэлбэ орох-дайсны сүрэгт дайран орох» (12, 668 б) гэх үгийн дотор гарч буй «дэлбэ» гэдэг үгтэй язгуур нэгтэй хуучирсан үг болов уу гэж бодож байна. Иймд **бид энэ үгийг**

«Тогориху тутам (бүслэн байлдах тусам)
Дори(Тойи) чокий-у (дорбитой чокиюу)
Дэрэлэкү кү тутам (Зууралдан байлдахдаа)
Дэм чокийу» (9, 54) дэлбэ (эсвэл дэндүү?) цохино.

гэсэн үг гэж ойлговол илүү учир зүйд нийцмээр санагдана.

514. Хатаг-и (Хатаг)-гэсэн Хэрээд аймгийн энэ баатарын нэрийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 176), Пеллио (9, 54), Лигети (33, 103), Рахевильз (25, 81), Дашцэдэн (26, 101) цөм «Хадаг» гэж сэргээжээ. Хэдийгээр хуучин монгол бичгээр сэргээн бичсэн Баяр (11, II, 634), Мансан (27, 170), Дугаржав (24, 111), Иринчин (28, 142), Элдэндэй Ардажав (8, 494) нар энэ үгийг чухам «хатаг» «хадаг» хоёрын алинаар сэргээснийг мэдэхэд бэрх боловч **Лувсанданзан энэ үгийг «Хатан-и»** (Хадан гэж уншиж болох боловч) (31, I, 130) гэж бичсэн хийгээд Дамдинсүрэн «Хатаги-баатар» (7, 140) гэж, Баяр «хатагин-и» (11, II, 634) гэж, Мансан «Хатагин-ийар» гэж тус тус сэргээн бичсэнээр үзвэл энэ судлагчид энэ үгийн дундах «д» гийгүүлэгчийг «т»-гээр уншсанаар барахгүй Хатагин овогт гэж ухаарсан бололтой. Бидний бодвол энэ хүний нэрийг «Хатаг» гэж унших нь зөв мэт. Учир нь «Хадаг» гэж уншвал энэ үг «хада» (чулуун) гэсэн үндэстэй байж болох боловч түүнээс Хадан гэж тэмдэг нэр үүсгэж болох хэдий ч тэмдэг нэрээр хүнийг тэгж нэрлэх нь ховорын дээр «Хада» гэж нэртэй хүн эх бичигт бас тохиолдох ба хада (нэр үг)+г (дагавраар энэ мэт үг бүтээгдэггүй тул энэ үгийг Хата гэсэн үйл үгэнд «г» дагавар залгаж «Хатаг» буюу хатуужилтай, «хатан» (хат бүхий төмөр буюу ган) гэсэн нэр үүсгэж болмоор юм. Энэ нь жиру+г (зураг), буда+г (будаг) гэх мэт загвараар бүтээсэн нэр байлтай санагдана. Хатаги гэж сэргээх нь Хэнишийн сэргээсэнтэй адил боловч «Хадаг+и» гэж Пеллиогийн адил заахын тийн ялгалын нөхцөлөөс нь ялгаж «Хатаг-и тусийалдун» гэж сэргээх нь илүү зөв мэт санагдана. Хадаг-ёслолын юм гэж Поуха (58, 94) тайлбарласан ч төдий л үнэмшилтэй биш үг болно.

515. Ачиг-Сирун (Ачиг Шорон (шор)-гэсэн энэ хүний хоч нэрийг хятад галиг үсгийн галиглалаас нь Хэниш (36, 172), Дамдинсүрэн (7, 140), Поуха (17, 100), Лигети (33, 103), Рахевильз (25, 81), Баяр (11, II, 635), Дугаржав (24, 111), Мансан (27, 170) нар цөм «Ачиг Ширүн» гэж сэргээгээд утгыг гагцхүү Элдэндэй Ардажав (8, 499, тайлбар № 23) түрэг хэлний «ачик» (уур хилэн), ширүн (ширүүн) гэсэн үг гэж тайлбарласан байна. Лувсанданзан «Начин ширун» (31, I, 130) гэж монгол үгийн утгыг нь олох гэсэн зөв эрмэлзэл илэрхийлжээ.

Бид энэ үгийг заавал түрэг хэлний үгээр монголчууд **өөрсдийгөө хоч** нэр өгч байсан гэж үнэмшихгүй тул **«Ачиг Ширу(н)»** гэсэн **монгол нэр** байж магадгүй гэж бодно. Тэгж үзвэл ачи-гэсэн үйл үгэнд «г» дагавар залгаж ачих хэрэгсэл «ачиг» гэж юмын нэр үүссэн байж болохоос гадна Сирун буюу Ширу-гэдэг нь Шор гэсэн үг байж болох юм. Тэмээний хоёр талын ачаа тэнг хоёр бүхний нь хоорондуур гогцоонд Шороор чагталдан тогтоодог тул «Ачаны Шор» гэсэн хочтой хүн байсан гэхэд «ууртай ширүүн» гэсэн түрэг хэлний үгээр нэрлэгдсэн хүн байжээ гэснээс илүү үнэмшилтэй гэж бодно. Энэ хүний нэрийг Рашид-ад-Дин «Аджик-Ширун» (4, 1, 1, 128) гэж тэмдэглэсэн юм. Түүнээс гадна эхний үг нь нэгд «ача-хоёр салаатай мэтийн» (12, 30б), «ачуг-үсгийн шүд, хөлс» (12, 31б) зэрэг үгтэй холбоотой гэж бодвол «ац шор» буюу «ацаг хөлсний шор» эсвэл бусдын төлөөнөөс хөлсөөр жингийн шор болдог гэсэн үг байж болно. Учир нь жинтэй холбож аливаа хүн өөрийн үүргээ биелүүлэх, ажлаа дуусгах гэсэн утгаар «Шор мултлах» гэсэн өвөрмөц хэллэг монгол хэлэнд ч байдаг.

516. ту [гу] рх-а [г] уд (туурга цэргүүд буюу торгон цэргүүд) гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галиг эхээс нь Хэниш (36, 155) Пеллио (9, 54), Лигети (33, 103), Рахевильз (25, 82), Баяр (11, II, 635), Дашцэдэн (26, 102), Элдэндэй Ардажав (8, 494), Иринчин (28, 143) нар «турха'ут-и», «турхаг-уд-и» гэж сийрүүлэн сэргээсэн байхаас гадна Лувсанданзан «турхур-ун» (31, I, 130), Мансан «торгуд» (27, 170) гэж сэргээгээд сүүлчийн зохиогч VI бүлгийн 5 дугаар тайлбарт (27, 188—189) «торгуд» «дөрбөд» гэдэг гол цэрэг гэсэн үг бус «Энэ нь лав Хэрэйдтэй нэг овог угсагааны «Ван ханы мянган торгуд» болай (27, 189) гэжээ. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «бие [хүний] хамгаалагч» (36. 155) гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 62), Кливз (42, 96), Дамдинсүрэн (7, 140), Дугаржав (24, 111) нар «торган цэрэг» (шадар цэрэг) гэжээ.

Бидний бодвол энэ «турхаг-уд-и» гэдэг нь худам монгол бичигт «тогурга (туурга) цэрэг» гэж бичдэг үгийн худам монгол бичигт «тохургa» гэж бичдэг байсан үгийг XIV зууны үеийн монгол хэлний нэг нутгийн аялгуугаар тэмдэглэсэн ташаа бичлэг гэж бодож байна. Ингэж бодох үндсийг Нууц товчооны худам монгол бичгийн эхтэй байсан болох нь ажиглагдаг Лувсанданзаны «Алтан товч»-ид «Тэмүжин хажар-тур уругу унана хэбтэжү машин хасалхуй-дур Хонгхотан-у Чараха сэргүгэн өгүлэгсэн ажуху:

«Тулу жигасун мэтү йакин
Тулбарин гасаламуй чи
Тохурх-а **чэрик йүгэн**
Бэкилэй-э эсэ кү кэмэлдүлүгэй үү?» (31, I, 32)

гэж бичсэний дотор тохурх-а чэрик бол даруй турхаг-уд→турха-уд→торгон цэрэг гэх зэргээр хувирч ирсэн бололтой юм. «МНТ»-ы 124 дүгээр зүйлд Чингис хаанд Сүбэгэдэй баатрын өгсөн тангаргийн үгэнд:

«Нэмбэгэ (нэмнэгэ) исгэй болжу
Нэмүрлэлдүн сорису
Гэрисгэ исгэй болжу
Гэр жүк гэрисгэлэлдүн сорису кэмэбэ» (9, 33) гэсэн үгс

гарч байгаагаас ч үзсэн эзний биеийг дайсны сумнаас **исгий** туурга мэт хамгаалдаг шадар цэргийг эртний монголчууд «тохург-а цэрэг» гэж хэлдэг, бас худам монгол бичгээр бичсэн эхэд нь «тохурх-а[г]-уд» гэж бичээстэй байсан гэж санамаар санагдана. Харин энэ үгийн дуудлага нь toһурх-а[г]уд→тоурх-а(г)уд→турха'уд гэх зэргээр улирч хувирч ирсэн болов уу гэж санагдах бөгөөд XIV зууны үед галигч нар мөнөөхөн «тухурх-а(г)уд» гэж бичээстэй байсан үгийг өөрийн үеийн нутгийн аялгууны дуудлагаар «турхаг-уд-и» гэж тэмдэглүүлсэн гэж бодном.

517. Хори Сирэмүн (Хури Ширмэн)-гэсэн энэ хүний нэрийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 177), Дамдинсүрэн (7, 141), Пеллио (9, 54), Поуха (17, 101), Лигети (33, 103), Рахевильз (25, 82), Баяр (11, II, 635), Кливз (24, 111), Мансан (27, 170), Дашцэдэн (26, 102), Иринчин (28, 143) нар цөм «Хори Шилэмүн тайижи» гэж монголоор сэр-

гээдэг **бөгөөд** хүний нэр тул үүний ямар утгатай үг болохыг хэн ч **төдий л сонирхоогүй билээ.**
Лувсанданзан энэ үгийг «Хори Шилмүн» (31, 130), Элдэндэй Ардажав (8, 494) **«Хоришилэмэн тайижи» гэж тус тус арай өөрөөр** сэргээсэн **байдаг.**
Гэвч энэ үгийг Хори Ширэмүн гэсэн үг байсныг XIV зууны үеийн галиглагч **нар «р» авиаг нь «л» авиагаар сольж ташаа** тэмдэглэсэн **байх гэж бодож бид ийнхүү** сэргээн **сийрүүлсэн юм.** Ингэж бодох **үндэс нь** гэвэл нэгд, «Юван улсын судар»-ын 120 дугаар дэвтрийн монгол орчуулгын гар бичмэл эхэд бичсэн нь «Жө[р]чидэй» жарлик-и кулийэжү данг морин ийар жигсагал-и эбдэжү Сийан-гүн (Сэнгүм-Ш. Г.) **-и харбужу алагад тэгүн-ү йэкэ жангжун Сирмэн, (зөв нь Ширэмүн** Ш. Г.) нар-и дагагулугад даруй киуэи Лиуэй гажар-и хамтудхан **олжухуй»** (52, 20а, боть № 120) гэж бичсэн явдал болно. Хоёрдугаарт Юван улсын хаадын удмын дотор «Ширэмүн» гэдэг нэртэй хүн тааралддаг юм. Жишээ нь Өгэдэй хааны нэг ач **нь Ширэмүн гэж нэртэй** хүн байв. Жич Монголын нууц товчоонд «ширэмү ширэмүн» гэсэн үг **(§195)** нэр гардаг зэргээс үзвэл энэ нь Шилэмүн бус «Ширэмүн» гэсэн үгийг XIV зууны үеийн монгол хэлний аман аялгууны дуудлагаар гажуу тэмдэглэгдсэн гэж бодохоор байна. Учир нь энэ үгийг Рашид-ад-Дин ч (4, 1, 2, 125 ба 1, 1, 133) мөн Нууц товчооны адилаар «Шилэмүн» гэх буюу «Силиун тайши» гэж бичсэн баримт 14 дүгээр зууны монгол хэл аялгууны гажуу дуудлага байсныг гэрчилж байна.

518. дүли-(д)-э (туршдаа, туушдаа)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 32), Козин (14, 251), Пеллио (9, 55), Лигети (33, 103), Рахевильз (42, 96) нар «дүлэт» гэж, Баяр (11, II, 637, Дашцэдэн (26, 102), Элдэндэй Ардажав (8, 494). Иринчин (28, 143) **нар «дүлэд» гэж сэргээн сийрүүлсэн нь бидний бодоход арай ташаа** сэргээлт шиг санагдана.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш **«тэгэх тусмаа» (36, 38), Кливз (42, 96) «бүр ч», Дугаржав (24, 112) «үүгээр үзвэл», Мансан «хараахан»** (27, 171), Элдэндэй Ардажав «нэн улмаар» (8, 499, тайлбар № 27) гэж тус тус орчуулсан нь утгыг төдий л оновчтой зөв **ойлгож чадаагүй** мэт бидэнд санагдана.
Бидний бодлоор бол энэ үгийг Лувсанданзан «дүлэдэ» (31, I, 131) гэж сэргээсэн нь «туршдаа, туушдаа, яваандаа» гэсэн утгатай дайвар үг гэж ерөнхийдөө зөв чиглэлтэй ойлгосон бололтой санагдах тул бид энэ үгийг дүли (шөнө дүли) гэх мэт үгийн үндсэнд өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаж дайвар үг бүтээхэд эгшгээр төгссөн үгийг эгшгээр эхэлсэн э нөхцөлөөс нь салгаж д гийгүүлэгч **жийрэглэсэн тул** дүли-[д]-э гэсэн дайвар үг бүтээжээ гэж бодож байна. Дүли-д-э гэсэн энэ үг нь **«туршдаа, туушдаа, уртаашаа, яваандаа»** гэсэн утга илэрхийлсэн бололтой. Энэ үгийн үндэс монгол хэлний толь бичигт **«дүли-өдөр, шөнө дүл зэргийн»** (12, 698а) гэсэн үгээр бүртгэгдсэн гэж санана.м.

519. до[о]рахан-[а] (до[о]рхан-а)-гэсэн энэ үгийг хятад үгсийн галигаас нь Хэниш **«доло'ун»** (36, 37) гэж, Пеллио (9, 55), Лигети (33, 103), Рахевильз 25, 82), Баяр (11, II, 637), Дашцэдэн (26, 102) гэж, Элдэндэй Ардажав (8, 494) нар «дорогун» гэж, Баяр, Иринчин (28, 143) хуучин монгол бичгийн маягаар **«до[о]ру-гун» буюу «до[о]рохун» гэж тус тус сэргээн сийрүүлснээс хамгийн ойртуулсан нь сүүлчийн хоёр судлагчийн сэргээлт болно гэж бодож байна.**
Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «далдуур» (36, 37); **15, 62) гэж тайлжээ. Энэ учраас энэ үгийг Дамдинсүрэн (7, 140),** Пеллио (9. 185), Поуха (17, 100), Калужинский (61, 100), Кливз (42, 96), Дугаржав (26, 112), Мансан (27, 170), Элдэндэй Ардажав (8, 500, тайлбар № 30) нар цөм хадмал хятад орчуулгыг дагаж «далдуур» гэсэн үг гэж **ойлгож орчуулсан буюу тайлбарлажээ.**

Энэ үгийг Лувсанданзан «дорахун» буюу эсвэл «дорхад» гэж уншиж болохоор бичсэн байгаа баримт болон үгийн утга судлалын үүднээс «до[о]ра-хан-[а]» (дорхан-а-даруй) гэсэн утгатай үг байсныг XIV зууны үеийн аман ярианы хэлбэрээр нь «дорухун» гэж ташаа галигласнаас хожим хадмал болон товч хятад орчуулга **хийгчид «далугун» буюу «далд»** гэсэн үг гэж андуурсан мэт санагдана. Ингэж бодох үндэс нь «до[о]р-а» до[о]р» гэсэн утгатай үгийн үндсэнд «хан» гэсэн дагавар залгаж хугацааны утгаар хэрэглэсэн утга найруулгад тохирхоос гадна Лувсанданзан энэ үгийг до[о]ра (о авиаг у авиагаас ялгах зорилгоор худам монгол бичигт давхарлан бичсэн дараалсан хоёр О үсгийг аман аялгуугаар тэмдэглэсэн учир «дор» гэж дууддаг) үгээс үүссэн гэдгийг нь тааварлаж а эгшигтэй бичсэн гэж бодох үндэстэй байна. Нөгөө талаар орчин цагийн монгол ярианы хэлэнд «тэр дороо» (даруй) дорхноо (дав даруй) гэсэн утгаар хэрэглэгддэг баримт ийм утгатай

«до[о]р-хан[-а]» гэдэг үг байж болохыг харуулж байна. Эсвэл энэ үг «до[о]р-а хун» гэж бичээстэй байсныг Лувсанданзан «дорхад» гэж уншиж бичсэн ч байж болох юм.

Ямраар ч бодсон Жамуха дав даруйхан Чингис хаанд хүн явуулж хэл хүргэсэн гэсэн утгаар ойлгох нь «дологун ~ доругун» (далдуур) гэсэн үг гэж ойлгохоос арай илүү утгандаа нийцнэ гэж бодож байна.

520. тумбулан (голлон, тумбалан)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 154), Пеллио (9, 55), Лигети (33, 101), Рахевильз (25, 83), Баяр (11, II, 638), Дашцэдэн (26, 102), Элдэндэй Ардажав нар (8, 494), Иринчин (28, 143) нар цөм «тумбулан» гэж сэргээн босгосон байна. Сонирхолтой нь ганц Лувсанданзан ганцаар «тумбилан» (31, 131) гэж сэргээгээд дэргэд нь «сэрэл тэй кэмэн» гэсэн үг бичсэнийг энэ үгийг тайлбарласан гэж санаж болмоор ажээ. Гэвч энэ нь бас «сэрэлтэн иргэн тэд буй» гэсэн үгийг нэмэлт оруулбар засвар хийх гэсэн зүйл ч байж магадгүй юм.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «анхдугаар зүйлд тавих» (36, 154) гэж тайлаад герман хэлэнд «дээд зэргээр үнэлдэг» (15, 64) гэж, Дамдинсүрэн (7, 140), Пеллио (9, 185), Дугаржав (24, 112), Мансан (27, 170), Элдэндэй Ардажав (8, 500—501), Иринчин (28, 144, тайлбар № 5) нар бүгдээр «толгойлуулах, тэргүүлэн, тэргүүнд» гэж, Калужинский (61, 100), Кливз (42, 96) «нэгдүгээр байранд» гэж, эцэст нь Поуха «хамгийн их, юу юунаас илүү» гэж тус тус орчуулснаас энэ сүүлчийнх нь уг утгад хамгийн их ойртуулсан орчуулга болсон шиг байна.

Бид энэ үгийг тумб-(тувт-шувт гэсэн утгатай дайвар үгийн үндэс)+ла (дайвар үг нэр үгээс үйл үг бүтээх дагавар)+н (**нөхцөл** үйл үгийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй «үргэлж, голлож» гэсэн утгатай монгол үг мөн гэж бодож байна. Ингэж бодох үндэс нь хэдийгээр ойр зуурын толь бичигт бүртгэгдээгүй боловч Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ард түмний хэл аялгуунд хадгалагдан үлдсэн «тумбу» «тувта» гэдэг үг «үргэлж, голлож» гэсэн утгатай байгаа тул энэ үгийг бид «тубта» буюу «тубту» гэж бичдэг үгтэй гарал үүсэл утгын холбоотой гэж үзэж байна. Энэ учраас бид энэ үгийг туб+та (ямагт, үргэлж, гол төлөв) гэсэн үгээс авианы хувислаар «тумба») гэж хэлэгддэг болж улмаар түүн дээр ла (үйл үг үүсгэх) дагавар залгахад хувилгах хувилах эгшгийн дүрмээр «тумбулах» гэсэн үг үүссэн гэж үзэж байгаагаа тайлбарлая.

521. учимаг-ийар (учмагаар) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «учумаг» (36, 158), Пеллио (9, 56), Лигети (33, 107), Рахевильз (25, 85), Баяр (11, II, 661), Дашцэдэн (26, 106), Элдэндэй Ардажав (8, 508), Иринчин (28, 148) нар бүгдээр «учма'ар буюу учумабар» гэж сэргээн босгосноос ерөнхийдөө зөв юм.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «харвах маяг», «сумны нэг зүйл» (36, 158) гэж тайлаад герман хэлэнд «нэг зүйл сумаар хацраа харвагдаж» (15, 64) гэж, Дамдинсүрэн (7, 143), Пеллио (9, 187), Поуха (17, 103), Кливз (42, 100), Дугаржав (24, 115), Мансан (27, 173), Элдэндэй Ардажав (8, 509, тайлбар № 2) цөм «учум-а гэдэг суманд шархадсан» гэж орчуулсан буюу тайлбарласан байна. Энэ үгийг Лувсанданзан «учужу манагар» гэж энэ үгийг хоёр салган бичсэнээс үзвэл энэ үг учум-а биш «учумаг-ийар» гэсэн үг байсан нь илэрхий тул Хэниш гуайн сэргээлт илүү ойртуулсан гэж бодох үндэстэй байна. Иймээс бид энэ үгийг учи-(гэсэн үгийн идэвхгүй язгуур)+маг (үйл үг, нэр үгийн үндэснээс нэр үг үүсгэх дагавар)-ийар (нэр үгийн үйлдэхийн тийн ялгалын нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж хэлж болно. «кирмаг-часу маш бага орсон цас» (12, 370б), «эдмэг-нэгэн зүйл тэжээл» (12, 66б), «уужимаг-эхнэрийн хувцас» (12, 152б) гэх мэт үгсийн загвараар энэ үг бүтсэн нь ил байна. Энэ үгийн дуудлага халхын аялгуунд ц биш ч хэвээр уламжлах ирснийг бодвол тэр үгийн үндэс учу биш учи байсан гэж төсөөлж болох бөгөөд ингэж үзвэл учиг гэдэг (утасны үзүүр) үгтэй нэг гаралтай болно. Энэ нь зүү **тэвнэ** мэт хурц нарийн шөвх үзүүр (учиг) гилбэр бүхий сум байсан гэж бодох үндэстэй. Учир нь энэ сумаар хацраа харвагдсан Сэнгүмийн тухайд «хайран хөвгүүний минь хацарт «хадагасун хадагулба» (§174) гэж Ун хан хэлсэнээс энэ нь илэрхий байна.

522. Силугудхуй-у (шулуудахуй уу?)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 76), Пеллио (9, 57), Мостарт (47, 340 [90]), Лигети (33, 107), Рахевильз (25, 85), Баяр (11, II, 661), Дашцэдэн (26, 106) нар цөм «**h**илухадху-йу» гэж сэргээн сийрүүлжээ. Харин Иринчин «илухадхуйу» (28, 148) Элдэндэй Ардажав нар «силугадхуйу» (8, 508) гэж сэргээснээс сүүлчийн хоёр судлагчийн сэргээлт илүү ойртсон гэж бодогдмоор байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хөөрөх» (морьтны хатгалдаан) (36, 76) гэж тайлаад «хөөрцөглөхгүй газар хөөрцөг-

лөв үү?» (15, 64) гэж, Козин «дэндүү ихэмсэглэн гайхуулагч их аюулд өртөгдөх» (14, 132) гэж, Пеллио «хөөрцөглөх чадах мэтэд хөөрцөглөв үү?» (9, 187) гэж, Мостарт «хөөрч болох ёстой мэт нөхцөл байдалд хөөрсөн үү?» (47, 342 [92]) гэж, Кливз «Бид түүнийг дэвэргэх хэргэтэй юу гэж өөрснөөсөө асуугууштай яг тийм цаг мэт» (42, 100) гэх мэтээр ойлгож орчуулсан шиг санагдана. Энэ үгийг Дугаржав «тэмцэхгүйд тэмцэх болон» (24, 115), Мансан «дайлж үл болох дайсантай дайралдаж» (27, 173). Ганцхан Элдэндэй Ардажав нар энэ үгийг силугатхуй-у гэж их ойртуулан галигласан байтлаа илугатхуйу гэмээх хадмал орчуулгад «халдах» гэмээв гэж II үгийн нь тайлбартай хутгаж ташаа заасан мэт санагдана.

Бид энэ үгийг «силугутхуй-у мэтү-дур шилугутба» гэсэн эрэслэн шийдэх үү мэтэд эрслэн шулуудав уу гэсэн утгатай гэж бодож байна. Учир хятадаас орчуулсан ном зохиолын «h» буюу хөндий х-гээр бичсэн зүйлийг с авиагаар сольж бичих жишээ цөөнгүй байдаг. Жишээ нь «hийан ~ Сийан» гэх мэт.

Иймд энэ үг бол силугу («шулугу-хүн юмны цэх шударга мэтийг» [12, 848] гэсэн утгатай нэр үгийн үндэс)+д (нэр үгээс үйл үг бүтээх дагавар)+хуй (үйл үгийн үйлт нэрийн үндэс бүтээх нөхцөл)+ -у (асуух утга оруулах сул үг дагуулсан) гэсэн бүтэцтэй бөгөөд «шулугудхушлуун болох» (12, 848б) буюу гуйвалтгүй эрс шулуун шийдэх гэсэн утгатай үг болох нь эргэлзээгүй байна.

523. йилбис-үн чалм-а (илбэсэн чалм-а)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигчиллаас нь Хэниш (36, 43), Пеллио (9, 57), Лигети (33, 107), Рахевильз (25, 85), Баяр (11, II, 664), Дашцэдэн (26, 105) нар цөм «элбэсүн жалам-а» гэж ижлээр сэргээдэг байна. Тэгээд энэ үгийн хадмал хятад орчуулга байхгүйг дурдаад «арга чарга илбэ өчил хийж» (15, 64) гэж, Пеллио «хүүгийн хутаг гуйхдаа далд нууцын илбэ хуйлаас зангиа хийж» (9, 187) гэж, Поуха «төрөөгүй хүүг олох гэж мөргөл өчил хийж» (17, 108), Калужинский «илби увдис гүйцэтгэж» гэж орчуулсан шиг бидэнд таамаглагдаж байна) (61, 102), Кливз «эчнээ хүүг эрин өчил залбарил хийж» (42, 100) гэж орчуулсан бололтой. Дугаржав «илбэ увдис гаргаж» (24, 116), Мансан (27, 191, тайлбар № 11), Элдэндэй Ардажав (8, 510, тайлбар № 7 ба № 8), Иринчин (28, 149, тайлбар № 3) нар цөм түрэг хэлний элбэсүн жалма гэдэг ид шидийн тахилга залбирлын ёслол, модонд уях цаас, хиур дарцаг гэх мэтээр хятад орчуулгын утгыг дагуулж тайлбарласан юм.

Бид эл хоёр үгийг түрэг хэлний мэдлэг ихт хүн галиглаж тэр түрэг үгэнд ойртуулан хятад үсгээр ташаа тэмдэглэж, хожим бас хадмал ба товч орчуулгад түрэг үгний утгаар тайлбар хийснээс ийм болсон гэж үзээд уг үгийг худам монгол бичигт «йилбис-үн чалм-а» гэсэн монгол үг байсан гэж төсөөлөн ийнхүү сийрүүлээд утгыг нь йилбис-үн (олон илбийн) арга чарга» хийв гэсэн үг гэж ойлгов. Учир нь монгол хэлэнд хөндий «в» авиа гарснаас хойш «йэлви» гэж бичих болсон энэ үгийг энэхүү хөндий «В» авиа гарахаас өмнөх худам монгол бичигт «илби» гэж түрэг хэлний «элби» (8, 510) гэдэг үгтэй ойролцоо дуудлагатайгаар бичиж байсан гэж таамаглав. Нөгөө «жалам-а» гэснийг худам монгол бичигт «чалм-а дэгэсү-бөгэ нар ун» (12, 749), «чалм-а огтулху-бөгэ нар-ун арг-а» (12, 748) гэж орсон «чалм-а» гэсэн үг мөн гэж үзнэ. Энэ үг нь монгол хэлний «чалик-онгод чалик ун» (12, 748б), мөн «арга чарг-а» гэдэг хэлц үгийн «чарга» гэх мэт үгстэй утга багарал нэгтэй гэж санана.

524. Эбэй абай (эвий бүүбэй)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 2), Лигети (33, 107), Рахевильз (25, 85), Баяр (11, II, 664), Дашцэдэн (26, 106), Элдэндэй Ардажав (8, 508), Иринчин (28, 148) нар «абуй бабуй» гэж, Пеллио «а бүй, ба бүй» (зөв нь: а буй, ба буй) (9, 57), Поуха (17, 103), Мансан (27, 174) нар «абай бабай» гэж сэргээн сийрүүлжээ.

Энэ үгэнд хадмал хятад орчуулга үг үгүйг дурдаад Хэниш (15, 64), Поуха (17, 248) нар «абай, бабай» гэсэн «сийрийн христосын несторийн чиглэлийн шашны өчил залбирал» гэж тайлбарлан орчуулсан байна. Кливз (42, 100) «[тэнгэрт] Абуй Бабуй» гэж залбирал өчил хийдэг» гэж, Иринчин бас энэ үгийн тайлбарт залбирах үгс уншдаг ямар нэг тарничилсан дуудлага эркүүдийн (несторийн) шашны номлолтой холбогдож мэднэ» (28, 149, тайлбар № 4), Мансан «Козин, Элдэндэй Оюундалай нарын өрөвдөх гашуудах энэрэгсэн хөөрхийлснийг илэрхийлсэн буюу хөгшдийг хүндэтгэх аялгуу үг гэснийг эргэлзээд П. Поухын тайлбарыг зөвшөөрөн урдах хойдох үгийн найруулгаас үзвэл шашин шүтлэгийн үг болох нь илэрхий. (27, 192), Дамдинсүрэн «энэлүн гаслан залбарижу» (7, 144) гэж, Дугаржав «эвэй хөөрхий» (24, 116) гэж тус тус ойлгож орчуулсан байдаг.

Бидний бодоход «эбэй абай» гэсэн монгол үг мөн болов уу гэж бодохын үндэс гэвэл нэгд «МНТ»-ы худам монгол бичгийн эхтэй гэгддэг

Лувсанданзан энэ үгийг «эбүр ба буй» гэж бичсэн нь эхний үг «абуй» биш «эбэй» гэсэн монгол үг байсныг гэрчилнэ. Хоёрт «иэлбисүн» гэсэн үгтэй «абуй» гэдэг үг биш «Эбэй-энэрикүй-дүр гаргаху айалгу» (12, 52) гэсэн үг шүлгийн толгой холбоц бүтээж чадах учраас «эбэй» гэж байсан байх гэж бодно. Гуравт, энэ абай гэдэг үг бол мал зал гэдэг шиг авиа давталт хос үг тул зөвхөн энэлэх өрөвдөхийн аялга үг мөн. Харин «абай-агсан, хүүхэд хуурах аялгуу» (12, 4б) гэсэн үг биш бололтой. Эл бүх учир шалтгааныг тунгаан бодвол «абуй, бабуй» гэсэн галиглал бол XIV үеийн аман аялгууг дагасан алдаатай тэмдэглэл гэж сэжиглэмээр санагдана.

525. **эдүн төрэн барагсан** (өдөн төрөн барсан)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Ардажав, Иринчин цөм «эдүн» гэж ав адилхнаар санал нэгтэй сэргээн босгож сийрүүлсэн бөгөөд зөв ч байх.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эдгээр эд олон, эд хос» (36, 41) гэж тайлжээ. Тэгээд Хэниш «тэр дараа нь адаг сүүлд нь төрчихсөн» (15, 64), Пеллио «хэдийн төрөн дуссан» (9, 187), Поуха «эцэстээ нэгэнт төрүүлсэн (?) хүү» (17, 103), Клливз «нэгэнт төрчихсөн хүү» (42, 100), Дугаржав эдүгээ болбоос төрж гарсан хүү» (24, 116), Мансан «Эдүгээ бид харин заяаж төрсөн» (27, 174) гэхчилэн орчуулсан байх мэт санагданам.

Тэгэвч судлагчид энэхүү эдүн гэдэг үгийг Хэниш энэ тэр гэдэг үгийн олон тооны хэлбэр гэж ойлгосон бололтой байхад Мансан Дугаржав тэргүүтэн цөм «эдүгээ (одоо)» гэж, Дамдинсүрэн «сая» гэж, Элдэндэй Ардажав эдүй (төдий) гэдгийн олон тооны хэлбэр гэх зэргээр олон янзаар ухаарсан байх юм. Бидний санавал энд ганц төрсөн хүү Сэнгүмийн тухай яригдаж байхад түүнийг заасан «энэ тэр» гэх мэтийн заах төлөөний үгийн олон тооны хэлбэр байж таарамгүйн дээр эдүгээ төрөн барсан гэдэг нь одоо ба өнгөрсөн хоёр цагийн явдлыг хутгалдуулан хэлсэн гэхэд бас ч эргэлзмээр санагдана. Энэ учраас бид энэ үгийг «эдүкү-үүсгэн хэлэлцэкүй-йин жэргэ» (12, 66б) гэсэн үйл үгийн үйлт нэрийн «н» авч хувилаад дараах «төрэн барагсан» гэсэн үгтэйгээ холбогдсон үг болов уу гэж бид таамаглав.

526. **богунитхажу** (богинотгож)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь судлагчид ерөөс «бокиниткажу» ～ «богунидхажу» гэж сэргээдэг нь эргэлзээгүй зөв болно.

Харин энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгаар «доош тавих» гэж Хэниш (36, 17) тайлаад «динг сагухуй исэр-и бохунитхажу» гэсний нь «миний ямагт суудаг сандлыг дорогш буулгаж» (15, 65—66) гэж, Пеллио «амгалан орноос нь хүмүүс буулгав» (9, 188), Поуха «суудаг сууд-лы минь доошлуулж» (17, 105), Клливз «тэдний динг суудаг сандлыг намсгаж» (42, 102) Дугаржав «амраар суух орыг минь намсгаж» (24, 118), Мансан «төвшин орь минь эвдэн сандааж» (27, 175) гэж, Дамдинсүрэн «Сандайлж суух орыг минь салгануулан тулхижу» (7, 145) гэж тус тус орчуулсан байна.

Бидний бодоход энэ үг «дэн сагухуй исэр-и богунитхажу» гэсэн үг бөгөөд «дэн» гэдэг үг «дэнж-өндүр дэнжи гажар кэмэкү жэргэ-йин (12, 657б), «дэндгэр-дэнд гүгүргэ тэргэ йин» (12, 657) гэх зэрэг үгтэй язгуур үндэс нэгтэй төрөл үгийн «өндөр» гэх утгатай үг мөн шиг байх тул түүнийг «динг» буюу «дэнг» гэж галигласан нь аман аялгууны (эсвэл сонсголын) гажуудуулал бололтой. Харин нөгөө «богинотхох» гэсэн үйл үг нь «дэн суух исэрийг» гэдэг нь удтал амран хэвтэх жаргалыг минь богино болгож гэсэн цаг хугацааны утгатай гэж бодно. Үүнийг доош болгох гэж ойлгох нь хадмал ба товч орчуулга хийгчдийн гүйцэд ухааранаагүйн эндэгдэл мэт санагдана. «Энд амгалан амрах оронд минь удаан хэвтүүлэхгүй, унтаж амрах цагийг минь богинохон болголоо гэсэн үг болох нь өмнөх «нойр ханган яахин үл айлгана чи?» гэсэн үгнээс ил байна. Тэр цагийн дуу бариулсан элчин харилцааны үг хэлэнд үгийг энэ мэт өөр шилжсэн утгаар хэрэглэх явдал өргөн дэлгэр байсныг хадмал ба товч орчуулагчид сайтар болгоолгүй алдаж эндсэн нь цөөнгүй байх шиг байгааг ч бодолцох ёстой бус уу?

527. **дөлүсгэжү** (дөлсгөх)-гэсэн энэ үгийг Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн нар «дөлүсгэжү» гэж, нөгөө Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин цөм «дөлүскэжү» гэж хоёр янзаар сэргээсэн нь уг чанартаа адил бөгөөд «к» авиатай нь эртний бичлэг нь болов уу гэж бодож байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «сарниулах» (36, 37) гэж тайлсан юм. Тэгээд «дэгэсги гархуй уни-(йи) дөлүсгэжү» Хэниш (5, 66), Пеллио (9, 188), Поуха (17, 105), Калужинский (61, 103), Клливз (42, 102), Дугаржав (24, 108) нар цөм «дээшээ гарах утаагий нь сарниулж» гэх мэтээр орчуулсан шиг байх ба Дамдинсүрэн «савсан гарах утаагий минь сацруулан хийсгэж» (7, 145), Мансан «сави-

ран гарах утаагий минь сарниулж» (27, 175) гэж, Элдэндэй Ардажав **дөлүг-дөлүрэхү-модон сав (хэрэгсэл)-ны уулзар (углуур) салах задрах** гэж таван хэлний толь зааи, шилжсэн утга нь холдох, жайцах, тарах **утгатай гэжээ.**

Бидний бодлоор энэ үгийн үндэс **дөлүг (галын дөл) мөн бөгөөд** энэ дөл ийш тийш өрвөлзөн гуйвалзах хэлбэртэй тул (+с) нэр үгээс **үйл** үг үүсгэх дагавар (+гэ) үйл үгийн бусдаар үйлдүүлэх үндэс үүсгэх нөхцөл) +жу (үйл үгийн нөхцөл үйлийн **зэрэгцэх хэлбэрийн нөхцөл** гэсэн бүтэцтэй үг мөн тул утга нь голомтны **бэлэг тэмдэг болсон утаа** үнсийг минь ийш тийш салхи шиг хийсгэж гэсэн утгатай **гэж бодно. Энэ нь голомтыг минь баллаж утаа үнэсээр хийсгэх гэж сандраав гэсэн утгатай бололтой.**

Ул+ай+с+га (улайсга-улаан болго) гэх мэтийн үгийн загвараар бүтсэн **үйл** үг гэж бодно. Ер нь эртний монгол бичгийн хэлний **«уни»** (утаа) үнэсү (үнс) гэсэн хоёр үг нэг язгуураас үүссэн төрөл үгс бололтой гэсэн сэтгэгдэл Нууц товчоонд эдгээр үгийг хэрэглэсэн байдал төрүүлдгийг тэмдэглэе.

528. халжирхуй-у (халжу-ирэхүй-үү?)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 68), Козин (14, 254), Пеллио (9, 188), Лигети (33, 109), Рахевильз (25, 86), Баяр (11, II, 676), Элдэндэй Ардажав (8, 518) нар цэм «халжирху-йу» гэж сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хэвгийн хүн» «хажуугийн хүн» гэжээ. Тэгээд энэ үгийг Хэниш «гадна ахуу хүний» (15, 66), Козин «зальхайчууд чамайг төөрөлдүүлэв» (14, 134) гэж, Пеллио «хажуугийн хүнээр хатгагдсан биш үү?» (9, 188), Мостарт «хажууд бүхий хэдэн хүнээр хатгагдсан биш биз?» (47, 348 [98]) гэж, Дугаржав (24, 118), Мансан (27, 176) нар «хажуугийн хүнд хатгагдсан биз», Дамдинсүрэн «хажуугийн ховч хүний халтай муу үгэнд» (7, 145), Элдэндэй Ардажав халтирахуй 21-тийн толь зааж хэлбийх, далиу, ташуу, хазгай зөрүү, нум баахан хазгай гэх утгатай, (8, 518 тайлбар № 14) гэжээ.

Гэвч энэ үгийг хажуугийн гэсэн үг биш, харин «халжу ирэкү» гэсэн хоёр үгнээс нийлж бүтсэн «халжирхуй-у» гэсэн үг байж магадгүй гэж бодно. Учир нь нэгд энэ үгийн язгуур «хажихал» байгаа тул хажуугийн гэсэн утгатай байж таарамгүй юм. Хоёрт энэ үг үйл үгийн үйлт нэрийн хэлбэртэй байгаа тул нэр үгээс «-жи», «-р» гэсэн хоёр дагав раар эхлээд **тусах үйл үг, дараа нь эс тусах үйл үг бүтэх ёстой** байсаар. Гэтэл хал-гэдэг нь **үйл** үндэс, хала-гэдэг нь нэр язгуур **байгаа нь Нууц товчооны эхийн бусад зүйлээс мэдэгддэг тул хал-гэсэн үйл үгнээс жи дагавраар үйл үг үүссэн байж таарахгүй. Гуравт,** авчу+ирэкү гэсэн хоёр үг нийлж **«а(б)чиражу»** (§16) гэх мэт үг Нууц товчооны эхэд олон байна. Эл учраас бид энэ үгийг «халж[у]ирахуй» гэсэн **хажуугийн гэдэг үг биш, харин халдаж наалдаж очсон хүмүүс буюу** эсвэл халдаж довтлох хүмүүсийн үгэнд хатгагдсан буюу ятгагдсан биз гэсэн утгатай өөр үг гэж таамаглав.

529. көндэлэд-у (көндлөнгийнхэнд-үү?)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш **«көндэлэду гү'үн»** (36, 104), Пеллио (9, 58), Мостарт (47, 345 [95]), Лигети (33, 109), Рахевильз (25, 86), Баяр (11, II, 677), Дашцэдэн (26, 108), Элдэндэй Ардажав (8, 518), Иринчин (28, 151) нар цугаар **«көндэлэдүйү»** гэж сэргээн сийрүүлсэн байдаг.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хажууд ахуд (базаахгүй атаархагч) хүмүүс» (36, 104) гэж тайлсан байна. Тэгээд Хэниш (15, 66), Мостарт (47, 348[98]), Калужинский (61, 103), Кливз (42, 102) цэм ерөнхийдөө «хөндлөнгийн хүн» гэсэн утгатайгаар орчуулсан нь маргаангүй зөв юм.

Харин бид энэ үгийг «көндэлэд-у» гэж Хэнишийн адил сэргээн сийрүүлэх нь илүү зөв болов уу гэж санаж байна. Учир нь көндэлэн гэдэг үгэнд олон тооны «д» нөхцөл залгахад эцсийн нь орхигдсон «хүндэлэд» гэсэн үг бүтсэн бөгөөд түүнд «у» гэсэн асуух сул үг дагуулж ийнхүү «көндэлэд-у» гэж бичиж болох юм. Хэрэв «хүндэлэд-у йу» гэдэг үг галигт тэмдэглэсэн нь зөв гэвэл энэ нь «хөндэлэд-хүй-у» гэсэн үг байж гэж таарахаас өөр зүйл байж таармаар үгүй санагдана. Учир нь хүндэлэ+ду+йу гэсэн харьцангуй нэр гэж тайлбарлах аргагүй: юу гэвэл хэрэв тийм байсан бол «хүндэлэдү» гэж ду дагаврын өмнө «э» эгшигтэй тэмдэглэх ёсгүй гэж бодож байна.

530. килагутай (арал ялаутай)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «килугу(н)-тай» (36, 102), Пеллио (9, 58), Баяр (11, II, 681), Дашцэдэн (26, 109), Иринчин (28, 151) нар «килүгүтэй», Лигети (33, 109), Рахевильз (25, 87) нар «килгутэй» буюу «кил(үүгутэй» гэж сэргээн сийрүүлснээс бидний бодоход Хэнишийн сэргээлт нь илүү оновчтой мэт санагдана.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «дугуйлах» «дугуй-

тай болгох» (36, 102) гэж тайлсан бөгөөд «хоёр дугуйтай тэргэний нэг дугуй нь эвдэрвэл» (15, 66), Пеллио (9, 189), Калужинский (61, 103), Дамдинсүрэн (7, 146—147), Мансан (27, 177), Дугаржав (24, 119), Элдэндэй Ардажав (8, 524—525), Кливз (42, 103) тэргэний арал арлын шургаагтай холбож ойлгож орчуулсан буюу тайлбарласан нь ерөнхийдөө зөв юм.

Гэвч бид энэ үгийг Элдэндэй Ардажав нарын адил Шагжийн толь бичигт «илау-тэрэгний арал, шат **зэргийн хөндлөвч»** (12, 102) гэсэн үгтэй холбож «килагутай» гэж сэргээв. Учир юун гэвэл бидний бодоход эртний монгол хэлэнд арлын хоёр **талын** хоёр урт урагшаа илүү гарсан хоёр модыг нь илагу буюу эсвэл **«илэгү»** гэж нэрлэж худам монгол бичигт **«илагу»** гэж нэрлэгддэг байжээ. Харин тэргээр хооронд холбож углуургадсан хөндлөн олон модыг ара (нугачаа зай) гаргаж хийсэн тул арал гэж нэрлэж байсан бололтой. Гэтэл хожим тэргэний эл хоёр эд ангийн нэр солигдож арал гэж бүхлийн нэр ялуу гэдэг нь хөндлүүдийн нэр болсон гэж бид таамаглаж байна.

531. Жүктэкү (зүтгэх)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 89), Пеллио (9. 58), Лигети (33, 109), Рахевильз (25, 87), Баяр (11, II, 682), Дашцэдэн, (26, 109), Элдэндэй Ардажав (8, 519), Иринчин (28, 151) нар «жикдүн» гэж сэргээн **сийрүүлсэн байгаа нь** цөм хятад үсгийн галигийг дагасан **хэрэг мөн. Харин** энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «дээш татах, татах» (36, 89) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 66), Пеллио (9, 189), Поуха (17, 106), Калужинский (61, 103), Кливз (42, 103) нар цөм «татаж чадахгүй гэж, Дамдинсүрэн (7, 147), Мансан (27, 177), «чирч чадахгүй гэж, Дугаржав (24, 119) «зүтгэж» гэж тус тус орчуулсан байна. Бид энэ үгийг худам монгол бичигт **«жүктэн»** гэж бичигдэж байгаад **хожим монгол хэлний аман аялгуу ба хуучин** (сонгодог) **монгол** бичигт **«житкүн»** гэж бичигдэх болсон **«жидгүкү-хичээн чармайх»** (12, 509б) үг мөн гэж бодож байна. **«Житгүкү»** ба «жиктэкү» гэдэг үеийн солигдлоор үүссэн нэг үгийн хоёр хувилбар гэж бодном. «Жүк» гэдэг нэр үгээс «-тэ» дагавраар «нэг зүгт хүчээ төвлөрүүлэх» гэсэн утгатай үйл үг бүтсэн нь илэрхий юм.

532. нигур[ул]хан (нүүрлэхэн) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 118), Пеллио (9, 58), Лигети (33, 110), Баяр (11, II, 685), Рахевильз (25, 87) нар «ни'урхан» гэж, Дашцэдэн «ниурхан» (26, 109), Баяр (11, II, 685), Дугаржав (24, 120), Элдэндэй Ардажав (8, 519), Иринчин (28, 152) нар «нигурхан» гэж тус тус сэргээн сийрүүлсэн юм. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «бэлэг» болгож (36, 118) өгөх гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 66), Поуха (17, 106), Калужинский (61, 104), Кливз (42, 104), Мансан (27, 177) нар «бэлэг болгож, охиноороо уулзсан» гэж, Дамдинсүрэн «бялдуучлан өгч» (7, 147), Дугаржав «Нүүр харан зусарлаж өгөөд» (24, 120) гэж ойлгож зөв орчуулсан буюу тайлбарласан байна.

Энэ үгийн утгын талаар бид судлагчидтай зөрөх зүйлгүй. Харин энэ үгийг «нигур+**хан**» гэдэг нь монгол хэлний үг бүтэх ёсны үүднээс зохисгүй тул бид «нигур+рх+н» гэсэн бүтэцтэй үг бөгөөд энэ үгэнд хоёр **«р» авиа** ойрхон орсны учир дагаврын «р» нь «л» авиагаар ондоошин «нигурулхан гэсэн үг байсныг галиглагчид ташаа тэмдэглэсэн болов уу гэж таамаглаж байна. Нэр нэрэлхэх гэсэн үгийн загвараар нийм үг үүссэн байж болох юм.

533. нөгүгэжи (нөгөөгий нь)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 119), Пеллио (9, 60), Лигети (33, 113), Рахевильз (25, 90), Баяр (11, II, 702) нар цөм «нөкожи» гэж, Дашцэдэн (26, 113), Элдэндэй Ардажав (8, 521) нар «нөгэжи» гэж, Баяр (11, II, 702), Иринчин (28, 155) «нөгүгэжи» буюу «нөкүкэжи» гэж тус тус сэргээн сийрүүлсний дотроос сүүлчийн хоёр судлаачийнхыг хамгийн зөв зүйтэй сэргээлт гэж бид үзнэ.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш **«хоёрдугаарыг»** (36, 119), гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 69), Поуха (17, 109) нар **«тэдний нэгийг» гэж хамгийн зөвөөр, Пеллио** (9, 191), Кливз (61, 106) нар «хоёрдугаарыг» гэж үндсэндээ **зөвөөр,** Дамдинсүрэн (7, 144) Дугаржав (24, 123), Мансан (27, 179) нар **«өөр,** ондоо» гэж арай ташаагаар тус тус орчуулсан буюу **ойлгосон байв.**

Бидний бодлоор бол энэ нь нэрлэсэн хоёр **хүнийг хоёулыг эс явуулбал** ядаж нөгөөгий нь явуул гэж шаардсан үг болох нь эргэлзээгүй бөгөөд аман ярианд **«—жи» болон сонстох авиа** нь бичигт **«ги»** болох тул чухамдаа энэ үг **«нөгүгэ-(г)-и» гэж бичээстэй** байсан гэж таамагланам. Жич энэ үгийн өөр нэг хэлбэр болох **«нөгөд»** (§ 181) буюу «нөгүгэд» гэсэн үг бол **«нөгүгэ»** гэдэг үгийн олон тооны хэлбэр мөн бөгөөд утга нь нэрлэсэн хоёр хүний аль нэгийг заавал ирүүл гэсэн хатуу шаардлагын утгатай бөгөөд тэр хоёрын аль нэгээс өөр хүнийг хүлээж авахгүй гэсэн санааг гаргажээ.

534. тагдай-дур (тагжгар саванд) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 31), Пеллио (9, 60), Лигети (33, 119), Рахевильз (25, 90), Баяр (11, II, 707), Элдэндэй Ардажав (8, 532), Иринчин (28, 156) нар цом «тагтай» гэж —тай дагавартай сэргээсэн нь буруу юм. Учир нь таг— гэсэн үгэнд харьцангуй нэр бүтээх ту, ту, тай, тэй дагавар залгасан бол худам монгол бичигт «таг—ту» (эр хүйст) үгээр бичих байсан байх. Харин энэ нь «оготор» гэдэг үгнээс үхэр огдой гэж жижиг гэсэн утгатай үг үүсгэсний загвараар «таг+дай» (тагдгар жижиг) сав гэсэн үг үүсгэсэн байх гэж бид таамаглаж байна. Жич энэ үгэнд монгол хэлтэн судлаач Баяр, Мансан, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Иринчин нараас бусад нь цом «—тур» нөхцөл дагуулсан худам монгол, хуучин (сонгодог) монгол бичгийн үсгийн дүрмийн үүднээс буруу юм. Учир нь тур, тур нөхцөлийг гагцхүү «багарсад» (б, г, р, с, д-т) үсгээр төгссөн үгэнд дагуулах ёстой. Дашрамд тэмдэглэхэд Монголын нууц товчооны хятад галиг эхэд энэ «—тур, түр, дур, дүр» нөхцөлийг хэрэглэсэн онцлогийн талаар японы эрдэмтэн Мураяма сонин ажиглалт хийснийг (101,) тэмдэглэе. Жич энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хусны үйсэн сав» гэж тайлсан тул судлаачид «үйсэн сав», «өчүүхэн үйсэн сав» гэж ойлгож орчуулсан цом зөв гэж бодож байна. Бас таг+дай, таг+си (тагш) зэрэг үгс нэг язгууртай төрөл үгс байж ч болно.

535. көкэ чунг (хөх хул) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 103), Пеллио (9, 60), Лигети (33, 114), Рахевильз (25, 90), Баяр (11, II, 709), Дашцэдэн (26, 113), Элдэндэй Ардажав, (8, 534), Иринчин (28, 534) нар цом «чунг» гэж сэргээсэн нь уг галиг эргэлзээгүй тодорхойг харуулж буй.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хөх том аяга» (36, 103) гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш «айргийн цом, том хун, бага утгуур, шанага» (15, 69) гэсэн олон утгатай үгээр орчуулж, Пеллио «аяга» гэж (9, 192) гэж, Поуха (17, 110), Калужинский (61, 106), Кливз (42, 107) нар цом «хөх цом, хөх [том] хундага» гэж Хэнишийг дагаж орчуулсан шиг санагдана. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 150), Дугаржав (24, 124), Иринчин (28, 156) нар «хундага» гэж, Элдэндэй Ардажав «их хувин, их суулга, их ган» (8, 535—536, т. № 2) гэж, Мансан «хөхүр» (27, 194, тайлбар № 22) гэж Элдэндэй Оюундалай нарын тайлбарыг заасан ба Элдэндэй Ардажав нар нь Мухаддиматын толь бичгийн тайлбарыг заажээ.

Гэвч бидний бодоход энэ нь Ун хааны айраг уудаг хөх өнгийн хул аягаар өглөө эрт түрүүлж боссон нь айраг уух мэлзээ тавьж Тэмүжин Жамухаас ямагт түрүүлж босч тэр хааны хүндэтгэлтэй хулаар айраг уудаг байсан тухай хэлсэн үг бололтой. Учир нь хэрэв Тэмүжин, Жамуха хоёрын аль түрүүлж боссон нь Ун хааны сөн хөхүүр, ган тойроотой айргийг уучих мэлзээ тавьсан гэж итгэх аргагүй бөгөөд хэрэв тэгж уучихдаг байсан нь үнэн бол тэр хоёр залуу язгууртныг Ун хаан хөөж гэрт нь буцаах байсан биз. Бид энэ үгийг архи уудаг «хундага —аягын хүндэтгэл, маш бяцхан аяга» (12, 397) ч биш, харин айраг уудаг «хулу—их аяга» (12, 409) байсан гэж бодно. Жич монгол хэлний хулун синага— «хулу—йи» (хулыг) хагалан хийсэн шанага» (12, 409), «хуса—багварын адил ихээхэн сав» (12, 407б), «хубинг—усны хувин зэргийн» (12, 399а) «хумбанг айаг-а—хумбагар аяга» (12, 403 а), «хумх-а—бумба гэмээгдэх сав» (12, 403 а) гэх зэрэг «ху—» язгууртай олон үг байгаагаас үзвэл хунхар гэсэн утгатай үгнээс үүссэн «хун» гэсэн монгол үгийг «чунг» гэсэн өөр хэлний үгтэй андуурч галигласан байж ч болмоор санагдана. Энэ чунг буюу хун гэдэг үг «хулу аяга» гэсэн утгатай гэж бодно. Нөгөө «хөрүгэ» гэдэг хэрээд үг ч бас «хөнүк (хувин)» гэдэг үгийн хувилбар болов уу гэж бодогдож байна.

536. жигужу (хөөх) гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 94), Козин (14, 256), Пеллио (9, 60), Лигети (33, 114), Рахевильз (25, 90), Баяр (11, II, 710), Дашцэдэн (16, 114), Элдэндэй Ардажав (8, 534), Иринчин (28, 156) цом «жухажу» гэж үзтэл буруу сэргээснээс үзвэл уул хятад үсгийн галигт энэ үгийг тэр үеийн монгол хэлний нэг аялгаар ташаа тэмдэглэсэн бололтой юм. Энэ үгийг ийнхүү буруугаар сийрүүлсэн учраас хожим хийсэн хадмал орчуулга нь ч буруу болсон шиг санагдана.

Хадмал хятад орчуулга үгийн утгыг нь Хэниш «тохиролцох» (36, 94) гэж тайлаад Хэниш «өөр хоорондоо маргалдан хөөх» (36, 94) гэж, Пеллио «үүлэн (газар) дээр хаях гэв үү, оршуулж орхих гэв үү» (9, 192) гэж, Кливз «үгсэн (тохиролцон) орхих гэв үү?» (42, 107), Дамдинсүрэн «мэхлэн урвах гэв үү» (7, 150), Мансан «мэхлэн хаях гэв үү» (27, 180), Элдэндэй Ардажав «хорчин аман аялгуунд жогоху, жугуху гэж аргацаах, дөнгөх, бодох санах, хорлон алах, алах нядлах, эвлүүлэх, түгээн, хийх, үйлдэх, зохион бичих, тааруулах, угсрах, тоноглох, дохих, шагайх» гэх мэт олон утгатайг заасан. «Та хоёр намайг тэвчиж (тоох-

гүй орхиж) ил хүү гээсү (хаях) гэв үү та? «Жигужу» (хөөж) гээсүү гэв үү, та» гэсэн утгатай үг болох нь илэрхий. Энэ үгийн «жигутаху» (зугтаах) гэсэн эс тусах хэлбэр нь хуучин (сонгодог) монгол бичигт үлдсэн боловч, нөгөө «жигуху—ами жигуху мэтү-йин» (12, 507) (амь хөөх) гэсэн үгэнд үлдсэн боловч дуудлага нь «зуух» гэж шал өөр болжээ. Хятад галигт «жугаху» гэсэн нь орчин цагийн монгол хэлэнд «зугтах» гэж бичих ярих болсонд их л ойролцоо дуудлагатай болоод байсныг харуулж байна. Алтан Хучар хоёрт Чингис хаан хэлүүлэхдээ түүнийг илээр орхиж гээж Ун ханд очсоныг нь хэлж харин одоо бас Ун хантай нийлж намайг хөөж (холдуулж) гээх гээ юу? гэж хэлсэн болох нь ив илэрхий байна. Энэ үг Нууц товчооны өөр зүйлд (§195)

«Жидату эрэ йи
Жигужу (хөөж)» цуст тоног тоногчин гэсэн шүлэгт орохдоо «жи—» үеэр толгой холбогдсон тул бичгийн эртний дуудлагаараа «жигужу» гэж тэмдэглэгдсэн бол энд XIV зууны аман яриаы аялгаараа «жугажу» гэж өөрөөр тэмдэглэгдсэнээс зайлахгүй.

537. элүн-эчигэ (элэнцэг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 43), Пеллио (9, 61), Лигети (33, 115), Рахевильз (25, 91), Баяр (11, II, 721), Дашцэдэн (26, 115), Иринчин (28, 158) нар цөм «элинчүк-үн» гэж сэргээснээс үзвэл хятад үсгийн галиг ингэж буулгасан нь гарцаагүй бололтой.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «язгуур эртний өвөг» (36, 43) гэж тайлжээ. Хэниш (15, 71), Пеллио (9, 61), Кливз (42, 109) нар «ихийн их өвөг дээдэс» гэж, монгол хэлтэн судлагч Дамдинсүрэн:

«Элүнчэ-йин үйэ-йин
Эситэй богул чимаду» (7, 152) гэж, Баяр (11, II, 721) «элүнчэ-йин» гэж, Дугаржав (24, 126), Мансан (27, 182) нар «элүнчэ-йин мину, Эгүдэн-ү богул», эсвэл «Эгүдэн-ү өмчи богул» гэж орчуулжээ. Элдэндэй Ардажав нар (8, 540, т. № 7) «элинчүк ~ элүнчэ» гэж тайлбарлаад «элүнчэ эбүгэ—кэмэбэсү эбүгэ эчигэ-йин эчигэ» «Элүнчэ эмэгэ—кэмэбэсү эбүгэ эчигэ-йин экэ» гэсэн тайлбарыг Шагжийн толь бичгээс эш татан (12, 85 б) дурджээ.

Тэгэвч бид энэ үгийг энд галигласнаар «элинчүк» гэж сэргээх нь буруу гэж үзэж байна. Учир нь энэ бол XIV зууны галиглагч нарын аман аялгууг тусгаснаас, харин бичгийн хэлбэр нь биш гэж батлан хэлж болно. Дурсгалт бичгийн худам монгол бичгийн эхэд «элүн эчигэ-йин мину» гэж энэ хоёр үг нийлж «элүнчэ» гэсэн үг бүрэлдээгүй үед авагдсан уг анхны бичлэгээрээ байсан гэж бодох үндэстэй юм. Үүнд энэ хоёр үгнээс бүтсэн «элүнчэ» гэдэг үгийг «элин» гэж бичдэггүй хуучин (сонгодог) монгол бичгийн уламжлал «элүн» гэсэн үг байсныг гэрчилнэ. Хоёр үгийг нь «эчигэ» гэж бичдэг уламжлалтай тул «элин+чүк» биш, «элүн—эчигэ» гэж бичих нь зүйд нийцнэ. Харин нууц товчоог хятад үсгээр тэмдэглэх үед энэ үгийн бүтцэд байсан и, ү хоёр авиа сэлгэн «элүн(э)чикэ» биш харин «элин(э)чүкэ(э)» гэж гаж буруу хэлэгддэг болоод байсныг энэ жишээ гэрчилж байна.

538. кэли (хэзээ)—гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «кэли» гэж сэргээгээд «хэзээ» гэсэн утгатайг санал нэгтэй хүлээн зөвшөөрч орчуулсан буюу нэгэнт тайлбарласан тул бид энэ талаар тайлбарлах зүйлгүй.

Харин бидний бодлоор хугацааг асуух дохионы тэмдэг болсон энэ үгкэ (хугацаа, зай, үйлийн байдлыг асуух үгийн үндэс)+ли (хугацааг асуух үүсмэл үг бүтээдэг дагавар) гэсэн бүтэцтэй юм. Энэ кэ— гэсэн асуух үгийн язгуур үндсэнд «р» дагавар залгаж «хэр» гэсэн үйлийн байдал шинжийг асуух үг бүтэх, бас кэ гэсэн үндсэнд «жи+й—э» гэсэн нийлмэл дагавар залгаж (хир хол гэсэн) зайн хэмжээг асуух үг тус тус үүсгэдэг нь «йа» гэсэн асуух үгийн үндсэнд +гу дагавар залгаж «йагу» (юу) гэсэн юмыг лавлах нэр үгийн асуулт, йа гэсэн энэ үндсэнд «кикү» гэсэн үйл үг нэмэн нийлүүлж «яах» гэсэн үйлийн явцыг асуух дохионы үг бүтсэн, ха—гэсэн асуух үгийн үндэстэй «мага» гэдэг тодорхойгүй утгат үгийг нийлүүлж хамага (хамига—хаана) гэдэг орон байр асуух үг тус тус бүтсэнтэй ижил төстэй юм. Кэли гэдэг үгийн оронд зай асуух «кэжий-э» гэдэг үг хожим хэрэглэгдэх болсноос кэли гэдэг үг нь мартагдсан биш болов уу гэж бидэнд санагдаж байна.

539. жубчижу йабуйу (зувчиж явъюу) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 93), Баяр (11, II, 727), Иринчин (28, 159) нар «жубчижу» гэж, Пеллио (9, 62), Лигети (33, 116), Рахевильз (25, 92), Дашцэдэн (26, 116), Элдэндэй Ардажав (8, 541) цөм «жубчижү» гэж хоёр янзаар сэргээснээс бид Хэниш, Баяр, Иринчиний сэргээлтийг илүү зөвд үзэж «жубчижу» гэж сийрүүлэв.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «гагцхүү» хонины сүүл яг таг дагаж явах» (36, 93) гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15,

71), Пеллио (9, 193), Кливз (42, 110), цөм «сартагчин хонины сүүлэнд холбосон Тогтао Бөө» гэдэг биш билүү?» гэсэн утгаар орчуулсан шиг санагдана. Мансан бас «Сартуулын хонины сүүл шиг Тогтоо бөөтэй «холбогачигсан» мэт гэдэг биш үү» (27, 183) гэж сэргээгээд утгыг «жүбчин» гэгч залгаж уях буюу барьж холбосон гэсэн утгатай гээд зөв тайлбарласан боловч Жигачид цэцний болон «Сийэ зай Шаң нарын орчуулгын тайлбарыг ихэд үнэлэн дагасан нь (27, 198) бидний бодоход төдий л үнэмшилтэй биш байна.

Бидний бодлоор бол уг галиг эхэд «Тогтуга бөкэ» гэдэг үгийн дараах харьяалахын тийн ялгалын нөхцөл хаягдсаны дээр **«зубчижу»** гэсэн үгийг Хэниш, Баяр, Иринчин гурваас бусад нь «жүбчижү» гэж буруу сэргээсэн учраас ойлгож орчуулах аргагүй өгүүлбэр болжээ. Ингэж бодох үндсийг Ун ханы намтрыг өгүүлсэн «МНТ»-ы бусад зүйлсээс (§ 177) «Харагун хавчил-аас гарахдаа Тогтуг-а-да Ижагур үжин охиноо нүүр тал харан өгч гарсан гэхээс гадна тэр үед нялх Сэнгүм Мэргидийн Тогтоогийн сартагчин хонины сүүлнээс уяатай юм шиг ямагт дагаж хариулж явсан удаатай байж болох юм. Тогтуга бэхи Баргужин төхөм өөд удаа дараа зугтаж байсан түүхтэй (§ 177) юм. Бас Эргүнэ гол уруу булга хэрмийн арьс худалдаж авахаар Асаң сартагдай мянган иргэ туугаад явж байгаад Халх гол уруу ухарч явсан Чингис хаантай дайралдаж байжээ. (§ 182). Эргүнэ голын сав нутаг, мөн Баргужин төхөмд Тогтуга бэхи сартагчин хоньтой байгаагүй гэж батлах аргагүй. «Жубчиху—гүжирмэгээр явах» (12, 523а) гэсэн үг монгол хэлний үгсийн санд бүртгэгдсэн байхаас гадна хэргийг ийш тийш нь булзааруулахыг бас «зувчуулах» гэж хэлэлцдэг юм. Жич энэ үг «Нууц товчооны» (§ 275) Элжигэдэйн хүү Харгасун өгүүлрүүн «модун сэгүл жубчий-а, тэдэн-и кэмээжүкүй» (9, 114) гэсэн үг байгаагаас үзвэл «модон сүүл зүүе» гэж эсрэгцэл этгээдээ адгуус гэж доромжлох ийм нэг өвөрмөц хэллэг ч тэр үед байжээ.

540. Харагун жидо[гу]ун-у ниругу (Харагай Жидооны нуруу)—гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 176), Дамдинсүрэн (7, 153), Поуха (17, 13), Калужинский (61, 108), Кливз (42, 111), Дугаржав (24, 183), Мансан (27, 184), Баяр (11, II, 733), Дашцэдэн (26, 117), Иринчин (28, 160), нар цөм «Харагун жидун-у ниругу» гэж, харин Пеллио анх «Хара'ун чидун-у ниругу» гэж, дараа нь «хара'ун жидун» (54, 259) гэж, Лигети (33, 117), Рахевильз (25, 93) нар **«хара'ун жидун»** гэх зэргээр өөр өөрөөр сэргээсэн боловч «харагун жидун» гэдэг ерөнхийдөө зөв сэргээлт гэж тооцогдох болж байна.

Энэ үгийн утгыг газрын тусгай нэр гэж бодох учир чухам ямар утгатай үг болохыг судлагчид тэр бүр тайлбарлаж байсангүй харин судлагч Дугаржав энэ зүйлд гарсан Харагун жидүн гэдэг нэрийг «Харагун жадун» (24, 128) гэж сэргээгээд энэ үгийн 2 дугаар тайлбарт түүхийн газрын зурагт энэ газрыг одоогийн Хянган даваяг «Харагун жадун» (24, 128) гэж бичдэгээс гадна одоогийн эвэнхи ба баргачууд одоо ч Хянган даваяг жадун (йадун?) даваа гэж дууддаг байсан зүүн өмнөөс урасч ирээд ягшаас хойш Хайлаар голд нийлдэг голыг Жадун (йадун?) гол гэж нэрлэсээр байна гэжээ. (24, 128) Гэтэл § 207 дурдагдсаныг нь Харагун Жидун гэж өөрөөр сэргээгээд тайлбар хийсэнгүй.

Мансан (27, 200, тайлбар № 34, § 206 тайлбар № 36), Элдэндэй Ардажав (8, 549—550, тайлбар № 3, § 206 тайлбар № 9) нар цөм одоогийн Хянган даваа гэж тайлбарлаад Харагун— хар Жидүн гэдэг нь манж жидэн (8, 550) уулын нуруу, халил (цогцгор) уулын нуруу болно гэж заахын хамт Жагчид цэцэн, Сийэ Зан Шаны орчуулгын тайлбарт «Хэнтий уулын нэгэн нэгэн салбар» гэж, «Харагун жидүн-и зөв өгүүлэв гэж заасныг Элдэндэй Ардажав нар бас заасан байв. Түүхч Сайшаал «Чингис хааны товчоон» дээд дэвтэр, IV бүлгийн «дагалдбар» тайлбар № 66-д энэхүү «харагун жидун» гэдэг нь одоогийн Улаан хотоос дээш байх рашаан орчмын Хянган даваяг заасан бололтой» (107, I, 356), П. Пеллио, Л. Амби нар «эцэст нь харагун гэгч «хара-ой-йин» гэсэн хам бүтэцтэй нэг үг бөгөөд энэ «хара'ун» гэдэг үг «хара'ун жидун» гэдэг нэрийн дотор ч сонгодог монгол бичигт байдаггүйг заагаад Пеллио энэ үг хара'утай тэрэг гэх зэрэг тэмдэг нэрийн байдлаар ч дайралдаг гэснээс гадна «Хара'ун хабчил» гэдгийг Рашид-ад-Дин «хар ой» гэсэн үг гэж тайлбарласныг тэмдэглэжээ (54, 259).

Бид энэ үгийг «Хар мод жидооны нуруу» гэсэн үг болов уу гэж бодох бөгөөд аливаа шүлмүүст модтой нурууг нэрлэдэг үг байсан учир § 183-д гарч буй «Харагун Жидун» болон § 206-д дурдагдсан «Харагун Жидүн» хоёр хоёр өөр газрын ижил нэр байсан болов уу гэж таамаглаж байна. Учир нь Ун ханыхаас оргоод ахыгаа Чингис хааныг эрж Хасарын төөрсөн Харагун Жидуны уул Хянган даваяны тэнд байж хэрхэвч таарахгүйн дээр Архангайн Өлзийт сумын төвийн баруун

талаар хойноос урагш чиглэн тогтсон их нурууг бас нутгийн ардууд Хар модны **нуруу** гэж нэрлэдэг нь Хасарын төөрсөн нуруу байж магадгүй юм. Хар модыг Монголын баруун аймагт «Харагай» гэж нэрлэдэг нь энэ модыг урьд хара+гу гэж нэрлэж байсны гэрч байж болно. Нөгөө талаар жидэн буюу жидун гэдэг «уулын нуруу» гэсэн манж үгийг хэрэглэсэн гэх үндэсгүй. Учир нь Монгол хэлэнд нуруу гэдэг үг байсаар байхад бас түүнгүс эвэнхи жидүн гэдэг үгийг Монголын түүх бичигч хүн хэрэглэмгүй юм. Харин хуучин (сонгодог) монгол бичигт нэг зүйл шүлмүүст модыг «жодоо ~ [жодоу]—модон» (12, 520а) гэж бичдэг нь худам монгол бичигт жидогу буюу «жидугу» гэж бичигддэг байсан байж болно. Учир нь тэр үгийн эхний ж үсгийн дараа «и» бичигдэж **байсан учраас** ч энэ модыг халхын аялгуунд «жодоо» гэж «ж» авиагаар хэлэгддэг болсон баймаар. Хэрэв о эгшиг байсан бол халхын аялгуунд «зодоо» болсон баймаар билээ. Иймд бид энэ **үгийг** «Харагун Жидо[гу]н-у нируугу» гэж сийрүүлээд Харагуй ~ харгай жодооны нуруу гэсэн утгатай гэж бодож байна.

541. кэгүрижү (хэрэн хэнгшин явах) — гэсэн энэ үгийг хятад үсгийг галигаас нь судлагчид (Хэниш, Қозин, Пеллио, Лигети, **Рахевильз**, Баяр, Элдэндэй Ардажав, Дашцэдэн, Иринчин) цөм «кигүрижү» гэж адилхнаар сэргээсэн боловч бид энэ үгийг «кэгүрижү» гэж сэргээх нь илүү зөв гэж үзэв.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «Хара **унжидүний** нурууг туушид нь кэжин хэрэн» (36, 201) гэж тайлжээ. Хэниш «Хара үнжидүн уулын нурууг туучин эрээд» (15, 71), Пеллио «Хара' **ун-чидүн даван** туулан, уулын царам **хяраар** эрээд амжил **олсонгүй»** (9, 194), Қливз «Хара'ун Жидүн (уулын) хэр царамаар авиран явж Чингис хааныг эрээд олсонгүй» (42, 111), Дамдинсүрэн (7, 153), Дугаржав (24, 128) нар «хэсэн ~ хэсүүчлэн тойрч» гэж, Мансан «бэдэрэксэн болбачу» (27, 184) гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав нар кэгүрижү—гэх нь **хөндэлэн хөндий (уулын нураа, ганга, жаба (зав)** (8, 550, т. № 4) гэж тайлбарлав.

Бид энэ үгийг кэгүриж буюу хөндлөн гулд хэрчиж туучсан гэсэн утгатай үйл үг гэж ухааран сийрүүлэв. Ингэж бодох үндэс гэвэл нэгд, хуучин монгол бичгийн хэлэнд «кэрүн кэнгшин—мохуж, **кэсүн айбухуйин** байндал» (12, 356 а) гэсэн үг бүртгэгдсэн явдал болно. Хасарын Харагун Жидуны нурууг чухамхүү мухардаж хэсэн хэрэн хөндлөн гулд огтчин явсан тул «хэрүн хэнгшин» явсан нь илэрхий байна. Хоёрт, хэгүрисижү, хэрүн, хэ(н)гсин, кэрчикү (12, 357), кэгүрү (§149), **кэгүс чабчилалдуху» (§ 141)** гэх мэт үгс бол энэ кэ— гэсэн нэг язгуур бүхүй төрөл үгс бөгөөд хөндлөн гулд огтчих хэрчих гэсэн ойролцоо утгатай үгс байгаа баримт болно.

Иймээс бид кэ (үгийн идэвхгүй язгуур)+гү (элдэв үгийн идэвхгүй язгуур үндэснээс дайвар үг бүтээх дагавар)+ри (дайвар болон нэр үгээс үйл үг бүтээх дагавар)+жу (үйл үгийн нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй,: «хэрүн хэнгшин (хэгүсин) явах» гэсэн утгатай үг гэж бодож сийрүүлэв. Энэ үгийн эхний үеийг «ки—» гэж тэмдэглэсэн нь XIV зууны хятад үсгээр галиглагчдын эндүүрэл гэж бодном.

542. итгэмж эрэбэн олбасу (итгэмж эрмэлзэл олвол) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «итгэмжи эрийэн» (36, 83), Дашцэдэн «итгэмжи эрээн» (26, 118), Пеллио (9, 62), Лигети (33, 117), Рихевильз (25, 93) нар **«итгэмжи эрэ'эн»** гэж гагцхүү Баяр (11, II, 736), Элдэндэй Ардажав (8, 548) нар «итгэмжи эрэбэн» гэж, Иринчин **«итгэмжи эрэкэн»** гэж тус тус сэргээн сийрүүлснээс бидний бодоход **Баяр, Элдэндэй Ардажав** нарын сэргээснийг зөвд бодож бид бас тийнхүү сэргээн сийрүүлэв.

Энэ үгийн хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «итгэл найдвар» (36, 72) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 72), Қливз (42, 111—112) нар «итгэл найдвар, итгэл хүлээмж» гэж, Пеллио «итгэлийн баталгаа олбол» (9, 194) гэж, Дамдинсүрэн (7, 154), Дугаржав (24, 129), Мансан (27, 184) нар «итгэмжтэй хүнийг илгээвэл, эриж олбол, **явуулбал»** гэж, Баяр (11, II, 736), Элдэндэй Ардажав (8, 548) нар «итгэмжи эрэ-бэн олбасу» гэж ухаарсан боловч Элдэндэй нар энэ эрэбэн гэснийг «эрмэлзэл хүсэл» гэсэн утгатай гэж (8, 552, т. № 12) арга билиг гэдгийн утгаар ихэд ойртуулан тайлбарласныг тэмдэглэе.

Бидний бодвол «эрэбэн» гэдэг үг бол эрэ бэн (эрээ) гэсэн үг бус харин эрэбэн (эрэмэн—эрмэлзэл) гэсэн үгийн эртний худам монгол бичгийн уламжлалт бичлэг гэж бодож байна. Үүнд монгол (хуучин) бичгийн хэлэнд «эрэмэгэй—эрэдэгүү» (12, 75 а), «эрэмэлжэкү—горилаху мэтү йин» (12, 75 а) эрэмэг гэх мэт энэ үгтэй язгуур нэгтэй төрөл үгс байгаа нь ингэж үзэх үндэс болно. Түүнээс гадна «эрбэйих дэрбэйих—буй бүхнээр» (12, 78), «эр-э күмүн шиг эрбэлзэж, эхнэртэй лам

шиг галбалзаху» (хувилбарыг үз: 98, 128 а) гэсэн зүйр цэцэн үгэнд гарч байгаа «эр[э]бэйикү» «эр(э)бэлжэжү» зэрэг үг ч «э» эгшиг нь балархайшин орхигдож бичигдэх болсон энэ «эрэбэн» гэдэг үгийн язгуур нэгт үгс гэж бодном.

543. Аргал кэбэгэй-дэ (аргал[ан] хэвгий) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Қозин, Дашцэдэн тэргүүтэн цөм «Аргал Гэүги-дэ» гэж, Дамдинсүрэн, Элдэндэй Ардажав, Дугаржав нар «Аргал хоги» гэж, Баяр, Иринчин, Мансан нар «Кэүги ~ «кэги гэх зэргээр арай өөр өөрөөр сэргээн босгосон байх бөгөөд Элдэндэй Ардажав нар Х. Пэрлээн сурвалжлан олсноор Ааруулт (долоон) көкүтү гэж нэрлэгдэх газар мөн гэж орших уртраг өргөргийг заажээ.

Бид энэ үгийг аргал[ан] өнгөт «Хэбэгэй — хазгай газар мэтийн» (12, 345 а) гэсэн газрын нэр болов уу гэж таамаглаж байна. Ингэж бодох үндэс гэвэл нэгд, Аргал гэдэг үгийг хэрэв үхрийн хатсан аргалаар хомоолоор нэр өгөх заншил байхгүй юм. Харин Бугат, Шилүүст гэх мэт гөрөөсний нэрээр Аргали (хонин гөрөөсний эм) (12, 37 б) гэж нэрлээд дуудлага нь аргали биш аргал гэж дуудагдах болсон байж болох талтай нь «Аргалингту-сум-Өмнөговь аймгийн» (12, 36б) гэдэг нэрийг одоо цагт Аргалант сум гэж нэрлэх болсонтой адил байж болох юм. Гэвч гөрөөсөөр нэрлэсэн бол Арган биш Аргалиту гэх буюу Аргалингту гэмээр тул энэ амьтнаар биш, харин тэр амьтны зүсээр аргалин (зүсэм өнгөт) гэсэн үг байгаад «аргал» гэж хожмын аялгаар тэмдэглэгдсэн байх гэж бодогдож байна. Нөгөө «гэүги» гэдэг үг бол хуучин монгол бичигт загасны дэгээр нэрлэх үгийн бичлэг тул аргалан өнгөт гөгий (загасны дэгээ) гэсэн нэртэй газар баймгүй юм. Худам монгол бичигт урт хос зэрэг хоёр эгшиг дараалан бичдэг ёсгүй байсны дээр XIV зууны үед үгийн дунд орсон б авиа суларч «у, ү» авиагаар тэмдэглэгдсэн баримт уг эхэд олон байгааг бодолцож бид «кэбэгэй» гэж бичээстэй байсныг аман аялгуунд тэр цагт хэлэгдэж байсан дуудлагаар нь «кэүги» гэж ташаа тэмдэглэсэн гэж ийнхүү сийрүүлсэн болно.

544. үдтэр йүгүлгүжү (үдтэр гүйлгэж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 81), Пеллио (9, 63), Лигети (33, 199), Рахевильз (25, 95), Дашцэдэн (26, 119), Элдэндэй Ардажав (8, 555) тэргүүтэн «игүлгүжү» гэж, Баяр (11, II, 744), Иринчин (28, 163) «үдтэрлэн икүлкүжү» гэж, Қозин ганцаар «икүлжү» гэж тус тус сэргээсэн мэт санагдана.

Энэ үгэнд хадмал хятад орчуулга үгүй бөгөөд Хэниш «довтлон завдсан буюу бэлтгэх» гэсэн утгатай бололтой гэж таамаглаад «нэн даруй мордон» (15, 72), гэж, Дамдинсүрэн (7, 155), Мансан (27, 185) нар «үтэрлэн мордох» гэж, Пеллио (9, 195) «түргэн хөдөлж» гэж, Қливз энэ үгийг орхиж «үтэрлэн (алхалж) явж» (42, 112—113) гэж, Дугаржав [морьдоо] «юүлж» (24, 130), Элдэндэй Ардажав нар Дорнотив, Хэниш, Жагачид-сэчэн, Қозин, Пеллио нарын орчуулга, тайлбарыг заагаад чигулгажу (хурааж нийлэх) гэсэн үг биш бол йэгүлгэжү гэсэн үг бололтой (8, 556, тайлбар № 1) гэжээ.

Бидний бодлоор бол энэ үг уг худам монгол бичгийн эхэд «гүйүгүлжү» гэж байсныг аман ярианы аялгаар үенүүдийг сольж хэлснээр нь ташаа тэмдэглэсэн байж болох юм. Үүнд гү (1) —йу (2) +гүл (3) +жү(4) гэсэн үенүүдийг йу (2) +гүл (3) +гү (1) +жү (4) гэсэн өөр дарааллаар хэлснээс зайлахгүй. Жич худам монгол бичигт үгийн эхний йэ авиа хожмын монгол хэлэнд и дуудлагатай болсон нь йэкэ —их гэх мэт тохиолдол байх тул «йу» нь «и»-гээр тэмдэглэгдсэн байж болох юм. Нөгөө талаар XIII—XIV зууны үед морь малын хурдлан явуулахыг «давхих» гэдэг үгээс гадна «гүйүкү» гэдэг үгийг хэрэглэж байсан баримт бий.

«Хурга болуд мохубасу билэгү үгэй үл даган ажуху,
Хүрдүн күлүк эчэбэсү михан үгэй үл гүйн (ө. х. гүйүн)
ажуху» (5, 157) гэх-буюу «МНТ»-ы §195-д «экэ-йүгэн орчин то [о] рулун гүйикү унугад мэтү» (25, 104) гэсэн үг байгаа нь «гүйүгүлжү» гэсэн үгийн йү нь йи [и] гээр солигдож байсныг гэрчилнэ. Энэ бүхнээс үзэхэд «игүлгүжү» гэсэн үг утга найруулгын учир зүйн үүднээс «йүгүлгүжү» буюу «гүйүгүлжү» гэсэн үг байсан гэж бодох үндэстэй мэт санагдана.

545. сөни-д-дүлил[и]гэжү (Шөнө дүлилгэж) — гэсэн энэ үгийг хятад галиг эхээс нь Хэниш (36, 38), Пеллио (9, 63) нар «сөнид дүлилигэжү» эж, Лигети (33,109), Иринчин (28, 163) нар уг галигаас нэг дү үсэг орхигдсон гэж үзэж «шөнид» дули дүлилгэжү ~ дүлигэжү» гэж, Рахевильз (25, 94), Дашцэдэн (26, 185) «сөнит дүлил[и]гэжү» гэж, Баяр «шөни дүлигэд күрчү» (11, II, 745) гэж тус тус өөр өөрөөр сэргээсний дээр Дамдинсүрэн (7, 155) «шөни дүли дү» гэж, Дугаржав «сөни дэгэн йабужу» гэж, Мансан «сөни тужи йабужу» гэж утгыг тус тус зөв орчуулжээ.

Хэниш, Пеллио, Элдэндэй Ардажав «сөнид» гэж арай ташаа буулгасан үгээ «шөнийн олон тооны хэлбэр» гэж орчуулсан буюу бууруу тайлбарласан бол Дамдинсүрэн Поуха, Калужинский, Кливз, Дугаржав, Мансан нар шөнид олон тооны нөхцөлгүй харин өгөх орших тийн ялгалын (өгөх оршихын) оронд байгаа үг гэж бидний бодлоор хамгийн зөвөөр ойлгосон шиг байна.

Учир нь бид энэ үгийг сөни (—д) дүлий[—и]гэжүү гэсэн үг байсныг галиглагчид эл хоёр үгийн эцсийн и авиа дараах үгийн эхний д авиатай нийлж сөнид←—дүлилигэжү гэж сонстсон учраас ингэж олон тооны нөхцөлтэй мэт санагджээ гэж бодмоор байна. Нөгөө үгийн үндэс нь «дүликү—унталгүй хонох» (12, 698) гэсэн утгатай үйл үг тул энэ дүли—гэсэн I үндсэнд нь +лгэ гэсэн үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл залгаж дараа нь жү гэсэн үйл үгийн нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл залгасан гэж бодож байна. Энэ нь дага +лга +жу (даалгаж) гэсэн загвараар бүтсэн үг бололтой. Энэ үйл үг «шөнө» гэдэг үгтэй заахын тийн ялгалын нөхцөлийн тэг хувилбараар холбоо үг үүсгэдэг нь «Бид шөнө дүлин явлаа» гэх мэт өгүүлбэрээс бэлхнээ мэдэгддэг билээ.

546. нэнгдэн бүчий-э (угтажу урьтаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 15), Козин (14, 259), Пеллио (9, 63), Лигети (33, 119), Рахевильз (25, 94), Баяр (11, II, 744), Дашцэдэн (26, 119) нар цөм «нэндэн» гэж зөв сэргээдэг боловч харин Элдэндэй Ардажав «нэндэнг» (8, 557), Иринчин «амдан» (28, 162) гэж тус тус ондоогоор буулгасан байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «урьдаас үзэх, болгоомжлох» (36, 15) гэж тайлжээ. Энэ үгийн оронд (§ 166) Лувсандан-зан «ухабасу» (31, 124) гэж, Хэниш «болгоомжлох, угтан харах» (15, 72) гэж, Дугаржав «гэнэт» (24, 130), Мансан «амжин хүрч» (27, 185), Элдэндэй Ардажав (8, 555, т. № 3) хорчины аман аялгуу, «Алтан хаан ы тууж» зэрэгт тулгуурлаж «гэнэдүүлэн дайрах» гэсэн утгатай гэжээ. Иринчин «амдан» гэж сэргээсэн нь сонин сэдэл бодол юм. Бидний бодвол энэ үг «нэнгдэн» гэсэн үйл үг бөгөөд, нэн «угтан мэдэх, хэтүрхүйэ мэдэх» гэсэн утгатай дайвар үгийн үндсэнд «—дэ» гэсэн дагавар залгаж нэндэ гэсэн үйл үг бүтээж түүний үндсэнд үйл үгийн нөхцөл үйлийн хам хэлбэрийн «н» нөхцөл залгасан үг гэж үзэв. Харин энэ үгийн утга «түрүүлэх, хэтрэх, давамгайлах» гэсэн утгатай бөгөөд үүнийг хуучин монгол бичгийн толь бичигт «нэнгдэн—харин» (12, 207 б) мөн тэнд «нэнгдэкү—хэтэрхийдэх» (12, 207 б) гэх мэт үг бүртгэгдсэн нь энэ үг мөн боловч дээр үед худам монгол бичигт өөр утгаар «урьдах» санамсаргүй байхад нь түрүүлж довтлох» гэх буюу урьдаас ухаарах, угтан харах гэх утгатай байсан нь «Нууц товчооны» бусад (§ 166) зүйлээс тодорхой бий. Уг бичигт «нэнгдэн» гэж бичээстэй байсан ч түүнийг хятад үсгээр галиглах үед энэхүү инкэлиг «нг» нь ааас нь залгаж орсон хэлний үзүүрийн өгүүлүүртэй -дэ—нөхцөлийн нөлөөгөөр «нэнгдэжү болж хэлэгдэх ба сонстох болж ийнхүү «нэндэн» гэж ташаа тэмдэглэгдсэн гэж бодож байна.

547. абулга (авлага) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтүүдээс нь судлагчид цөм «аблих-а ~ аблиг-а» гэж сэргээн өнчдөд олгох, асрамж аблигаас авч бай гэж зарлиг болсон гэж цөм зөв зүйтэй ойлгож орчуулсан буюу тайлбарласан учир бидэнд энэ үгийн утгын талаар ярих зүйлгүй.

Гагцхүү бид энэ үгийг «абулга» гэж сэргээх нь илүү зөв гэж бодож байна. Учир нь хуучин (сонгодог) монгол бичгийн уламжлалаар бичигдсэн үгсийн толь бичигт «абулга-бусуд—ача абху йагум-а» (12, 5) гэсэн үг, бас «аблиг-а гэгэли хахуули» гэсэн үг бүртгэгдсэн байгаагаас өнчин хүүхдэд олгох тэтгэмж өглөг бол хэрхэвч хээл хахуулийн зүйл бус авлага өглөгийн зүйл мөн тул худам монгол бичгийн эхэд нь «абулг-а ача абун атугай» гэж бичээстэй байсан гэж бодох үндэстэй. Харин энэ үгийг XIV зууны үед түүнийг хятад үсгийн галигаар нь тэмдэглэгчид тэр үеийн аман аялгууны ташаа дуудлагаар «аблиг-а» гэж ташааран өөр үг болгосон боловч хожим хадмал хятад орчуулга хийхдээ өнчидийн абулга гэх мэт үгийн утгын авцалдаагаар нь зөв ойлгож өнчдөд олгох хишиг тэтгэмжийн зүйл гэж орчуулсан болов уу гэж бодож байна.

548. дунда [г]-а (дундаа) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш (36, 154), Козин (14, 259), Пеллио (9, 64), Лигети (33, 121), Рахевильз (25, 95), Элдэндэй Ардажав (8, 561), Баяр (11, II, 754) нар цөм «тумда'а» гэж, Козин (14, 259), Дашцэдэн (26, 121) нар «тумдаа» гэж, Баяр (11, II, 754), Элдэндэй Ардажав (8, 561) «тумдаг-а» гэж, Иринчин «тумдах-а» гэж тус тус сэргээжээ.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «дугуй, орчин тойрон, бүрэн бүтэн» гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш

«хаалттай бүлэг» (15, 74) гэж орчуулсан бололтой. Бусад нь харьяатныхаа хамт хааны нөгөө арал бол гэснээр (Поуха, Калужинскийн, Кливз) ойлгосон бололтой. Дугаржав харьяат нарыг нь Жаха Хамбуу «бүрнээр захируулж» (24, 132) гэж, Мансан «хөндөлгүй үлдээж» (27, 205), Элдэндэй Ардажав «бүрэн бүтэн гэсэн утгатай тум гэдэг түрэг үг» (8, 561) гэж тус тус орчуулсан буюу тайлбарлажээ. Дамдинсүрэн энэ үгийг алгасч нөгөө «хилгүн бол» гэснийг (надад тус болж яв) гэсэн үг гэж тайлбарласан байна. Бид энэ үгийг «думда[-г] а» гэсэн үг бөгөөд Жаха Хамбу-г харьяатан хүмүүсийн хамт тусгай овгоор нь Чингис хааны хүрээнд дунд бие даан аж төр (амьдар) гэсэн утгатай нэр томьёоны үг гэж бодож байна. Ингэж бодох үндэс нь нэгд, «МНТ»-ы § 208-д «Мэргид найман-у бусунгхуй хогур-тур кэрийэд-үн Жаха хамбу Жирин өкид-үн-ийэн силтаг-ийар өбэр-үн харийатан улус-ийар-ийан дунда-[-г]-а агсан ажуху жэ. Нөгүгэ'[-д] э дайисун болун хагачагсан и...» гэсэн өгүүлбэр байгаад оршино. Энэ өгүүлбэрийг «Нууц товчоон»-ы худам монгол бичгийн эхтэй байсан гэгдэх Лувсанданзан «Мэркэд Найман[-а] бусангхаху [таргагахуй] хогур (жабсар) тур кэрэйид-үн Жиг-а Кимбу [-у] Хойар өкид-үн силтахабар өбэрүн харий-а ту улус-тур-ийан думда[+г—а] агсан ажуху» (31, I, 137) гэж сэргээснээс үзвэл энэ нь «тумдага» «думда» [+г—а] гэсэн үг бичээстэй байсан нь лавтай байна. Иймд энэ үг угтаа өөр овгийн тусгай бүлгийг хүрээнийхээ дунд оруулж «думда (г)-а» байлгахыг хэлдэг үг байснаа хожим хоёр эгшгийг салгаж жийрэглэсэн «г» нь бичигт орж «думдаг-а» гэдэг үг болж нэг овгийн хүрээн дотор нөгөө овгийг бүхлээр нь оруулж амьдруулах гэсэн утгатай нэр томьёо болсон шиг санагдана.

549. алтан көрүгэ (алтан хөнөг) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 53), Пеллио (9, 87), Лигети (33, 121) Рахевильз (25, 95) нар «гүрү'э» гэж, Козин (14, 260), Дашцэдэн (26, 121) нар «күрүэ» гэж, Баяр (11, II, 756), Элдэндэй Ардажав (8, 562), Иринчин (28, 164) нар «күрүкэ» гэж тус тус сэргээн сийрүүлсэн нь хятад үсгийн галигийг дагасан хараахан арай ташимхай сэргээлт болно. Энэ үгийн утгыг хадмал хятад орчуулгын үгийг «дагаж дарсны хэрэгсэл, дарсны хадгалах сав» гэж тайлсан байна. Хэниш «дарсны хэрэгсэл» (15, 74), Дамдинсүрэн (7, 159), Элдэндэй Ардажав (8, 563), Кливз (42, 114) нар «алтан завьяа» гэж, Поуха (17, 119) Калужинский (61, 113), Дугаржав (24, 132) нар «архины алтан сав», Мансан (27, 205), Иринчин (28, 164) нар «архины хөхүүр» буюу «том сав» гэж тус тус орчуулсан байдаг.

Бид энэ үгийг «гүрүкэ» биш, харин «көрүгэ» буюу үүний өөр нэг хувилбар дуудлага болох «көнүк» гэсэн үг гэж бодож байна. Энэхүү тайлбарын № 535-д энэ талаар саналаа хэлсэн тул энд хэмнэе. Бидний бодлоор бол энэ нь архи дарс сөгнөдөг алтан чимэгтэй агар хөнөг гэсэн үг байх.

550. Хори Сүбэчи (Найманы хилийн хайчийн дарга гэсэн хүний алдар) — гэсэн энэ хүний алдрыг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 177), Козин (14, 260), Дамдинсүрэн (7, 161), Баяр (11, II, 761), Магауия (78, 93), нар «Хорису-бэчи» гэж, нөгөө Пеллио (9, 64), Поуха (17, 120), Лигети (33, 122), Калужинский (61, 113), Рахевильз (25, 96), Кливз (42, 115), Дугаржав (24, 134), Мансан (27, 206), Дашцэдэн (26, 122), Элдэндэй Ардажав (8, 567), Иринчин (28, 165) нар «Хори-Сүбэчи» гэж үндсэндээ хоёр янзаар сэргээсэн нь сонирхолтой бөгөөд уг хятад үсгийн галиг ингэж хоёр янзаар сэргээх боломжийг агуулж байгаа нь бүр ч сонирхолтой юм.

Бидний бодоход Хори-Сүбэчи гэж сэргээх нь Хорису-бэчи гэж буулгахаас илүү зөв мэт санагдаж байна. Үүнд энэ хүний нэрийг Элдэндэй Ардажав нар (8, 569, тайлбар № 2) Хори гэдэг нь ерөнхий хамаарах тушаалтай хүний нэр буюу аймгийн нэр болно. Сүб буюу Сүбэ гэдэг нь боомт хавчил зам гэсэн үг бөгөөд Сүбэчи гэмээх нь боомт сахигч болно гэж тайлбарласан нь зөв үнэмшилтэй тайлбар юм. Гэвч Хори гэдэг нь тушаалтай хүний нэр гэсэн энэ үгийг хури гэдэг тушаалын нэр гэж хэлэх гэсэн саная байж болох юм. Бид бол Хори овгийн нэр ч биш, харин Хори гэж жинхэнэ хүний нэр нь сүбэчи гэдэг нь үнэхээр найманы харуулын нэг сүвийг сахигч гэсэн тушаалын нэр алдар нь болж Хори Сүбэчи гэгдсэн нь Йэсүхэй баатар, Хадаан тайши, Дэгэй хонич гэх мэтийн адил болов уу гэж бодож байна. Түүнээс гадна энэ хүний нэрийг Рашид-ад-Дин бас Кори Сүбэчү (4, 1, 2, 132) гэж бичсэн нь сүүлчийн Элдэндэй Ардажав нарын тайлбарын зөвийг давхар баталж байна.

551. нохай нигуртай (нохой нүүртэй) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлаачид «нохай нүүртэй» гэж сэргээн босгох буюу үгчлэн орчуулдаг байсан юм. Гагцхүү Дамдинсүрэн «нохой мэт ичгүүргүй амьтан гэх буюу» (7, 161) гэж далд утгыг нь анх тайлсан байна.

Судлаач Мансаны энэ үгэнд хийсэн тайлбараас (27, 224, тайлбар № 4) Мураками өлөгчин гэж садар самуун эмэгтэйг хараадаг үгтэй холбож тайлбарласныг зааж «эм хүн бүхэн ийм биш, харин ч (Көхэчү) хүний сайныг мэдэхгүй зангилгааны үед царай хувилж хүн танихгүй амьтан гэх санааг илтгэсэн гэсэн нь арай л эндүү тайлбар болжээ. Бас Элдэндэй Ардажав нарын хийсэн тайлбараас (8, 570, Тайлбар № 9) гэснээс үзвэл Сийэ Зай Шан «эм хүн нохой нүүртэй ч шударга...» гэж Дорнотив «тэжээсэн эзнээ дагах гэсэн утгатай гэж тайлбарласныг зажээ. Гэвч энэ үгийн шилжсэн утгын талаар Мостарт «ичгүүргүй самуун» гэсэн утгатайг түүхэн бичгүүдийн олон жишээгээр нотолж бүр анх дөч тавиад онд (47, [107—109]) дэлгэрэнгүй тайлбарласан ба бид урьд бичсэн өгүүлэлдээ (10, 36—48) Монголын нууц товчоонд нохой гэдэг үгийг «ичүүр сонжуургүй», «үнэнч шударга» гэсэн утга шилжүүлэн хэрэглэх утга найруулгын эсрэг тэсрэг хоёр өөр чиглэлээр хэрэглэснийг илэрхийлсэн юм.

Энд «эм хүн нохой нүүртэй гэдьюу зэ» гэсэн нь «ичүүр сонжуургүй үжид самуун» гэсэн утгаар хэрэглэгдсэн болно.

552. алтан жантагу (алтан жантагу) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид «жантао'у ~ жан таоу» (Хэниш, Қозин) «жантаву ~ жантау» (Пеллио, Лигети, Рахевильз, Дашцэдэн), «жантагу» (Баяр, Элдэндэй Ардажав), «жантахур» (Иринчин) гэх зэрэг элдвээр сэргээж утгыг нь хадмал хятад орчуулгад (Хэнишийн орчуулснаар) аяга утгуур цом гэж, зарим судлагчид хундага (Дамдинсүрэн, Дугаржав), нөгөө нь «хундага цом» (Хэниш, Поуха, Қалужинский, Қливз, Мансан) гэх зэргээр ерөнхийдөө хадмал хятад орчуулгыг дагаж орчуулсан байна. Бас энэ үгийн утгын талаар Элдэндэй Ардажав (8, 570, тайлбар № 10) нар буриад хэлний «зантуу» торгууд лам нарын аман аялгууны «жантоу» гэх зэрэг үгтэй холбож сайтар тайлбарласан байна. Гэвч бид энэ үгийг Ун ханы «хөх чунг» гэдэг үгийн тайлбарт (бидний энэ тайлбар № 535) хэлсний дагуу бодож хундага ~ эсвэл хундагу эсвэл ху[н]тагур гэсэн үг өөр нутгийн аялгууны дуудлагаар галиглагдсан болов уу гэж төсөөлж таамаглав. Учир нь урьд цагт хан буюу хаан хүний нэг бэлэг тэмдэг нь алтан аяга хундага утгуураар ууж иддэг явдал байсан бололтой санагддаг. Үүнд «амьд явбал алтан аяганд ус уух» (96, 35) гэсэн цэцэн үг байдаг нь амьд явбал хаан ч болж болно» гэсэн утгатай үг байж болох юм. Жич энэ цэцэн үгэнд алтан аяганд архи буюу цай ууна гээгүй «ус ууна» гэж хэлснийг үзвэл «хундага гэдэг үг архи дарс уух сав» харин хундагу буюу хундагур (Иринчиний сэргээснээр «жантагур») нь ус утгах «цому»-ны нэр байсан байж ч болох юм. Эсвэл энэ цэцэн үг архи цай гарахаас өмнө зөвхөн ус уудаг агсан маш эрт цагаас гарсны гэрч байж ч болно.

553. кэмбэрид-э [гишгилүгүлкү] (хэмх [гишгилүүлэх]) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 65), Лигети (33, 123), Рахевильз (25, 97), Баяр (11, II, 771), Элдэндэй Ардажав (8, 571), Дашцэдэн (26, 124), Иринчин (28, 167) тэргүүтэн «кэмгэрит», «кэмкэрид» гэж сэргээн сийрүүлжээ.

Энэ үгийн утгыг Хэниш «няц гишгэх» (15, 76), Дамдинсүрэн «хэмхчин хаяж» (7, 162), Дугаржав «хэмх хамх гишгэлэж» (24, 136) Мансан «хэмхэчин хаях» (27, 207) гэх мэтээр ямагт үйл үгээр орчуулсан байна.

Бид энд «кэмкэрид-э» гэж үйл үг биш харин «кэмкэрү буюу кэмкэри» гэсэн үгэнд өгөх оршихын тийн ялгалын «э» нохцөл залгахад хоёр эгшгийн хооронд «д» гийгүүлэгч жийрэглэн бичиж бүтээсэн дайвар үг учир түүний ард орсон «гишгилэгүлкү» гэсэн үйл үг нь хятад үсгийн галигт орхигдсон бололтой гэж үзэж ийнхүү оруулж сийрүүлэв. Эсвэл энэ «кэмкэлэ[гэ]д» гэсэн үг байсныг аман аялгууны дуудлагаар «абчу ирэгэд» гэдгийг «абчират» гэж ташаа галигласны нэг адил хэмкэлэ[гэ]д гэж бичсэн байх гэж таамаглаж байна. Харин «кэмкэрид йагу жокику» гэвэл монгол хэлний зүйд нийцэхгүй тул утгын авцалдаагүй болох нь лавтай.

554. торлуг (торлог) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «торлүх» гэж (36, 152) сэргээн, хэдийгээр хадмал хятад орчуулга байхгүй боловч «сул дорой зориггүй» гэж орчуулсан байна. Энэ үгийг судлагчид «торлуг» гэж сэргээн, түүний утгыг Хэниш (15, 76), Поуха (17, 120), Қалужинский (61, 114), Мансан (27, 207), Иринчин (28, 168, тайлбар № 2) нар «дорой» гэж, бусад нь уг үгийг хүн бүхэнд ойлгомжтой гэж тайлбаргүйгээр «торлуг» гэж, Баяр, (11, II, 772), Дашцэдэн (26, 124), Дугаржав (24, 136) гэхчилэн бичиж сэргээсэн боловч чухам энэ үгийг зарим нь жишээлбэл Элдэндэй Ардажав (8, 575, тайлбар № 13) «түрлак» гэж түрэг хэлний «залхуу, хойрго, хичээнгүй биш, салан хааш яаш, туршлага дадлагагүй, юм үзээгүй» гэх утгатай гэж, Иринчин (28, 168, тайлбар № 3) «дорой» гэсэн

түрэг үг гэж тус тус тайлбарласныг бид эргэлзэж байна. Учир нь **«торлуг»** гэдэг бол монгол хэлэнд нойтон туяхан бургас модны нэр бөгөөд урьд хүрээ хийдийн банди нарыг номоо үзэхгүй буюу сахил сахилга алдагдуулвал тийм нойтон бургасаар нүцгэлэн ороолгож цээрлүүлэхийг торлогдаху гэдэг байсан тул уяхан зөөлөн биеэ дааж чадахгүй сул дорой зан авирт Даян ханыг тэр модтой зүйрлэн хэлсэн нь үзтэл илэрхий. Чухам ийм учраас ч Дамдинсүрэн **«торлуг гуа биетэй торомгор бор хүү минь»** (7, 163) гэж орчуулсан нь монгол хэлний үүднээс утгыг хамгийн зөв илтгэсэн гэж бид бодно. Энэ үг монгол хэлний үгсийн сангийн толь бичигт «торлуг—нарийн мод» (12, 608б) гэж бүртгэгдсэн байх тул түүнийг «түрак» гэсэн түрэг үг уруу адил төстэй үгээр тайлбарлах нь төдий л үнэмшилтэй биш юм.

555. идүрэхүй хучал (гаарах хучал) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 80), Козин (14, 261), Пеллио (9, 65), Лигети (33, 124), Рахевильз (25, 97), Баяр (11, II, 772), Дашцэдэн (26, 124), Элдэндэй Ардажав (8, 571), Иринчин (28, 167) цом **«идүрэкүй хучал»** гэж сэргээн сийрүүлсэн нь, миний бодоход, эргэлзэх газаргүй.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш **«давхин** хурдлан, эргэн хоргон» (36, 80) гэж тайлсан бололтой. Тэгээд энэ үгийг Хэниш «Бидэнд ёрлох мэт» (15, 76) гэж, Дамдинсүрэн «муу ёроор» (7, 163), Калужинский (61, 114), Кливз (42, 117) нар **«муу** ёр айсуй мэт хуцах» гэж, Дугаржав «бачимдсан мэт хуцлаар» (24, 137), Мансан **«сүрхий муухай улин хуцаж»** (27, 205—206) гэж тус тус орчуулсан шиг санагдана. Элдэндэй Ардажав «Идүрэхүй гэмээх нь үдэрэкү үгийн эртний дуудлага хадмал (хятад) орчуулгад ойртох утгатай... монголчууд өтлөө насанд хүрэхийн цагт нохойн хуцал дуу ойртох тутам миний үхэх хүрч ирнэ гэмээн тэд өгүүлж, үхэл дөхсөнийг зүйрлэдэг юм. Тус зүйлд муу ёрын бэлгийг харуулж байна» Шагж нүүр 179а-д «үдэрэкү гэмээх нь ойртож» (8, 576, тайлбар № 16) гэж тайлбарлав. Энэ нь бараг зөв байх. Гэвч энэ «нохойн дуу ойртох» гэсэн үг заавал үхэл хатал ойртов гэсэн үг биш бөгөөд аян жин, цэрэг сургуульд явсан хийгээд аливаа удтал хийсэн ажил, дуусах дөхлөө» гэсэн утгатайг анхаарууштайн дээр нохойн хуцах дуун их тэвдүү ямар нэг аюулт амьтантай барилцах мэт түргэн түргэн бачим яаруу хуцахыг аван идэн алдаж хуцах гэх тул үүнээс гадна «үдтэрэхүй» (хурдсаж тэвдүү) хуцах гэсэн өөр үгтэй холбоотой байж ч болох юм. Дөрвөн нүдтэй улаан халтар нохой гэдэг нь хөмсөгийн оронд хоёр нүдний нь дээр хоёр шар толботой халтар нохойг хэлдэг бөгөөд тийм нохой тэр хөмсгийн хоёр шар толбоороо далдын юмыг үздэг гэж монголчууд итгэдэг тул нохой шалтгаангүй аяндаа улин хуцах, боорлож хуцахыг тухайн айлд ойртож ирж буй гай зэтгэр аюул зовлонг зөгнөсөн «идэрэхүй» (ид шидэт) хуцал гэсэн үг ч байж болмоор санагдана.

Найманы хатгалдагч баатар Найманы хаант улсын мөхөх гай нүүрлэсний муу ёрыг нохойн тэр бачимдан хуцах бэлэг тэмдгээр сануулан хэлсэн гэж бодох үндэстэй мэт санагдана.

556. тэдгэд — гэсэн энэ үг нь **«тэдгээр»** гэсэн холын юмыг заах үүсмэл төлөөний үгийн олон тооны хэлбэр бөгөөд энэ үг «монголчууд» гэсэн олон тоот нэр үгэнд хамаарагдаж буй тул түүнтэйгээ олон тооны нөхцөлөөр зохицож байсны нэг баримт болно.

557. барта [г] тан (бартагтан) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш **«барату»** (36, 13) гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын үгийн нь утгыг «хар (бараан) хувцастан» гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 66), Лигети (33, 124), Рахевильз (25, 98), Баяр (11, II, 775), Элдэндэй Ардажав(8, 572) Дашцэдэн (24, 125), Иринчин (28, 167) тэргүүтэн цом **«баратутан»** гэж сэргээн босгосон нь хятад үсгийн галигийг дагасан хэрэг юм.

Энэ үгийн утгыг Дамдинсүрэн (7, 163), Хэниш (15, 76), Калужинский (61, 115), Кливз (42, 117), Дугаржав (24, 138) нар цом «хар муухай, хар бараан» гэх мэтээр орчуулсныг болон хадмал орчуулгын алдаатайг Элдэндэй Ардажав (8, 577—578, т, тайлбар № 22) гэж зөв зүйтэй шүүмжлээд хир буртаг, бузар буртаг гэсэн утгатайг заажээ. Мансан «хар бузар хувтастай» (27, 208) гэсэн хамгийн оновчтой зөв орчуулга болсон гэж бодож байна. Учир нь бид энэ үгийг «буртаг» гэдэг үгийн өөр эртний авиа сэлгэлтийн хэлбэр болох «бартаг» гэдэг үг дээр ту (эр хүйс) тай (эм хүйс), тан (олон тоо) гэсэн харьцангуй эзэмшигчийн утга оруулах дагавар залгахад р гийгүүлэгч төгсгөл нь хасагдаж **«бартатан»** гэсэн нэр үг үүссэн гэж үзэж байгаа учир барату-тан биш **«бартатан»** гэж сэргээх нь зөв гэж бодож байгаагаа тэмдэглэе.

558. силугун (шулуун) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 140), Козин (14, 261), Пеллио (9, 66), Элдэндэй Ардажав (8, 572), Лигети (33, 124), Рахевильз (25, 98) нар **«шилигун»** (шулуун)

гэж, нөгөө Баяр (11, II, 776), Дамдинсүрэн (7, 164), Дашцэдэн (24, 125), Дугаржав (24, 138), Мансан (27, 208) гэж тус тус ухааран сэргээсэн байхаас гадна Хэниш (15, 76) «язгуур сайт» (арагуухан?), Дамдинсүрэн (7, 164), Мансан (27, 208) нар «шилдэг сайн» Дугаржав **«цэвэр шилдэг»** (24, 138) гэж, Поуха «ховор охин» (17, 122), Кливз «гоёмсог охид» (42, 117) гэж тус тус орчуулсан буюу тайлбарласан **бололтой байна.** Бид энэ үгийг **«силигун»** буюу «шилигүн» бус «шилүгү» гэсэн үг гэж үзэж байгаа бөгөөд энэ үг нь «шулуун шударга» гэхээс гадна «аруухан ариун цэвэр» гэсэн утгаар XIII—XIV зууны үед хэрэглэгдэж байжээ. Үүний баримт нь Бодичарьяавадарагийн XIV зууны эхний орчуулгад: «күжи-бэр сүрчиксэн аригун шилүгун гажар тур, сэткил-дур жокис-ту сэчиг-үд-и дэлгэн сачумуй би» (40, 13) гэж бичсэн явдал болно. Иймд «шилүгун бэринэд өкид»гэдэг нь ариун цэвэр бэринүүд охид гэсэн утгатай нь дамжиггүй үнэн биз ээ.

559. Тэмэгэн кэгэр-э-йи абалажу, Түргэн чикид-и хамурчу (Тэмээн хээрийг авлаж, Түргэн чихидэйг хамарч) — гэсэн энэ хэллэгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш «Тэмэйэн кэгэр» (36, 182), «Түлкин чэ'үт» (36, 182) гэж сийрүүлээд газрын нэр гэжээ.

Энэ үгийг бүх судлагчид цөмөөр хятад галиг ба хадмал орчуулгыг баримтлан «Тэмэгэн кэ'эр-и абалажу, Түлкин чэгүд-и хоморчу» гэж сэргээн газрын нэр гэж тайлбарладаг билээ. Элдэндэй Ардажав нар Х. Пэрлээн саналыг үндэслэн энэ газрыг Халх голоос баруун хойш, мөн Халх голын ойр байсан гэх боловч энэ тайлбар төдий л үнэмшилтэй биш юм.

Бид энэ хэллэгийг Тэмэгэн кэгэр-э-йи аблажу, Түргэн Чихид (Чихидэй буюу адуун гөрөөсийг) хамран (бүсэлж) ав хийж явсан гэсэн үг байсан болов уу гэж өөрөөр бодож үзэж байна. Ингэж бодох үндэс гэвэл нэгдүгээрт «Тэмэгэн хэгэр-и абалажу» гэж, нөгөө «Түлкин чэгүд-и хоморчу» гэж хоёр өөр үйл үг хэрэглэсэн явдал болно. Аблаху гэдэг үгийг голдуу ав тавьсан газарт, нөгөө «хомурга» гэдэг үгийг нөгөө агнаж буй амьтанд холбогдуулан хэрэглэдэг байсан баримт түүхэн бичиг ба түүний дотор уламжлан ирсэн домгуудад байна: «Хангай хан**дур** йэкэ аба талбихуй-дурийэн жарлаба. Бөртэ Чину-а Хоба Марал орху буй. «Тэгүн-и бүү ала» (5, 39) гэсний дотор ав гэдэг нь ан хийсэн газарт, «орох» гэдэг үг нь хоморгонд хамаарагдаж байна. Бас «Идсэн чоно хонгилд, Идээгүй чоно хоморгонд» (98, 38 б) гэсэн зүйр цэцэн үг ч үүнийг давхар баталж байна.

Хоёрдугаарт «чэгүд» гэдэг үг «Нууц товчоон»-ы өөр зүйлд (§ 274) «Чормахан хорчи-йи мөн тэндэ тама[гачи]сагужу... күжүгү уртус, көл өндүр Төбичэгүд» (9, 114) гэж бичсэний энэхүү тоби чэгүд гэдэг нь том биет адуу морьд гэсэн үг болох нь адуун гөрөөснийг «чикид» (чикидэйн олон тооны хэлбэр) хэлсэн нь илэрхий тул энэ түлкин чэгүд—гэж буруу галиглагдсан «түргэн чикид» гэсэн үг байж болно гэж бодсон юм. Сонирхолтой нь «тому» гэдэг үг Нууц товчоонд огт гардаггүй тул «тоби» гэдэг үгнээс «тому» гэдэг үг үүссэн болов уу гэж таамаглаж бай нам. Чэгүд биш «Чикид» гэж сэргээх нь энэ амьтны нэр «хулан чихидэй» гэдэг үгэнд орсон Чихидэй гэдэг үг халхын аялгуунд ц-гээр биш ч-гээр дуудагдаж байгаа баримт энэ амьтны нэр чики гэдэг үгнээс үүссэнийг батлах тул чэгүд биш «чикид» гэж бичдэгийг хожмын аман аялгаар, тэгэхдээ «түргэн» гэсэн үгийг «түлкин» гэж хазгай дуудлагаар галигласан болов уу гэлтэй.

560. дагус [ха] жу (дуусгаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио тэргүүтэн судлагчид цөм «да'усху» (36, 33), «давусчу» (9, 67), «дагусчу» (11, II, 795) гэх зэргээр сэргээн сийрүүлж утгыг нь «дуусаад» (7, 167) гэсэн утгатай үг гэж санал нэгтэй үзэж байв. Иймээс «Нууц товчооны» худам бичгийн уг эхэд ч бас «дагусчу» гэж алдаатай бичигдсэн байжээ гэж бодож болмоор юм.

Гэвч монгол хэлний зүйн үүднээс авч үзвэл энэ үг «дагусчу» гэж байхгүй харин «дагусгаж» гэж үйлдүүлэх хэвийн нөхцөлтэй бичигдэх ёстой мэт бидэнд санагдаж байна. Учир юун гэвэл эс тусах «дуусч» гэсэн үг урдаа «кэсик эдүр-ийэн» заахын буюу шууд тусагдахуун авч учир зүйн талаар тохирохгүй. Иймээс бид энэүги йг «дугус [ха] жу» гэж сэргээж байна.

561. төридчү (түрдэж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас Хэниш (36, 152) «төритхү» гэж сэргээгээд хадмал хятад орчуулга үгийн нь утгыг «барьж тогтоох» гэж тайлсан юм. Энэ үгийг Қозин (14, 263), Пеллио (9, 68), Лигети (33, 128), Рахевильз (25, 100), Баяр (11, II, 799), Элдэндэй Ардажав (8, 588), Иринчин (28, 172) тэргүүтэн судлагчид цөм «төритчү» гэж сэргээгээд энэ үгийн утгыг Дамдинсүрэн «хүрч буугаад» (7, 167), Поуха уўл үгийг орхин (17, 125), Дугаржав «түр түтгэлзэн саатаж» (24, 143) гэж Мансан «багугад» (27, 211) гэж, Элдэндэй Ардажав (8, 589, тайлбар № 6) «зогсож», «явахаа байж» гэж тус тус ойлгож орчуулсан нь үндсэндээ зөв юм.

Гэвч энэ үгийг монгол бичгийн хэлэнд «төриткү—эвдрэн өнгөрөх» (12, 631б) бүртгэгдсэн байх бөгөөд мөн XIV зууны үеийн бичгийн дурсгалд «хамуг бурхан бодисаду-а нар төритгэл үгэй насу үзэгч буюу» (40, 42—43) гэх зэрэг өгүүлбэр байгаагаас үзвэл энэ нь «зогсолтгүй», «саатуулж болохгүй» гэсэн утгатай үг бололтой. Бидний бодвол энэ үг монгол хэлэнд ө, ү хоёр эгшиг авиа ялгаран салаагүй байхад «төриткү» гэж үүсээд дараа нь «түридкү» гэж дуудагдах бололгүй хэвээр хоцорсон үг шиг санагдана. Утга нь «эвдрэн өнгөрөх» биш аливаа нэг үйл явц мөнхийн үргэлжлэх бус, харин түр болох саатах гэсэн утгатай «түрдэх» гэсэн үг болов уу гэж төсөөлнө.

562. огжатхай-а (цочион айлгах) — гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «огжатху» гэж сэргээн сийрүүлээд түүний хадмал хятад орчуулгын утгыг нь «айх цочих, ай...ах» (36, 122) гэж тайлсан байна.

Энэ үгийг Козин (14, 263), Пеллио (9, 68), Лигети (33, 128), Рахевильз (25, 101), Баяр (11, II, 801), Элдэндэй Ардажав (8, 588), Дашцэдэн (26, 129), Иринчин (28, 172) нар цөм «огжатхай-а» гэж сэргээдэг байна.

Энэ үгийн утгыг Хэниш «гал ба мануухайгаар айлгах» (15, 79) гэж. Дамдинсүрэн «сүр бадруулъя» (7, 168) гэж, Поуха (17, 125) Калужинский (61, 117) нар «галаар дайсны эс тоох явдлыг даръя» гэхчилэн, Кливз (42, 121), Дугаржав (24, 143), Мансан (27, 211) нар «галаар сүрдүүлье, айлгая, цочооё» гэж тус тус ойлгож орчуулснаас гадна Элдэндэй Ардажав (8, 590, тайлбар № 11) «огз-огц» гэсэн үндэстэй үг: 1) балмад, зэрлэг, ихэрхэг, хэгсгэр, ярамтгай тэвдүү—огцом бодлого, 2) цочмог, гэнэт, санамсаргүй гэх зэрэг олон үгээр тайлж одоогийн хэлэнд «огзомлаху—огзом зан гаргах, холчлох бодлогогүй» гэх мэт Шагжийн толийн заалт (12, 111) гэх мэтийг зааж тайлбарлажээ.

Бидний санавал энэ үг дурдсан тайлбарт заасан олон утгын дотроос тэр үед чухамхүү «айх, цочих, сүрдэх, ширвэгдэх» явдал голлож байсан гэж бодно. Энэ нь уул үг «МНТ»-ы өөр зүйлд (§ 199) «одун огжатчу, харин (эргин) харбучажу огургату хулан сумуту бугу болжу одба» (25, 109) гэж, 244 дүгээр зүйлд «...огжатчу гаруусан-и онтучажу оругулху бүлэгэ» (25, 140) гэх мэтээр хэрэглэгдсэн байдлаас ил байна. Жич энэ «ог—» гэсэн үгийн язгуураас огзом, огцом, огло үсрэн, огцрох гэхчилэн үүссэн төрөл олон үгс байна гэж бодном. Иймд энэ үг нь: ог (үгийн идэвхгүй язгуур)+з=огж (дайвар үгийн үндэс) +[а]т (дайвар ба нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +чу (үйл үгийн нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй монгол үг гэж тайлбарлая.

563. өл [и] гэс (өндөр уулс) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «өлкэс» гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын нь утгыг «уулсын өвөр тал», «уулын хормойн газрууд» (36, 123) гэж тайлжээ. Энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 68), Лигети (33, 129), Рахевильз (25, 102), Баяр (11, II, 811), Дашцэдэн (26, 130), Иринчин (28, 173), Элдэндэй Ардажав (8, 592) цөм «өлкэс» буюу «өлгэс» гэж сэргээн босгодог билээ.

Энэ үгийн утгыг ч Хэниш (15, 20), Поуха (17, 126), Калужинский (61, 118) нар «Алтайн өвөр уулс хүртэл» гэж, Дамдинсүрэн «Алтайн Өлүгэй ий хүртэл-э» (7, 169), Дугаржав (24, 145), Кливз (42, 122), Мансан (27, 213) нар Алтайн «доор», «хөл», «хормой» хүртэл гэж тус тус орчуулсан байхаас гадна Элдэндэй Ардажав (8, 595, тайлбар № 11) нар газрын тусгай нэр гэж «Чингис богдын өчиг» Х. Пэрлээгийн өгүүллийг иш татан заахын хамт өлгөс гэдэг нь «өлгэ»-гийн олон тоо, уулын өвөр, энгэр, урд этгээд» гэж толь бичиг заан тайлбарласан нь эргэлзээгүй зөв шиг санагдана.

Гэвч энэ үгийг бид «өл [и] гэс» гэсэн үг болов уу гэж үзэж байгаагийн учир зөвтгөл нь өли хөтүл (өндөр хөтөл) гэж хэлсэн болов уу гэж бодмоор байна. Үүнд «Чинггис-үн чадиг (чэдиг)»-ийн дотор «ха [га] н ача часун унабасу хатун сиру (шируй) абурайу, хатхулдуху өдүд (эдүд—өдрүүд) күрбэсү хагучин өри уруг абурайу. Өлгэ-д —эчэ часун унабасу өтүд (өтүг) сиру (шируй) абурайу. Үкүлдүкү өдүд (эдүд—өдрүүд) күрбэсү өтүгэ өри абурайу» (5, 155—156) гэсэн өгүүлбэр байгаагаас үзвэл энэ «өлгэ» гэдэг үг өндөр уулс гэсэн үг болох нь ил байна. Учир нь үүний нөгөө бадаг ха [га] наас цас унавал гэсэн нь мөн «хан уулнаас» гэсэн утгатай үг байгаагийн адилаар ухагдах ёстой гэж үзэв.

Иймээс бид «ел [и] гэс» гэдэг үг гэж бодож байна. Хэрэв Алтайн өвөр гэсэн үг байсан бол эрхбиш (эл[и]гэс» гэж бичих байсан болов уу. Тийм бол «элигэ», «эбүр», «энггэр» зэрэг үг төрөл үгс байх учиртай. Өл [и] гэс гэдэг үг бол «өли—өли көтүл зэргийн» (12, 168), «өликү

—хөшин эргүкү» (12, 168) «өлийкү—толгой, өлийкү мэтү йин» (12, 168) гэх мэт үгэстэй язгуур нэгтэй өли+гэ гэсэн үг баймаар санагдана.

564. нохай хэрүл (нохой хэрэл) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш «кэрэл» (36, 99) гэж сэргээгээд хадмал хятад орчуулгын утгыг нь «нохой мэт нэг нэгэнтэйгээ тэмцэх» (36, 99), гэж тайлсан байна. Энэ үгийг Пеллио (9, 68), Лигети (33, 129), Рахевильз (25, 102), Баяр (11, II, 811), Дашцэдэн (26, 130) Элдэндэй Ардажав (8, 592), Иринчин (28, 173) тэргүүтэн «нохай хэрэл» гэж сэргээн үүний утгыг Хэниш (15, 80), Поуха (17, 126), Кливз (42, 122) нар «нохойн тэмцэл (тулалдсан?) тэмцэж» гэж, Дамдинсүрэн «займруулан чирэгдүүлэн» (7, 69) гэж, Дугаржав «нохай хэрүл-ийэр кэрүн йабужу» (24, 145) гэж, Мансан «нохай кэрэлгүлдэкү мэтү жигуралдун байилдужу йабуя» (27, 213) гэж тус тус ойлгож орчуулснаас гадна Элдэндэй Ардажав нар «хэрэл» —үгийн язгуур хэрэ. Бичгийн хэлний «хэрэгүл» гэмээх нь хэрэлдэх, цохилцох, зодолдох» (8, 595, тайлбар № 12) гэж тайлбарлажээ.

Бидний бодоход Дугаржавын «хэрүн явах» гэсэн нь илүү зөв гэж бодох бөгөөд энэ үг нүүдэл даган яваа нохой ийш тийш хэрэн (хэрүн) хэсэн явдаг тул түүнтэй адилаар «ийш тийш гажиж «займруулан» (Ц. Дамдинсүрэн) явах гэсэн утгатай гэж бид урьд бичсэн өгүүлэлдээ (10, 112—116) нэгэнт тайлбарласан тул энд хэмнэе.

565. эбэртэл-э, бэртэтэл-э (өвдтөл бэрттэл) — гэсэн энэ үг судлагч эрдэмтэд цөм ийнхүү сэргээн өвдөх бэртэх гэсэн утгатай гэж орчуулсан буюу тайлбарласан бөгөөд үүнийг зөв гэж хүлээн зөвшөөрөхөөс өөр зүйлгүй.

Харин энэ үгийг судлагчдын хятад үсгийн галигаас сэргээдгийн адил «эбэрэтэлэ» гэх нь арай ташаа бөгөөд харин «эбэргэл-э, бэртэтэл-э» гэж сийрүүлэх нь илүү зөв гэдгийг тэмдэглэе. Учир нь хуучин (сонгодог) монгол бичгийн хэлэнд уламжлан ирсэн энэ үгийн өөр хувилбарыг «эбэрсийэкү—хатгалах хорсох зэргийн» (12, 53) гэх буюу «эбэрлэкү—эбэрсийэкү» (12, 54) гэх мэт уламжлалт бичлэг нь бүртгэгдсэн тул бид «эбэрэтэлэ» гэх нь ташаа гэж бодож сэргээв.

566. агтын харгам (агтын харгам) — гэсэн энэ үгийг судлагчид хятад үсгийн галигаас нь «хархам» (харгам) гэж сийрүүлдэг бөгөөд үүний утгыг нь хадмал хятад орчуулгаар нь Хэниш «гуя, хойд гуя» (36, 61) гэж тайлсан бидний бодлоор хамгийн зөв юм. Энэ үгийг Хэниш (36, 61), Поуха (17, 127) нар «агтны хойд гуя» гэж, Дамдинсүрэн «агтаа ухруулж» (7, 170) гэж, Калужинский (61, 194), Кливз (42, 123) «агтын бөгс» гэж тус тус орчуулснаас гадна Өвөр Монголын судлагч Дугаржав (24, 146), Мансан (27, 213), Элдэндэй Ардажав (8, 593) нар энэ үгийг огт тайлбаргүйгээр хэн бүхний мэдэх үгийн ёсоор «харгам» гэж хэрэглэн сийрүүлсэн байдаг.

Гэвч бид энэ үгийг Хэниш нарын орчуулгын адилаар агт морины гуя гэж орчуулах нь төдий л үнэмшилтэй бус, харин бөгс гэдэг нь илүү ойр гэж бодно. Учир нь энэ үгийг С. Шагж «харгам-морь малын хондлойн арьс» (12, 332 б) гэж толь бичигтээ оруулсан тул харгам гэдэг нь морины хондлой гэсэн үг лавтай мөн.

567. чима хайиран (юутай харамсалтай) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «чима хайиран» гэж утгыг хадмал хятад орчуулгаар нь «шүүрс алдах, гаслах аялга» (36, 27) гэж оновчтой зөв тайлсан юм. Энэ үгийг Пеллио, (9, 69), Лигети (33, 130) Рахевильз (25, 103), Баяр (11, II, 814), Дашцэдэн (26, 131), Элдэндэй Ардажав (8, 593), Иринчин (28, 174) цөм «чима хайран» гэж сэргээсэн бөгөөд энэ үгийг Хэниш (15, 81), Калужинский (61, 118), Поуха (17, 127) тэргүүтэн) «юутай харамсалтай» гэсэн халаглан харамсах аялга үгээр орчуулсан бололтой байна.

Баяр Дугаржав (24, 147), Элдэндэй Ардажав (8, 599, тайлбар № 34, нар) «чим-а» гэдэг үгийг харамсах аялга үг нь дангаараа мөн бөгөөд «чима—гэдэг нь «чи» гэсэн утгатай гэж, **нөгөө «хайран» гэсэн** үгнээс нь салгаж ойлгожээ. «Хайран» гэдэг нь Хөхсүү **сабраг баатрыг** өрөвдсөн өөр аялга үг гэж цөм ойлгосон бололтой нь сонирхолтой боловч төдий л үнэмшилтэй биш юм. Харин Дамдинсүрэн (7, 170), Мансан (27, 213) нар тус тус «чима хайиран» гэсэн үгсийг нэг харамсах аялга үг гэж ойлгоод «хөөрхий» гэсэн ганц үгээр «Көгсэгү Сабраг» баатарт хамааруулан хэлсэн нь илүү зөв орчуулга болжээ.

Бидний бодвол энэ «чима хайиран» гэдэг харамсах аялга үгсийн чима нь «чи бас» (чаабаас) гэдэг өөр харамсах үгийн нэг хувилбар бус, харин чимлах (харамсах) гэдэг үгийн язгуур аялга үг болно. Энэ үгийн үндэс нь «чи—» биш, «чим» гэсэн өөр үг болох нь § 176-д «йагун чимартур нама-йи айугулба» гэх буюу § 242-д «дэгү нар-ун мину нилх-а отчигин буй жэ гэмэжү экэ-д-э отчигин-у хуби кигэд түмэн иргэ өкбэ. Экэ чиматчу эсэ донггудба» гэх зэрэг үгс дурдагдсанаас илэрхий мэ-

дэгддэг билээ. «Арай чимай» гэдэг хоршоо үгийн «чимай» нь мөн энэ чима—гэсэн язгуураас үүссэн төрөл үг гэж бодно. Чи гэдэг төлөөний үгээс үүссэн үг гэвэл чим-а (чамд) гэсэн өгөх оршихийн тийн ялгалын хэлбэрээр аялга үүссэн гэж итгэх аргагүй.

568. Харагана жорчил (харгана зорчил) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь судлаачид цөм «харахана» буюу хараган-а жорчил» гэж сэргээдэг бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «ширэнгэ» бут шиг жагсаалын нэг маяг (36, 60) гэж тайлсан юм.

Энэ үгийг Дамдинсүрэн анх «харгана-йин думдагур хатхулдан байилдажу» (7, 171) гэж байлдааны газар орныг заасан үг мэтээр орчуулсан бол энэ номын III хэвлэлтэд «харгана зорчлоор хатгалдаж» (102, 146) гэж залруулсан байна. Поуха (17, 128) Калужинский (61, 119), Кливз (42, 124), Дугаржав (24, 147), Мансан (27, 214) нар «харгана шиг маягаар явах жагсах» гэж орчуулсныг Мансан (27, 228, тайлбар № 20) Элдэндэй Ардажав (8, 606, тайлбар № 8) нар дайны арга тактикийн утгатайг дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Гэвч энэ үгийн ийм дайн хийх арга тактикийн учир холбогдолтой бөгөөд харгана мэт «цөөн цөөнтэй бүлэг болж таруу давшин явна гэсэн» утгатайг бид урьд бичсэн нэг өгүүлэлдээ (10, 116—117) нэгэнт бичсэн учир үүгээр тайлбараа цэглээ.

569, нагур байилдуг-а (нуур байлдаа) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 114), Лигети (33, 131) «на'ур байилду'а байилдужу» гэж, нөгөө Пеллио (9, 69), Баяр (11, II, 822), Элдэндэй Ардажав (8, 600), Иринчин (28, 175) нар «на'ур байду байилдужу» гэж, Козин (14, 265), Дашцэдэн (26, 132) нар «наур байлду байилдужу» гэж, Рахевильз «на'ур байи[л]ду (?) байилдужу» (25, 103) гэж тус тус сэргээснээс бид хамгийн зөвөөр сэргээсэн нь Хэниш, Лигети нар гэж бодож байна. Хятад галигт энэ үгийг «байиду» гэж ташаа тэмдэглэсэн болов уу гэж бодож байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг «нуур маягийн тэмцэл хийх арга» (36, 114) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 81), Поуха (17, 128), Мансан (27, 214) «нуур мэт байрлан засаж» гэж, Калужинский «нуур хэлбэрийн бүгээ бүгж» (61, 119), Кливз (42, 124), Дугаржав (24, 147), Элдэндэй Ардажав (8, 606, тайлбар № 9) нар байлдааны журам буюу жагсаал жагсаж гэж тус тус ойлгосон буюу тайлбарласан байна. Дамдинсүрэн энэ үгийг «нуурын хөвөөгөөр нудралдан тэмцэж» (7, 171) гэж, дараа нь «нуур байрлалаар байрлаж» (102, 146) гэж засварлан зөв болгожээ.

Энэ үгийн утгыг бид «нуур мэт өргөн дэлгэр байр эзлэн дайсан этгээдэд их цэрэг байгаа мэт сүр үзүүлэх гэсэн бололтой» (10, 117) гэсэн саналаа урьд бичсэн өгүүлэлдээ нэгэнт бичсэн тул энд үүгээр тайлбараа товчилъё.

570. сигучи хатхулдуга хатхулдуй-а (цүүц хатгалдаа хатгалдъя) гэсэн энэ өгүүлбэрийг хятад үсгийн галигаас нь Хэниш «си'үчи хатхулду'а» гэж сэргээгээд хадмал хятад орчуулга үгийн утгыг «өрөм маягийн тэмцлийн (дүр?) хэлбэрээр тэмцэх» (36, 114) гэж тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 69), Лигети (33, 131), Рахевильз (25, 103), Баяр (11, II, 822), Дашцэдэн (26, 132), Элдэндэй Ардажав (8, 600), Иринчин (28, 175) тэргүүтэн цөм «си'үчи хатхулду'а хатгулдуйа» гэж сэргээн босгосон байна. Эл үгийн утгыг Хэниш (15, 81), Поуха (17, 128) «өрөм хэлбэрийн тулаан» гэж, Дамдинсүрэн анх «ирт мэсээр ивэлцэн тулъя» (7, 171) гэж дараа нь «цүүц хатгалдаанаар цөмөрч тулъя» (102, 146) гэж, Калужинский (61, 119), Дугаржав (24, 147), Элдэндэй Ардажав (8, 607, тайлбар № 10), Мансан (27, 228), Иринчин (28, 278, тайлбар № 2) Баяр (11, II, 822) нар цөм «цүүц хатгалдаан хатгалдъя» гэж зөв орчуулжээ.

Бид энэ үгийн утгын талаар урьд нийтлүүлсэн өгүүлэлдээ (10, 116—119) нэгэнт тайлбарласнаа энд тэмдэглэе.

571. дөрбэн нохас (дөрвөн ноход) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 118), Пеллио (9, 70), Баяр (11, II, 725), Дашцэдэн (26, 133), Элдэндэй Ардажав (8, 601) нар нохайс» гэж, Лигети (33, 131), Рахевильз (25, 104) нар «нохаи]с-и» гэж Иринчин (28, 175) «нохас-н» гэж тус тус сэргээх босгож сийрүүлсэн байна. Гэвч бид «дөрбэн нохад-и» гэж сийрүүлэх нь илүү зөв гэж үзсэн юм. Энэ холбоо үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нохайс» (нохойн олон тоо) гээд «нохай» гэж (36, 118) гэж тайлсан байна. Дамдинсүрэн (7, 171) Хэниш (15, 81), Поуха (17, 128), Калужинский (61, 119), Дугаржав (24, 148), Мансан (27, 214), Кливз (42, 125) цөм «дөрбэн нохай» гэж орчуулсан боловч энэ холбоо үг чухам ямар учиртай хэрэглэгдсэнийг Мансан (27, 230, тайлбар № 23) баатарлаг туулинд хэлдэгийн адил уран зохиолын хэллэг гэх төдий тайлбарласан байна. Энэ үгийн хэрэглэгдсэн найруулгын онцлогийг Мостарт §188-д

буй «эмэ күмүн нохай нигуртай кэмэгдэбэ жэ» үгэнд холбогдуулан дэлгэрэнгүй тайлбарласан (47, [108—109]) билээ.

Дараа нь бид энэ «дөрвөн нохойс» гэдэг үгийг дурсгалт бичигт өөр (үнэнч итгэлтэй гэсэн) утгаар хэрэглэсэн хийгээд ер нь «нохай» гэдэг үгийг найруулга зүйн өөр өөр утгаар хэрэглэдэг тухай урьд нийлүүлсэн өгүүлэлдээ (10, 36—48) дэлгэрэнгүй тайлбарласан тул энд үүгээр тайлбараа товчилъё.

572. то(о)рулун [то [о]рлан] (торлон) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглаас нь Хэниш (36, 152), Пеллио (9,70), Лигети (33, 132), Рахевильз (25, 104), Баяр (11, II, 832), Элдэндэй Ардажав (8, 602), Дашцэдэн (26, 133), Козин (14, 266), Иринчин (28, 176) цом «торолун» гэж сэргээдэг нь энэ үгийг XIV зууны үед хэлж байсан аман аялгууны дуудлагыг тусгахаас хэтэрсэнгүй гэмээр бодогдоно.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «тайвангүй» «Нааш дураар гүйгч унага» гэхчлэн тайлсан бололтой. Энэ үгийг Хэниш (15, 82), Поуха (17, 129), Калужинский (61, 120), Дугаржав (24, 149—150), Мансан (27, 216), Дамдинсүрэн (7, 172) нар цом эхийнхээ тойронд хурдлан давхигч» гэж адил төстэйгээр орчуулсан боловч энэ «то[о]рулун» гэсэн үг чухам ямар утгатай үг болохыг тодорхой тайлсангүй. Элдэндэй Ардажав нар торолун-гэдэг үгийг баргын аялгуунд унага эхийгээ тойрон баярлан давхихыг хэлдэг гэхийн хамт түрэг хэлний «торлан» унага өсөх ба сайжрахыг өгүүлнэ гэснээс гадна «тору» (тоос) гарган давхих гэсэн утгатай (8, 610, тайлбар № 27) гэжээ. Бидний бодоход энэ үгийн утгын талаар хоёр хувилбар бичлэгтэй байж болох «торлон» (тор нэхэх мэт эргэж буцан) гэсэн утгатай үг болов уу гэсэн таамаглал хэлж болох байна. Учир нь нэгд, хуучин (сонгодог) монгол бичигт ганц үет зарим үгийн эхний о эгшгийг у авианаас ялгахын тулд о үсгийг нь хоёрлон «го[о]л» (нурууны гол, гол мөрөн) «хо[о]р» (амь хөнөөх хор) «до[о]р» (нам «дор» газар) гэх мэтээр бичдэг тул энэ тор нэхэх мэт эргэн буцан давхих гэсэн үгийг худам монгол бичигт «то[о]р» гэж бичдэг байсан бололтой. Гэтэл бичлэгийн энэ ялгааг XIV зууны үеийн монгол хүний аман аялгууны дуудлагаар сийрүүлсэн Монголын нууц товчооны хятад галиг үсэгт тусгаж чаддаггүйн баримт §24-д «го[о]л дагари ту» гэж бичвэл зохихыг «гол «да'ариту» гэж, §67-д хо[о]р холижу» гэж бичвэл зохихыг «хоро холижу» гэж бичсэн явдал юм. Хэрэв «то[о]р» гэсэн нэр үгэнд үйл үг үүсгэх «-ла» дагавар залгасан гэж үзвэл энэ үгийг «то[о]рлан» гэж сийрүүлж бичих ёстой тул «торолун» гэдэг нь алдаатай галиглал болно.

Эсвэл монгол хэлэнд о, у хоёр эгшиг ялгарч хоёр авиа болж чадаагүй байсан үед авсан худам монгол бичигт тор (юманд тулах торох) гэсэн үйл үгэнд уул үйлийг олон дахин хийхийн байдлыг заах л дагавар залгаад дараа нь нөхцөл үйл үгийн хам хэлбэрийн «н» нөхцөл нэмж «торулун» гэж бичсэн байж болно. Гэвч энэ тохиолдолд «то[о]рлан» гүйх гэсэн утгаа хадгалж байж болно. Учир нь энэ тор гэдэг үг эрт цагийн худам монгол бичигт мөнхүү «торох гэсэн үйл үгтэй нэг язгууртай, ижил бичлэгтэй байсан байж болно гэж бодож байна. Учир нь «торху-тулгарчу торху жэргэ-йин» (12, 607а) «торгахуйалалан йагум-а абху» (12, 607б), «торгуху-торхуй-дур күрүгүлкү» (12, 607б) «то[о]р-элдэб нидү сэгэ гарган сүлжиксэн эд» (12, 611а) гэх мэт олон үг цом «торох торгох» «то[о]р» (загас тороход хүргэх хэрэгсэл) гэх мэтээр цом ойролцоо утгатай үгс байна. Иймд нууц товчооны үг эхэд бүр о, у ялгараагүй эрт цагийн бичлэгээрээ «торулун» гэж, эсвэл «ө, у» хоёр эгшгийг ялгаж бичих болсон «МНТ»-г зохиогдох үеийн худам монгол бичгээр «то[о]рлан» бичсэнийг «торулун» гэж ташаа галигласан байж болох юм.

573. чисуту тонуг тонугчин... үб тонуг абугчин (Цуст тоног тоногчин, үв тоног авагчин) — гэсэн эдгээр үгсийг хятад үсгийн галиглалаас нь «чисуту тоног тоногчин», «үб тоног абугчин» (36, 151) гэж Хэниш сэргээн хадмал хятад орчуулгын нь утгыг «дайсны цустай хувцасыг тоног дээрэмдэгч» гэж тайлжээ.

Эдгээр үгийг судлагчид Хэнишийн сэргээсэн ба орчуулгын дагуу ойлгож орчуулж ирсэн боловч бид энэ үгийг «цустыг хуулах» гэсэн үгийг цуст хувцасыг нь биш харин ялсан баатар ялагдсан дайсны толгойн «баатар» хуйхыг хуулан авч ялсны тэмдэг дурсгал болгодог «тоног авах» ёсны тухай өгүүлсэн үг өгүүлбэр болохыг бид урьд нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ (10, 78—93) нэгэнт дэлгэрэнгүй тайлбарласан тул энд үг үг хэллэгийн тайлбарыг үүгээр товчилъё.

574. өкйүгэсүксэн [сибагун] (өеөссөн [шувуу]) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 129), Пеллио (9, 70), Лигети (33, 132), Рахевильз (25, 104), Баяр (11, II, 838), Дашцэдэн (26, 134), Элдэндэй Ардажав (8, 603), Иринчин (28, 177) тэргүүтэн судлагчид

цөм «өйэсэксэн» гэж сэргээн сийрүүлсэн юм. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг «ховдог» (цадашгүй) «өлөн ховдог» (36, 129) гэсэн үгээр Хэниш тайлжээ.

Энэ үгийг утгыг Дамдинсүрэн (7, 173), Дугаржав (24, 151) нар «өлссөн шувуу» гэж, Поуха (17, 130), Калужинский (61, 120), Кливз (42, 126) нар «өлөн ховдог шонхор» гэж, Баяр (11, II, 838), Мансан (27, 216) нар «өйүгэсүксүн» (өлссөн) шувуу гэж тус тус ойлгож сэргээсэн буюу орчуулж тайлбарласнаас хамгийн зөв үгийг олж бичсэн нь бидний бодлоор Баяр Мансан нар болно.

Бид тэдний саналыг зөв гэж баримтлахын хамт энэ үгийг хуучин монгол бичгээр бичдэг «өгйүгэ-шибагун-у тэжигэл» (12, 159а) хэлбэр нь язгуур эртний худам монгол бичгийн бичлэгээс уламжлалтай болов уу гэж төсөөлж таамаглаж энэ үгийг «өгйүгэсүксэн» гэж сэргээсэн болно. Хэрэв Баяр Мансан нарын сэргээсэн шиг «өйүгэсүксэн» гэж сэргээвэл «ейүгэ буюу өйүкэй эбчигүн-у доорахи гажар» (12, 159б) гэсэн үгтэй адил болж өйүгэссүгсэн (өехийгөрөө өөдөө харж ойчсон) гэсэн өөр утгатай үг болоход хүрэхээс гадна бас «өйүк» (ховдогүй) (12, 159) гэдэг үгтэй ч ойртож өлссөн биш, харин «өегдсөн» буюу өег учраас хоолонд дургүй хүрэх» гэсэн эсрэг утга ч гаргаж болох учир бидниы ингэж «өгйүгэсүксэн» гэж сэргээх нь илүү зөв гэж бодож байна.

575. жагужан-а (зуузайнд) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 94), Пеллио (9, 71), Лигети (33, 133), Рахевильз (25, 105) Баяр (11, II, 839), Дашцэдэн (26, 135), Элдэндэй Ардажав (8, 603), Иринчин (28, 177) нар цөм «жужа'ан-а» гэж сэргээсэн байна. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «бүдүүн зузаан» гэж тайлаад хойд үгийн хам утгыг «нэн зузаан (ойрхон дараацаж) ирж яваа» (36, 94) гэж орчуулжээ.

Энэ үгийг Хэниш (15, 82), Поуха (17,130), Калужинский (61, 120), Кливз (42, 127) нар цөм «түүний араас нягт дагалдан бөөгнөрөн айсуй» гэж орчуулсан бололтой санагдана. Үүнийг Дамдинсүрэн «хойноос нь ирж яваа нүсэр амьтан» (7, 174) гэж, Дугаржав «тэдний хойноос зузааран ирж явагч хэн бэ?» (24, 152), Элдэндэй Ардажав, Иринчин нар «зузаан-а» гэж тайлбарлалгүй бичсэн хийгээд Мансан «бас тэр хойноос нь олноор ирэх хэн бэ?» (27, 217) гэж орчуулаад уул үгийн утгыг» «олноор ирэх» гэх утгатай үг болой. Хасар голыг захирч олон цэрэгтэй явж байх тул ингэж хэлжээ» (27, 230, тайлбар № 25) гэж тайлбарлажээ.

Бидний бодлоор энэ үг «зузаан» гэсэн утгатай «жужаган-а» гэсэн үг биш харин «жагужа[й]-н-а» буюу «зуузайнаа» гэсэн үг шиг санагдана. Учир нь уралдаанд түрүүлсэн морийг яг дагаж бараг зэрэгцэн ирсэн морийг «зуузай холбож ирлээ» гэж монголчууд хэлэлцдэг юм. Энэ «зуузай» гэдэг үгийг толь бичигт «зуузай 1. хуучин, амгай төмрийн нэр байснаа эдүгээ хазаарын амгайвч холбох цагариг төмөрлөг» (53, 287 а) гэж тайлбарлаад хуучин монгол бичгээр «жуужай» гэж бичдэг гэжээ. Гэвч энэ бичлэг бол монгол хэлэнд үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс болон урт эгшиг үүссэнээс хойших үед тогтсон бичлэг мөн бөгөөд харин энэ хоёр ёс гарахаас урьд үед хэрэглэж байсан худам монгол бичигт «жагужай» гэж бичиж байсан нь лавтай. Учир нь морины аманд зуулгадаг төмөрийг нэрлэж байсан тул «жагуху» (амандаа зуух) гэдэг үгнээс энэ үг үүссэн юм.

Гэтэл «гутлын зуузай» гэдэг үгийг хуучин монгол бичгээр «жаужай» (53, 287а) гэдэг үг нь энэ үг худам монгол бичигт «забжай» буюу юмын завсар хавчуулж оёсон хатуу шир (хатуулга) гэсэн утгаар «жаб» гэдэг өөр язгуураас гарсныг харуулж байна. Энэ талаараа энэ «жаужай» гэдэг үг «жабсиху», «жабсар», «жабхай» зэрэг үгтэй язгуур нэгтэй төрөл үг мөн бололтой.

Иймд «жагужа[й]-н-а» гэсэн энэ үгийн дуудлага Нууц товчооны»-г галиглах үед аман аялгуунд «ж[а]ужа[й]н-а» гэсэн өөр дуудлагатай болж хувирсан байсан учраас галигч нар ийнхүү «жужа'ан-а» гэж ташаа тэмдэглэж хожим хадмал хятад орчуулга хийгчид «жужаган» (зузаан) гэсэн үгтэй хутгаж буруу орчуулсан бололтой байна. Иймээс энэ нь «олнооров зузааран бөөгнөрөн» гэсэн утгатай үг биш, харин зуузай холбож зэрэгцэн ирэгч гэсэн үг мөнөөс зайлахгүй.

576. үлгэтэлэ (унатал) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 162) Пеллио (9, 71), Лигети (33, 133), Рахевильз (25, 105), Баяр (11, II, 844), Дашцэдэн (26, 135), Элдэндэй Ардажав (8, 604), Иринчин (28, 177) нар булт «үлкэтэлэ» буюу «үлгэтэлэ» гэж сэргээн босгож сийрүүлж байжээ.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нэвт өрөмдөх, арав хорин хүнийг шувт харвах» гэж тайлсан байв.

Энэ үгийг Дамдинсүрэн «ундуй сундуй үхцгээнэ» (7, 175) гэж, Хэниш

(15, 83), Поуха (17, 131), Калужинский (61, 120) нар «арав хорин хүнийг нэвт ононо, харвана» гэж, Дугаржав «алтал харвадаг» (24, 153), Мансан «уулын цаадах хүнийг арав хориор шувтална (ө. х. шувт нэвт харвана) (27, 218) гэж тус тус орчуулсан байдаг. «Үлгэтэл» гэдэг үгийг Элдэндэй Ардажав нар «утас» холбоо авалцаа, оосор, сэжим, ...хэлхин холбох гэсэн утгатай «үлхөө» гэсэн буриад үг, хорчны аман ярианд хуучин цагийн дөрвөлжин нүхтэй гуулин зоосыг утсаар хэлхэн холбосныг «өлгэ» гэнэ» (8, 614, тайлбар № 48) гэжээ. Гэвч энэ «эд өлэг» (53, 435б) гэдэг утгаа өлгэ буюу «элгүү» (өлгөх юм) гэсэн үгнээс гарсан байж болох тул «эд, мөнгө зоос» гэсэн утгатай байсан байж болох юм. Гэхдээ энэ «өлгэ» гэдэг үгээр сумаар нэвт харвахыг хэлдэг байсан гэх баримтгүй юм.

Бид энэ үгийг «үлгэтэл» гэж арай өөрөөр сэргээж «шархтуулан үхлүүт эрэмдэг зэрэмдэг болгодог» гэсэн утгатай болов уу гэсэн таамаг гаргаж байна. Учир нь монгол хэлэнд «үлгэн-үлгэн салган, ухаан мэдрэл, тамир тэнхээ нь муудсан байдалтай» (53, 619б) гэсэн үг байдаг нь энэ үйл үгийн язгуураас үүссэн үг мөн шиг санагдана. Иймээс Дамдинсүрэнгийн «ундуй сундуй үхцгээнэ» гэсэн нь илүү оновчтой зөв орчуулга гэж болмоор. Учир нь энэ «ундуй сундуй гэдэг үг уттаа унаж, сунаж (гулдайн) ойчих гэсэн утгатай бөгөөд эмх замбараагүй ийш тийш гулдайн ойчихыг хэлдэг үг юм.

577. **кэйи[-с]бүри** (хийсэн хол явах сум) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглаас нь Хэниш (36, 100), Пеллио (9, 71), Лигети (33, 133), Рахевильз (25, 105), Баяр (11, II, 845), Дугаржав (24, 153). Мансан (27, 218), Дашцэдэн (26, 135), Элдэндэй Ардажав (8, 604), Иринчин (28, 177) тэргүүтэн цөм «хэйибүр» гэж ижлээр сэргээн сийрүүлсэн юм. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нэг зүйл сум» гэж тайлжээ. Чухам ямар сум байсныг судлагч Хэниш (15, 83) Поуха (17, 131), Калужинский (61, 120), Кливз (42, 127) нар үгийг орчуулалгүй хэрэглээд гагц Кливз хадмал хятад орчуулгад [нэг зүйл] сум гэснийг заажээ. Үүнийг Дамдинсүрэн «хийсвэр сум» (7, 175), Мансан чухам ямар маягийн сум болох нь тод үгүйг заахын хамт Элдэндэй «ханууp жад шидэх, жад» гэж Жигачид сэчэн «хийсвэр «нисэх» буюу «хийсэх» сум гэж тайлбарласныг заав (27, 230, тайлбар № 27), Элдэндэй Ардажав «жэбэ»,-ханагур жад гэж Мухаддимат толь бичиг заан дурдахын хамт Төвд тангадын хүмүүсийн чулуу шидэх зэвсэг (өртүү)-г «хүйибүр» гэж тайлбарлав (Нима) (8, 614, тайлбар № 50) гэжээ.

Бидний санавал «хэйибүр суму» гэж бичсэнээс үзвэл ямар ч гэсэн жад буюу дүүгүүрийн нэр биш нь илэрхий бөгөөд харин дүүгүүрийг «хүйибүр» гэснээс үзвэл хий салхины хүчээр чулууг алс шидэх дүүгүүрийн адил хий салхиар хүч эрч авдаг нэг зүйл сум байсан байж болох тул Дамдинсүрэн, Жигачид-сэчэн нарын ойлгосон нь илүү үнэмшилтэй санагдана. Харин энэ үг «хэйи+бүр» гэж бичигдэг үг байсан гэвэл «талабур-сургагули болба-сурагулху агудам газар» (12, 574б) гэдэг үгтэй төстэй нэг загвараар бүтсэн үг шиг харагдавч тал+бар нь талабай гэдэг өөр дагаврын авианы хувилбар тул ондоо юм. Нөгөө талаар утгын үүднээс үзвэл «хэйисхү» гэсэн үйл үгнээс гарсан гэдэг нь илүү үнэмшилтэй тул бид энэ үгийг «хэйи[с]бүри» гэж сэргээсэн Дамдинсүрэнгийн саналыг илүү зөв гэж таамаглаж байна. Иймд бид энэ үгийг «тайилбури» гэх мэт үйл үгийн үндэс дээр «-бури» дагавар залгаж бүтээсэн үг гэж үзэж ийнхүү галиглав. Галигч нарын үеийн ярианы аялгуунд эцсийн и эгшиг авиа нь балархайшиж орхигдсон болоолтой. Бас ийнхүү залгаврын аргаар үг бүтээхэд амур-аму(-р) гуланг гэх мэтээр эцсийн гийгүүлэгч нь орхигдох ёс монгол хэлэнд байдаг тул хийсхийл-гэх мэт үйл үгийн үндэсний с буюу л гийгүүлэгч нь орхигдон «хэйибүри» болсон байж ч болох мэт санагдана.

578. **Гүрүлгү манггус** (гүрвэл мангас) — гэдэг энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 53), Пеллио (9, 71), Дугаржав (24, 153), Дашцэдэн (26, 135) нар «Гүрэлгү» гэж, нөгөө Лигети (33, 133), Рахевильз (25, 105), Баяр (11, II, 847) нар «гүрөлгү» гэж, Элдэндэй Ардажав (8, 604), Иринчин (28, 178) нар «гөрүлгү буюу гүрөлгү» хоёрын аль нэгээр ойлгогдохоор сэргээсэн байна.

Бидний бодлоор бол энэ үгийг «гүрүлгү» гэж сэргээх нь зөв болов уу гэхийн дээр энэ нь хадмал хятад орчуулгад дурдсаны адил аварга могой гэсэн үг биш, харин аварга гүрвэл гэсэн үг болов уу гэсэн саналаа урьд нийтлүүлсэн өгүүлэлдээ (103, 96—100) нэгэнт дэлгэрэнгүй тайлбарласан учир энд тайлбараа үүгээр товчилъё.

579. **үкүд кижү** (үхэдхийж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 162), Пеллио (9, 71), Лигети (33, 134), Рахевильз (25, 106), Баяр (11, II, 855), Дашцэдэн (26, 136), Элдэндэй Ардажав (8, 816), Иринчин (28, 178) нар цөм «үкүткүжү» гэж сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «(айснаас) ухаан ал-

дах» гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 83), Дамдинсүрэн (7, 176), Поуха (17, 132), Кливз (42, 129) Калужинский (61, 121) нар ухаан алдтал, толгой (ухаан) алдтал айж гэх мэтээр орчуулсан мэт байх бөгөөд Дугаржав «үкүткижү» (24, 154) гэж, Элдэндэй Ардажав «үкүтгэжү-муужиран унаху, үкүтгэн унаху» шилжсэн утга нь өнггэ чирай багуражу бүдэгирэкү йи үкүткикү кэмэмүй» гэж Б. Цэвэлийн толь бичиг заан тайлбарласан юм.

Бид энэ үгийг «үкүдкижү-магужираху мэту йин» (12, 174а) гэсэн үгийн нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрт байгаа үг гэж Дугаржавын адилаар ойлгож байгаа боловч энэ «үкүткикү» гэсэн үг «үкүд кикү» гэсэн хоёр үг нийлж бүтсэн үг мөн гэж санах учир худам монгол бичгээр «үкүд кижү» гэж хоёр үгээр бичигдсэн байсан гэж төсөөлөн ингэж сэргээсэн болно. «Үкүдүжү» гэсэн нь энэ үгийг XIV зууны үеийн монгол хүний ярианы хэл аялгууны дуудлагаар ташаа галигласан гэж бодож байна.

580. **бүсэлэгүн** (бүслүү) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «бүсэлгүгү» (36, 23) гэж, Пеллио (9, 71), Лигети (33, 134), Рахевильз (25, 106), Баяр (11, II, 857), Дашцэдэн (26, 136), Элдэндэй Ардажав (8, 616), Иринчин (28, 179) нар цөм «бүсэлгүн ~ бүсэлкүн» гэж сэргээн сийрүүлжээ.

Эл үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «орчин тойронд бүсэлж» (15, 23) гэж тайлаад судлагчид энэ үгийг цөм бүсэлж тойрч хүрээлэн гэсэн үйл үгээр орчуулсан юм.

Гэтэл бид «бүсэлкүн» буюу «бүсэлгүн» гэсэн үйл үг биш харин бүсэлэгүн буюу «бүслүү» гэсэн тэмдэг нэр үг гэж үзэж ийнхүү сийрүүлэв. Учир нь нэгд, энэ үг бүсэ+лэ+гүн гэсэн бутэцтэй тул дори+гун, хала+гун гэм мэт үйл үгийн үндсэнд «гу- гү» дагавар залгаж «доригун», «халагун» гэх мэт үгтэй ижлээр үүссэн нэр гэдэг нь илэрхий байна. Хоёрт, хэрэв энэ үгийг -гун дагаврыг үйлт нэрийн ирээдүй цагийн үндэс үүсгэх «-ху -хун» нөхцөл гэж үзвэл энэ «бүсэлкү» гэдэг үг «байжу» гэсэн үйл үгтэй найруулга ба хэл зүйн үүднээс нийцэхгүй. Учир нь бүслэх (ирээдүй цаг) байж хонов. (өнгөрсөн цаг) тул утга ба хэл зүйн үүднээс авцалдаагүй болно.

Харин «бүсэлэгү(н)» гэсэн тэмдэг үгтэй энэ «байж» гэдэг үйл үг нийлэмжтэй юм. Мал **тарагу бэлчижу** байв. Тэд **буругу** ярьж байв гэдэгтэй адил «бүсэлэгү байжу хонуба» гэж хэлж болох юм. Жич бүсэ (үгийн нэр үндэс) +лэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +гу[н] (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг тул бүсэлкүн буюу «бүсэлгүн» гэдэг нь ташаа бичлэг мөн.

581. **жэтгэкдэжү** (тотгорлох) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Элдэндэй Ардажав, Дашцэдэн, Иринчин тэргүүтэн цөм «жэтгүкдэжү» гэж сэргээн босгож, үүний утгыг хадмал хятад орчуулгаар нь Хэниш «хаагдаж, зам саатагдаж» (36, 89) гэж тайлжээ. Хэниш (15, 84), Поуха (17, 133), Дамдинсүрэн (7, 178), Калужинский (61, 122), Дугаржав (24, 156), Мансан (27, 220), Элдэндэй Ардажав (8, 619) цөм «сатуулагдах» гэсэн утгаар зөв орчуулсан юм. Ялангуяа Элдэндэй Ардажав «бичгийн хэлэнд жэтгэр» (8, 622) гэдгийг зааж хэлсэн нь хамгийн оновчтой болсон тул түүнийг зөвшөөрөн дэмжиж энэ үгийг жэтгүкдэжү бус, харин «жэтгэкдэжү» гэж сэргээсэн болно. Учир нь жэт-(саат гэсэн эс тусах үйл үгийн үндэс) +гэ (бүсдаар үйлдүүлэх хэвийн үйлдэгдэх эс тусах үйл үгийн үндэс бүтээх нөхцөл (+гдэ (бусдын эрхэнд үйлдэгдэх эс тусах үйл үгийн үндэс бүтээх нөхцөл (+жү) нөхцөл үйл үгийн зэрэгцэн болох хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг мөн тул жэтгэкдэжү» гэж сэргээх нь зөв гэж бодож байна.

582. **агулху** (байлгах) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс нь Хэниш (36, 4), Пеллио (9, 72), Лигети (33, 135), Рахевильз (25, 107) нар «ahулху ~ a'улху» гэхчлэн, Дашцэдэн «аулху» (26, 138), нөгөө Баяр (11, II, 864), Элдэндэй Ардажав (8, 620), Иринчин (28, 180) цөм «ахулху» буюу «агулху» гэж сэргээн, үүний хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «байх, суух, аж төрөх, хадгалагдах» (36, 4) гэж тайлсан бөгөөд олонхи судлагчид иймэрхүү утгаар орчуулсан байна. Харин Дамдинсүрэн «үл агулху» гэснийг «хо[о]рлаху» (7, 178) гэж, Мансан (27, 220) «амийг чину хо[о]рлажу» (27, 221) гэж, Дугаржав «чама-йи жүгэр байилгаху үгэй мөртэгэн» (24, 156) гэх зэргээр өөр өөрөөр орчуулжээ. Агулху гэсэн энэ үг жирийн «байлгах, байгуулах, агуулах» гэсэн утгатай байсангүй. Харин «амьд байлгах, амьдруулах, аж төрүүлэх» гэсэн өөр утгатай бүрэн хувиллаар хувилдаг биеэ даасан утгатай байжээ гэдгийг эл үгийг энд хэрэглэсэн жишээ харуулжээ. Иймд энэ «чамай-йи улү агулху» «чамайг ална» гэсэн утгатай тул Дамдинсүрэн Мансан нарын орчуулга утгадаа илүү оновчтой болсон шиг санагдана.

583. **түйиткүй-дүр** (саатах ~ сүйдэхэд?) гэсэн энэ үгийг Хэниш (36,

153), Баяр (11, II, 866), Элдэндэй Ардажав (8, 620), Иринчин (28, 180) тэргүүтэн зарим нь «түйихүй» гэж, Пеллио (9, 72) Лигети (33, 136), Рахевильз (25, 107), Дашцэдэн (26, 138) нарын зарим нь «сүй(т) күй, сүй(д)күй» гэж хоёр өөрөөр сэргээдэг байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг «үүсэх» гэсэн үгээр оноосон боловч энэ зүйлийн хувьд «самууны үүсгэлд хүнд байдалд орох» (36, 153) гэж тайлсан байв.

Энэ үгийг Хэниш «эвгүй байдалд хүрэх байлаа» (15, 84), Поуха (17, 133), Калужинский (61, 122), Клывз (42, 130) нар Хэнишийн орчуулсантай адил төстэйгээр ойлгож орчуулсан бололтой санагдана. Дамдинсүрэн «завсрын цэрэгт баригдаж тэдний завшаан болох биш үү?» (7, 179) гэж, Дугаржав «түвэгтэй байдалд учрах ч магадгүй» (24, 157) гэж, Мансан «садур самагун түүгкэй болчинг йагу магад» (27, 121) гэж тус тус орчуулжээ. Элдэндэй Ардажав нар энэ үгийг түкүй-түкэй-түүгкэй гэх нь «татар» идэж уух зүйл» «түүхий болсон гэдэг үгтэй холбож тайлбарласан (8, 623, тайлбар № 13) боловч төдий л оновчтой үнэмшилтэй санагдахаар үгүй болжээ. Иринчин түйикүй-түүгкэй-энд зэрлэг самуун гэсэн утгатай гэжээ.

Бидний санавал энэ үгийг Пеллио нарын сийрүүлснээр «түйиткүй» гэж сийрүүлэх нь илүү зөв бөгөөд утгыг зөв илэрхийлмээр санагдана. Учир нь нэгд «түйиткү-түйитгэрлэкү, сагатагулху, зэргийн» (12, 630а) гэсэн үг монгол хэлний үгсийн санд бүртгэгдсэн байгаа нь энэ үг мөн болохоос зайлахгүйн дээр утга нь Чингис хаанд Хулан охиныг авааччиж өгөхөөр замд тохиолдсон саат түйтгэрийн тухай өгүүлэгдэж буйтай яв цав нийцэж байна. Нөгөө талаар энэ үг хэрэв «түйдкүй» (сагтах) гэсэн утгатай үг биш гэж эргэлзэхэд хүрвэл бас «сүйидкүй» гэсэн монгол үгний дуудлагын хэлбэр байж магадгүй гэж бас төсөөлөн бодох үндэстэй юм. Учир нь худам монгол бичигт «т»-гээр бичигдсэн олон үг хуучин (сонгодог) монгол бичгийн хэл, орчин цагийн монгол хэлэнд с үсгээр бичигдэх ба «с» авиагаар хэлэгдэх болсны жишээ олон юм. (Үүнд тагуба-сагуба, туури-суури, ноход-нохас, эбүгэд эбүгэс г.м) Ингэж үзвэл замдаа Наяа ноёноос өөр цэрэгт учирсан бол бид сүйдэж амь үрэгдэх, бусдын олз болж сүйдэх байсан гэж хэлсэн байхад утгын хувьд бас л нийлэлцмээр санагдана. Гэтэл түйнхүй-гэдэг нь түүгкэй гэдэг үгийн хувилбар гэж үзвэл түүхий мах, түүхий эд, түргэн түүхий зэрэг энэ үгийг хэрэглэх аль ч тохиолдлын утга энд яригдаж буй зүйлийн утга ба учир зүйд нийцмээргүй бодогдоно.

584. болган (болгон) — гэсэн энэ үгийг бүх судлагч «болган» гэж сэргээдэг бөгөөд энэ талаар болох гэсэн эс тусах үйл үгэнд үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх «га» дагавар залгаж тусах үйл үг бүтээсэн нь илэрхий. Харин энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «нарийн (яг) туршин шалгавал» (36, 18) гэж тайлаад тэр ёсоороо орчуулав (15, 85). Дамдинсүрэн (7, 180), Мансан (27, 222) «мөн өдөр тэр даруй» гэж, Поуха (17, 134), Калужинский (61, 122) Клывз (42, 131) нар ерөнхийдөө Хэниш, Дамдинсүрэн нарынхтай ойролцоо утгаар тэр өдөртөө, даруй, нарийн шалгасан» гэж орчуулсан мэт санагдана. Харин Дугаржав «болгуган сорьж үзсэнд» (24, 157), гэж, Элдэндэй Ардажав нар «бөгөөд болгон сорибаас»-даруй үнэнчилэн (үнэн болгон) туршин үзвээс» гэсэн үг гэж тайлбарлажээ.

Энэ «болган» гэсэн үгийн бичлэг нь зөв бол үнэхээр «өдрөөр (болдоггүй юмыг) болгож биеэр шалгасан» гэсэн утгатай байж болно гэж бодохын хамт нөгөө талаар энэ үг нь гүйцэд бодож боловсруулах гэсэн утгатай «болгун» буюу эсвэл «болгуган» гэсэн үг худам монгол бичгийн эхэд байсныг хожим уг эхийг дуудан уншиж өгсөн хүний тэр (XIV з.) үеийн ярианы хэлнийхээ дуудлагаар «болгуан» гэж хэлж өгсөнийг галигч нар «болган» гэж ташаа тэмдэглэсэн байж болох талтай санагдана. Учир нь бол+га гэвэл болох гэдэг үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн нөхцөлтэй нэг үндэс болно. Харин болгу-юмыг гүйцэд бодох гэсэн утгатай өөр үйл үгийн эс тусах үндэс байсан бололтой юм. Учир нь энэ болгу гэсэн үндэснээс «болгумжи (юмыг урьдаас бодож хандах), болгу-үндсэнд үйлдүүлэх хэвийн «-га» дагавар залгаж тусах үйл үгийн үндэс үүсгээд бодуулахын хүндэтгэл үгийн ёсоор хэрэглэхдээ «болгугаху» гэж хэлдэг байсан бололтой тул энэ үнэхээр Дугаржавын орчуулсан шиг «болгуган» гэсэн үг буруу галиглагдсан байж ч болмоор санагдана.

585. сиба-йин сумун-а (шавын суманд) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалын тэмдэгээс нь «Шиба йин сумун-а» гэж сэргээжээ. Энэ үгийг Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр (11, II, 876), Дашцэдэн (26, 140), Иринчин (28, 184) цөм «шиба-йин сумун-а» ～ «Сиба-йин сумун-а» гэж тус тус ойролцоогоор сэргээсэн юм. Энэ үгэнд хийсэн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «тэнэсэн сум» (36, 139) гэж тайлсан тул Хэниш өөрөө «хуурамч суманд» (15, 86) гэж, Поуха (17, 137), Калужинский (61, 125), Клывз (42, 132), Рахевильз (49, № 21, 1990) нар «тэнэсэн суманд» гэж, Мансан (27, 235), Элдэндэй

Ардажав нар (8, 629—630, тайлбар № 10) нар «самуун сум» гэж бүгд хадмал хятад орчуулгыг дагаж орчуулсан нь ил байна. Эдгээр орчуулгаас бидний бодоход «тэнэсэн суманд» гэдэг нь илүү тэр цагийн найруулгад ойртсон мэт санагдана. Учир нь монголчуудад «тэнэсэн сум тархинд» (98, 82б) гэсэн зүйр үг байдаг.

Тэгэвч бид энэ «сиба (шавын)-йин сумун дур» гэсэн үгийг бид дан ганц «сибани жэбэ (жаба уу?)-сиба ни жэбэ (жаба?)-дайисун-у жүк хөндэлэн гулду харбугсан жэбэ» (12, 831б) гэсэн энэ утгаар зөвхөн ухаарвал арай дутуу дулимаг болно. Учир нь мөн толь бичигт «Сиба-харбулга-йин» (12, 831б) гэсэн тайлбартай өмнөх үгийн нь үүднээс бодож үзвэл «Сиба-йин сумун» гэдэг үг тэнэсэн зэрлэг сум биш шав мөрийцэн харвагчийн харин хавт мэргэн сум цэцэн сум гэсэн утгатай байж болох юм гэж бодно. Учир нь «шиба» гэдэг бол харвах «бай» мөн тул мэргэн харвахын сургуулийн сум гэсэн утга байж болно. Иймэ тохиолдолд шиба-йин суму гэдэгт хожим хадмал орчуулга хийгчид утгыг андууран өөрөөр ташаа буулгасан байж болох юм.

586. **чиббу тусчу** (жив тусч) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллиө, Лигети, Рахевильз, Дашцэдэн, Элдэндэй Ардажав (8, 626) нар «чубтусчу ~ чүбтүсчү» гэх зэргээр сэргээдэг нь галиг үсгийн үүднээс зөв байвч худам монгол бичгийн үүднээс үзвэл уул үгийн утгыг ойлгоход хэцүү болгосон талтай.

Энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш (36, 29) «усанд унах» гэж бүдүүн тоймоор тайлсан юм. Энэ үгийг Хэниш (15, 86), Дамдинсүрэн (7, 183), Поуха (17, 138), Калужинский (61, 125), Кливз (42, 133), Рахевильз (49, № 21, 1980, 18) Дугаржав (24, 159), Мансан (27, 295) нар «усанд живэж цацаж үхсэн» гэсэн утгатайг мэдэж зөв орчуулсан боловч гагцхүү Баяр(11, II, 877) «чөв тусчу» гэж сийрүүлснээрээ энэ үг хоёр үгнээс нийлж бүтсэнийг илэрхийлсэн бол Элдэндэй Ардажав «чүбтусчу» гэж (бодвол эртний бичлэг дуудлага нь мөн гэж бодоод ташаа чигээр нь сийрүүлсэн болов уу) бууруу галиглаад харин энэ нь «чиб-чибкү» «жиб жибкү» гэсэн үндэснээс үүсгэн зөв тайлбарласан (8, 630—631, тайлбар № 13) боловч уг үгийг нэг бүрэлдэхүүнт үг гэж үзсэн учир II үгийн утгыг дурдсангүй.

Бид энэ үгийг «жиб+тусчу» гэсэн хоёр бүрэлдэхүүнт нийлмэл үг гэж Баяр авгайн адилаар үзсэнээс гадна чуб гэдэг нь эртний дуудлага нь бөгөөд харин худам монгол бичгийн үед анх бичигдэж байсан хэлбэр нь «чиббү тусчу» гэдэг нь хожим «жиббү тусчу» гэж зарим аялгуунд хэлдгээр хуучин монгол бичигт хоёр янзаар бичигдэх болсныг толь бичигт «чибкү-усан-дур далда оруху мэтү-йин» (12, 761а), «жибкү-усандур шуггун оруху мэтү-йин» (12, 505б) гэх мэт баримтаас үзвэл «чиббү тусчу», «жиббү тусчу» гэж бичигдэж байгаад монгол хэлэнд үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс гарснаас хойш XIV зууны үеийн аман аялгуунд «чубтусчу» гэж нийлмэл үг болж тэмдэглэгдсэн гэж бодно. Энэ үгийн эхний ч авианы дараа «у» зэрэг «и»-гээс бусад эгшиг бичигддэг байсан бол «чивэх», «живэх» гэх мэт ч буюу ж авиатай үг бус, харин «зуб» буюу «цув» гэх мэт дуудлагатай үг халхын аялгуунд уламжлан ирсэн баймаар санагдана.

Энэ учраас бид энэ үгийг «чиббү тусчу» гэж сэргээснээ худам бичгийн үүднээс зөв бичлэг гэж бодож байна.

587. **олан-[х]и-ийан** (олонхийгаа) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлаачид цөм санал нэгтэй «олонгки-ийэн» гэж сэргээн буулгаад утгыг нь «олонхи» гэж бичдэг «зонхилох олон» гэсэн утгатай үгтэй адил галиглагдсан тул энэ үг нь утгын тайлбар хийдэггүй байна. Энд бид энэ үгийг «йада+нгги» гэх мэт үйл үгийн үндэснээс үүссэн үгтэй адилгүй бөгөөд олон цөөн гэх мэт тооны шинж тэмдэглэдэг тэмдэг нэр үгийн язгуур үндэснээс өөрөөр үүссэн үг гэж бодож байна. Энэ үгийг «олонгхи-йэн» гэж галигласнаас үзэхэд Монголын нууц товчооны хятад галиг үсэг худам монгол бичигт бичигддэг дүрмий нь бус гагцхүү тэр үед тухайн үгийг яаж хэлж дуудаж байсныг тусгаж галигласан гэж хэлж болохоор байна. Харин тооны олон тоотойн ерөнхий шинжийг тэмдэглэдэг олан, түүний эсрэг нэр цөөн хоёрыг тэмдэг нэрийн нь үүргэсэ гадна тооны шинжээр нэршүүлэн хэрэглэж байсан баримт Монголын нууц товчоонд цөөнгүй байна. Үүнд (§195) «олан-ача олан, чөгэн-эчэ чөгэн хо(о)р болому жэ» (8, 600) гэсний дотор тооны шинж тэмдэглэх эл хоёр тэмдэг нэр нэгэнт нэр үгийн тийн ялгалаар хувиртснаас үзвэл эл хоёр үг нэр үгийн оронд түүнийг орлон (нэршсэн нэр болж) хэрэглэгдсэн нь энд «олон цэргээс олон цэрэг, цөөн цэргээс цөөн цэрэг хохирох биз» гэж хэлсэн утгатай байна. «Олан[а](хи)и-йн» гэдэг ч мөн найман ба мэргэдийн «олон цэргийг» гэсэн утгатай нь ил байна. Иймээс энэ үгийг орчин цагийн монгол хэлэнд «олныхоо-олныгоо-олонхоо-олонхоор нь-олонхтой нь гэх мэт хамаатуулах нөхцөлт тийн ялгалын хэлбэр гэж үзэж бид «олан[х]и-йн»

гэж сэргээх нь зөв бөгөөд энэ нь «ядангги», «урсангги», «нангги (шавар)» гэх мэттэй адил үгийн гаралтай эдгээр үгнээс өөр бүтэцтэй гэдгийг энд тэмдэглэе.

588. **эрүжу** (ухаж) гэсэн утгатай энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлаачид «эрижү» гэж сэргээн босгоод газар ухаж орвол гэсэн үг гэж орчуулдаг буюу эсвэл тайлбарласан байдаг бөгөөд бид энэ үгийг «эрижү» гэж галигласан нь хятад үсгээр галиглагчдын ярианы дуудлагын буюу эсвэл түүнийг сонсч тэмдэглэсэн галигчийн сонсголын алдаат тэмдэглэл гэж үзэж үүнийг «эрүжү» гэж галиглах ёстойн учирлалаа урьд нийтлүүлсэн (10,161—164) тул энэ тайлбараа үүгээр цэглэе.

589. **хучахатхун** (гуцаагтун) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 70), Пеллио (9, 74), Лигети (33, 139), Рахевильз (25, 110), Баяр (11, II, 886), Дашцэдэн (26, 142), Элдэндэй Ардажав (8, 633) нар цөм «хучи'атхун» «хучигатхун» гэж сэргээн босгож байв.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «гамнаж хэмнэх» (36, 70) гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 87), Дамдинсүрэн (7, 185), Поуха (17, 139), Калужинский (61, 126), Кливз (42, 134), Рахевильз (49, № 21, 1980, 19), Дугаржав (24, 161), Мансан (27, 238), Элдэндэй Ардажав (8, 637, тайлбар № 12) нар цөм «арвилан хэмнэгтүн, гамнагтун» гэсэн үг гэж ерөнхийд нь зөв тааж орчуулжээ.
Бидний бодвол «хучийатхун» буюу эсвэл «хучигатхун» гэсэн үг биш харин «хучагатхун» (гучагатхун) гэсэн үг мөн мэт бодогдном. Учир нь монгол хэлний үгсийн санд «гучаху-дутажу гучаху йин», «гучаху-дутагу гучагу йин» (12, 473б) гэсэн үгс хадгалагдан үлдсэний дээр ардын ярианд жишээ нь дээл эсгэхдээ мөчиг тачиг даавуу буюу торгоор хүргэж ядан эсгэж хийхийг «хуруу хуцаж, эрхий эмжиж» арай чамай хүргэж эсгэв гэж ярилцдаг байна. Энэ дээлийг эсгэх торгыг «хуруу гуцааж, харин эмжээрийг эрхий хурууны чинээ хэмжээгээр өргөн хэмжиж хүргэв» гэсэн утгатай үг болов уу.

Хэрэв энэ үгийн «ч» гийгүүлэгчийн дараа худам монгол бичигт «и» авиа байсан бол энэ үг халхын аман аялгуунд «хуцаху» «гуцуу» гэж «ц» авна болж хувирахгүй байсан болов уу гэж санах учир «хучахатхун» гэж сэргээх нь зөв гэж бодож «хучийад» буюу «хучигад» нь XIV зууны аялгуугаар арай ташаа тэмдэглэсний үр дагавар байх гэж бодном.

590. **өнггэгэкү эй-э[-н]** (өнгөргөөх эе) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 124), Лигети (33, 139), Рахевильз (25, 110), Баяр (11, II, 887), Дашцэдэн (26, 142), Элдэндэй Ардажав (8, 633), Иринчин (28, 184) нар цөм «өнггэгү» «өнггэкү» гэж сэргээдэг, гагцхүү Пеллио «өнггэг-ийэн» [«өнггэг-ү-йэн?»] (9, 74) гэж сэргээв. Баяр, Иринчин нар «өнггэкү-бэн» гэж хуучин монгол бичгийн дүрмийн дагуу засварлан буулгажээ.
Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг «ихэсгэж», «нэмэ'э-сүн өнггэгү» гэснийг «нэмэр ба нөхөөс» гэж тайлаад энэ үгийг Хэниш (15, 88), Поуха (17, 139), Калужинский (61, 126), Кливз (42, 134), Рахевильз (49, № 21, 1980, 19), «хангахад нэмэр болгож» гэж, Дамдинсүрэн (7, 186), Дугаржав (24, 162), Мансан (27, 238) нар цөм «хүнсний нэмэр болгож хэмжээтэй авла» гэсэн утгаар орчуулснаас гадна Элдэндэй Ардажав хоёр энэ «өнггэхү»-түрэг хэлний «өнг өн-нэмэх» гэсэн үг гэснээс гадна өнг (сайхан цаг улирал) зэрэгтэй холбож тайлбарласан боловч утга нь сайн авцалдахгүй, үнэмшилгүй тайлбар болсон шиг санагдана.

Бид энэ үгийг «өнггэгэкү (өнгөрөөх)-[э]йэн (эе)» гэсэн үгийг хамаатуулах нөхцөлтэй үг болгон ташаа галигласан байх гэж бодно. Учир нь энд «өнггэкү-ийэн» гэсэн ерөнхийд нь хамаатуулах нөхцөлтэй үг гэж үзвэл «болтугай» гэсэн үйл үгтэйгээ огт утга авцалдахгүй байна. Хоёрт, хэрэв «өнггэкү» гэсэн үг «нэмэх» гэсэн утгатай гэвэл «нэмэгсүн» гэсэн үгтэйгээ утга давхардах тул тэгж нэг утгатай хоёр үгийг дараалан бичмээргүй санагдах юм.

XIII, XIV зууны бичгийн хэлэнд бас энэ үгийг «көнггэгүлжү» «көнггэжү» гэх мэтээр үгийн эхэнд (к→х→п→О) алга болсон «к» авнатай бичигдэж байсан болов уу гэж энэ тайлбарын 348 дугаарт бичсэн юм. «Бодичаръя Авидара» номын XIV зууны эхний орчуулгад: «Маси догсин нигүл ту үйилэс-и үйилэдбэсү-бэр Багатуд-да ситүжү йэкэ айулача көнггэкүй-дур адил» (40, 5) гэсний дотор байгаа энэ «көнггэкүн»-дур гэсэн үгийг аюулаас нэмэх буюу эсвэл «көнггэрэкү» гэсэн үг байж таарамгүй харин «аюулаас өнгэрэкү» (өнгөрөх) гэсэн үг байж таармаар.

Жич хуучин монгол бичгийн бичлэгийн ёсоор бол «өнггэкү» гэсэн эгшгээр төгссөн үгэнд ерөнхийлэн хамаатуулахын «-йэн» нөхцөл дагахгүй тул Баяр (11, II, 887), Иринчин (28, 184) нар «-бэн» нөхцөл дагуулсан байна. Иймд бид «өнггэкү-бэн болтугай» гэсэн холбоо үг утгын үүдээс зохилдохгүй тул бид энэ үгийг «-йэн, -бэн» нөхцөл биш харин

эйэн (эе)-(арга эв) гэсэн биеэ даасан үг байжээ гэж ийнхүү сэргээв. **Иймд бидний бодлоор бол «хүнсний нэмээс өнгөрүүлэх** эе (арга эв) бөлтугай» гэсэн үг гэж ухаарч байна.

591. илэткүн (илгээгтүн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 74), Лигети (33, 139), Рахевильз (25, 110), Элдэндэй Ардажав (8, 633) нар «ирэткүн» гэж, харин Пеллио «илэткүн үү?» гэж эргэлзэн тэмдэглэсэн болно. Гэтэл Хэниш (36, 81), Баяр (11, II, 888), Иринчин (28, 184) нар «илэткүн» гэж орчуулсан бөгөөд энэ үгийг Хэниш (15, 88), Поуха (17, 140), Калужинский (61, 126), Рахевильз (49, № 21, 1980, 20) Дамдинсүрэн (7, 187) нар «бидэнд илгээгтүн» буюу бидэнд явуул» гэж, Кливз (42, 134), Дугаржав (24, 163), Мансан 27, 239) нар «бидэнд өгч ирүүл» гэх буюу «бидэнд хүргэж ир» гэж тус тус орчуулсан байна.

Бид энэ үгийг илэткү (илэгэгтүн-Баяр) гэж сэргээх нь зөв гэж үзэж харин «ирэткүн» гэснийг «р, л» авиаг сольсон галигч нарын алдаатай сэргээлт гэж үзэх үчир утгыг Хэниш нарын орчуулгыг дэмжиж байгаагаа тайлбарлая. Учир нь «өгчү ирэткүн» гэдэг нь монгол хэлний зүйд төдий л сайн нийцэхгүй юм. Юу гэвэл өгч гэдэг нь явуулагч этгээдийн тусах үйл үг гэтэл ирэткүн гэгч нь өгөгдөгч хүний эс тусах үйлийг тэмдэглэх учир хоорондоо учир зүйн талаар авцалдахгүй буруу найруулга шиг санагдаж байна.

592. мөс[г]илдүкүн (мөсгилдүхүн) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь (36, 111) Пеллио (9, 74), Лигети (33, 139), Рахевильз (25, 110), Баяр (11, II, 889), Дашцэдэн (26, 142), Элдэндэй Ардажав (8, 633), Иринчин (28, 184) нар цөм «мүсэлдүкүн» гэж сэргээн сийрүүлдэг бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг «салгагдахун» **гэж тайлжээ.**

Энэ үгийг Хэниш «их мөрний цаад тал уруу салган явуулъя» (15, 88) гэж, Поуха (7, 140), Калужинский (61, 126), Кливз (42, 135), Рахевильз (49, № 21, 1980, 20), Дугаржав (24, 163) нар «мөрний цаана салгавч» гэж, Дамдинсүрэн «мөрөн голыг гатлавч» (7, 187), Мансан «мөрний цаана холдовч» (27, 239), Элдэндэй Ардажав (8, 640, тайлбар № 27) нар «салалцах, салж одохуйа» гэж тус тус орчуулсан нь цөм хадмал орчуулгыг барьжээ.

Бидний бодоход Сүбэгэтэйг Тогтога, бэхийн дайжин зуггаасан хүүхдүүдийг мөрдөн хөөж даруулахаар явуулсан тул энэ үг «мөсэлдүкүн» бус «мөс[г]илдүкүн» гэсэн үг байж болох юм.

«Мүсэлдүкүн, алгасалдухун» гэсэн хоёр үгийн дуудлагыг мэдэхгүйдээ сүүлчийн зохиогч «мөсэлдүткүн, алгасалдутхун» болгож засаад орчуулсныг юутай ч шүүмжилж болох буй за. Би энэ өгүүлбэрийг дараах маягаар уламжлах үүнд: «мөрний тэртээ уруу салж одугтун, га мөн маягаараа урагшлагтун» (47, [125]) гэж Мостарт гуай орчуулсан юм. Гэвч бид мөн Мостарт гуайн адилаар «мэсэлдүхүн» гэдэг үг чухам ямар үг болохыг энэ бичлэгээр нь мэдэхгүйдээ дэмий л «мөс[г]илдүкүн та» гэсэн үг биш байгаа даа гэж таамаглахаар зориглосон тул уг үгийг хэтэрхий гуйвуулсан гэж зэмлэгчдэд урьдаас хүлчил өчих байнам.

593. үжүгүлэн (үзүүр[р]лэн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 161), Пеллио (9, 74), Лигети (33, 140), Рахевильз (25, 110), Баяр (11, II, 893), Элдэндэй Ардажав (8, 634), Иринчин (28, 185) цөм «үжү'үлэн» буюу «үжүгүлэн» гэж, Дашцэдэн «үжүүлэн» (26, 143) гэж сэргээн босгосон билээ.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эцэст нь хүртэл мөшгин нэхүүлэн явуулав» (36, 161) гэж тайлав. Энэ үгийг Хэниш (15, 88), Поуха (17, 140), Калужинский (61, 127), Рахевильз (49, № 21, 1980, 20), Кливз (42, 135) нар ерөнхийдөө Хэнишийн дээр тайлсны дагуу эцэст нь хүртэл мөрдөн хөөлгөх гэсэн санаагаар орчуулсан бололтой.

Дамдинсүрэн уул үгийг тойрч «төлөөс өшөөг ав гэж» (7, 188) гэж, Дугаржав «яасан ч нэхэгтүн» (24, 164) гэж, Мансан «мохтол нэхүүлэхээр» (27, 240) гэж тус тус орчуулаад Мансан (27, 259), Элдэндэй Ардажав (8, 640, тайлбар № 32) нар «үзүүрт хүртэл нэхүүлэх» гэсэн үг гэж тайлбарлажээ.

Энэ нөхөд энэ үгийг «үзүүр» гэсэн үгтэй холбож үзсэн нь ерөнхийдөө зөв боловч бидний санахад энэ үг «үжүгү[р]лэн» гэсэн үг бөгөөд «бүцалтгүй зориулан зүтгүүлэн» гэсэн утгаар XIII—XIV зууны үед монгол бичгийн хэлэнд хэрэглэгдэж байсан үг юм. XIV зууны эхний гүн ухааны номын орчуулгад:

«Өд[өөд] үгэй дайисун-а йар-а гаргагдабасу-бэр
Бэйэ-дэгэн чимэг мэтү үжүгүргэкүй болбасу элэ
Йэкэ утх-а-йи бүтүгэкү йин тулада сайитур хатагужигчи
Надур жобаланг-ун хо[о]р-а ишу таки йагун жэ болху»

(40, 34—35) гэсэн шүлэг байгаагийн утгыг «өөд дайсанд шархдсан шархаа өөрийн биед буй чимэг мэт нэгэн үзүүрт сэтгэлээр зорин сэтгэвэл их утгыг бүтээхийн тулд хатуужил (бясалгал) хийгч надад зовлонгийн хор хөнөөл нь чиг юу л болов зэ» гэсэн үг гэж ойлгож байна. Энд «үзүүрхэх» гэдэг үг «гуйвшгүй нэг үзүүрт сэтгэлээр зорин итгэх» гэсэн утгаар хэрэглэгдсэнээс үзвэл «үжүгүлэн» гэсэн үг «нэг үзүүрт сэтгэлээр зориулан явуулсан» гэсэн утгатай байж болох бөгөөд ер нь энэ «үжүгү[р]лэх» гэдэг үгийн гаргаж байсан үгийн утгыг хожим «нэгэн үзүүрт сэтгэлээр» гэдэг үгээр хэлэлцэх болсон болов уу гэж санагдана. «Үжүгүр» (үзүүр) гэсэн нэр үгийн үндсэнд нэр үгээс үйл үг бүтээх «лэ» дагавар залгаж үйл үг үүсгэхэд эцсийн «р» гийгүүлэгч нь орхигдон «үжүгүлэ» гэдэг үүсч түүнд нөхцөл үйлийн хам хэлбэрийн «н» нөхцөл залгаж энэ «үжүгүлэн» гэсэн үгийг бүтээсэн нь лавтай.

594. өбэрмичэлэн (өвөрмөцлөн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш (36, 122), Пеллио (9, 75), Лигети (33, 141), Рахевильз (25, 111) нар «ө'эрмичилэн» гэж, Дашцэдэн «өэрмичилэн» (26, 144) гэж, Баяр (11, II, 903), Иринчин (28, 186) нар «өбэрмичилэн» гэж, Элдэндэй Ардажав «өгэрмичилэн» (8, 642) гэж тус тус сэргээснээс бид Баяр Иринчин нарын сэргээлтийг илүү ойртсон гэж бодно. Харин энэ үгийн хятад орчуулгын утгыг Хэниш «онцгойрч» «ялгарах» гэж тайлаад энэ үгийг Хэниш (15, 89), Поуха (17, 142) Калужинский (61, 127) нар «өөр зүгт тэмүүлэн сэтгэнэ» гэж, Кливз (42, 137), Рахевильз (49, № 21, 1980, 21), Баяр (11, II, 903) нар «өөрийнхөөрөө бодож» гэж, нөгөө Дамдинсүрэн (7, 190) Дугаржав (24, 167), Мансан (27, 242), Элдэндэй Ардажав (8, 642) нар цөм «өөрөөр сэтгэх» гэж тус тус ойлгож тайлбарласан байв.

Бидний бодлоор бол энэ үгийг «өбэрмичилэн» гэж сэргээх нь буруу бөгөөд зүй нь хуучин монгол бичгээр Баяр гуайн сэргээсэн шиг «өбэрмичэлэн» гэж сэргээх нь зөв гэж бодно. Учир нь энэ үг монгол хэлний үгсийн санд «өбэрмичэ-мал амитан-у өбэрмичэ мөн кэмэкү мэтийин» (12, 156б) гэж бүртгэгдсэн бөгөөд ингэж бичигддэг уламжлалтай үгнээс үүссэн үг мөн болох нь эргэлзээгүй. Энэ өөр гэсэн үгнээс шал өөр буюу эсрэг утгатай нь хүн ба юмын чухам бусдаас ялгарах гойд тавдагдашгүй шинжийг тэмдэглэсэн утгатай үг юм. Иймд энэ үг «өөрөөр бодох» гэсэн үг биш, харин зөвхөн «өөрийнхөөрөө бодох» гэсэн утгатай нь гарцаагүй. Иймээс бид энэ үгийг өбэр (өөрийн бие гэсэн утгатай төлөөний үгийн анхдагч үндэс) +ми (нэр үгээс үйл үг үүсгэх дагавар +чэ (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) +лэ (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +н (нөхцөл үйлийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй бөгөөд дан ганц «өөрийнхөөрөө бодох» гэсэн утгатай үг худам монгол бичигт ингэж бичигдэж байжээ гэж төсөөлөн сийрүүлэв.

595. хагатлажу агдажуху жэ (хагаслаж агджээ зэ) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 56), Пеллио (9, 75), Лигети (33, 141), Рахевильз (25, 112), Баяр (11, II, 911), Дашцэдэн (26, 144), Элдэндэй Ардажав (8, 647), Иринчин (28, 187) нар «хахалдажу» гэж сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хуваах хуваагдсан байх» (36, 56) гэж тайлсан бөгөөд Хэниш (15, 89), Поуха (17, 143), Калужинский (61, 128), Кливз (42, 138), Рахевильз (49, № 21, 1980, 22) нар «нэг хөнжил хуваалцан нөмөрч» гэж, Дамдинсүрэн (7, 191), Дугаржав (24, 169), Мансан (27, 244) «нэг хөнжил нөмөрч» гэж тус тус орчуулдаг нь утгаа утга чанар адил бөгөөд ерөнхийдөө зөв юм. Бид энэ үгийг Хэнишийн адил «хагалагдаж» буюу хагалах гэдэг үгийн бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн үг гэж үзэхгүй бөгөөд харин «хагалтажу» гэж сэргээхийг бууру болов уу гэж бодно. Учир нь нууц товчоонд хэрэглэгдсэн бусад дараалсан хоёр үйл үгийн сүүлчийн үйл үгэнд үйлдэгдэх хэвийн нөхцөлтэй үгийг хэрэглэж, эхний үйл үгийг идэвхтэй (үйлдэх) хэвийн нөхцөлтэй хэвээр хэрэглэдэг тохиол олон юм. [Жишээ «абчу нэгүкдэрүн» (§73) «булижу абтаба» (§76) г.м] Иймд энэ холбоо үгийн «агдажуху жэ» гэсэн сүүлчийн үг нь үйлдэгдэх хэвийн үйл үг байгаа тул өмнөх үг нь эрхбиш мөн «хагалтажу» гэсэн үйлдэгдэх хэвийн үйл үг баймгүй юм. Энэ учраас энэ үг угтаа «хагатлажу» (хагаслаж) гэсэн үг байсныг галиглагчид авиа сольж бууру тэмдэглэсэн гэж бодох үндэстэй. Учир нь хөнжил мэт зөөлөн юмыг «хагалах» гэж хэлдэггүй харин «хагаслаху» гэж хэлсэн байх монгол хэлний учир зүй бий. Ингэж үзвэл «хагатлажу» гэдэг нь хадмал хятад орчуулгынхаа «хөнжлөө хуваалцаж» гэсэн утгад илүү нийлэлцэнэ. Энэ «хагатлаху» гэдэг үйл үгийн т авиа халхын аялгуунд с авиагаар сэлгэж «хагаслажу» гэж хэлэгдэх бичигдэх болсон боловч буриад зэрэг зарим аялгуунд «хагадлаху» гэж д, т авиатай хэвээр хадгалагдсан баримт ч байна. Иймд бид энэ үгийг «хагатлажу» гэж сийрүүлэв.

596. Үжэн йадажу (үзэн ядаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Иринчин тэргүүтэн бүх судлагчид цом «үжэн йадажу» гэж сэргээн босгодог бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «халидүи йадажу», «ойртон (халдун) йадажу» (36, 58) гэдэг өмнөх холбоо үгийн нь утгын дагуу «уулзан ядаж» гэж тайлсан болоштой байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 90), Поуха (17, 143), Калужинский (42, 128), Кливз (61, 138), Рахевильз (49, № 21, 1980, 23) нар цом «учрахаас зайлж түвэгшээх» гэж, Дамдинсүрэн «ухаант царайг харахаас ухран зовж явав» (7, 192), Мансан «ичиж зовж байв» (27, 245), Дугаржав (24, 170), Баяр (11, II, 815), Элдэндэй Ардажав (8, 647), Дашцэдэн (26, 145) цом «үжэн йадажу» гэж ухаарсан байв. Энэ үгийг сэргээн босгох болон уг үгийн утгыг ойлгох талаар судлагчидтай бидэнд зөрөөтэй санал үгүй тул бидэнд тайлбарлах зүйлгүй юм. Гэвч энд «үжэн йадажу» гэсэн үгэнд орчин цагийн монгол хэлэнд байдгийн адил «занан дургүйцэх» гэсэн утга тэр цагт байсангүй, харин үүний эсрэг «уулзахаас эмээж, ичиж, халшрах» гэсэн утгатай байсныг нь зөвхөн онцлон тэмдэглэх гэсэн билээ.

597. жагиг-ун (завигийн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдгийн галигаас нь Хэниш (36, 84), Пеллио (9, 76), Лигети (33, 142), Рахевильз (25, 112), Баяр (11, II, 921), Дашцэдэн (26, 145) Элдэндэй Ардажав (8, 648), Иринчин (28, 188) нар цом «жахинг» гэж санал нэгтэй сэргээн сийрүүлдэг байна.

Энэ үгийн хятад хадмал орчуулгын утгыг Хэниш «Хүрэм цамцны дотоод зах» (36, 84) гэж, Иринчин «энгэр» (28, 189) гэж тус тус тайлсан байна. Энэ үгийг Хэниш «өмдний чинь өргөс» (15, 90) гэж Поуха (17, 144), Калужинский (61, 128) нар Хэнишийнхтэй ойролцоо утгаар, Кливз (42, 139), Рахевильз (49, № 21, 1980, 23) нар «хүрэмний дотоод энгэрийн өргөс» гэж, Дамдинсүрэн «эгэмийн чинь өргөс» (7, 193), Дугаржав «жасимын (эгмийн) чинь өргэсүн» (24, 171), Элдэндэй Ардажав «жасинг» өвөр монголын зарим нутгийн аялгуунд нэгэн хаалгат үүд, гал зуухыг тойруулан тавьсан модон хүрээ, хоёр тасалгааг салгаж модоор хийсэн гэрсэгээ зэргийн нэр байдаг учир «үүдэн дээрх өргөс» гэсэн үг байх бөгөөд өдөр турш хүн амьтныг амар төвшин эс байлгах гэсэн утгатай гэж тайлбарлажээ.

Бид энэ үгийг «жабинг» буюу «жабиг» гэсэн үг байж магадгүй гэж бодно. Ингэж таамаглах үндэс нь нэгд дэгэл ~ дэбэл гэх мэтээр «г, б» хоёр авиа сэлгэдэгт оршино. Хоёрт, забилах суудал бол монгол хүний бодлоор хүндтэй хүний тухтай суудал мөн учраас «завилах нь жанжин, залгих нь мангас» (98, 32а) гэсэн зүйр үг гарсан юм. Суудал дороос нь хатгах өргөс бол ямар ч хүний тухтай суудлыг алдагдуулах зүйл тул түүгээрээ зүйрлэж хааны тух тавыг алдагдуулах шалтгаан нь би болно гэсэн утгаар хэлсэн байж болно.

Гуравт үйл үгэнд «г» дагавар залгаж жиру ~ г-жируг (зураг) «бичибичиг» гэх мэт жишээ олон байвч заримдаа нэр үгээс буюу дайвар үгээс энэ дагавраар үг бүтсэн цомноху гэдэг үйл үгийн үндэс «цом» гэсэн дайвар үгээс «цомуг-өвсийг урт цогцлагсан ану» (12, 780а) гэх мэт үг бүтсэн байх тул завилах гэдэг үгийн үндэс зави-гэдгээс «завиг» гэдэг үг бүтсэн байж болохыг үгүйсгэх аргагүй. Жабинг гэдэг энэхүү «жабиг» гэсэн үгийн ташаа галиглал байж ч бас магадгүй юм.

598. өрүлиг-үд нөкүд-ийэр-ийэн (есөн өрлөгүүдээрээ) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 126), Пеллио (9, 76), Лигети (33, 142), Рахевильз (25, 112) тэргүүтэн зарим нь «өрлү'үд нөкөд-ийэр-ийэн» гэж, Баяр (11, II, 923), Элдэндэй Ардажав (8, 648), Иринчин (28, 188) нар «өрлүгүд нөкөд (Иринчинээс бусад нь)-дур ийэн» гэж сэргээсэн нь уг хятад галиг, Хэниш, Пеллио нарын (эсвэл уг эхийн) алдаатай галиглалыг дагаж ташаа сэргээсэн шиг санагдаж байна.

Энэ «өрлүкүд» гэсэн үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эрэлхэг, баатарлаг, баатар» (36, 126) гэж тайлсан бөгөөд бусад судлагчид, хожмын бүх түүхчид цом энэ утгаар буруу ойлгож орчуулсан буюу тайлбарласнаар барахгүй хуучин (сонгодог) бичгийн хэл болон олон түүхэн домогт ташаа ухагдахуун болж орсон шиг бодогддог.

Цагаан түүхийн хэрэглэгдэхүүн баримтаас үзвэл энэ үгийг «Нууц товчоог» XIV зууны үед галиглагчид тухайн ярианы хэлэнд түрэг үгийн бичлэгт ойртуулан «өрлүгүд» гэж тэмдэглэсний учраас Хубилай хааны үед төрийн есөн бэлгэ (бэлэг) хариуцаж агсан есөн баатар эрэлхэг сайд есөн эрлүкүүдтэй андуурагдан «баатар эрэлхэг өрлүгүүд» байсан гэдэг төөрөгдөл гарсан болоштой гэж таамаглав. Нөгөө талаар Нууц товчоонд бичигдсэн «[есөн] өрэлигүд нөкүд-ийэр-ийэн» гэсэн үг худам монгол бичгийн болон эртний монгол хэлэнд байсан олон тооны зохицлын улмаас есөн удаа ялнаас хэлтэрч өршөөгдөх эрхтэй хүмүүсийг хэлдэг «есөн» (ес гэдэг нь ганц тооны хэлбэр) «өрэлигүд» (есөн буюу

олон удаа өршөөгдөх эрх бүхүй учраас) гэсэн хоёр үг хоорондоо олон тооны зохицолтой бичигдсэн нь монгол хэл бичигт олон тооны зохицол алга болсон хожим (XVIII зууны) үед есөн өрлүг (гэгч есөн баатар) байсан гэж буруу ойлгоц төрүүлсэн гэж бид урьд нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ (10, 49—75) тодорхой тайлбарласан учир бид тэр баримтлалынхаа үүднээс Нууц товчооны худам монгол бичгийн эхэд «[йөсүн] өрэлигүд-нйэр-ийэн» гэж бичсэн байсан гэж таамаглан ийнхүү өөрөөр сийрүүлэв.

599. далан гурбан агтас-ийар-ийан (далан гурван агтсаараа) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь сэргээн босгох болон түүний утгыг ойлгох талаар бидэнд тайлбарлах зүйлгүй боловч харин энэ бол аман зохиолын нөлөөгөөр орж ирсэн тэнгэрийн ёсны бэлэг тэмдгийн утгатай. Харин Чингис хаанд байсан алдарт сайн агтын тоо биш гэдэг саналаа энд тэмдэглэх гэсэн юм. Үүнийг С. А. Козин зөрэг зарим эрдэмтэн ерэн таван мянганы ноёдын дотроос хааны язгуур удамтайг нь хасаад үлдсэн далан таван хүнийг нь ёгтлон оруулсан байх (105, 168) гэсэн таамаглал дэвшүүлж байв.

Бидний бодлоор бол энэ 73 агтас гэдэг үг Монголын ардын аман зохиолын уламжлалаар «Цуутын цагаагч гүү» гэдэг тэнгэрийн адууны сүргийн домог-үлгэрийн өсөн нэмэгдэхийн бэлгийг тусгасан тоо юм. Учир нь тэр үлгэрт тэр гүүг Далан хоёр ижилтэй, дархан хул азаргатай гэж гардаг бөгөөд энд бүгд 73 адуу гарч буйн 72 нь 8 хөлтэй унага (хурга ишиг ямар ч мал) төрвөл өсөхийн бэлгэ тэмдэг тул түүнийг 9 тэнгэрийн тоогоор үржүүлбэл 72 гэсэн тоо гарна. Түүн дээр Цуутын цагаагч гүүний цуурай цагаан унагыг Хан Харанхуй буюу эсвэл түүний дүү Эрхий Мэргэн баатрын унаа болсон гэдэг тул бүгд 73 агт болж тэнгэр язгуурт Чингис хааны далан гурван агтсын тооны уг сурвалж болж нууц товчоонд орсон гэж бид бодож байна. Харин Чингис хаан овгоосоо хасагдаад байхдаа 9 шарга морьтой байсан нь үнэн бол хамгийн хаан болсон хойноо далан гуравхан агттай байсан гэдэг нь төдий л түүхэн агуулгатай мэдээ гэж итгэхийн аргагүй юм. Учир нь агт гэдэг бол агталж зассан адууны нэр болохоос бус, хүлэг сайн морины нэр биш билээ.

600. булха-[х-]айитчу (дайсан болж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 105), Пеллио (9, 76), Лигети (33, 143), Рахевильз (25, 113), Баяр (11, II, 929), Элдэндэй Ардажав (8, 649), Иринчин (28, 189) нар цөмөөрөө «булха көйитчү» гэж сэргээсэн байна. Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «төлөвлөх» хам утгыг «урвах, урвалт сэдэх» (36, 105) гэж тайлжээ. Энэ холбоо үгийг Хэниш (15, 91), Поуха (17, 145), Калужинский (61, 129), Кливз (42, 140), Рахевильз (49, № 21, 1980, 24) нар «урвалт [бослого] сэдэж» гэж, Дамдинсүрэн «буруу зан, булихай явдал гаргаж» (7, 196) гэж, Дугаржав «тусгайлан булихай хэрэг болгон өдөөж» (24, 175), Мансан «дайн өдөөж» (27, 247) гэж тус тус орчуулсны дээр энэ «көйитчү» гэсэн үгийг Элдэндэй Ардажав нар түрэг хэлний асаах, сэтгэл хөдөлгөх хүчтэй шунал төрүүлэх гэсэн утгатай «күйдүр» гэдэг үгтэй холбож тайлбарлав (8, 659, тайлбар № 44).

Бид энэ үгийг «булха-х-айитчу» гэсэн үг болов уу гэж таамаглаж ийнхүү сийрүүлсэн болно. Учир нь «булха»-урвасан дайсныг хэлдэг а эгшгээр төгссөн үг тул түүний араас «айитчу» (айлд орж) гэсэн үгийг залгахад аман ярианы дуудлагад хоёр эгшгийг нь засварлах х, г, н, д гэх мэт гийгүүлэгч жийрэглэн оруулж тэмдэглэсэн энэ мэт жишээ «МНТ»-ы хятад үсгийн галигт өдий төдий байх тул булха-[х]айтчу гэсэн үг булха көйитчү» гэж буруу тэмдэглэгдсэнээс зайлахгүй. Иигэж бодох өөр нэг үндэс бол орчин цагийн монгол хэлэнд аливаа тоглоомд оролцогчид тоглоомын дүрмийг зөрчиж залилдахыг «булхайдах» гэж ярилцдаг нь «булха айтху» (урван буруугаар тоглох) гэсэн утгатай үг үүсгэсэн гэж бодогдуулж байна. Гэвч энэ үгийг хуучин монгол бичигт «булихайчаху-булихай гаргаху» (12, 285б) гэж бичдэгийн «булихай» гэдэг нь ч мөн булих[у]+ай гэсэн хоёр үгээс бүтсэн гэж мэдэж болно. Булиху гэгч «МНТ»-ы эхэд «булаах» гэсэн утгатай гардаг тул анхандаа наадагчид булхайлахдаа шууд «булааж» авдаг байснаас энэ үг анх «булих+ай» гэж үүсээд сүүлд хүчээр биш залиар тоглоомын журамнаас урваж авах гэсэн утгаар булха+ай=булхай гэж солигдсон ч байж болох юм.

Энэ үг хэрэв зарим судлагчдын ойлгож орчуулсан шиг «булха+өдүжү» гэсэн үгнээс үүссэн бол галигт «булха хөйидүжү» гэж бичигдэх байсан байх. «Булха-хайтчу бөл-дэ-айтчу» гэх мэт нийлмэл үгс «МНТ»-ы эхэд байгаагаас үндэслэн бид үүнийг «булха-[х]-айтчу» гэсэн үг гэж ийнхүү сийрүүлсэн болно.

601. эрэгүн (эрүү) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 45), Пеллио (9, 78), Лигети (33, 145), Рахевильз (25, 115)

нар цөм «эри'үн» гэж, Дашцэдэн «эриүн» (24, 148), Баяр (11, II, 945), Элдэндэй Ардажав (8, 675), Иринчин (28, 192) нар «эригүн-» гэж тус тус сэргээн босгосон байна.

Энэ үгийн утгын талаар бүх судлагчид цөм санал нэгтэй бөгөөд толгойн доод хэсгийн нэр гэж зөв ухаарсан юм. Бид энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «эрэү-толугай ийн» (12, 75б) гэж бичдэг нь худам монгол бичгийн уламжлалтай гэж төсөөлөхийн хамт худам монгол бичгийг монгол хэлэнд урт эгшиг үүсэхээс өмнө авсан тул «эү» гэсэн хоёр эгшиг нэг доор урт хос эгшгийн маягаар бичиж байгаагүй байх гэж таамаглан «эрэгү» гэж сийрүүлснээ зөв гэж бодож байна. «Эригү» гэдэг нь галиглах үеийн аман аялгууны дуудлагын гажуудал байх гэж бодсон билээ. Жич «МНТ»-ы эхний хэсэгт өгөх оршихын тийн ялгалын «-тур» нөхцөл хэрэглэдэг нь эгшгээр төгссөн энэ үгэнд тохирохгүй тул «эрэгүн-дур» гэж сийрүүлэв.

602. орочи (орч) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 127), Пеллио (9, 78), Лигети (33, 146), Рахевильз (25, 115), Баяр (11, II, 949), Козин (14, 278), Дашцэдэн (26, 148), Элдэндэй Ардажав (8, 675), Иринчин (28, 192) нар цөм «орочу» гэж сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын үгийн утгыг Хэниш «хожуу төрсөн» (36, 127) гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 90), Поуха (17, 147—148), Кливз (42, 143), Мансан (27, 267—268, тайлбар № 29), Элдэндэй Ардажав (8, 678, тайлбар № 14) нар «орой төрсөн» оттон дүү гэсэн утгаар орчуулсан байна. Элдэндэй Ардажав нар энэ үгийг «орочы» (оттон хүү) гэсэн үгтэй холбож тайлбарлажээ.
Харин Дамдинсүрэн (7, 199), Дугаржав (24, 178) нар «өргөмөл» дүү гэж орчуулсан нь оручу (буюу орж ирсэн дүү) гэсэн үг гэж ухаарсныг харуулах бөгөөд ингэж үзэх үндэс байж ч болмоор санагдана. Энэ үгийг монгол хэлний үг гэх зөв үзлийн үүднээс авч үзсэн нь үнэнд илүү ойр юм. Хэрэв энэ үгийн хадмал хятад орчуулгын утгатай «оручу» гэсэн үгийн утга таарахгүй гэж үзвэл бид бас «орочи дэгү» гэсэн монгол үгийг арай ташаа галигласан болов уу гэж бодном. Учир нь орой (хожуу) төрсөн гэсэн үгийн «оро(й)+чи» дагавар залгаж энэ үгийг бүтээсэн гэх үндэстэй. Юу гэвэл монгол хэлэнд: Орой гарсан, дорой төрсөн» гэдэг үгийг «отгон» гэсэн санаагаар биш, харин дорой донгию «хэнз бага» гэсэн утгаар хэлэлцдэг байна. Иймд орой гарсан хүүхдийг «орой» гэдэг үгэнд чи дагавар залгаж өглөө эрт босдог хүнийг «эртэчи» гэж нэрлэдгийн адил «оройч» гэж хэлсэн байж болохоос гадна Нууц товчооны хятад галигт Багурчи буюу тогооч гэсэн нэрийг «Богорчу» гэж ташаа галигласан баримт ч байдаг. Орой гэдэг үгэнд-чи дагавар залгахад эцсийн «й, р» гийгүүлэгч орхигддог хэлний жамаар й нь хаягдаж «орочу» гэдэг үг бүтсэн байх гэж үзэж «орочи» гэж сийрүүлэх нь худам монгол бичгийн бичлэгт ойртоно гэж үзсэн билээ. Жич орой гэдэг үг МНТ-д (§195) орой буюу хожуу гэсэн утгаар хэрэглэгдсэн байдгийг дурдвал «эртэ-ун унтагчи орай-а (зөв нь орой-а) босугчи» (9, 71) гэж Чингис хааны отгон дүүг тодорхойлсон байгаа нь бидний саналыг давхар батлах мэт санагдана. Иймд «орочу» буюу чухамдаа «орочи» гэгч үг түрэг хэлний «орочы» гэдэг үгтэй шууд холбоогүй, харин тэр үг нь монголын «орочи» гэдэг үгтэй холбоотой байж болохыг харуулав. Жич «орочы» гэдэг түрэг үгийн бичлэг ч уг үг «орочу» биш харин «орочи» гэж бичигддэг үг байсныг харуулж байна биш үү?

603. цаглаба (цаглав) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «чаглаба» гэж зөв сэргээн босгож сийрүүлдэг юм. Харин энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «бодох, үнэлэх, тодорхойлох» (36, 23) гэж тайлжээ. «Биеэ цаглав» гэсэн холбоо үгийн хам утгыг «өөрөө өөрийгөө үнэлэв» гэжээ. Энэ үгийг Хэниш (15, 93), Поуха (17, 48) «чи биеэ үнэлсэн» гэж, Калужинский «чи энэ тухай өөрөө шүүж шийд» (61, 131) Дамдинсүрэн (7, 200), Кливз (42, 144), Рахевильз (49, № 21, 1980, 28) нар «чи энэ хэргийг өөрөө мэдэх тул өөрөө шийд» гэхчилэн, Дугаржав (24, 179—180), Мансан (27, 251) нар «өөрөө зохистойгоор мэдэж (эсвэл бодож) шийд» гэж орчуулсны дотроос Чингис хаанаас өмч хувь хубааж бүртгэж байх эрхийг олсон хүний хувьд өөрөө мэдэх (цагласан) хүн тул өөрөө шийд гэх санаагаар хэлсэн Дамдинсүрэн, Кливз, Рахевильз нарын орчуулга хамгийн оновчтой болсон шиг санагдана.

Харин энэ үгийг түрэг хэлний «чагала» гэсэн үгнээс гаралтай тул хязгаарла гэх мэт утгатай үг гэж ойлгоод «чи биеэ дорогшлуулав» «чи биеэ барив» гэсэн утгатай гэж тайлбарласан (8, 681, тайлбар № 30), Элдэндэй Ардажав нарын тайлбарыг зөвшөөрөх аргагүй юм.
Учир нь бидний бодоход энэ нь «чагала» гэсэн түрэг үг биш харин «чагла» гэсэн монгол үйл үг бөгөөд мэдэж захирах гэсэн утгаар Нууц

товчооны өөр зүйлд (§222, §278) «тэргэн-дүр жаримуд-ийан саглажу (цаг хэмжээн тогтоон) талбитугай кэмэбэ» (25, 134) гэх зэргээр гарч байх тул захирах мэдэх гэсэн утгаар хэрэглэгдэж байсан нь ил байна. Орчин цагийн монгол хэлэнд ч «цагдан сэргийлэх гэдэг нь захиран мэдэж гэмт хэргээс сэргийлэх байгууллагын нэр байна. Шиги хутаг Чингис хаанаас өрх гэрийн өмч иргэнийг хуваарилж, заргыг шүүх гүр улсын заргачийн дээд албанд томилогдсон тул өөрөө ямар өмч эрх олж авахаа өөрөө мэдэх эрхтэй болсон тул Чингис хаан ямар соёрхол авахаа чи өөрөө мэд гэж тэр үгийг хэлсэн бололтой юм.

604. энэ нугу ижагур-а (энэ нуга (н) язгуурт) — гэсэн энэ үгийг хятад үсгээр тэмдэглэсэн галигаас нь Хэниш «но'у» (36, 78), Пеллио (9, 79), Лигети (33, 147), Рахевильз (25, 116) нар «ну'у hижагур-а» гэж, Баяр (11, II, 958), Элдэндэй Ардажав (8, 682), Иринчин (28, 194) нар «энэ нугу ужагур-а» гэж, Дашцэдэн «энэ нуу hужагур-а» гэж тус тус сэргээн сийрүүлэв.

Энэ үгийн хятад хадмал орчуулга-үгийн утгыг Хэниш «булан» (36, 78) гэж тайлсан учир Поуха (17, 149), Кливз (42, 145), Рахевильз (49, № 21, 1980, 28) нар «булангийн суурь буюу гэрийн хамгийн хүндэт сууринд суулгана» гэх чиглэлээр орчуулсан шиг санагдана. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 200), Дугаржав (24, 181), Мансан (27, 251) нар «эрхэм», «эхний», «их суурийн гол» суудалд суулгана гэсэн ба Элдэндэй Ардажав «Нугу-гэдгийг «булан»-булангийн язгуурт буюу угт нь суулгана гэсэн үг гэж тайлбарлав (8, 683, тайлбар № 6 ба 7).

Бид «энэ нугу ижагур-а» гэсэн хааны нугу (баруун) талын эхэнд суу гэсэн үг болов уу гэж өөрөөр таамаглаж байна. Учир нь нэгд, орд гэрт дугуй ханатай тул нугу гэж нэрлэгдэх ямар ч булан байхгүй юм. Хоёрт, Марко Поло бичихдээ: «Хурим найр дээр их хаан... хойд (хоймор-Ш. Г.) талд өмнө зүг харж сууна. Зүүн гар талд нь их гэргий нь баруун гар талд нь эзэн хааны хөвгүүд, ач, үр сад сууна. Тэдний толгой нь их хааны хөлийн тушаа нэгэн төвшинд байхаар доор сууна. Бусад ноёд өөр ширээнд бүр доор сууна. Их хааны хөвгүүд ач үр садын гэргийд зүүн талаар сууна. Тэдний дараа жанжин баатар тайж нарын гэргийд бүр доогуур сууна» (37, 111) гэснээс гадна өөр нэг газар эдгээр ноёдын «ард нь түшмэд... бусад хүн өөр өөрийн оногдсон газар дэс дараагаар байрлах ажээ» (106, 104) гэжээ. Нугу гэдэг бол энд нуган хөвгүүдийн буюу баруун талын гэсэн утгатай байж болох бөгөөд «нугун» хөвгүүдийн дараах буюу эсвэл арын суудлын эхэнд «язгуурт) суулгана гэсэн үг болов уу гэж бодогдоно. Энэ суудлыг тэр үед их чухалчлан зааж өгдөг байсныг мөн Богурчид «эдүгээ бүрин-ү дэгэр-э сагури сагужу» (§205) гэсэн соёрхол өгсөн баримт давхар гэрчилж байна. Суудлын энэ хатуу дэс дараа бол зохион байгуулалтын чухал арга хэмжээ мөн учраас ч «Дээд хүн суудлаа олохгүй бол доод хүн гүйдлээ олохгүй» (98, 30б) гэсэн цэцэн үг гарсан биз. Энэ бол дээд хүмүүс байр байрандаа суухгүй бол доорд (үйлчлэгч) хүн эхлээд хэнд очиж хундага дугараа барихаар «гүйх» учраа олохгүй болдог энэ найрын тодорхой байдлаас гарсан нь магадтай авч харин цаашдаа дээдэс (удирдлага) нь замбараагүй бол доордос (гүйцэтгэх хүмүүс) нь ажил бүтээж чадахгүй гэсэн гүнзгий утга сургаалтай үг болжээ.

605. сар-а-дур сатажу (сард сарлаж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид энд бичсэнээр сэргээн босгодог билээ.

Харин энэ «сатажу» гэсэн үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «зөвлөн туслах, шийдэх, шийдвэрлэн тогтоох» (36, 132) гэж тайлсан тул Хэниш өөрөө (15, 93), Поуха (17, 149), Калужинский (61, 131) нар «бэлэг өршөөл өглөг (шагнал) гаргаж өгөх» гэж, Кливз (42, 145), Рахевильз (49, № 21, 1980, 28) нар «он сар бүрд тантай зөвлөлдөж» гэж, Дугаржав «сар бүр хэлэлцэж» (24, 181), Мансан «орхиж», Элдэндэй Ардажав нар «садака» (өглөг юм) гэсэн түрэг үгнээс гаралтай үг гэж Юан улсын судрын орчуулга зэргээс иш татан тайлбарласан (8, 683, тайлбар № 8) боловч тэр нь албадан таарууллсан шинжтэй болжээ. Гагцхүү Дамдинсүрэн энэ үгийг «сар бүр саатахгүй» (7, 200) гэж орчуулсан нь маш оновчтой болсон шиг санагдана.

Учир нь энэ үг хадмал хятад орчуулгад нь хэлсэн шиг зөвлөх шийдэх гэсэн биш, бидний бодлоор са[р]) сар гэдэг үгийн р нь орхигдсон язгуур) +та (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +жу (нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг бөгөөд «сардаж» (сар сард тооцон бодож) гэсэн утгатай үг гэж бодож байна. Энэ үгийн сар сардах тооцон бодох гэдэг утгыг нь хожмын үед ойлгохоо байсан учраас ерөөл магтаалдаа «Өдрийн сайныг өнжин хүлээж, сарын сайныг саатан хүлээж» гэж хэлдэг болсон бололтой бөгөөд энэ учраас ч Дамдинсүрэн энэ «сатажу» гэсэн үгийг «сар бүр саатахгүй» гэж орчин цагийн монгол хэлэнд байгаа «саатах» гэсэн утгаар нь оновчтой орчуулсан байна.

606. нойир а[+б]тугай (нойр автугай) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 120), Пеллио (9, 79), Лигети (33, 148), Рахевильз (25, 117), Баяр (11, II, 965), Дашцэдэн (26, 151), Иринчин (28, 195) нар цөм «нойир атухай» гэж, ганцхан Элдэндэй Ардажав (8, 686) «нойир автугай» гэж сэргээн сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын хам утгыг Хэниш дээр дурдсан хуудсанд «нойр» гэж тайлаад уул үгийг «намайг нойртой байг гэж» (15, 84) гэж орчуулжээ. Энэ үгийг Поуха (17, 150), Калужинский (61, 132), Клливз (42, 146) нар «унтаг гэж» гэж, Рахевильз «миний нойрыг хүрэхгүй гэж» (49, № 21, 1980, 29) гэж, Дамдинсүрэн (7, 201), Мансан (27, 252) «намайг унтуулах» гэж, Дугаржав «нойр автугай» (24, 182) гэж тус тус орчуулснаас, миний бодоход, Элдэндэй Ардажав Дугаржав нарын сэргээлт хамгийн зөв оновчтой болсон тул «а[б]тугай» гэж бид сийрүүлэв. Учир нь **«намайг нойр атухай»** гэдэг монгол хэлний зүй ба учир зүйд нийцэмгүй өгүүлбэр юм. Монгол хэлний учир зүйн үүднээс авч үзвэл нэг бол «намайг нойртой атугай» гэж, эсвэл «намайг нойр автугай» гэсэн өгүүлбэр баймаар санагдана. Монгол хэлний хавсарсан нийлмэл өгүүлбэрийн доторх гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн заахын тийн ялгалын нөхцөлтэй үгээр байж болдог жамтай тул бид «намайг нойр абтугай» гэсэн сэргээлтийг дэмжин сийрүүлэв.

607. нэмүр[г]эгсэгэр (нөмөргөсөөр) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас Хэниш (36, 115), Пеллио (9, 79), Лигети (33, 148), Рахевильз (25, 117), Баяр (11, II, 965), Дашцэдэн (26, 151), Элдэнтэй Ардажав (8, 686) нар «нэмүрэгсэгэр» гэж, Иринчин «нэмүрэгсэбэр» (28, 195) гэж тус тус сийрүүлсэн байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «эсгий цамц (эсгий дээл) хучих» гэж тайлсан байна. Тэгээд Хэниш (15, 94), Поуха (17, 150), Калужинский (61, 132), Клливз (42, 146), Рахевильз (49, № 21, 1980, 29) нар цөм намайг эсгий нөмөргөөрөө халхалаж (бүтээж хучиж бүрхээж) үргэлжлүүлсэн гэсэн утгаар ерөнхийдөө зөв болгон орчуулсан юм шиг санагдана.

Дугаржав, Элдэндэй Ардажав, Иринчин нар «нэмүрэгсэгээр» «нэмүрэксэбэр» гэж буруу хэвээр сийрүүлсэн буюу орчуулсан байхад ганц Дамдинсүрэн (7, 201), Мансан (27, 252) «нэмүргэгсэгээр» буюу эсвэл «нэмүргэбэ» гэж галигийн алдааг залруулж зөв болгон орчуулсан байна. Бид «нэмүргэ-бэн нэмүрэксэгэр» гэсэн холбоо үг утгын үүднээс биш бол монгол хэлний зүйн үүднээс нийлэмжгүй буруу байгаа учир энэ үгийг худам монгол бичигт «нэмүр[г]эксэгэр» гэж бичсэн байснаар төсөөлөн бодож сийрүүлэв. Учир нь гэвэл нэгд «нэмүргэ-бэн» гэсэн үг ерөнхийлэн хамаатуулахын нөхцөлтэй заахын тийн ялгалын хэлбэрт байгаа нь тодорхой атал «нэмүрэксэгээр» гэдэг нь заахын тийн ялгалт шууд тусагдахуун үгийг захирч чадахгүй эс тусах үйл үг байгаа нь нийцэхгүй. байх тул энэ үг эрхбиш үйлдүүлэх хэвийн «-гэ» нөхцөл бүхүй тусах үйл байгаад «г» нь галигт хаягдсанаас зайлахгүй. Энэ холбоо үгэнд байгаа хэлзүй, учир зүйн энэ алдаатай сэргээлтийг Дамдинсүрэн мэдэж «Нэмүргэ-бэн на-д-а нэмүргэгэд» (7, 201) гэж залруулсан нь зөв гэж бодно. Нөгөө талаар «нэмүрэксэбэр» гэж Иринчиний сэргээсэн нь нөхцөл үйлийн энэ хэлбэр анх «нэмүрэксэ[н]-бэр» гэсэн үйлт нэрийн хэлбэрээс үүссэн гэж үзвэл илүү зөв бөгөөд эртний бичлэг мөн боловч бид Нууц товчоог зохиох үед энэ үг нэгэнт үүсээд «нэмүрэксэнээр» гэдэг хэлбэрээсээ өөр утгатай нөхцөл үйл үгийн үргэлжлэх хэлбэр болчихсон байсан болов уу гэж бодогдох тул худам монгол бичигт «нэмүр[г]эксэгэр» гэж бичигдсэн байх гэж таамаглаж ийнхүү сийрүүлсэн болно. Өөрөөр хэлбэл энэ үгийг хуучин монгол бичигт «нэмүр(г)эксэгэр» гэх мэтээр бичдэг нь худам монгол бичигийн бичлэгийн уламжлал мөн гэж бодож байна.

608. нойитан нобсилдужу, хүйитэн хөбсилдужу (нов нойтон хүв хүйтэн болж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид «нойитан нобсилдужу, хөйитэн көбсилдужу» гэж бас утгыг нь «нойтанд норолдож хүйтэнд хөрөлдөж» (хамаг хэцүү бэрхийг хамт туулалцаж явсан) гэж ойлгодог тул энд бидний тайлбарламаар зүйл төдий л ихгүй.

Гагцхүү энэ «нобсилдужу көбсилдужу» гэдэг үг орчин цагийн монгол хэлэнд мартагдсан үг бүтцийн хувьд ямар үг болохыг судлагчид нэг ч хүн тайлбарлаагүй өнгөрсөн юм. Бид энэ хоёр үгийг «ноб-(норох гэдэг үгийн хүч нэмэгдүүлэх утгвар үгийн үндэс) +си (өөр аймгийн үгээс үйл үг бүтээх дагавар) +лду (үйл үгийн үйлдэлдэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жу (нөхцөл үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл), хөб (мөн хүйтэн гэдэг үгийн хүч нэмэгдүүлэх утгвар үгийн үндэс) +си (өөр аймгийн үгээс үйл үг бүтээх дагавар) +лду (үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл) +жу (нөхцөл үйл үгийн зэрэгцэн болох хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Ин-

гэж бодох үндэс нь нэгд, нойитан (нойтон) көйитэн гэсэн хоёр үг хоёулаа ноб нойитан, көб күйитэн гэж нойтон хүйтний зэрэг заах угтвар үг өмнөө хэрэглэж болох чанар шинжийн тэмдэг нэр байгаа явдал байв. Иймд «норулдужу» «көрүлдүжү» гэсэн үгээр энэ утгыг гаргаснаас «нобсилдужу көбсилдүжү» гэсэн нь чанар шинжийн илүү зэрэг заах үгийн үндэснээс үүсгэсэн үйл үг учраас «улам ихээр норолдож хөрөлдөж (даарч) явсан» гэсэн санаа гаргажээ.
Ийм журмаар тэмдэг нэрийн зэрэг заах угтвар үгээс үг бүтээсэн өөр жишээ төдий л олонгүй боловч мөн тийм угтвар үг дайвар үгээс үг бүтээсэн удаа цөөн боловч байна гэж бидэнд бодогддог билээ. Жишээлбэл гав шав (габ сиб) хийх гэдэг дайвар үгийн нэгдүгээр үндэснээс нь габ+си+гай гэсэн үг энэ загвараар бүтсэн мэт санагдана.

609. нэнг-түү хутуг (нэнт хутаг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 115), Пеллио (9, 80), Баяр (11, II, 971), Дашцэдэн (26, 152) тэргүүтэн судлагчид цөмөөр «нэндү хутуг» гэж санал нэгтэй сэргээсэн байдаг. Харин энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «хутагт гэгээн» гэсэн үгээр тайлжээ.

Энэ үгийг Хэниш (15, 95), Поуха (17, 151), Калужинский (61, 132) нар «ивээгч хутагт, онгон, зол ивээгч тэнгэр» гэх зэргийн утгаар орчуулсан байхын дээр бас монгол хэлтэн судлагч Дамдинсүрэн «Өлзийт нөхөр болжу» (7, 202), Дугаржав «Өлзий хутагт чиний» (24, 180), Мансан «алсыг зөгнөх эрхэм дээд өлзий оршуулагч мэтү» (27, 253) гэж ихэд ойртуулан орчуулсан байв. Ялангуяа Мансангийн орчуулга «арай нуршуу олон үгээр тайлбарласан орчуулга боловч энэ «нэнгт» гэдэг үгийн жинхэнэ утга санааг зөв зүйтэй илэрхийлж чадсан байна. Бид энэ үгийг нэнг+түү» гэсэн үг гэж тааварлаж байгаа бөгөөд энэ бусдаас «нэн» их буюу хэтүрхэй угтан зөгнөн мэдэх чадал бүхий гэсэн утгатай үг гэж бодож байна. Ингэж бодох үндэс нь нэгд манай 546 дугаар тайлбарт тайлбарласан шиг нэнг нэнгдэн, нэнгдэкү-хэтэрхийдэх гэх мэт үг толь бичигт бүртгэгдсэнд оршино. Хоёрт Монголын түүхэн бичигт:

«Ухагату цэцэд бүгдэгэр
Хэтүрхэй-э йисүн өрлүк-үн үгэс-и
Кэрэглэн эмэгэл-үн (эмкилүн) дагун-дур абубай»

31, II, 19) гэх мэт үг тэмдэглэгдсэн явдал болно. Энэ «кэтүркэй-э» гэсэн үг бол хэт (алс) холын буюу ирээдүйн юмыг мэддэг их зөнт (гоц ухаант) буюу эртний монгол хэлний «нэнг-түү» гэдэгтэй ойролцоо утгатай үг юм.
Хэтэрхий гэдгийг орчин цагт сайн муу аль ч зүйлд бусдаас дэндүү «дэнгдэгүү-хэтүркэй» (12, 671б) нэнг илүү гэсэн утгаар хэрэглэдэг юм. Иймээс энэ үгийг «нэнг-түү» буюу хэтү алсын (хойшид болох) юмыг угтан (зөгнөн) мэдэх чадалт гэсэн үг гэж ойлговол зохих болов уу гэж бодож байна. Нэнг-түү гэсэн үгийг «нэндү» гэж хятад үсгээр тэмдэглэсэн нь уг эхийг шууд бичгээс нь биш, харин уул бичгийг дуудаж өгсөн хүний аман аялгаас тэмдэглэсний гэрч мэт бидэнд санагдахаас гадна бичгийн их инхлэг «нг» нь хэлний үзүүрээр бүтэх д, ж гийгүүлэгчийн өмнө хэлний үзүүрийн «н» болон ижилсэн хувирах жамаар өөр болсон гэж бодох үндэстэй юм. Эсвэл «нг» инхлэгийн н нь хаягдан г нь үлдэх ёс ч бас байна. (Дүнгнэх-дүгнэх, зөнгнэкү-зөгнөх г.м.)

610. [-Тэр] Тэйин хагачажу (Тийн хагачажу) гэсэн энэ үгийг бид «тэр хагачажу» гэсэн хятад үсгийн галиг эхийн алдаа гэж үзэж Тэр гэдэг үгийн ороид «Тэйин» гэсэн үг байсан гэж бодож байгаа юм. Ингэж бодох үндэс нь нэгд Монголын нууц товчоонд «тэр» гэдэг үгийг ямагт нэр үгтэй холбож нэр үгийн өмнө бичдэг, нөгөө «тэйин» гэсэн үгийг ямагт үйл үгтэй холбож үйл үгийн өмнө бичсэн байдаг найруулга зүйн онцлогт оршино.
Хоёрт, «Тэр хагацаж» гэсэн хоёр үг утгын талаар авцалдахгүй байгааг бодолцов. Эсвэл «Тэр» «хагацаж» гэсэн хоёр үгийн хоорондоос «дайинача» гэсэн үг орхигдсон байж бас болох юм.

611. унжилдужу (унжилдаж) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 125), Пеллио (9, 81), Лигети (33, 150), Рахевильз (25, 119), Баяр (11, II, 979), Элдэндэй Ардажав (8, 698), Дашцэдэн (26, 153), Иринчин (28, 198) нар цөм «онгжалдажу» гэж сэргээн босгодог энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш (36, 125) [ухрах зама] «огтлогдож, таслагдаж» гэж тайлсан юм. Тэгээд энэ үгийг Хэниш «чухам ихэмсэг улсуудыг дуусгасан» (15, 96) гэж, Поуха «хядан устгаж» (17, 152), Калужинский (61, 208), Кливз (42, 148), Рахевильз (49, № 21, 1980, 31) нар цөм их (чухал) улс буюу улс амьтан хядагдаж, мөхөөгдөж, доройтож гэх мэтээр орчуулсан мэт санагдана. Энэ үгийг бас Дугаржав (24, 184), Мансан (27, 254) нар гол улс **аймаг «сөнөөгдөж»** гэж, Дамдинсүрэн «салгаж дарсан»-

(7, 203) гэж орчуулжээ. Элдэндэй Ардажав нар ч «тасрагдаж сөнөөгдөж» (8, 700, тайлбар № 8) гэж тайлбарлажээ. Ганц Иринчин энэ үгийн галигт эргэлзсэн бололтой Лувсанданзаны Алтан товчид «нөхүчэлдүжу»(31, 90) гэж заагаад «өнжилдэжү» гэсэн үг биш байгаа гэж асуулт тавьжээ.

Лувсанданзан уг үгийг «нөхүчилдүжү» гэж Иринчинийхээс арай өөрөөр ч-гийн дараа э-тэй биш, и-тэй бичсэн нь маш сонирхолтой юм. Бидний бодвол энэ үг «онгжалдажу» гэсэн үг байгаагүй харин «унжилдужу» гэсэн үг байсан бөгөөд галиглагчид үүнийг хятад үсгээр алдаатай галигласан учраас хожим хадмал хятад орчуулгыг хийгчид «онглажаху» гэдэг үгтэй хутгаж огтлох хадах устгах гэсэн үг гэж орчуулсан гэж бодогдоно.

Учир нь нэгд монгол хэлэнд их инхлэг (нг) авиа г, х гэх мэтийн өмнө голцуу тохиолдоно. Харин ж мэтийн хэлний үзүүрийн гийгүүлэгчдийн өмнө бараг байрладаггүй учир «онгжалдаху» гэж баймгүй. Иймээс «унжилдужу» гэсэн галиглал зөв мэт. Учир нь энэ үгийг буруу ойлгож «үкүчилдүжү» гэж ташаа бичсэн Лувсанданзаны алдаатай бичлэг ж-гийн дараа а биш и байсныг гэрчилэх мэт байна. Бас дараа нь лдэ биш лдү- байсныг ч харуулж байна.

Иймээс бид уг эхэд худам монгол бичгийн эхэд нь «унгжилдужу» гэж алдаатай бичигдсэн үг байжээ гэж таамаглан зөв нь «унжилдун» гэж ийнхүү сийрүүлэв. Энэ үгийн утга нь «унах доройтох урвайх» гэсэн утгатай гэж бодно. Учир нь энд «эркид (эркин олон) улс (кэрээд) унаж доройтож (мөхөж) гэсэн утгатай үг бичигдсэн гэж бодно. Энэ үг «сэтгэлээр унах, унжийх, уйлж унжих (уйлж царай алдах) урвайх» гэх мэт олон үгтэй утга ба үүсэл гарлын холбоотой төрөл үг нь мөн гэж бодож байна.

612. Борухула-д-а (Борхулд) — гэсэн энэ үгийг Нууц товчооны хятад үсгийн галигаар тэмдэглэсэн эхэд «Борухул-а» гэж байгаа нь эл бичлэгийн хувьд зөв боловч бид энэ Бору-хула-д-а гэж худам монгол бичигт байсан гэж **төсөөлөн** бодож ийнхүү сэргээв. Учир нь монгол ардын аман зохиолд олонтоо гардаг үлгэр домгийн Хара-хула, Борухула, Сира-хула гэх мэт амьтадын нэр өнгө зүсээрээ (хула зүсмийн) нэрлэгдсэн тул худам монгол бичгийн эхэд «Бору-хула-д-а» гэж байсан боловч энэ «хула» гэдэг үгийн эцсийн «а» авиа нь балархайшин дуулдахаа больсон XIV зууны ярианы дуудлагаар Борухул гэж хазгай дуудлагаар бичигдсэн байх гэж итгэж байна.

613. сайи эригүлсэн (сайныг эрэгч буюу мөргөлчин бадарч лам) гэсэн энэ үгийг Хэниш (36, 133), Пеллио (9, 84), Лигети (33, 156), Рахевильз (25, 123), Баяр (11, II, 1022), Дашцэдэн (26, 157), Элдэндэй Ардажав (8, 716), Иринчин (28, 204) нар «сайи эригүлсүн» гэж ижлээр сэргээсэн тулд үүний зөв бурууд эргэлзэх газаргүй.

Харин энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «сайныг (хувцас хоол) гуйх» (36, 133) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 100), Поуха (17, 161), Калужинский (61, 139) нар «би гуйлгачин буюу» гэж, Кливз (42, 156) «Сайныг эрэгч би» гэж тус тус орчуулсан шиг байна. Энэ үгийг Дамдинсүрэн «идэх юм гуйя» (7, 213), Дугаржав «өглөг гуйж байна гэжээ» (24, 193) гэж, Мансан (27, 277, тайлбар № 10), Элдэндэй Ардажав (8, 718, тайлбар № 7), Иринчин (28, 205, тайлбар № 1) цөм «өглөг, дусал гуйгч бадарчин» гэж тайлбарласны Мансан санваартан лам бололтой гэдгийг онцлон тэмдэглэсэн нь уг утгыг зөв тайлбарласан байна.

Бидний бодлоор бол «сайи (сайныг) эригүлсэн» гэгч сайныг эрэгч буяны эрэлчин ариун сахилтай бадарчин гэсэн үг бөгөөд XIII зууны үед бурханы шашин Монголд дэлгэрсэн байсны нэг баримт мөн. Буддийн шашны гүн ухааны XIV зууны эхэн үеийн орчуулга «сайи-бар одугсан ном-ун биет көбэгүд-лүгэ нэгэн-э

Хамуг сөгүткүн-э бэр күндүлэн сөгүтчү
Бодисаду-а нар-ун санвар тур оруху-йи

Жарлик-ун йосугар кү үгүлэсүгэй» (40, 3) гэсэн өгүүлбэрээр эхэлж байгаагийн доторх «сайибар одугсан» гэсэн үг «сайн (буюу буяны) замаар одсон» гэсэн үг мөн бөгөөд энэ нь «сайи эригүлсүн» гэдэг санваартан, буяны эрэлчин гэсэн үг мөнийг давхар батлан гэрчилсэн шиг бидэнд санагдана.

614. дарбийан урий-а-[д]-ача (дарвиан урианаас) — гэсэн энэ үгийг Хэниш (36, 32), Пеллио (9, 84), Лигети (33, 158), Рахевильз (25, 124) нар «дараба'ан» гэж, Баяр (11, II, 1031), Дашцэдэн (26, 159) нар «дарба ан» гэж, Баяр (11, II, 1031), Элдэндэй Ардажав (8, 717), Иринчин (28, 205) нар «дарбаган урий-а дача» гэж тус тус сэргээсэн бөгөөд энэ бол хятад үсгийн галигийг л дагасан хэрэг юм.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үг Хэнишийн тайлснаар (9, 32), «дохио зангаа» гэсэн утгатай ажээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 101), Поуха (17, 162), Калужинский (61, 140), Кливз (42, 157) нар цөм «дохио зангаа ба дуудлагаас» гэж, Дамдинсүрэн «уриалах дуунд

уухай болж» (7, 214), Дугаржав «уриалах дуунаас хожимдсонгүй» (24, 194) Мансан «даллах урианд» (27, 278), Элдэндэй Ардажав (8, 722, тайлбар № 22, 23) энэ үгийг «дарбийан» гэсэн үгтэй холбож тайлбарлахын хамт дарбах гэдэг нь хийсэх намилзах гэх мэт үгээр тайлбарласан байна.

Бидний бодлоор түүний 1 тайлбар хамгийн зөв оновчтой болсон тул бид тэр саналын ёсоор энэ үг худам монгол бичгийн эхэд «дарбаган» гэж байгаагүй харин «дарбийан» гэж бичигдсэн гэж төсөөлөн ингэж сийрүүлэв. Ингэж бодох үндэс нь хуучин монгол бичгээр энэ үгийг «дарбийан» гэж бичдэгт оршино. Учир нь «дарбийандур гүйүү-олан-у күкийэл-дур гүйүкү» (12, 650) монгол бичгийн толь бичигт тодорхойлсон нь миний бодлоор дарба'ан гэдэг үгийн утгыг яг нарийн илтгэсэн гэж бодмоор байна. Хуучин монгол бичгийн бичлэг бол олон талаараа Нууц товчооны хятад үсгийн галигийнхаас илүү эртний худам монгол бичгийн бичлэгийн уламжлалыг тусгасан байдаг тул энэ «дарбийан» гэсэн бичлэгээр Нууц товчооны худам монгол бичгийн эхэд бичигдсэн гэж итгэж байна. Жишээлбэл хуучин бичгээр өдөр гэдэг үгийг «эдүр» гэж бичдэг бол Нууц товчооны хятад галигт «үдүр» гэж бичдэг нь авианы хувирлын хамгийн сүүлчийн шатны бичлэг мөн болно.

615. абуг-а (ауга [их])-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 10), Пеллио (9, 87), Лигети (33, 162), Рахевильз (25, 128), Баяр (11, II, 1060), Дашцэдэн (26, 163), Элдэндэй Ардажав (8, 736) Иринчин (28, 211) цөм «ауха ~ ауг-а» гэж сэргээгээд энэ үгийн хадмал хятад орчуулгын үгийн утгыг Хэниш «эрх хүчин» (36, 10) гэж тайлсны дагуу бүгд зөв ойлгож орчуулсан байдаг. Иймд энэ үгийн галиг ба түүний утгын талаар бид судлагчидтай бүрэн санал нэгтэй байна.

Харин хуучин сонгодог монгол бичигт бичигддэг тэр бичлэгийн хэлбэрээрээ энд «МНТ»-ы хятад үсгийн галигт тэмдэглэгдсэн гэдгийг тэмдэглэхийн ялдамд монгол хэлэнд урт эгшиг ерөөс үүсч гараагүй эрт үед монголчуудын худам монгол бичигт энэ үгийг яаж тэмдэглэдэг байсан бол гэж бодвол хоёр эгшгийг дараалан оруулж «ауг-а» гэж бичиж байгаагүй нь мэдээж хэрэг бодно. Иймд бид «МНТ»-ы худам монгол бичгийн эхэд энэ үгийг «абуг-а» гэж бичиж байснаар төсөөлөн бодож ийнхүү «абуг-а» гэж сийрүүлэв. Үүнд энэ үг нь ауга их гэсэн утгатай байсан тул «абуг-а» гэдэг энэ үг «абургу» их гэсэн үгтэй нэг язгууртай төрөл үг байснаар бодож ингэж бичсэн болно. Энэ үгийг орон зайн холбогдолтой «агуу» (агужим талбиху) (12, 12) гэсэн үгнээс гарсан гэж бодвол «агуг-а» гэж бичиж байсан байж болох боловч энэ нь «хэмжээ хязгаргүй их хүч» гэсэн утгатай нь төдий л нийцэхгүй тул эртний монгол хүний домог-үлгэрийн зүйлд олонтоо агуугийн тухай биш хүч чадлын тухайг тусгасан олон «абургусун»-ы үлгэр домог зохиогдсон байдгийг харгалзан «абургу» гэсэн үгийн абу гэсэн үндэснээс га (үг бүтээх) дагаврын аргаар бүтсэн үг тул ингэж бичигддэг байсан гэж таамаглав. Үгийн дунд орсон «б» авиа хожим бүдгэрч хөндий в буюу у-тай адил сонстох болсон тул «ауга» гэж хэлэгдэх болж улмаар ингэж хуучин (сонгодог) бичгийн хэлэнд XIV зууны дуудлагаараа орсон гэж бодном.

616. сил[и]сайид (шил сайтан) — гэсэн энэ үгийг хятад үсгийн тэмдэгтийн галигаас нь Хэниш (36, 140), Пеллио (9, 87), Лигети (33, 162), Рахевильз (25, 128), Лувсанданзан (31, I, 150) Баяр (11, II, 1062), Дашцэдэн (26, 163), Элдэндэй Ардажав (8, 736), Иринчин (28, 211) нар цөм «шил сайид» гэж сэргээснээс үзвэл хятад галиг алдаатай тэмдэглэсэн нь мэдэгдэнэ.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэнишийн тайлснаар (36, 140) «гадаад үзэмж, үзэсгэлэн сайтай» гэсэн утгатай ажээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 104), Поуха (17, 166), Калужинский (61, 143) нар «үзэсгэлэн ба эрдмээрээ сайн» гэж, Кливз «сайн хүмүүсийн ангиас моринд сайн эр хүн» (42, 163) гэж тус тус ойлгосон бололтой. Энэ үгийг Баяр (11, II, 1062) «шил (хүзүү) сайт» гэж, Дамдинсүрэн (7, 218), Дугаржав (24, 198), Мансан (26, 283) нар «эрдэм билэг, эрдэм чадал, бие бялдар сайтай» гэж хамгийн зөв ойлгож оновчтой орчуулсан байна. Элдэндэй Ардажав нар энэ үгийг «хурц сайн, цог жавхлан, дүрс байдал гуа сайхан, цэцэн сэргэлэн, хурц шаламгай» (8, 738, тайлбар № 5) гэсэн хэтэрхий олон утгаар арай бүрхэгдүү тайлбарласан байна.

Бидний бодлоор бол «шил» гэдэг үгийг «шили» гэж Баяр гуайн ойлгож бичсэнээр сэргээвэл зохих бөгөөд үүний утга нь үзэсгэлэн гэсэн үг биш «бие бялдар сайтай» гэдэг нь илүү оновчтой гэж бодно. Учир нь монголчууд эр хүний сайхныг шили хүзүү бүдүүн бөгөөд «шили» (хүзүүний шөрмөс) нь гувгарыг эр хүний бие бялдар сайтайн шинж гэж, нөгөө бүсгүйчүүд охидын үзэсгэлэн үс зүс нүд шүд сайтайд нь

үзэсгэлэн гуагийн шинж байдаг гэж үздэг байжээ. Баримт нь нэг га**лын тахилгын сударт:**

«Шили сайиту көбэгүнтэй болгаху чи
Шибэргил (үс гэээг) сайиту бэритэй болгаху чи
Шилугун (гоо голшиг цэвэрхэн царайтай) өхинтэй
болгаху чи!» (99, 113) гэж гарч **байгаа явдал болно. Иймд «сили сайид»** гэж энэ үгийг бичсэн байсан нь эргэлзээгүй мэт санагдана. «Сили» худам болон хуучин монгол бичгээр бичдэг үг нь чухамдаа хүзүүг **хэлсэн** биш, харин хүзүүний арын хоёр салаа шөрмөсийг хэлдэг үг болно Үүнийг:

«Голсон юм (хоол)
Голд орох
Шилсэн юм (мах)
Шил (сили) хазуулна» [Үүний арай өөр хувилбарыг хар (108, 42)] гэсэн энэ цэцэн үгэнд сайн мах гээд шилж авсан юм хонины хүзүүний огт зажилж идэж болохгүй бөгөөд амт ба шимгүй шөрмөс байна гэсэн утгатай юм. Гэтэл их эршүүд зоримог бөгөөд эрүү шүүлтийг дажгүй давж чадах хатуужил ихтэй хүнийг «Шилтэй (силитэй) эр» гэж бие бялдар, хатуужил тэвчээртэй хүн гэж бахархан хэ**лэлцдэг зэрэг нь энэ шил (сили) гэгч** эр хүний бие бялдар сайтайн шинж гэж үздэг ардын үзлийн гэрч болно.

Харин энэ үгийг «МНТ»-ы хятад үсгийн галигт «шил» гэж бичсэн нь XIV зууны монгол хүний үг ярианы аялга бичгээсээ их зөрж, харин орчин цагийн аялгуу дуудлагатай ижил болсныг харуулж байна.

617. ончидутхун (журамлагтун) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 77), Пеллио (9, 89), Лигети (33, 166), Рахевильз (25, 131), Дашцэдэн (26, 167) нар «hончитутхун» (Хэниш), «hончидутхун» (Пеллио, Лигети, Рахевильз), «hончидудхун» (Дашцэдэн), гэж, Баяр (11, II, 1086), Элдэндэй Ардажав (8, 743), Иринчин (28, 216) нар «ончидутхун» гэж тус тус сэргээжээ.

Энэ үгийн утгыг Лувсанданзан «бүү жасагдахун» (31, I, 154) гэж, мөн үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «буруутгах», «шийтгэх», «донгодон торгох» (36, 77) гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 107) «загнах омогдох» гэж, Поуха «зодох» (17, 169), Калужинский (61, 145) «цээрлүүлэх», Кливз «зэмлэн донгодох» (42, 165), Дамдинсүрэн «бүү шийтгэ» (7, 220), Дугаржав «зэмлэж шийтгэж» (24, 201), Мансан «бүү буруушаан засаглаж шийтгээрэй» (27, 286) гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав «хадмал орчуулгад агуурлах, зэмлэх, буруушаах» (8, 745, тайлбар № 9) гэж тайлбарлажээ.
Энэ үгийг бид Лувсанданзаны Алтан товчид «тайлбарласны дагуу «журамлана», «зэмлэн донгодно» гэсэн үг болов уу гэж бодож байна. Энэ үгийн үндэс нь ончи гэдэг нэр үгэнд үйл үг бүтээх -д- дагавар залгаж түүн дээр үйл үгийн захирах хүсэх төлөвийн хүндэтгэн захирах хэлбэрийн «гтун» нөхцөлийн эртний хэлбэр болох «тхун» (тгун) гэсэн авиа солигдлын хувилбар нөхцөл залгаж бүтээсэн үг гэж таамаглаж байна. Энэ «ончи» гэдэг үгийн утгыг Шагж «ончи-хэрэхүн ночитай гажар жэргэ-йин» (12, 108) гэж, нөгөө «ночитай» гэдэг үгийг «ночитай-үгэн-ү жокистай хэрэк-үн холбугдалтай мэтү-йин» (12, 222а) гэж тайлбарласнаас үзвэл «хэргийг хүндрүүлэн жалхаху» залхаахыг хориглосон үг байж болох юм. Гэвч «ончидутхун» гэсэн үг чухам ямар үг байгаад мартагдсаныг баттай мэдэхгүй байна.

618. дагулжу (даалгаж) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 33), Пеллио (9, 89), Лигети (33, 167), Рахевильз (25, 132), Баяр (11, II, 1092) нар «та'улжу» гэж, Козин (14, 289), Дашцэдэн(26, 167) нар «таулжу» гэж, нөгөө Баяр, Элдэндэй Ардажав (8, 747) нар «тагулжу [~дагулжу(?)]» гэж Иринчин (28, 217) тахулжу [~дахулжу (?)]» гэж тус тус сэргээсэн байдаг.

Энэ үгэнд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш «гаргах өгөх, тараан өгөх, дамжуулан өгөх» гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 108), Калужинский (61, 146) нар «өгч» гэж, Поуха «буцаан өгч» (17, 169) гэж, Дамдинсүрэн (7, 220) Дугаржав (24, 202) Мансан (27, 287) нар «тушаан өгч» гэж тус тус орчуулсан байна. Жич энэ үгийг Элдэндэй Ардажав нар «тахул, захирах сануулах «татар» «Мухаддимат» зүзад та'улба түндү гэмээх нь түүнд даалгав, даалгах тушаах», «хэвтүүлд тушааж одун явтугай» (8, 748, тайлбар № 2) гэжээ.

Бидний бодлоор бол энэ нь «тагулж» гэсэн үг биш, харин «дагулжу» гэж сэргээвэл зохих үг **бөгөөд** энэ үг нь орчин цагийн монгол хэлний даалгах гэдэг үгийн эртний монгол бичгийн бичлэг мөн. Ингэж бодох үндэс нь нэгд энэ үгийг худам монгол бичгийн эхтэй байсан гэгдэх Лувсанданзан «дагалгажу» (31, I, 156) гэж энэ үгийн хожмын үеийн бичлэгийн тохирох хэлбэрээр сольж бичсэн явдал болно. Хоёрт, дээр

Элдэндэй Ардажав нарын заасан Мухаддимат толь бичигт энэ үгийг Нууц товчооны галиг эхийнхтэй адилаар «та'улба» гэж бичээд дагалгаба гэсэн нь энэ «та'улба» гэж XIV үеийн дуудлагаар тэмдэглэгдсэн «дагулж» гэсэн үг хуучин монгол бичигт «дагалгаба» гэж бичигдэг үгийн өөр хувилбар мөн гэдгийг харуулав.

Гуравт, энэ үгийг бид да- (даах, хариуцах гэсэн утгатай үйл үгийн язгуур, 1 үндэс)+гул (үйл үгийн үйлдүүлэх хэвийн үндэс бүтээх нөхцөл)+жу (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж үзэж байгаа бөгөөд худам монгол бичигт «да-» гэж бичигддэг байсан үндэс нь хожим уртаар «дага» гэж хэлэгдэх бичигдэх болсны улмаас түүнд үйлдүүлэх хэвийн «-гул» нөхцөл биш, харин «-лга» нөхцөл залгаж хэрэглэдэг болсон бололтой юм. Иймээс энэ үгийн эртний бичлэг «дагулжу» гэдэг хэлбэр нь мартагдаж түүний оронд «дагалгажу» гэдэг бичлэгийн шинэ хэлбэртэй үг нь хэрэглэгдэх болжээ. Иймээс энэ «дагулжу» гэдэг үг нь «дагалгажу» гэсэн утгатай болох нь ил байна.

Иймд энэ үгийг бид «таулжу буюу тагулжу» биш «дагулжу» гэж сэргээх нь зөв гэж шийдсэн болно.

619. хагули (хууль) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид цөм «хаули» гэж сэргээн босгоод «хууль» гэсэн үг гэж ойлгож орчуулсан буюу тайлбарласан юм.

Гэвч бид энэ үгийг худам монгол бичгээр «Нууц товчооны» хятад галиг ба хуучин (сонгодог) монгол бичгээр «хаули» гэж бичдэгээс өөрөөр «хагули» гэж бичиж байснаар төсөөлөн бодож ийнхүү сийрүүлсэн болно. Үүний учир нь нэгд гэвэл худам монгол бичгийг монгол хэлэнд урт хос эгшиг үүсээгүй байхад монголчууд авч хэрэглэсэн тул хоёр эгшиг дараалан орсон бичлэгтэй үг худам монгол бичигт байгаагүй гэсэн бодолд үндэслэв.

Хоёрт гэвэл «хагули» гэдэг хугу- (хагу) (цохь) гэсэн үйл үгийн үндэс)+ли (үйл үгээс нэр үг бүтээх дагавар) гэсэн бүтэцтэй үг болов уу гэж төсөөлөн бодсон юм. Энэ утгаар «хагули» буюу «хаули» гэдэг бол аливааг хаʻалан шийдэж өгөх журам ёс гэсэн утгатай байж магадгүй гэж таамаглав.

620. гэтэгэлжэн йабуху (гэтэлхийлж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид цөм «хэтүгэлжэн» гэж сэргээгээд Хэнишийн тайлснаар (36, 100) «хөндлөн өнгөрөн явах» гэсэн хадмал хятад орчуулгыг баримтлан олон судлагч орчуулсан байхаас гадна Элдэндэй Ардажав нар ч үгийн язгуур кэтү-манж хэлэнд «хөндэлэн» (хөндлөн) гэсэн утгатай гэсний дээр орчин цагийн (ямар хэлэнд?) хэлэнд давж гарах, хөндлөн өнгөрөх, хэтэрч өнгөрөх гэсэн утгатай. Энд хөндөлсөх, хөндлөн өнгөрөх, хөндлөн гарахыг заав» (8, 749, тайлбар № 6) гэжээ.

Бидний бодоход энэ үг «хэтүгэлжэн» гэсэн үг биш, харин «гэтэгэлжэн айбуху» гэсэн үг мөн шиг санагдах учир бид ингэж сийрүүлэв. Үүнд нэгд гэвэл уул эхэд ордны хойгуур урдуур явах хүний хаагуур явах чигийг заасан тул түүнтэй давхардуулан «хөндлөн гарах» гэсэн чиг заамгүй санагдана.

Хоёрт, урасч байгаа гол мөрнийг буюу эсвэл нүүж яваа айл нь замыг хөндлөн гарсан гэж ярьж болох боловч, харин нэгэн газар байрлаж байгаа ордыг хөндлөн гарах гэж ярьсан гэхэд эргэлзмээр.

Гуравт, гэвэл энэ үгэнд «-гэлжэн» гэсэн үйл үгийн байдлын нөхцөл залгасан байгаа нь энэ үг уг хүний явах чигийг биш, харин хэрхэн явах байдлыг заасан болохыг давхар гэрчлэх мэт байна. Чухам тийм учраас ч судлаач Дугаржав «гэтэлхилжү» (24, 202) гэж, Мансан «гэтэжү явах» (27, 287) гэж хэрхэн явах байдлыг гаргаж орчуулсан нь зөв оновчтой болсон гэж бодмоор байна. Иймээс хятад үсгийн «кэтүлгэлжэн» гэсэн нь ташаарал гэж бодоод бид «гэтэгэлжэн» гэж сэргээв. Энэ үгийг хятад үсгийн галигт «кэтүгэлжэн» гэж тэмдэглэсэн учраас ч хожим хадмал хятад орчуулга хийгч «гэтэх» гэдэг үйл үгийг «кэтүлэх (гэтлэх)» гэдэг үгтэй хутгаж «хөндлөн гарах» гэж ташаа орчуулсан мэт бодогдоно.

621. өрөк (төвшин аюулгүй) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 128), Пеллио (9, 91), Лигети (33, 269), Рахевильз (25, 133), Баяр (11, III, 1102), Дашцэдэн (26, 169) Элдэндэй Ардажав (8, 750), Иринчин (28, 218) нар цөм «өрүк» гэж ав адилаар сэргээн босгов.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг «нам тайван» (36, 128) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 109), Поуха (17, 173), Кливз (42, 268), Рахевильз (49, № 26, 1982, 39) нар «амар тайван», «амгалан тайван унтуулж» гэж, Калужинский (61, 149) «амгалан» гэж, Дамдинсүрэн «энх» (7, 225), Дугаржав (24, 204),

Мансан (27, 299) нар «энх амар» гэж тус тус орчуулсан нь хадмал хятад орчуулгыг дагажээ.

Энэ үгийг Элдэндэй Ардажав нар түрэг хэлний «өрүг ~ өрүк» гэмээх нь сайхан зантай, элэгсэг, элсэг, уужуу тавиу, даруу, хөнгөмсөг томоотой» (8, 752) гэж тайлбарласан үзэгдэнэ.

Бидний санахад энэ үг монгол хэлэнд үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс гарахаас өмнө авсан худам монгол бичигт «өрэк» гэж бичигдэг байсан байх гэж бодох үндэстэй боловч XIII, XIV үед энэ үгийн эгшгүүд уруулаар зохицох ёс гарснаас хойших үеийн хэл аялгууны байдлаар «өрүк» гэж бичсэн баримт Алтан ордны үйсний бичигт «өрүк нунтаг-тур-йиэн эгэсү» (34, 106) байх тул бид «өрэк» гэж худам монгол бичигийг дагаж бичив.

Харин энэ үгийн утгыг «амар амгалан, нам тайван» гэх ойролцоо утгатай хоёр үгээс бүтсэн хоршоо үг биш «өрэг» (төвшин аюулгүй), «нута» (сэрэхгүй бат бөх) гэсэн өөр утгатай хоёр үгээр бүтсэн хоршоо үг гэж ойлгож байна.

Учир нь нэгд хуучин монгол бичигт «өрү» гэж «айулхай-йин доорки гажар мэтү-йин» (12, 164а) хүн болон амьтны гол төлөв цэгийн орших газрыг нэрлэх нэр учраас үгийн энэ үндсэнд г (нэр үгээс нэр үг бүтээх) дагавраас бүтсэн үг бөгөөд «гол төвшин» гэсэн үг байж болох юм. Түүнч Лувсанданзан түүнд агсан «МНТ»-ы уг эхэд «өрүг» гэж бичсэнийг ойлгохгүйд хүрээд «орун дотор-а эсэ окжатхагсан» гэдэг өгүүлбэрийн адилаар «орон дур нута унтагулж» (31, I, 157) гэж бичсэн болов уу гэж санамаар.

Нөгөө талаар «МНТ»-ы §255-д «Өгэдэй элэ өрүг буй» гэсэн өгүүлбэрт байгаа «өрүг» гэдэг үг мөн «голч төлөв төвшин» гэсэн утгатай үг байгаа нь бидний бодлын зөвийг гэрчилж байна.

Бидний бодоход энэ нь хума (тоос) $^{+}$г -«умаг-сирой хумаг-ун» (12, 402б) чому (бичихан чомбугур айаг-а) $^{+}$г -«чо-муг-эбүсү-йи урту (цомбогор?) чогчалагсан ану» (12, 780а) гэх мэт үгийн загвараар өрү (гол, төв) -өрүк (төвшин, голч, дундыг баримтлагч) үүсмэл үг гэж бодож байна.

622. силтэстэй [хэлтэстэй] гэр (хэлтэстэй гэр) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 140), Пеллио, (9, 91), Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Иринчин тэргүүтэн цөм «шилтэсүтэй» гэж сэргээдэг бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш (36, 140) «сүлжмэл ханатай гэр» гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 109), Поуха (17, 173) нар «сүлжмэл гэр» гэж Дамдинсүрэн «ханат гэр» (7, 226), Кливз (42, 168), Рахевильз (49, № 26, 1982, 40) «торон (нүдэт) гэр» гэж, Дугаржав «хэлхээтэй гэр» (24, 205), Мансан «удмэл ханатай гэр» (27, 300) гэж ойролцоо боловч ялгаатай үгсээр орчуулсан байдаг.

Элдэндэй Ардажав нар энэ үгийг «сүлдэсү, илтэсү» (ялтас) гэх зэрэг үгтэй холбож «төмөр хавтагай хавчуулан оруулсан гэрийн туурга» (8, 754—755) гэж тайлбарласан ажээ.

Бид энэ үгийг кэлтэстэй буюу хэдэн хэсгээс бүрдсэн хана (эсвэл дээвэр) бүхий гэр гэсэн утгатай үг гэж төсөөлөн бодож сийрүүлэв. Учир нь бидний бодлоор цэцгийн хэлтэс, илтгэсэн хуйаг, шилтэс гэх мэт нь цөм эртний худам монгол бичигт килтэс ~ хэлтэс гэж хоёр янзаар бичигддэг нэг л үгнээс үүссэн шиг санагдана. Үүнд цэцгийн хэлтэс гэдэг нь цэцгийн тоорцог дэлбэрэхэд цэцгийн дэлбээг бүрхэж байсан ногоон бүрхүүл нь хэдэн хэсэг болж задардаг бөгөөд тэрхүү хэдэн хэсэг болсон бүрхүүлийн нэг хэсгийг «хэлтэс» гэж, монгол гэр тэр цэцгийн хэлтэс мэт дөрөв буюу таван хэсэг ханыг хооронд ам нийлүүлж оосор дээсээр боож гэрийн дугуй туурга ханыг босгодог байсан учир ханын тэр салдаг хэсэг бүрийг нэг хэлтэс буюу хилтэс («хи» нь XIV зууны галиглагчдад си буюу ши авиагаар хэлэгддэг болсон «силтас-у» гэж ташаа тэмдэглэгдсэн байх гэж бид таамаглаж байна.

Хилтэс нь силтэс болж улмаар илтэс болж хувираад олон хэсэг төмөр хэлхэж бүтээсэн хуягийг «илтэсэн хуяг» гэж шинэ үг үүссэн байх гэж төсөөлж байна. Нэгэнт цэцгийн хэлтэс гэдэг үг хуучин монгол бичигт «хэлтэсүн» гэж бичигддэггүй харин «хэлтэс» гэж бичигддэгээс ургуулан бодвол энэ нь үйл үгийн язгуураас «-тэсүн» дагавраар үүссэн үг биш, харин хэсэг хэлтэрхий гэх зэрэг үгтэй төрөл хэлтэ гэсэн үгийн олон тооны нөхцөл «хэлтэс» гэсэн үг гэвэл гэр ба хуягийн ямагт олон хэсэгтэй юмыг нэрлэдэг учраас ямагт «хэлтэс» гэдэг олон тооны хэлбэрээрээ уг юмыг тэмдэглэдэг нэр болсон гэж бодож «силтэстэй [хэлтэстэй] гэр» гэсэн үг гэж ийнхүү сэргээсэн болно.

623. Ибалан (явганан) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 80), Пеллио (9, 91), Лигети (33, 169), Рахевильз (25, 133), Дашцэдэн (26, 169), нар «ибулун» гэж, Баяр (11, III, 1108),

Лувсанданзан (31, I, 157), Элдэндэй Ардажав (8, 751), Иринчин (28, 218) нар «ибүлүн» гэж, Баяр «ибилүн» (11, III, 1108) гэж тус тус сэргээсэн байна.

Энэ үгийг хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш (36, 80), Поуха (17, 174) нар «дайсны битүү тоосон дунд» гэж, Кливз (42, 168), Рахевильз (49, № 26, 1982, 40) нар «үймэлдэн бүхүй дайсны дунд» гэж, Козин «Хорон санаат дайсны дунд» (14, 272) гэж, Мостарт «үймээн гаргагч дайсны дунд» (47, 391 [141]) гэж, Дамдинсүрэн «өрсөх дайсны мөрөөс өших хортны гараас» (7, 226), Дугаржав «ивж байх дайсны дунд» (24, 205), Мансан (27, 315), Элдэндэй Ардажав (8, 753), Баяр (11, III, 1108) нар «үнээ ивлэх, булаг мэт ундран, ивлэх булаг мэт дайсны хойноос орж ирэх (довтлох)» гэх мэтээр тайлбарлажээ.

Бидний бодвол энэ үгийг үнээ «ивлэх» -сүү дэлэнд буух» гэснээс өөр «ибаганаху -олон бяцханы хөдэлкү» (12, 90б) гэдэг үгтэй холбож «явганан хөдлөх асар олон дайсны дунд» гэсэн үг болов уу гэж тааманглан «ибалан» гэсэн үг ийнхүү сэргээн сийрүүлэв. Энэ үгийн бүтэц гэвэл бидний бодлоор и- (үгийн язгуур) +ба (ижа-гэдгийн адил и язгуураас үүссэн үйл үгийн үндэс) +ла (үйлийн давтагдах байдлын үндэс бүтээх нөхцөл) +н (нөхцөл үйл үгийн хам хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг гэж бодож байна. Энэ үгийг XIV зууны үед «ибалан» гэхийг «ибүлүн» гэж эм үгийн дуудлагаар хэлдэг нутгийн аялгууны дагуу ташаа тэмдэглэсэн байх гэж санагдмаар байна. Энэ үгийн эм үгийн дуудлагатай хэлбэрээс нь ойролцоо утгатай «ирэлзэх яралзах» гэх мэт үг үүссэнийг бас тэмдэглүүштэй. Энэ үг «бичихан» гэдэг үгийн язгуураас -ча дагавраар дайвар үг (бича) үүсч түүнд -ла дагавар залгаж үйл үг (бичала) бүтээсэний «би+ча+ла +н» гэдэг үгийн загвараар бүтсэн «и+ба+ла+н» гэдэг үг гэж бодож байна.

624. [г]үйилсүн хор [г]үбэс кикү-дүр (хуймсан сум хувис хийхэд) гэсэн энэ өгүүлбэрийн дотроос «үйилсүн» гэсэн үгийг Пеллио (9, 91), Лигети (33, 169), Рахеильз (25, 133), Мостарт (47, 385 [135]), Дашцэдэн (26, 169) нар уйилсун» гэж, Хэниш (36, 168) Баяр (11, III, 1109), Элдэндэй Ардажав (8, 751), Иринчин (28, 218) нар «үйилсүн», гэж тус тус сэргээсэн бөгөөд Лувсанданзан «үйилэс-үн» гэж бичсэн нь үг үгийг «үйс» гэсэн үг биш өөр үг гэж ухаарсныг харуулна. Нөгөө «убис» гэсэн үгийг Хэниш, Пеллио Лигети, Рахевильз, Дашцэдэн тэргүүтэн зарим нь «убис» гэж. нөгөө Баяр, Элдэндэй Ардажав нар «өбүс» «убис» гэж сэргээсэн боловч «өбүс» буюу «обос» гэсэн үг гэж өөрөөр ойлгосон байна.

Энэ «үйилсүн» гэсэн үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш **«Хус модны холтос» (36, 168) гэж, нөгөө «убис»** гэсэн үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг «ялгүй хөдлөх» (36, 157) гэж тус тус тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 109), Поуха (17, 174), Калужинский (61, 149), Кливз (42, 169), Рахевильз (49, № 26 1962, 40) нар цөм «хус модны үйсэн сум хөдлөх төдийд» гэж, Дамдинсүрэн «холтсон хоромсого хорд хийх чимээнээс» (7, 226) гэж, Дугаржав «үйсэн хоромсгыг үбис хийх дуунд» (24, 208), Мансан «хус модон хор хурайлцан хөдөлөхөд» (27, 300) гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав «үйсэн сум, суман онгоц, багвар суулга зэргийн сав буюу нуманы зэргийн зүйл бүрийн зэвсэгт хүчин хэрэглэнэ» гэж үйсээр хучсан сум гэх маягийн тайлбар хийж хорин нэгтийн тайлбар толийг заажээ.

Энэ бүх тайлбараас үзвэл үнэхээр энэ нь хусны үйсээр хийсэн сум «убис» хийж хөдлөх төдийд байраа эзэлдэг гэж туурга цэргээ Чингис хаан магтаж болох мэт. Гэвч бид энэ үйсээр хийсэн сум байж болно гэдэг нь л эргэлзээтэй зүйл юм. Иймд бид галигийн дагуу «үйилсүн хор убис кикүй-дүр» гэж энд сэргээсэн боловч бас нэг өөр санал таамаг байж болмоор санагдана. Энэ үгийн энэ зэрэгцүүлэлт дараах бадагт гарч буй «хутун хор» гэснийг Хэниш, Элдэндэй Ардажав нар «уд» (бургас) модоор сумны мөлс буюу мөс хийж болдог тул энэ бадгийн үйлсүн гэдэг нь бас сумны мөс (мөгсү) хийдэг нэг өөр модны нэр тухайлбал «гүйилэс (жимсний)-үн хор» гэж байсныг XIV зууны монгол хэлний аялгуунд «үйил[э]сүн хор» гэж тэмдэглэсэн юм биш биз гэсэн санаа төрж байна. Энэ санаа нэгд энэ үгийг Лувсанданзан [г]үйилэс-үн» (31, I, 158) гэж энэ үгийг бичсэнээс хоёрт гүйлс гэдэг үгийн хуучин монгол бичигт «гүйилэсү-жимс» (12, 483б) гэж үг байгаа зэрэг шалтгаанаас төрөгдөж байна. Нөгөө талаар үүнтэй холбоотой байгаа «убис» гэдэг үг сумны хөдлөх байдлыг «овос кийкү» **гэж хэлсэн байж таарамгүй. Энэ үг «гүйилэсүн»** гэсэн үгтэйгээ толгой холбогдож «гүбэс кикүй-дур» гэж бичигдсэн байж болмоор бас санагдах бөгөөд хадмал хятад орчуулгын утгад илүү нийцэм юм.

Учир нь энэ үгийн үндэс «гүб кижү-маси томогатай-йин байидал» (12, 482) гэсэн утгатай байгаа нь «гүбэс кикү» гэдэг «яльгүй хөдлөхөд гэсэн утгатай байж болохыг гэрчлэх мэт байна. Иймээс энэ үг үнэндээ:

«Гүйилэсүн хор

Гүбэс кикүй-дүр» гэсэн холбоо шүлэг байсан байж болмоор санагдана. Жич «гүйилэсүн шир-а-өнггэ» (12, 483б) гэсэн өнгө байх тул «гүйилэсүн хор» гэдэг үг бас «гүйлсэн шар сум» гэсэн үг байж ч болох юм.

625. урийалагун (уриалагхан) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 166), Пеллио (9, 91), Лигети (33, 169), Рахевильз (25, 133), Баяр (11, III, 1110), Элдэндэй Ардажав (8, 751), Дашцэдэн (26, 169), Иринчин (24, 218) тэргүүтэн цөм «урийархун» гэж сэргээснээс гадна Лувсанданзаны Алтан товчид (34, I, 158) ч мөн ингэж бичсэн байв.

Энэ үгийн хажууд хадсан хятад орчуулгын үгийн утгыг Хэниш «хөгжөөтэй» (36, 166) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 109), Поуха (17, 174), Калужинский (61, 149), Кливз (42, 169) Рахевильз (49, № 26, 1982, 40) нар цөм «золбоолог, зол жаргал төгс, баяр баясгалант, хөгжөөнт» гэх мэт үгээр орчуулсан бол Дамдинсүрэн «Шигшмэл сайн» (7, 226), Дугаржав (24, 205), Мансан (27, 300), Элдэндэй Ардажав (8, 758, тайлбар № 17) нар «ори сайтай» «ори жавхаа», «тэнхээ төгөлдөр, тэнхээ сайтай, идэрхэн адилтгашгүй, зүйрлэшгүй, зэргээс хэтрэх, хамгийн дээд гэх мэт олон утгатай урийархун гэгч идэрхэг» гэх зэргээр тайлбарлажээ.

Бидний бодоход энэ «урийархун» гэсэн үг бол «орь залуу, орь ганц», «баяр баясгалан ба цог золбоот, золтой» гэх мэт утгатай үг биш харин «уриалагхан» буюу хүний юу хэлснийг сайнаар угтан авч тэр дор нь гүйцэтгэдэг гэсэн утгатай «урийалагун» гэсэн үг болох нь эргэлзээгүй мэт санагдана.

Энэ үг халх монголын үгсийн санд одоо ч бараг энэ хэлбэрээрээ өргөн хэрэглэгддэг юм. Цэвэл гуайн толинд «урийалга» II, уриалаг «урийалагу» (хуучин монгол бичгээр) гэх буюу «урийалган-уриалаг, уриалагхан» [хуучин монгол бичгээр] «урийалган» (53, 598) гэсэн тайлбар бүхий үг бүртгэгдэн орсон байгаагийн дотор одоогийн бидний уриал-гэдгийг хуучин монгол бичгээр «урийалагу» бичсэн нь үзтэл бидний энд авч үзэж буй «урийархун» гэдэг үгийн хожим үеийн буюу эсвэл эртний хувилбар болох нь эргэлзээгүй байна. Угтаа энэ үг «урийархун» гэсэн үг байсан байж болох боловч нэг үгэнд орсон олон «р» авиа уг үгийг дуудаж хэлэхэд бэрхшээл учирдаг тул монгол хэлний өгүүлүүр зүйд нийцүүлэн олон р авианы аль нэгийг нь «л» авиагаар сольдог баримт байдаг. Жишээлбэл «арчуур» гэхийг «алчуур» гэх буюу эсвэл «арчуул» гэж хэлдэг билээ. Иймээс энэ урийархун гэсэн үгийг «урийалагун» гэж бичдэг байсан гэж бодох үндэстэй тул бид энэ үгийг «урийалагун» гэж сэргээгээд хааны зарлиг тушаалыг уриалагхан хүлээж авч шадамгай биелүүлдэг хэвтүүл гэж магтсан утгатай үг гэж бодож байна. Харин хадмал хятад орчуулга нь энэ монгол үгийн утгыг оновчтой гаргаж чадаагүй гэж бодно.

626. бэйэ чах-а-да (бие чага-да) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 15), Пеллио (9, 91), Лигети (33, 169), Рахевильз (25, 133) нар «ча'ада» гэж, Баяр (11, III, 1116), Элдэндэй Ардажав (8, 759), Иринчин (28, 219) нар «чахада» гэж тус тус сэргээн босгосон байв.

Энэ үгэнд хийсэн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «бие үйлчлэгч» (36, 15) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 109), Поуха (17, 175), Калужинский (61, 230), Кливз (42, 169), Рахевильз (49, № 26, 1982, 40) нар «бие үйлчлэгч» «бие хамгаалагч» «миний **биеийн** дэргэд байх үйлчлэгч» гэх зэргээр орчуулсан байна. Түүнчлэн Дамдинсүрэн «Миний биеийн шадар өмч» (7, 127), Дугаржав «биеийн дэргэд шалгаж ирүүлсэн» (24, 206) гэж, Мансан «өмч болгож ялгаж өгсөн» (27, 301), Баяр «бие захад» (11, III, 1116) гэж тус тус ойлгож орчуулснаас гадна Элдэндэй Ардажав нар «зах дэргэд» (8, 759) гэсэн үг гэж тайлбарлажээ.

Бидний бодоход энэ «чах-а» гэдэг үг «жахада» (захад дэргэд) гэсэн үг биш харин миний энхрий биед гэсэн утгатай «чах-а-да» «чаг-а-да» гэсэн үг мөн болно. Учир нь «бие чаг-а-да» гэсэн үг өгөх оршихын тийн ялгалын хэлбэрээр байгаа тул хэрэв «чах-а» гэдэг үг Чингис хааны бие үйлчлэх хүмүүс гэсэн утгатай бол тэдгээрт түмэн хишигтэн ялгаж өг гэсэн өөр утгатай болох юм. Иймээс «бие чага-да» гэдэг үг бол дан ганц Чингис хаанд өөрт нь хамаарах үг болох нь ил байна. Иймд «миний биеэ чаг-а-да» гэдэг бол «миний энхрий хайрт биед» ялгаж өгсөн түмэн хишигтнийг гэсэн үг гэж ухаарах нь учир зүйд

илүү нийцэнэ. «Чих-а» (хэүкэ) «хүүхэд» (36, 25) гэсэн утгатайн дээр сонгодог монгол бичигт «чах-а_улаган чах-а йин» (12, 734) гэсэн тайлбартайгаар бүртгэгдсэн байна. «Улаган чах-а-сая төрүксэн кэүкэд-и улаган чах-а кэмэмүй» (104, 1, 10, 25), гэсэн үг байгаагаас энэ үг энхрий нялх хүүхдийг тэмдэглэдэг үг байгаад хожим «хүү минь» гэж энхрийлэх утгаар хүнд хандах хандлага үг болсныг бид «МНТ»-ы §68-д эхнэр хүүхдээ гэрээслэн захиад үхэж байгаа Есүхэй баатар төрлийн дүү Мэнгэлиг эцэг гэгчийг «чих-а мину, Мэнггэлиг кэмэгэд нөгчиба» гэсэн үг байгаа нь яавч түүнийг нялх үр минь! гэсэн үг бус, харин «хүү минь, энхрий (дүү) минь!» гэсэн утгатай нь илэрхий. (Энэ тайлбарын № 206) Энд ч бас «миний энхрий биед» гэсэн утгатай хэрэглэгдсэнээс зайлахгүй болов уу. Гэхдээ энэ үг «чаха» гэсэн дуудлагаараа «хэүкэн» (хэүхэ_хүүхэд) гэсэн үг болж нөгөө «чаг-а» буюу «чиг-а» дуудлагаараа хайрлан энхрийлэх хандлага үг болж үлдсэн мэт бодогдоно.

627. үл гэмүригүлүн (үл гомдоож) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 49), Пеллио (9, 91), Лигети (33, 170), Рахевильз (25, 133) нар «үлү гэмүри'үлүн» гэж, Дашцэдэн «үлү гэмүриүлүн» (26, 169) гэж, Баяр (11, III, 1116), Элдэндэй Ардажав (8, 759), Иринчин (28, 219) нар цөм Лувсанданзаны бичсэнээр «гэмүригүлүн» (31, I, 158) гэж сэргээсэн байдаг юм. Энэ нь ч зөв ч байх. Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «өвдөх, хор хүргэх» гэж тайлаад «өвдөх» (15, 112) гэж, Поуха (17, 175), Кливз (42, 169), Калужинский (61, 169), Рахевильз (49, № 26, 1982, 40), Дугаржав (24, 207), Мансан (27, 301), Элдэндэй Ардажав (8, 760) тэргүүтэн цөм «бүү гомдоо, гонсойлго, доромжил, бууруул» гэх мэт утгаар орчуулсан байхад Дамдинсүрэн «аливаа гасланд хүргүүлэхгүй» (7, 227) гэж орчуулсан нь илүү жинхэнэ утгад ойртуулсан шиг санагдана.

Учир нь бидний бодлоор бол энэ үг гэм (гэм зэм буруу хэрэг гэсэн утгатай нэр үгийн үндэс) +ри (нэр үгээс үйл үг бүтээх дагавар) +гүл (үйл үгийн үйлдүүлэх хэвийн дагавар) +н (нөхцөл үйлийн хам (болох) хэлбэрийн нөхцөл) гэсэн бүтэцтэй үг тул «сэтгэлийг бүү гэмтээ, бүү эвд, бүү гутаа» гэсэн утгатай үг мөн шиг санагдана. Харин «гомдоох гонсойлгох» гэхийг «чимар» (§177) «чиматгабасу» (§254) гэх мэт үгээр «гэмших» гэхийг «гэнүгэр» (§ 254) гэсэн өөр үгээр тус тус хэлдэг байна. Жич энэ үг бас «кимурагулун» гэдэг сэтгэлийг бухимдуулах гэсэн өөр үгтэй их л ойр утгатай тул гарал төрлийн холбоотой байж ч мэдэшгүй санагдана.

628. дөрү[гү] (дөрөг) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллио (9, 91), Дашцэдэн (26, 170) нар «доро» гэж, Лигети (33, 170), Рахевильз (25, 134) нар «дооро» гэж, Баяр (11, III, 1116), Элдэндэй Ардажав (8, 760) «дөрү жад», Иринчин «тоор-а» жад (28, 220) гэхчлэн олон янзаар сэргээн босгосон шиг байдаг.

Энэ үгийг Хэниш (15, 110), Поуха (17, 175) нар «түүний дотор жад» гэж, Кливз «дороо нэг загварын тулгууртай жад» (42, 169) гэж, Рахевильз «дээр нь төхөөрөмжилсөн жад» (49, № 26, 1982, 41), Дамдинсүрэн (7, 227), Мансан (27, 302), Баяр (11, III, 1116), Элдэндэй Ардажав (8, 761, тайлбар № 4) нар цөм «дөрү буюу дөрүгэ (дөрөө) жад» гэж тус тус ойлгож орчуулсан байх бөгөөд энэ нь ерөнхийдөө зөв юм.

Бид энэ сүүлд дурдсан судлагчдын саналыг ерөнхийдөө зөв гэж дагаж баримтлахын хамт гучин зургаатын тайлбар толинд «дөрүгү-сэрэгэн-ү араг-а-йин үжүгүр-үн этэгэд-тур талбигсан бунгхугур_и «дөрүгү» кэмэмүй» (104, IX дэвтэр, 29) гэсэн тайлбарыг энэ үгэнд холбогдсон тайлбар гэж үзэж уг эхэд «гу» гэсэн үе хаягдсан гэж үзэж хаалтад нэмж оруулав. Үүнээс үзвэл дөрүгү жад гэдэг нь салаа сэрээ бүхүй бөгөөд сэрээний араа шүд бүрийн үзүүртээ «бунгхугур» бага зэрэг бүдүүрүүлж хийсэн төмөр зэвтэй жадыг хэлдэг ажээ.

629. хор[у] комса (хор хомс) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «хорхомса» (36, 67), Пеллио (9, 91), Лигети (33, 170), Рахевильз (25, 134), Баяр (11, III, 1117), Элдэндэй Ардажав (8, 760), Дашцэдэн (26, 170), Дугаржав (24, 207), Козин (14, 291) нар «хор хомса» гэж Лувсанданзан (31, I, 159) Элдэндэй Ардажав (8, 762, тайлбар № 6), Иринчин (28, 220) нар «хоор хомса» гэж, Дамдинсүрэн (7, 227), Баяр (хуучин монгол бичгээр) (11, III, 1117) нар «хору хомса» гэж элдэв олон янзаар сэргээн босгосны дотроос бид сүүлчийн хоёр судлагчийн саналыг зөв гэж үзэж байна.

Энэ үгийн хадмал хятад орчуулгын утгыг Хэниш «урэмтгий, хүрэлцээгүй» (36, 67) гэж тайлаад энэ үгийг Хэниш (15, 110), Поуха (17, 175), Кливз (42, 170), Рахевильз (49, № 26, 1982, 41) нар цөм «урэмтгий, хүрэлцээгүй болбол» гэж, Мансан «ховор хомс» гэж тус тус

орчуулсан нь ерөнхийдөө зөв чиглэлтэй ойлгож зөв орчуулсныг харуулав.

Бид харин энэ үгийг «хору хомса» гэж бичих нь худам монгол бичгийн үүднээс илүү зөв гэж бодно. Учир нь бид «хор» гэдэг үйл үгийн үндсээрээ «хомс» гэсэн үгтэй холбоо үгийн бүрэлдэхүүнд орсон гэж үзэж болохгүй учир нь ийм нийлмэл холбоо үг эрхбиш дайвар үгийн үндсээр нийлж ийм хоршоо үг бүтдэг нь «хар бор ажил» «хам хум хийх» гэх мэтээс үзтэл илэрхий. Тэгвэл энэ хор- гэдэг үг далбай гэдэг үйл үгийн үндэснээс «далбару» цавчих гэх мэтийн загвараар хор гэдэг үйл үгийн үндэснээс «хору» гэсэн дайвар үг үүсч «хору хомса» гэсэн хоршоо үг үүссэн гэж үзэх үндэстэй. Харин худам монгол бичигт «хору» гэсэн үгийг XIV зууны монгол хүний хэл аялгуунд үгийн эцсийн «у» эгшиг нь балархайшиж орчин цагийн монгол хэлэнд «хор хомс» гэж бичдэгтэй адил хэлэгдэх болсоны баримт гэлтэй. «Хорогдаху» гэсэн үйл үгээс үүссэн энэ дайвар үгийг «хор» (ингэж бичвэл «сум» гэсэн үгтэй хутгалдана) буюу эсвэл хо[о]р гэж бичвэл (амьхөнөөх «хор» гэсэн өөр үгтэй хутгалдах тул) даруй «хору[-н] хомса» (12, 386а) гэж хуучин бичигт бичигдэж байсан илүү зөв бөгөөд худам монгол бичгийн бичлэгээс уламжлалтай гэж бодох үндэстэй юм.

630. Өгэси(н) (өгөөш) —гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Пеллиот (9, 92), Лигети (33, 171), Рахевильз (25, 135), Баяр (11, III, 1127) нар «hө'өшин» гэж, Козин «hоошин ачижу» (14, 292) Дашцэдэн hөөшин ачижу» (26, 171), Баяр (11, III, 127), Дугаржав 24, 208), Мансан, (27, 303), Иринчин (28, 221) нар «өгэсин» буюу «өгэси» гэж сэргээн босгосноос сүүлчийн санал нь хамгийн зөв гэж бид баримтлав.

Энэ үгийн утгыг Хэниш (15, 111), Поуха (17, 176), Калужинский (61, 150), Дамдинсүрэн (7, 228) нар «боодол ачаа, ачаа тээш» гэж ойлгосон бөгөөд Кливз (42, 171), «ангийн олзны тор» гэж орчуулсан байна. Элдэндэй Ардажав «өгүсин» (8, 763) гэж сэргээгээд хорин нэгт тайлбар зааж «өгэси» гэж бичсэнийг заажээ.

Бид энд «өгэси» (өгөөш) гэдэг үг тэр цагт аливаа юм хийх торыг тэмдэглэдэг нэр байжээ. Бид ганц загасны торыг «өгэси» гэж нэрлэж байгаагүй болов уу гэж бодно. Учир нь түүнд «күлми» губчигур» гэдэг өөр үг хэрэглэдэг байжээ гэж бодно. Эл учраас энэ үг анд явах эзэд ноёдынхоо хоол хүнс багаж хэрэгсэл бэлтгэл ачааг цөмийг өгэси (ганц тоо) өгэсин (олон тоо) гэж нэрлэдэг байсан учраас энд тор биш харин ачаа баглаа гэсэн утгаар хэрэглэгдсэн гэж бодож байна.

631. «Алтан бүсэ-йин горкид-ача, ал дэбэл-үн үртэсүн-эчэ» (Алтан бүсийн горхиноос, ал (гал-хурц өнгөт) дээлийн үртэснээс) гэсэн энэ хоёр мөр шүлгийн үгсийг сэргээн босгосон талаар судлагчдын дунд онцын зөрөө байхгүй тул энэ талаар тайлбарлах зүйлгүй билээ.

Гагцхүү энэ хоёр мөр шүлэгт гаргасан далд ёгт санаа нь монгол аман зохиолын уламжлал ба монголын зан заншил, элчин харилцахад хэрэглэж агсан «дуу бариулах» ёстой гүнзгий холбоотой байсныг тэмдэглүүштэй. Үүнд «Алтан бүс» бол тэр цагийн монголчуудад овгийн толгойлогч буюу ханы эрхийн бэлгэ тэмдэг байсны дээр энэ бүсийг чимдэг элдэв цоолворт алтан гарихнууд бол хааны эрхэт хүнийг харь бусад овогтой ураг худ болгон холбогч гуа сайхан охидын бэлэг тэмдэг болгож энд ёгтолсон байна.

Судлагч Мансан (27, 320, X бүлгийн тайлбар № 14), Элдэндэй Ардажав (8, 769, тайлбар № 3) «Ал дээл гэвэл-улаан дээл, түрэг хэлний ал гэгч улаан өнгө» гэх эсвэл «ал гэгч түрэг үг, улаан гэгээн улаан, гүн улаан өнгө болай» гэх зэргээр тайлбарладаг нь бидний бодоход алдаатай. Учир нь ал гэдэг монгол хэлэнд «улаан» гэсэн утгагүй харин «хурц» гэсэн өөр утгатай бөгөөд энэ нь түрэг хэлний «ал» гэдэг үгийг зээлж авсан бус, кал>гал гэдэг үгийн эхний к авиа х→h→о (тэг) болох зэргээр гал шиг «хурц өнгөтэй» гэсэн утгаар хэрэглэгдэх болсон юм. Учир нь түрэг хэлний ал (улаан) гэдэг үгийн оронд монгол хэлэнд «улаан» гэдэг үг байгаа учир түрэг хэлний «ал» гэдэг үгийг монголчууд «зээлж» авах учир шалтгаангүй гэж бодно. Харин түрэг хэлний ал монгол хэлний «ул» хоёр язгуур нэгт хэлний төрөл үгийн авиа хувьслын хоёр өөр хувилбар байж л тун магадгүй юм. Хэдийгээр Чингис хааны Бөртэ хатан улаан дээл өмсөх дуртай байсан гэх, Тэмүжиний амийг унгаст тэргэнд нууж байхад харуулдаж байсан Хадаган хожим том болоод байлдааны үед улаан дээлтэй явж уйлж хайлж байсан зэрэг мэдээ байдаг боловч тэр үеийн монгол бүсгүйчүүд дан ганц улаан дээл өмсч байгаагүй тул «ал дэбэлүн үртэсүн-эчэ» гэсэн үг бол Улаан дээлийн гэсэн үг биш, харин «янз бүрийн хурц өнгөт торгон дээл» гэсэн үг болно. Нөгөө талаар «Үртэсүн-маси бичихан хэсэк» (12, 182б) гэсэн үг байгаа нь «язгуурты

охиноос» гэсэн ёгт санаа болно. Учир нь урьд монголчууд бэрийн сайн шинжийг магтахдаа «үйл үртэс сайтай» гэж магтдаг бөгөөд үйл гэдэг нь «оёх ажил сайтай», «үртэс» гэдэг нь үргэлж дээл эсгэж торго хайчилж байдаг учир торго давууны өөдөс үртэс (маш бага хэсэг) ихтэй байдаг сайн оёдолчин уран (гартай) бэр гэж магтдаг байжээ.

Иймээс Уйгурын залуу ноёны хэлсэн үгийг монголын шүлэгч буюу түүхчин (ойллого) сударч өөрөө «дуунд авч» шүлэг болгосон нь илэрхий гэж бид таамаглав.

632. таблай (туулай) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид «та'улай» эсвэл «таулай» гэж сэргээн босгодог бөгөөд энэ үгийг хуучин монгол бичигт ч мөн «таулай» гэж бичдэг нь уламжлалтай тул энд онцлон тайлбарламаар юмгүй.

Харин худам монгол бичгийг монгол хэлэнд урт ба хос эгшиг үүсэн гарахаас өмнө монголчууд авсан бөгөөд тэр үед авсан эртний монгол бичгээрээ ч «МНТ»-ыг бичсэн байх гэж бид боддог учир тэр худам монгол бичгээр энэ үгийг «таулай» биш «таблай» буюу эсвэл «табулай» гэж бичиж байсан гэж ийнхүү төсөөлөн «таблай» гэж сэргээв. Ингэж бичих үндэс нь Алтай язгуурын зарим хэлэнд иймэрхүү дуудлагаар хэлдэг үг нь мөн адил «туулай» гэдэг амьтныг нэрлэдэг гэдгийг Б. Я. Владимирцов зэрэг эрдэмтэн хэл шинжлэлийн номдоо бичсэн байдаг шиг санагдана.

Үгийн дунд хэлэгдэж бичигдэж байсан «б» авианы дуудлага нь сулран «в» буюу эсвэл «у-ү» авиатай сэлгэн дуудагдах ба бичигдэх болсон тул хуучин (сонгодог) монгол бичгээр «таулай» хожим (XIV зууны үед) тэмдэглэх болжээ гэж төсөөлнөм.

633. Сиксид (Чишгид) — гэсэн энэ газрын нэрийг хятад үсгийн галигаар нь Хэниш (36, 182), Пеллио (9, 93), Лигети (33, 173), Рахевильз (25, 136), Дашцэдэн (26, 173) нар «Сигсид, сик(а)-сит» ямагт агшлага үсэгтэй тэмдэглэсэн байдаг. Мөн Баяр (11, III, 1141), Элдэндэй Ардажав (8, 770), Иринчин нар (28, 224) цөм «сигсид» гэж мөн агшлагатай сэргээв. Харин Дамдинсүрэн (7, 231), Дугаржав (24, 211), Мансан (27, 305) нар энэ үгийг «Сиксид» гэж эгшлэгтэй бичсэн нь бидний бодоход орчин цагийн дуудлагад нь ойртуулан орчуулсан байна.

Хамгийн сонирхолтой нь энэ үгийг Лувсанданзан «сингсинг-тур» (31, II, 22) гэж тэмдэглэсэн явдал бөгөөд энэ нь уг үг Шигшид биш «Шингсүд» эсвэл «Синэсүд» (хар мод) гэсэн үгнээс гаралтай байж болохыг дохиолж байгаад оршино. Учир нь «МНТ»-ы галигт энэ үгийг «шиг» гэж агшлагатай бичсэн нь урьдын худам монгол бичигт агшлагын хоёр ацаг биш «нэ» гэсэн үеийг тэмдэглэсэн хоёр ацаг байж болно. Хоёрт гэвэл «синэсү» (хар мод) гэсэн энэ үгийн өмнө цэггүй бичигдсэн хэлний хөгжлийн явцад «нэ» гэсэн хэлний үзүүрийн н(э) авианаас (хэлний угийн) «нг» авиа болон хувирсан байж болно. Энэ тохиолдолд «Сингсинг» гэсэн Лувсанданзаны бичлэг гарч ирж байна. Хожим тэрхүү «нг» авиа нь бас задарч зөвхөн «г» буюу «к» авиа нь үлдээд шигшид буюу эсвэл шикшид болж улмаар үе нь солигдон дуудагдах болж «Шисгид» гол гэгдэх болсон байх гэмээр санагддаг. Жич Лувсанданзан «МНТ»-ы хятад эхэд бий «Шэнчи» буюу Шинчи баян урианхайн нэрийг бас «Сингсинг байан» (31, 1, 9) гэж бичсэн нь Шинэчи баян биш «Шинэсү тү баян» байсныг дохиолох мэт байна. Бас Боданчарын үед Тойрон хяраас Түнхлэг горхи руу нүүж ирсэн хэсэг хүмүүсийг Боданчар ах дүү нартайгаа хүчээ нэгтгэн эзэлж авсан тухай «МНТ»-ы §31—39-д гардаг бөгөөд Боданчар нэг дунд хээлтэй эмийг барьж юун хүн гэж асуухад тэр бүсгүй Жарчигудай адангхан урианхайн хүн гэж хэлж байгаа нь мөнөө Шинэчи баян урианхайн олон үеийн хойно удмынхан нь байсан болов уу гэж санагдмаар байдаг. Хамгийн сонирхолтой нь Монголын түүхч Саган цэцэн тэр эмийн нэрийг бас «Тэрэ богол сингситу бодан хатун» (23, 105) гэж бичсэн явдал юм.

Бид энэ бүхний үндэс дээр энэ «Сигсид» (Шигшид) буюу өөр зүйлд «Сискис» гэж нэрлэгддэг үгийг «Шинэсүд» буюу олон хар модот гэдэг үг байж магадгүй гэсэн санал тайлбараа урьд нийтлүүлсэн (10, 94—111) өгүүлэлдээ нэгэнт бичсэн тул энэ үгийн тайлбарыг энд үүгээр цэглэе.

634. «чага+нугуд сингхуд, чага-нугуд агтас ийар, хар-а нугуд булагадийар» (цагаанууд шонхорууд, цагаанууд агтсаар, харнууд булгадаар) — гэсэн энэ үгийг орчуулагчид судлагчид цөм ойролцоогоор сэргээн босгож, утгыг энд дурдсанаар нь зөв ойлгоно.

Бид үүнийг эртний монгол хэл бичигт шинж тэмдгийн зүйлс хойдох үгэнд холбогдож тооны талаар нэр үгтэйгээ тооны зохицолтой байсан гэдгийг тэмдэглэх гэсэн билээ. Тоо тэмдэг зэрэг хүртээл нэрийн зүйлс

холбогдсон нэр үгтэйгээ ганц ба олон тоогоор зохицож байсныг хожим үед ор тас мартсан учраас хуучин шинэ хоёр ухагдахууныг ойлгохгүй алдаа гаргаж байсныг бид энэ тайлбарын № 597-д нэгэнт хийсэн, түүнийг үзмүү! Энэ хүртээл нэр ба түүнийг авсан нэр үг, үйл үгийн тооны болон хүйсийн зохицол хожмын сонгодог монгол бичигт алга болсон зэрэг баримт нь энэ худам монгол бичгийг Монголын нууц товчооны зохиогдохоос хэдэн зуун (500 з.) жилийн өмнө жишээлбэл уйгур улсаас авсан бус, харин 1200—1500 жилийн өмнө (өөрөөр хэлбэл Хүн улсын үед) авч хэрэглэсэн болов уу гэх бодол эрхгүй төрүүлнэ.

635. гэр-т [ү бүхүй]-эчэ (гэртээс) гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглаласаас нь Пеллио (9, 94), Лигети (33, 174), Рахевильз (25, 137) тэргүтэн цөм **«гэр-тэчэ» гэж сэргээгээд, Хэниш (15, 113), Поуха (17,** 178), Рахевильз (49, № 26, 1982, 45), Дугаржав (24. 211), Мансан **(27, 305) нар цөм зүгээр л «гэрээс»** гэж орчуулсан байхад Дамдинсүрэн (7, 231), **Элдэндэй Ардажав** (8, 771), Иринчин (28, 225) нар мөн Дашцэдэн ч **цөм одоогийн ярианы хэлэнд хэлэгддэгээс өөр ялгаагүй** тул «гэр-тэчэ» гэж тайлбаргүйгээр хэн бүхний мэдэх үгийн ёсоор хэрэглэсэн байна. Гагцхүү Баяр гуай (11, III, 1145) хуучин (сонгодог) монгол бичгээр **«гэр ту эчэ»** гэж сэргээсэн нь уг үгийг өөрөөр ойлгосныг нь харуулсан шиг санагдана. Энэ гэр-т-эчэ-гэртээс гэсэн үгийг орчин цагийн монгол хэлний зүйчид ч мөн **учрыг олохгүй «давхар тийн» гэж ярьцаадаг.** Гэтэл нэр үгийн тийн ялгал нь тухайн нэр үгийг өөр үйл үгтэй холбож өгдөг тул нэгэн зэргээр хоёр **өөр тийн ялгалын нөхцөлтэй байж арай боломгүй санагдана. Үүнийг Лувсанданзан** тэргүүтэн **анх давхар тийн ялгал гэж үзэж байснаас тийм биш, харин харьцангуй нэр гэгчтэй** (эзэмшихийг илтгэх утгатай) -ту, -түү, -тай, -тэй дагавартай үгэнд залгасан тийн ялгалын нөхцөл гэж **үздэг байна. Тодорхой нөхцөлд үнэхээр тийм тохиолдол байдаг нь** «Уулаад морьтой явган хоёр хүн явна. Би морьтойтой нь уулзаж **ярилаа» гэх мэт өгүүлбэрт энэ тайлбар** нийцэж байна. Гэвч «гэр-тэчэ» гэсэн энэ үг **«гэр ту (гэр бүхүйгээс)-эчэ» гэсэн үг байж бас** боломгүй юм. Иймд бид **«гэр-ту»** гэдэг үг нь гэрт (бүхүй хүмүүс) **орох гэх мэт өгөх оршихын тийн ялгалд хэлбэрээ «бүхүй хүн» гэсэн утга дам илэрхийлээд түүгээрээ гэрт «бүхүй хүүхдүүдээс»** гэсэн **нэршсэн** нэр болжээ. Ийээс бид үүнийг Баярын адил «гэр-ту [р] [бүхүй]-эчэ» гэсэн үг гэж ойлгож, **ийнхүү** сийрүүлсэн учраа тэмдэглэхийн хамт судлаач Кливз бас «гэр-тур (дотор) ача» 42, 173) гэж англи хэлэнд оновчтой зөв орчуулсныг дурдалтай.

636. үлү сираган (жаргаан) —гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 142), Пеллио (9, 94), Лигети (33, 174) Рахевильз (25, 137), Баяр (11, III, 1145), Элдэндэй Ардажав (8, 771), Дашцэдэн (26, 173), Иринчин (28, 225) бүгд **«сирхан»** гэж сэргээсэн ба энэ үгийн хятад **товч орчуулгын утгыг Хэниш «шархатгалгүй, хор хүргэлгүй»** (36, 142) гэж **тайлсан тул Өрнөдийн эрдэмтэд Хэниш** (15, 113), Поуха, Кливз (42, 173), Рахевильз (49, № 26, 1982, 45) нар «шарх, хохиролгүйгээр» гэж, Дамдинсүрэн «хүн морь гарздаж зовоосонгүй» (7, 231), Дугаржав (24, 211) «шархдуулсангүй, зовоосонгүй» гэж, Мансан **«тураж сүйд хийсэнгүй»** (27, 305), Элдэндэй Ардажав (8, 771), Иринчин (28, 225) нар **«шархан»** гэж уг үгийг тайлбарлалгүй тавьсан нь чухам яаж ойлгож байгаа нь тодорхойгүй боловч, ерөнхийдөө шархдуулаагүй гэдгээр өвөр монголын бусад эрдэмтэдийн адил үзэж байгаа болов уу гэж бодогдохоор байна.

Бид энэ үгийг **«шархан»** гэсэн үйл үг байж таарахгүй гэж үзнэ. Учир нь энэ үгийн үндэс нь **«Сирх-а»** гэдэг нь үзтэл нэр үг мөн тул түүнд нөхцөл үйл үгийн хам хэлбэрийн нөхцөл залгасан байж таарахгүй. Иймд бидний бодлоор энэ нь **«сиргаху-тавьж өгөхгүй булаалдах мэтийн»** (12, 846б) **«иргажу сиргаху-хүлээхгүй булаалдах»** (12, 98) гэх утгаар монгол үгсийн санд бүртгэгдсэн үгийн эртний бичлэг нь мөн. «Үлү сирган» эр цэрэг, агт морьдын хүч сүйтгэж ядраалгүйгээр гэсэн утгатай хэрэглэгдсэн гэж бодож байна. Хүнийг асуултаар гартаан залхаахыг бас шалгаах буюу шаргаах гэнэ. Харин **«сиргаху»** гэсэн үг морь малыг зунжин унаж, сиралагаху шаралуулж гундаах, шарланги хүчтэй болгох гэдэг үгтэй холбоогүй биз дээ. Бидний бодоход «сирган» гэдэг үг харин «симдаху-кичийэжү симдаху йин» (12, 741б) **«синдасу»** гэх мэт үгтэй нэг язгууртай төрөл үг болов уу гэж бодож байна. Нэг үе доктор Б. Ринчин «сиргагу» гэсэн үгийг сиргух гэдэг үгнээс гаралтай тул «сиргагу» (шаргуу) биш «сиргугу» (шургуу) тэмцэл хийх гэж бичих нь зөв гэж тайлбарлаж байсан нь «МНТ»-ны энэ баримтаас үзвэл үнэн зөв нь батлагдахгүй байна. «Ирагу сиргагу» тэмцэл хийх гэж бичих нь худам монгол бичгийн үүднээс зөв мэт бодогном.

637. хагас [хагас] кэлэлэгдэжү (тал талаас (зэрэг зэрэг) хэлэгдэж)—

гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас бүх судлаач нар «хахас» буюу «хагас» гэж сэргээн сийрүүлдэг билээ. Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш **«тухайлбал, тодорхой»** (36, 56) гэж тайлснаас үзвэл хадмал **орчуулга оновчтой** биш шиг санагдана. Энэ үгийг Хэниш (15, 114), Дамдинсүрэн (7, 233), Поуха (17, 180), Калужинский (61, 154), Кливз (42, 176), Рахевильз (49, № 26, 1982, 47), Мансан (27, 307) **нар энэ үгийг** орхиж орчуулсан нь хадмал орчуулгын өгсөн тайлбар итгэгдээгүйн гэрч болно. Энэ үгийг Дугаржав «ятган» (24, 214) **гэж, Элдэндэй** Ардажав (8, 781) «тодорхой» **хэлэгдэж гэж хадмал хятад орчуулгыг дагажээ.**

Бидний бодлоор бол энэ «хагас» гэдэг үг **«тал талаас»** буюу эсвэл **«зэрэг зэрэг»** гэсэн утгатай үг шиг бодогдоно. Учир нь «хагас» гэдэг үгийн өөр ойролцоо утгат үг нь **«тал» гэсэн үг** байдаг бөгөөд чухам **«хагас хагас йабудал тан» (§ 233) гэж хэлж байгаагийн** утга нь **«тал** талын» буюу эсвэл **«тал бүрийн ажилтай»** гэсэн үг болох нь ил юм. Харин энд ч чухам л ийм утгаар «хагас [хагас] хэллэгдэжүү гэсэн үг байснаас нэг **«хагас»** гэдэг үг нь орхигдсон байж магадгүй юм. **Юу ч гэсэн энэ** хагас гэдэг үг хожмын хуучин монгол бичгийн болон аман яриандаа «тал талын» гэсэн утгатай хэрэглэгдэж байсан нь баримт**тай байна.**

638. Жэ тэли (Зэ тэглэе) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Пеллио (9, 95), Лигети (33, 176), Рахевильз (25, 139), Дашцэдэн (26, 176) нар цөм энэ үгийг «жэ дэли» гэж хятад үсгийн галигийн алдааг дагаж буруу сэргээсэн боловч монгол хэлт судлагч Баяр (11, III, 1162), Элдэндэй Ардажав (8, 779), Иринчин (28, 228) нар **«жэ тэли» гэж зөв сэргээсэн байна.**

Энэ үгийн утгыг Хэниш (15, 114) Поуха (17, 180), Дамдинсүрэн (7, 233), Дугаржав (24, 214), Мансан (27, 307), Рахевильз (49, № 26 1982, 47), Иринчин (28, 228) нар «за зөвшөөрье, за тэгье, зөв» гэх зэргээр зөвшөөрсөн үг гэж **орчуулсан ба нөгөө Мостарт гуай** энэ үгийн өөр «жэ тэли» гэсэн бичлэгтэй үгийг (§246) тайлбарлахдаа «за боллоо, цаан ярих хэрэггүй. За тийм болог» гэх мэт франц үгтэй адил **утгатай» (47, [173]) гээд олон** толь бичиг дурджээ. Тэгээд энэ «жэ тэли» гэдэг үгийг эл хэргийг ярихаа **больё» (47, [175]) гэж орчуулсан байна. Энэ учраас энэ үгийг Кливз «За боллоо!» (42, 176)** гэж орчуулсан бололтой санагдана.

Бид энэ үгийг зөв, тэгье гэж зөвшөөрсөн үг биш харин өөрийнхөө бодсон шийдвэрээс няцаж «больё» гэсэн утгатай үгийг **хэлний** аялгууны дагуу буруу хазгай тэмдэглэснээс ийм учир нь олдохгүй үг үүссэн гэж төсөөлөн бодож байна. Ингэж бодох үндэс нь нэгд энэ үгийг Нууц товчооны 246 дугаар зүйлд «манагар-у[н] үгүлэксэн-и идэши ударубасу, идэ-йин үгүлэксэн-и манагар ударубасу ичир-э мага кэмэкдэкү элэ. Урида үгэ барил (-г) дулуга. Жэ тэли [тэглэй-э] кэмэн сой'урхажу жичи **жалираба»** гэсэн өгүүлбэр байгаагаас үзвэл утгаа таны ийм буруу **авирыг** ухсан бол Алтан Хучар нарын адил алах бөлгөө. Тэгээд өглөө хэлснээ үдэд няцааж, үдэд хэлснээ өглөө нь няцаавал магад ичүүр болох биз ээ. Урьд үг барилдлаа гэдэг нь урьд (§204) хэлсэн өглөг соёрхол өгч байхаар хэлэлцсэн үг бий тул «жэ тэ[г]л [э]й-[э]» «за цэглэе, больё» гэж хэлсэн нь лавтай мэт. Урьд **үг барилдлаа «за тэгье, за тийм болог,** одоо боллоо!» гэх мэт **үгийг хэлсэн гэж** бодох үндэс утга **зүйн** үүднээс байхгүй байна. Хоёрт, зарим үгийн үндсэнд дагавар залгахад үгийн үндсэнд байсан зарим **гийгүүлэгч хасагддаг ёс монгол хэл бичигт** байдаг тул тэг (хоосон) гэсэн үгийн үндсэнд **«-лэ-»** гэсэн нэр үгээс үйл үг бүтээх дагавар залгахад **«тэ[г]лэй-э» гэж үг хураагдаж болох** талтайн дээр болъёо гэсэн үг орчин цагийн монгол хэл аялгуунд **«болий»** гэж дуудагдах болсон зэрэг монгол хэлний авиа эгшиг балархайших хураагдах зүйгээр «эй-э» нь «и»-гээр тэмдэглэгдсэн болов уу гэж бид бодож байна.

639. оборажу жанггижуху (овоорч зоджээ) — гэсэн **энэ үгийг хятад** үсгийн галиглалаас **нь Хэниш (36, 124), Пеллио (9, 95), Лигети** (33, 177), Дашцэдэн (26, 176), Баяр (11, III, 1167), Элдэндэй Ардажав (8, 783), Иринчин (28, 229) нар **«өмэрэжү»** гэж, Рахевильз **«өмэрэжү»** (25, 139) гэж бараг цөм адилаар боловч, бидний бодлоор, буруу дуудлагаар сэргээдэг байв.

Энэ үгийн утгыг Хэниш **«тойрч хамтраад зодсон»** (15, 115), Поуха «бөөгнөрөөд» (17, 181), Калужинский (61, 154), «нэг зэрэг цуглаад Хасарыг зодсон» гэж, Кливз «нэг нь нөгөөтэйгээ холбоо байгуулаад» (42, 177) гэж, Рахевильз **«бүлэглээд»** (49, № 26, 1982, 47) гэж тус тус ерөнхийдөө зөв чиглэлтэй орчуулсан шиг бидэнд санагдана. Монгол хэлтэн судлагчдаас Дамдинсүрэн **«бариад** элбэж жанчжээ» (7, 233), Дугаржав «нэг удаа Хасарыг барьж байгаад жанчив» (24, 214)

Мансан «долуулаа нийлж Хасарыг зодов» (27, 308) гэж орчуулаад энэ үгийг хадмал орчуулгад «нам нийлж» гэж ерөнхий орчуулгад «хэрцгийлж» гэж орчуулсныг заахын хамт Элдэндэй Оюундалай нар «өмэрэжү» гэх үгийн язгуур нь өм-э «хамсах, хамтарч, нийлж» гэсэн утгатай «өм-э чэрик» гэх. Үүнийг «өмүглэх»-тэй хялбархан хутгадаг. Хонхтоны долуулаа нийлж (хамсаж) Хасарыг жанчив гэж орчуулбал зохино гэжээ». (27, 323, тайлбар № 24) гэж тайлбарлажээ. Баяр энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичгээр «өмүгэрэжү» (11, III, 1167) гэж бичсэнээс үзвэл «өмүгэрэкү» (өмөөрөх, өмөглөх) гэсэн үг гэж бодсон бололтой. Элдэндэй Ардажав «өмэрэжү — өмөглэжү» (8, 786, тайлбар № 3) гэж тайлсан байв. Бидний санавал худам монгол бичгийн эхэд нь «оборажу» гэж бичигдсэн үгийг XIV зууны үед хятад үсгээр галиглуулахдаа тэр үеийн болон хожмын аман ярианы хэлэнд дууддаг «оморажу» гэж хэлж өгснийг «өмэрэжү» гэж ташаа тэмдэглэсэн учраас омоорох буюу овоорох гэсэн үгийн оронд «өмөөрөх» гэсэн өөр үгийн бичлэгтэй болж өгүүлбэрийн үгсийн утгын холбоо алдагджээ. Долоон хүн нэг хүнийг тал талаас нь овоорч жанчиж болно. Харин өмөөрч байгаа мөртөө жанчив гэсэн үг байж учир зүйд нийцэхгүй. Иймээс Дамдинсүрэн гуай энэ «өмэрэжү» гэсэн үг байж таарахгүй, харин «овоорох» буюу «омоорох» гэсэн үг байх гэж бодоод ч юм уу, эсвэл хадмал хятад орчуулгын утгыг Хэнишийн тайлсны дагуу ойлгоод ч юм уу «элбэж» зодсон гэж орчуулсан нь маш оновчтой болжээ.

640. бисирэгүлжү үгүлэрүн (үнэмшүүлэн үзүүлж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 16), Пеллио (9, 96), Лигети (33, 178), Рахевильз (25, 140), Баяр (11, III, 1172), Дашцэдэн (26, 177) нар цөм «бисари'улжу» буюу эсвэл «бисариулжу» гэж сэргээдэг. Баяр (11, III, 1172), Элдэндэй Ардажав (8, 784), Иринчин (28, 230) нар «бисаригулжу» гэж хуучин монгол бичгээр сийрүүлсэн билээ. Үүнийг Лувсанданзан «бисихари гулжу» (31, II, 37), гэж утгыг ойлголгүй үгийг хоёр тасалж бичсэн нь уг худам монгол эхэд алдаа мадагтай бичигдсэн байгаа юу гэдэг сэтгэл төрүүлдэг билээ.

Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш дээр дурдсан нүүрт «элбэг дэлбэг, бүрэн дүүрэн, ихэд өргөн дэлгэж» гэсэн үг гэж тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 115), Поуха (17, 181), Калужинский (61, 155), Кливз (42, 177), Рахевильз (49, № 26, 1982, 48) нар хоёр хөхөө гаргаж хоёр өвдөг дээрээ тавьж (унжуулж) гэснээр орчуулцагаасан нь чухамдаа уул үг ямар утгатайг мэдэхгүй гагцхүү хадмал орчуулгыг л дагасан хэрэг юм. Дамдинсүрэн (7, 234), Дугаржав (24, 215) нар «хоёр хөхөө гаргаж өвдөг дээрээ барьж» (байгаад) гэж ойлгосон бол Элдэндэй Ардажав (8, 787, тайлбар № 14) өвдөг дээгүүр дүүрч гарах гэсэн утгатай «татар»-ын бисахариху-бялхах, халих гэх мэт утгатай үгтэй холбож тайлбарлаад хөхөө гаргаж унжуулсан нь хоёр өвдгийг «бисаригулугсан» [бүтээсэн?] мэт байдлыг үзүүлж дүрслэв гэжээ.

Бидний санавал энэ үг «бисаригулжу» гэсэн үг биш ерөөсөө л «бисирэгүлжү» өөрөөр хэлбэл барим тавим бодтой баримтаар үнэмшүүлж гэсэн утгатай гэж бодно. Энэ нь «МНТ»-ы өөр зүйлд энэ «бисирэкү» гэдэг үгийг хэрэглэсэн байдлаас мэдэгдэж байна. 164 дүгээр зүйлд Ун хан Тэмүжин хоёр завсрын хов жив сонсвол түүнд итгэхгүй «шидү-бэр ама-бар үгүлэлдүжү бисирэй-э...» гэх буюу эсвэл «ама-бар кэлэ-бэр [учраа] олулчажу бисирэй-э» (25, 77) гэж бичсэнээс үзвэл монголчууд гагцхүү өөрсдийн нүдээр үзэж чихээр сонссон өөрсдийн нүүр тулж уулзан ам шүд хэлээрээ хэлэлцсэн зүйлд л үнэмшин итгэж биширдэг байжээ. Энд ч Тэмүжин Хасар хоёр Өгэлүн эхийн хоёр хөхийг хөхөж өссөн тул нэг нь нөгөөгөө хөнөөж болохгүйг тэр хоёр баримт болгож «бисирэгүлүн» (бодтой баримттай) мэдрүүлж сургамжилсан нь илэрхий байна. Энэ үгийг хуучин монгол бичгээр ямагт «бисирэкү», «бисирэл» гэх зэргээр тогтсон нэг журмаар бичдэг нь бидний бодоход «МНТ»-ы хятад үсгийн галигт энэ үгийг «бүсирэкү» (25, 204б—205а) гэх буюу эсвэл «бисари'улжу» (25, 196б) гэх мэтээр буруу хазгай тэмдэглэдэгтэй харьцуулахад илүү бичгийн хэлний бөгөөд худам монгол бичгээс уламжлан ирсэн бичлэгийн үүсгэл зөв хэлбэр нь мөн гэж бодном. «Бисирэкү-итэгэмжилэкү», «бисирэл-бисирэкүй-йи ину», «бисилгал-бисилгахуй-йи ину» «бисилгаху-олан та сэткикү» (12, 264б) «бисигүй-бисигүй байина «кэмэкү жэргэ-йин» (12, 264а) болон «МНТ»-ы 54 дүгээр зүйлд гарах «буситай» буюу (зөв нь «биситай») гэдэг үгс цөм нэг язгуураас үүссэн төрөл үгс атал «МНТ»-ы хятад галигт элдэв олон янзаар буулгаснаас өөр өөр үгс шиг ташаа ойлгогдох болсныг энд тэмдэглэе.

641. онтутчу (оной харван) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 77), Пеллио (9, 96), Лигети (33, 178), Рахевильз (25, 140), Баяр (11, III, 1176), Дашцэдэн (26, 177) нар цөм «нонтучажу»

гэж, Баяр (11, III, 1176), Элдэндэй Ардажав (8, 784), Иринчин (28, 231) нар «онтучажу» гэж тус тус сэргээн босгосон ажээ.

Энэ үгийн хажууд бичсэн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «Алсын зайд сум харвах, цаазлах, торгох шийтгэх» (36, 77) гэж тайлсан билээ. Тэгээд энэ үгийн утгыг Хэниш (15, 216), Поуха (17, 182) Кливз (42, 178), Рахевильз (49, № 26, 1982, 49) нар цом «хол зайн сумаар» гэж ойлгож орчуулсан шиг санагдана. Энэ үгийг Дамдинсүрэн «онох сумын хүчээр оруулж авчирдаг билээ» (7, 235) гэж, Дугаржав «сочижу гаругсан-и сумдажу авчирадаг билэ» (24, 216) гэж, Мансан «атагархан гаруг сан дайисун-и алус-ача бучагаху күчүтэй» (27, 309) гэж элдвээр орчуулснаас гадна Элдэндэй Ардажав нар «онтучажу» - үгийн язгуур hoн нь оны эртний дуудлага сумны хамгийн холын тусалтыг нэг он гэнэ. Ондучажу гэвэл холын сумыг харилцан харвах гэсэн утгатай» (8, 789, тайлбар № 25 гэж тайлбарлажээ.

Бидний бодвол энэ нь хэрхэвч «ондучажу» гэсэн үг бус харин «онтутчу» ~ «онтутчу» гэсэн үг гэж бодно. Учир нь энэ үгийг «МНТ»-ы худам бичгийн эхтэй байсан гэгддэг Лувсанданзан энэ үгийг «огтутчу оругулху бүлэгэ» (31, II, 38) гэж бичсэн нь үнэндээ хамгийн зөв бичлэг шиг санагдаж байна. Учир нь нэгд энэ «Хонтучаху» буюу «онтучаху» гэсэн үг суманд холбогдохгүй, харин уур уцаар хилэгнэх гэсэн өөр утгатай үг болно. Хоёрт хадмал хятад орчуулгын алс харвах сум гэдэгт нь «он[у]-тутчу» гэдэг галиг нь илүү тохирно. Юу гэвэл Чингисийн чулууны бичигт холын зайд мэргэн харваж оносон Иэсүнгкэ хонгодорын дурсгалын чулуунд «гурбан жагуд гучин табун алдас-тур онтутлаг-а» (109, 15) гэж бичсэн нь үүнийг гэрчилнэ. Ер нь энэ үгийн бүтцийг бид «он[ужу] тусху» гэсэн хоёр үг нийлж хоршоо нийлмэл үг бүтсэн гэж таамаглаж байна. Ийм учраас «онтусху» гэдэг үйл үгийн үндэс нь бүр эрт цагт онтут-хожим т нь с болон хувирч «онтус» болжээ. Энэ үйл үгийн үндэс Багарсад гэгддэг хатуу дэвсгэр үсгийн нэг «с» мөн тул нөхцөл үйлийн «чу» нөхцөл залгах дүрмээр «онтусчу» гэж сэргээх нь зөв гэж төсөөлөн ийнхүү сийрүүлэв.

642. айун бэ(р) айуба, ичин бэ(р) ичиба (айхаараа айв, ичихээрээ ичив) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид Пеллио (9, 96), Лигети (33, 178), Рахевильз (25, 140), Баяр (11, III, 1177), Дашцэдэн (26, 245), Элдэндэй Ардажав (8, 784), Иринчин (28, 231) гэж цом «айун ба айуба, ичин ба ичибэ» гэж сэргээгээд утгыг Хэниш (15, 116), Поуха (17, 182), Калужинский (61, 155) нар айж ичлээ гэж сул үгийг орхиж, Кливз (42, 178), Рахевильз (49, № 26, 1982, 49), Дамдинсүрэн (7, 235), Дугаржав (24, 216), Мансан (27, 310), Элдэндэй Ардажав нар (8, 789, тайлбар № 26, 27) нар цом айхын их айх, ичихийн ихээр ичих гэсэн утгатайг ойлгож зөв орчуулсан эсвэл тайлбарласан юм.

Би энэ ба гэдэг бол нэгд «бид» гэдэг 1 биеийн олон тооны нөхцөлтэй хэлбэр биш, хоёрт энэ бол бас жинхэнэ нэрийн үйлдэхийн тийн ялгалын нөхцөл ч биш харин хүч нэмэгдүүлэх «бэр» гэдэг дагавар үг гэж бид бодож энэ учраас худам монгол бичгээр бол ямагт «бэр» гэж эм үгийн дуудлагаар бичигддэг үг эцсийн -р гийгүүлэгч нь орхигдон хаягдсан гэж бодож ийнхүү «бэ(р)» гэж сэргээн босгох нь зөв гэж бодном. Учир нь энэ хэргийг Чингис хаан ганцаар өдөөсөн тул «ба» (бид) айлаа ичлээ гэж хань татсан үг хэлэхгүй байх учиртай. Хоёрт, гэвэл «айун» «ичин» гэдэг үг нөхцөл үйлийн хам хэлбэрийн үг мөн тул үйлдэхийн тийн ялгалын нөхцөл «бар бэр» дагуулж чадахгүй нь ил байна. Иймээс «бэр» гэсэн хүч нэмэгдүүлэх дагавар үгтэй л орж бичигдэх ганцхан сонголт бидэнд үлдсэн тул бид «айун бэр айуба, ичин бэр ичибэ» гэж сийрүүлэхээс өөр замгүй болжээ.

643. Ийсүн кэлэтэн (есөн хэлтэн)-гэдэг энэ үгийг хятад үсгийн галигаас нь сийрүүлэх болон энэ үгийн утгыг зөв ухаарах **тухайд судлагч** авгай нартай сөргөлдөх маргах зүйл байхгүй гэж үзнэ.

Харин есөн хэлтэн гэдэг бол тэр цагийн есөн хэлтэн ард түмнийг хамарсан түүхэн агуулгатай мэдээ л лав биш, харин «есөн тэнгэр» ерэн есөн тэнгэр гэх мэт эртний монголчуудын бөө мөргөлийн буюу цаашилбал бүр ч эртний аман зохиол домог-үлгэрийн уламжлалын холбогдолтой эртний бэлэг тэмдгийн учир утгатай мэдээлэл юм. Үүнд ялангуяа нэг «Хүрэлдэй хүү» гэж нэг үлгэрт түүний зүүдэнд нэг цагаан сахалтай онгон өвгөн уулзаж, хэлэн дээр нь зүүгээр ес шивж өгсөнд сэрвэл есөн төрлийн амьтны хэл мэддэг болсон байжээ гэдэг үлгэр ч байдаг. Иймээс энд хэлсэн «есөн хэлтэн иргэн» гэж бичсэн нь «есөн шидийн» «зүсэм зүйлийн» «элдэв хүмүүс» гэсэн уран яруу үг хэрэглүүрийн утга агуулгатайг л энд тэмдэглэе.

644. Отчигин та жирин (Отчигин та хоёр)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь сэргээн босгох ба түүний утгыг олж ойлгох ухаарах та-

лаар судлаачдын дунд гойд зөрөөтэй зүйл байхгүй юм. Харин энэ «жирин» гэдэг эм хүйс заасан үгийг Отчигин ноён ба түүний элчи Сохор хоёрт «та жирин» гэж хэрэглэсэн нь тэднийг «эм-э чилэн» (эм хүнтэй адилтган) доромжилсон үнэн бодтой харилцааны тусгал, бичгийн хэл найруулгын нэг онцлог болно. Энэ онцлог бас «МНТ»-ы §150-д «Анай йин эм-э Дайан» гэж Хүчүлиг хүү нь Даян хааныг доромжилсон үг, бас Өгөдэйн хүү Гүюг (Гүйүк-арслангийн зулзага), Чагатайн хүү Бүрчи, Элчидэйн хүү Харгасун нар Зочийн хүү Батыг доромжилж «сакалтан эмэгэд сачагу болжу эскэй-бэр түрижү өлмэй-бэр гишгэлэжүкүй» гэх буюу. Гүюг «тэд хор (сум) тан эмэгэд-и эбчигүд ину жоругалдуиа «кэмэжүкү» (§265) гэх мэтээс үзэхэд тэр баатар эрэлхэг эр зоригийг эрхэмлэн хүсдэг агсан цагт зориг зүрхгүй эр хүнийг эм хүнтэй адилтган эм чилэн өгүүлэх тийм хүмүүст эм хүйс заах тодотгол үг хэрэглэх зэрэг нь уран найруулгын нэг арга хэрэглүүр болж байсныг энд тэмдэглэх гэсэн билээ.

645. нэгүлэ мэтү бэй-э (үүл мэт бэйэ[?])-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 116), Пеллио (9, 97), Лигети (33, 180), Рахевильз (25, 142), Мостарт (47, [155]), Баяр (11, III, 1188) нар «нэ'үлэ» гэж, Козин (14, 254), Дашцэдэн (26, 179) нар «нэүлэ» гэж, Баяр, Дугаржав (24, 218), Элдэндэй Ардажав (8, 791), Иринчин (28, 233) нар цөм «нэгүлэ мэтү бэй-э чину» гэж хуучин монгол бичгийн бичлэгээр сэргээн босгожээ.

Энэ үгэнд хийсэн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «том мод, хөгшин мод» (36, 116), гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш «өндөр модны гол мэт бие» (15, 117) гэж, Поуха «өндөр мод шиг биенийг»(17, 183), Калужинский «аварга их мод шиг» гэж (61, 156), Кливз «хөгшин мод шиг биенийг чинь» (42, 180), Рахевильз «аварга бүдүүн хөгшин мод шиг биенийг чинь» (49, № 26, 1982, 51) гэж, Дамдинсүрэн «эгүлэ (үүл) мэтү бэй-э ий чину» (7, 236), Дугаржав «нэгүл-э мэтү бэй-э чини» (24, 218), Мостарт «хөгшин дархи мод шиг бие чинь» (47, [159]) гэж, Мансан «сангси мэтү бэй-э чини» (27, 311) гэж тус тус орчуулсан байхаас гадна Элдэндэй Ардажав «нэ'үлэ гэкү ину модон нэүлэ, хасагсан бүдүгүн моду-йи нэүлэ кэмэмүй» (хорин нигэтү тайилбури, боть XIV, нигур 44), нэ'үлэ нүүлэ кэмэкү ину дарки (унанги) тому моду» (8, 797) гэх мэтээр тайлбарлав.

Мөн Мостарт Нэүлэ гэсний хятад хадмал орчуулгыг «хөгшин мод» гэснийг заахын хамт Ковалевскийн болон манж, хятад монгол зэрэг элдэв толинд «нэүлэ» гэдэг нь модны тайрдас, хагадас, модны гол, бөөрөнхий түймэрт шатсан дархи» гэх мэт олон утгатайг заажээ. (47, [156]).

Бидний бодвол нэгүлэ (эгүлэ-үүл) гэсэн эртний монгол үгийг XIV үед галигч нар өөрсдийн үеийн монгол хэлний дуудлага аялгаар «нэүлэ» гэж ташаа галигласны улмаас хожим хийсэн хадмал болон бусад орчуулга хөгшин дархи мод, модны гол, тайрдас гэх мэт өөр утгатай модтой хутгаж буруу орчуулсан бололтой.

Учир нь «нэүлэ» гэдэг модны үндсэнд гарсан түймрийг хэлдэг бөгөөд түймэрт шатсан том том дархи модны иш голыг ч бас «нэүлэ» гэж хэлэлцдэг байна. Энэ үг худам монгол бичгээр нэүлэ буюу хар «нэгүлэ» буюу «эгүлэ» гэж бичээстэй байж гэж таамагламаар байна. Юу гэвэл Лувсанданзан энэ үгийг «эгүлэн» (31, II, 42) гэж бичсэнээс гадна Козины сийрүүлэг эхийн нь дотор (14, 389) «нэгүлэн» гэж бичсэнийг Мостарт иш татсан байна. Түүнээс гадна «нэкүс (нэгүн) одбасу» гэсэн үг бол эргэж хөрвөх, зөөлөн зүйлд холбогддог тодотгол үг юм. Жишээ нь Жэлмэ-г Чингис хаанд Жарчигудай өвгөн «эгүдэ бэн нэкүл (үүдээ сөхүүл, эргүүлүүл)» гэж өгдөг. Гэрийн эсгий үүдийг «нэкүс» эргүүлээд гэр дээр хаяж болно. Харин хөгшин дархи бүдүүн мод ямар ч тохиолдолд «нэхүс нахис» хийж унах учиргүй биз ээ. Үүл гэдэг үг монгол хэлэнд «нэгүкү» (нүүх) гэсэн үгнээс үүсч «нэгүлэн-нэгүлэ, эгүлэн, эгүлэ, эүл,→үүл» гэж хувиран хувирсаар үүссэн нь илэрхий.

Ийм учраас бид «эгүлэ мэтү бэй-э йи чини Үгэй болжу одубасу» гэж орчуулсан Дамдинсүрэнгийн орчуулгыг хамгийн зөв оновчтой гэж үзэж энэ үгийг «нэгүлэ» (үүл) гэж сэргээв.

646. нэт [и]гэл мэтү (нэтгэ хөрөнгө мэт)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 116), Пеллио (9, 97), Лигети (33, 180), Рахевильз (25, 142), Козин (14, 254), Баяр (11, III, 1187) нар «нэтгэл» гэж, Мостарт (47, [155]), Дашцэдэн (26, 179), Элдэндэй Ардажав (8, 791), Иринчин (28, 233) нар «нэдкэл～нэдгэл мэтү» гэж арай өөрөөр сэргээсэн байдаг.

Энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «ээдэрсэн олс шиг улс» (36, 116) гэж тайлсан юм. Хэниш (15, 117), Поуха (17, 183), Кливз (61, 180), Рахевильз (49, № 26, 1982, 51), Мостарт (47, [159]) «ээдэрсэн утас түүдэг шиг улсыг чинь» гэх ерөнхий санаагаар орчуулсан бол Дамдинсүрэн «үлэксэн йэкэ улус-йи чини» (7, 236), Дугаржав «нигэтгэксэн йэкэ нийнтэ улус-йи чини» (24, 218), Мансан (27, 311)

«нүүдлийн шувуу шиг цугларсан улсыг чинь» гэж тус тус орчуулсан байна. Энэ үгийг Баяр (11, III, 1187) хуучин монгол бичгээр «нитгэл» гэж бичиж сийрүүлснээр үзвэл нийтгэсэн утас мэт улс гэсэн үг гэж Баяр гуай үзсэн мэт байна.

Энэ үгийг Элдэндэй Ардажав юмын өтгөрсөн шөл зэргийн нэтгийг хэлнэ. Шараг (шавхруу шаар). Үүнээс гадна бас ээрч томох (нийтгэх) бас эрчлэх гэсэн үгтэй холбож энэ «нэтгэл» нь нитгэлийн эртний дуудлага, орчин цагийн хэлэнд цай, мах чанахын үед гарсан шаарыг «нитгэл» гэнэ. Энд холимог олон гэсэн утгатай (8, 798, тайлбар № 24) гэжээ.

Бидний санавал «нэтгэл» гэдгийг Элдэндэй Ардажав нарын тайлбарын I зүйлд дурдсан зүйл хамгийн зөв үндэстэй сайн тайлбар мэт санагдана. Энд тэдний гаргасан баримт бол аж төрлийн ердийн баримт юм. Бидний бодол энэ үгийг зүй нь «нэтигэл» гэж худам монгол бичигт бичдэг байсан болов уу гэж бодож байгаа юм. Учир нь монголын маш эртний домог үлгэрийн сэтгэлгээнд орчлон дэлхий их усан далайд «нэтигэ» гарч усан дотор өрөм байсан мэт газрын өрүү (эрт «өрэ») анх тогтсон гэж үздэг үзэл байсан бололтой бөгөөд газар дэлхийг «этүгэн эх» гэх, бас монголын бөөгийн ёсонд Натигай-насигай-нэтигэй-нэтүгэй-нэтүгэн-этүгэн гэх зэрэг олон янзаар бичигдэж ирсэн энэ тэнгэрийн нэр ч бас нэтигэй буюу усанд газрын өрэ (гол төв) тогтсон газар шорооны эх үүсвэр гэдэг утга бий байх. Энэ талаар бид өөр номд (77, 41) дурдсан тул энд товчилъё.

Нэтигэл бол аливаа шингэн, түүний дотор бас айргийн дотор гарсан тунадас өтгөнийг нэрлэдэг нэр бөгөөд аливаа юмын үүсгэл үр хөрөнгө гэсэн утгаар ч энэ үгийг хэрэглэдэг байна. Хөхүүрийн ёроолд үлдсэн айргийн нэтиг бол дараах зунд айраг исгэх эхэр хөрөнгө болдог билээ. Эл учраас «Даян хааны хайрт зургаан түмний магтаал»-д:

«Эрдэм түү богда-йин ирэгүл болугсан
Эртэ эдүр күчин-ийэн өкгүксэн
Эсүк-үн экэр
Тараг-ун көрүнггэ болугсан

Тунг йэкэ йөнгсийэбү» (99, 184б) гэж бичсэнээс үзвэл «нэт[и]гэл» мэт улс гэдэг нь «ээдэрсэн буюу нийтгэсэн утас шиг эсвэл хольмог шөлний нитгэ шиг улс гэсэн үг бус. Харин хамаг юмын үг хөрөнгө болсон гол төлөв нэгдсэн монгол ард түмнийг минь хэнд мэдүүлэв гэсэн утгатай үг гэж бид төсөөлөн бодож энэ үгийг «нэт (и)гэл» гэж сийрүүлэв.

647. **туйал [түгэл?] мэтү** (түгэл мэтү)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 157), Пеллио (9, 97), Мостарт (47, [155]), Лигети (33 ,180), Рахевильз (25, 142), Баяр (11, III, 1190), Дашцэдэн (26, 179), Элдэндэй Ардажав (8, 791), Иринчин (28, 233) нар цөм «туйал» гэж сэргээсэн бол харин «МНТ» худам монгол эхтэй байсан гэгдэх Лувсанданзан «түн мэтү» (31, II, 42) гэж, бас Қозин энэ үгийг «Түʼел мэтү» гэж эм үгээр сэргээсэн нь маш сонирхолтой бөгөөд Лувсанданзантай ойртсон ойлголт болно.

Энэ үгийн утгыг хажуугийн хадмал хятад орчуулга үгээр нь Хэниш «шувууны сүрэг» гэж дээр дурдсан хуудсанд тайлсан байна. Энэ үгийг Хэниш (15, 117), Поуха (17, 183), Калужинский (61, 156), Кливз (42, 180) Мостарт (47, [159]), Рахевильз (49, № 26, 1982, 51) нар цөм «сүрэг шувуу шиг» гэж орчуулсан байв.

Гэвч Дамдинсүрэн «сүрүк йэкэ улус-и чини» (7, 236), Дугаржав «төрү улус-и чини» (24, 218), Мансан «туйагату сайихан улус-и чини» (27, 311) тус тус орчуулснаас үзвэл энэ «туял» гэдэг үг сүрэг шувуу гэсэн үг биш, өөр үг байх гэсэн эрмэлзэл байсныг харуулж байна.

Бидний санавал энэ үг худам монгол бичгийн эхэд «туйал» гэж байсангүй. Харин «түгэл» буюу эсвэл «түнэл» гэсэн үг байжээ гэж таамаглан «түгэл» «түнэл» гэж хоёр янзаар сийрүүлэв. Учир нь Лувсанданзан «Түн[эл]» гэж хагас бичсэнээр ухаарвал «шугуй мэт» улс гэсэн утга гаргах бөгөөд Чингис хааны цуглуулсан улсын (хүмүүсийн) тоо томшгүй олныг адилтгасан үг болно. Хэрэв энэ үг Қозины буулгасан шиг «түгэл» гэсэн үг байсан бол эзэн хааны албат иргэн улсын тоог түгсэн од шиг олон гэсэн утга гаргаж болох бөгөөд хэний ч цуглуулж болдоггүй шувууны чөлөөт сүрэгтэй Чингисийн албалан цуглуулсан улс иргэнийг зүйрлэсэн гэснээс илүү үнэмшилтэй юм. Цэрэг албатын олныг тэнгэрийн одтой (түгэлтэй) зүйрлэдэг уламжлалтай нь «МНТ»-ы дотор Найманы Даян ханыг галаар сүрдүүлсэн тухайд (§194) Даян хаан «hодон-ача олан галтан кэмэмү» (9, 68) гэж хэлснээс мэдэгдэж байна. Энэ үгийг МНТ-ы өөр зүйлсэд хэрэглэгдсэн утгаар нь авч үзвэл ямагт бүрэн, гүйцэд, дутуугүй (§ гэсэн утга гаргах учир «оддын түгэл мэт» бүрэн улсыг нь» гэсэн утгатай нь ойлгомжтой юм. «Түгэл» гэдэг үгийг «туйал» гэж хятад үсгээр галигласан учраас хо-

жим хадмал хятад орчуулга хийхэд, шувууны сүрэг гэсэн буруу орчуулга хийхэд хүргэсэн гэж тааварланам.

648. Мөндүлүд-э (мөндүлүдэд)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 107) «мандугу» гэж үйл үгээр, Козин «мандутила мино» (14, 296), Пеллио (9, 97), Мостарт (47, [155]), Лигети (33, 180), Рахевильз (25, 142), Баяр (11, III, 1191), Дашцэдэн (26, 179), Элдэндэй Ардажав (8, 792), Иринчин (28, 233) нар цөм «мандутала ~ мандутал-а» гэж бидний бодлоор арай ташаагаар сэргээсэн юм. Тэгээд энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн нь утгыг Хэниш «амжилт олох, мандах» (36, 107) гэж тайлжээ. Энэ учраас энэ үгийг Хэниш (15, 117), Поуха (17, 184) Калужинский (61, 156), Рахевильз (49, № 26, 1982, 51), Козин (14, 177) нар «хөгжил муутай» гэж, харин Дамдинсүрэн (7, 236), Мостарт (47, [159]), Дугаржав (24, 219), Мансан (27, 312) нар цөм «өсч бойжиж амжаагүй», «өсөх насанд яваа», «бойжтол», «өгэлэй өндүр болтала» гэх зэргээр орчуулсан ерөнхий утгаараа арай ойртуулсан орчуулга болсон шиг санагдана.

Бид энэ үгийг «мандутала» гэсэн үйл үг байгаагүй харин «мөндүлүд-э» (тарбаган-у жулжаг нугудад) гэсэн үгийг буруу галигласнаас хожим хадмал орчуулга хийгчид ингэж «мандутал-а» гэсэн үйл үг ташаа орчуулахад хүрчээ гэсэн шинэ тайлбар санал болгож байна. Учир нь «мин-у гурван дөрвөн өчүкэд магу» гэсэн энэ олон тодотгол болох хүртэл нэр «мандутала» гэдэг нэр үгэнд холбогдох тийм үгийн нийлэмж монгол хэлний үүднээс алга юм. Иймээс муу мандутала биш, харин муу өсөж бойжоогүй «мөндөл» «мөндүлүд-э» гэсэн тарваганы арчаагүй нялх төлөөр зүйрлэн хэлсэн нь ив илэрхий байна. Түүнээс гадна үйл үгийн дараа орсон биеийн төлөөний үг хэдийгээр монгол хэлний зарим нутгийн аялгуунд үйл үгийн бие ялгах хувиллалын нөхцөл болж «би йабхуб(и)» гэх мэтээр хэлдэг болсон байвч энэ тохиолдолд «мандутала мину» гэж хослон хэлж болохгүй. Учир нь мандах үйлийн эзэн нь Бөртэ-үжин биш, түүний муу хүүхдүүд байгаа учир зүй нь «мандутала мину» гэх биш харин «мандутала ану» гэх ёстой билээ. Эл учраас энэ үг «мандутала» гэсэн үйл үг биш миний «мөндүлүд-э мину» (мөндлүүдэд минь) юу мэдүүлэх гэсэн үг болох нь монгол хэлний өгүүлбэр зүйн үүднээс илүү зөв учир зүйтэй санагдана.

Ман-да (бидэнд) гэсэн үгийг «МНТ»-ы хятад галигт «мунда» гэж эндүүрсэн баримт байх тул энд түүний эсрэг эр үгийн эгшгээр эм үгийн эгшгээр уруулын гийгүүлэгчийг хэлний гийгүүлэгчээр солиж алдаа гаргахгүй гэх баталгаа алга. Иймээс мөндүл+үд+э гэсэн үгийг «мөндү+дэ+лэ» гэж үе солин эр үг болгосон гэж бодох үндэстэй гэж үзнэ.

649. хойитугул-ача (хойтуулаас)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь сэргээх талаар судлагчдын дунд гойд маргаан байхгүй боловч энэ үгийн утгыг судлагчид янз бүрээр орчуулж энэ үгийн цаана монголын эзэн харьяат нарын орон гэрийн байршил, тэдгээрийн үчир шалтгааныг тусгасан учир судлагчдын анхаарлын гадна хоцорч ирсэн байна. Бид энэ үгийн үчрыг урьд нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ (10, 148—154) тайлбарласнаас гадна энэ тайлбарын № 332 дугаарт дурдсан тул түүнийг үзнэ үү.

650. эрүкэ [би]тэгүлэжү (өрх [би] түүлж)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 154), Пеллио (9, 98), Лигети (33, 132), Рахевильз (25, 143), Мостарт (47, [164]), Баяр (11, III. 1203), Дашцэдэн (26, 181), Иринчин (28, 235) нар цөм «түлижү» гэж сэргээн босгосон ажээ. Козин «түл(к)ижү» (14, 297) гэв. Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «таглах, бүтээх» (36, 154) гэж зөв тайлсан байв. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 118), Дамдинсүрэн (7, 238), Козин (14, 178) Мостарт (47, [174]), Поуха (17, 185), Калужинский (61, 157), Кливз (42, 182), Рахевильз (49. № 26, 1982, 52), Мансан (27, 313) нар цөм «бүтээж» «таглаж» гэж цөм туйлын зөв орчуулсан байх бөгөөд харин Дугаржав ганцаар «татаж» (24, 221) гэж орчуулсан нь бүтээж, нээж гэдгийн алиныг хэлж буй нь тодорхойгүй болжээ. Бас Элдэндэй Ардажав нар энэ үгийг «түрижү» (8, 803) гэж өөрөөр сэргээсэн нь улам ташаа болгожээ. Тэгээд энэ үгийг хадмал хятад орчуулгад «бүтээж» гэснийг (8, 804, тайлбар №1) заан тайлбарлажээ. Бид энэ үгийг «түлижү» ч биш, «түрижү» ч биш, харин «[би]тэгүлэжү» гэсэн үг өөрөөр төсөөлөн сэргээсэн болно. Энд [би] гэсэн авиаг хаяж «тэгүлэжү» гэж байсан үлдсэн хэсгийг энэ үгийн орчин цагийн дүүдлагаар «түлижү» гэж «э» авиаг «и»-гээр сольж галигласан учир ийм утга нь сайн мэдэгдэхгүй үг үүссэн гэж төсөөлсөнөө өөр баталгаа шаардагдахгүй зүйл гэж үзэж байна.

651. жалираба (уур нь намдаж царай нь засрав)-гэсэн энэ үгийг Хэниш (36, 85), Пеллио (9, 98), Козин (14, 297), Лувсанданзан (31, II, 45). Мостарт (47, [164]), Лигети (33, 183), Рахевильз (25, 144), Баяр (11, III, 1207), Дашцэдэн (26, 181), Элдэндэй Ардажав (8, 804), Иринчин

(28, 236) нар цөм «жалираба» гэж зөв сэргээн сийрүүлсэн юм. Энэ үгийн хятад хадмал орчуулга үгийн утгыг Хэниш дээр дурдсан нүүрт «килин намдах» гэж тайлжээ.

Тэгээд энэ үгийг Хэниш «миний хилин тайтгарав» (15, 119), Қозин «би өршөөлтэйгээр дүгнэж өгүүлбэл» (14, 178) гэж, Мостарт «өршөөнгүй болж царай нь цайрав» (47, [175]) гэж, Поуха «танд өршөөл үзүүлж ууруа намхруулав» (17, 185), Қалужинский «түүнд элэгсэг болж, хилэнгээ тайтгаруулав» (61, 158) гэж, Қливз «тэр түүнийг өршөөн, жич уур нь намхрав» (42, 182), Рахевильз «тэгээд хилэн нь намдаад түүнд жич өршөөл үзүүлэв» (49, № 26, 1982, 53) гэж, Дугаржав «соёрхоод уур хилэнгээ тайтгаруулж» (24, 221) Мансан «соёрхож уур нь аажмаар намхарч» гэж тус тус ойлгож орчуулсны дотроос зарим нь энэ «жичи жалираба» гэсэн зүйлийг Чингис хааны хэлсэн үгэнд оруулан орчуулж алдаа гаргасан байна.

Элдэндэй Ардажав нар «нам гүм, намжуухан, нам сэлүүн амрах, завсарлах, зог хийх гэх зэрэг олон толь бичгийн тайлбар, бас жалирахын «жали» нь түрэг хэлний жалын гэмээх нь 1) дөл, 2) цахилгаан аянга гэсэн үг гэж түрэг хэлний зээллэг үг (8, 806—807, тайлбар № 15) гэж тайлбарлав.

Гэвч бид энэ үгийг түрэг хэлний «жалын» гэсэн ормол үг биш харин монгол хэлний «жали» гэдэг галын дөлийн нэрнээс «цог заль» «суу заль» гэх мэт цог жавхлан нүүрэнд баяр хөөр цог золбоо гэрэлтэн илэрхийг тэмдэглэдэг монгол үг гэж бодож байна. Энэ заль мэх гэдэг ч бас авхаалж самбаагаа бүрүүгаар хэрэглэх гэсэн сөрөг утгаар хэрэглэдэг юм. Энэ жали+ра (царай нь цог жавхлантай болох барайхаа болих, сайхан болов гэсэн утгаар хэрэглэгдсэн нь үзтэл илэрхий энэ үйл үгийн үндсэнд -жу гэдэг нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл залгасан-ийм бүтэцтэй монгол үг байх тул түрэг хэлэнд монгол хэлнээс орсон, эсвэл түрэг хэлнээс монгол хэлэнд орсон ормол үг гэж шийдэхэд хэцүү болов уу гэж бодогдож байна.

652. **жиб[э]т[эг]үрэжүкүй** (зэвтүү болох)-гэсэн энэ үгийг судлагчдын сэргээсэн ба тайлбарлан орчуулсныг бид буруушаан маргалдах санаагүй боловч энэ үгийг «жибтүрэжүкүй» гэсэн энэ галиглал нь угтаа «жибэтэгүрэжүкүй» гэсэн үйл үгийг аман аялгуунд хураагдсан хэлбэрээр нь арай өөрөөр тэмдэглэсэн биш болов уу гэж санаж байна. Учир нь энэ үгтэй язгуур нэгтэй «жибэрэкү-тэмүрлик түр жибэ гарху» (12, 505), «жибэгүчэкү-бахан айускикү» (12, 505) гэх мэт айх, өнгө царай нь буурах гэсэн утгатай үгс байна.

653. **хала[г]-бар** (халаар)-гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 57), Пеллио (9, 100), Лигети (33, 158), Рахевильз (25, 145), Баяр (11, III, 1217), Элдэндэй Ардажав (8, 814), Иринчин (28, 239) нар цөм «хала'ар» буюу эсвэл «халагар» гэж, Қозин (14, 301(?)), Дашцэдэн «халаар» (26, 183) гэж тус тус буулгажээ.

Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «магад» «лавтайя» (36, 57) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 121) «аюулгүй, магад» гэж, Поуха «дараа нь» (17, 190) гэж, Қалужинский (61, 161) энэ үгийг тойрч орхин, Қливз «мэдээжээр» (42, 184) гэж тус тус орчуулсан мэт санагдана. Дамдинсүрэн (7, 244) тойрч орхин, Дугаржав «аяндаа» (24, 223), Мансан «зайлшгүй» (27, 330) гэж элдвээр орчуулсан байх бөгөөд энэ үгийг Элдэндэй Ардажав нар «халагар»-түрэг толиос үнэн, зөв, лав, магад» гэсэн утгатай «халагар» гэдэг үгтэй дүйлгэн бас «МНТ»-ы «хала чину бусу болгабасу» гэсэн үгийн хала гэснийг «зарлиг» гэсэн утгатай гэв. Зарлиг албадах чанартай тул «зайлшгүй, ярианүй, гарцаагүй» гэсэн утгатай (8, 815—816, тайлбар № 4) гэх зэргээр тайлбарлажээ.

Бид энэ үгийг «халаг-ийар» гэсэн үгийг хятад үсгийн галиг арай өөрөөр тэмдэглэсэн болов уу гэж санал гаргаж байна. Ингэж санах үндэс нь энэ үгийг Лувсанданзаны Алтан товчид «халагар» гэж бичсэн явдал юм. Учир нь хэрэв энэ үг Хала-гэсэн үг байсан бол худам монгол бичигт «хала-бар» гэж бичигдэх учир хуучин бичгээр түүнийг «халагаар» гэж бичимгүй юм.

Нөгөө талаар энэ «халаг-ийар» гэсэн үг «монгол-а даругдабасу» гэсэн үгийн дараа бичигдсэн байх тул тийнхүү дахин дарагдсандаа «халаглан гутарч айгаад» гэсэн утгаар энэ үг хэрэглэгдсэн байж болно. Хэн хэндээ «хала балагүй» гэвэл бие биестээ аюул ба муу нөлөөгүй» гэсэн холбоо хоршоо үг болдог бөгөөд энэ хоёр дайвар үгээс «хала+г, бала+г», «халаг балаг» гэх зэрэг үг бүтдэг нь илэрхий. Иймд Монголд дарагдсаны балгаар цэргүүд хот хотдоо тарчихна гэж Алтан хааны мэргэн түшмэл болгоомжилсноос зайлахгүй мэт санагдана. Гэвч энэ бол бидний л санал төдий юм.

654. **эдүгэ-д-э түр** (одоохондоо түр) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 41), Пеллио (9, 100), Лигети (33, 185), Рахевильз

(25, 145), Баяр (11, III, 1217), Дашцэдэн (26, 183), Элдэндэй Ардажав 8, 814) Иринчин (28, 239) нар цөмөөр «эду'эт-түр», «эдүгэд-түр эсвэл эдүгэ-түр» гэх зэргээр арай ташаа сэргээгээд энэ «түр» гэдгийг эдүгэ гэдэг үгэнд дагуулсан өгөх оршихын тийн ялгалын нөхцөл гэж бодож орчуулсан буюу тайлбарласан байна.

Бид энэ үгийг «эдүгэ-д-э түр» гэсэн хоёр үг гэж өөрөөр утгачилан унших санал тавив. Учир юу вэ гэвэл «эдүгэт» гэж галиглагдсан үгийн эцсийн т-д гийгүүлэгч бол тухайн ганц цагийг үзүүлдэг ухагдахуунт олон тооны нөхцөл залгасан гэж үзэх үндэсгүй. Тэгвэл энэ-д бол бидний бодлоор «-д-э» гэсэн өгөх оршихын тийн ялгал залгаж цагийн утгатай дайвар үг бүтээхэд эдүгэ гэж эгшгээр төгссөн үгэнд -э гэсэн өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгахад хоёр эгшгийн дунд жийрэглэсэн-д-гийгүүлэгч мөнөөс зайлахгүй. Нөгөө талаар «эдүгэ-д-э» гэсэн өгөх оршихын тийн ялгалын нөхцөлтэй болсон дайвар үгэнд дахиад өгөх оршихын «-дур, -дүр, -тур, -түр,» нөхцөл давхардуулан залгах нь монгол хэлний зүйд нийцэхгүй. Иймээс түүний ард бичигдсэн «түр» бол өгөх оршихын нөхцөл бус харин «түр» нь (одоохондоо) гэсэн утгатай биеэ даасан үг байхаас гарцаагүй мэт. Жич «Эйэ дүр оружу монгул-и ничубасу ничугагсан-у хойина баса сэткил бидэ тэндэ эйэтүлдүд-жэ» (25, 145) гэж тэр түшмэлийн хэлснээс үзвэл тийнхүү «түр... эйэтүй-э» (Түр зуур эвлэрье) гэсэн болох нь давхар батлагдаж байх шиг санагдаж байна.

655. Кэгүсийэхү (газар халуудан бэрхшээх) гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 76), Пеллио (9, 100), Лигети (33, 185), Рахевильз (25, 145) нар «hэ'үши'эжү» гэж, Козин (14, 301), Дашцэдэн (26, 183) нар «кэүшиэжү» гэж, Баяр (11, III, 1216), Элдэндэй Ардажав (8, 814), Иринчин (28, 239) нар «экүсийэжү» гэж тус тус сэргээж босгожээ. Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «тохирохгүй, тэшэсгүй» (36, 76) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 121), Поуха (17, 190), Калужинский (61, 162), Кливз (42, 184) нар «газар, цаг агаар таарахгүй» гэж, Дамдинсүрэн «эндэки гажар-ун халуунд тэсч ядаж байна гэнэ». (7, 244 гэж, Дугаржав «гажар бисигүркэжү» (24, 223) гэж, Мансан «гажар-ун усу сигон тохираху үгэй» (27, 330) гэж тус тус орчуулсан байхыг дээр Элдэндэй Ардажав нар энэ үгийг «эгүсийэжү» гэж сэргээгээд «эгүсичийг нойтон гэсэн утгатай үг гэж «жихүүн нойтонд зохирохгүй гэсэн утгатай» (8, 816, тайлбар № 8), гэж тайлбарлажээ. Гэвч энд Лувсанданзан хүртэл энэ үгийг «эгүскэжү»-үүсгэж (31, II, 70) гэж буруу бичсэн боловч энэ үгийг бид газар «кэгү(-р) сийэкү» гэсэн үг эхний «к-h-о(тэг)» хувирлын явц дундаа нутгийн аялгууныхаа хэлбэрээр тэмдэглэгдсэн үг байх гэж төсөөлөн бодож байна. Учир нь «кэүрсикү-галд чонун хэбэрэгсикү мэту-йин» (12, 363а) гэсэн үг монгол бичгийн хэлний үсгийн санд бүртгэгдсэн нь энэ үгийн хожимын бичлэгийн хэлбэр мөн шиг бодогдоно. Учир нь худам монгол бичигт урт ба хос эгшиг үсэг хоёрлон бичиж тэмдэглэх ёс байгаагүй учир энэ «кэүрсикү» гэсэн үгийг лавтайяа «кэгүсийэкү» гэж бичих үндэстэй. Кэгүр-(хүүр гэсэн утгатай дайвар үгэнд) си (эс тусах үйл үг үүсгэх дагавар) залгахад уул үгийн үндэсний р- авиа нь гээгдэн «кэгүси» гэсэн үйл үг үүсч түүнд газар халаах цоонох гэсэн тус үйл үг үүсгэхйэ-(үйл үгийн үйлдүүлэх хэвийн нөхцөл) залгаж «кэгүсийэ» гэсэн үйл үг бүтээж түүнд «-жү» гэсэн (нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн) нөхцөл залгаж «кэгүсийэжү» гэсэн бүтэцтэй үг бүтсэн гэж бодно. Энэ нь «газар цоноож» (их халуун болж) цэрэг эр, морьдыг «көлчүркэмүй» (халууцана) гэсэн утгатай болюлтой. Энэ учраас Дамдинсүрэнгийн «эндэх газрын халуунд тэсч ядаж байна гэнэ» гэсэн орчуулга хамгийн оновчтой зөв болжээ гэж эрхгүй бодогдож байна.

656. кэн (хум)-гэсэн энэ үгийг Хэниш, Пеллио, Лигети, Рахевильз Баяр, Элдэндэй Ардажав цөм «ха» гэж сэргээн босгосноос үзвэл хятад үсгийн галигт «ха» гэж тэмдэглэгдсэн нь илэрхий. Энэ үгийн хадмал орчуулгын утгыг Хэниш (36, 54) «мэдэлд өгөх» гэж тайлсан байна. Дамдинсүрэн «өргөл болгож» (7, 245) гэж, Дугаржав «хөсгэ болгож» (24, 225), Мансан «өргөн барьж» (27, 332) гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав энэ үгийг «ха-хан-ноён» (8, 820) гэж тайлбарласан уг үгийн утгатай огт авцалдаагүй болжээ. Үүнийг Хэниш (15, 122), Поуха (17, 191), Калужинский (61, 162) нар «болзол болгож» гэж, Кливз «да-төлөөний захирагчийн хөрөнгө гэж тайлбарлажээ» (42, 186, № 18). Бидний бодлоор бол энэ үг «ха» биш харин «кэн» гэдэг үг буруу галиглагдсан байна. «Йа+гу+м-а кэ+(г)үм-э» (юум хум) гэдэг үгийн үндэс кэ-нь хүн ба малын хөрөнгө зоорийн нэр юм. Хэрэв йа+гэсэн асуух үгийн үндсэнд «йагум-а» (юум ~ юм) гэдэг үг бүтдэг бол энэ кэ-гэсэн үндсэнд «-гүм-э» залгаад худам монгол бичигт «кэгүм-э» гэдэг үг бүтдэг байжээ. Харин хуучин (сонгодог) монгол бичгийн үг хэлэнд энэ үгийн «г» авиа нь сугарсан тул «кэүм-э» (12, 538) гэж бич-

дэг болсон байна. Энэ үг эл тайлбарын № 484-д «йагу кэ» гэж хоршоо үгийн бүрэлдэхүүнд урьд тохиолдсоныг тэмдэглэе. Хэн нь хэ-гийн олон тооны хэлбэр.

657. жул олжагур-а (жул олзны орхидост)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «чүл'үл жа'ура эсвэл чүл илжа'ура» (36, 29) гэж хоёр янз байж болно гэж сэргээсэн байна. Қозин «чулоул жаура» (14, 301), Пеллио «гүл үл жа'ура» (9, 103), Лигети (33, 191), Рахевильз (25, 150) нар «чул улжа'ура» гэж, Баяр (11, III, 1257) «чул олжагура» гэж, Дашцэдэн «чул улжаура» (26, 188) гэж, Элдэндэй Ардажав «чолгул-жагур-а» (8, 390), Иринчин «чул олжагур-а» (28, 248) гэх зэргээр элдвээр сэргээн босгосон байх юм. Энэ үгэнд хадмал хятад орчуулга үгүй гэдгийг заахын хамт Хэниш үгийн утгыг «олзны хүүхэд» (36, 29) буюу «бутач хүү» (15. 125), Поуха (17, 195), Қалужинский (61, 165), нар «мэргэдийн олзны буюу бутач хүү» гэж, харин Қливз «(чүл?) улжа'ар» хэвээр (42, 190) орхин тус тус орчуулжээ. Энэ үгийг Дамдинсүрэн «орхидос ту» (7, 250), Дугаржав «үрэдэсү» (24, 231), Мансан мэргидийн «чул олжабури-бэр» (27, 337). Мансан энэ үгийг XI бүлгийн 33 дугаар тайлбарт «чулу олжабури» буюу «цул олэвор» (холимогүй олзны хүү) гэсэн үг гэж тайлбарлав (27, 362—363, тайлбар № 33), Элдэндэй Ардажав «чолгул-жагура» удум (цусан сүлбээ) гэсэн үг (8, 836—837, тайлбар № 16) гэж тайлбарлав.

Бид энэ үгийг «жул олжагур-а» гэсэн үг гэж бодож ч- биш ж-гээр эхэлсэн үг гэж үзэв. Учир нь энэ «жул» гэдэг «жулбудасу», «жулжаг-а» гэх мэт үгийн үндэс болсон үг тул хүнийг доромжлох «жулдрай» «дорой донгио» гэсэн утгатай үг байх гэж төсөөлж байна. Нөгөө «өлжагур» гэдэг нь чухал «олжагул» гэсэн үг боловч нэг үгэнд орсон хоёр л авианы нэг нь ондоошин хувирч р авиагаар солигдсон учир олжагур болжээ. Энэ нь Бөртэ үжин эхийг нь мэргидэд олзлогдож явахад олдсон мэргидийн олжагул (олзны золбин хүүхэд) гэж доромжилсон хочлол үг юм. Энэ нь «алдагул» морь гэдэгтэй адил загвараар олжа[ла]гул-гэсэн бүтэцтэй үг боловч гул дагавар залгахад олон л авиа ондоошиж р-ээр солигдсоноос гадна -ла-олз гэдэг үгнээс үйл үг бүтээсэн -ла дагавар нь ч гээгдсэн учраас «олжагур» гэж бичигдсэн үг гэж бодож байна. Энэ үг өгөх оршихын -а нөхцөлтэй учир «олжагур-а» гэж бичих нь зөв юм.

658. жикэ[гү]рчү-(жихүүн болж, хүйтэрч)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 88), Қозин (14, 303), Пеллио (9, 103), Мостарт (47, [188]), Лигети (33, 193), Рахевильз (25, 151), Баяр (11, III, 1266), Элдэндэй Ардажав (8, 332), Дашцэдэн (26, 189), Иринчин (28, 249) нар цөм «жэкирчү» гэж санал нэгтэй сэргээж босгодог байна. Иймд хятад үсгийн галигт энэ үг чухам иймээр л тэмдэглэгдсэн гэдэг нь илэрхий.

Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хайр сэтгэл нь хөрч хүйтэрч» (36, 88) гэж тайлсан юм. Тэгээд энэ үгийг Хэниш (15,127), Поуха (17, 197), Қалужинский (61, 166), Кливз (42, 192) нар бараг цөмөөр «чанар нь» гэсэн үгийг хаяж харин хайр сэтгэл, санаа нь хөргөвөл, хүйтрүүлбэл гэж орчуулсан бололтой. Тэгээд энэ үгийг Дамдинсүрэн (7, 251) «чанар нь жакирч» гэснийг тойрч гарсан байна. Қозин «сэтгэл нь хүйтэрвэл» (14, 183) гэж, Мостарт (47. [207]), Дугаржав (24, 234) Мансан (27, 361, тайлбар № 35), Элдэндэй Ардажав (8, 840, тайлбар № 41) нар цөм «сэтгэл хөрвөл» гэж утгыг зөв орчуулжээ.

Бидний нэмж хэлэх зүйл гэвэл «сэтгэл нь хөрвөл» гэдэг утгыг хадгалсан үгийн бичлэг нь утгатайгаа нийцэхгүй байх шиг санагдана. Үүнд хуучин (сонгодог) бичгийн хэлэнд хөрөх хүйтрэх гэсэн утгатай үгийг «жэкиркү» гэж бичдэггүй, харин «жикэркү» гэж бичдэг уламжлалтай байжээ. Иймээс бид хадмал орчуулга үгийн утгад нь нийцүүлэн «жикэрчү» гэж сэргээх нь худам монгол эхийн уг бичлэгт ойртмоор санагдана.

Харин энд энэ үг чанар ину гэсэн үгтэй нь холбон бодож үзвэл «жэкирчү» гэсэн үг биш харин «жакирчу» буюу эсвэл «йакирчу» (ягирчу) гэсэн бичлэгтэй үг байсан ч байж мэдэшгүй. Учир нь «чинар» гэдэг үг нь чин буюу эсвэл «бат бэх» гэсэн утгатай үндэснээс үүссэн үүсмэл («чин+р») үг мөн тул чинар нь жакирчу буюу ягирчу (өөрөөр хэлбэл) «хатуу болсон» гэсэн үг байж болно. Энэ тохиолдолд хадмал хятад орчуулгын утга өөр болж «жикэгүн» болж буюу «жикэрчү» гэсэн үг бус «хатуу болох» «хатаж хагдарч» гэх мэт өөр утга оноож тайлах ёстой байжээ гэж бодно.

659. далдаригсан-ийан (далдирснаа) гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 31), Пеллио (9, 104), Лигети (33, 193), Рахевильз (25, 151), Баяр (11, III, 1282), Элдэндэй Ардажав (8, 845),

Дашцэдэн (26, 190), Иринчин (28, 251)-д тус тус «далдаригсан ийан» гэж цөм бидний бодоход худам монгол бичгийн бичлэгийн үүднээс маш зөв сэргээсэн байна.
Энэ үгийн хажууд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш «үүргээсээ зайлсхийх, сэм нуугдах» (36, 31) гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 127), Поуха (17, 198) «үүргээсээ зайлсхийснээ» гэж, Калужинский «үүрэг дүрмээ мартсанаа» (61, 176) гэж, Кливз «зайлж булталх гэснээ» (42, 195), Дамдинсүрэн «далдиран зайлсан» (7, 254), Дугаржав «далдирснаа» (24, 237), Мансан «далдирвал» (27, 342) гэж тус тус орчуулсан шиг санагдана. Ер нь энэ үгийн утга санааг зөв илтгэсэн гэж бид ч бас санал нэгтэй байна.

Гагцхүү энэ «далдаригсан» гэдэг үгийн бүтцийг хадмал хятад орчуулга хийгчид эсвэл түүнийг толь болгосон Хэниш (36, 31) (халх бамбайн цаана) гэсэн тайлбар хийсэн байхаас үзвэл энэ үг далда-ирэх гэсэн хоёр үгнээс үг нийлэх аргаар бүтсэн үг байж болох юм. Энэ тохиолдолд энэ үгийг хуучин монгол бичгийн үг хэлэнд «далдираху» (12, 656) гэж бичдэг нь эртний худам монгол бичгийн уламжлал байж болох юм.

Нөгөө талаар энэ үг «далда+ри+ху» гэж залгаврын аргаар «тогориху, дагариху» гэх мэт үгийн загвараар бүтсэн үг байж болох юм. Энэ тохиолдолд «МНТ»-ы хятад үсгийн галигласны адил «далдаригсан» гэж бичих нь зөв бөгөөд энэ бол худам монгол бичгийн уламжлалт бичлэг байж болно. Тэгвэл энэ үгийг хожим хуучин (сонгодог) монгол бичгийн үгэнд дуудлага нь өөрчлөгдсөний дагуу «далдирагсан» гэж өөрөөр бичдэг болсон гэж бодох үндэстэй юм. Бид ингэж бодоод «далдаригсан» гэж худам монгол бичгийн эхэд ийнхүү сэргээн сийрүүлэв.

660. Багури-(б)а(н) танигулбасу болба жэ (бууриа таниулбал болов зэ)-гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 12), Козин (14, 30), Пеллио (9, 104) нар «баолийа» гэж, Пеллио (9, 104), Дашцэдэн (26, 191), Лигети (33, 193), Рахевильз (25, 152), Баяр (11, III, 1282), Элдэндэй Ардажав (8, 845) нар «баулийа» гэж, Иринчин «бахулийа» (28, 251) гэж тус тус сэргээн сийрүүлснээс бидний бодлоор Иринчиний сийрүүлэг худам монгол бичигт байсан үгийн хэлбэрт илүү ойртсон шиг санагдана.
Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш дээр дурдсан нүүрт «сургаж заах, сургууллих» гэсэн үг гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 127), Поуха (17, 109), Калужинский (61, 167), Кливз (42, 195) нар цөм «байх гадаад хэлбэр сургаалыг мэдүүлбэл», «гарч ирэх гадаад байдал төлөвийг сургаж мэдүүлбэл» гэсэн санаагаар тойм төдий орчуулжээ. Дамдинсүрэн «бараат их малгайг бариулан мэдүүлж болно» (7, 254) гэж, Дугаржав «их малгайг бариулж сурган хүмүүжүүлбэл болох биз» (24, 237) гэж, Мансан «бараа их малгайн доор боловсрол хүртэж болно» (27, 342) гэж тус тус орчин цагийн монгол хэлэнд орчуулжээ.

Тэгээд энэ үгийг Мансан их малгай гэдэг үгийг Жинҕкин гэдэг хүний их дүрслэг ухан мэдэхийн сэтгэцээр «их шүхэр» гэсэн үг гэж тайлбарласныг зааж их шүхрийн чинь доор боловсрол хүртэж болно гэсэн үг (27, 362—364) гэж тайлбарлажээ. Элдэндэй Ардажав «Булиа-ангийн шувуугаа тавьсны хойно дахин эгүүлэн авчрахад хэрэглэх тэмдэг боулиху гэмээх нь ан агнах, шувуу нохойг сургах гэж «хорин нэгэт тайлбар» боть IV, нүүр 33, «түрэг нутаг» боть IV, нүүр 1434B) гэж тайлбарласан байв» (8, 849, тайлбар № 11) гэжээ.

Бидний санавал энэ үг баулийа гэсэн үг биш харин уг худам бичгийн «багури-йан» (бууриан) гэсэн үг байсныг XIV зууны үед энэ эхийг хүний дуудан уншсанаар галиглагч(ид) «р» авианы оронд «л» авиа ташаа оруулж галигласан болов уу гэж өөрөөр төсөөлөн бодож байна. Ингэж бодох үндэс нь нэгд хаан аавын дэргэд байж, бараа их малгайн буури-бан (Чингис хаан түүнд) таниулбал болох биз гэсэн утга санаа байж болох учир зүйд оршино. Ингэж бодвол «бараа их малгай» гэдэг эзэн хааны ёслолын титэм» гэсэн утгатай нь илэрхий. Өрнө дахинд хан ун хүнээ хүндэлж бусад бүх хүмүүс малгайгаа авдаг ёс байсан (Англид Уэлсийн хунтайжтай адилхан төрж түүнтэй нэгэн зуур солигдон Унгийн суудалд суусан гуйлгачин хүүгийн удмынхан эзэн унгийн дэргэд малгайтайгаа суух эрхтэй байсан гэдэг домогтой ажээ) бол Монголд хааная хүндлэхдээ малгайгаа өмсдөг өөр ёс заншил байдаг тул хааны титэмийг «бараа их малгай» гэдэг байсан биз. Нөгөө талаар Юван улсын судар 120 боть, олон шастир 7 дугаар дэвтрийн монгол орчуулгад Чаган... «баг-а-даган көдүгэ хони адугулахуй-дур модун-и гажар-тур жогсугажу малаг-а йи абчу модун-у үжүгүр [э] талбижу сөкүдүн мөргүжү дагулан бүжиглэкү-и Дайи-зу абалар-а гархуйдур үжэгэд асагугсан дур Чаган өчиксэн ину: гаҕчагар йабубасу малагай дэгэр-э бүкүй-ийн тула эрким хойар күмүн йабубасу насун ах-а

ану эрким кэмэдэг. Би гагчагар йабуху тула тэйин кү малагай-дур кичийэнгкүйилэмүй. Баса сонусбасу йэкэ түсимэл болху ану урида йосулал йанжу-йи болбасургулмуй кэмэксэн дур хаган гайихажу тэгүнэчэ абчу эгэгэд гэрэлтэй тэмдэктэй хувансу өгүлэксэн ину энэ эдүр гарчу абалахуй дур сайихан көбэгүн-и олбай. Сайин-ийар үжэктүн кэмэн дотугаду хорийан-у кэрэк и тусийабай» (52, 2а) гэсэн нэгэн тэмдэглэл байгаагаас үзвэл энэхүү «бараа их малгайн буури» таниулах гэгч хаан хүний буурь суурийг мэдэж засан захирах арга барилд сургаж, хаан ор суух хүнийг урьдаас бэлтгэх гэсэн утгатай үг болох нь мэдэгдэж байна.

Энэ бүхнээс үзвэл «багури-[б]ан» гэж сэргээх нь зөв гэж ийнхүү сийрүүлсэн болно.

661. аран-а бү ам[а]гар[у]гулутхун (ардад бүү ам гаруулагтун-өөрөөр хэл бэл үгээр доромжлуулагтун)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Козин (14, 305), Лигети (33, 195) нар «хабхариулутхун» гэх буюу эсвэл «хабхари'улутхун» гэж, Хэниш (36, 54), Пеллио (9, 104), Рахевильз (25, 152), Дашцэдэн (26, 191) нар «hабхари'улутхун» ~ «hабхариулутхун» гэж, Элдэндэй Ардажав (8, 846), Иринчин (28, 251) нар «хабхаригулутхун ~ хабхарихулутхун» гэж, Баяр хуучин (сонгодог) монгол бичгээр «абхаригулугтун» (11, III, 1285) гэж түс түс сэргээн босгосноос бидний бодлоор Баяр гуайн сэргээлт илүү ойртуулсан мэт санагдана.

Энэ үгийг хажуугийн хадмал орчуулга-үгийн утгыг Хэниш «Ардад инээдэм бүү бологтүн» гэсэн утгатай гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш «хүмүүсийг ихэд инээлгэх үндэс бүү бологтун» (15, 127), Поуха «хаахаалахын шалтгаан бүү өг» (17, 199), Калужинский «албат ардадаа элэг доог бүү бол» (61, 167), Кливз (42, 195), Дамдинсүрэн (7, 255), Дугаржав, (24, 238), Мансан (27, 342) нар «инээдэм, тоглоом элэг доог бүү бол» гэсэн утгаар цөм зөв орчуулжээ. Гэвч энэ үг чухам ямар үг болохыг Элдэндэй Ардажав «хабхаригулутхун» гэж сэргээгээд түүнээ «синжийанг-ун торгуд аман ярианд буй «хабхарих»-их дуугаар инээж наадах гэсэн хорчин аман ярианы «хабханатал инээх гэх нь ха-ха гэж ихэд инээхийг гэнэ» (8, 850, тайлбар № 17) гэж тайлбарласан боловч утга зүйн үүднээс энэ нь төдий л үнэмшилтэй бус юм. Учир нь «иргэн-э бү инэйэгүлүткүн» гэсэн үгтэй нь харьцуулбал аран-а «хабхаригулуткун» гэж шүлгийн толгой холбоцгүй үг байсан баймааргүй, харин аран-а «абхаригулутхун» гэсэн а авиагаар эхэлсэн үг баймаар тул «хабхаригулутхун» үг байгаагүй гэж бодмоор юм бас урьд мөрт нь инэйэгүлүткүн (инээлгэгтүн) гэсэн үг байхад дараах мөрт нь бас чанга инээх гэсэн ижил үг нуршин давтсан үг дахиад хэрэглэсэн байж таарамгүй нь «Нууц товчооны» бусад зэрэгцүүлэлээс илэрхий юм.

Энэ учраас бид энэ үгийг «ама--гаругулутхун» хоёр үгийг нийлүүлж XIV үеийн аман аялгууны дуудлагаар ташаа галигласан болов уу гэсэн санал таамаглал гаргав. Ингэж бодох үндэс нь хожим үеийн монголын феодалуудад тайж угсаатай ноён хүнийг ам хэлээр доромжлохыг «ноёнд ам гарав» гэж хэрцгийгээр залхаадаг байсан юм. Энэ тухай «Замд дайралдсан бадарчин» үлгэрт голын хөвөөнд хумбан тогоондоо цайгаа чанаж суусан нэг бадарчинд нэг дархан ноёны хиа ирээд «зам зайл» гэж хөөсөнд бадарчин хоёр модныхоо нэгийг авч замыг ширвээд «замаа чамайг зайл гэж байна гэжээ. Хиа юм хэлэлгүй давхиад явжээ. Удалгүй хоёр хиа давхин ирээд «ноёнд ам гарч гэж чамайг дуудуулж байна гэсэнд бадарчин: «Ээ харла! Ноёнд ам гараа юу? Тэгээд эмч биш, домч биш, би очоод яах вэ дээ! Ноёнд ам гарсан юм бол нэгээр нь хоол, нөгөөгөөр нь цай зооглож бай л гэж хэл дээ» (85, 190) гэж дооглосон тухай өгүүлжээ.

Үүнээс үзвэл «бү ама гаругулатхун» гэсэн үг «ардад үгээр дооглуулж бүү доромжлуул» гэсэн утгатай үг бололтой. Монгол хэлний нутгийн аялгуунд «м» авиа «б» авиагаар сэлгэн солигдох явдал байдаг тул энэ «бү ама гаругулутхун» гэсэн үг «аб[а]харигулутхун» гэсэн ташаа хэлбэрээр тэмдэглэгдсэн гэх үндэстэй тул бид энэ үгийг ийнхүү сэргээн сийрүүлж «ардад бүү ам хэлээр доромжлуул» гэсэн утгатай үг болов уу гэж таамаглав.

662. Асий-а хамбу (хүний нэр алдар)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь бүх судлагчид «Ашагатбу» гэж сэргээдэг нь XIV зууны үеийн монгол хэлний аман аялгууны дагуу тэмдэглэгдсэн гэж бид бодож байна. «Ш» авиаг тэмдэглэх үсэг худам (эртний) монгол бичигт байгаагүй тул бид энэ үгийг худам монгол бичигт «Асий-а хамбу» гэж бичиж байснаар төсөөлөн бодож сийрүүлэв. Учир нь ш авиа монгол хэлэнд гагцхүү и эгшгийн өмнө тохиолдсон с авианаас хожим үүссэн гэдэг нь тодорхой болно.

663. Бадагсийан (газар орны нэр)-гэсэн энэ нэрийг «МНТ»-ы хятад үгсийн галигаас нь судлагч нар **«Баткесен»** гэж энэ үгийг сэргээдэг боловч эртний худам монгол бичигт үгийн эгшгүүд хэлээр (эр эмээр) зохицох ёс баримтлан бичдэг байсан учир «Баткэсэн» гэж бичиж байгаагүйн дээр Д'Оссоны түүхийн номд энэ газрын нэрийг «Бадахшан» (63, гл. VII) гэж бичсэн байсан тул уг нэрийг худам монгол бичгээр «Баткэсэн» гэж бичихгүй, харин «Бадаксийан» гэж бичсэн байсан болов уу гэж төсөөлөн бодож сийрүүлэв. Учир нь ша авиаг гагцхүү и-гийн өмнө орсон си гэсэн үеэр тэмдэглэдэг байсан нь баримттай юм.

664. [Н]ис[ий]абура (Нэг хотын тусгай нэр) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид «Исэбүр» гэж сэргээдэг боловч худам монгол бичигт уг үгийг Исэ бүр биш харин [h]исабура гэж бичсэн гэх үндэстэй. Учир нь энэ нэрийг Рашид-ад-Дин «hишапур» (4, I, 1, 33) гэж «ш» авиагаар тэмдэглэх тул бид худам монгол бичигт hис[ий]абура гэж бичсэн байсан байх гэж төсөөлөн бодож ийнхүү сэргээсэн бөгөөд учрыг өмнөх тайлбар (№ 62, 63)-аас үзмүү.

665. бахайижу амуй (бахархаж байна)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 106), Козин (14, 308), Пеллио (9, 107), Лигети (33, 198), Рахевильз (25, 150), Баяр (11, III, 1316), Дашцэдэн (26, 195), Элдэндэй Ардажав (8, 865) нар цөм «махайжу» гэж санал нэгтэй сэргээн босгодог ажээ.

Тэгээд энэ үгийн хадмал хятад орчуулга үг үгүйг зааж утгыг Хэниш «ялалтандаа бахдаж» (36, 106) гэж бидний бодлоор туйлын зөв орчуулсан (15, 131) байна. Энэ үгийг Поуха «хөгжилдөн» (17, 204) гэж, Калужинский «хүндэтгэн ёслон баярлан»(?) (61, 170) гэж, Кливз энэ үг хаа ч тохиолдоогүй ба хадмал орчуулгагүй учир орхин (42, 201, зүүлт 105) орчуулсан бололтой байна.
Энэ үгийг Дамдинсүрэн (7, 258), Дугаржав (24, 243) «бахдаж» гэж, Мансан «баясч» (27, 347) гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав «хүчлэн зүтгэх, чармайх, зүтгэх» гэх мэт утгатай гэж тайлбарласан (8, 867, тайлбар № 6) нь бидний бодвол авиа дуудлагаар ойролцоо «махран зүтгэх» гэсэн өөр үгтэй эндүү жишсэн зүйл шиг санагдана.

Бидний санавал энэ үг Дамдинсүрэнгийн «бахдаж» гэж орчуулсан нь илүү үнэн зөв оновчтой орчуулга болсон шиг санагдана. Учир нь бид энэ үгийг Хэнишийн орчуулсантай яг адил утгатай ялалтандаа бахдаж гэсэн утгатай «махайижу» гэсэн үг гэж таамаглаж байгаа юм. Учир нь монгол хэлэнд ялангуяа үгийн эхний «б» авиа «м» авиагаар солигдон ондоошсон жишээ олон байдгийн жишээнд бид бан-у ~ ман-у, Байалиг ~ Майалик, хабар ~ хамар гэх мэт үгийг дурдаж болно. Эл учраас энэ үгийн худам монгол бичгийн уг эхэд «бахайижу» гэж байсныг галиглагчид «махайижу» гэж тэр цагийнхаа аман аялгууны дуудлагаар ташаа тэмдэглэсэн гэж итгэн ийнхүү сэргээн сийрүүлсэн болно. Ярианы хэлэнд биеэрээ бахархан гайхуулах маягтай ихэмсэг байдал гаргахыг «ма'адгар» зан гаргах гэх зэргээр язгуур нэгтэй төрөл үг нь мэр сэр дайралдаг билээ.

666. багулий-а (бурийа)-дур (нисч буух шугуйд)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 12), Козин (14, 308) «баолийа» гэж, Пеллио (9, 107), Лигети (33, 199), Рахевильз (25, 156), Баяр (11, III, 1321), Элдэндэй Ардажав (8, 866) нар тус тус «баулийа-дур» гэж, Дашцэдэн «баулийа» (24, 196) гэж тус тус сэргээн босгосон боловч энэ нь жинхэнэ зөв сэргээлт хараахан биш болов уу гэж эргэлзмээр.
Энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «амьтан сургах» (36, 12) гэж тайлжээ.

Тэгээд энэ үгийг Хэниш (15, 131), Поуха (17, 204), Калужинский (61, 170), Кливз (42, 202), Дамдинсүрэн (7, 258), Дугаржав (24, 244), Мансан (27, 348) нар цөм залуу шонхор (начин, харцага, бор харцага, зулзага харцага) гэх мэт шувуун анх сургуулих, анд гарах, гөрөөнд гарах мэт» гэсэн утгаар орчуулсан байна. Харин Элдэндэй Ардажав нар «бору сибагун» гэдгийг зөвөөр галигт байгаагаар нь буулгасан боловч харин «баулийа» гэсэн үгийг тайлбарлалгүй хэвээр бичжээ. Бидний бодлоор «МНТ»-ы Лувсанданзанд байсан худам монгол бичгийн энэ хэсэг маш балархай, алдаа ихтэй утга бүрхэг байснаас «бору сибагун» гэснийг «бургуатахун» гэж, «бурийа» гэхийг «хүлийэ» гэх зэргээр Лувсанданзан маш их алдаатай бичжээ.

Бид энэ үгийг «баулийа-дур» гэсэн үг бус, харин «бурийа» буюу «бурага-икчу ургасан мод» (12, 282а) шугуй гэсэн үг гэж төсөөлж байна. Учир нь нэгд «баулийа» гэх мэтийн ба-гэсэн үеэр эхэлсэн шувуу сургахтай холбогдох үг байхгүй. Харин зарим туулинд «буйилсун бүргэд» гэж хардаг тул «бао» гэсэн галиг бол чухамдаа «бу»-гэсэн үгийн галиглал байж тарлаа.
Хоёрт «бору сибагу» гэсэн үг бол бор харцага, шонхор начин гэх мэт

махчин шувууны нэр биш бөгөөд харин богширга гэдэг жижиг жиргэмэл шувууны нэр мөн тул түүнийг сойж буйилуулж (сургаж) ан агнуулах тухай яриа байж үл болно. Харин бор шувууны ангаахай богшоодой (нисч сураад) анх нягт шигүү ургасан шугуй модонд орсон гэж хэлж болох ажээ.

Иймээс энэ үгийг баулийа биш харин «бурийа» буюу «бурага» (нягт шугуй) гэсэн утгатай үг байх нь илүү үнэмшилтэй санагдах тул бид энэ үгийг хуучин монгол бичгээр «бурага» гэж хожим бичих болсон үгийг худам монгол бичигт: «бурий-а» гэж бичиж байсан байх гэж таварлаж «бурий-а-дур» гэж сийрүүлэв. Хавирганы «бураа (бурага?) гэдэг хавирганы толгой сээрний хоёр үеийн завсарт нягт шигдэж ургасан яс тул бас тэгж нэрлээ болов уу гэж санана. «Бургасун» (шигүү ургадаг мод), «бургалиг цасу» (нягт шигүү ширхэгтэй цас) гэх мэт үгстэй энэ «бурага» (бураа) гэдэг үг утгын хувьд ойролцоо язгуурын хувьд нэг гаралтай төрөл үгс нь байж магадгүй мэт санагдана.

Энэ үгэнд хожим хийсэн хадмал хятад орчуулгын утга «баулий-а» гэсэн буруу ташаа галигийн улмаас «буйилагулаху» гэсэн өөр үгтэй эндүүрч утгыг гуйвуулснаас улмаар бору «сибагу» гэсэн үгийг бас бор шувуу биш, харцага, начин, шонхор гэх мэт махчин шувууны нэр гэж эндүүрсэн гэж бодном.

667. ман-а мэтү (биднийг мэт)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 109), Пеллио (9, 107), Лигети (33, 199) Рахевильз (25, 156), Баяр (11, III, 1321), Элдэндэй Ардажав (8, 865), Дашцэдэн (26, 196), Иринчин (28, 258) цөм «мэнэ» гэж сэргээсэн бөгөөд энэ үгийн хадмал хятад орчуулгын үгийг Хэниш «олон, тэвчээргүй, маш шургуу» (36, 109) гэж тайлсан нь утгын үүдээс сайн авцалддаггүй байв.

Тэгээд энэ үгийг Хэниш (15, 131), Поуха (17, 204—205), Калужинский (61, 170), Кливз (42, 202) нар энэ үгийг цөм орчуулалгүй торч өнгөрсөн байна. Гагцхүү Дамдинсүрэн (7, 258), Дугаржав (24, 244) нар «энэ мэтээр» гэж, Мансан «юунд ингэж хэлж баршгүй» (27, 348) гэж тус тус орчуулжээ.

Бидний бодлоор бол энэ үг хятад галигт тэмдэглэсний адил «мэнэ» гэж байсангүй харин худам монгол бичгийн эхэд нь «ман-а мэтү» (бидэнд адилаар) гэсэн үг байсныг уг эхийг дуудан өгч галиглуулагч уг үгийг «мэнэ» гэж ташаа галигласны улмаас энэ үг «бидэнд адил» гэсэн «ман-а» мэт гэснийг «мэнэ» гэж алдаатай дуудаж өгсний улмаас уг үг орчуулж болмоор хэл зүйн авцалдаагүй өгүүлбэр болсон тул **ийнхүү** олон орчуулагч тойрч гарахаас **өөр** аргагүйд хүрсэн нь илэрхий байна. Ингэж бодох үндэс нь нэгд утга зүйн үүднээс «мэнэ» гэснээс «ман-а мэтү» гэдэг нь илүү нийцтэй буюу утга бүрдмэл өгүүлбэр болгож байгаад оршино. Хоёрт: энэ үгийг гагцхүү Лувсанданзаны «Алтан товчид» «ман-а мэтү» (31, 83) гэж бичсэн баримт бидний бодлыг давхар гэрчлэх мэт байна.

Гэтэл «МНТ»-ы §41-д «мэнэ, мэтү» (25, 19) гэсэн үгийг Лувсанданзан «Маха [мэнэ]-[а-э] гэж хоёр янзаар уншиж болохоор бичсэн нь (31, 16) уг үг «мана буюу эсвэл «мэнэ» гэж уг эхэд бичээстэй байсныг харуулж түүнд «-а, э» гэсэн өгөх оршихын нөхцөл нэмсэн гэж санагдахаар байна. Товчоор хэлбэл түрүүчийн (§41)-ийнх нь мана ~ мэнэ, сүүлчийн (§160) үг нь «ман-а» гэсэн хоёр үг мөн болохыг гэрчилж байна. Иймд бид энэ сүүлчийнх нь үгийг «ман-а» гэж Лувсанданзаны бичсэнээр сэргээн **түүнээ** энд тайлбарлав.

668. төбүдүд нохуд (нас бие гүйцсэн том ноход)-гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь судлагчид «төбөдүт» Хэниш (36, 150), Пеллио (9, 107) гэж сэргээн босгоод «төвөд-үд буюу түбэд нохой» гэж орчуулдаг байсан юм.

Бид урьд бичиж нийтлүүлсэн нэг өгүүлэлдээ энэ бол «төбөд үд ноход» гэсэн үг бус, харин нас бие гүйцсэн эр ноход гэсэн үг байж магадгүй (10, 42, зүүлт № 2) гэсэн саналаа нэгэнт гаргаж хэлсэн түүнээ баримтлан «төбүдүд нохуд» гэж сийрүүлэн «нас бие гүйцсэн ном ноход» гэж тайлбарлав.

669. сихуражу (сонирхон шохоорхож)-гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 135), Пеллио (9, 108), Лигети (33, 198), Рахевильз (25, 156), Баяр (11, III, 1323), Иринчин (28, 258) нар «сохоражу» гэж, Баяр, Элдэндэй Ардажав (8, 866) нар хуучин (сонгодог) монгол бичгээр «согоражу» гэж, Козин (14, 308), Дашцэдэн (26, 196) нар «сооражу» гэж тус тус сэргээн босгосон юм.

Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «МНТ»-ы толь бичигтээ (36, 135), «[хилэн?] [эргэлзээ?]-г шийдэх ухаарах» гэж тайлсан юм. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 131), Поуха (17, 205) нар «ухаж мэдээд» гэж, Кливз «[уур нь] намдаж» (42, 348) гэж элдвээр ойролцоо орчуулсан байдаг. Элдэндэй Ардажав энэ үгийг тү-

рэг хэлний сооран (тайтгараху) гэсэн үгтэй холбож тайлбарласнаас гадна **шинэ баргын аман яриандсугурижу** кэмэкү ину санага **бодулг-а** бан талбихыг өгүлэмүй» (8, 871—872, тайлбар № 20) гэжээ.

Бид энэ үгийг хуучин (сонгодог) монгол бичгийн үгсийн санд «шохугураху-нэлийэд дуралаху мэтү-йин» (12, 881а) гэсэн утгатайгаар бүртгэгдсэн үг мөн гэж бодож байна. Тэгэхдээ энэ үг Нууц товчооны хятад үсгийн галигт тухайн цагийн монгол хэлний нэг аман аялгууны гажуу дуудлагаар тэмдэглэгдсэн тул уг үгийн худам монгол бичгийн хэлэнд хожмын хуучин монгол бичгийн хэлэнд бүртгэгдсэн хэлбэрийн алинаас нь ялгаатай эндүү ташаа хэлбэрээр галигдсан гэж бодож байна. Учир нь гэвэл хуучин монгол бичгээр энэ үгийн эхэнд шо-гэсэн авиа авиагаар бичигдсэнээс үзвэл худам монгол бичгийн хэлбэр нь со биш, гагцхүү «си» гэсэн үеэр эхэлж бичдэг байсан гэж бодох үндэстэй юм. Учир нь монгол бичгийн хэлэнд ш авиа анх «с+и» гэсэн байршилтай с авианаас үүссэн бөгөөд хожим хуучин монгол бичигт нэгэнт үүссэн ш авианы дараа и-гээс бусад эгшиг бичдэг болсныг и-гийн нугарал хугарлын жам гэж монгол хэл шинжлэлтэн хэлэлцдэг болсон юм. Энэ бүхэнд үндэслэж бид энэ үгийг худам (язгуур эртний) монгол бичгээр «сихуражу» гэж бичиж байсан гэж сийрүүлсэн бөгөөд «ихэд сонирхох, онц анхаарал тавих, сонирхон хүсэх» гэсэн утгатай үг гэж төсөөлөв. Энэ үг монголын шинэ (кирилл) бичигт «шохоорхох-юманд дүрлаж сонирхох байдал гаргах» «шохоорхох-маш их хүсч дурлах» (53, 855-б) гэх мэтээр бичигдэн хэрэглэгдэж байна.

670. алтан сүмэс (алтан сүмс) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 137), Пеллио (9, 110), Баяр (11, III, 1353), Рахевильз (25, 160), Дашцэдэн (26, 267) тэргүүтэн бүх судлагчид «сүмэс» гэж сэргээгээд алтан сүм-э гэсэн үгийн олон тооны хэлбэр гэж ухаарч сэргээн босгосон нь ерөнхийдөө зөв ч байх гэж бид санал нийлж боддог.

Гэвч энэ үгийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «Бурхан(-ы баримал дүр) «алтан сүмс» гэдэг нь «бурханы барималууд» (36, 137) гэж тайлсан юм.

Хэниш (15, 135), Поуха (17, 212), Кливз (42, 208), Рахевильз (49, № 31, 1985, 24), Дугаржав (24, 248), Мансан (27, 375), Элдэндэй Ардажав (8,888—889, тайлбар № 2), Мостарт (47, [223]) нар цөм бурханы буюу «Буддагийн алтан баримал» гэж орчуулахдаа «сүм-э» гэдэг үг **«бурхан орших орон» гэсэн нэг утга, бас «бурханы баримал» гэх мэт өөр утга** буйг Мухаддимат толь зэрэг сурвалж заадаг байна.

Гэтэл нийт монголчуудын бичгийн хэлэнд «сүм-э» гэгч юуны урьд бурханы тахилын орон «дуган» гэсэн гол утгатай үг тул зарим судлагчид Бурханы дүрийг агуулах тахилын орон гэдэг үг гэнэт «бурханы дүрс, баримал» гэсэн утгатай болдог нь их л эргэлзээтэй зүйл тул энэ үгийг Дамдинсүрэн (7, 265), Баяр (11, III, 1353) нар сүм-э» гэж ганц тоот хэлбэрээр нь зөвхөн бичсэн байна.

Бид энэ үгийг бурхны тахилын орон «бурханы дүр» гэдгээс гадна харин бурхны тахилгын ордны хэлбэрээр хийсэн их хааны жууз тэргийг бас «сүм-э, сүмэс» гэж хэлдэг байсан бололтой гэсэн өөр санал тавьж байна. Учир нь энэхүү §276-г «Илуку-ийн абчу ирэксэн нэгүкүй Харси айага саба сэлтэ Толун абтугай кэмэн жарлиг болба» гэх өгүүлбэрээр төгсгөсөн явдал юм. Үүнээс үзвэл Илуху-Бурханы авчирч өгсөн бэлгийн Алтан сүмэс тэригүлэн алтан мөнгөн аяга сав гэж тоочсон бол энд харин Алтан сүмэс тэргүүлэн гэдэгт холбогдох бэлгийг нь «нэгүкүй харсн» гэж нэрлэсэн байх тул алтан сүм-э гэдэг нь алтадсан бөгөөд бурхны сүмийн дүрстэй асар бүхүй нэгүхүй харши буюу алтадсан хааны сэнтий суудал бүхүй жууз тэрэг байсан биш биз? гэсэн санаа сэдэл төрүүлж байна. Гэвч энэ бол судлагчдын цаашид нарийвчлан анхаарлаа хандуулууштай нээлттэй асуулт болно.

671. торгул-торгуд (торгож түр тогтосон) — гэсэн энэ үгийг Хэниш «дорхул-дорхуд» (36, 37), Пеллио (9, 111), Лигети (33, 206), Рахевильз (25, 162), нар цөм «дорхут» гэж, Баяр «торхут» (11, III, 1366) гэж, Дашцэдэн «дурхул» (26, 202) Иринчин «дорхуд (28, 267) гэж, хуучин монгол бичгээр Баяр, Элдэндэй Ардажав (8, 893) нар «торгуд-доргуд» (?) гэж сэргээсэн байна.

Гэвч энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хараахан эхлээгүй, дусаагүй» гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 136) «дуусгаж амжаагүй» гэж, Поуха «эцгийн эзлэн захирч амжаагүй» (17, 213), Калужинский «эцэг Чингис хааны нь үед хараахан бут цохигдоогүй» (61, 178) гэж, Кливз «түүний аавын хийгээгүй орхисон» (42, 210) гэж, Рахевильз «эзлэн хуваагаагүй» (49, № 31, 1985, 26) гэж, бас Дамдинсүрэн (7, 269), Дугаржав (24, 250) «хаан эцгийн дусгаагүй [үлдээсэн]» гэж, Мансан «эцгийн дутуу орхисон» (27, 377) гэж цөм хадмал хятад орчуулгыг мөрдөн орчуулжээ.

Харин бид энэ үгийг «торгул» [торгур]-олон тоонд «торгуд» гэдэг бөгөөд анх эхийг тавьсан гэсэн утгатай үг болов уу гэж арай өөрөөр бодож байна. Хэрэв хадмал хятад орчуулгад хэлсний адил «дурхуддурхун-дурхуд» гэсэн үг байгаад «эхлээгүй» гэсэн утгатай бол «эхлээгүй талбиху» гэсэн холбоо үг үүсч гарах нь монгол хэлний учир зүйд нийцэмгүй юм. Нөгөө талаар хараахан эхлээгүй юм гэсэн утгатай бол «дутуу орхих» гэдэг утгатай гэхэд бас зүйд нийцэхгүй. Ийм учраас «дорхун» бус, харин «торхул» (мөрт нэгэнт торсон юм гэх утгатай) үйл үгэнд +гур гэсэн арга хэрэглүүрийн утгатай нэр үг бүтээх дагавар залгахад үгийн үндсэнд байгаа «р» авианаас ондоошин эцсийн «р» авиа нь «л»-ээр сэлгэсэн торхул гэдэг үүссэн гэж таамаглаж байна. Олон тооны д нөхцөл залгахад уг нөхцөлийн эцсийн «р» (түүний хувилбар «л») гийгүүлэгч нь орхигдон «торхуд» гэсэн үг болсон гэж бодож байна. Гэвч энэ бол бидний нэг л санал төдий зүйл билээ.

672. кинггалаба (хянгардав) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш «кинггулху» (36, 102) гэж, Пеллио (9, 113), Лигети (33, 209), Рахевильз (25, 164), Дашцэдэн (26, 205), Баяр (11, III, 1385), Элдэндэй Ардажав (8, 899), Иринчин (28, 270) тэргүүтэн цөм «кингкүлбэ» гэж сэргээсэн байв.

Энэ үгэнд хадсан хятад орчуулга үгийн нь утгыг Хэниш «хөндлөн хугалаху» (36, 102) гэсэн үг гэж тайлжээ. Энэ үгийг Хэниш (15, 138), Поуха (17, 216), Калужинский (61, 180), Кливз (42, 213), Рахевильз (49, № 31, 1985), нар ерөнхийдөө «хугалах, нугалах, хуваах, таллах, тас оглох» гэх мэт утгаар орчуулсан болоолтой санагдана. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 276) Дугаржав (24, 253) нар «хяргаж явлаа» гэж, Мансан «хугас цавчиж явлаа» (27, 330) гэж тус тус орчуулсны гадна Элдэндэй Ардажав «дундуур таслав, хөндлөнгөөр таслах» (8, 906, тайлбар № 28) гэж тайлбарлажээ.

Гэвч бид энэ үгийг «кинггалаба» гэсэн үг гэж бодно. Учир нь юмыг тас цавчих багажийг «хинггар» гэж нэрлэнэ. Энэ үгийн үндсэнд «-ла» гэсэн нэр үгээс үйл үг бүтээх дагавар залгахад «хинггар» гэдэг үгийн үндэсний эцсийн «р» авиа орхигдон «хинггала» гэсэн үйл үг болж дээр саяхан (буюу мэдэгдэж) өнгөрсөн цагийн -ба нөхцөл нэмж «хинггалаба» гэсэн үг бүтсэн гэж итгэнэм. Харин «кинггүлкү» гэсэн хэлбэртэй утга ойролцоо үгс нэн ховор юм. «Кинган хабар», «Хинган-у дабага» гэх мэтээр энэ аливаа хурц ирмэгтэй юм бүхний нэрийн үндэс ямагт а эгшигтэй байгаагаас «кинггүлкү» гэх мэтээр энэ үгийг эм эгшигтэй галиглах үндэсгүй нь илэрхий тул энэ бол «МНТ»-г галиглагчдын аман аялгууг дагасан ташаа сийрүүлэлт мөн гэдгийг тусгайлан батлах шаардлагагүй мэт санагдана.

673. Илэ-йи би илагба Хада-йи би хатхуба (Илэ-г би ялав, Хада-г би хатгав) — гэсэн эдгээрээс «Илэ-и» гэсэн үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 81), Козин (14, 314), Пеллио (9, 113) Лигети (33, 209), Рахевильз (25, 164), Баяр (11, III, 1385), Дашцэдэн (26, 205), Элдэндэй Ардажав (8, 899), Иринчин (28, 270) нар цөм «илэ-йи» гэж зөв галигласан боловч харин үүнийг цөмөөр хүний тусгай нэр гэж үзэхгүй «илэ» «далд» гэдгийн «ил» гэдэг ерөнхий нэр гэж ташааран ойлгожээ. Нөгөө «Хада-ий» гэсэн үгийг мөн хүний нэр биш, харин «гада-йи» гэсэн үг гэж Хэниш (36, 55), Пеллио, Козин, Дашцэдэн, Баяр, Элдэндэй Ардажав, Иринчин бүгд «хада-йи» гэж бас ерөнхий нэрийн ёсоор бага үсгээр сэргээсэн байна. Харин Лигети (33, 209), Рахевильз (25, 164) нар «хадаа» гэж урт эгшигтэйгээр сэргээсэн байна.

Гэвч энэ хоёр үгийн хадмал орчуулга үгийн утгыг Хэниш «Илэ» гэснийг «үзтэл ил, нүдэн дээр, харин чиг» (36, 81) гэх мэтээр нөгөө Хада буюу Хадаа гэснийг «гадна тал» «гаднах» (36, 55) гэж тус тус тайлсан байв. Тэгээд энэ хоёр мөр шүлгийг Хэниш «Илийг нь ялж, гаднахыг нь нэвт цохьсон (цоолсон)» (15, 138) гэж, Поуха (33, 216), Калужинский (61, 180), Кливз (42, 213), Рахевильз (49, № 31, 1985, 29—30) нар ерөнхийдөө Хэнишийн орчуулгатай ойролцоо хөрвүүлсэн мэт санагдана. Тэдгээрийг Дамдинсүрэн «илийг ялж далдыг дарж байв» (7, 271), Дугаржав «Илийг ялж байв, гадна байхыг гардаж дарав би» (24, 203) гэж, Мансан «Илэ-йи би илажу Хада-йи би байлдав» (27, 330) гэж тус тус орчуулснаас сүүлчийн энэ орчуулга хамгийн зөв орчуулга болсноор зогссонгүй Мансан энэ хоёр үг бол Алтан улсын алдарт хоёр жанжин Илэ, Хада гэсэн хоёр хүний нэр гэдгийг заахын хамт Толуй тэднийг ялж хатгалдсан ч үнэн болохыг Нууц товчооны өөр газар дурдагдсан баримтаар магадлан тайлбарлажээ (27, 408—409, тайлбар № 26).

Элдэндэй Ардажав нар энэ үгийн Илэ гэдэг нь «ил дайсан гэсэн буюу» гэж заахын хамт Дорнотивийн орчуулгын тайлбарт «Алтан улсын алдарт баатар Илэбуха буюу» гэж тайлбарласныг дурдажээ. (8, 906—907, тайлбар № 29). Бас тайлбар № 30-д «илагба-илаба-илгуба (ялав)» гэ-

сэн үг гэж, тайлбар № 31-д мөн Дорнотивийн орчуулгын тайлбарыг **зааж** Хада гэдэг нь Алтан улсын монгол цэргийг эсэргүүцэн байлдах **цэргийн** ерөнхий ноён Ван йан Хада мөн бөгөөд Толуйд ялагдсаныг **нь** дурджээ (8, 907)

Бид Мансан Элдэндэй Ардажав нарын тайлбарыг эргэлзээгүй зөвд үзэж дэмжин тэр ёсоор сийрүүлэхийн хамт худам монгол бичигт «ялав» гэсэн үгийг «илагба» гэж бичиж байсны уг үндэс нь энэ үйл үгийн үндэс ила биш харин илагу-гэсэн өөр үг байсныг тэмдэглэх гэсэн билээ. Чухам ийм учраас хожмын хуучин монгол бичигт «ялсан цэрэг» гэхийн оронд «илагугсан цэрик» гэх эсвэл «илагулсун жанжин» гэх мэтээр бичдэг байсан нь «ялах» гэж одоогийн бидний хэлдэг үйл үг илаху гэдгээс өөр «илагуху» гэсэн үндэстэй үйл үг байсныг давхар гэрчилж байна. Жич ялав гэсэн үгийг бид хуучин монгол бичгээр «илаба» гэж бичдэг нь худам монгол бичгийн үүдэнээс буруу бөгөөд хэрэв «Бида илаба» (Бид ялав) гэж худам монгол бичгээр бичвэл тэр нь «Бид илэбэ» гэсэн өөр үгтэй хутгалдах байжээ.

674. бөгэс арга[ду]тхун (бөө нэр аргадагтун) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 8), Пеллио (9, 113), Лигети (38, 209), Рахевильз (25, 164), Баяр (11, III, 1385), Дашцэдэн (26, 205), Элдэндэй Ардажав (8, 899), Иринчин (8, 270) нар цөм «арбатхун» гэж сэргээн босгож сийрүүлсэн ажээ.

Энэ үгийн хадмал орчуулга-үгийн утгыг Хэниш «шид оршуулан шивших» (36, 8) гэж тайлсан ажээ. Тэгээд энэ үгийг Хэниш «залбарилаа уншигтун» (15, 138), Поуха (17, 216), Калужинский (61, 180), Кливз (42, 213), Рахевильз (49, № 31, 1985, 30) нар ерөнхийд нь «Бөө (илбэч, чалигч) нар аа залбарилая залбирч, шившлэгээ шившигтүн!» гэсэн ерөнхий чиглэлтэй үг хэлснээр орчуулсан шиг санагдана. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 271), Дугаржав (24, 253), Мансан «бөө нар тарнидагтун, зүхэгтүн» (27, 330) гэж тус тус орчуулсан байна. Элдэндэй Ардажав «арбатхун» гэснийг 1) илбэдэх, урьдаас мэдэх, төлгөдөх, яриагаар согтоох толгой эргүүлэх гэмших, 2) зөвлөлгөө өгөх, сануулах, 3) хараах зэмлэх, өгүүлэх илэрхийлэх, царай өнгө үзүүлэх, бурууштаах 4) булзах, хэлэлцэх, тохирох, бялдуучлах, зусардах, мэхлэх; 5) үлгэр ярих, зэрэг олон утгатай арба гэдэг түрэг үгээр тайлбарлаж монгол хэлний бөөч, уйгур хэлний арбагачи, манж хэлний байлиси цөм убидисчин илбэчи гэж таван хэлний толь заажээ.

Гэвч бид энэ үгийг ч уйгурын «арбатху» гэсэн үг биш, харин монгол хэлний «аргад[ат]хун» гэсэн үг гэж бодно. Учир нь нэгд монгол хэлний зарим үгэнд дэбэл ~ дэгэл гэх зэргээр ба-га авиа солигдсон гэж үзэх үндэстэй. Хоёрт Нууц товчоог зохион бичигч бөө гэдэг монгол үгээ хэрэглэсэн байтал «арбатху» гэж уйгур үг хэрэглэсэн байж болномгүй. Гуравт энэ арбатху ~ аргадад[хун] гэсэн хоёр үг бол монгол түрэг хоёр хэлтэн нэг хэлнээсээ нөгөө нь авсан ормол үг бус харин хоёр үндэстний хэлний адил нэг язгуураас хоёр өөр авианы бүрхүүлтэй болсон дундын үгийн хоёр өөр хэлбэр байх гэх үндэстэй. Нөгөө талаар бөөгийн энэ ид шидийн зүйлийг халхад «арга чарга» гэж холбоо үгээр хэлэлцдэг нь тохиолдлын хэрэг биш түүнээс гадна хуучин бичигт «чалиг» (онгон чалиг) гэдэг үгийг эрт цагийн худам монгол бичигт лав «чилиг» гэж бичиж байсан нь үнэн тул арга чарга гэдгийг «арга чирга», «чалм-а» (бөөгийн огтлох арга) гэж бичдэгийг «чилм-а» гэх зэргээр бичиж байсан байж тун болзошгүй тул энэ бүхэн нэг язгуурт үг байж таарна.

675. жүкэрүдкүн (зүхэрэгтүн) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш, Козин, Пеллио, Лигети, Рахевильз, Баяр, Дашцэдэн, Элдэндэй Ардажав, Иринчин, цөм «жүгэрүдкүн» гэж санал нэгтэй сэргээн сийрүүлдэг боловч Элдэндэй Ардажав нар энэ үгийг орчин цагийн монгол хэлний «харааж зүхэх» гэдэг үгтэй үүсэл язгуур нэгтэй гэж тайлбарласан (8, 907—908, тайлбар № 35) нь зөв зүйтэй тул «жүкэрүдкүн» гэж «жүкэкү» гэдэг үйл үгийн үндсэнд ойртуулан сэргээж сийрүүлсэн болно.

Жич энэ үгийн хажууд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш (36, 94) «өчил залбарил, шившлэг шивших» туйлын оновчтой тайлсан тул эрдэмтэд энэ утгаар ухаарч зөв орчуулсан буюу тайлбарласан юм. Үүнд Дамдинсүрэн «бөөлөн залбиригтун» (7, 271) гэж, Дугаржав мөн адилаар, Мансан «бөө нар тарнидан зүхэгтүн» (27, 330), Поуха (17, 216), Калужинский (61, 180), Кливз (42, 213), Рахевильз (49, № 31, 1985, 30) нар цөм Хэнишийн «өчил залбарч шившлэгээ шившигтүн» (15, 138) гэсэнтэй ойролцоо утгатай үгээр орчуулсан шиг санагдаг. Бид энэ бөө мөргөлийн мэргэ төлгө, өчил залбарил, арга чаргатай холбоотой «жүкэкү жүкэли жүкэрэкү» гэдэг үг монгол хэлний «жүк» (зүг) чигээ олох гэсэн үйл үгийн үндэснээс үүссэн болов уу гэж төсөөлөн таамагладаг билээ. Малчны жаал хүүхдүүд бид хээр төөрч зүгээ оло-

хоо болихлоор шүлсээ алган дээрээ дусаагаад **түүний** дээрээс **долоовор хуруугаараа цохиж** шүлс **аль** зүгт ихээр үсэрвэл тэр зүгт явдаг **нэг сонин заншил** байсан нь балчир хүүхэд **мэт** гэнэн цайлган сэтгэлт **нүүдэлчдийн** маш эртний итгэл биширлийн уламжлалтай зүйл байсан болов уу гэж боддогийн дээр амьтан жишээлбэл тэргэнд **хөллөсөн олон** шар үхэр биеийн хүчийг нэг зүг чигт хандуулахыг «житгүкү» **буюу** «жүктэкү» гэж хэлж байжээ гэдгийг бид «МНТ»-ы үг хэллэгээс **мэдэж** авсан билээ. Тэгвэл оюун сэтгэлийн бүхий л хүч чадлаа мөн сэрэл сэтгэлээр мэдэж үл болох юмыг мэдэж «чадахын зүгт хандуулж **өчил** залбирал хийхийг «жүкэрэкү жүклэкү» гэж хэлдэг байсан байхад үгүй гэх газаргүйн дээр аливаа үйлсэд гадагш явах хүн зүгээ **гаргах гэж шашин** мөргөлийн зан үйл байдаг зэргээс энэ «жүкэли, жүкэкү, жүкэрүдхүн» гэх мэт үгс цөм «жүк» буюу «зүг» гэдэг үгээс үүсч гарсан болов уу гэсэн таамаг бидэнд төрсөн билээ.

676. барад-а ойи-н-а күртэл (бэридийн хойно хүртэл) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 173), Лигети (33, 210), Рахевильз (25, 164), Козин (14, 314), Баяр (11, Ш, 1386), Дашцэдэн (26, 205), Элдэндэй Ардажав (8, 899), Иринчин (28, 270), Мостарт (47, [236]) цөм «Бэрүдэ», «бэрүдэ» гэж сийрүүлэн буулгасан бөгөөд гагцхүү Пеллио ондоогоор «баруда» (9, 113) гэж уг галиг эхэд байгаагаас нь өөрөөр сэргээжээ.

Энэ үгийг Иринчин зарим эрдэмтэд Толуйн эхнэрийн нэр гэснийг «итгүүштэй биш» (28, 271, тайлбар № 3) гэж эргэлзсэн байна. Энэ үгэнд хадмал хятад орчуулга үг байхгүйн дээр судлагчид Толуйн эхнэрийн нэр гэж үзэж хүний тусгай нэрийн ёсоор том үсгээр эхэлж тайлбарлалгүй бичсэн (Хэниш, Поуха, Козин, Мостарт, Кливз, Дамдинсүрэн, Дугаржав) байна. Гагцхүү Мансан «бяртай чадалтай ухаан **төхөөтэй** болтол» (27, 30) гэж өөрөөр орчуулснаас гадна Элдэндэй Ардажав **нар** түрэг хэлний «пэрдэ» гэдэг үгийн «урам, урам зориг, бах, санаа сэтгэлгээ, сэтгэлийн хөдөлгөөн, ааш зан байдал, шинж байдал гэх мэт шилжсэн утгаар хэрэглэгддэг үгийг түүнтэй ижил **ойролцоо утгатай** «ойина» гэсэн үгтэй хоршоо үг болгож шүлгийн толгой холбох зорилгоор хэрэглэжээ (8, 908, тайлбар № 40) гэж тайлбарласан нь төдий л үнэмшилтэй биш юм.

Бидний санахад энэ нь «барад-а ойи-н-а күртэл-э» гэж сэргээвэл зохих үгс бөгөөд нас «барах цагаа хүртэл» гэсэн утгатай үг мөн шиг байна. Учир нь нэгд, аав хүү, ах дүү, эсвэл «анд» хоёрын хэн түрүүлж үхэх ээлжтэй нь үлдэхдээ **энэ мэт** утгатай гэрээс үг хэлсэн жишээ «МНТ»-нд олон (Есүхэй баатар **авга** дүү Мэнгэлигт, Хуйилдар цэцэн Тэмүжин андадаа г.м) байна. Хоёрт, гэвэл энэ «Баруда» буюу «Бэрүдэ» эсвэл «барада» гэсэн үгс Толуйн эш хатны тусгай нэр биш, Учир нь «МНТ»-ы баттай мэдээгээр Толуйн авааль гэргий нь «Сурхагтани» буюу эсвэл «Сортагтани» гэдэг **өөр** нэртэй хүн байна. Эцэст нь «ойи» гэдэг үг ой ухаан дурдан санах чадвар гэх мэт олон утгатайгаас гадна бас он гэдэг хугацааны ухагдахууны ганц тооны хэлбэр юм. Ой гэгч жилийн аль нэг хэсгээс эхэлсэн цаг өнгөрсөөр дахиад дараах **оны** мөн сар **өдөрт** хүрч очих нэг жилийн хугацааг «ой» гэж нэрлэдэг тул нас барах тодорхойгүй хугацааг «ойи-н-а» гэж нэг жилийг хэмжих нэрээр хэлсэн байж болох юм. Эцэст нь зарим иймэрхүү гэрээслэлд хугацааг тодорхойлохдоо «уруг-ун уруг-а хүртэл-э» гэх мэтээр хэлсэн байх тул «бара-д-а ойин-а хүртэл-э» гэж энэ загвараар хэлж хугацааг тодорхойлсон гэрээсийн үг гэж болно.

677. Хара Күрмэ-д-э (Хар хүрэмд) — гэсэн энэ үгийг хятад галиг үсгийн галигаас нь Хэниш (36, 176), Пеллио (9, 113), Лигети (33, 210), Рахевильз (25, 165), Баяр (11, Ш, 1389), Дашцэдэн (26, 205), Элдэндэй Ардажав (8, 909), Иринчин (28, 271) нар цөм «Хара хорум» гэж сэргээснээс үзвэл XIV зууны үед хятад үсгээр галиглагчид уйгуржуулсан хэл аялгууны дагуу гажуу тэмдэглэснийг харуулж байна.

Энэ үгийг «МНТ»-нд ингэж түрэг хэлэнд ойртуулсан дуудлагаар «Қара Қорум» гэж тэмдэглэсний улмаас энэ үгийг монгол үг бус харин түрэг хэлнээс монгол хэлэнд орсон үг гэсэн үзлээр судлагчид үздэг болжээ. Энэ нь уг үгийг бусад бүх судлагч түрэгжсэн гажуу дуудлагаар нь Қара-Қорум гэж тэмдэглэсэн байхад ганц Дамдинсүрэн «Хара Күрм-э хота ду ирэжү багуба» (7, 272) гэж хуучин монгол бичигт тэмдэглэгдэн үлдсэн монгол уламжлалт бичлэгээр нь зөв сэргээн сийрүүлж орчуулсан байв.

Иймд бид Нууц товчоог анх бичиж үлдээсэн худам (язгуур эртний) монгол бичигт энэ үг түрэгжсэн «Хара Қорум» гэж бичээгүй орчин цагийн монгол хэлний гуйвуулагдсан дуудлагаар нь «Хар Хорин» гэж байгаагүй, харин хуучин монгол бичигт бичигдэж байсан уламжлалтай бичлэгээр нь «Қара Күрмэ-[д]-э» бичээстэй байснаар таамаглан сэргээж сийрүүлэв. Ингэж бичээстэй байсныг XIV зууны галиглагчид

«Кӯрмэ» гэсэн үгийн эцсийн «э» эгшиг нь суларч гээгдсэн дуудлагаар дуудан уншаад доор нь дагуулсан өгөх оршихын тийн ялгалын «э» нөхцөлтэй нийлүүлж тэдгээрийг салгах -д- гийгүүлэгч жийрэглэлгүй «Кӯрм[э]-э» гэж тэмдэглүүлсэн гэж бодно. «Кӯрм-э» (Хүрэм) гэдэг энэ үг бол жинхэнэ монгол үг гэдгийн гэрч болсон бөгөөд монгол хэлний утга зүйн үүднээс үндэстэй эртний дуудлага нь мөн. Учир нь Хара Хӯрм-э хотыг Өгэдэй хааны үед байгуулсан учир түүнийг түрэг хэлний үгээр бус, жинхэнэ монгол хэлний үгээр нэрлэсэн байж таарна. Хоёрт энэ хотыг Орхон голын хар хӯрмийн дэргэд байгуулсан тул энэ газрын нэрээр нь нэрлэсэн байж таарна. Гуравт гэвэл «Кӯрм-э» гэдэг монгол үг бол галт уулын халуун хайлмалаас хөрж царцаж тогтсон нүх сүвэрхэг барзгар хар буюу хүрэн чулууны нэр бэгөөд тийм чулууг хӯрмэн чулуу гэж одоо ч нэрлэдэг юм. Бас хүний цээжиндээ давхарлан дээлийн гадуур өмсөх богино дээлийг бас кӯрэм гэж нэрлэнэ. Энэ үг хуучин монгол бичгийн хэлний үгсийн санд «Кӯрм-э-хубчасу, агула-йин кӯрм-э» (12, 437а) гэж бүртгэгдсэн байна.

678. тобу чик[и]үд (том чихтэйнүүд) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 150), Пеллио (9, 114), Лигети (33, 210), Рахевильз (25, 165), Баяр (11, III, 1391) нар «тобича'ут» гэж Козин (14, 314), Дашцэдэн (26, 205) нар «тобичаут» буюу «тобичауд» гэж, Баяр (11, III, 1391), Элдэндэй Ардажав (8, 912), Иринчин (28, 272) нар «тобичаг-уд» гэж сэргээснээс үзвэл энэ үг хятад үсгийн галигт нэлээд гуйвуулагдсан ташаа дуудлагаар тэмдэглэгдсэн бололтой.
Энэ үгийн хажууд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш «Өрнө дахинаас авчирсан морь» гэж тайлсан байна.
Энэ учраас энэ үгийг Хэниш (15, 139), Поуха (17, 217), Калужинский (61, 180), Кливз (42, 215) нар «Тобича'ут морь» гэж, Рахевильз «Өрнөдийн (араб) морьд» (49, № 31, 1985, 30) гэж, Дамдинсүрэн «аргумаг морь» (7, 272), Дугаржав «тобичаг (томсог) морь» (24, 254), Мансан «тобичаг морь» гэж тус тус орчуулсан байна.

Энэ үгийг Мансан «тобичаг бол эртний Иракийн нутагт гарах нэг зүйлийн морь. Хас цагаан өнгөтэй, бугын биетэй, өндөр морь, монгол бичиг материалд «аргамаг тобучаг» гэж бий» (27, 410, тайлбар № 31) гэж сонирхолтой тайлбарлажээ. Элдэндэй Ардажав «түрэг хэлний топчак кэмээх нь 1) тарган бөгөөд сайхан морь; 2) бөөрөнхий утас адил юум, тойрог дугуй, цагираг төгрөг, бас баруун орноос ирсэн том морь» гэж тайлбарлаад «түрэг нутаг» ном заажээ. Мухаддимат тольд тобчак морин гэх нь араб морь болой. «Чинггис-үн йэкэ такилга-йин өчиг»-т «аргамаг тобучаг» кэмээх гэдэг үг байдаг гэж заагаад энэ үгийг «Өрнөд орны үүлдрийн морьд» (8, 914, тайлбар № 6) гэжээ.
Бидний санахад энэ нь түрэг хэлний «топчак» гэсэн үг биш, харин монгол хэлний «тобу чик[и]-уд» (тому чихтэйнүүд) гэсэн үг байх, Өнөөх түрэг хэлний «топчак» гэдэг нь харин эртний монгол хэлний тобу (тому) чик[и] гэдэг үгнээс уламжлан авсан үг байх гэж төсөөлөн бодно.

Учир нь нэгд монголын Нууц товчооны эхэд орчин цагийн монгол хэлэнд өргөн хэрэглэгддэг «том» хуучин бичигт «тому» гэж бичигддэг үг огт дайралддаггүй билээ. Энэ нь тэр үгийн «б» авиа нь «м» авиа болж хувираагүй хэвээр «тобу» гэж хэлэгддэг байснаас бидэнд танигдахгүй байжээ. Энэ үг чики-уд гэж ч-гээр эхэлсэн үгийн өмнө тохиолдохдоо «тобу» гэсэн үгийн хэлний хойгуурхи «у» эгшиг нь хэлний үзүүрийн «ч» гийгүүлэгчид татагдан «томи» гэж өөр дуудлагаар тэмдэглэгдсэн гэж бодох үндэстэй. Үүнд Элдэндэй Ардажав болон Мансан нарын иш татаж тайлбарласан «аргамаг тобучаг» гэсэн үг угтаа «тоби» биш «тобу» (тому) гэсэн үндэстэй байсныг давхар баталж байна. Сонирхолтой нь монголчууд сайн үүлдрийн том адууг «томсог» (тоомсог) гэж нэрлэдэг юм. Үүнийг Томск хотын нэрээр нэрлэсэн гэдэг боловч энэ нь «Томчик» гэдэг эртний нэрээрээ нэрлэсэн хэрэг байж болох юм. «Хулан чигигүд» гэдэг газрын нэрийг хятадын жуулчин Жан Дэ-Хойн «Хулан-чи-гин» өөрөөр хэлбэл «Улаан чики» гэдэг уулыг дайрч өнгөрсөн бөгөөд энэ уул улаан чихтэй төстэй учир тэгж нэрлэжээ» (110, 14) гэсэн тайлбар байдаг боловч энэ нь ийм нэртэй газар байхын дээр бас «хулан ба чигидэй» (хулан тахи) гэсэн амьтны нэр байдгийг няцаахгүй. Энэ мэт баримтаас үүсгэн төсөөлж энэ «тобичаг» гэсэн үгийг «тобу чик[и]-уд» гэсэн хоёр үг гэж ийнхүү сэргээн босгож сийрүүлэв.

679. тогус (?) (тогос) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш «да'ус(и)-» гэж сэргээгээд «хадмал хятад орчуулга үгүй, «тэмээний нэг зүйл болов уу?» (36, 33) гэж утгыг тайлжээ. Энэ үгийг Пеллио (9, 114), Лигети (33, 210), Рахевильз (25, 165), Баяр (11, III, 1391), Дашцэдэн (26, 205), Козин (14, 314) латин үсгээр «да'уси» буюу «даучи» гэж сэргээдэг бөгөөд Баяр, Элдэндэй Ардажав (8, 912), Иринчин (28, 272) нар хуучин (сонгодог) монгол бичгээр сэргээсэн нь «дагус-и ~ тагус-и» гэж ямар дуудлагаар бичсэнийг нарийвчлан ял-

гаж мэдэх аргагүй. Энэ үгийг Хэниш (15, 139), Поуха (17, 217), нар «да'ус үүлдэрийн кичидуд тэмээ» гэж, Рахевильз «арабын [ганц?] бөхтэй тэмээ(?)» (49, № 31, 1985, 30—31) гэж, Дамдинсүрэн «зэргийн юм» (7, 272) гэж тойрон өнгөрч, Дугаржав «хүрэнг эри йэн тохубчи тэй кичир бөкү тэй тэмэгэ» (24, 254) гэж, Мансан «хүрэнг эрүк тэмэгэ, дагус кичир тэмэгэ» (27, 381) гэж орчуулаад үүнийг онц тайлбарлалгүй «хүрэн эрүг тэмээ,тагус кичитү тэмээ» гэж давтан хэлэхийн хамт Нака түрэг үг ганц бөхөт тэмээ» гэсэн (27, 410, тайлбар № 32) тайлбар хийжээ. Элдэндэй Ардажав нар энэ үгийг түрэг уйгур тэбэ-гийн монгол дуудлагаар «да'у, дэ'ү та'у, тэ'ү» гэж дуудаж болох ба түүнд олон тооны с, мөн заахын тийн ялгалын «и» нөхцөл залгасан (8, 214, тайлбар № 7) гэж тайлбарласнаас гадна энэ үгийг Козин, Калужинский (61, 180) нар «тогос» гэсэн үгээр орчуулсан бололтой байх бөгөөд бидний бодлоор энэ нь зөв юм. Учир нь монголчууд эзлэн авсан өөр улсаас алттай артай торго, гоё сайхан морь мал, сувд танас зэрэг баян тансаг зүйл цуглуулж явуулахыг төлөөний түшмэл, даргач, тамгач нартаа тушаадаг байсан нь илэрхий бөгөөд өрнөдөөс зөвхөн олон зүйлийн тэмээ л авсан гэдэг нь эргэлзээтэй юм. Харин тогус бол их хааны ордыг чимэх нэг зүйл ховор гоёл тансагийн зүйл тул «дагус» гэдэг үг бол «тогус» гэдэг шувууны нэрийн ташаа галиглал мөн болохоос зайлахгүй мэт санагдана. Түүнээс гадна монгол манжийн феодалууд түшмэлийн зэрэг дэгийг хэдэн нүд хээтэй отго зүүснээр ялган хэлэлцдэг заншил хожим дэлгэрсэн тул Монголын эзэнт улсын үеэс эхэлсэн тогосын өд малгайдаа хадах заншлын илрэл болгож хараат улсаасаа тогос, түүний өдийг албадан гувчдаг байсан болов уу.

680. кичид-үд (анчин нохойн, сайн үүлдрийн ноходын эм нь) — гэсэн үг болов уу гэж бидний таамаглаж буй энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 101), Пеллио (9, 114), Лигети (33, 210), Рахевильз (25, 165), Баяр (11, III, 1391), Дашцэдэн (26, 205), Элдэндэй Ардажав (8, 912), Иринчин (28, 272) нар цөм «кичидүд» буюу эсвэл «кичид-үд» гэж нэг ижлээр сэргээн босгож сийрүүлсэн байна.

Энэ үгийн хажууд хадсан хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «хачит гэдгийн олон тооны хэлбэр, «да'уси»-тай нийлж «нэг зүйлийн тэмээ» (36, 101) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг тайлбар № 679-д «да'уси» гэдэг үгтэй нь хамтарсан хэн яаж орчуулсныг бид үүний өмнөх тайлбарт бичсэн тул энд хэмнэе.

Бид энэ үгийг нэг зүйлийн тэмээний нэр биш, харин ангийн олон зүйл үүлдрийн сайн угсааны ноходын гичий гэдэг үгийн олон тооны давхар нөхцөлтэй үг юм уу гэж өөрөөр төсөөлөн сийрүүлэв. Учир одоогийн бидний гичий гэдэг үгэнд олонт тооны «д» нөхцөл залгахад төгсгөлийн «й» гийгүүлэгч нь хасагдаж «кичид» гэж үүссэн байж болох нэг үүлдрийн кичид-ээс гадна өөр үүлдрийн кичидийг бас авчир гэсэн утга гаргахын тулд «кичид-үд» гэж давхар олон тооны нөхцөл залгасан байж болох юм.
Ингэж бодох үндэс нь хэдийгээр монголд олон тайган ноходтой анд гарах явдал өрнөдийн ангуучинтай харьцуулахад ховор байсан нь үнэн боловч Марко Пологийн өгүүллээс үзэхэд Хубилай хааны үед хааны авд гарахад олон нохой хэрэглэж байсан тухай (106, 107) дурдсан байдаг. Энэ нохойтой ан сонирхох явдал Өгэдэй хааны үеэс, өрнө зүгт харилцаатай болсоны үр дүнд олон янз үүлдрийн кичид-үд гаднаас авчруулах ажил эхэлсэн байж ч болох юм. Энэ бүхнийг бодож кичид-үд гэдэг нь тэмээний нэг зүйл бус анч тайган нохдын зүйл болов уу гэсэн таамаглал санал болгон тайлбарлав.

681. дөлүс кижү (гуйваж) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галиглалаас нь Хэниш (36, 37), Козин (14, 315), Пеллио (9, 114), Лигети (33, 212), Рахевильз (25, 166), Баяр (11, III, 1402), Дашцэдэн (26, 207), Элдэндэй Ардажав (8, 921), Иринчин (28, 212) нар цөм «дөлүсгүжүдөлүскүжү» гэж ижлээр сэргээн сийрүүлжээ.
Энэ үгэнд хийсэн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хэнд дулдуйдаж» «хэний үгийг соносч (дагаж)» (36, 37) гэж маш зөв тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 140), Поуха (17, 218) нар «хэний үгэнд уриалагдаж» гэж, Калужинский «хэний үгэнд дулдуйдаж» (61, 181), Кливз «Хэний үгийг сонсоод» (42, 216) гэж, Рахевильз «хэний ятгалгыг дагаж» (49, № 31, 1985, 32) гэж, Дамдинсүрэн (7, 273), Дугаржав (24, 255), Мансан (27, 382) нар «хэний үгэнд орж» гэж тус тус ерөнхийдөө цөм зөв зүйтэй орчуулжээ.

Элдэндэй Ардажав нар «энэ үгийн язгуур дөлү-дөлүрэкү гэмээх нь модон сав (хэрэгсэл)-ын уулзар (углагуур) салах, задрах, тасрах» гэж таван хэлний толь заан ондоо үгтэй хутгаж тайлбарлаад шилжсэн утга нь холдох, зайцах, тарах гэж ойлгожээ. Тус үг §177-д «дөлүсгэжү» §276-д «дөлүскүжү» гэмээн илэрдэг (8, 922, тайлбар № 2) гэжээ.
Бид энэ үгийн утгыг судлагчид зөв ойлгож орчуулсан боловч харин энэ

үгийг «дөлүскүжү ~ дөлүсгүжү» гэж сэргээх нь буруу бөгөөд монгол хэлний учир зүйд нийцэхгүй гэж үзэж энэ үгийг «дөлүс кижү» гэсэн хоёр үг гэж төсөөлөн тэр ёсоор сийрүүлэв. Учир нь энд «дөлүс кикү» гэсэн үг бол «түрэмгий» гэж нэрлэгдэж байгаа Гүюг (арслангийн зулзага) гэдэг хүний хийсэн үйл тул «дөлүсгэжү» (§177) буюу «дөлүсгүжү» (§276) гэж тусах үйл үгийн хэлбэрээр байж хэлний учир зүйд нийцэхгүй юм. Ун хаан Тэмүжин хүүгийнхээ утааг хажуу тийш гуйвуулж гэсэн утгаар §177-д гарсан тул шууд тусагдахуун (утааг) захирсан тусах үйл үг нь «дөлүс+гэ» гэж үйлдүүлэх хэвийн нөхцөлтэй хэрэглэгдэж болох учиртай. Гэтэл энд «хэний үгэнд» гэсэн шууд бус тусагдахуун авсан дөлүсгэхү буюу дөлүсгүкү гэдэг үйл үг үйлдүүлэх хэвийн нөхцөлтэй хэрэглэгдэж болохгүй юм. Иймээс энэ үг монгол хэлний учир зүйн үүднээс «дөлүсгэжү ~ дөлүсгүжү» гэсэн үйл байж таарахгүй тул тийм үг биш юм. Энэ нь харин «дөлүс» гэсэн байдлын дайвар үг урдаа авсан «кикү» гэдэг үг байж болох юм. Дөлүс гэдэг үг бол Элдэндэй Ардажав нарын ойлгосон шиг дөлүрэкү шантрах гэсэн утгатай үйл үг бус харин галын дөлү мэт салхины аясаар нүш тийш гуйвалзагч гэсэн утгатай дөлүс гэдэг өөр үг гэж бодож байна. «Хэний үгэнд дөлүс хийж» гэдэг нь хэний үгийн эрхэнд гуйваж, дайваж, татагдаж байна вэ? гэсэн утга гаргажээ.

682. Ганц өнтэгэн өгтүгэ үгүй-э (ганц өөнтөг өгтөө үгэй-[e]) гэсний сүүлчийн хоёр үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 79), Пеллио (9. 114), Лигети (33, 212), Рахевильз (25, 166) нар «hү'үтүгэй» гэж, Козин (14, 315), Дашцэдэн (26, 207) нар «hүүтүгэй» гэж, Баяр «hүүтүгэй-үүтүгэй» (11, III, 1403) Элдэндэй Ардажав (8, 921), Иринчин (28, 275) «үкүтүгэй» гэж тус тус олон янзаар сэргээснээс гадна нөгөө «өндэгэн» (36, 124) гэдэг үгийг цөм «д» авиагаар ганцхан Баяр «өнткэн» (11, III, 1403) латин үсгээр «т» авиатай сэргээснийг онцлон тэмдэглэе.

Энэ «hү'үтүгэй» гэсэн үгийн хажууд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш «үнэр орох, ялзрах» (36, 79) гэж тайлсан юм. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 140), Поуха (17, 218), Калужинский (61, 181), Кливз (42, 216), Рахевильз (49, № 31, 1985, 32), Дамдинсүрэн (7, 273), Дугаржав (24, 255), Мансан (27, 382) цөм «ганц өндөг ялзартугай, эсвэл ялзарчээ», «ялзарсан өндөг шиг хэвээр үлдэг!» гэх мэтээр орчуулсан байна. Энэ үгийг Элдэндэй Ардажав «үкүтүгэй», «hүкүтүгэй, үүтүгэй, кэмэкү нь үжирэтүгэй үмэкэйиртүгэй» (8, 922, тайлбар № 4) гэсэн үг гэж тайлбарлажээ.

Энэ бүх тайлбар орчуулга гагцхүү хятад үсгийн галиг ба хадмал хятад орчуулгын үүднээс л зөв мэт бодогдох боловч монгол хэлний найруулга, утга зохиолд юмыг дүрслэх уламжлал, утга зүйн үүднээс авч үзвэл энэ маш буруу бөгөөд ийм үг энд хэлэгдэх учиргүй шиг санагдана. Өөрөөр хэлбэл энэ үг утгын ямар ч авцалдаагүй болсон нь илэрхий мэт бодогдоно. Учир нь бүх монголчууд XIII зууны үед юм бүхнийг иддэг хүмүүс гэж зарим судлагчдын тэмдэглэгдсэн ч, харин шувууны өндөг идэж байсан тухай мэдээ байдаггүйгээс гадна хөдөө нутагт байгаа шувууны өндөг ялзардаг эсэх тухай ухагдахуун ч монгол аман зохиол утга зохиолд огт тохиолддоггүй билээ. Аргасун хорчийн домогт үр хүүхэд ар гэрийг нь «өндөг зулзага» гэсэн үгээр дохиолон ёгтолж хэлсэн ганц удаа байвч харин үр хүүхдийн авир төрх муудсаныг өндөг ялзарахтай зүйрлэн хэлэх уламжлал огт үгүй юм. Иймд бид энэ үгийг «ганц өнтэгэн өгтүг[э] [ү]гэй-[э]» гэсэн үг хятад үсгээр бууру тэмдэглэгдэж, тэгсэн учраас ч хожим хэдэн арван жилийн дараа хийгдсэн хадмал хятад галигт ташаа орчуулагдсан болов уу гэж бодож байна. Учир нь монгол хэлэнд «өнчин хүн өөнтөгч» гэдэг цэцэн үг байдаг. «Өөнтэг» гэдэг үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «өгэнтүгчи» (53, 442а) гэж бичдэг бөгөөд энэ үг «хүнээс өө эригч» гэсэн утгатай тул энэ үгийн язгуур I үндэс нь өө гэдэг үг болно. Энэ «өө» гэдэг үгийг хуучин (сонгодог) монгол бичигт «ө эрикүнагаху сэб эрикү» (12, 154а) гэж богино үеэр бичдэг уламжлалтай. Иймд энэ үгийг монгол хэлэнд урт эгшиг үүсээгүй, бас нэг үгийн эгшгүүд уруулаар зохицон ижилсэх ёс бий болоогүй байсан эрт язгуур цагт монголчуудын авч хэрэглэсэн худам монгол бичигт энэ үгийг «өнтэгчи» «өнтэгэн» гэж бичиж байсан гэдэг нь үнэмшилтэй билээ. Нууц товчооны худам монгол бичгийн эхэд «өнтэгэн» гэж бичсэнийг зуун тавиад жилийн хойно дуудан хэлж өгч галиглуулагч «өнтэгэн» гэсэн үгийг «өндэгэн» гэж эндүүрэн дуудах бүрэн үндэстэй. Учир нь худам болон хуучин монгол бичигт «т, д» авиа ижил зурлагатай юм. Нөгөө «өкүтү[гэ ү]гэй-[э]» (өгөгдөөгүй) гэсэн үгий галиглах үед зарим эгшиг ө, ү солигдох ба зарим эгшиг гийгүүлэгч нь хураагдан «өгтөөгүй-э» гэж өнөөгийн бидний хэлдэгтэй их л ойр дуудлагаар XIV зууны галиглагчид олон үгийг галигласан нь одоо огт эргэлзээгүй бол-

сон тул «өнгүтүгэ үгэй» гэсэн үг «өгүтүгэй» гэж гуйвуулагдан тэмдэглэгдсэн гэж бодох бүрэн үндэстэй юм.
Иймд бид эдгээр үгсийг «гагча өнтэгэн өкгүтүгэ үгэй-э» буюу ямар «ганц ч өө өгөгдөөгүйд» ах хүний өвчүүнд дайрхсан гэж зэмлэсэн үг гэж ийнхүү сэргээн сийрүүлж тайлбарлав.

683. мухиратугай (эргэж тойртугай) гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь судлагчид «мухуритугай» (36, 111) гэж нэг ижлээр сэргээж босгодог нь зөв ч байх. Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «эргүүл хийх» (36, 111) гэж тайлсан билээ. Энэ үгийг Хэниш (15, 142), Поуха (17, 220), Калужинский (61, 182), Кливз (42, 220), Рахевильз (49, № 31, 1985, 34), Дамдинсүрэн (7, 274), Дугаржав (24, 257), Мансан (27, 384) нар цөм «гэрийн хойгуур урдуур эргүүлд гартугай, сахитугай, манатугай» гэх мэтээр утгыг зөв чиглэлтэй орчуулж байжээ. Энэ үгийн жинхэнэ утга юу болох ямар үгнээс гарсныг Элдэндэй Ардажав хоёр «Буриад-монгол-орос» толь бичигт буй «өнхрөх мухуриху» гэдэг үгийн хөдлөх ахих эргэлдэх, гулгах, хальтрах гэх мэт утгатай холбож тайлбарласан нь төдий л үнэмшилтэй биш болжээ. Харин тэд Алаша нутгийн үгэнд «хаяа дүгэрэглэн явах, хонь, хотыг тойрон явахыг «мухурижу айбуна гэдэг» (8, 936, тайлбар № 6) гэсэн сүүлчийн тайлбар нь энэ үгийн жинхэнэ утгыг олж мэдэхэд ойртсон тайлбар болжээ.

Бид энэ үгийг «мухиратугай» гэж сэргээх нь зөв гэж үзэв. Учир нь мухури гэдэг үйл үгийн үндсэнд тойрох тахирлах гэсэн утга байхгүйн дээр мухур гэдэг нь тойрох гэсэн үгнээс бус харин «төгсгөл мохоол» гэсэн утгатай нэр үг тул түүнээс ганц «ий дагавараар үйл үг бүтээсэн гэж итгэхийн аргагүй юм. Гэтэл нөгөө «мухи» гэсэн язгуур буюу 1 үндэс нь «тахир мухир» (12, 559б) гэх мэт үгэнд үлдсэнээс гадна бас эхний «б» авиа нь «м» авиагаар сэлгэж амжаагүй бүр эртний дуудлагаараа хэвээр уламжлан ирсэн «бугир» (букир-мухир) гэх мэт үг ч монгол бичгийн хэлэнд үлдсэн байна. Жишээ нь нэг сангийн сударт:

«...Богда чаган эбүгэн
Бусиу (бушуу) бух-а хүлгэлэн
Бугир тайаг барижу...» (111, 1б) гэж бичжээ.

«Бугир тайаг» гэдэг тахир мухир таяг гэсэн утгатай нь ил байна. Иймд хуучин бичигт уламжлан ирсэн эдгээр үгийг худам монгол бичигт эдгээр үгийг яаж бичиж байсны уламжлалын гэрч гэж үзэж энэ үгийг «мухиратугай» гэж сийрүүлсэн бөгөөд зөв гэж бодно. «Мухуритугай» гэсэн нь XIV зууны монгол хэлний нэг нутгийн аялгууны дагуу ташаа тэмдэглэсэн зүйл гэж түүнээс өөрөөр сийрүүлэв.

684. чинад-а (цаана) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 24), Пеллио (9, 116), Лигети (33, 215), Рахевильз (25, 168), Баяр (11, III, 1424) нар энэ үгийг «ча'ада» гэж, Козин, Дашцэдэн (26, 210) нар «чаада» гэж, Баяр (11, Ш, 1424), Элдэндэй Ардажав (8, 939), Иринчин (28, 278) нар хуучин (сонгодог) монгол бичгээр «чагада ~ чахада» гэж сэргээсэн байна. Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «ойр шадар» (36, 24) гэсэн үг гэж тайлсан байна. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 142), Поуха (17, 221), Калужинский (61, 183), Кливз (42, 221), Рахевильз (49, № 31, 1985, 35) нар үүдчин, хэвтүүл, үүдний яг дэргэд, үүдэнд тулж зогстугай гэх утгаар орчуулсан шиг бодогдоно. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 275), Мансан (27, 385) нар «үргэлж» «сахиж байтугай» гэж Дугаржав (24, 259) энэ үгийг орхиж орчуулжээ. Элдэндэй Ардажав нар энэ үгийг «чаха-да» биенийн дагуу, дагах, дэргэд гэсэн үг гэсэн ба халхын аялгуунд захад гэж хэлдэг үг гэж тайлбарласан (8, 940, тайлбар № 29) нь хадмал хятад орчуулгын дагуу тайлсан мэт санагдана.

Бидний бодоход энэ үг «чих-а» буюу «жах-а-да» гэсэн үг бус, харин үүний «чинада» буюу үүдний «цаана» (гадаа) гэсэн үгийг хятад үсгийн галигчид уг худам монгол бичгийн эхээс дуудан өгч тэмдэглүүлсэн хүн бичгийн дагуу «чина-д-а» гэж дуудаж өгсөнгүй, бидний бодлоор тэр XIV зууны монгол хэл аялгуунд дуудаж байснаараа «чаада» гэж хэлсэн бололтой юм. Иймээс ча'а-да гэж хятад үсгийн галигт нь байгаа тул «бэйэ чих-а-да» гэсэн өөр үгтэй андуурагдан ойр шадар дэргэдийн хүн гэсэн утгатай үг гэж хадмал хятад орчуулга үгийг цэлээд хожим хадахдаа «чана-д-а» гэсэн үг гэж танилгүй, харин «чагада», «чиха-да» гэсэн үг гэж буруу ташаа тайлбарласан бололтой байна. Учир нь хэвтүүл буюу шөнийн манаа бол хааны бие чих-а (эрхэм хайрт алтан амь) гэсэн үнэлгээ авахаар тийм дотно шадар хүн нь бус, адаглаад л үүдчин хэвтүүл бол хаалганы гадна талд хааны ордонд хүн оруулахгүйн тулд тавигдсан төрийн цагдаа байсан тул үүдний «ойр шадар» зогсохыг заасан эрхэмсэг бие хүн чих-а бус, харин үүдний чина-д-а үүдийг нохой мэт үнэнч сахих хатуу албаны үнэнэ

зарц өмч нь мөн гэдгийн үүднээс ингэж «чана-д-а» гэж сэргээсэн болно. Энэ үгийн дуудлага одоогоос зургаан зуун жилийн өмнө и-гийн хувирал (нугарал) нь явгдаж өнгөрөөд гагцхүү «ча» авиа нь халхын аялгууны адил «ца» болж хараахан амжаагүй байсан тул «ча'ада» (цаад буюу чаада) гэсэн дуудлагатай болчихсон байсныг гэрчлэх мэт байна. Ча'ада (цаад) гэсэн хоёр үгийн дундах чухам ямар гийгүүлэгч сугарч хоцорсныг судлагчид тулгуурлан мэдэлгүй урт эгшиг үүсэхэд «га» гэсэн үеийн «г» нь сугарсан гэж төсөөлөн хоёр а'а үсгийн хооронд «х, г» гийгүүлэгч оруулж сэргээснээс энэ чаада (цаад гэсэн үг «чига» буюу «чих-а» гэсэн үгтэй язгуур, гарал, үүсэл, утгаараа холбогдолгүй шал өөр үгстэй адил бичлэгтэй болж ийнхүү андуурагдсан гэж бодоод ийнхүү өөрөөр сийрүүлж түүнийхээ учрыг энд цухас тайлбарлав.

685. сагахун сагали(-и)чин тан и, адугулахуд нунтагчин тан-и (саах сааль-чин таныг адуулах хүмүүс нутагчин таныг) гэсэн эдгээр холбоо үгсийн дотроос «адугулахуд» гэсэн үгийг Хэниш (36, 3), Пеллио (9, 118), Лигети (33, 218), Рахевильз (25, 171) нар «са'аринчинтан-и (са'ари-нчи(н)тан-и, са'арин(чин тан-и) аду'ула'ат» гэж, Дашцэдэн (саалинчин тани адуулаад» (26, 212) гэж, Баяр (11, III, 1441), Элдэндэй Ардажав (8, 947), Иринчин (28, 283) нар «сагаличин тан и адугулагад нунтугчин тан-и» гэж тус тус сэргээсэн байна.

Гэвч «сааль чныг адугулагад» гэсэн холбоо үг монгол хэлний учир зүйд нийцэмгүй зүйл болсноос хадмал хятад орчуулгын-үгийн утгыг Хэниш тайлбарлалгүй өөр зүйлд гарах ижил үгийн утгыг заасан байв. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 145), Поуха (17, 224) нар «сааль-чидын талаар санаа тавихыг даатгаж» гэж, Кливз (42, 224), Мансан (27, 387) нар «саальчдаар саалийн гүүгээ адуулуулж» гэх буюу сааль-чинд саалийн гүүний сүрэгтэй болгож» гэх зэргээр ухааруч, Рахевильз «гүү саагчидыг орон гэртээ болгож» (49, № 31, 1985, 39) гэж, харин Дамдинсүрэн (7, 277), Дугаржав (24, 260) нар «мөн саах саальчин, адуулах нутагчныг томилж» гэж их бүтээлчээр орчуулсан байна.

Бидний бодоход «саальчин тан-и адуулаху» гэсэн үг энэ хэлбэржлээ-рээ монгол хэлний зүйд нийцэмгүй зүйл болох нь илэрхий, учир нь «хоннийг адуулах» гэвэл хонийг хариулах гэсэн утга гаргаж болно. Гэ-тэл «саали(н)чин тан-и адугулагад» гэдэг бол саальчин нь адуу буюу мал биш учраас учир зүйн үүднээс энэ «адугулагад» гэсэн үгэнд заа-хын тийн ялгалын нөхцөлөөр шууд захирагдсан тусгдахуун гишүүн байж үл болно.

Энэ учраас бид худам монгол бичгээр «адугулахуд нунтагчин тан-и» гэдгийн хойтох нутагчин гэдэг үгийн тан (ту, тай гэдэг харьцангуй нэрийн олон тоотой зохицсон олон тооны -хун төгсгөл бүхий үйлт нэ-рийн хэлбэртэй үг байсныг дуудаж галиглуулагч нэг ацаг илүү бичигд-сэнээр эндүүрч «адугулагад» гэж ташаа тэмдэглүүлсэн гэж бодож байна. Хэрэв «сагалинчин тан» гэдэг үг нь заахын тийн ялгалд тэмдэг-лэгдсэн бол энэ холбоо үг «сааль чин тан адуутай болоод» гэсэн өөр утга гаргасан үг байж болох байв. Жишээ нь «Энэ айил тараглагад (тараг бүрж тарагтай болоод) удаагүй» гэсэн загвараар хэлсэн байж болох байжээ. Иймд бид «адугулахуд нутагчин тан-и» гэсэн Дамдин-сүрэн нарын орчуулгыг илүү учир зүйд нийцнэ гэж ийнхүү сийрүүлсэн болно. Энэ тохиолдолд «сагали(н)чин тан-и, нутагчин тан-и» гэсэн заах тийн ялгалаар холбогдсон хоёр тусгдахуун гишүүн зэрэгцэн бичигдсэн гэх үндэстэй болно.

686. санг-уд төсүрчү (сангуудыг төлөвлөн байгуулж) гэсэн энэ холбоо үгийг Хэниш (36, 25; 36, 156), Пеллио (9, 118), Козин (14, 319), Эл-дэндэй Ардажав (8, 947) нар «чанг-ут түсүрчү» гэж, Лигети (33, 218), Рахевильз (25, 171), Баяр (11, III, 1442), Дашцэдэн (26, 213), Ирин-чин (28, 282) нар «санг-уд» гэж хоёр янзаар сэргээн босгодог байна. «Чанг» буюу «санг» гэсэн үгийн хажуугийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «дэлгүүр, агуулах, гэйид» гэж таалсан юм. Нөгөө «түсүркү» гэсэн үгийг нь «хувиарлах тараах» гэсэн үгээр орчуулан тайлсан юм.

Тэгээд энэ үгийг Хэниш (15, 145), Поуха (17, 224), Калужинский (61, 185), Кливз (42, 224), Рахевильз нар «дэлгүүр, агуулах, нөөцийн гэр байгуулж» гэж, Дамдинсүрэн «байисин зогорин ду хадагалажу» (7, 277), Дугаржав «санг көмүргэ-йи дүгүргэжү» (24, 260), Мансан «санг көмүргэ дү оруулун» (27, 387) гэж тус тус орчуулж бас Элдэндэй Ардажав нар энэ үгийг «чаанг» гэдэг хятад үгтэй тохирч буй «санг, санг күү, санг көмүргэ» гэх мэт үгийн адил утгатай хадгалах гэр, ба-раа хураах гэр гэх зэрэг олон утгатай (8, 954, тайлбар № 16) гэж нөгөө түсүрчү-цутгах юүлэх зэргийг хэлдэг түсүргэ гэдэгтэй утга яз-гуур нэгтэйгээр мөн тэнд тайлбарласан нь аанай л хадмал хятад ор-чуулгыг дагасан тайлбар юм.

Бидний бодвол хэрэв «чанг» гэдэг нь тэрхүү агуулахад хадгалах нэг юмны нэр бол «түсүрчү» гэдэг нь «тараах түгээх» гэдэг утгатай үг байж болох боловч харин «чанг» гэдэг нь «санг» (хөмүргэ) гэсэн үг мөн бол нөгөө «түсүрчү» гэдэг үг нь юүлэх, түгээх гэсэн утгатай үг байж таарахгүй болов уу. Иймд бид энэ үгийг «санг төсүрчү» гэсэн холбоо үг байх гэж бодож байна. Учир нь энэ төсүрчү гэдгийн үндэс төс гэдэг үгнээс төсүгэ (адил тал), төсүгэлэл (байхгүй зүйлийг санаанд байгаагаар төлөвлөн бодох гэсэн ухагдахуун), шинэ цагийн монгол хэлэнд хэрэглэгдэх болсон төсүл (бүтээгүй зүйлийн урьдчилан гаргасан төлөвлөгөө) гэх зэрэг олон үгтэй язгуур гарал нэгтэй, утга ойролцоо үг мөн юм. Иймд «санг-уд төсүрчү» гэвэл санггуд урьдаас төсөвлөж төлөвлөн байгуулах гэсэн утга гаргаж болно гэж бодож байна. Иймд энэ үгийг «төсүрчү» гэж ө эгшигт үеэр сийрүүлэх нь «юүлэх» гэсэн утгатай «түсүрчү» гэж хятад үсгээр галигласан нь аман аялгууны буруу тэмдэглэл мөн гэж төсөөлөн бодож байна.

687. илэгү тэй буй (илүүтэй бий) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галиглалаас нь Хэниш (36, 82), Қозин (14, 319), Пеллио (9, 119), Лигети (33, 219), Рахевильз (25, 172), Баяр (11, III, 1452), Элдэндэй Ардажав (8, 959), Дашцэдэн (26, 214), Иринчин (28, 284) нар цөм «[илүбтэ] ∼ илүб-тэ [би], буи» гэж сэргээн сийрүүлэв.
Энэ үгийн хажуугийн хадмал хятад орчуулга-үгийн утгыг Хэниш «аятай, тустай» (36, 82) гэж тайлжээ.

Тэгээд энэ үгийг Хэниш (15, 146), Поуха (17, 225), Қалужинский (61, 186) нар элчний ажлыг «хөнгөвчилсөн» гэж, Қливз (42, 226), Рахевильз (49, № 31, 1985, 40) нар «аятай, таатай, их таатай» гэж, Дамдинсүрэн (7, 278), Дугаржав (24, 261), Мансан (27, 388) нар цөм элчинд буюу зам харилцаанд «дөхөмтэй» болов гэж тус тус орчуулснаас гадна Элдэндэй Ардажав энэ үгийг «Хуа-и-и-июй» тольд илдар, ташрам, далим, дөхмийг «илубда» гэв (8, 961, тайлбар № 6).

Бидний санавал энэ үг «илүб-тэ» гэсэн үг хараахан биш, харин «илэгү-тэй» (илүү сайн) гэсэн үг мөн болов уу. Учир нь энэ үг «илдар-а» гэсэн үгнээс гаралтай нэг үндэстэй байсан бол «илү» гэж бичигдэмгүйн дээр «илэгү-тэй» (давуу тай) гэсэн утгатай үг байх найруулга зүйн чадамжтай юм. Учир нь хуучин (сонгодог) монгол бичигт ялдар гэдэг үгийн «йабуху-йин илдара» гэх мэтээр ямагт харьяалах тийн ялгалын нөхцөлтэй үйлт нэрийг өмнөө авч захирдаг уламжлалтай. Харин энэ илэгү (илүү) бэрх, хялбар гэх мэт тэмдэг нэр бол өмнөө гол төлөв өгөх оршихын тийн ялгалт үг авч захирах нь цөөнгүй. («Олхуй-а бэркэ», «ном сурахдаа сайн», «усанд гарамгай» гэх мэт) Иймд энэ «йабухуй-а» гэсэн үгийн дараа үйл үгээс үүссэн илэ+гү+тэй гэсэн тэмдэг нэр орж бичигдсэн байх гэж бодох үндэстэй юм. «Илэгү» гэсэн худам монгол бичгийн үгийг XIV зууны үеийн монгол хүн дуудахдаа бараг орчин цагийн халхчуудын хэлдэг шиг «илүүтэй» гэж дуудан хэлж өгснийг ил+гэсэн үеийн дараах «үү» авиа нь үгийн дундах балархайшсан буюу хөндий дуудагдах болсон в-б авнатай адил сонстсон учир ингэж «илүб-тэ» гэж тащаа галигласан гэж таамаглаж байна. Иймд бид энэ үгийг «илэгү тэй» гэж сэргээсэн учраа энд тэмдэглэе.

688. өрэгэл-ийэр (өрөөлөөр) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 126), Қозин (14, 319), Пеллио (9, 119) Лигети (33, 220), Баяр (11, III, 1456), Дашцэдэн (26, 214), Элдэндэй Ардажав нар (8, 959), Иринчин (28, 284) нар цөм «ургул-ийар» гэж сэргээж ирсэн боловч энэ үгэнд хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «толгой (?)», «шилээр нь тэгшлэх» (36, 126) гэж тайлжээ.

Энэ үгийг Хэниш «хүзүүгээр нь таллах мэт эд юмын торгуульд унана» (15, 146—147) гэж, Қозин «нэг уруулаа алдана» (14, 198) гэж орчуулсныг «энэ бол эхээс хамаагүй хол хөндий орчуулга» гэж Мостарт (47, [147] (147 дугаар зүүлтийн үргэлжлэлд) хэлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш уруулыг огтлох цавчих гэсэн үг бус харин «хүзүүгээр нь таллах мэт юмыг хагаслан хураах» гэж ойлгосныг дурдаад хөрөнгө хогшлын нь талыг хурааж торгох (47, [150—152]) гэсэн утгатайг тайлбарлажээ. Хожим Мансан (27, 389) Мостартын адилаар орчуулаад энэ үгийг Элдэндэй Оюундалай нарын тайлбарласны дагуу ойлгож орчуулснаа (27, 412—413, XII бүлгийн тайлбар № 46) тайлбарласан юм. Дамдинсүрэн (7, 279), Дугаржав (24, 262) нар Қозины адил уруулыг буюу хамрыг огтол гэж алдаатай орчуулжээ.

Энэ үгийг Элдэндэй Ардажав нар «өр го(о)л-ийар» гэсэн үг гэж дэлгэрэнгүй тайлбар (8, 963—965, тайлбар № 14) хийж түүнд Зөвлөлтийн болон Японы эрдэмтэдийн алдаатай ташаа орчуулсныг заасан байв. Гэвч өмч хөрөнгийн тэн хагасыг алдах ял хүлээнэ гэсэн утгаар тайлбарлав.
Эцэст нь Америкийн талийгаач эрдэмтэн Хангины Гомбожав «Өвөр Монголын багшийн их сургуулийн «Монголын нууц товчооны» олон

улсын эрдэм шинжилгээний ярилцах хурал»-д тавьсан илтгэлдээ Элдэндэй нарын энэ үгийг «өргөл» гэсэн үг мөн байх гэхийн хамтаар хагас алдалтан болох шалтгааныг Өгэдэй хааны зарлигт өртөө байгуулах ажлыг Арачан, Тохучар хоёр хүнээр хариуцуулсан тухай дурдсан тул уг горгуулийг хоёр ноён тэнцүүхэн хувааж хүлээнэ гэсэн утгатай (84, 21—22) гэж тайлбарлав.

Бид энэ үгийг Элдэндэй Ардажав нарын тайлбарласан шиг «өр[э]го(о)л-ийар» гэсэн хоёр үг байсан байж болно гэж бодохын хамт «өрэгэл-ийэр» (өрөөлөөр) гэсэн үг XIV зууны хүний аман аялгууны дуудлагаар ташаа тэмдэглэгдсэн байж бас болох бус уу гэсэн нэг санал сэдлэг нэмж хэлэх гэсэн юм. Ингэж бодох нэг үндэс гэвэл монгол хэлэнд хуучин монгол бичгээр өрү (худам монгол бичгээр бидний төсөөлснөөр «өрэ» гэж бичигдэг байсан болов уу гэмээр) гэдэг үг худам ба хуучин монгол бичгээр адилхан «го[о]л» гэж ялгах эгшиггэй бичигдэг агсан «гол» гэсэн хоёр үг бараг адил утгатай тул нөгөөд нь «хагас» гэж ганц үг хэрэглээд өөр нэг мөрд нь «өр(э)го(о)л» гэж хоёр үг хэрэглсэн гэхэд шүлгийн хэмнэл айзмын хувьд тохиромгүй юм.

Жич «хонины хагас мах» гэвэл хонины цээж буюу бөгс махны аль нь ч байж болно. Гэтэл «өрүгэл» (худам монгол бичгээр «өрэгэл») мах гэвэл хонины гулдмай махны уртааш хуваасны өрөөсөн талын мах гэсэн утгатай болно. Иймд энэ үг «өр[э]-го(о)л» гэсэн хоёр үг биш «өрэгэл-ийэр» хагас алдалтан гэсэн үг байсныг XIV зууны хүний нэг аялгууны дуудлагаар алдаатай сэргээсэн гэж бодогдоно. Тэгэхдээ энэ бол хөрөнгө торгуулийг хувааж төлнө гэсэн үг бус харин энэ ажлыг дутуу буруу хийлгэсний ял зэмлэл хариуцлагыг удирдан байгаа Арачийан, Тохучар гэдэг хоёр хүнд тэнцүү оногдоно гэсэн утгатай үг гэж ойлгож байна.

689. хихасулаху (хяхаслан хөнөөх) — гэсэн энэ үгийг хятад үсгийн галигаас нь Хэниш (36, 97), Козин (14, 319), Пеллио (9, 119), Лигети (33, 221), Рахевильз (25, 173), Баяр (11, III. 1463), Дашцэдэн (24, 215), Элдэндэй Ардажав (8, 967), Иринчин (28, 285) нар цөм «кэгэсүлэкү» гэж сэргээн сийрүүлсэн байна. Энэ үгийн хадмал хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хувийн дайсагналаар хүнийг далдуур хорлох хөнөөх» (36, 97) гэж тайлжээ.

Тэгээд энэ үгийг Хэниш «алуулах» (15, 147) гэж, Поуха (17, 226), Калужинский (61, 187), Кливз (61, 228), Рахевильз (49, № 31, 1985, 42) нар ерөнхийдөө «хөнөөх, хорлох, нууцаар хорлох» гэх мэт ерөнхийдөө Хэнишийнхтэй төстэй орчуулжээ.

Энэ үгийг Дамдинсүрэн (7, 279), Дугаржав (24, 262) нар «далдаас хардсан» гэж, Мансан «нууцаар хорлосон» (27, 390) гэж тус тус орчуулжээ. Энэ бол Элдэндэй Ардажав нар энэ үгийг Мансаны адилаар «далдуур хорлох» гэсэн үг гэж тайлбарлажээ (8, 969, тайлбар № 11). Тэгэвч энэ үг чухам ямар үгнээс үүсэл гаралтай, ямар үг болохыг судлагчид сайтар тодорхойлж бичээгүй юм. Бид энэ үгийн үндэс болсон «кэкэсү» гэдэг үгийг «кихасу» (тайлбар № 201) гэсэн үгийн ташаа галиглал гэж үзсэн бөгөөд энэ «кэкэсүлэкү» гэгч «кихасулаху» гэсэн үүсмэл үйл үг болов уу гэж сананам. Нууц товчооны хятад үсгийн галигт эр үгийг эм эгшиггэй болгож XIV зууны монгол хэлний ээглэх үүглэх аялгуу зонхилож тэмдэглэгдсэн хандлага илэрсэн байдаг жишээ нь «умар ача» гэхийг «өмөр-эчэ» гэх, «ороҳаху» гэхийг «эмөрэкү» гэх зэргээр тэмдэглэсэн баримт олсн тул «кигэсү» (тэргэний дугуйн «кэгэсү» гэж «кихасулаху» гэхийг «кэгэсүлэкү» гэх мэтээр ташаа тэмдэглэсэн байж болох юм. Эсвэл энэ «кэгэсүлэкү» гэдэг нь «кихасулаху» гэдэг үгийн ойролцоо утгатай өөр утгатай өөр дуудлагатай хувилбар үг байгаад бичгийн хэлэнд хожим хуучран мартагдаж, а о у дуудлагатай хувилбар нь уламжилж ирсэн байж ч болно.

690. кэбэсү (гэвэл) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг үсгийн галигаас нь Хэниш (36, 96) «кэ'э'эсү=кээ'эсү» гэж сэргээгээд «онцлон тэмдэглэвэл» гэсэн утгатай гэж тайлжээ.

Энэ үгийг Пеллио (9, 119) «кэ'эсү» гэж, Дашцэдэн «кээсү» (26, 215) гэж, Лигети (33, 221). Рахевильз (25, 173) нар «кэ'эсү» гэж, Баяр хуучин монгол бичгээр «кэбэл» (11, III, 1462) гэж, Элдэндэй Ардажав (8, 967), Иринчин (28, 286) нар «кэмэсү» гэж элдэв янзаар сэргээсэн байна.

Энэ үгийг Хэниш «асуувал» (15, 147), Поуха (17, 226), Калужинский (61, 187), Кливз (42, 228), Рахевильз (49, № 31, 1985. 42) нар их төлөв «гэж, хүн асуувал, хэлбэл, яагаад гэж хэлбэл» гэх мэтээр орчуулсан шиг бодогдоно. Энэ үгийг Дамдинсүрэн (7, 279) Элдэндэй Ардажав (8, 967), Иринчин (28, 286) нар «кэмэбэсү» гэж, Дугаржав (24, 262), Мансан (27, 390), Баяр (11, III, 1462) нар «гэбэл» «кэбэсү» гэж хуучин (сонгодог) монгол бичгээр сэргээсэн буюу орчуулсан байна.

Бид энэ үгийг «кэбэсү» гэж худам (язгуур эртний) монгол бичгээр сэргээхийг зөв гэж бодно. Учир нь бидний бодоход худам монгол бичигт кэхү гэдэг кэлэкү гэдэг үгийн язгуур I үндэс болсон үйл үг байсан бөгөөд одоогийн монгол хэлэнд хожим «гэх» язгуурт үйл үг болжээ. Энэ үйл үгийг худам монгол бичигт «кэ» гэж задгай үеэр бичдэг байсан тул задгай үеийн төгсгөлийн эгшиг үгийн эцэст ямагт уртаар дуудагддаг монгол хэлний нэг жамаар энэ үгийг хуучин монгол бичигт кэмэ гэдэг «тэ» үеэр уртыг тэмдэглэх болсноор «кэбэсү» гэж худам монгол бичигт бичиж байсныг «кэмэбэсү» гэж хуучин монгол бичигт бичдэг болсон гэж бид төсөөлөн бодож байна. Бас кэ үйл үгэнд -лэ дагавар залгаж «кэлэ» гэдэг хэлэх ярих эрхтний нэрийг бүтээж улмаар кэ язгуурын «кэлэх» гэсэн утга нь мартагдаж ирэхэд «кэлэ» гэсэн нэр үгэнд дахин «лэ» (нэр үгээс үйл үг бүтээх дагавар залгаж «кэлэлэкү» (хэлэх) гэсэн утгатай шинэ үг бүтээжээ. Гэвч хожим хэлэгдэг нэр үгийн төгсгөлд орсон э эгшиг лэ гэсэн дагаврын өмнө орохдоо суларч балархайшин сонстохгүй болж хоёр талын л авиа нь урт үргэлжлэх дуудлагатай «ганц» л авиа болж «хэлэ» гэдэг нь хэлэх эрхтний нэрээс гадна хэлэх гэдэг үйл үгийн шинэ үндэс болжээ. Нөгөө кэлэх гэдэг утгатай анхны кэ нь гэ дуудлагатай болж улмаар эзэн биегүй «кэлэх» ерөнхий үйл үг, эсвэл өгүүлбэрийг холбох гэүндэст холбоос үгийн үүрэг ч гүйцэтгэх болж нөгөө кэлэкү гэсэн үүсмэл үйл үг нь хүний хэлсэн тодорхой эзэн биенйн үйлийг тэмдэглэсэн үг болсон гэж бодном. Гэвч гэ- язгуурт үг ярианы хэлэнд эл хуучин утгаа мөн хадгалж байна.

691. Йэкэ хурил-да(ган)дур-ийан хурижу (Их хуралдаа хуран цуглаж) — гэсэн энэ үгийг хятад тэмдэг-үсгийн галигаас нь Хэниш «Хурил(та)» (36, 72) гэж Пеллио (9, 120), Мостарт (47, [258]), Лигети (33, 221), Рахевильз (25, 174) нар цөм «Йэкэ хурил-та хурижу» гэж Баяр (11, III, 1466), Дашцэдэн (26, 216), Элдэндэй Ардажав (8, 972), Иринчин (28, 286)нар «Йэкэ хуралда (эсвэл хурил-да) хурижу» гэж тус тус сэргээн босгосон байна.

Энэ «хурилда» гэдэг үгийн хажууд хадсан хятад орчуулга үгийн утгыг Хэниш «хурал» (36, 72) гэж тайлжээ. Тэгээд энэ үгийг Хэниш (15, 148), Поуха (17, 227), Калужинский (61, 188), «Эзэнт улсын Их хурал хуралдсан газар» гэж, Козин (14, 199) Дамдинсүрэн (7, 280), Дугаржав (24, 263), Мансан (27, 390), Элдэндэй Ардажав (8, 972), тайлбар № 1), Иринчин (28, 286) нар цөм «Их хуралдаан (хурилда) болж, хураж, хуралдаж байх цагт» гэж ухаарч, нөгөө Мостарт (47, [262]), Рахевильз (49, № 31, 1985, 43) нар «Их хуралд цугларсан үед» гэж тус тус ойлгож орчуулсан байна. Товчоор хэлбэл судлагчид цөм энэ зохиолыг Их хурал хуралдаж байх үед буюу эсвэл хуралдаж байсан газар бичиж дуусан гэж ойлгодог хэвшил тогтжээ. «Йэкэ хурилта» буюу «Хурилда» гэж «Хуралтай» гэж засгийн эрх барих улсын дээд хурлыг хэлдэг нэр томьёо гэж гадаад дотоодын түүхч эрдэмтэд үзэж энэ үг шинжлэх ухааны нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр томьёо мөн гэсэн ташаа ухагдахуун судлагчдын хүрээнд бат төлөвшсөн юм.

Бид энэ үгийг «Йэкэ хурил-да хурижу» гэсэн үгийг «Их хурал буюу Хурилтай» гэгч болж, эсвэл тэр хуралд Чингисийн алтан ургийнхан хуран цугларчихсан, товчилбол Их хурал болж байх буюу эхэлчихсэн үед бичиж дуусгасан гэсэн үг биш, харин Их хурил хуралдаа хан хөвгүүд ноёд хурин цугларч «бүхүй» үед Ордос Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог ба Шилихэнцэг гэдэг нэртэй хоёр гаврын хооронд бууж «бүхүй» үед хулгана жил (1228 онд) хуран (бороoны сар 7 дугаар сарын хоридоос хойш 8 дугаар сарын хорьд хүртэл) сард бичиж дуусан гэсэн утгатай гэж таамаглаж байна. Учир нь, нэгд «хурижу» гэсэн үйл үг нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөлтэй байгаа учир дараа гарч буй «багужу» гэдэгтэй зэрэгцэн болж буй үйлийг тэмдэглэхийн хамт түүний араас орсон «бүхүй» гэсэн үйлт нэрийн одоо цагийн хэлбэртэй шийлж энэ үйл үг үргэлжилж буй дуусаагүй үйлийн байдлыг илтгэх тул «хуралд цугларан ирж байгаа («бүхүй») үед бас ордос дурдсан цагт бууж байгаа («бүхүй») цагт энэ зохиолыг бичиж дуусан гэдгийг нотолж байна. Иймээс Их хуралдаан болж байхад биш, харин «хурал-дур-ийэн хурижу» (цугларч) бүхүйд гэсэн өөр утга гаргаж байгаа нь баттай. Хоёрт, «Их хурил хурижу» байхад зохиолыг бичиж дуусгасан гэвэл дурдсан газарт Ордос бууж бүхүйд бичсэн гэдэгтэй учир зүйн авцалдаагүй болж байна. Учир нь ордосоо бууж дуусаагүй байхад Их хуралдаан нь хаана (ордонд биш, хээр) болж байсан юу? гэдэг асуулт гарна. Гуравт, Монголын нууц товчоог бичсэн хулгана жил бол Чингис хааныг нас барсны дараах 1228 оны хулгана жил байсан гэсэн Рахевильзын саналын зөв болохыг харуулна. Учир нь энэ онд «Йэкэ хурил-да (Алтан ургийн хан хөвгүүд ноёд алс Европ, дундад Ази, Иран персээс) хурижу» (цугларч) байх үед Ордос

Хэрлэн мөрний Хөдөө арлын Долоон болдог, Шилихэнцэг хоёрын хооронд бууж байсан нь үнэн биз-ээ. Мөн «Йэкэ хурил» хуралдаж Өгэдэй хааныг мөнөөхөн Хэрлэний (Хэлүрэний) Хөдөө аралд хаанд өргөмжилсөн нь 1229 онд болсон тул Ордос урьд жилийн буусан бөгөөд Нууц товчооны ихэнх хэсэг буюу §1—268-ыг бичиж дуусгасаныг энэ төгсгөл үгэнд зөв тэмдэглэсэн байх. Тэгээд 269 дүгээр зүйлд нь байсан энэ төгсгөл үгийг хожим бичээд «МНТ»-ы ард хавсаргахад мөнөөхөн «төгсгөл үг нь эхийн дунд орох болоход түүнийг дараа зохиосон хоёр бүлгийн ард Өгэдэй хааны ойллогын ард (§282-т) зөөж бичсэн гэж бодох үндэс эндээс харагдаж байна. Харин Өгэдэй хааны нас барсан тухай бичээгүй нь түүний түүхийг бичих үед гарсан улс төр ширээний тэмцлийн нөхцөл байдлаас шалтгаалсан өөр зүйлээр тайлбарлагдах болов уу гэж бидэнд санагдаж байгааг энд цухас тэмдэглэе.

Төгсөв.

ИШ ТАТАЖ ХЭРЭГЛЭСЭН НОМЫН ЦЭС

1. P. Pelliot. Le tetre mongol du Yuan tch'ao pi-she. «T'oung Pao» Vol XIV, 1913;
2. Ч. Хасдорж. Монгол гэдэг нэрийн тухай. УБ., 1969.
3. Намжилдэвээн. Монгол гэдэг нэрийн тухай. УБ.. 1959.
4. Рашид-ад-Дин. Сборник летописей. М-Л., 1952.
5. Чинггис хаган-у чадиг. [Бээжин] 1925.
6. Бйамба. Асарагчи нэрэтү-йин тэүкэ. УБ., 1960.
7. Монггол-ун нигуча тобчийан. Хагучин монггол кэлэн-эчэ одо-йин монгол бичик-үн кэлэ-бэр Чэндү-йин Дамдингсүрүнг орчигулба. 1947 он. Улаганбагатур хота.
8. Элдэнгдэй Ардажаб. Монггол-ун нигуча тобчийан-сэйирэгүлүл тайилбури. Көкэхота. 1986.
9. P. Pelliot. Histoire secrete des Mongols. Paris, 1949.
10. Ш. Гаадамба. Нууц товчооны нууцсаас. УБ., 1976.
11. Байар. Монггол-ун нигуча тобчийан, (Нэйитэ гурбан дэбтэр), Көкэхота, 1981.
12. [С]Шагжи. Монггол үсүг-үн дүрэм-үн толи бичик. 27 (1937) он. Улаганбагатур.
13. A. Mostaert. Texte oraux ordos. Pei'ping, 1937.
14. С. А. Козин. Сокровенное сказание Монголов. М-Л., 1941.
15. E. Haenisch. Die geheime Geschichte der Mongolen. Zweite verbesserte Auflage. Leipzig, 1948.
16. L. Ligeti. A Mongolok. Titkos Története, Budapest, 1962.
17. P. Poucha. Taina kronika Mongolu. Praha, 1955.
18. Архимандарит Палладий. Старинное монгольское сказание о Чингис-хане. «Труды членов Российской Духовной Миссии в Пекине». том IV, СПб., 1868.
19. Г. Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980.
20. B. Rintschen. L'explications du nom Burqan galdun. «Acta Orientalia» t. 1. (Acta Orient. Hung), 1950—1951. Fasc. 1.
21. Ротмистр Баранов. Словарь монгольских терминов. «Материалы по Маньчжурии и Монголии», Вып. XI, г. Харбин, 1907.
22. P. Pelliot. Une tribu méconne des Naiman: Bätäkin [par. P. P.] «T'oung pao» Vol. XXXVII., Livr. 2, 1943.
23. Саганг сэчэн. Эрдэни-йин тобчи. Улаганбагатур, 1961 (1963?)
24. Дугаржаб. Монггол-ун нигуча тобчийан-у харагүгулүн кинаксан дэбтэр. Харгүгулүн кинаксан ни Элдэнгдэй. Ойундалай. Багулгагсан ни Хувасай Дугаржаб. Хайилар, 1984.
25. I. de Rachewiltz, Index to the secret History of the Mongols. Bloomington, 1972.
26. Т. Дашцэдэн. Монголын нууц товчоо. УБ., 1985.
27. Мансанг. Шинэ-бэр орчигулжу тайилбурилагсан «Монггол-ун нигуча тобчийан», Көкэхота, 1985.
28. Й. Иринчин. Монггол-ун нигуча тобчийан. 1987., Көкэхота.
29. К. К. Юдакин. Киргизско-русский словарь. М., 1940.
30. Е. М. Мелетинский. Происхождение героического эпоса. (Ранние формы и архаические памятники) М., 1963.
31. Лувсангданжин. Эртэн-үн хад-ун үндүсүлүксэн төрү йосун-у жокийал-и тобчилан хурийагсан Алтан тобчи кэмэкү орушибай. Дэгэдү дэбтэр 27(1937)-дугар он, Улаганбагатур.
32. Н. П. Шастина. Шара туджи-монгольская летопись XVII в. М-Л., 1957.
33. L. Ligeti, A mongolok titkos története. Budapest, 1964.
34. «Советское Востоковедение» II, 1941., (Н. Н. Поппе, Золотоордынская рукопись на бересте. с, 81—137), М-Л., 1941.

35. Ринчиндоржи (Өбүр Монгол-ун) «Монгол-ун нигуча тобчийан»-у кэлэн-дү урту экшик бүрилдүкү нөкүчэл тогтагсан ни «Монгол кэлэ жокийал тэүкэ», 1960., № 4.
36. E. Haenisch. Wörterbuch zu Manghul-un niuca tobca'an (Vuan-chao pi-shi) Geheime Geschichte der Mongolen. Leipzig, 1939. (II, Aufl., Wiesbaden, 1962)
37. Книга Марко Поло. (Перевод старофранцузского текста И. П. Минаева. Ред. и вст. статья И. П. Магидовича) М., 1956.
38. Путешествие в восточные страны Плано Карпини и Рубрука. М., 1957.
39. П. Поуха. Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дурсгалт бичиг мөн. УБ., 1957.
40. Bodhicaryàvatàra Càntideva. Изд. Б. Я. Владимирцов Ленинград, 1929.
41. Х. Пэрлээ. Нууц товчоонд гардаг «alan» гэдэг үгийн учир. «Халх дархадын этнографын бүтээл» УБ., 1964.
42. F. W. Cleaves. The secret history of the Mongols Vol. I (translation), London, 1982.
43. Б. Я. Владимирцов. Монгольские беки и беги. В сб. «Доклады АН СССР»., Серия В., 1929.
44. «T' oung pao» 1931, XXVII, № 1—2.
45. Баруун Монголын баатарлаг туульс. (Ж. Цолоо, У. Загдсүрэн), УБ., 1966 (Studia Folclorica t. I, Fasc № 2).
46. Широ Хаттори. Анх монгол хэлний урт эгшиг. (Вандуй) «Монголын судлал» УБ., 1961, t. I, Fasc. № 23.
47. A. Mostaert. Sur quelques passages de L'Histoire secréte des Mongols, Cambridge, Massachusetts, 1953.
48. Ш. Гаадамба. Сурган хүмүүжүүлэх уламжлал Нууц товчоонд тусгагдсан нь. «Шинжлэх ухаан, амьдрал», 1974, № 5, (38—41)
49. I. de Rachewiltz. The secret history of the Mongols. Translated by [I. de R.] Papers on Far Eastern History, № 4, september, 1971.
50. Ц. Дамдинсүрэн. Монголын уран зохиолын тойм. УБ., 1957.
51. Дайизу Чинггис хаган-у тугужи. (Хуучин монгол орчуулгын гар бичмэл)
52. Юван улус-ун судур, тэригүн дэбтэр, (Дандаа чансангийн монгол орчуулгын гар бичмэл) 1915 он
53. Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966.
54. P. Pelliot et L. Hambis. Histoire des campagnes de Gengis khan, Gheng-wou ts'in-Tcheng lou, tome I, Leiden, 1951.
55. P. Pelliot. Deux Lacune dans le texte mongol actuel de L' Histoire secrete des Mongols. [par P. P.]. «MELANGE ASIATIQUES» Année 1940—1941, Fasc. 1.
56. Г. Д. Санжеев. Дархатский говор и фольклор. Л., 1931.
57. Juvaini, Ala-ad-Din Ata-Malik. The History of the World Conqueror. Vol. I—II, Manchester, 1958.
58. P. Poucha. Die Geheime Geschichte der Mongolen als Geschichtsquelle und Literaturdenkmal. Prag. 1956.
59. L. Bese. Some turkic personal names in the Secret History of the Mongols. «Acta orient. Hung.» tomus XXXII, Fasc. 3, 1978.
60. N. Poppe. Ein altmongolischer Hochzeitgebrauch (In: Studia Sino-altaica. (Festschrift fur Erich Haenisch zum 80 Geburtstag) Wiesbaden, 1961. (159—164).
61. S. Kaluzynski. Tajna Historia Mongolow, Anonimowa kronika Mongolska z XIII w. Warszawa. PIW, 1970.
62. A. Mostaert. A propos de quelques portraits d'empereurs mongols. «ASIA MAJOR» vol. IV. Fasc. I., Leipzig 1927.
63. К. Д'Оссон История Монголов. т. I. Иркутск., 1937.
64. Жангарын туульс [Ү. Загдсүрэн] УБ., 1968. «Аман зохиол судлал», Боть VI, 15 дугаар дэвтэр
65. A. Mostaert. ORDOSICA. (Refrint from Bulletin № 9 (1934) of the Catholic University of Peking) (65. 23. 30. 43).
66. Ц. Дамдинсүрэн. Монгол хэл бичгийн тухай. УБ., 1957. (121—129 дүгээр т.)
67. Ш. Гаадамба. Монгол ардын баатарлагийн тууль. «Аман зохиол судлал», Боть XVIII, 3 дугаар дэвтэр. УБ., 1988.
68. Дорунатиб. Монггул үндусүтэн-ү сонггудаг жокийал-ун сонггумал. «Монггул-ун нигуча тобчийан»-ача сонггуба. [Дорунатиб сонггун тайилбурилаба.] Көкэхота, 1980.
69. A. Mostaert. Le deuil chez les Mongols. MCMLX (1960) Brugge.
70. Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982.

71. Э. Вандуй, Ж. Дашдорж. Орос монгол нэр томьёоны толь. II боть, УБ., 1960.
72. Табан жүйил-үн үсүк-нйэр хабсуругсан манжу үгэн-ү толи бичик. I—III боть, Бэгэжинг, 1957.
73. Bolor erike. Mongolian Chronicle by Rasipungsuq. Part IV, Cambridge, Massachussetts, 1959.
74. Х. Пэрлээ. Нууц Товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь. УБ., 1958.
75. Н. Ходза. Монгольские сказки. Детгиз. Ленинград, 1954.
76. Ш. Гаадамба. Зүйр цэцэн үгийн төрөл зүйлийн тусгай онцлогийн асуудалд. «Аман зохиол судлал» УБ., 1988. t. 10, F. I.
77. Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв. Монгол ардын аман зохиол. УБ., 1988.
78. Магауия Сұлтанияұлы. Монголдын күпия шежіресі, Өлгий, 1979.
79. Б. Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Л., 1929.
80. А. Позднеев. Монгольская хрестоматия для первоначального преподавания. СПб., 1900.
81. Монгол ардын баатарлаг туульс. Эмхтгэн боловсруулж, өмнөх үг, тайлбар сэлт үйлдсэн Г. Ринчинсамбуу. УБ., 1960.
82. Ш. Гаадамба. Монгол ардын оньсого таавар, «Аман зохиол судлал» t. XV, Fasc. 1, УБ., 1986.
83. A. Mostaert. Le mot Natigay/Nacigay chez Marco Polo., Roma — MCMLVII (1957).
84. Х. Гомбожав. «Монголын нууц товчоон» дахь зарим зүйр үгийн тухай «Өбүр Монгол-ун багши-йин Йэкэ сургагули-йин «Монгол-ун нигуча тобчийан»-у олан улус-ун эрдэм шинжилэгэн-ү ярилчаху хурал. (Хэлэн-ү салбури-йин хуралдуган) Көкэхота 1988.
85. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. М. Гаадамба, Д. Цэрэнсодном. УБ., 1967.
86. Энэ савуча гэдэг үгийн тухай Мостартын өгүүлэлийг үз: «Central Asiatic Journal. Vol II, № 1, Otto Harrassowitz. wies baden, pp. 9—11.
87. P. Pelliot. Sao-houa, saura, suarat saquate. «T' oung pao» t. XXXII, livre 4, 1936. Leiden.
88. J. E. Kowalewski. Distionnaire Mongol-Russe-Francaic. t. I—III, Kasan 1844—1849.
89. Д. Цэрмаа. «Нууц товчооны нууцсаас» номын тухай. «Шинжлэх ухаан. амьдрал», 1987, № 3.
90. Элдэнгдэй, Ойундалай. Хэйниши- ун «Монгол-ун нигуча тобчийан»-у үгэс-үн толи»-йин эндэгүрэл-и жаларагулху ани. «Монгол кэлэ утга жокийал», 1985, 1.
91. Живанни дель Плано Карпини «Монголчуудын түүх», Гильом де Рубрук. «Дорно этгээдэд зорчсон минь» УБ., 1988.
92. Монгол дагуу нугуд-ун тэгүбүри. Хорин табудугар (1935) он, Улаганбагатур хота.
93. М. Гаадамба. Цуу мэргэн гэгч хэн бэ? «Монголын судлал» t. VII, Fasc. 2, УБ., 1969.
94. P. Pelliot. Un passage altéré dans le texte mongol ancien de L'Histoire secréte des Mongols. «T'oung pao». XXVII [1930]
95. Б. Я. Владимирцов. Образцы монгольской народной словесности. (Северо-западная Монголия), Л., 1926.
96. [Б.] Содном. Сэчэн үгэс. «Монггул кэлэ бичик-и сайижирагулху бодулга-йин бичик. Ийсүдүгэр дэбтэр, 25 (1935) дугар он, Уланганбагатур хота.
97. Ц. Ж. Жамцарано. Монгольские летописи XVII века, М-Л., 1936.
98. Ж. Дашдорж, Г. Ринчинсамбуу. Монгол цэцэн үгийн далай. I, УБ., 1964.
99. Чэ. Дамдинсүрүнг. Монггул уран жокийал-ун дэгэжи жагун билик орушибай. MCML IX (1959) Улаганбагатур хота.
100. Г. Сүхбаатар. Даригангын хүүхдийн тоглоом. Улаанбаатар, 1962, Studia Folclorica. t.I, Fasc. 4.
101. Шичиро Мураяма. «Монголын нууц товчоон»-ы эх бичгийн хятад галиг үсгийн зарим нэгэн онцлогийн тухай. (герман хэлээр бичсэн илтгэл).
102. Монголын нууц товчоо. (III удаагийн хэвлэл хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлэнд Ц. Дамдинсүрэн орчуулав. Редактор Ш. Гаадамба), УБ., 1976.
103. Gàadamba Sh. The problem of interrelation detween the Mongols and Mongolian folclore. «Олон улсын монголч эрдэмтний II их хурал» I боть, УБ., 1973.

104. Gucin jirgugatu tayilburi toli. Corpus scriptorum Mongolorum t. I. Fasc. 8, УБ., 1961.
105. С. А. Козин. Фрагмент из цикла эпических сказаний о Чингисе ЛГУ. Ученые записки № 20. Серия филологических наук. Ленинград. 1939.
106. Марко Поло. «Орчлонгийн элдэв сонин» УБ., 1987.
107. Сайисийал жокийаба. Чинггис хаган-у тобчийан. Дэгэду дэбтэр. [Көкэхота(?)] 1987.
108. Н. Дамбасүрэн. Монгол ардын зүйр үг. УБ., 1959.
109. Preklasszikus emlekek, I, XII—XIV szazad, közzéteszi LIGETI LAJOS, kézirat. Budapest, 1963.
110. [Ф. Палладий] Путевые записки китайца Чжан Дэ-хой во время путешествия его в Монголию. в I половине XIII столетия. «Записки Сибирского отдела И. Р. Г. О. кн. IX и X, Иркутск, 1867.
111. Богда чаган эбүгэн-үн сан судур орусибай. (Зохиогчийн хувийн номын хөмрөгт хадгалагдан буй гар бичмэл).

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг
5

Хоёрдугаар бүлэг
25

Гуравдугаар бүлэг
43

Дөрөвдүгээр бүлэг
63

Тавдугаар бүлэг
79

Зургадугаар бүлэг
95

Долоодугаар бүлэг
111

Наймдугаар бүлэг
127

Есдүгээр бүлэг
145

Аравдугаар бүлэг
161

Арваннэгдүгээр бүлэг
177

Арванхоёрдугаар бүлэг
197

Оршлын оронд
218

Зарим үг, хэллэгийн тайлбар
221

Иш татаж хэрэглэсэн номын цэс
417

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

Худам монгол бичгээр сийрүүлсэн Ш. Гаадамба

Зураач **Д. Энхдаваа**
Уран сайхны редактор **П. Төмөрпүрэв**
Хянагч **Т. Оюун,** (Толийн хэсэг) **Ш. Эрдэнэбаатар**

Өрөлтөнд 1990 оны 1 сард орж 1990 оны 8 сард хэвлэв.
Цаасны хэмжээ 60×108 1/16 Хх 26,5 Хнх 31,8 Тх. 29.
За № 08. ХГ №ц Б03Н 101/89

Үнэ 22 төг

Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Улаанбаатар хот. Партизаны гудамж 2.